



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 27 (214)

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ:

- *Монгол Улсын Их Хурлын тухай*
- *Монгол Улсын Их Хурлын гишүүний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай*
- *Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай*
- *Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай*
- *Цацрагийн хамгаалалт, аюулгүй байдлын тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар

Улаанбаатар хот
2001 он

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот 2001 оны долдугаар сарын 6 №27 (214)

Гарчиг

Нэг. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

348. Монгол Улсын Их Хурлын тухай (2001 - 6 - 21 - ний хууль) 697

349. Хууль хүчингүй болсонд тооцох тухай (2001 - 6 - 21 - ний хууль) 708

350. Монгол Улсын Их Хурлын гишүүний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай (2001 - 6 - 21 - ний хууль) 708

351. Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай (2001 - 6 - 21 - ний хууль) 710

352. Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай (2001 - 6 - 21 - ний хууль) 711

353. Цацрагийн хамгаалалт, аюулгүй байдлын тухай (2001 - 6 - 21 - ний хууль) 711

Хоёр. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

354. Цацрагийн хамгаалалт, аюулгүй байдлын тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай Дугаар 60 718

355. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэг батлах тухай Дугаар 61 718

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2001 оны 6 дугаар сарын 21-ний өдөр **Улаанбаатар хот**

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТУХАЙ

/Шинэчилсэн найруулга/

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1. Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын Их Хурлын /цаашид "Улсын Их Хурал" гэх/ бүрэн эрх, түүний зохион байгуулалтын бүтэц, бүрэлдэхүүн, үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Улсын Их Хурлын тухай хууль тогтоомж

2.1. Улсын Их Хурлын тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль[1] /цаашид "Үндсэн хууль "гэх/, энэ хууль болон бусад хууль тогтоомжоос бүрдэнэ.

[1] *Монгол Улсын Үндсэн хууль – "Төрийн мэдээлэл" сэтгүүлийн 1992 оны №1 дугаарт нийтлэгдсэн.*

3 дугаар зүйл. Улсын Их Хурлын үйл ажиллагааны үндэсэн зарчим

3.1. Улсын Их Хурлын үйл ажиллагаа нь Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг хамгаалах, эрх зүйт, ардчилсан төрийг төлөвшүүлэх, ард түмний хүсэл зориг, эрх ашиг, эв нэгдлийг хангах, ардчилал, шударга ёс, хүний эрх, эрх чөлөөг баталгаажуулан хэрэгжүүлэх зарчимд үндэслэнэ.

4 дүгээр зүйл. Улсын Их Хурлын бүрэн эрх

4.1. Улсын Их Хурал нь Үндсэн хуулийн хорин тавдугаар зүйлд заасан онцгой бүрэн эрх, хуулиар тогтоосон бусад бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

4.2. Энэ хуульд заасан "Улсын Их Хурлын нийт гишүүн" гэдгийг Үндсэн хуульд заасан ёсоор 76 гишүүн гэж ойлгох бөгөөд Улсын Их Хурлын шинэ сонгуулийн дараа Улсын Их Хурлын нийт гишүүдийн деревний гурав буюу 57-гоос доошгүйн бүрэн эрх хууль ёсоор хүлээн эввэвөөрсөн нөхцөлд Улсын Их Хурлыг бүрэн эрхээ хэрэгжүүлэх бүрэлдэхүүнтэйд тооцно.

4.3. Улсын Их Хурлын тухайн бүрэн эрхийн хугацаанд гишүүн нас барсан, бүрэн эрхийг нь түдгэлзүүлсэн, эгүүлэн татсан бөгөөд нөхөн сонгууль явагдаагүй тохиолдолд Улсын Их Хурлын 57-оос доошгүй гишүүний бүрэн эрх хүчинтэй байвал Улсын Их Хурлыг бүрэн эрхээ хэрэгжүүлэх бүрэлдэхүүнтэй гэж үзнэ.

5 дугаар зүйл. Улсын Их Хурлын бүрэн эрхийн хугацаа

5.1. Улсын Их Хурлын бүрэн эрхийн хугацаа 4 жил байна.

5.2. Улсын Их Хурлын бүрэн эрхийн хугацаа нь Үндсэн хуулийн хорин гуравдугаар зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар гишүүд Төрийн сүлдэнд тангараг өргөснөөр эхэлж, Улсын Их Хурлын дараагийн сонгуулиар шинэ сонгогдсон гишүүд тангараг өргөснөөр дуусгавар болно.

5.3. Үндсэн хуулийн хорин хоёрдугаар зүйлд заасан онцгой нөхцөлийн улмаас ээлжит сонгууль явуулах боломжгүй бол мөнхүү нөхцөл арилж, шинэ сонгогдсон гишүүд тангараг өргөтөл Улсын Их Хурал бүрэн эрхээ хэрэгжүүлнэ. Хэрэв ээлжит сонгууль зарласны дараа дээрх нөхцөл байдал бий болбол тухайн үед зарласан сонгуулийг зогсоож, мөнхүү нөхцөл байдал арилсны дараа сонгуулийг дахин зарлана.

5.4. Үндсэн хуулийн хорин хоёрдугаар зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар Улсын Их Хурал өөрөө тарах буюу Ерөнхийлөгч тараах тухай шийдвэр гаргасан бол шинэ сонгогдсон гишүүд тангараг өргөтөл бүрэн эрхээ хэвээр хадгална.

5.5. Улсын Их Хурал өөрөө тарах бол тогтоол, Ерөнхийлөгч Улсын Их Хурлыг тараах бол зарлиг гаргана. Эдгээр шийдвэр нь эцсийн байна.

5.6. Энэ хуулийн 5.4 дэх хэсэгт зааснаар Улсын Их Хурал өөрөө тарах тухай шийдвэр гаргасан бол Улсын Их Хурлын сонгуулийг товлон зарлах тухай тогтоолыг хамтад нь батлан гаргана.

5.7. Монгол Улсын Ерөнхийлөгч Улсын Их Хурлыг тараах тухай шийдвэр гаргасан бол Улсын Их Хурал уг шийдвэр гарснаас хойш 7 хоногийн дотор Улсын Их Хурлын сонгуулийн хугацаг товлон зарлана.

5.8. Энэ хуулийн 5.6, 5.7-д заасан хугацаанд Улсын Их Хурлын сонгуулийг товлон зарлаагүй бол дараагийн өдрийг Улсын Их Хурлын сонгууль товлон зарласан өдөрт тооцно.

6 дугаар зүйл. Улсын Их Хурал хууль тогтоох бүрэн эрхээ хэрэгжүүлэх

6.1. Улсын Их Хурал хууль тогтоох бүрэн эрхээ гагцхүү чуулганаар хэрэгжүүлэх бөгөөд Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаан болон Байнгын хороодын хуралдааныг бэлтгэн явуулах, хуралдаанаар хууль болон Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл, тодорхой асуудал хэлэлцэх, санал хураалгах, батлах, шийдвэр гаргахдаа Улсын Их Хурлын хуралдааны дэгийг баримтална.

6.2. Улсын Их Хурлын хуралдааны дэгийг Улсын Их Хурлын тогтоолоор батална.

7 дугаар зүйл. Улсын Их Хурал хянан шалгах бүрэн эрхээ хэрэгжүүлэх

7.1. Улсын Их Хурал дараахь хэлбэрээр хянан шалгах бүрэн эрхээ хэрэгжүүлнэ:

7.1.1. Засгийн газар болон Улсын Их Хурлаас байгуулагдаж түүнд ажлаа хариуцах тайлагнадаг бусад байгууллагад асуулга тавих;

7.1.2. Засгийн газар болон Улсын Их Хурлаас байгуулагдаж түүнд ажлаа хариуцах тайлагнадаг бусад байгууллагад асуулт тавьж хариулт авах;

7.1.3. Засгийн газар болон Улсын Их Хурлаас байгуулагдаж түүнд ажлаа хариуцах тайлагнадаг бусад байгууллагын тайлан, мэдээлэл илтгэл сонсох;

7.1.4. хяналтын ажлын хэсэг байгуулах, түүний ажлын үр дүнг сонсох.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Улсын Их Хурлын зохион байгуулалтын бүтэц

8 дугаар зүйл. Улсын Их Хурлын зохион байгуулалтын үндсэн хэлбэр

8.1. Улсын Их Хурал бүрэн эрхээ чуулган, Байнгын болон түр, дэд хороо, намын бүлэг, зохион байгуулалтын бусад хэлбэрээр хэрэгжүүлнэ.

8.2. Улсын Их Хурлын үйл ажиллагааны зохион байгуулалтын үндсэн хэлбэр нь чуулган мөн.

8.3. Чуулган нь Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаан, Байнгын хороодын дагнасан бүюу хамтарсан хуралдаан, нам, эвслийн бүлгийн хуралдаанаас бүрдэнэ.

8.4. Улсын Их Хурлын нэгдсэн хуралдааныг Үндсэн хуулийн хорин долдугаар зүйлийн 6 дахь хэсэгт зааснаар нийт гишүүний олонхи нь хүрэлцэн ирснээр хүчинтэйд тооцно.

Энэхүү ирцийг Улсын Их Хурлын ээлжит, ээлжит бус, онцгой чуулганы нээлтийн хуралдаан, чуулганы өдөр бүрийн хуралдааныг эхлүүлэх, тухайн өдрийн хуралдаанаар шинэ асуудал хэлэлцэж эхлэх, санал хураахад заавал бүрдүүлсэн байвал зохино.

8.5. Улсын Их Хурлын нэгдсэн хуралдааныг чуулганы хугацаанд долоо хоног бүрийн пүрэв, баасан гаригт, шаардлагатай бол лхагва гаригт үдээс хойш зохион байгуулж байна.

8.6. Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай хуулийн дагуу өргөн мэдүүлсэн төслийг Улсын Их Хурлын дарга түүний агуулгыг үндэслэн тухайн асуудлыг эрхэлсэн Байнгын хороонд шилжүүлнэ.

9 дүгээр зүйл. Улсын Их Хурлын анхдугаар чуулган

9.1. Улсын Их Хурлын анхдугаар чуулганыг Улсын Их Хурлын сонгууль явуулсан өдрөөс хойш 30 хоногийн дотор Монгол Улсын Ерөнхийлөгч зарлиг гаргаж товлон зарлана.

9.2. Улсын Их Хурлын анхдугаар чуулганаар дараахь зохион байгуулалтын асуудлыг хэлэлцэн шийдвэрлэнэ:

9.2.1. Улсын Их Хурлын шинээр сонгогдсон гишүүдийн бүрэн эрхийг хүлээн зөвшөөрөх;

9.2.2. Улсын Их Хурлын дарга, дэд даргыг сонгох;

9.2.3. Байнгын болон дэд хороодын бүрэлдэхүүн, дарга нарыг сонгох;

9.2.4. Ерөнхий сайдыг томилох;

9.2.5. Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүний тухай хууль хэлэлцэн батлах;

9.2.6. Засгийн газрын гишүүдийг томилох.

9.3. Улсын Их Хурал шаардлагатай гэж үзсэн зохион байгуулалттай холбогдсон бусад асуудлыг анхдугаар чуулганаар хэлэлцэж болно

10 дугаар зүйл. Ээлжит чуулган

10.1. Үндсэн хуулийн хорин долдугаар зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар Улсын Их Хурлын ээлжит чуулган хагас жил тутам нэг удаа 50-иас доошгүй ажлын өдөр хуралдана.Улсын Их Хурлын намрын чуулганыг 10 дугаар сарын 1-ний өдөр, хаврын чуулганыг 4 дүгээр сарын 5-ны өдөр тус тус нээнэ.Улсын Их Хурлын ээлжит чуулган нээх өдөр нь амралт, баяр ёслолын өдөртэй давхцвал дараагийн өдөрт шилжүүлнэ.

10.2. Улсын Их Хурлын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын талаар нэгдсэн хуралдаанаар урьдчилан хэлэлцэж тогтоол гаргана. Улсын Их Хурлын дарга ээлжит чуулган эхлэхээс 7-оос доошгүй хоногийн өмнө Улсын Их Хурлын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын дараалал тогтоосон захирамж гаргана.

10.3. Улсын Их Хурлын ээлжит чуулганы нээлт дээр Монгол Улсын Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, нам, эвслийн бүлгийн төлөөлөгч үг хэлж болно.

11 дүгээр зүйл. Ээлжит бус чуулган

11.1. Ээлжит чуулганы чөлөө цаг зайлшгүй шаардлагаар ээлжит бус чуулган зарлан хуралдуулж болно.

11.2. Ээлжит бус чуулганыг Улсын Их Хурлын нийт гишүүний гуравны нэгээс дээшхийн шаардсанаар, эсхүл Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын даргын санаачилгаар хуралдуулна.

11.3. Улсын Их Хурлын даргаас бусад ээлжит бус чуулган санаачлагч нь уг чуулганаар хэлэлцүүлэх гэж байгаа асуудлынхаа зайлшгүй хэлэлцэх болсон үндэслэл, хуралдах өдөр, цагийн талаархи саналаа Улсын Их Хурлын даргад өргөн мэдүүлнэ.

11.4. Улсын Их Хурлын дарга ээлжит бус чуулганы хэлэлцэх асуудал, хуралдах өдөр, цагийг товлон зарлаж, энэ тухай захирамж гаргана.

11.5. Ээлжит бус чуулганаар зөвхөн хэлэлцэхээр шийдвэрлэсэн асуудлыг хэлэлцэнэ. Тухайн нөхцөл байдлын улмаас зайлшгүй хэлэлцэх шаардлагатай бусад асуудлыг хэлэлцэж болно.

12 дугаар зүйл. Онцгой чуулган

12.1. Үндсэн хуулийн хорин тавдугаар зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан онцгой нөхцөл

байдал Улсын Их Хурлын чуулганы чөлөө цагт бий болсон, эсхүл Монгол Улсын Ерөнхийлөгч онц болон дайны байдал зарласан бол түүнээс хойш 72 цагийн дотор Улсын Их Хурал онцгой чуулган товлохгүйгээр, тухайлбал Улсын Их Хурлын гишүүд зар мэдээ хүлээлгүйгээр хурэлцэн ирж хуралдана.

12.2. Улсын Их Хурлын онцгой чуулганаар онц болон дайны байдал зарласан тухай Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигийг уг зарлиг гарснаас хойш 7 хоногийн дотор батлах, эсхүл хүчингүй болгох, түүнчлэн тухайн нөхцөл байдлаас үүссэн хойшлуулшгүй бусад асуудлыг хэлэлцэн шийдвэрлэнэ.

12.3. Улсын Их Хурлын ээлжит болон ээлжит бус чуулган хуралдаж байх үед онц болон дайны байдал зарлах онцгой нөхцөл үүсвэл тухайн чуулганаар хэлэлцэх аливаа асуудлыг хойшлуулж онц болон дайны байдал зарлах тухай асуудлыг хэлэлцэж шийдвэрлэнэ.

13 дугаар зүйл. Улсын Их Хурлын хүндэтгэлийн чуулган

13.1. Гадаад улсын өндөр дээд зочин Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанд үг хэлэх, Монгол Улсын түүхт ой, үйл явдал зэрэг төрийн хүндэтгэлийн ёслолын үйл ажиллагаатай холбоотойгоор Улсын Их Хурлын хүндэтгэлийн чуулганыг зарлан хуралдуулж болно.

13.2. Улсын Их Хурлын дарга хүндэтгэлийн чуулганыг товлон зарлаж, энэ тухай шийдвэр гаргана.

14 дүгээр зүйл. Улсын Их Хурлын чуулганы нийтлэг журам

14.1. Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүд, Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Улсын ерөнхий прокурор, Үндэсэн хуулийн цэцийн дарга чуулганд оролцож болно.

14.2. Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн нь Улсын Их Хурлын чуулганаар хүний эрхтэй холбогдсон асуудал хэлэлцэхэд зөвлөх эрхтэй оролцож болно.

14.3. Улсын Их Хурлаас байгуулдаг бусад байгууллагын эрх баригчид, хэлэлцэж байгаа асуудал хариуцсан Улсын Их Хурлын Тамгын газрын ажилтан, ажлын хэсгийн гишүүд чуулганд байлцана. Улсын Их Хурлын даргын урилгаар чуулганд бусад хүмүүсийг байлцуулж болно.

14.4. Чуулганд иргэд, дотоод, гадаадын зочид, төлөөлөгчид, хэвлэл, мэдээллийн байгууллагын ажилтан зохих журмын дагуу байлцаж болно.Энэ журмыг Улсын Их Хурлын дарга тогтооно.

14.5. Хэлэлцэх асуудлын шинж байдлыг харгалзан чуулганыг хаалттай явуулахаар шийдвэрлэснээс бусад үед Улсын Их Хурлын чуулган нээлттэй байна. Улсын Их Хурлын чуулганы шийдвэрийг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр мэдээлнэ.

14.6. Байнгын хороо, нам, эвслийн бүлэг, Улсын Их Хурлын гишүүн нэгдсэн хуралдаанд шинээр асуудал хэлэлцүүлэх тухай саналаа Улсын Их Хурлын даргад бичгээр буюу амаар гаргаж болно.

14.7. Улсын Их Хурлын нэгдсэн хуралдааныг нам, эвслийн бүлгийн саналыг үндэслэн Улсын Их Хурлын даргын захирамжаар 7-14 хоногийн хугацаагаар түр завсарлуулж болно.

14.8. Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг нам, эвслийн бүлэг урьдчилан хэлэлцсэн байвал зохино. Хүндэтгэн үзэхээс бусад шалтгаанаар нам, эвслийн бүлэг асуудлыг урьдчилан хэлэлцэж санал, дүгнэлт гаргаагүй нь уг асуудлыг нэгдсэн хуралдаанаар хэлэлцэхэд саад болохгүй.

15 дугаар зүйл. Чуулганы хуралдааны дэг зөрчигчид хүлээлгэх хариуцлага

15.1. Улсын Их Хурлын гишүүн чуулганы дэг зөрчсөн, бусдыг доромжилсон бол хуралдаан даргалагч дараахь хариуцлага хүлээлгэнэ:

15.1.1. урьдчилан сануулах;

15.1.2. урьдчилан сануулга авсан гишүүн дахин зөрчил гаргавал түүний тухайн өдрийн хуралдаанд үг хэлэх эрхийг хасах;

15.1.3. чуулганы хуралдааны дэг удаа дараа зөрчсөн гишүүнийг нийтэд зарлах.

16 дугаар зүйл.Улсын Их Хурлын Байнгын хороо, түүний бүтэц

16.1. Улсын Их Хурлын Байнгын хороо / цаашид "Байнгын хороо" гэх/ нь Улсын Их Хурлын үйл ажиллагааны зохион байгуулалтын хэлбэр мөн. Байнгын хороо нь Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудал боловсруулах, урьдчилан хэлэлцэж дүгнэлт гаргах, түүнчлэн эрхлэх асуудлынхаа хүрээнд Улсын Их Хурлын хяналтыг хэрэгжүүлэх нийтлэг чиг үүрэгтэй.

16.2.Улсын Их Хурал Байнгын хороог үйл ажиллагааныхаа салбар, чиглэлээр Улсын Их Хурлын гишүүдийн бүрэлдэхүүнтэйгээр байгуулах бөгөөд дараахь Байнгын хороотой байна:

16.2.1.Аюулгүй байдал, гадаад бодлогын;

16.2.2.Байгаль орчин, хөдөөгийн хөгжлийн;

16.2.3.Нийгмийн бодлогын;

16.2.4.Төрийн байгуулалтын;

16.2.5.Төсвийн;

16.2.6.Хууль зүйн;

16.2.7.Эдийн засгийн.

17 дугаар зүйл.Байгнын хорооны бүрэн эрх, эрхлэх асуудал

17.1. Байнгын хороо тус тусын эрхлэх асуудлын хүрээнд дараахь нийтлэг бүрэн эрхтэй:

17.1.1. Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хууль, бусад шийдвэрийн төслийн талаар дүгнэлт гаргах;

17.1.2. Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх тодорхой асуудлуудаар дүгнэлт гаргах;

17.1.3. Улсын Их Хурлын хянан шалгах чиг үүрэгтэй холбогдсон асуудлаар дүгнэлт гаргах;

17.1.4. Улсын Их Хурлын даалгасныар, эсхүл өөрийн санаачилгаар Монгол Улсын Засгийн газар /цаашид "Засгийн газар" гэх/-т санал оруулах, хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэр биелүүлэхийг шаардах;

17.1.5. хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн биелэлт, Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын үйл ажиллагаанд тавих хяналтыг хэрэгжүүлэх;

17.1.6. Засгийн газар, түүний гишүүн, Улсын Их Хурлаас байгуулдаг бусад байгууллага, тэдгээрийн удирдлагын тайлан, мэдээллийг сонсож хэлэлцэх, тэднийг томилох, сонгох, огцруулах тухай дүгнэлт гаргах;

17.1.7. Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцэх асуудлаар болон хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн биелэлтийн талаар судалгаа, тайлан, мэдээ, дүгнэлт зэрэг баримт сэлтийг холбогдох байгууллага, албан тушаалтнаас гаргуулан авах, тэдний мэдээллийг сонсох;

17.1.8. Улсын Их Хурлын хяналтыг хэрэгжүүлэх зорилгоор дагнасан болон холимог бүрэлдэхүүнтэй шалгалтын хэсэг байгуулж ажиллуулах;

17.1.9. Улсын Их Хурлын хууль, бусад шийдвэрийн төслийн талаар дүгнэлт гаргахад туслалцаа авах, мэргэжлийн байгууллага болон олон нийтээс санал авах зорилгоор шинжээч, мэргэжилтнээс бүрдсэн ажлын хэсэг байгуулж ажиллуулах.

17.2. Байнгын хороо дараахь эрхлэх асуудлын хүрээнд бүрэн эрхээ хэрэгжүүлнэ:

17.2.1.Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо:

-Монгол Улсын үндэсний аюулгүй байдал;
-Монгол Улсын аюулгүй байдлыг хангах бодлого;
-Монгол Улсын батлан хамгаалах, зэвсэгт хүчин;
-Төрийн нууцын хадгалалт, хамгаалалт;
-Монгол Улсын хил, түүний хамгаалалт;
-гадаад бодлого;
-бусад улс, олон улсын байгууллагад суух бүрэн эрхт төлөөлөгчийн газрын тэргүүнийг томилох асуудал;
-Монгол Улсын олон улсын гэрээ, Монгол Улс олон улсын байгууллагад элсэх тухай асуудал.

17.2.2.Байгаль орчин, хөдөөгийн хөгжлийн байнгын хороо:

-газар, түүний хэвлий, ой, ус, амьтан, ургамал, агаар мандал болон байгалийн бусад баялаг;
-улсын тусгай хамгаалалттай газар, бэлчээр, тариалангийн газар;
-геологи, уул уурхайн холбогдолтой эрэл, хайгуул, ашиглалтын ажилд тавих байгаль орчны хяналт;
-агаарын бохирдол, хорт бодис байгаль орчны асуудал;
-усны бодлого, нөөц, усны бохирдол;
-хог хаягдал, дахин боловсруулалт;
-байгаль орчны бодлого;
-байгаль орчны судалгаа, хөгжил;
-ан агнуур;
-газар тариалан, үрийн аж ахуй, хүнсний үйлдвэрлэлийн бодлого;
-хүнс, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний хяналт, тэдгээрийн аюулгүй байдал;
-хөдөөгийн хөгжлийн бодлого;
-хөдөөг хөгжүүлэх бодлоготой холбоотойгоор хэрэгжих гадаад орны болон олон улсын байгууллагын зээл тусламжийн гэрээ;
-мал аж ахуйн бодлого;
-малын даатгал болон малын өвчний асуудал;

17.2.3.Нийгмийн бодлогын байнгын хороо:

-боловсрол;
-соёл, урлаг;
-шинжлэх ухаан, мэдээлэл, технологийн хөгжил;
-ард түмний түүх, соёл, оюуны өвийг сэргээх, хамгаалах талаархи бодлого;
-монгол хэл, бичиг, үндэстний цөөнхийн хэл, бичиг, соёл, урлаг, ёс заншлын талаар төрөөс баримтлах бодлого;
-хүн амын бодлого;
-хүн амын эрүүл мэнд;
-нийгмийн хамгаалалын бодлого;
-нийтийн биеийн тамир, спортын талаархи бодлого;
-хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөр хамгаалал.

17.2.4.Төрийн байгуулалтын байнгын хороо:

-төрийн эрх барих дээд болон гүйцэтгэх дээд байгууллага, Ерөнхийлөгчийн байгууллалт;
-Улсын Их Хурал, Монгол Улсын Ерөнхийлөгч, аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн

Төлөөлөгчдийн Хурлын сонгууль;
-Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлага, зохион байгуулалт, үйл ажиллагаа, хилийн цэс;
-төрийн алба;
-төрийн бэлгэ тэмдэг, төрийн дуулал;
-ард нийтийн санал асуулга;
-тер, сүм хийдийн харилцаа;
-хэвлэл, мэдээллийн хэрэгсэл;
- төрийн байгуллага, улс төрийн нам;
-Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийн асуудал;
-Улсын Их Хурлын гишүүний ёс зүй;
-Улсын Их Хурлын гишүүний хөдөлмөр, ахуйн асуудал;
-Улсын Их Хурал, Улсын Их Хурлын гишүүний төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлийн хяналт;
-Улсын Их Хурлын гишүүний орлогын мэдүүлэг;
-Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн асуудал.

17.2.5.Төсвийн байнгын хороо:

-төсвийн нэгтгэл, гүйцэтгэл, хяналт;
-терийн санхүү, зээл тусламжийн ашиглалт, зарцуулалт, үр ашиг, албан татварын бодлого;
-Монгол Улс, гадаад орон, олон улсын санхүүгийн байгууллагатай байгуулсан зээлийн хэлцэл;
-Улсын Их Хурлын төсөв.

17.2.6.Хууль зүйн байнгын хороо:

-төрийн эрх зүйн бодлого;
-хүний эрх, эрх чөлөө, түүний баталгаа:
- гэмт хэрэгтэй тэмцэх урьдчилан сэргийлэх бодлого;
-хэвлэл, мэдээллийн эрх чөлөө;
-хууль зүйн хариуцлага хүлээлгэх эрх зүйн үндэс, ялын бодлого;
-шүүх, прокурор, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, шүүхийн шийдвэр биелүүлэх байгууллага;
-нийтийн болон хувийн өмчийн эрх зүйн үндэс;
-эрүү, иргэн, захиргааны байцаан шийтгэх ажиллагаа;
-өршөөл үзүүлэх асуудал;
-патент, зохиогчийн эрх, барааны тэмдэг;
-цагаачлал, иргэний харьяалал;
-архив;
-эрх зүйн суртачилгаа;
-эрх зүйн туслалцаа;
-өмгөөлөл;
-үл хөдлөх хөрөнгийн бүртгэл.

17.2.7.Эдийн засгийн байнгын хороо:

-эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэл;
-эдийн засгийн дотоод, гадаад бодлого;
- бүсчилсэн хөгжил, барилга, хот байгуулалт;
-төрийн мөнгөний бодлого, банк Монголбанкны үйл ажиллагаа;
-үнэт цаас, даатгалын бодлого;
-төрийн өмчийн удирдлага, зохицуулалт хувьчлалын бодлого;
-гадаадын хөрөнгө оруулалт, зээл тусламжийн нэгдсэн бодлого;
-дэд бүтцийн хөгжлийн бодлого;
-газар, газрын тосны асуудал, ашигт малтма ашиглалтын бодлого;
-үйлдвэрлэл, үйлчилгээ, хөрөнгө оруулалты дэмжих бодлого:
-шударга бус өрсөлдөөнийг хязгаарла бодлого;
-терөөс аж ахуй эрхлэлтийг дэмжих бодлого
- стандартчилал, хэмжил зүй, чанары баталгаажуулалт;
-албан ёсны статистикын үйл ажиллагаан зохицуулалт;
-үйлдвэрлэлийн бүтээмжийн өсөлт, техни технологийн шинэчлэл;
-аялал жуулчлалын хөгжлийн стратеги.

18 дугаар зүйл. Байнгын хорооны ажлы зохион байгуулалт

18.1. Байнгын хорооны ажлын зохио байгуулалтын үндсэн хэлбэр нь хуралдаан мөн.

18.2. Байнгын хороо эрх хэмжээнийхэ асуудыг хуралдаанаар хэлэлцэж, өролцсо гишүүдийн олонхийн саналаар шийдвэрлэнэ Хуралдааныг Байнгын хорооны нийт гишүүни олонхи нь хүрэлцэн ирснээр хүчинтэйд тооцно.

18.3. Байнгын хороо нь Улсын Их Хурал ергөн мэдүүлсэн хууль, бусад шийдвэрийн төсө болон Улсын Их Хурлаар хэлэлцэн шийдвэрлэ тодорхой асуудлыг хэлэлцэн дүгнэлт гаргана Эрхлэх асуудлынхаа хүрээнд Байнгын хорс хэлэлцэн шийдвэрлэсэн асуудлаараа тогтоо гаргаж болно.

18.4. Байнгын хорооны хуралдаан хуваарийг чуулганы хугацаанд долоо хоног бүрий мягмар, лхагва гаригт зохион байгуулна.

18.5. Байнгын хорооны хуралдааны явц протоколд нэг бүрчлэн тэмдэглэнэ.

19 дүгээр зүйл.Улсын Их Хурлын дэ хороо

19.1. Улсын Их Хурал зохих Байнгы хороонд харьяалах дор дурдсан дэд хороо байна:

19.1.1. Аюулгүй байдал, гадаа бодлогын байнгын хороонд:

1/ Түсгай хяналтын;

19.1.2. Төрийн байгуулалты байнгын хороонд:

1/ Ёс зүйн;

2/ Нутгийн өөрөө удирдах ёсны;

19.1.3. Төсвийн байнгын хороонд

1/ Төсвийн зарлагын хяналтын.

19.1.4. Хууль зүйн байгууллын хорооны:

1/ Хүний эрхийн.

19.2. Улсын Их Хурал шаардлагатай гэж үзвэл өөр дэд хороо байгуулж болно.

19.3. Дэд хороо нь харьяалах Байгуулагын хорооныхоо эрхлэх асуудлын тодорхой хэсгийг дээрхи заалтад заасан жижиг ажлыг жижиг хариуцаж асуудал боловсруулах, дүгнэлт гаргах, түүнийгээ харьяалах Байгуулагын хорооны даргад танилцуулах, шаардлагатай бол Байгуулагын хорооныхоо уламжлан Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх, хянан шалгах бүрэн эрхтэй байна.

19.4. Дэд хороод дараахь асуудлыг хэлэлцэнэ:

19.4.1.Тусгай хяналтын дэд хороо:

-Монгол Улсын аюулгүй байдал;

-Төрийн нууцын хадгалалт, хамгаалалт.

19.4.2. Ёс зүйн дэд хороо:

-Улсын Их Хурлын гишүүний ёс зүй;

-Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай;

-Улсын Их Хурлын гишүүний орлогын мэдүүлэг.

19.4.3. Нутгийн өөрөө удирдах ёсны дэд хороо:

-нутгийн өөрөө удирдах ёс;

-нутгийн өөрөө удирдах байгууллагын чиг үүрэвшил, хөдөлгөөнийг;

-нутгийн өөрөө удирдах байгууллагын удирдлага, зохион байгуулалт, эрх зүйн байдал.

19.4.4. Төсвийн зарлагын хяналтын дэд хороо:

-төвлөрсөн болон орон нутгийн төсвийн орлого, зарлага;

-төсвийн хяналт.

19.4.5. Хүний эрхийн дэд хороо:

-хүний эрх, эрх чөлөөний баталгаа;

-өршөөл үзүүлэх асуудал;

-цагаачлал, иргэний харьяалал.

19.5. Ёс зүйн болон Төсвийн зарлагын хяналтын дэд хороо өөрсдийн эрхэлж байгаа асуудлаар гаргасан дүгнэлтээ Улсын Их Хурлын эрэгдсэн хуралдаанд бие даан оруулж болно.

19.6. Дэд хороо нь тухайн эрхэлсэн асуудлаараа шалгалт, судалгаа хийх, холбогдох эдэлгээл авах, зохих албан тушаалтан, иргэд, байгууллагаас тайлбар авах, өөрийн байгуулсан багнасан буюу хамтарсан ажлын хэсгээр хяналт шалгалт хийлгэх, эрхэлсэн асуудлаараа тогтоол гаргах, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл боловсруулж Байгнын хороныхоо, эсхүл Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх эрхтэй байна.

19.7. Дэд хорооны бүрэлдэхүүнд зөвхөн харьяалах Байгнын хорооны гишүүд орох бөгөөд тухайн Байгнын хорооны гишүүдийн хоёрны нэгээс дээшгүй байна Хэрэв дэд хорооны бүрэлдэхүүнд байгаа Улсын Их Хурлын гишүүн харьяалагдах Байгнын хорооны бүрэлдэхүүнээс гарсан тохиолдолд тухайн дэд хорооны бүрэлдэхүүнээс гарсанд тооцно.

19.8. Дэд хорооны даргыг харьяалах Байгнын хорооны хуралдаанаар гишүүдийн олонхийн саналаар сонгох бөгөөд Төсвийн зарлагын хяналтын болон Ёс зүйн дэд хороодын даргыг Улсын Их Хурал дахь цөөнхийн бүлгийн гишүүдээс сонгоно. Дэд хорооны даргын бүрэн эрхийн хугацаа 1 жил байх ба түүнийг улируулан сонгож болно.

19.9. Дэд хорооны үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан мөн.Дэд хороо эрхэлсэн асуудлаа хуралдаанаараа хэлэлцэж гишүүдийнхээ олонхийн саналаар шийдвэрлэнэ. Хуралдааныг дэд хорооны гишүүдийн олонхи нь хүрэлцэн ирснээр хүчинтэйд тооцно.

20 дугаар зүйл. Улсын Их Хурлын бусад хороо, ажлын хэсэг

20.1. Улсын Их Хурал бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ тодорхой асуудлыг судлан боловсруулах, шийдвэрлэх, дунг Улсын Их Хуралд оруулах зорилгоор түр хороо байгуулан ажиллуулж болно. Түр хороо эвөхөн Улсын Их Хурлын гишүүнээс бүрдэх бөгөөд түүний тоог тухайн үед тогтооно. Түр хороо эрхлэх асуудлынхаа хүрээнд Байгнын хороотой адил эрх эдэлнэ.

20.2. Улсын Их Хурал шаардлагатай гэж үзсэн асуудлаар холимог болон дагнасан бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг байгуулан ажиллуулж болно. Ажлын хэсэг тодорхой мэргэжлийн шинжээч, ажилтныг зохих хөлсийг нь олгон ажиллуулж болно.

21 дүгээр зүйл. Улсын Их Хурал дахь нам /эвсэл/-ын бүлэг

21.1. Улсын Их Хуралд 8-аас доошгүй суудалтай нам /эвсэл/ бүлэг /цаашид "нам, эвслийн бүлэг" гэх/ байгуулж болно. Нам, эвслийн бүлэгт эвөхөн тухайн нам, эвслээс нэрийг нь дэвшүүлж сонгогдсон Улсын Их Хурлын гишүүд орно. Улсын Их Хурлын сонгуульд эвсэл байгуулж оролцсон намууд Улсын Их Хуралд 8-аас доошгүй суудал эзэлбэл Монгол Улсын Их Хурлын сонгуулийн хуулийн 19 дүгээр зүйлийн 2-т зааснаар эвслийн нэг бүлэг байгуулна.

21.2. Улсын Их Хуралд 8-аас доош суудал эзэлсэн хэд хэдэн намыг төлөөлж байгаа гишүүд нийлж намын нэг бүлэг байгуулж болохгүй. Харин тэдгээр нь аль нэг нам, эвслийн бүлэгт нэгдэх бол тухайн нам, эвслийн бүлэгт нэгдэн орох хүсэлтээ тавина. Хүсэлтийг хүлээн авсан бол энэ тухай шийдвэрээ нам, эвслийн бүлгийн ахлагч Улсын Их Хурлын даргад бичгээр мэдэгдэнэ. Улсын Их Хурлын дарга уг баримт бичгийг үндэслэн Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанд албан ёсоор мэдээлнэ.

21.3. Аль нэг нам, эвслийн бүлгийн гишүүн уг нам, эвслийн бүлгийн харьяаллаас татгалзсан тохиолдолд нам, эвслийн бүлгээс албан ёсоор гарч өөр бүлэгт нэгдэн орж болно. Ийнхүү нам, эвслийн бүлгээс албан ёсоор гарах тухайгаа тухайн нам, эвслийн бүлгийн ахлагчид урьдчилан мэдэгдсэн байна.

21.4. Нэрээ бие даан дэвшүүлж соногдсон Улсын Их Хурлын гишүүн аль нэг нам, эвслийн бүлэгт нэгдэж болох боловч дангаараа бүлэг байгуулж болохгүй.

21.5. Нам, эвслийн бүлэг ахлагчаа гишүүдийнхээ дотроос сонгож, энэ тухайгаа Улсын Их Хуралд албан ёсоор мэдэгдэнэ.

21.6. Нам, эвслийн бүлгийн ахлагч Улсын Их Хурлын анхдугаар чуулган дээр Улсын Их Хурлын даргыг сонгогдсоноос хойш 24 цагийн дотор нам, эвслийн бүлэг байгуулсан тухай шийдвэр, нэрсийн жагсаалтыг Улсын Их Хурлын даргад өргөн мэдүүлнэ.

21.7. Улсын Их Хурлын дарга нам, эвслийн бүлгээс өргөн мэдүүлсэн баримт бичгийг үндэслэн нам, эвслийн бүлгийг бүртгэж, энэ тухай Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаан дээр албан ёсоор зарлана. Шинээр нөхөн сонгогдсон Улсын Их Хурлын гишүүн аль нэг нам, эвслийн бүлэгт эвсэн нэгдвэл түүнийг тухайн нам, эвслийн бүлгийн ахлагч бүлэгтээ бүртгэн авч, энэ тухай шийдвэрээ гаргаж Улсын Их Хурлын даргад бичгээр мэдэгдэнэ. Улсын Их Хурлын дарга уг шийдвэрийг нэгдсэн хуралдаанд албан ёсоор мэдээлнэ.

21.8. Улсын Их Хуралд суудал бүхий аль нэг нам тарах буюу намууд эвслээ цуцалбал тухайн нам, эвслийн бүлгийн үйл ажиллагаа дуусгавар болсонд тооцно. Нам тарсан буюу намууд эвслээ цуцалсан тухай шийдвэрийг, иймхүү шийдвэр гарснаас хойш хуралдах эхний нэгдсэн хуралдаанд, чуулганы завсарлагааны үед уг шийдвэр гарвал ээлжит чуулганы эхний нэгдсэн хуралдаанд тус тус мэдээлнэ.

21.9. Нам, эвслийн бүлгийн хуралдааныг чуулганы хугацаанд долоо хоног бүрийн даваа гариг зохион байгуулж байна.

21.10. Улсын Их Хурал дахь нам, эвслийн бүлэг 2 гишүүнд орон тооны нэг ажилтан байхаар тооцож тогтоосон ажлын албатай байж болно. Ажлын албаны дотоод зохион байгуулалтын асуудлыг дүрмээр зохицуулна.

Нам, эвслийн бүлгийн гишүүдийн тоог харгалзан үнаа, албан томилолт, бичиг хэргийн зардал, орон тооны ажилтны цалингийн санг Улсын Их Хурлын төсөвт тусгана.

21.11. Нам, эвслийн бүлэг батлагдсан төсвөө зохих журмын дагуу зарцуулах бөгөөд түүнд Төсвийн зарлагын хяналтын дэд хороо хяналт тавина.

21.12. Нам, эвслийн бүлгийг ажиллах нөхцөлөөр хангах асуудлыг Улсын Их Хурлын Тамгын газар хариуцна.

21.13. Нам, эвслийн бүлэг Улсын Их Хурлын бүтцийн хэсгийн хувьд эрхлэх ажлаа намынхаа төв байгуллагын удирдлагын өмнө шууд хариуцахгүй.

22 дугаар зүйл. Нам, эвслийн бүлгийн эрх, үүрэг

22.1. Улсын Их Хурал дахь нам, эвслийн бүлэг дараахь эрх, үүрэгтэй:

22.1.1. Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж байгаа хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийн талаар тус тусын дүгнэлт гаргаж, тухайн асуудал хариуцсан Байнгын хорооны хуралдаан болон нэгдсэн хуралдаанд оруулах;

22.1.2. чуулган, Байнгын хорооны үйл ажиллагаанд өөрийн бүлгийн гишүүдийг татан оролцуулж, хуралдааны дэгийг чанд сахиулах;

22.1.3. Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах санал гаргах;

22.1.4. Улсын Их Хурлын нэгдсэн болон Байнгын хорооны хуралдааны үед завсарлага авах;

22.1.5. бүлгийн төсвийн гүйцэтгэлийг үнэн зөв мэдээлэх;

22.1.6. Байнгын болон дэд хорооны бүрэлдэхүүний талаар Улсын Их Хурлын даргатай зөвшилцөх;

22.1.7. Улсын Их Хурлын үйл ажиллагаатай холбогдсон саналаа Улсын Их Хурал, Байнгын хороонд оруулах;

22.1.8. Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж байгаа асуудлаар нам,эвслийн бүлгийн байр суурийг тодорхойлох ажлын хэсэг байгуулж ажиллуулах;

22.1.9. чуулганаар хэлэлцэж байгаа асуудлаар нам, эвслийн бүлгийн байр суурийг тодорхойлох, ажлын хэсэг байгуулж ажиллуулах;

22.2. Улсын Их Хурал дахь нам, эвслийн бүлгийн бусад бүрэн эрхийг Улсын Их Хурал хуулиар тогтоож болно.

22.3. Улсын Их Хуралд 8-аас доош суудал эзэлсэн нам, эвслийг төлөөлж байгаа Улсын Их Хурлын гишүүн дараахь бүрэн эрхтэй:

22.3.1. Улсын Их Хурлын зохион байгуулалт, үйл ажиллагаатай холбогдсон саналаа Улсын Их Хурал, харьяалагдах Байнгын хороонд оруулах;

22.3.2. Байнгын хорооны бүрэлдэхүүнд орох тухай асуудлаа Улсын Их Хурлын даргатай зөвшилцөх;

22.3.3. Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийг чанд сахих.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Улсын Их Хурлын бүрэлдэхүүн

23 дугаар зүйл. Улсын Их Хурал дахь олонхи ба цөөнх

23.1. Улсын Их Хурлын нийт гишүүний олонхи буюу 39 ба түүнээс дээш суудал авсан нам буюу эвслийг Улсын Их Хурал дахь олонхи /цаашид "олонхи"/-д тооцно.

23.2. Улсын Их Хурлын нийт гишүүний 38-аас доош суудал авсан нам буюу эвслийн бүлэг, гишүүнийг Улсын Их Хурал дахь цөөнх /цаашид "цөөнх"/-д тооцно.

24 дүгээр зүйл. Улсын Их Хурлын бүрэлдэхүүн

24.1. Улсын Их Хурал нь Үндсэн хуулийн хорин нэгдүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэгт зааснаар нэг танхим бүхий, Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэд, нийтээрээ, чөлөөтэй, шууд сонгох эрхийн үндсэн дээр саналаа нууцаар гаргаж сонгосон 76 гишүүнээс бүрдэнэ.

25 дугаар зүйл. Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрх

25.1. Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрх, түүний баталгаат Монгол Улсын Их Хурлын гишүүний эрх зүйн байдлын тухай хуулиар зохицуулна.

26 дугаар зүйл. Улсын Их Хурлын дарга, түүний чиг үүрэг

26.1. Улсын Их Хуралд олонхийн суудал авсан нам буюу эвсэл Улсын Их Хурлын даргын сонгуульд нэр дэвшүүлэх эрхтэй. Хэрэв аль ч нам буюу эвсэл олонхийн суудал авааГүй бол хамгийн олон суудал авсан нам буюу эвсэл, бусад нам, эвсэлтэй зөвшилцөн нэр дэвшүүлэх эрхтэй.

26.2. Улсын Их Хурлын дарга нь дараахь чиг үүрэгтэй:

26.2.1. Улсын Их Хурлын эзлэжит болон эзлжит бус чуулган зарлаж, бэлтгэлийг хангах;

26.2.2. чуулганаар хэлэлцэх асуудлын дараалал тогтоох;

26.2.3. нэгдсэн хуралдаан даргалж, хуулийн төсөл, бусад асуудал хэлэлцүүлэх;

26.2.4. бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь Улсын Их Хурлын гишүүдэд туслах;

26.2.5. Улсын Их Хурлаас Засгийн газрын үйл ажиллагаанд тавих хяналтыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

26.2.6. Улсын Их Хурлын үйл ажиллагаанд Үндсэн хууль, бусад хуулийг сахин биелүүлэх ажлыг зохион байгуулах;

26.2.7. төрийн захиргааны байгууллагатай Засгийн газраар дамжуулан харилцах асуудал болон Улсын Их Хурлаас байгуулдаг байгууллагын үйл ажиллагаагуялдуулан зохицуулах;

26.2.8. Улсын Их Хурлын гадаад харилцааны ажлыг зохицуулах;

26.2.9. Улсын Их Хурлын даргад хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хариуцуулж болно.

26.3. Улсын Их Хурлын дарга дотоод, гадаад харилцаанд Улсын Их Хурлыг төлөөлнө.

26.4. Улсын Их Хурлын дарга төрийн хамгаалалтад байна.Улсын Их Хурлын даргын орон сууц, унааны зардлыг төрөөс хариуцах бөгөөд түүний бие, өргөө, унаа халдашгүй дархан байна.

26.5. Улсын Их Хурлын дарга эрх хэмжээнийхээ асуудлаар хууль тогтоомжид нийцүүлэн захирамж гаргана.

26.6. Улсын Их Хурлын дарга нь бүрэн эрхийнхээ хугацаа дуусснаас эхлэн нэгэн бүрэн эрхийнхээс илүүгүй хугацаагаар Улсын Их Хурлаас тогтоосон хангамж эдэлж, хамгаалалтад байна. Улсын Их Хурлын дарга нь хугацаанаасаа өмнө огцроох, чөлөөлөгдөх зэргээр бүрэн эрх нь дуусгавар болсон бол Улсын Их Хурлын даргаар ажилласан хугацаатай нь дүйцэхүйц хугацаагаар хангамж эдэлж, хамгаалалтад байлгана. Улсын Их Хурлаас тогтоох хангамж гэдэгт унааны болон холбооны зардал хамаарна. Уг хангамжийн хэмжээг Засгийн газар тогтоож мөрдүүлнэ.

26.7. Улсын Их Хурлын дарга биеийн эрүүл мэндийн байдал, хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй болсноос үүрэгт ажлаас чөлөөлөхийг хүсч, Улсын Их Хуралд өргөдөл гаргавал Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанаар уг асуудлыг хэлэлцэн шийдвэрлэнэ.

26.8. Улсын Их Хурлын дарга гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай болохыг шүүх тогтоосон, эсхүл огцруулах, эгүүлэн татах үндэслэлтэй гэж Үндсэн хуулийн цэц дүгнэлт гаргаж түүнийг нь Улсын Их Хурал хүлээн зөвшөөрвөл бүрэн эрхийнх нь хугацаа дуусахаас өмнө тухайн албан тушаалаас огцруулах асуудлыг Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэнэ.

27 дугаар зүйл. Улсын Их Хурлын дэд даргын чиг үүрэг

27.1. Улсын Их Хурлын тухайн сонгуулийн үр дүнд бий болсон нам, эвслийн бүлэг тус бүрээс Улсын Их Хурлын дэд даргыг сонгоно.

27.2. Улсын Их Хуралд олонхи суудал авсан нам, эвслийн бүлгээс сонгогдсон дэд дарга дараахь чиг үүрэгтэй:

27.2.1. Улсын Их Хурлын даргын эзгүйд түүний үүргийг гүйцэтгэх;

27.2.2. Улсын Их Хурлын гишүүдийн ажиллах нөхцөл, ахуй хангамжтай холбоотой асуудлыг зохицуулах;

27.2.3. бусад.

27.3. Улсын Их Хурлын дэд дарга нар дараахь нийтлэг чиг үүрэгтэй:

27.3.1. Улсын Их Хурлын Байнгын болон бусад хороод, нам, эвслийн бүлэг, ажлын хэсгийн үйл ажиллагаат уялдуулан зохицуулах;

27.3.2. Улсын Их Хурлын нэгдсэн болон Байнгын хороодын хуралдааны ирц бүрдүүлэх ажлыг зохион байгуулах;

27.3.3. Улсын Их Хурлын даргаас даалгасан бусад ажил.

28 дугаар зүйл. Байнгын хорооны бүрэлдэхүүн

28.1. Байнгын хороо нь 12-оос доошгүй гишүүний бүрэлдэхүүнтэй байна. Улсын Их Хурлын гишүүн нэгэн зэрэг хоёр Байнгын хороонд сонгогдон ажиллаж болно.

28.2. Байнгын хороог Улсын Их Хурлаас 1 жилийн хугацаатай сонгогдсон дарга тэргүүлнэ. Байнгын хорооны даргыг тухайн Байнгын хорооны гишүүдийн дотроос сонгох бөгөөд түүнийг улируулан сонгож болно.

28.3. Байнгын хорооны дарга хорооныхоо өдөр тутмын ажлыг удирдаж, хуралдааныг даргална. Байнгын хорооны даргын эзгүйд түүний томилсон нэг гишүүн үүргийг нь түр орлон гүйцэтгэнэ.

29 дүгээр зүйл.Байнгын хорооны даргын чиг үүрэг

29.1. Байнгын хорооны дарга дараахь чиг үүрэгтэй:

29.1.1. Байнгын хорооны хуралдааны бэлтгэл ажлыг хангаж, зохион байгуулах;

29.1.2. Байнгын хорооны хуралдааныг удирдах;

29.1.3. Байнгын хорооны нэрийн өмнөөс бусад байгууллагатай харьцах;

29.1.4. Байнгын хорооны ажлын алба болон тодорхой төсөл боловсруулахаар Байнгын хорооноос байгуулсан ажлын хэсгийн үйл ажиллагаат уялдуулан зохицуулах;

29.1.5. Байнгын хорооны ажлыг Улсын Их Хурлын өмнө хариуцан тайлагнах.

30 дугаар зүйл. Парламентын бүлгэм байгуулах тухай

30.1. Улсын Их Хурлын гишүүд сайн дурын үндсэн дээр Монголын парламентын бүлгэм байгуулж болно.

30.2. Парламентын бүлгэмийн бүтэц, зохион байгуулалтын асуудлыг дүрмээр зохицуулна.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Бусад зүйл

31 дүгээр зүйл. Улсын Их Хурлын ажлын нөхцөл

31.1. Улсын Их Хурал "Төрийн ордон"-д байрлана.

31.2. Улсын Их Хурал аж ахуй, санхүүгийн хувьд бие даасан байна.

31.3. Улсын Их Хурлын төсвийн зарцуулалтад Төрийн байгууллагын байгаль хороо хяналт тавина.

31.4. Улсын Их Хурал нь өөрийн гишүүд, Байнгын болон бусад хорооны үйл ажиллагаанд мэргэжил, арга зүй, техник, зохион байгуулалтын туслалцаа үзүүлэх болон ажилгах нөхцөлөөр хангах үүрэг бүхий Тамгын газартай байна.

32 дугаар зүйл. Улсын Их Хурлын Тамгын газар, түүний эрхлэх ажил

32.1. Улсын Их Хурлын Тамгын газар /цаашид "Тамгын газар" гэх/ нь дараахь ажлыг эрхлэн гүйцэтгэнэ:

32.1.1. Улсын Их Хурал, Байнгын болон бусад хороод, ажлын хэсэг, Улсын Их Хурлын гишүүдэд мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх, туслалцаа үзүүлэх;

32.1.2. Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх төслийг хянаж, зохих журмын дагуу өргөн мэдүүлэх бэлтгэлийг хангах;

32.1.3. хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл өргөн мэдүүлэх, хэлэлцүүлэх, батлах, нийтлэх үйл ажиллагаат зохион байгуулан хэрэгжүүлэх;

32.1.4. Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцэх хууль, бусад шийдвэрийн төслийн талаар Байнгын хороо, дэд хороо, Улсын Их Хурлаас хүсэлт гаргасан буюу шаардлагатай гэж үзсэн асуудлаар мэргэжлийн санал гаргах;

32.1.5. Улсын Их Хурал, түүний Тамгын газар, Улсын Их Хурал дахь нам, эвслийн бүлгийн аж ахуй, санхүүг хөтлөн явуулах, төсвийг хууль тогтоомжийн дагуу зарцуулах;

32.1.6. Улсын Их Хурлын гишүүдээс хууль санаачлах эрхээ хэрэгжүүлэхэд нь мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх;

32.1.7. Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаан, Байнгын болон бусад хороодын хуралдаан, ажлын хэсгийн үйл ажиллагааны зохион байгуулалт, техникийн бэлтгэл, чуулганы хэвийн ажиллах нөхцөлийг хангах;

32.1.8. Улсын Их Хурлаас баталсан хууль, бусад шийдвэрийн эцсийн найруулга хийх, хэлбэржүүлэн гаргах, нийтлэх, мэдээлэх;

32.1.9. Улсын Их Хурлын чуулган, Улсын Их Хурлын гишүүний ажлын зөвлөлгөөний явцыг дэс дараалан албан ёсоор тэмдэглэн хөтөлж, уг тэмдэглэлийг ашиглах, хадгалах ажлыг Ерөнхий нарийн бичгийн даргын тогтоосон журмын дагуу эрхлэн явуулах;

32.1.10. Улсын Их Хурал, Улсын Их Хурлын Тамгын газрын бичиг хэрэг, архивын үйл ажиллагаат хөтлөн явуулах, чуулганаар хэлэлцэх асуудалтай холбоотой баримт бичгийг олшруулан тараах ажлыг эрхлэн гүйцэтгэх;

32.1.11. Улсын Их Хурлаас олон нийттэй харилцах ажиллагаат зохион байгуулах, Улсын Их Хуралд иргэд, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, санал, гомдлыг нэгтгэж, Улсын Их Хурлын чуулганд мэдээлэх, шийдвэрлүүлэх арга хэмжээг зохион байгуулах;

32.1.12. Улсын Их Хурал, Тамгын газрын гадаад харилцааны асуудлыг хариуцан, шаардлагатай баримт бичиг бэлтгэх, Улсын Их Хурлын шугамаар гадаад оронд айлчлах болон гадаадаас ирэх төлөөлөгчидийг хүлээн авах бэлтгэл хангах, гадаадын зочин, төлөөлөгчдөд үйлчлэх;

32.1.13. хянан шалгах чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь Улсын Их Хуралд туслалцаа үзүүлэх;

32.1.14. Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцэх хууль, бусад шийдвэрийн төсөл болон тодорхой хуулийн хэрэгжилтээр мэдээллийн эх үүсвэрийг бүрдүүлэх;

32.1.15. Улсын Их Хурлын хэлэлцэж байгаа асуудлаар мэргэжлийн шинжээч томилон дүгнэлт гаргуулах;

32.1.16. Байнгын хороо, нэгдсэн хуралдаанаас гаргасан шийдвэрийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр иргэдэд мэдээлж, сурталчлах;

32.1.17. Улсын Их Хурлын гишүүдийг шаардлагатай мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах;

32.1.18. хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрээр даалгасан бусад үүргийг биелүүлэх.

32.2. Тамгын газар нь хуулийн этгээд мөн бөгөөд түүний дүрмийг Улсын Их Хурал батална.

33 дугаар зүйл. Ерөнхий нарийн бичгийн дарга

33.1. Улсын Их Хурлын Тамгын газрын ажлыг Ерөнхий нарийн бичгийн дарга удирдана. Ерөнхий нарийн бичгийн дарга нь хуульч мэргэжилтэй байна.

33.2. Ерөнхий нарийн бичгийн дарга нь ямар нэг намын харьяалалгүй байна.

33.3. Ерөнхий нарийн бичгийн дарга эрхлэх асуудлаараа захирамж гаргана.

34 дүгээр зүйл. Ерөнхий нарийн бичгийн даргын эрхлэх ажил

34.1.Ерөнхий нарийн бичгийн дарга дараахь ажлыг эрхлэн гүйцэтгэнэ:

34.1.1. Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаан даргалагчид хууль, дэгийн асуудлаар зөвлөх;

34.1.2. Улсын Их Хурал, Байнгын болон бусад хороодын хуралдааны тэмдэглэл, гаргасан шийдвэрийг эрх зүйн хувьд хэлбэржүүлэх;

34.1.3. боловсон хүчний бодлого боловсруулж, тэдгээрийг томилох, чөлөөлөх;

34.1.4. Улсын Их Хурлаас олон нийттэй харилцах ажлыг зохион байгуулах;

34.1.5. Улсын Их Хурлын төсвийн төслийг бэлтгэх, төсвийг зарцуулах;

34.1.6. Тамгын газрын захиргаа, санхүүгийн хяналтыг хэрэгжүүлэх.

35 дугаар зүйл. Улсын Их Хурлын даргын ажлын хэсэг

35.1. Улсын Их Хурлын дарга бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ зөвлөгөө авах, шуурхай ажил гүйцэтгэх зөвлөх , ажлын хэсгэтэй байна.

35.2. Улсын Их Хурлын даргын ажлын хэсгийн орон тоо, зардлын төсвийг Улсын Их Хурал тогтооно.

35.3. Улсын Их Хурлын даргын зөвлөх, ажлын хэсгийн ажилтан Улсын Их Хурлын даргад ажлаа шууд хариуцаж, Тамгын газарт харьяалагдана.

36 дугаар зүйл. Улсын Их Хурлын шийдвэр

36.1. Улсын Их Хурал хууль, бусад шийдвэр гаргана. Улсын Их Хурлын бусад шийдвэр нь тогтоол байна.

37 дугаар зүйл. Улсын Их Хурлын тамга,тэмдэг, хэвлэмэл хуудас

37.1. Улсын Их Хурал нь тогтоосон журмаар үйлдсэн тамга, тэмдэг, хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

38 дугаар зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

38.1. Энэ хуулийг 2001 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА Л.ЭНЭБИШ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2001 оны 6 дугаар сарын 21-ний өдөр Улаанбаатар хот

ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. 1997 оны 2 дугаар сарын 6-ны өдөр батлагдсан Монгол Улсын Их Хурлын тухай, Монгол Улсын Их Хурлын хуралдааны дэгийн хуулийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн шинэчилсэн найруулга хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Л.ЭНЭБИШ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2001 оны 6 дугаар сарын 21-ний өдөр Улаанбаатар хот

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын Их Хурлын гишүүний эрх зүйн байдлын тухай хуульд дараахь зүйл, заалт, хэсэг, өгүүлбэр нэмсүгэй.

1/ 14 дүгээр зүйл:

"**14 дүгээр зүйл. Чуулганы хуралдааны дэг зөрчигчид хүлээлгэх хариуцлага**

1. Монгол Улсын Их Хурлын гишүүний эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2, 3 дахь заалтыг зөрчсөн Улсын Их Хурлын гишүүнд дараахь хариуцлага хүлээлгэнэ:

1/ тухайн чуулганы хугацаанд нэгдсэн болон Байнгын хорооны хуралдааныг 3-аас дээш удаа тасалсан гишүүний талаар хуралдаан даргалагч тухай бүр нийтэд мэдээлнэ;

2/ хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр Улсын Их Хурлын нэгдсэн хуралдааныг дуурайн орхиж гарвал Улсын Их Хурлын дарга хуралдааны оролцохыг шаардана. "

2/ 5 дугаар зүйлийн 3 дахь хэсэг:

"3. Нөхөн сонгогдсон Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийн хугацаа нь орон гарсан гишүүний бүрэн эрхийн үлдсэн хугацаатай адил байна."

3/ 8 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 11 дэх заалт:

"11/ Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүнээр томилогдвол хавсран ажиллах."

4/ 8 дугаар зүйлийн 3 дахь хэсэг:

"3. Улсын Их Хурлын гишүүн нь Монгол Улсын Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүний үүргийг хавсран гүйцэтгэж болно. Иймхүү Засгийн газрын гишүүний үүргийг хавсарч байгаа Улсын Их Хурлын гишүүн өөрийнх нь эрхэлсэн ажлын хүрээнд хяналт тавих үүрэг бүхий Байнгын болон дэд хорооны гишүүн байх, Байнгын болон дэд хорооны даргаар сонгогдохыг хориглоно."

5/ 10 дугаар зүйлийн 10, 11, 12 дахь хэсэг:

"10. Улсын Их Хурлын онцгой чуулган зарласан тохиолдолд Улсын Их Хурлын гишүүнийг чуулганд хүрэлцэн ирэх боломжийг Монгол Улсын Ерөнхийлөгч хангаж, шаардлагатай бол төрийн тусгай хамгаалалтад авна.

11. Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийн хугацаанд түүний амь насны даатгалыг төр хариуцаж, даатгалын хураамжийг улсын төсвөөс төлнө.

12. Улсын Их Хурлын гишүүн албан үүргээ гүйцэтгэж яваад нас барсан тохиолдолд 6 сарын үндсэн цалинтай нь тэнцэх буцалтгүй тусламжийг гэр бүлд нь өгнө".

6/ 11 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 2 дахь өгүүлбэр:

"Улсын Их Хурлын гишүүн сонгогдсон тойргоотоо ажиллахтай холбогдсон зардлын норм, хэмжээг Улсын Их Хурал тогтооно"

7/ 11 дүгээр зүйлийн 8, 9, 10, 11 дэх хэсэг:

"8. Улсын Их Хурлын гишүүн Засгийн газрын бүрэлдэхүүнд орвол тухайн хоёр албан тушаалын цалин, хангамжийн аль нэгийг нь сонгох эрхтэй. Түүний ажлын цагийг зохицуулах журмыг Улсын Их Хурлын дарга Ерөнхий сайдтай зөвшилцөн захирамжаараа тогтооно.

9. Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлсэн едрөөс эхлэн түүний цалин, унаа, албан томилолтын зардлын хангамжийг түр зогсооно. Улсын Их Хурлын гишүүнд холбогдсон хэргийн талаар анхан шатны шүүхийн шийдвэр гарсан едрөөс эхлэн түүний туслах, бие төлөөлөгч-туслахын цалин, гишүүний бусад хангамжийг түр зогсооно. Улсын Их Хурлын гишүүнийг эгүүлэн татах тухай Улсын Их Хурлын шийдвэр гарсан бол түүнд энэ хуулийн 10 дугаар зүйлийн 9 дэх хэсгийн заалт үл хамаарна.

10.Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийг сэргээсэн тохиолдолд түүний цалин, бусад хангамжийг гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлсэн едрөөс эхлэн нэгэн адил сэргээнэ.

11. Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийг сэргээсэн тохиолдолд түүний туслах, бие төлөөлөгч-туслахын цалингийн хангамжийг гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлсэн едрөөс эхлэн нэгэн адил сэргээнэ."

8/ 13 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь өгүүлбэр:

"Ингэхдээ Улсын Их Хурлаас уг асуудлаар ажлын хэсэг байгуулахгүй бөгөөд хяналтын үйл ажиллагаа явуулахгүй."

9/ 13 дугаар зүйлийн 6 дахь хэсэг:

"6. Чуулганы чөлөө цагт Улсын Их Хурлын дарга Улсын Их Хурлын гишүүнийг баривчилсан тухай мэдээлэл авсан бүюу гишүүнийг цагдан хорих зөвшөөрөл авах тухай хүсэлт хүлээн авснаас хойш 48 цагийн дотор тухайн гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх эсэх асуудлыг шийдвэрлүүлхээр Улсын Их Хурлын эзлжит бус чуулганыг санаачлан хуралдуулна."

10/ 13 дугаар зүйлийн 7 дахь хэсэг:

"7.Шүүх Улсын Их Хурлын гишүүнтэй холбогдсон хэргийн талаар гаргасан шийдвэрээ нэн даруй Улсын Их Хуралд илгээнэ."

2 дугаар зүйл. Монгол Улсын Их Хурлын гишүүний эрх зүйн байдлын тухай хуулийн дараахь зүйл, заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/ 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалтыг:

"5/ Байнгын болон бусад хороонд саналаараа гишүүнээр орох, нэг Байнгын хороонд бүрэлдэхүүнээс гарч өөр Байнгын хороонд бүрэлдэхүүнд орох саналаа намын бүлгийн дүгнэлтийн хамт Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанд шууд оруулах, аль нэгэн нам, эвслийн бүлэгт харьяалагүй гишүүн Байнгын хороонд хуваарилагдах саналаа Улсын Их Хурлын даргад гаргах;

6/ Улсын Их Хурлаас болон Байнгын хорооноос байгуулсан ажлын хэсэгт хүсэлтэрээ орж ажиллах;"

2/ 11 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг:

"1. Улсын Их Хурлын гишүүний төсөвт түүний төрийн өндөр албан тушаалтны зэрэг дэвд тохирсон цалин, унаа, албан томилолт, бичиг хэрэг, гэрийн болон үүрэн телефон утасны зардлын хэсэг, энэ хуулийн 12 дугаар зүйлд заасан туслах, бие төлөөлөгч-туслахын цалингийн сан, бичиг хэргийн зардал болон бусад зардал багтана."

3/ 11 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг:

"4. Улсын Их Хурлын гишүүн тойргийнхоо сонгогчиддоо үйл ажиллагааныхаа талаар мэдээлэх, сурталчлах зардал болон хэвлэлийн захиалгын зарим төлбөрийг улсын төсвөөс гаргана."

4/ 12 дугаар зүйл:

"12 дугаар зүйл. Улсын Их Хурлын гишүүний туслах, бие төлөөлөгч-туслах

Улсын Их Хурлын гишүүн өөрийн төсөвтөө багтаан гэрээний үндсэн дээр туслах, бие төлөөлөгч-туслах авч ажилуулж болно. Улсын Их Хурлын гишүүн өөрийн туслах, бие төлөөлөгч-туслахтай байгуулах гэрээний үлгэрчилсэн нөхцөл, журмыг Улсын Их Хурлын дарга батална."

5/ 13 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2, 3 дахь заалтыг:

"2/ эрх бүхий байгууллага Улсын Их Хурлын гишүүнд холбогдох эрүүгийн хэрэг үүсгэсэн бөгөөд түүний бүрэн эрхийг нь түдгэлзүүлж өгөхийг Улсын Их Хурлаас хүссэн."

3 дугаар зүйл. Монгол Улсын Их Хурлын гишүүний эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар

зүйлийн 1 дэх хэсгийн эхний өгүүлбэрийн "Улсын Их Хурлын гишүүн" гэсний дараа " Монгол Улсын Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүнээр томилогдох.", 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 11 дэх заалтын "асуулга" гэсний дараа ", асуулт" , 10 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн эхний өгүүлбэрт "албаны хэвлэмэл хуудас" гэсний дараа ""Монгол Улсын Их Хурлын гишүүн" гэсэн тэмдэг," гэж тус тус нэмсүгэй.

4 дүгээр зүйл. Улсын Их Хурлын гишүүний эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалт, 8 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 6 дахь заалтад "чуулган" гэснийг "нэгдсэн хуралдаан", 13 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт "чуулганы хуралдаанаар" гэснийг "нэгдсэн хуралдаанаар" гэж тус тус өөрчилсүгэй.

5 дугаар зүйл. Монгол Улсын Их Хурлын гишүүний эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 10 дахь заалтын "тухайн албан тушаалтан, ажилтанд асуулга, асуулт тавих", 8 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн "Төрийн байгууллагын байнгын хороонд" гэсний дараахь "тухай бүр" гэснийг тус тус хассугай.

6 дугаар зүйл. Улсын Их Хурлын гишүүний эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн "6, 7, 8, 9, 10, 11, 12, 13" гэсэн заалтын дугаарыг "7, 8, 9, 10, 11, 12, 13, 14" болгон өөрчилсүгэй.

7 дугаар зүйл. Энэ хуулийг 2001 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН

ИХ ХУРЛЫН ДАРГА Л.ЭНЭБИШ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2001 оны 6 дугаар сарын 21-ний өдөр **Улаанбаатар хот**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 12, 14 дүгээр зүйлд дараахь хэсэг, өгүүлбэр тус тус нэмсүгэй:

1/ 12 дугаар зүйлийн 3 дахь хэсэг:

"3. Монгол Улсын Ерөнхий сайдыг томилох тухай саналыг Улсын Их Хуралд өргөн мэдүүлснээс хойш 45 хоногийн дотор Улсын Их Хурал хэлэлцэн шийдвэрлэж чадаагүй бол Монгол Улсын Ерөнхийлөгч Улсын Их Хурлыг тараах тухай шийдвэр гаргана. Ерөнхийлөгч Улсын Их Хурлыг тараах бол зарлиг гаргана."

2/ 14 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт:

"Монгол Улсаас гадаад улсад суух бүрэн эрхт төлөөлөгчийн газрын тэргүүнээр томилуулахаар саналаа болгосон нэр дэвшигч хуралдаанд оролцсон нийт гишүүний олонхийн дэмжлэг авч чадаагүй тохиолдолд Ерөнхийлөгч дахин өөр санал оруулна. Өмнө нь олонхийн дэмжлэг авч чадаагүй нэр дэвшигчийг тухайн албан тушаалд томилох бүюу дахин нэр дэвшүүлэхийг хориглоно."

2 дугаар зүйл. Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/ 12 дугаар зүйлийн 2 дахь хэсэг:

"2. Улсын Их Хурлын анхдугаар чуулганаар Улсын Их Хурлын дарга сонгогдсон, Засгийн газар огцорсон, Улсын Их Хурал Ерөнхий сайдыг огцруулах бүюу хүчэлтээр нь чөлөөлөх тухай шийдвэр гаргасан, Ерөнхий сайд нас нөгчсөн тохиолдолд Улсын Их Хуралд олонхи суудал авсан нам бүюу намуудын сонгуулийн эвсэл /цаашид "эвсэл" гэх/-ээс нэр дэвшүүлсэн хүнийг; аль ч нам, эвсэл олонхийн суудал аваагүй бол Улсын Их Хуралд хамгийн олон суудал авсан нам, эвсэл бусад нам эвсэлтэй эвлэлцэн нэр дэвшүүлсэн хүнийг; хэрэв хамгийн олон суудал авсан нам , эвсэл бусад нам, эвсэлтэй эвлэлцэж нэр дэвшүүлж чадаагүй бол Улсын Их Хуралд суудал авсан нам, эвсэл эвлэлцэн олонхироо нэр дэвшүүлсэн хүнийг Ерөнхий сайдаар томилох саналыг Ерөнхийлөгч хүлээж авснаас хойш 5 хоногийн дотор Улсын Их Хуралд оруулна."

3 дугаар зүйл. Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн "3, 4, 5, 6, 7, 8, 9, 10, 11, 12, 13, 14, 15, 16, 17" гэсэн хэсгийн дугаарыг "4, 5, 6, 7, 8, 9, 10, 11, 12, 13, 14, 15, 16, 17, 18" гэж өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл. Энэ хуулийг 2001 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН

ИХ ХУРЛЫН ДАРГА Л.ЭНЭБИШ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2001 оны 6 дугаар сарын 21-ний өдөр **Улаанбаатар хот**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 20 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 23 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалт, 26 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт дараахь агуулга бүхий өгүүлбэр тус тус нэмсүгэй:

1/ **6 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт:**

"Засгийн газар огцорсон тохиолдолд шинэ Ерөнхий сайдыг томилох хүртэл тухайн Засгийн газар бүрэн эрхээ хэрэгжүүлнэ."

2/ **20 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт:**

"Улсын Их Хурлын гишүүн Засгийн газрын гишүүнээр томилогдвол гишүүнийхээ бүрэн эрхийг хэвээр хадгална."

3/ **23 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалтад:**

"Засгийн газрын гишүүнд нэр дэвшиг нь Улсын Их Хурлын гишүүдийн олонхийн санал авч чадаагүй бол 14 хоногийн дотор тухайн Улсын Их Хурлын бүрэн эрхийн хугацаанд Засгийн газрын гишүүнд нэр нь дэвшиж байгаагүй хүний нэрийг дэвшүүлнэ. "

4/ **26 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт:**

"Улсын Их Хурал Засгийн газарт итгэл хүлээлгэхгүй байгаа тухай шийдвэр гаргавал Засгийн газар огцорно."

2 дугаар зүйл. Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 4 дүгээр зүйлийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

"**4 дүгээр зүйл.Засгийн газрыг эмхлэн байгуулах үндэслэл, журам**

1.Засгийн газрыг Үндсэн хуулийн хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 6, гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2, гучин есдүгээр зүйл, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 9 дүгээр зүйл, Монгол Улсын Их Хурлын хуралдааны дэгийн зургадугаар бүлэгт заасан үндэслэл, журмын дагуу эмхлэн байгуулна.

2. Засгийн газар огцрох, шинээр байгуулагдах, Засгийн газрын гишүүний огцрох, чөлөөлөгдөх, нөхөн томилогдох болон Засгийн газарт итгэл хүлээлгэх тухай асуудлыг Үндсэн хуулийн хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 6, гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 9 дүгээр зүйл, Монгол Улсын Их Хурлын хуралдааны дэгийн зургадугаар бүлэгт заасан үндэслэл, журмын дагуу Улсын Их Хурал шийдвэрлэнэ."

3 дугаар зүйл. Энэ хуулийг 2001 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА **Л.ЭНЭБИШ**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2001 оны 6 дугаар сарын 21-ний өдөр **Улаанбаатар хот**

ЦАЦРАГИЙН ХАМГААЛАЛТ, АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1. Энэ хуулийн зорилт нь цацрагийн хамгаалалт, аюулгүй байдлыг хангах, түүнчлэн цацрагийн үүсгүүр, цацраг идэвхт ашигт малтмалын ашиглалтад тавих үндсэн шаардлагатай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Цацрагийн хамгаалалт, аюулгүй байдлын тухай хууль тогтоомж

2.1. Цацрагийн хамгаалалт, аюулгүй байдлын тухай хууль тогтоомж нь энэ хууль, түүнтэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2. Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл. Хуулийн нэр томъёо

3.1. Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1. "ионжуулагч цацраг" гэж шууд болон шууд бус замаар бодис, биологийн биет дотор хос ион үүсгэх цацрагийг;

3.1.2. "цөмийн материал" гэж цөмийн зэвсэгт хэрэглэгддэг уран, плутонийн изотоп бүхий зүйлсийг;

3.1.3. "цацрагийн үүсгүүр" гэж цацрагийн шарлага үүсгэгч цацраг идэвхт бодис болон ионжуулагч цацраг гаргаж аливаа техник хэрэгслийг;

3.1.4. "цацрагийн хамгаалалт, аюулгүй байдал" гэж хүн ам, байгаль орчныг цацраг идэвхт бодис болон ионжуулагч цацрагийн бусад үүсгүүрийн нөлөөллөөс хамгаалах, цацрагийн үүсгүүрийн аюулгүй байдлыг хангасныг;

3.1.5. "шарлага" гэж цацраг идэвхт бодис, ионжуулагч цацрагийн үүсгүүрээс хүнд үзүүлэх нөлөөллийг;

3.1.6. "мэргэжлийн шарлага" гэж ажлын нөхцөлийн улмаас цацраттай ажиллагчийн өртөж байгаа аливаа нөлөөллийг;

3.1.7. "тун" гэж ионжуулагч цацрагаас бие махбодид шингээгдсэн энергийн хэмжээгээр тодорхойлогддог цацрагийн шарлагыг илэрхийлэх хэмжигдэхүүнийг;

3.1.8. "цацраг идэвхт хаягдал" гэж цацраг идэвхт изотопын агуулгын хэмжээ нь стандартад заасан хэмжээнээс хэтэрсэн, ямар ч төлөв байдалд байж болох, цаашид дахин хэрэглэгдэхгүй зүйлсийг;

3.1.9. "цацраг идэвхт ашигт малтмал" гэж уран болон торийн бүлийн цацраг идэвхт изотоп агуулсан эрдэс бодисын хуримтлалыг.

4 дүгээр зүйл. Цацрагийн хамгаалалт, аюулгүй байдлыг хангах зарчим

4.1. Цацрагийн хамгаалалт, аюулгүй байдлыг хангах зорилгоор цацрагтай холбогдсон үйл ажиллагаа эрхэлж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллага дараахь үндсэн зарчмыг баримтална:

4.1.1. үндэслэлгүйгээр аливаа шарлага үүсгэхгүй байх;

4.1.2. шарлагын түнг зохистой хэмжээний доод түвшинд байлгах;

4.1.3. хүн ам үүний дотор цацрагтай ажиллагчийг шарлагын түнгийн тогтоосон хязгаараас илүүгээр өртүүлэхгүй байх.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Цөмийн энергийн комисс

5 дугаар зүйл. Цөмийн энергийн комисс

5.1. Шинжлэх ухааны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний эрхлэх асуудлын хүрээнд цөмийн судалгаа, технологийг хөгжүүлэх, цацрагийн үүсгүүрийг ашиглах, цацрагийн хамгаалалт, аюулгүй байдлыг хангах бодлого боловсруулах, хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлэх байгууллага нь Цөмийн энергийн комисс (цаашид "Комисс" гэх) мөн.

5.2. Шинжлэх ухааны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн Комиссын дарга байна.

5.3. Комиссын бүтэц, орон тоог Засгийн газар тогтооно.

5.4. Комиссын дүрмийг Засгийн газар батална.

5.5. Комисс нь тогтоосон журмаар үйлдсэн тамга, тэмдэг, хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

5.6. Комисс нь ашиглагдахгүй болсон цацрагийн үүсгүүр болон цацраг идэвхт хаягдлыг улсын хэмжээнд төвлөрүүлэн хадгалах, тээвэрлэх, булшлах тусгай байгуламжтай байна.

5.7. Тусгай байгууламж нь улсын онцгой объект байна.

5.8. Комисс нь улсын төсвөөс санхүүжинэ.

6 дугаар зүйл. Комиссын бүрэн эрх

6.1. Комисс дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

6.1.1. цөмийн энерги ашиглах, цөмийн технологи нэвтрүүлэх, цацрагийн хамгаалалт, аюулгүй байдлыг хангах бодлого боловсруулж эрх бүхий байгууллагаар батлуулан хэрэгжүүлэх;

6.1.2. Монгол Улсын нэгдэн орсон цөмийн судалгаа, цацрагийн хамгаалалт, аюулгүй байдалтай холбогдсон олон улсын гэрээ, хэлэлцээрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, түүний явцад гадаад хэргийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран хяналт тавих, гадаад орон болон олон улсын холбогдох байгууллагатай хамтын ажиллагаог хөгжүүлэх;

6.1.3. ашиглагдахгүй болсон цацрагийн үүсгүүр, цацраг идэвхт хаягдлыг улсын

хэмжээнд төвлөрүүлэн хадгалах, тээвэрлэх, булшлах үйл ажиллагаат хэрэгжүүлэх;

6.1.4. цацраг идэвхт ашигт малтмалыг ашиглах үйл ажиллагаат холбогдох байгууллагатай хамтран зохицуулах;

6.1.5. цөмийн технологи нэвтрүүлэх, цацрагийн хамгаалалт, аюулгүй байдлын тухай хууль тогтоомж, цацрагийн аюулгүйн стандарт, холбогдох заавар, журам болон олон улсын гэрээ, хэлэлцээрийн хэрэгжилтэд хяналт тавьж, биелэлтийг хангуулах;

6.1.6. энэ хуулийн 8 дугаар зүйлд заасан тусгай зөвшөөрлийг хуульд заасны дагуу олгох;

6.1.7. цацрагийн үүсгүүрийн улсын бүртгэл хөтлөх, цацрагтай ажиллагсдын өртөж байгаа мэргэжлийн шарлагын түнд хяналт тавих, шарлагын түнгийн мэдээллийн сан бүрдүүлэх;

6.1.8. үйлдвэрлэл, судалгаа, оношлогоо, эмчилгээнд хэрэглэж байгаа цацрагийн үүсгүүр бүхий тоног төхөөрөмжийн хамгаалалт, аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг хяналт тавих;

6.1.9. улсын хилээр нэвтрүүлэх цацрагийн үүсгүүр бүхий багаж, тоног төхөөрөмж, тээврийн хэрэгсэлд хяналт тавьж, хамгаалалт, аюулгүй байдлыг хангах;

6.1.10. цацрагийн ослоос урьдчилан сэргийлэх, гарсан ослын шалтгааныг тогтоох, хор уршгийг арилгах, цацрагийн ослын үед ажиллах журам, авах арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулах, мэргэжлийн холбогдох байгууллагатай хамтран хэрэгжүүлэх;

6.1.11. хүрээлэн байгаа орчны болон ахуйн өргөн хэрэглээний бараа, материал, хүнсний бүтээгдэхүүн, ундны усны цацрагийн түвшний хяналт-шинжилгээ хийх, тэдгээр нь хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлж байгаа эсэхийг тогтоох ажлыг холбогдох мэргэжлийн хяналтын байгууллагатай хамтарч гүйцэтгэх, цацрагийн аюулгүй байдлын баталгаажилтыг хангах арга хэмжээ авах;

6.1.12. үйл ажиллагааныхаа хүрээнд судалгаа явуулах, захиалгат төсөл гүйцэтгэх, лаборатори, орон тооны бус зөвлөл, ажлын хэсэг байгуулах, шинжээч томилох, холбогдох лаборатори, мэргэжлийн байгууллага, мэргэжилтний туслалцаа авах;

6.1.13. хуульд заасан үүргээ биелүүлэхэд шаардлагатай мэдээлэл, баримт бичгийг цацрагтай холбогдсон үйл ажиллагаа эрхэлж байгаа иргэн, албан тушаалтан, байгууллага, аж ахуйн нэгжээс үнэ төлбөргүй гаргуулан авах;

6.1.14. цацрагтай холбогдсон үйл ажиллагааг тавих шаардлага хангаагүй хуулийн этгээдийн тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох;

6.1.15. холбогдох байгууллагатай нь тохиролцсоны үндсэн дээр зохих мэргэжлийн хүмүүсийг хяналт шалгалтын ажилд татан оролцуулах;

6.1.16. хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

7 дугаар зүйл. Цацрагийн хяналтын байцаагч, түүний эрх, үүрэг

7.1. Комисс нь цацрагийн хяналтын улсын ерөнхий байцаагч, ахлах байцаагч, улсын байцаагчтай байна.

7.2. Цацрагийн хяналтын байцаагч нь цацрагийн хяналтын чиглэлээр мэргэшсэн, зохих шалгалт өгч тэнцсэн байна.

7.3. Цацрагийн хяналтын байцаагч дараахь эрх эдэлж, үүрэг хүлээнэ:

7.3.1. энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан цацрагийн хамгаалалт, аюулгүй байдлыг хангахтай холбоотой хяналт шалгалтыг хэрэгжүүлэх;

7.3.2. цацрагийн хяналт шалгалт хийх объектод саадгүй нэвтрэх;

7.3.3. Төрийн хяналт шалгалтын тухай[1] хууль, Захиргааны хариуцлагын тухай[2] хууль болон бусад хууль тогтоомжид заасан улсын байцаагчийн нийтлэг бүрэн эрхийг хэрэгжүүлэх.

8 дугаар зүйл. Цацрагтай холбогдсон үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл

8.1. Энэ хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид заасан шаардлага, цацрагийн аюулгүйн стандартыг хангасан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад цацрагтай холбогдсон дараахь үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоно:

8.1.1. цацрагийн үүсгүүрийг захиалах, импортлох, экспортлох, хүлээн авах, хуваарилах, угсрах, байрлуулах, ашиглалтад оруулах, зээмшилдээ буюу ашиглалтад байлгах, хэрэглэх, засвар үйлчилгээний болон шилжүүлэх шатанд байлгах, худалдах, түрээслэх, үйлдвэрлэх, боловсруулах, дахин боловсруулах, олборлох, олж авах, түүнийг ашиглах техникийн төсөл зохиох, ашиглалтаас гаргах, задлах, тээвэрлэх, хадгалах, идэвх сулруулах, булшлах;

8.1.2. цацраг идэвхт ашигт малтмалын хайгуул хийх, түүнийг ашиглах, олборлох, боловсруулах, баяжуулах, импортлох, экспортлох, тээвэрлэх, хаягдлыг булшлах, ашиглалтын дараа газар сэргээх үйл ажиллагаа явуулах.

8.2. Тусгай зөвшөөрөл нь хүчингүй болсон

[1] *Төрийн хяналт шалгалтын тухай хууль. "Төрийн мэдээлэл"-ийн 1995 оны №4 дугаарт нийтлэгдсэн.*

[2] *Захиргааны хариуцлагын тухай хууль. "Төрийн мэдээлэл"-ийн 1992 оны №4-5 дугаарт нийтлэгдсэн.*

тохиолдолд иргэн, аж ахуйн нэгж, байгууллага ашиглаж байсан цацрагийн үүсгүүрийнхээ аюулгүй байдлыг хангаж, шаардлагатай бол түүнийг энэ хуулийн 5.6-д заасан тусгай байгууламжид хадгалуулна.

9 дүгээр зүйл. Тусгай зөвшөөрөл авахад бүрдүүлэх баримт бичиг

9.1. Тусгай зөвшөөрөл хүсэгч нь Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай[1] хуулийн 17 дугаар зүйлд зааснаас гадна дараахь нэмэлт баримт бичгийг бүрдүүлж Комисст ирүүлнэ:

9.1.1. цацрагийн үүсгүүр ашиглаж явуулах үйл ажиллагааны зорилго, төрөл, үндсэн чиглэл, техник, эдийн засгийн үндэслэл, мэргэжлийн боловсон хүчний тухай танилцуулга;

9.1.2. ашиглах үүсгүүр, багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийн үйлдвэрийн гэрчилгээ, үндсэн үзүүлэлтүүд;

9.1.3. үйл ажиллагаа явуулах байрны цацрагийн хамгаалалт, цацрагийн аюулгүйн стандартын шаардлага хангасан тухай Комиссын үнэлгээ;

9.1.4. үйл ажиллагаа явуулах байрны хөдөлмөрийн нөхцөл, аюулгүй ажиллагаа болон эрүүл ахуйн шаардлага хангасан тухай хөдөлмөр хамгаалал, эрүүл мэндийн холбогдох хяналтын албаны дүгнэлт;

9.1.5. цацрагийн үүсгүүр ашиглаж явуулах үйл ажиллагааны төсөлд холбогдох хууль тогтоомжийн дагуу байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийгэж гаргуулсан дүгнэлт;

9.1.6. цацрагийн болзошгүй ослын үед авах арга хэмжээний төлөвлөгөө;

9.1.7. цацрагийн аюулгүй байдлыг хариуцсан ажилтныг томилсон тухай шийдвэр;

9.1.8. Комиссоор баталгаажсан цацрагийн аюулгүй ажиллагааны дотоод дүрэм.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Цацрагийн хамгаалалт, аюулгүй байдлыг хангах талаархи нутгийн захиргааны байгууллага болон иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын бүрэн эрх

10 дугаар зүйл. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын бүрэн эрх

10.1. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

10.1.1. нутаг дэвсгэртээ цацрагийн хамгаалалт, аюулгүй байдлын тухай хууль тогтоомж, цацрагийн аюулгүйн стандарт, холбогдох дүрэм, журам, Комиссын шийдвэрийн биелэлтийг зохион байгуулах;

10.1.2. цацрагийн хамгаалалт, аюулгүй байдлыг хангах, цацрагийн ослоос урьдчилан сэргийлэх талаар нутаг дэвсгэртээ сургалт, сурталчилгаа явуулах.

11 дүгээр зүйл. Цацрагийн хамгаалалт, аюулгүй байдлыг хангах талаархи иргэдийн эрх, үүрэг

11.1. Цацрагийн хамгаалалт, аюулгүй байдлыг хангах талаар иргэд дараахь эрх эдэлж, үүрэг хүлээнэ:

11.1.1. цацрагийн хамгаалалт, аюулгүй байдлын тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдэд хариуцлага хүлээлгэхийг холбогдох байгууллагаас шаардах;

11.1.2. цацрагийн хамгаалалт, аюулгүй байдал, цацрагийн түвшний хяналт-шинжилгээтэй холбогдсон үнэн зөв мэдээллэл авах;

11.1.3. цацрагийн хамгаалалт, аюулгүй байдлын тухай хууль тогтоомжийг сахин биелүүлэх;

11.1.4. цацрагийн осол гарсан, эсхүл цацрагийн үүсгүүр алдагдсан тохиолдолд Комисс, иргэний хамгаалалт, тагнуул болон цагдаагийн байгууллагад нэн даруй мэдэгдэх;

11.1.5. цацрагийн хамгаалалт, аюулгүй байдлын талаархи зөрчил, дутагдлыг холбогдох байгууллагад шуурхай мэдээлэх.

12 дугаар зүйл. Цацрагийн хамгаалалт, аюулгүй байдлыг хангах талаархи аж ахуйн нэгж, байгууллагын эрх, үүрэг

12.1. Цацрагтай холбогдсон үйл ажиллагаа эрхэлж байгаа аж ахуйн нэгж, байгууллага дараахь эрх эдэлж, үүрэг хүлээнэ:

12.1.1. цацрагийн хамгаалалт, аюулгүй байдлын тухай хууль тогтоомж, цацрагийн аюулгүйн стандарт, холбогдох дүрэм, журмыг мөрдөж ажилах;

12.1.2. цацрагийн хамгаалалт, аюулгүй байдлыг хангаж ажилах, цацрагийн ослоос урьдчилан сэргийлэх, цацрагтай ажиллагчийг мэргэжлийн шарлагын хувийн тунгийн хэмжээнд хамруулах;

12.1.3. Комисс, цацрагийн хяналтын байцаагчаас тавьсан шаардлагыг хүлцэлгүй нь биелүүлж хариу мэдэгдэх, илэрсэн зөрчлийг бүрэн арилгах арга хэмжээ авах;

12.1.4. мэргэжилтнийхээ мэдлэгийг дээшлүүлэх, цацрагийн ослын аюулыг арилгах арга ажиллагаанд сургах арга хэмжээ болоосруулж

[1] *Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль. "Төрийн мэдээлэл"-ийн 2001 оны № 6 дугаарт нийтлэгдсэн*

хэрэгжүүлэх;

12.1.5. цацрагийн хамгаалалт, аюулгүй байдлыг хангах асуудлаар мэргэжлийн байгууллагаас арга зүйн туслалцаа, зөвлөгөө авах;

12.1.6. цацрагийн түвшний тухай мэдээллийг холбогдох байгууллагад гаргаж өгөх.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Цацрагийн үүсгүүрээс хамгаалах, түүнийг ашиглахад тавих шаардлага

13 дугаар зүйл. Цацрагийн үүсгүүрээс хамгаалах

13.1. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага цацраггай холбогдсон үйл ажиллагаа эрхлэхдээ энэ хууль, цацрагийн аюулгүйн стандарт, холбогдох дүрэм, журмыг мөрдөж ажиллана.

13.2. Цацрагийн үүсгүүрийг ашиглах явцад хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллөөс хамгаалах, цацрагийн ослоос урьдчилан сэргийлэх, гарсан осолын хор уршгийг арилгах арга хэмжээг үйл ажиллагаа эрхэлж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллага өөрийн зардлаар хэрэгжүүлнэ.

14 дүгээр зүйл. Цацрагийн үүсгүүрийг экспортлох, импортлоход тавих үндсэн шаардлага

14.1. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага цацрагийн үүсгүүрийг экспортлох, импортлоход дараахь шаардлагыг биелүүлнэ:

14.1.1. цацрагийн үүсгүүрийг ашиглах, шинээр гарган авах үүсгүүрийн шинж чанар, цацрагийн төрөл, цацраг идэвхийн хэмжээ, нөлөөллийн талаар Комиссын дүгнэлт гаргуулж, тусгай зөвшөөрөл авах;

14.1.2. цацрагийн үүсгүүрийг захиалах, экспортлох, импортлоход Комиссын дүгнэлт гаргуулж, тусгай зөвшөөрөл авах.

15 дугаар зүйл. Цацрагийн үүсгүүрийг хадгалахад тавих үндсэн шаардлага

15.1. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага цацрагийн үүсгүүрийг хадгалахад дараахь шаардлагыг биелүүлэн:

15.1.1. тухайн цацрагийн үүсгүүрийн онцлог шинж чанарыг харгалзан Комиссоос зөвшөөрсөн зориулалтын тусгай байранд цацрагийн хамгаалалт, аюулгүйн дүрмийн дагуу хадгалах;

15.1.2. технологийн болон аюулгүй ажиллагааны шаардлага хангахгүй болсон, эсхүл ашиглагдахгүй байгаа цацрагийн үүсгүүрийг энэ хуулийн 5.6-д заасан тусгай байгууламжид хадгалуулах.

16 дугаар зүйл. Цацрагийн үүсгүүрийг тээвэрлэхэд тавих үндсэн шаардлага

16.1. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага цацрагийн үүсгүүрийг тээвэрлэхэд дараахь шаардлагыг биелүүлнэ:

16.1.1. цацрагийн үүсгүүр, цацрагийн үүсгүүртэй багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж тээвэрлэхэд Комиссоос батлагдсан цацрагийн үүсгүүр, цацраг идэвхт хаягдлыг аюулгүй тээвэрлэх дүрмийг мөрдөх;

16.1.2. хууль өөрөөр заагаагүй бол улс хоорондын тээврийг олон улсын холбогдох гэрээ, хэлэлцээрийн дагуу гүйцэтгэх.

16.2. Цацрагийн үүсгүүрийг хүн, амьтан болон бараа, бүтээгдэхүүнтэй хамт тээвэрлэхийг хориглоно.

17 дугаар зүйл. Цацрагийн үүсгүүрийг худалдах

17.1. Цацрагийн үүсгүүрийг экспортлох, импортлох, ашиглах тусгай зөвшөөрөл бүхий иргэн, аж ахуйн нэгж, байгууллага Комиссоос зөвшөөрсний дагуу цацрагийн үүсгүүрийг худалдах эрхтэй.

18 дугаар зүйл. Цацрагийн үүсгүүрийн ашиглалтад тавих үндсэн шаардлага

18.1. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага цацрагийн үүсгүүрийг ашиглахад дараахь шаардлагыг биелүүлнэ:

18.1.1. цацрагийн үүсгүүрийн ашиглалтын бүртгэл хөтөлж, тайлан, мэдээг жил бүрийн 12 дугаар сарын 20-ны дотор Комисст гаргаж өгөх;

18.1.2. цацрагийн үүсгүүрийг хүлээн авснаас хойш ажлын 3 хоногийн дотор Комисс, тагнуулын байгууллагад мэдэгдэж бүртгүүлэх;

18.1.3. цацрагтай холбогдсон үйл ажиллагааг цацрагийн аюулгүйн стандартыг бүрэн хангасан, Комиссоос зөвшөөрсөн зориулалтын байранд явуулах;

18.1.4. цацрагийн үүсгүүр ашиглах явцад ажлын байрны хөдөлмөрийн нөхцөл, аюулгүй ажиллагааны дүрмийн шаардлагыг хангаж ажиллах;

18.1.5. үйл ажиллагаа эрхэлж байгаа этгээд цацрагийн аюулгүй ажиллагааны дотоод дүрмийг боловсруулж Комиссоор батлуулж, мөрдөх;

18.1.6. гарсан осол, зөрчлийг Комисс болон иргэний хамгаалалт, тагнуул, цагдаагийн байгууллагад нэн даруй мэдээлэх, ослын хор уршгийг арилгах, аюулгүй болгох арга

хэмжээг холбогдох дүрэм, журмын дагуу авч хэрэгжүүлэх;

18.1.7. цацрагтай ажиллагч нь түүний хөтөлбөрийн дагуу явардах цацрагийн хамгаалалт, аюулгүй байдлын сургалт, давтан сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан байх.

18.2. Цацрагийн үүсгүүрийг Комиссын зөвшөөрөлгүйгээр шудангаар илгээх, бусдаар дамжуулах, нийтийн тээврийн хэрэгслээр биедээ авч явахыг хориглоно.

18.3. Цацрагийн үүсгүүрийн нэр төрөл, шинж чанар, идэвхийн хэмжээ, хэрэглэх зориулалт, аргачлал нь тодорхой бүс бол түүнийг хэрэглэхийг хориглоно.

19 дүгээр зүйл. Цацрагийн үүсгүүрийг улсын хилээр нэвтрүүлэх

19.1. Цацрагийн үүсгүүр болон цацрагийн үүсгүүр бүхий багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийг Комиссын зөвшөөрөлтэйгээр улсын хилээр нэвтрүүлнэ.

20 дугаар зүйл. Цацраг идэвхт хаягдал, түүнийг бүлэлэх

20.1. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага цацраг идэвхт хаягдлыг бүлэлэхэд дараахь шаардлагыг биелүүлнэ:

20.1.1. цацраг идэвхт хаягдлыг бүлэлэхэд цацрагийн хэмжээ нь улсын байцаагчаар дүгнэлт гаргуулж, Комисс болон холбогдох мэргэжлийн хяналтын байгууллагаас зөвшөөрөл авах;

20.1.2. цацраг идэвхт хаягдлыг бүлэлэх ажлыг Комисс болон холбогдох мэргэжлийн хяналтын байцаагч нарын хяналтын дор гүйцэтгэх.

20.2. Цацраг идэвхт хаягдлыг тээвэрлэхдээ Комиссын батлагдсан дүрмийг мөрдөнө.

21 дүгээр зүйл. Цөмийн материал

21.1. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага цөмийн материалыг боловсруулах, үйлдвэрлэх, бусад аргаар олж авах, эзэмших, хадгалахыг хориглоно.

21.2. Цөмийн материалыг Монгол Улсын хилээр нэвтрүүлэх, нүүлгэн дэвсгэрээр дамжуулан тээвэрлэхийг хориглоно.

22 дугаар зүйл. Мэргэжлийн шаардлагад тавих үндсэн шаардлага

22.1. Цацрагтай ажиллагч нь мэргэжлийн шаардлагын хувийн тунгийн хяналтад хамрагдана.

22.2. Мэргэжлийн шаардлагын хувийн тунгийн хяналтын нэгдсэн бүртгэлийг архивт 50 жил хадгална.

22.3. Цацрагтай ажиллагчийг цацрагийн аюулгүйн стандартад заасан шаардлагын тунгийн хязгаараас илүүгээр өртүүлэхийг хориглоно.

22.4. Цацрагтай ажиллагч нь цацрагийн хамгаалалт, аюулгүй байдлын шаардлага, хөдөлмөрийн хэвийн нөхцөлийг хангах асуудлаар байгууллагын захиргаанд шаардлага тавих, ажиллахаас татгалзах, Комисст гомдлоо гаргах эрхтэй.

22.5. Цацрагтай ажиллагч нь мэргэжлээс шалтгаалах өвчний эмнэлгийн тогтмол хяналтад байж, эмнэлгийн үйлчилгээнд хамрагдана.

22.6. Шаардлагатай бол цацрагтай ажилладаг жирэмсэн эмэгтэй Хөдөлмөрийн тухай[1] хуулийн 107 дугаар зүйлд заасны дагуу ажлын нөхцөлөө өөрчлөх эрхтэй бөгөөд энэ нь түүнийг ажлаас халах үндэслэл болохгүй.

22.7. Насанд хүрээгүй хүнийг цацрагтай холбогдсон ажилд авч ажиллуулахыг хориглоно.

23 дугаар зүйл. Эмнэлгийн шарлагад тавих үндсэн шаардлага

23.1. Эмнэлгийн шарлага хийхэд дараахь үндсэн шаардлага тавина:

23.1.1. цацрагийн үүсгүүрээр оношлогоо, эмчилгээ хийхдээ энэ хууль, цацрагийн аюулгүйн стандарт болон бусад холбогдох дүрэм, журмыг мөрдөж ажиллах;

23.1.2. цацрагийн үүсгүүрээр оношлогоо, эмчилгээ хийхэд ашиглаж байгаа багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийн тохируулга, чанарын баталгаа, хяналтыг тогтмол хийж байх;

23.1.3. хүүхдэд цацрагийн үүсгүүрээр оношлогоо, эмчилгээ хийхдээ түүний эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн зөвшөөрлийг авна;

23.1.4. рентген оношлогооны үед цацрагийн аюулгүйн стандартад заасан тунгийн хязгаараас илүү шарлагад өртүүлэхгүй байх.

24 дүгээр зүйл. Цацраг идэвхт ашигт малтмалын ашиглалтад тавих үндсэн шаардлага

24.1. Цацраг идэвхт ашигт малтмалын хайгуул хийх, түүнийг ашиглах, олборлох, боловсруулах, баяжуулах, импортлох, экспортлох, тээвэрлэх, хаягдлыг бүлэлэх, ашиглалтын дараа газар сэргээх үйл ажиллагаа эрхлэх иргэн, аж ахуйн нэгж, байгууллага Комиссоос тусгай зөвшөөрөл авна.

24.2. Энэ хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид заасан шаардлага хангасан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад цацраг идэвхт ашигт малтмал ашиглахтай холбоотой тусгай зөвшөөрөл олгоно.

24.3. Энэ хуулийн 24.1-д заасан үйл ажиллагаат эрхлэх явцад хүний эрүүл мэнд, байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэхээс хамгаалах арга

[1] *Хөдөлмөрийн тухай хууль. "Төрийн мэдээлэл"-ийн 1999 оны № 5 дугаарт нийтлэгдсэн.*

хэмжээг уг үйл ажиллагааг эрхэлж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллага өөрийн зардлаар хэрэгжүүлнэ.

24.4. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага энэ хуулийн 24.1-д заасан үйл ажиллагааг явуулахдаа энэ хуулийн, цацрагийн аюулгүйн стандарт болон холбогдох дүрэм, журмыг баримтална.

24.5. Цацраг идэвхт ашигт малтмалыг тээвэрлэхэд Комиссын батална цацраг идэвхт ашигт малтмалыг аюулгүй тээвэрлэх дүрмийг мөрдөнө.

25 дугаар зүйл. Цацрагийн ослоос сэргийлэх, хор уршгийг арилгах

25.1. Цацрагтай холбогдсон үйл ажиллагаа эрхэлж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллага цацрагийн болзошгүй ослоос урьдчилан сэргийлэх, гарсан ослын хор уршгийг арилгах, аюулгүй болгох шаардлагатай арга хэмжээг тусгай хөтөлбөрийн дагуу өөрийн зардлаар хэрэгжүүлнэ.

25.2. Цацрагийн ослын түвшин, шалтгааныг тогтоох, ослын хор уршгийг арилгах ажлыг Комисс зохион байгуулна.

25.3. Цацрагийн ослын түвшингээс шалтгаалан түүний хор уршгийг арилгах арга хэмжээг Улсын байнгын онцгой комиссын удирдлагын дор Комисс, иргэний хамгаалалтын байгууллага болон холбогдох мэргэжлийн байгууллага хамтран хэрэгжүүлнэ.

25.4. Нийтийг хамарсан цацрагийн ослын хор уршгийг арилгахад гарах зардлыг Засгийн газар хариуцна.

ТАВДУГААР БҮЛЭГ

Хяналт, хариуцлага

26 дугаар зүйл. Цацрагийн хамгаалалт, аюулгүй байдлын тухай хуулийн биелэлтэд тавих хяналт

26.1. Цацрагийн хамгаалалт, аюулгүй байдлын тухай хууль тогтоомжийн биелэлт, цацрагтай холбогдсон үйл ажиллагаанд Комисс, бүх шатны Засаг дарга эрх хэмжээнийхээ хүрээнд хяналт тавина.

26.2. Цацрагтай холбогдсон үйл ажиллагаандаа цацрагийн хамгаалалт, аюулгүй байдлын тухай хууль тогтоомж, цацрагийн аюулгүйн стандарт, дүрэм, журмын шаардлагыг хангах зорилгоор аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага дотоодын хяналт тавина.

26.3. Төрийн бус байгууллага хуулиар тогтоосон эрх хэмжээнийхээ хүрээнд энэ хууль, цацрагийн аюулгүйн стандарт, дүрэм, журмын биелэлтэд олон нийтийн хяналт тавьж, санал хүсэлтээ Комисст тавьж шийдвэрлүүлж болно.

27 дугаар зүйл. Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага

27.1. Цацрагийн хамгаалалт, аюулгүй байдлын тухай хууль тогтоомж зөрчиж бусдад болон байгаль орчинд учруулсан хохирлыг хууль тогтоомжид заасны дагуу гэм буруутай этгээдээр нөхөн төлүүлнэ.

27.2. Цацрагийн хамгаалалт, аюулгүй байдлын шаардлага, цацрагийн аюулгүйн стандарт хангагдаагүйгээс бусдад болон байгаль орчинд хохирол учирсан болохыг эрх бүхий байгууллага тогтоосон бол үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллага уг хохирлыг барагдуулах буюу нөхөн төлнө.

27.3. Цацрагийн хамгаалалт, аюулгүй байдлын тухай хууль тогтоомж зөрчсөн гэм буруутай этгээдэд зөрчлийн шинж байдал, хохирлын хэмжээг харгалзан эрүүгийн болон захиргааны хариуцлага хүлээлгэнэ.

27.4. Цацрагийн хамгаалалт, аюулгүй байдлын тухай хууль тогтоомж зөрчсөн гэм буруутай этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхүйгээр бол шүүгч, эсхүл цацрагийн хяналтын байцаагч дор дурдсан захиргааны шийтгэл ногдуулна:

27.4.1. цацрагийн үүсгүүрийг хүлээн авсан тухайгаа Комисст тогтоосон хугацаанд мэдээлж бүртгүүлээгүй, ашиглалтын мэдээ, тайланг гаргаж өгөөгүй буюу санаатайгаар худал ташаа мэдээлсэн, цацрагтай ажиллагчийг мэргэжлийн шарлагын хувийн тунгийн хяналтад хамруулаагүй иргэнийг 5000-25000, албан тушаалтныг 15000-40000, аж ахуйн нэгж, байгууллагыг 100000-200000 төгрөгөөр торгох;

27.4.2. үйл ажиллагаанаас учирсан хохирлыг арилгах арга хэмжээ аваагүй, тусгай зөвшөөрөлд заагдсан үүсгүүрийн нэр төрлийг өөрчилсөн, хэмжээг хэтрүүлж ашиглаасан, эсхүл ашиглахыг завдсан иргэнийг 15000-50000, аж ахуйн нэгж, байгууллагыг 150000-250000 төгрөгөөр торгох;

27.4.3. цацрагийн хяналтын улсын байцаагчийн хууль ёсны шаардлагыг биелүүлээгүй гэм буруутай иргэнийг 15000-50000, албан тушаалтныг 25000-60000, аж ахуйн нэгж, байгууллагыг 80000-150000 төгрөгөөр торгох;

27.4.4. цацрагийн үүсгүүрийг үйлдвэрлэх, экспортлох, импортлох, ашиглах, хадгалах, тээвэрлэх, булшлах болон түүнтэй ажиллагчид тавих шаардлагыг зөрчсөн, эсхүл Комиссын тусгай зөвшөөрөлгүйгээр буюу тусгай зөвшөөрөлд заасныг зөрчиж үйл ажиллагаа явуулсан бол хууль бусаар олсон орлогыг хураах, зөрчил гаргасан иргэнийг 30000-50000, аж ахуйн нэгж, байгууллагыг 150000-250000 хүртэл төгрөгөөр торгох.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА **Л.ЭНЭБИШ**

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2001 оны 6 дугаар сарын 21-ний өдөр **Дугаар 60** **Улаанбаатар хот**

Цацрагийн хамгаалалт, аюулгүй байдлын тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Их Хурлын хуралдааны дэгийн хуулийн 40 дүгээр зүйлийн 12 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Цацрагийн хамгаалалт, аюулгүй байдлын тухай хууль батлагдсантай холбогдуулан дор дурдсан арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Засгийн газар /Н.Энхбаяр/–т даалгасугай:

1/Энэ хууль, цөмийн болон цацрагийн аюулгүй байдлыг хангахтай холбогдсон олон улсын гэрээг хэрэгжүүлэхэд шаардагдах дүрэм, журмыг олон улсын жишигт нийцүүлэн боловсруулахад Олон улсын атомын энергийн агентлагтай хамтран ажиллах;

2/Цөмийн энергийн комиссын үйл ажиллагаанд боловсронгуй болгох болон цацрагийн хамгаалалт, аюулгүй байдлыг хангах талаар гарсан Засгийн газрын шийдвэрийг Цацрагийн хамгаалалт, аюулгүй байдлын тухай хуульд нийцүүлэх арга хэмжээ авах;

3/Цөмийн энергийн комиссыг ажлын байр, цацрагийн судалгаа, хяналтын ажилд ашиглах тэсвэрийн хэрэгсэл, улсын хил дээр цацрагийн хяналтыг хэрэгжүүлэхэд шаардагдах суурин болон хөдөлгөөнт тоног төхөөрөмжөөр хангах.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА **Л.ЭНЭБИШ**

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2001 оны 6 дугаар сарын 21-ний өдөр **Дугаар 61** **Улаанбаатар хот**

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэг батлах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 6 дугаар зүйлийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийг хавсралт ёсоор батлалсугай.

2. Энэ тогтоолыг Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн шинэчилсэн найруулга хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА **Л.ЭНЭБИШ**

Улсын Их Хурлын 2001 оны 61 дүгээр тогтоолын хавсралт

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ ДЭГ

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны зохион байгуулалт, үйл ажиллагаог Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Их Хурлын тухай хууль болон энэ дэгээр зохицуулна.

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Улсын Их Хурлын хуралдааны ажиллагаа нь хууль дээдлэх, асуудлыг чөлөөтэй хэлэлцэх, цөөнхийн санаа бодлыг хүндэтгэж олонхийн саналаар шийдвэрлэх зарчимд үндэслэнэ.

1.2. Улсын Их Хурлын гишүүн чуулганы хуралдаан эхлэхээс эмнэ суудлаа эзэлсэн байна.

1.3. Улсын Их Хурлын гишүүн чуулганы хуралдаанд оролцохдоо хуралдааны дэгийг сахих үүрэгтэй бөгөөд үг хэлэхдээ дараахь журмыг баримтална:

1.3.1. хуралдаан даргалагчаас зөвшөөрөл авах;

1.3.2. чуулганы хуралдаанд Улсын Их Хурлын гишүүний үг хэлэх хугацаа 5 минутаас илүүгүй байх;

1.3.3. үг хэлэх хугацааг бусдад шилжүүлэхгүй байх;

1.3.4. Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаан даргалагч онцгой тохиолдолд гишүүдийн

үг хэлэх хугацааг нэгтгэн, нэг нам, эвслийн бүлгийг төлөөлөн нэг гишүүнд 30 хүртэл минут ярих эрх олгож болно. Энэ тохиолдолд нам, эвслийн бүлэг үг хэлэх саналаа хуралдаан даргалагчид урьдчилан өгнө.

1.4. Улсын Их Хурлын чуулганы хуралдааны оролцож байгаа хүмүүс хуралдаан даргалагчийн зөвшөөрснөөр үг хэлж болно.

1.5. Улсын Их Хурал хаалттай хуралдаанаар асуудлыг хэлэлцэхэд дараахь журмыг баримтална:

1.5.1. улсын нууцын жагсаалтад хамаарах асуудлыг хаалттай хуралдаанаар хэлэлцэнэ. Уг жагсаалтад ороогүй асуудлыг хуралдааны оролцон нийт гишүүний олонхийн саналаар хаалттай хуралдаанаар хэлэлцэж болно;

1.5.2. хаалттай хуралдааны Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга /цаашид "Ерөнхий нарийн бичгийн дарга" гэх/, нарийн бичгийн дарга, Тамгын газрын нууцын асуудал хариуцсан ажилтан, тухайн асуудлыг боловсруулахад оролцсон ажлын хэсгийн гишүүдээс бусад хүн байлцах асуудлыг Улсын Их Хурлын даргын баталсан журмын дагуу Ерөнхий нарийн бичгийн дарга зохицуулна. Хаалттай хуралдааны оролцох хүмүүсийн нэрсийг урьдчилан гаргасан байх бөгөөд шаардлагатай бол тэдгээр хэлэлцэх асуудлын нууц задруулахгүй байх баталгаа гаргуулна;

1.5.3. хаалттай хуралдаанд албан ёсоор зөвшөөрснөөс бусад тохиолдолд бичлэг хийх, дуу хураагч, гар утас авч орох, утсаар ярихыг хориглоно;

1.5.4. Ерөнхийлөгч, Ерөнхий сайдаас бусад Улсын Их Хурлын чуулганд зөвлөх эрхтэй оролцож болох албан тушаалтныг хуралдааны оролцон нийт гишүүний олонхийн саналаар хаалттай хуралдаанд байлцуулна;

1.5.5. хаалттай хуралдааны талаар зөвхөн нууцын дэвтэрт тэмдэглэл хийнэ.

1.6. Улсын Их Хурлын өглөөний нэгдсэн хуралдаан 9.00 цагаас 13.00 цаг хүртэл, оройн нэгдсэн хуралдаан 15.00 цагаас 18.00 цаг хүртэл хуралдана.

1.7. Улсын Их Хурлын өглөөний нэгдсэн хуралдааныг 2 цаг тутам 20 минутын, оройн нэгдсэн хуралдааныг 1 цаг 30 минут тутам 10 минутын завсарлагатай хийнэ.

1.8. Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанаар долоо хоног бүрийн Баасан гаригийн 16.40 цагаас 18.00 цаг хүртэл Засгийн газрын мэдээлэл, Засгийн газарт тавьсан асуулга, асуултын хариуг сонсоно.

1.9. Тодорхой асуудал хэлэлцэх явцад шаардлагатай бол гишүүдийн олонхийн саналаар хуралдааныг түр завсарлуулах буюу хугацаа нь сунгаж болно. Харин түр завсарлах хугацаа нэг цагаас илүүгүй байна.

1.10. Чуулганы хуралдаанаар хэлэлцэх тодорхой асуудлыг эрс эсэргүүцсэн Улсын Их Хурлын гишүүн, нам, эвслийн бүлэг тухайн асуудлыг хэлэлцэхэд оролцохгүй гэдгээ уг асуудлыг хэлэлцэж эхлэхээс өмнө хуралдаан даргалагчид албан ёсоор мэдэгдэж болно. Энэ тохиолдолд нам, эвслийн бүлэг, Улсын Их Хурлын гишүүн хуралдаанд оролцохгүй тухай шалтгаан, хугацаагаа мэдэгдэж, хуралдаан даргалагчид бичгээр өгнө. Иймхүү чуулганы хуралдаанд оролцоогүй нь хуралдааны хүчин төгөлдөр байхад нөлөөлөхөөр бол дэгийн дагуу хуралдаанд оролцохыг шаардах, эсхүл хуралдаан завсарлах эсэхийг хуралдаан даргалагч шийдвэрлэнэ. Хуралдаан завсарласан хугацаанд нам, эвслийн бүлгийн ахлагч нар уг асуудлаар зөвшилцөнө. Иймхүү авсан хуралдааны завсарлагаа нь нэг цагаас илүүгүй байна. Зөвшилцөлд хүрч чадаагүй бол хуралдаанд оролцохгүй байх хугацаа дуусмагц түхайн гишүүн, нам, эвслийн бүлэг хуралдаандаа ирэх үүрэгтэй. Хэрэв хуралдаанд ирэхгүй бол Улсын Их Хурлын дарга нэгдсэн хуралдаанд оролцохыг шаардсан захирамж гаргах бөгөөд дээрх шалтгаанаар нэгдсэн хуралдаанд оролцохүй байгаа Улсын Их Хурлын гишүүнийг хуралдаан тасалсанд тооцно. Зөвшилцөж чадаагүй асуудлыг нэгдсэн хуралдаанд оролцогчдын олонхийн саналаар шийдвэрлэнэ.

1.11. Хуралдаан даргалагч дараахь эрх, үүрэгтэй:

1.11.1. хуралдааны дэгийн биелэлтэд хяналт тавьж, гишүүнээс түүнийг биелүүлэхийг шаардах;

1.11.2. илтгэл сонсох, санал дүгнэлт гаргах, санал хураах цагийг тогтоох;

1.11.3. саналаа ирүүлсэн дараалллыг баримтлан гишүүдэд үг хэлэх зөвшөөрөл олгох;

1.11.4. хуралдаанд оролцсон хүмүүст үг хэлэх зөвшөөрөл олгох;

1.11.5. хэлэлцсэн асуудлаар санал хураалт явуулж, дүнг мэдээлж, эцсийн шийдвэрийг сонсгон батлуулах;

1.11.6. хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийг сар тухайд нь гаргах ажлыг зохион байгуулах;

1.11.7. хуралдааны дэг, дотоод журам зөрчигчид Улсын Их Хурлын тухай хуулийн 15 дугаар зүйл, Улсын Их Хурлын гишүүний эрх зүйн байдлын тухай хуулийн 14 дүгээр зүйлд заасан арга хэмжээ авах;

1.11.8. хэлэлцэж байгаа асуудлаар гишүүдийн гаргасан горимын саналыг сонсох, түүгээр санал хураалгах;

Горимын санал гэж хуралдаанаар тухайн асуудлыг хэрхэн хэлэлцэх, шийдвэрлэх талаар Улсын Их Хурлын гишүүнээс гаргасан саналыг ойлгоно. Горимын саналаар нэг удаа санал хураалгана.

1.11.9. чуулганы хуралдааны хүрэлцэн ирсэн гишүүдэд танхимаас гарах зөвшөөрөл олгох;

1.11.10. Улсын Их Хурал хуралдаан даргалагчид бусад эрх олгож болно.

1.12. Улсын Их Хурлын гишүүн нэгдсэн болон Байнгын хорооны хуралдааны оролцох боломжгүй бол энэ тухай хуралдаан эхлэхээс өмнө Улсын Их Хурлын дарга, эсхүл Байнгын хорооны даргад мэдэгдсэн байвал зохино. Ийнхүү хуралдааны оролцоогүй бол долоо хоногийн дотор Байнгын хорооны дарга буюу Улсын Их Хурлын даргад бичгээр тайлбар өгнө.

1.13. Дараахь үндэслэлээр тухайн гишүүнийг хуралдааны оролцох боломжгүй байсанд тооцно:

1.13.1. өвчтэй байсан буюу өвчтэй хүн асарч байсан;

1.13.2. Улсын Их Хурлын томилолтоор дотоод, гадаадад явж ажилласан;

1.13.3. Байнгын хорооны хуралдаан давхардсан;

1.13.4. эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр чөлөөтэй байсан;

1.13.5. хуульд заасан бусад үндэслэл байвал.

Хоёр. Улсын Их Хурлын анхдугаар чуулганы зохион байгуулах

2.1. Монгол Улсын Ерөнхийлөгч анхдугаар чуулганы нээж үг хэлнэ.

2.2. Улсын Их Хурлын сонгуулийн нэгдсэн дүн, Улсын Их Хурлын шинээр сонгогдсон гишүүдийн бүрэн эрхийг хүлээн зөвшөөрөх тухай асуудлаар Улсын Их Хурлын дэргэдэх Сонгуулийн ерөнхий хорооны дарга илтгэл тавина. Илтгэлтэй холбогдуулж асуулт тавьж, хариулт авч болно.

2.3. Шинээр сонгогдсон Улсын Их Хурлын гишүүд тангараг өргөнө. Тангаргийн үгийг Улсын Их Хурлын насаар хамгийн ахмад гишүүн уншиж бусад гишүүд давтан хэлнэ. Улсын Их Хурлын анхдугаар чуулганы хуралдаанд оролцож амжаагүй гишүүн өөрийн оролцсон анхны өдрийн чуулганы хуралдаанд тангараг өргөнө.

2.4. Тангараг өргөсний дараа Улсын Их Хурлын гишүүд цагаан толгойн үсгийн дарааллаар Төрийн сүлдэнээ мэхийн ёсолж, тангаргийн хуудсанд гарын үсэг зурах ёслол үйлдэнэ.

2.5. Тангаргийн хуудсанд гарын үсэг зурах ёслол үйлдсэний дараа Улсын Их Хурлын гишүүдийн бүрэн эрхийг хүлээн зөвшөөрөх тухай Улсын Их Хурлын тогтоол батална.

2.6. Шинээр сонгогдсон Улсын Их Хурлын гишүүдийг тангараг өргөх ёслол үйлдэж дуустал Ерөнхийлөгч, харин Улсын Их Хурлын даргыг сонгох хүртэл Улсын Их Хурлын насаар хамгийн ахмад гишүүн чуулганы хуралдааныг даргална.

2.7. Улсын Их Хурлын гишүүн нас барсан, хүсэлтээрээ гишүүний үүрэгээс чөлөөлөгдсөн, эсхүл Улсын Их Хурлын гишүүнээс эгүүлэн татсан тохиолдолд түүний оронд нөхөн сонгогдсон Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийг хүлээн зөвшөөрөх тухай асуудлыг дээрх журмаар явуулна.

Гурав. Улсын Их Хурлын Байнгын болон дэд хороо, бусад байгуулагыг байгуулах

3.1. Байнгын хорооны бүрэлдэхүүнд орох Улсын Их Хурлын гишүүн саналаа өөрийн харьяалах нам, эвслийн бүлэгт танилцуулах бөгөөд бүлэг нь Байнгын хорооны бүрэлдэхүүний олонхи, цөөнхийн харьцаа Улсын Их Хуралд суудал авсан нам, эвслийн гишүүний тооны харьцаатай адил тэнцүү байх зарчмыг баримталж гишүүдээ хуваарилна. Нам, эвслийн бүлэгт харьяалагдахгүй гишүүдийг тухайн гишүүний саналыг харгалзан Улсын Их Хурлын дарга Байнгын хороонд хуваарилна. Байнгын хорооны бүрэлдэхүүнийг тухай асуудлыг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдааныаар хэлэлцэж Байнгын хорооны бүрэлдэхүүний тухай тогтоол батална.

3.2. Улсын Их Хурлын бүрэн эрхийн хугацаанд Улсын Их Хурлын гишүүн Байнгын хорооны харьяаллаа өөрчлөх саналгаргавал дээрх заасан журмыг баримтална.

3.3 Тухайн Байнгын хороо гишүүдийнхээ

дотроос Байнгын хорооны даргад нэр дэвшүүлэх эрхтэй. Ингэхдээ Улсын Их Хуралд олонхи суудал эвсан нам, эвслийн бүлэг, хэрэв аль ч нам бүюу эвсэл олонхийн суудал аваагүй бол хамгийн олон суудал авсан нам, эвслийн бүлэг Байнгын хорооны даргад нэр дэвшүүлэх эрхтэй бөгөөд нэр дэвшигчийг холбогдох Байнгын хорооны дүгнэлтийг үндэслэн хүн тус бүрээр ил санал хураалт явуулна. Санал хураалтад оролцон гишүүдийн олонхийн саналаар тухайн Байнгын хорооны даргаар сонгогдсонд тооцно. Улсын Их Хурлын тогтоол батална. Хэрэв нэр дэвшигч олонхийн санал авч чадаагүй бол дээрх журмаар сонгуулийг дахин явуулна.

3.4. Дэд хорооны бүрэлдэхүүний тухай асуудлыг харьяалах Байнгын хорооны хуралдаанаар урьдчилан хэлэлцэнэ. Улсын Их Хурал харьяалах Байнгын хорооны дүгнэлтийг үндэслэн дэд хорооны бүрэлдэхүүний тухай тогтоол батална.

3.5. Улсын Их Хурлын гишүүн Байнгын хорооны харьяаллаа өөрчлөх санал гаргасан үед нь дэд хорооны бүрэлдэхүүнээс гаргах асуудлыг самтад нь шийдвэрлэнэ.

3.6. Дэд хорооны даргыг харьяалах Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэж ил санал хураалтаар сонгох бөгөөд санал хураалтад оролцон гишүүдийн олонхийн саналаар дэд хорооны даргаар сонгох тухай холбогдох Байнгын хороо тогтоол гаргана.

3.7. Бусад хуульд өөрөөр заагаагүй бол Улсын Их Хурлын бусад байгууллагыг байгуулахад дээрх журмыг баримтална.

Дөрөв. Улсын Их Хурлын дарга, дэд даргыг сонгох чөлөөлөх, огцруулах

4.1. Улсын Их Хурлын дарга, дэд даргын сонгуулийг тус тусад нь, тэгэхдээ даргын сонгуулийг эхэлж явуулна.

4.2. Улсын Их Хурлын даргын сонгуульд нэр дэвшигчийн талаар ил санал хураалт явуулж, санал хураалтад оролцон гишүүдийн олонхийн саналаар гүүнийг Улсын Их Хурлын даргаар сонгогдсонд тооцно. Хэрэв нэр дэвшигч Улсын Их Хурлын гишүүдийн олонхийн санал авч чадаагүй бол дахин нэр дэвшүүлж энэ журмын дагуу санал хураалт явуулна. Улсын Их Хурлын даргыг сонгох тухай Улсын Их Хурал тогтоол батална.

4.3. Улсын Их Хурлын дэд даргад нэр дэвшигч тус бүрээр ил санал хураалт явуулж, санал хураалтад оролцон гишүүдийн олонхийн саналаар гүүнийг Улсын Их Хурлын дэд даргаар сонгогдсонд тооцно. Хэрэв нэр дэвшигч Улсын Их Хурлын гишүүдийн олонхийн санал авч чадаагүй бол дахин нэр дэвшүүлж энэ журмын дагуу санал хураалт явуулна. Улсын Их Хурлын дэд даргыг сонгох тухай Улсын Их Хурал тогтоол батална.

4.4. Улсын Их Хурлын дарга, дэд дарга бие биеийн эрүүл мэндийн байдал, хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй болсноос үүрэгт ажлаас чөлөөлөхийг хүссэн өргөдлийг харьяалах нам, эвслийн бүлэг болон Төрийн байгуулалтын байнгын хороо хэлэлцэж дүгнэлт гаргана. Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд өргөдөл гаргагчийн тайлбар, нам, эвслийн бүлгийн болон Төрийн байгуулалтын байнгын хорооны дүгнэлтийг сонсоно. Улсын Их Хурлын дарга, дэд даргыг үүрэгт ажлаас нь чөлөөлөх тухай асуудлыг ил санал хураалтаар шийдвэрлэж Улсын Их Хурал тогтоол батална. Улсын Их Хурлын даргыг үүрэгт ажлаас нь чөлөөлөх тухай асуудлыг хэлэлцэх нэгдсэн хуралдааныг Улсын Их Хурал дахь олонхийн бүлгээс сонгогдсон дэд дарга даргална.

4.5. Улсын Их Хурлын даргыг огцруулах үндэслэлтэй гэсэн Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг харьяалах нам, эвслийн бүлэг болон Төрийн байгуулалтын байнгын хороо хэлэлцэж дүгнэлт гаргана. Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанд Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт, нам, эвслийн бүлгийн болон Төрийн байгуулалтын байнгын хорооны дүгнэлтийг сонсоно. Энэ асуудлаар Улсын Их Хурлын гишүүд Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаан дээр санал дүгнэлт гаргаж болно. Улсын Их Хурлын даргыг огцруулах тухай асуудлыг ил санал хураалтаар шийдвэрлэж Улсын Их Хурал тогтоол батална. Улсын Их Хурлын даргыг огцруулах тухай асуудлыг хэлэлцэх нэгдсэн хуралдааныг Улсын Их Хурал дахь олонхийн бүлгээс сонгогдсон дэд дарга даргална.

Тав. Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг хүлээн зөвшөөрөх, чөлөөлөх

5.1. Улсын Их Хурлын дэргэдэх Сонгуулийн ерөнхий хорооны нэрийн өмнөөс түүний дарга Үндсэн хуулийн гучин нэгдүгээр зүйлийн 4,5 дахь хэсэгт зааснаар анхан шатны сонгуулья оролцон нийт сонгогчийн олонхийн санал авсан нэр дэвшигчийг Монгол Улсын Ерөнхийлөгчөөр сонгогдсон гэж үзэж бүрэн эрхийг нь хүлээн зөвшөөрүүлэх тухай асуудлыг санал хураалт дуусан өдрөөс хойш ЗО хоногийн дотор Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ.

5.2.Сонгуулийн ерөнхий хорооны дүнг Төрийн байгуулалтын байнгын хороо хэлэлцэж Ерөнхийлөгчийн анхан шатны сонгуулийн санал хураалт хүчин төгөлдөр болсон, нэр дэвшигч

Ерөнхийлөгчөөр сонгогдоход харшлах шалтгаан байхгүй гэсэн асуудлаар дүгнэлт гаргана. Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанд Ерөнхийлөгчийн анхан шатны сонгуулийн дүнгийн тухай Сонгуулийн ерөнхий хорооны илтгэлийг сонсож, энэ асуудлаар Үндсэн хуулийн цэц дүгнэлт гаргасан бол түүнийг сонсоно. Дараа нь Төрийн байгуулагчын байнгын хорооны дүгнэлтийг сонсоно. Илтгэл болон дүгнэлттэй холбогдулан Улсын Их Хурлын гишүүд асуулт асууна. Улсын Их Хурал анхан шатны сонгуулийн санал хураалт хүчин төгөлдөр болсон, нэр дэвшигч Ерөнхийлөгчөөр сонгогдоход харшлах шалтгаан байхгүй гэсэн санал хураалт явуулж, дээрх асуудлаар Улсын Их Хурлын гишүүдийн олонхи нь зөвшөөрсөн санал өгснөөр нэр дэвшигчийг Ерөнхийлөгчөөр сонгогдсон гэж үзэж бүрэн эрхийг нь хүлээн зөвшөөрсөн хууль батална.

Улсын Их Хурлын гишүүдийн олонхи нь зөвшөөрсөн санал өгөөгүй бол сонгогчдын нэрсийн жагсаалтад бүртгэгдсэн нийт сонгогчийн 50 хувь нь анхны санал хураалтад оролцоогүй, хоёр дахь санал хураалтаар нэр дэвшигчийн хэн нь ч сонгуульд оролцсон нийт сонгогчийн олонхийн санал авааГүй, санал хураалт хуулийн дагуу явагдаагүй гэсэн асуудлаар нэг бүрчлэн тодруулж санал хураана. Санал хураалт бүрт Улсын Их Хурлын гишүүдийн олонхи нь зөвшөөрөөгүй /эсрэг/ санал өгсөн бол нэр дэвшигчийг Ерөнхийлөгчөөр сонгогдсон гэж үзэж бүрэн эрхийг нь хүлээн зөвшөөрсөн хууль батална.

5.3. Ерөнхийлөгч биеийн эрүүл мэнд, хүндэтгэн үзэх бусад шалтгааны улмаас Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг хэрэгжүүлэх боломжгүйгээ илэрхийлж, Улсын Их Хуралд хүсэлт гаргасан бол Төрийн байгуулагчын байнгын хороо хэлэлцэж дүгнэлт гаргана. Улсын Их Хурал түүнийг чөлөөлөх эсэхийг хянан хэлэлцэхдээ хүсэлт гаргагчийн тайлбар Төрийн байгуулагчын байнгын хорооны дүгнэлт, эрүүл мэндийн хувьд бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй болсон тухай эмнэлгийн дүгнэлтийг сонсоно. Ерөнхийлөгчийг чөлөөлөх тухай асуудлыг ил санал хураалт явуулж Улсын Их Хурлын гишүүдийн олонхийн саналаар шийдвэрлэнэ. Хэрэв Ерөнхийлөгчийг чөлөөлөхийг гишүүдийн олонхи нь дэмжсэн бол энэ тухай Улсын Их Хурал хууль батална.

Зургаа. Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүдийг томилох, Засгийн газрыг огцруулах, Засгийн газарт итгэл хүлээлгэх эсэхээ илэрхийлэх

6.1. Улсын Их Хурал дахь нам, эвсэл Улсын Их Хурлын даргыг сонгосноос хойш 7 хоногийн дотор Ерөнхий сайдад нэр дэвшүүлж, Ерөнхийлөгч Үндсэн хуулийн гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2-т заасан хүрмаар нэр дэвшүүлсэн хүнийг Ерөнхий сайдаар томилуулах тухай саналаа Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ.

Ерөнхий сайдыг шинээр томилох нөхцөл байдал үүссэн бусад тохиолдолд Ерөнхийлөгч шинэ Ерөнхий сайдыг томилуулах саналаа үүнөөс хойш 14 хоногт багтаан Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ. Ерөнхий сайдыг томилох саналыг Улсын Их Хурал 15 хоногийн дотор хэлэлцэн шийдвэрлэнэ.

6.2. Ерөнхий сайдын албан тушаалд нэг хүний нэр дэвшүүлнэ.

6.3. Нэр дэвшигчийг Ерөнхийлөгч танилцуулна. Нэр дэвшигчийн талаар Төрийн байгуулагчын байнгын хорооны дүгнэлт, хэрэв шаардлагатай гэж үзсэн тохиолдолд Хууль зүйн байнгын хорооны дүгнэлтийг сонсоно. Улсын Их Хурлын гишүүд Ерөнхий сайдад нэр дэвшигчид асуулт тавьж, хариулт авч болно. Нэр дэвшигчийн талаар Улсын Их Хурлын гишүүд үг хэлж, дүгнэлт гаргасны дараа саналыг илээр хураана, хуралдааНд оролцсон гишүүдийн олонхийн саналаар Ерөнхий сайдыг томилох тухай Улсын Их Хурал тогтоол батална.

6.4. Ерөнхий сайдад нэр дэвшиг олонхийн санал авч чадаагүй бол 14 хоногийн дотор дахин өөр хүний нэр дэвшүүлэхийг Улсын Их Хурал дахь нам, эвсэл болон Ерөнхийлөгчид Улсын Их Хурал зөвлөнө. Дахин нэр дэвшүүлж, томилох асуудлыг дээрх жүрмаар гүйцэтгэнэ.

6.5. Засгийн газрын гишүүнд нэр дэвшүүлсэн хүн бүрийг Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороогоор урьдчилан хэлэлцүүлэх бөгөөд Байнгын хорооны дүгнэлт гарсны дараа Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанаар хэлэлцэнэ.

6.6. Улсын Их Хурал Засгийн газрын гишүүнд Ерөнхий сайдын нэр дэвшүүлсэн хүн бүрийг тусад нь хэлэлцэнэ. Улсын Их Хурлын гишүүд нэр дэвшигчид асуулт тавьж, хариулт авсны дараа санал, дүгнэлтээ гаргана.Нэр дэвшигчийг Засгийн газрын гишүүнээр томилох талаар ил санал хураалтыг хүн бүрээр явуулна.Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонхийн санал авсан хүнийг Засгийн газрын гишүүнээр томилогдсонд тооцож. Улсын Их Хурал тогтоол батална.

6.7. Үндсэн хуулийн гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2-т зааснаар Монгол Улсын Ерөнхийлөгч Засгийн газрыг огцруулах саналаа, мөн Үндсэн хуулийн дөчин гуравдугаар зүйлийн 4 дэх хэсэгт зааснаар Улсын Их Хурлын нийт гишүүний дөрөвний нэгээс доошгүй нь Засгийн газрыг огцруулахыг хүсч гарын үсэг зурсан саналаа Улсын Их Хурлын даргад өргөн мэдүүлснээс хойш хорин

дөрвөөс доошгүй цагийн дараа гэхдээ 15 хоногийн дотор Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар хэлэлцэнэ. Иймхүү хэлэлцэхдээ Засгийн газрыг огцруулах болсон үндэслэл бүхий санал, Байнгын хороодын дүгнэлт, нам, эвслийн бүлгийн саналыг сонсоно. Уг асуудлаар Ерөнхийлөгч, Ерөнхий сайдын санал, хэрэв Үндсэн хуулийн жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 3, 4-т заасан үндэслэл байна гэж үзвэл Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг заавал сонсоно. Дараа нь Улсын Их Хурлын гишүүн, Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, эсхүл Засгийн газрыг огцруулахыг санаачлагч гишүүдэд асуулт тавьж, хариулт авна. Улсын Их Хурлын даргын саналаар асуулт, хариултыг тасалсны дараа санал, шүүмжлэл явуулна.

Санал, шүүмжлэл тасалсны дараа Ерөнхийлөгч, Ерөнхий сайд үг хэлж болно.

6.8. Засгийн газрыг огцруулах эсэх асуудлыг Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонхийн саналаар шийдвэрлэнэ. Улсын Их Хурлын гишүүд саналаа илээр гаргана. Энэ асуудлаар Улсын Их Хурал тогтоол батална.

6.9. Үндсэн хуулийн дөчин гуравдугаар зүйлийн 1, 2 дахь хэсэгт зааснаар Ерөнхий сайд, эсхүл Засгийн газрын гишүүдийн тэн хагас нь огцрох тухайгаа Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн бол Улсын Их Хурал уг асуудлыг энэ дэгийн 6.7, 6.8-д заасан журмаар хэлэлцэн шийдвэрлэнэ. Гэхдээ Ерөнхий сайдын саналыг эхлэн сонсоно.

6.10. Үндсэн хуулийн дөчин дөрөвдүгээр зүйлд заасны дагуу өөрт нь итгэл хүлээлгэж байгаа эсэхээ илэрхийлж өгөхийг хүсч Засгийн газар холбогдох тогтоолын төсөл Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн бол уг асуудлыг нам, эвслийн бүлэг болон Төрийн байгуулалтын байнгын хороо урьдчилан хэлэлцэж. тус тус дүгнэлт гаргана. Улсын Их Хурал нэгдсэн хуралдаанаар уг асуудлаар Засгийн газрын тайлбар, нам, эвслийн бүлгийн болон Төрийн байгуулалтын байнгын хорооны дүгнэлтийг тус тус сонсоно. Улсын Их Хурлын гишүүд Засгийн газар болон дүгнэлтэй холбогдуулан асуулт асууж, санал, дүгнэлт хэлж болно.

Долоо. Улсын Их Хуралд Улсын дээд шүүхийн шүүгчидийг танилцуулах

7.1. Үндсэн хуулийн тавин нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар Шүүхийн ерөнхий эвлөл Улсын дээд шүүхийн шүүгчидийг томилуулахаар Ерөнхийлөгчид санал болгохын өмнө нэр дэвшигч бүрийг Хууль зүйн байнгын хороонд танилцуулна.

7.2. Хууль зүйн байнгын хороо Шүүхийн ерөнхий эвлөлөөс санал болгосон нэр дэвшигчийн талаар Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанд мэдээлнэ. Улсын дээд шүүхийн шүүгчээр томилогдохоор нэр дэвшигчийн талаар Улсын Их Хурал шийдвэр гаргахгүй.

Найм. Ерөнхий прокурор, түүний орлогчийг Ерөнхийлөгч томилохдоо Улсын Их Хуралтай зөвшилцөх

8.1. Үндсэн хуулийн тавин зургадугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасанаар Ерөнхий прокурор, түүний орлогчийг Ерөнхийлөгч томилохдоо Улсын Их Хуралтай зөвшилцөн тохиролцоонд хүрнэ.

8.2. Ерөнхий прокурор, түүний орлогчоор томилогдохоор нэр дэвшсэн хүмүүсийг Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо урьдчилан хэлэлцэж, дүгнэлтээ Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанд танилцуулна.

8.3. Улсын Их Хурал Ерөнхийлөгчийн санал, Хууль зүйн байнгын хорооны дүгнэлттэй танилцаад Ерөнхий прокурор, түүний орлогчоор томилогдохоор нэр дэвшигчидийн талаар ил санал хураалт явуулж, дунг Ерөнхийлөгчид өргөн мэдүүлнэ.

8.4. Ерөнхийлөгчийн санал болгосон нэр дэвшигч хуралдаанд оролцсон нийт гишүүний олонхийн дэмжлэг авч чадаагүй тохиолдолд Ерөнхийлөгч дахин өөр санал оруулна.

Ес. Үндсэн хуулийн цэцийн гишүүдийг томилох, эгүүлэн татах

9.1. Улсын Их Хурлын дарга Үндсэн хуулийн цэцийн гишүүнд нэр дэвшүүлэх хүний тухай саналаа Төрийн байгуулалтын байнгын хороонд оруулна. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн гуравдугаар зүйлд зааснаар Улсын Их Хурлын дарга Төрийн байгуулалтын байнгын хорооны дүгнэлтийг үндэслэн Үндсэн хуулийн цэцийн гишүүнд нэр дэвшүүлнэ.

9.2. Дээрх нэр дэвшигч болон Үндсэн хуулийн цэцийн гишүүнд Ерөнхийлөгч, Улсын дээд шүүхээс санал болгосон нэр дэвшигчийг Хууль зүйн байнгын хороо урьдчилан хэлэлцэж, дүгнэлтээ Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанд танилцуулна.

9.3. Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанаар Хууль зүйн байнгын хорооны дүгнэлт, Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн саналыг сонсож, нэр дэвшигч түс бүрээр ил санал хураалт явуулж, нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонхийн санал авсан хүнийг Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилох тухай Улсын Их Хурал тогтоол батална.

9.4. Үндсэн хуулийн жаран тавдугаар зүйлийн 4 дэх хэсэгт зааснаар Үндсэн хуулийн цэцийн гишүүнийг эгүлэн татах асуудлыг Улсын Их Хурал хэлэлцэхдээ энэ талаар гарсан Үндсэн хуулийн цэцийн шийдвэр, анх нэр дэвшүүлсэн байгууллагын саналыг сонссоны дараа ил санал хураалт явуулж, нэгдсэн хуралдаанд фролцсон гишүүдийн олонхийн саналаар шийдвэрлэнэ.

Арав. Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх, түүнийг эгүүлэн татах, бүрэн эрхийг сэргээх журам

10.1. Улсын Их Хурлын гишүүний эрх зүйн байдлын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 7 дахь хэсэгт зааснаар Улсын Их Хурлын гишүүнийг баривчилсан тохиолдолд түүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх асуудлыг дараахь журмаар хэлэлцэн шийдвэрлэнэ:

10.1.1. Улсын Их Хурлын дарга Улсын Их Хурлын гишүүнийг баривчилсан тухай мэдэгдэл хүлээн авснаас хойш 24 цагийн дотор нэн даруй энэ тухай Төрийн байгуулалтын байнгын хорооны даргад мэдэгдэж холбогдох арга хэмжээ авахыг үүрэг болгоно.

10.1.2. Төрийн байгуулалтын байнгын хороо Улсын Их Хурлын даргын мэдэгдэл хүлээн авснаас хойш 24 цагийн дотор хуралдаж тухайн гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх эсэх тухай асуудлыг хэлэлцэж энэ талаар Улсын Их Хурлаас гарах шийдвэрийн төслийг хэлэлцэн дүгнэлт гаргана.

10.1.3 Төрийн байгуулалтын байнгын хорооны дүгнэлтийг Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанаар түүнийг хүлээн авснаас хойш 24 цагийн дотор авч хэлэлцэн зохих шийдвэр гаргана.

10.2. Улсын Их Хурлын дарга эрх бүхий байгууллагаас Улсын Их Хурлын гишүүнд холбогдох эрүүгийн хэрэг үүсгэсэн бөгөөд гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх тухай хүсэлт тавьсан бол уг хүсэлтийг хүлээн авснаас хойш 24 цагийн дотор Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлнэ. Төрийн байгуулалтын байнгын хороо 72 цагийн дотор хуралдаж тухайн гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх тухай дүгнэлт гаргана. Улсын Их Хурал уг дүгнэлтийг тухайн долоо хоногийн нэгдсэн хуралдаанаараа хэлэлцэн зохих шийдвэр гаргана.

10.3. Улсын Их Хурлын гишүүнийг эгүүлэн татах үндэслэл байна гэж үзэж Үндсэн хуулийн цэц дүгнэлт гаргасан бол Улсын Их Хурал 15 хоногийн дотор тухайн гишүүнийг эгүүлэн татах тухай шийдвэр гаргана.

10.4. Улсын Их Хурлын гишүүнийг гэмт хэрэг үйлдсэн гэж үзсэн анхан шатны шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болсноос хойш 15 хоног, хэрэв энэ хугацаанд хяналтын шатны шүүхэд гомдол гаргасан бол хяналтын шатны шүүхийн шийдвэр гарснаас хойш 15 хоногийн дотор Улсын Их Хурал түүнийг эгүүлэн татах тухай шийдвэр гаргана. Энэ шийдвэрийн төслийг Төрийн байгуулалтын байнгын хороо саналчлан нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлнэ. Уг шийдвэрийн төслийг Хууль зүйн байнгын хороо заавал хянан хэлэлцэж зохих дүгнэлт гарган Улсын Их Хуралд оруулна.

10.5. Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх тухай эрх бүхий байгууллагын санал, тухайн гишүүнийг эгүүлэн татах үндэслэл байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт буюу гишүүнийг гэмт хэрэг үйлдсэн гэж үзсэн шүүхийн шийдвэр нь Улсын Их Хурлын эхлэхээс чуулган завсарласан үед хүчин төгөлдөр болсон тохиолдолд уг асуудлыг хэлэлцүүлэхээр Улсын Их Хурлын тухай хуулийн 11 дүгээр зүйлд заасны дагуу эхлэхээс чуулган зарлан хуралдуулна.

Арван нэг. Гадаад улсад суух бүрэн эрхт төлөөлөгчийн газрын тэргүүнийг Ерөнхийлөгч томилох, эгүүлэн татахдаа Улсын Их Хуралтай зөвшилцөх

11.1. Гадаад улсад суух бүрэн эрхт төлөөлөгчийн газрын тэргүүнийг томилох, эгүүлэн татах асуудлыг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо урьдчилан хэлэлцэж, дүгнэлтээ Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанд танилцуулна.

11.2. Улсын Их Хурал Ерөнхийлөгчийн санал, Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дүгнэлттэй танилцаад бүрэн эрхт төлөөлөгчийн газрын тэргүүнийг томилох, эгүүлэн татах асуудлаар ил санал хураалт явуулж, дүнг Ерөнхийлөгчид өргөн мэдүүлнэ.

11.3. Гадаад улсад суух бүрэн эрхт төлөөлөгчийн газрын тэргүүнийг томилохтой холбогдож гарсан тухайн төлөөлөгчийн газрын байршилтай холбогдсон асуудлыг дээрх журмаар шийдвэрлэнэ.

Арван хоёр. Ерөнхийлөгч Улсын Их Хуралд ажлаа хариуцах

12.1. Монгол Улсын Үндсэн хуулийн гучин тавдугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасанаар Ерөнхийлөгч Улсын Их Хуралд ажлаа хариуцна.

12.2. Ерөнхийлөгч ажлын тайлангаа жил бүр Улсын Их Хуралд иргүүлнэ.

Арван гурав. Ард нийтийн санал асуулга явуулах

13.1. Ард нийтийн санал асуулга явуулах асуудлаар Төрийн байгууллагын байнгын хорооны болон зохих Байнгын хорооны дүгнэлтийг Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанд танилцуулна. Дүгнэлттэй холбогдуулж гишүүд асуулт тавьж, хариулт авч болно.

13.2. Улсын Их Хурал Байнгын хороодын дүгнэлттэй танилцаад, ард нийтийн санал асуулга явуулах талаар санал хураалтыг илээр явуулж шийдвэрлэнэ. Энэ асуудлаар Улсын Их Хурал тогтоол батална.

Арван дөрөв. Ерөнхийлөгчийн хоригийг хянан хэлэлцэх

14.1. Үндсэн хуулийн гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1-д заасны дагуу Улсын Их Хурлын батална хууль, бусад шийдвэрт бүхэлд нь буюу зарим хэсэгт нь Ерөнхийлөгчийн тавьсан хоригийн үндэслэлийг Ерөнхийлөгч, эсхүл Ерөнхийлөгчийн итгэмжилсэн төлөөлөгч Улсын Их Хуралд танилцуулна.

14.2. Ерөнхийлөгчийн хоригийн талаар тухайн хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийг хариуцаж байсан зохих Байнгын хороо болон Хууль зүйн байнгын хорооны дүгнэлтийг сонсоно.

Байнгын хороодын дүгнэлтийг сонссоны дараа асуулт, хариулт явуулж, гишүүд санал гаргаж болно. Иймхүү санал, дүгнэлт гаргаж дууссаны дараа Ерөнхийлөгч тухайн хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрт бүхэлд нь буюу зарим хэсэгт нь хориг тавьсныг үндэслэн үг хоригийг хүлээн зөвшөөрөх эсэх асуудлаар санал хураалт явуулна. Хэрэв Ерөнхийлөгч хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн зарим хэсэгт хориг тавьсан бол тухайн зүйл, заалт нэг бүрээр санал хураалт явуулна.

Ерөнхийлөгчийн тавьсан хоригийг чуулганд оролцсон нийт гишүүний гуравны хоёр нь хүлээж аваагүй бол уг хууль, шийдвэр хүчин төгөлдөр хэвээр үлдэнэ.

14.3. Улсын Их Хурал Ерөнхийлөгчийн хоригийн талаар тогтоол батална.

14.4. Улсын Их Хурал Ерөнхийлөгчийн хоригийг хүлээн зөвшөөрсөн тохиолдолд тухайн хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийг бүхэлд нь буюу түүний зарим хэсгийг хүчингүй болгож, эсхүл тэдгээрт зохих нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийг хэлэлцэж батална.

14.5. Тухайн хууль, бусад шийдвэрийг хүчин төгөлдөр дагаж мөрдөж эхлэх тусгайлан заасан хугацаа Ерөнхийлөгчийн хориг тавьсан хугацаатай давхацвал хоригийг хэрэхэх тухай асуудлыг Улсын Их Хурал хянан хэлэлцэж дуусах хүртэл уг хууль, бусад шийдвэр бүхэлдээ буюу түүний зарим хэсгийн үйлчлэл түр зогсоно.

14.6. Хориг тавьсан асуудлыг хэрхэн шийдвэрлэсэн тухай хариуг уг шийдвэрийг батласнаас хойш 72 цагийн дотор Ерөнхийлөгчид илгээнэ.

Арван тав.Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хэлэлцэх

15.1. Үндсэн хуулийн жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1, 2-т заасан асуудлын талаархи Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хэлэлцэхэд дараахь журмыг баримтална:

15.1.1. Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг Үндсэн хуулийн цэцийн дарга, эсхүл цэцийн аль нэг гишүүн Улсын Их Хуралд танилцуулна.

15.1.2. Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг танилцуулсны дараа тухайн хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийг хариуцаж байсан Байнгын хороо болон Хууль зүйн байнгын хороо дүгнэлтээ танилцуулна;

15.1.3. Улсын Их Хурлын гишүүд Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт болон Байнгын хороодын дүгнэлтийн талаар асуулт тавьж, санал, дүгнэлт гаргаж болно;

15.1.4. Улсын Их Хурал Үндсэн хуулийн жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1, 2-т заасан асуудлаар Үндсэн хуулийн цэцийн гаргасан дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх эсэхээ нэгдсэн хуралдаанд оролцон нийт гишүүний олонхийн саналаар шийдвэрлэнэ;

15.1.5. Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэр Үндсэн хуульд нийцэхгүй байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг Улсын Их Хурал тогтоолоороо хүлээн зөвшөөрвөл тухайн хууль, шийдвэрт зохих нэмэлт, өөрчлөлт оруулна. Харин Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын шийдвэр, Монгол Улсын олон улсын гэрээ, Сонгуулийн ерөнхий хорооны шийдвэрийг Үндсэн хуульд нийцэхгүй байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг Улсын Их Хурал тогтоолоороо хүлээн зөвшөөрсөн бол тэдгээр шийдвэрүүд нь хүчингүй болсонд тооцогдоно;

15.1.6. Улсын Их Хурал Үндсэн хуулийн жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1, 2-т заасан асуудлаар Үндсэн хуулийн цэцийн гаргасан дүгнэлтийг хүлээн зөвшөөрөөгүй бол энэ талаар Улсын Их Хурал тогтоол батална.

15.2. Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, гишүүн, Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн Үндсэн хууль зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хэлэлцэхэд дараахь журмыг баримтална:

15.2.1. Үндсэн хуулийн жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 3-т заасны дагуу Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүн, Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүний /цаашид "холбогдох албан тушаалтан" гэх/ талаар Үндсэн хуулийн цэцээс гаргасан дүгнэлтийг хэлэлцэх Улсын Их Хурлын нэгдсэн хуралдааныг Улсын Их Хурлын дарга даргална. Улсын Их Хурлын даргын талаар Үндсэн хуулийн цэцийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэх нэгдсэн хуралдааныг Улсын Их Хурал дахь олонхийн бүлгээс сонгогдсон дэд дарга даргална;

15.2.2. холбогдох албан тушаалтны талаар Үндсэн хуулийн цэцээс гаргасан дүгнэлтийг Үндсэн хуулийн цэцийн дарга, эсхүл түүний эзгүйд орлож байгаа цэцийн ахлагч нь нэг гишүүн Улсын Их Хуралд танилцуулна;

15.2.3. холбогдох албан тушаалтан цэцийн дүгнэлтийн талаар үг хэлнэ. Түүний үг хэлэх хугацаа 10 минутаас илүүгүй байна. Хэлсэн үгтэй нь холбогдуулан гишүүд асуулт тавьж болно;

15.2.4. холбогдох албан тушаалтан Үндсэн хууль зөрчсөн тухай цэцийн дүгнэлттэй танилцсаны дараа уг албан тушаалтныг огцруулах, эгүүлэн татах эсэх, тухайн зөрчлийг арилгуулах асуудлын талаар Төрийн байгуулалтын байнгын хорооны дүгнэлтийг хэлэлцэнэ.

15.2.5. Төрийн байгуулалтын байнгын хорооны саналаар санал хураалтыг илээр явуулна. Хэрэв тухайн албан тушаалтан Үндсэн хууль зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүдийн олонхи дэмжсэн бол Улсын Их Хурал холбогдох шийдвэр гаргана. Шийдвэрийн төслийг Төрийн байгуулалтын байнгын хороо оруулна.

15.3. Шаардлагатай гэж үзвэл Үндсэн хуулийн жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 4-т заасан албан тушаалтныг огцруулах, эгүүлэн татах үндэслэл байгаа эсэх талаар Улсын Их Хурал, эсхүл тухайн албан тушаалтан өөрөө Үндсэн хуулийн цэцэд хандаж болно.

Үндсэн хуулийн цэц тухайн албан тушаалтныг огцруулах, эгүүлэн татах үндэслэл байна гэсэн дүгнэлт гаргавал түүнийг огцруулах, эгүүлэн татах эсэх асуудлыг 15.2-т заасан журмын дагуу хэлэлцэн шийдвэрлэнэ. Ерөнхийлөгчийг огцруулах эсэх асуудлыг хуралдаанд оролцон нийт гишүүний дийлэнхи олонхийн саналаар шийдвэрлэж хууль батална.

15.4. Тухайн албан тушаалтныг огцруулсан, эсхүл эгүүлэн татсан нь түүнд хуулийн хариуцлага хүлээлгэхээс чөлөөлөх үндэслэл болохгүй.

15.5. Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, гишүүн, Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн Үндсэн хууль зөрчөөгүй байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанд сонсоно.

15.6. Улсын Их Хурал Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн авснаас хойш 15 хоногийн дотор, хэрэв Улсын Их Хурлын чуулганы чөлөө цагт гаргасан бөгөөд тэр нь онц болон дайны байдал зарласнаас бусад асуудлаар гаргасан бол дараагийн чуулган эхэлснээс хойш 15 хоногийн дотор заавал хэлэлцэн шийдвэрлэнэ.

15.7. Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Улсын ерөнхий прокурор Үндсэн хууль зөрчсөн эсэх талаархи Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтэй Улсын Их Хурал танилцаж, энэ тухайгаа Ерөнхийлөгчид мэдэгдэнэ.

Арван зургаа. Ерөнхийлөгч, Засгийн газар Монгол Улсын олон улсын гэрээний төслийг Улсын Их Хуралтай зөвшилцөх, түүнийг хэлэлцэх

16.1. Үндсэн хуулийн гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4-т заасны дагуу Ерөнхийлөгч Монгол Улсын нэрийн өмнөөс байгуулах олон улсын гэрээний, мөн хуулийн гучин наймдугаар зүйлийн 2 дахь хэсгийн 9-д заасны дагуу Засгийн газар дараа соёрхон батлуулах Монгол Улсын олон улсын гэрээний /цаашид "гэрээ " гэх/ төслийг Улсын Их Хуралтай зөвшилцөнө.

16.2. Монгол Улсын олон улсын гэрээний төслийг нөгөө талтай зарчмын хувьд тохиролцсоны дараа, түүнд гарын үсэг зурахаас өмнө Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо урьдчилан хэлэлцэнэ. Гэрээний төсөл, эсхүл түүний дэлгэрэнгүй танилцуулга, холбогдох бусад баримт бичгийг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо урьдчилан хэлэлцэхээс гурваас доошгүй хоногийн өмнө Улсын Их Хурлын гишүүдэд тараасан байна.

16.3. Олон улсын гэрээний төслийг Улсын Их Хурлын Эдийн засгийн болон Төсвийн байнгын хороод урьдчилан заавал хэлэлцэж, дүгнэлтээ Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд өгнө.

16.4. Шаардлагатай гэж үзвэл гэрээний төслийг бусад Байнгын хороо хэлэлцэж болох бөгөөд Байнгын хороо дүгнэлтээ, Улсын Их Хурлын гишүүн төслийн талаархи саналаа Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд бичгээр ирүүлнэ. Уг санал, дүгнэлтийг тус Байнгын хорооны хуралдаанд заавал танилцуулна. Байнгын хорооны хуралдаанаас төсөлд нэмэлт, өөрчлөлт оруулах талаар дүгнэлт гарвал Засгийн газар гэрээний төслийг нөгөө талтай эцэслэн тохиролцохдоо тэдгээрийг тусгах чиглэлээр ажиллаж, дүнг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд танилцуулна.

16.5. Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо гэрээний төслийг урьдчилан

хэлэлцэж дараахь шийдвэрийн аль нэгийг гаргана:

16.5.1. гэрээний төслийг бүхэлд нь зөвшөөрөх;

16.5.2. гэрээ байгуулах шаардлагагүй гэж үзэж татгалзах.

16.6. Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дүгнэлт нь зохих Байнгын хорооны гаргасан дүгнэлттэй санал нэгдээгүй тохиолдолд уг асуудлыг Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанд оруулан зөвшилцөнө.

16.7. Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо гэрээг байгуулах шаардлагагүй гэж үзсэн тухай шийдвэр гаргавал Ерөнхийлөгч, Засгийн газар уг асуудлыг Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж болно.

16.8. Хүчин төгөлдөр болоогүй байгаа олон улсын олон талт гэрээнд Ерөнхийлөгч Монгол Улсын нэрийн өмнөөс гарын үсэг зурахын өмнө уг асуудлыг Улсын Их Хуралтай зөвшилцехэд энэ журмыг нэгэн адил баримтална.

Арван долоо. Олон улсын олон талт гэрээг соёрхон батлах тухай Улсын Их Хурлын шийдвэрийн төслийг хэлэлцэх

17.1. Олон Улсын олон талт гэрээг соёрхон батлах тухай Улсын Их Хурлын шийдвэрийн төслийг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо хуралдаанаараа урьдчилан хэлэлцэж дараахь саналын аль нэгийг дүгнэлтдээ тусгаж Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанд танилцуулна:

17.1.1. тухайн гэрээг соёрхон батлах нь зүйтэй;

17.1.2. тухайн гэрээг соёрхон батлах шаардлагагүй гэж үзвэл төслийг буцаах тогтоолын төслийг батлах;

17.1.3. тухайн гэрээг тайлбар мэдэгдэлтэй соёрхон батлах.

Тухайн гэрээг тайлбар мэдэгдэлтэй соёрхон батлахаар дүгнэлт гаргасан бол тайлбар мэдэгдлийн агуулгыг тодорхой заана.

17.2. Олон улсын олон талт гэрээг соёрхон батлах тухай Улсын Их Хурлын шийдвэрийн төслийг холбогдох бусад Байнгын хороо хэлэлцэж дүгнэлтээ Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дүгнэлтэд тусгуулах, эсхүл Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанд танилцуулж болно.

17.3. Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанаар холбогдох Байнгын хорооны дүгнэлтэд тусгасан саналаар санал хураалт явуулж, анхны хэлэлцүүлгээр батална. Харин шаардлагатай бол тайлбар мэдэгдлийн агуулгаар эцсийн хэлэлцүүлэг явуулахаар зохих Байнгын хороонд шилжүүлнэ.

17.4. Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанаар олон улсын олон талт гэрээг соёрхон батлах тухай Улсын Их Хурлын шийдвэрийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулахдаа дараахь журмыг баримтална:

17.4.1. тайлбар мэдэгдлийн агуулгаар эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаар Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны танилцуулга;

17.4.2. зохих Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан асуулт, хариулт явуулж болно;

17.4.3. тайлбар мэдэгдлийн талаар зохих Байнгын хороонооос дэмжигдсэн саналаар санал хураалт явуулж төслийг бүхэлд нь батална.

Арван найм. Гадаад улсыг хүлээн зөвшөөрөх, түүнтэй дипломат харилцаа тогтоох, цуцлах тухай асуудлыг хянан хэлэлцэх

18.1. Гадаад улсыг хүлээн зөвшөөрөх тухай Засгийн газраас өргөн мэдүүлсэн асуудлыг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо урьдчилан хэлэлцэж дүгнэлтээ Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлнэ.

18.2. Гадаад улстай дипломат харилцаа шинээр буюу сэргээн тогтоох тухай Засгийн газраас өргөн мэдүүлсэн асуудлыг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо урьдчилан хэлэлцэнэ. Байнгын хороо уг асуудлыг сайшаан зөвшөөрөх тухайн улстай тодорхой тохиролцохыг Засгийн газарт үүрэг болгоно. Засгийн газар тухайн улстай тодорхой тохиролцсоны дараа уг асуудлыг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо дахин хэлэлцэж, дүгнэлтээ Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлнэ. Энэ асуудлаар Улсын Их Хурал тогтоол батална.

18.3. Гадаад улстай дипломат харилцаагаа цуцлах тухай Засгийн газраас өргөн мэдүүлсэн асуудлыг зохих Байнгын хороо урьдчилан хэлэлцэж дүгнэлтээ Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлнэ. Энэ асуудлаар Улсын Их Хурал тогтоол батална.

Арван ес. Улсын Их Хурлын хяналт

19.1. Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанд Засгийн газрын мэдээлэл хийх хугацаа 15 минутаас илүүгүй байна. Мэдээлэлтэй холбогдуулж Улсын Их Хурлын гишүүд асуулт тавьж, хариулт авч болно.

Асуулт, хариултын үргэлжлэх нийт

хугацааг хуралдаан даргалагч тогтооно.

19.2. Засгийн газарт тавьсан асуулт гэдэг нь тодорхой нэг асуудлын талаар мэдээлэл авах зорилгоор Улсын Их Хурлын гишүүнээс Засгийн газарт, эсхүл Засгийн газрын аль нэг гишүүнд амаар болон бичгээр хандсаныг хэлнэ.

19.3. Улсын Их Хурлын гишүүн асуултын хариуг Байнгын хорооны хуралдаанд сонсох эсэх, хэзээ сонсох тухай саналаа Байнгын хорооны даргад бичгээр ирүүлнэ.

19.4. Засгийн газар, түүний гишүүн асуултын хариуг 14 хоногийн дотор өгөх бөгөөд асуултын хариуг Ерөнхий сайд, эсхүл Засгийн газрын аль нэг гишүүн Байнгын хорооны хуралдаанд сонсогно.

Бичгээр тавьсан асуултын хариу өгөх хугацаа 5 минутаас илүүгүй байна

19.5. Асуулт тавьсан Улсын Их Хурлын гишүүд хуралдаан-даргалагчийн зөвшөөрсний дагуу тавьсан асуулттайгаа нэг сэдэвтэй, ойролцоо, ижил асуултыг хуралдаан дээр тодруулан тавьж болно.

19.6. Засгийн газарт тавьсан асуулга гэдэг нь Улсын Их Хурлын нэг буюу хэд хэдэн гишүүн нийлж, эсхүл Байнгын болон бусад хороо, нам, эвслийн бүлгээс улс орны нийтлэг эрх ашигт хөндсөн болон бүрэн эрхэд нь хамаарах бусад асуудлаар Засгийн газрын бодлого, байр суурийг тодруулах, тодорхой үйл ажиллагаа явуулахыг шаардаж Засгийн газарт бичгээр хандсаныг хэлнэ. Асуулга нь Засгийн газрын бүрэн эрхийн хүрээнд нийцсэн байна.

19.7. Асуулга тавсан Улсын Их Хурлын гишүүн, Байнгын хороо, нам, эвслийн бүлэг асуулгынхаа хариуг хэзээ сонсох талаархи саналаа Улсын Их Хурлын даргад ирүүлнэ.

19.8. Засгийн газар асуулгын хариуг 30 хоногийн дотор бичгээр өгөх бөгөөд Ерөнхий сайд, эсхүл Засгийн газрын гишүүн асуулгын хариуг Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанд сонсогно. Асуулгад өгөх хариултын хугацаа 15 минутаас илүүгүй байна.

Асуулгын хариутай холбогдуулж Улсын Их Хурлын гишүүд тухайн сэдвээр тодруулан асууж болно.

Асуулга тавьсантай холбогдуулан Улсын Их Хурлаас зохих шийдвэр гаргах шаардлагатай гэж үзвэл уг асуудлыг холбогдох Байнгын хороонд тавина.

19.9. Улсын Их Хурал тодорхой албан тушаалтан, байгуллага эсхүл тодорхой асуудлын талаар баримт нотолгоо бүрдүүлэх, мөрдөн шалгах, мэдээлэл цуглуулах, санал дүгнэлт бэлдүүлж, Улсын Их Хуралд хэлэлцүүлэх зорилгоор шалгалтын ажлын хэсгийг байгуулж болно.

Шалгалтын ажлын хэсгийг Улсын Их Хурлын дарга өөрийн санаачилгаар, эсхүл зохих Байнгын хороо, Улсын Их Хурлын гишүүнээс гаргасан саналын дагуу захирамжаараа байгуулна. Үүл захирамжид шалгалтын ажлын хэсэгт орох Улсын Их Хурлын гишүүдийн нэрс, ажлын үр дүнг танилцуулах хугацаог заана.

Шалгалтын ажлын хэсгийн бүрэлдэхүүнд Улсын Их Хурал дахь олонхи, цөөнхийн нам, эвслийн бүлгийн аль алинын нь төлөөлөл байвал зохино.

19.10. Шалгалтын ажлын хэсэг дараахь бүрэн эрхтэй:

19.10.1. тухайн байгууллагын эрх баригчдыг дуудан ирүүлэх, тэдний мэдээллийг сонсох, асуулт тавьж, хариулт авах, судалгаа тайлан, дүгнэлт бусад мэдээллийг гаргуулан авах;

19.10.2. хяналтын явцад олж авсан төрийн нууцыг хадгалах, шаардлагатай гэж үзвэл дүнг Улсын Их Хурлын хаалттай хуралдаанд хэлэлцүүлэх санал гаргах.

19.11. Шалгалтын ажлын хэсгийн санал, дүгнэлтийг зөвшөөрөөгүй ажлын хэсгийн гишүүн тусдаа дүгнэлт гаргаж болно. Шалгалтын ажлын хэсгийн санал, дүгнэлтийг үндэслэн зохих Байнгын хороо саналаа чуулганы хуралдаанд оруулна.Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанд гишүүд асуулт тавьж, санал, дүгнэлт гаргаж болно. Шаардлагатай бол нэгдсэн хуралдаанаар шалгалтын ажлын хэсэг, Байнгын хорооны дүгнэлтийн талаар санал хураалгаж, Улсын Их Хурал зохих шийдвэр гаргана.

19.12. Шалгалтын ажлын хэсгийн хяналтын явцад тухайн асуудлыг хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, шүүх байгууллагаас шалгаж эхэлсэн бол Улсын Их Хурлын хяналт хэрэгжүүлэх ажлын хэсэг үйл ажиллагаагаа даруй зогсооно.

(Төгсгөл нь дараагийн дугаарт)

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Хаяг: «Төрийн мэдээлэл» эмхтгэлийн зөвлөл
Улаанбаатар-12 ☎ 329612
Төрийн ордон Индекс 14003

Улсын Их Хурлын Тамгын газрын
Хэвлэх хэсэгт хэвлэв.
☎ 329487



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 28 (215)

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ:

- *Монгол Улсын 2001 оны төвлөрсөн төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай*
- *Хүн амын орлогын албан татварын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай*
- *Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай*
- *Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай*

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ:

- *Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал батлах тухай*
- *Улсын Их Хурлын 2001 оны 61 дүгээр тогтоолын хавсралтын төгсгөл*

Улсын Их Хурлын Тамгын газар

Улаанбаатар хот
2001 он

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот 2001 оны долдугаар сарын 7 №28 (215

Гарчиг

Нэг. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

356. Гэрээ соёрхон батлах тухай (2001-6-29-ний хууль) 730

357. Монгол Улсын 2001 оны төвлөрсөн төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай (2001-6-29-ний хууль) 730

358. Хүн амын орлогын албан татварын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай (2001-6-29-ний хууль) 731

359. Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай (2001-6-29-ний хууль) 732

360. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай (2001-6-29-ний хууль) 734

Хоёр. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

361. Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал батлах тухай Дугаар 57 734

362. Улсын Их Хурлын 2001 оны 61 дүгээр тогтоолын хавсралтын төгсгөл 743

363. Төрийн захиргааны албаны зөвлөлийн орон тооны гишүүдийг томилох тухай Дугаар 62 749

364. Аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг буцаах тухай Дугаар 63 750

365. 2001оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай Дугаар 64 750

366. Монгол Улсын Их Хурлын 2000 оны 49 дүгээр тогтоолд нэмэлт оруулах тухай Дугаар 65 751

Гурав. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

367. Элчин сайдыг эгүүлэн татах, томилох тухай Дугаар 01 751

368. Элчин сайдыг эгүүлэн татах, томилох тухай Дугаар 02 751

369. Дитрих Неллег "Найрамдал" медалиар шагнах тухай Дугаар 03 751

370. БНЭУ-ын зарим иргэнийг одон, медалиар шагнах тухай Дугаар 04 752

371. Зарим шүүгчийг чөлөөлөх тухай Дугаар 05 752

372. Б.Доржготовыг Улсын Дээд шүүхийн шүүгчээр томилох тухай Дугаар 06 752

373. Р.Жамъянчойжилыг Улсын дээд шүүхийн иргэний хэргийн танхимын тэргүүн шүүгчээр томилох тухай Дугаар 07 752

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2001 оны 6 дугаар сарын 29-ний өдөр — Улаанбаатар хот

ГЭРЭЭ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улс, Азийн хөгжлийн банкны хооронд 2001 оны 4 дүгээр сарын 25-ны өдөр байгуулсан Кадастрын зураглал болон газрын бүртгэлийн тєслийн зээлийн Гэрээг Засгийн газрын өрсөн мэдүүлснээр соёрхон батлагдсугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Л.ЭНЭБИШ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2001 оны 6 дугаар сарын 29-ний өдөр — Улаанбаатар хот

МОНГОЛ УЛСЫН 2001 ОНЫ ТӨВЛӨРСӨН ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Монгол Улсын 2001 оны төвлөрсөн төсвийн тухай хуулийн 1 дүгээр зүйлд заасан Улсын төвлөрсөн төсвийн орлогын нийт дүн, нэр төрлийн хэмжээнд дор дурдсан өөрчлөлт оруулсугай:

	/мянган төгрөгөөр/
1.1. ОРЛОГО-БҮГД	**19,328,082.1**
1.1.1. Албан татварын орлого	**10,841,468.2**
1.1.1.а. орлогын албан татвар	1,658,855.6
1.1.1.в. нэмэгдсэн өртгийн албан татвар	191,722.7
1.1.1.г. онцгой албан татвар	8,094,223.3
1.1.1.е. гаалийн албан татвар	-630,700.0
1.1.1.ж. бусад албан татвар	-137,920.9
1.1.1.з. нийгмийн даатгалын шимтгэл, хураамж	1,665,287.5
1.1.2. Татварын бус орлого	**8,486,613.9**
1.1.2.в. хувьцааны ногдол ашиг	10,690.4
1.1.2.в. түрээсийн орлого	-300,000.0
1.1.2.д. төсөвт байгууллагын өөрийн орлого	8,387,423.5
1.1.2.е. навигац /өнгөрөлт/-ын орлого	388,500.0

2 дугаар зүйл. Монгол Улсын 2001 оны төвлөрсөн төсвийн тухай хуулийн 2 дугаар зүйлд заасан Улсын төвлөрсөн төсвийн 2001 оны зарлагын нийт дүн, үүний дотор цалин, хөрөнгө оруулалт, батлан хамгаалах арга хэмжээний зардал, төвлөрүүлэн захирагчийн санхүүжилт, тэтгэврийн даатгалын санд өгөх татаасын хэмжээнд дор дурдсан өөрчлөлт оруулсугай:

2.1. ЗАРЛАГА-БҮГД	**19,348,113.9**
2.1.1. цалингийн сан	91,288.9
2.1.2. хөрөнгө оруулалт	-276,200.0
Үүнээс:-шинээр эхлэх барилга объектын нийт төсөвт өртөг	-5,156,000.0
Үүний дотор: -2001 онд санхүүжүүлэх объектын төсөвт өртөг	-158,500.0
2.1.3. батлан хамгаалах арга хэмжээний зардал	-257,318.0
2.1.4. Улсын Их Хурлын төсөв	216,761.2
2.1.5. Монгол Улсын Ерөнхийлөгчийн төсөв	3,647.1
2.1.6. Монгол Улсын Ерөнхий сайдын төсөв	2,423.8
2.1.7. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн төсөв	-740.8
2.1.8. Шүүхийн ерөнхий зөвлөлийн төсөв	-16,402.1
2.1.9. Улсын дээд шүүхийн төсөв	653.8
2.1.10. орон нутгийн шүүхийн төсөв	-11,483.1
2.1.11. прокурорын төсөв	11,193.4
2.1.12. Улсын аюулгүй байдлыг хангах газар	-57,150.9
2.1.13. тэтгэврийн даатгалын санд өгөх татаас	776,744.9

3 дугаар зүйл. Монгол Улсын 2001 оны төвлөрсөн төсвийн тухай хуулийн 3 дугаар зүйлд заасан Улсын төвлөрсөн төсвөөс аймгийн төсөвт өгөх татаасын хэмжээнд дор дурдсан өөрчлөлт оруулсугай:

3.1.ТАТААСЫН ДҮН	**2,731,086.2**
3.1.1.Архангай	228,506.1
3.1.2.Баян-Өлгий	152,173.0
3.1.3.Баянхонгор	145,995.8
3.1.4.Булган	14,151.3
3.1.5.Говь-Алтай	72,005.5
3.1.6.Дорноговь	75,757.0
3.1.7.Дорнод	140,417.5
3.1.8.Дундговь	188,782.3
3.1.9.Завхан	229,419.1
3.1.10.Өвөрхангай	172,211.3
3.1.11.Өмнөговь	69,215.0
3.1.12.Сүхбаатар	42,493.0
3.1.13.Сэлэнгэ	243,027.8
3.1.14.Төв	205,751.3
3.1.15.Увс	126,321.8
3.1.16.Ховд	104,267.4
3.1.17.Хөвсгөл	165,842.0
3.1.18.Хэнтий	146.343.7
3.1.19.Дархан-Уул	144,943.9
3.1.21.Орхон	55,513.6
3.1.22.Говь-Сүмбэр	7,947.8

4 дүгээр зүйл.Энэ хуулийг 2001 оны 7 дугаар сарын 5-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА **Л.ЭНЭБИШ**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

:001 оны 6 дугаар **Улаанбаатар**
:арын 29-ний өдөр **хот**

ХҮН АМЫН ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Хүн амын орлогын албан атварын хуулийн 10 дугаар зүйлд дор дурдсан гуулгатай хэсэг нэмсүгэй:

1/ 2 дахь хэсэг:

"2.Арилжааны банк иргэний хадгаламжид үү бодох бүрдээ энэ хуулийн 8 дугаар зүйлийн 4 эх заалтад заасан хувиар албан татвар ногдуулан уутган авч, төсөвт шилжүүлнэ."

2 дугаар зүйл. Хүн амын орлогын албан атварын хуулийн 7 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн 5" заалтын "үнийн дүнгийн 3 хувиар;" гэсний дараа Энэ заалт нь түүний ноос, ноолуур, арьс ширэнд амаарахгүй."; 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 2 ахь заалтын "Алдарт" гэсний өмнө "Хуульд заасны агуу олгож байгаа тэтгэмж, нөхөн олговор, төлбөр"; өн хэсгийн 10 дахь заалтын "болон" гэсний дараа Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу айгуулагдсан" гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл. Хүн амын орлогын албан атварын хуулийн 8 дугаар зүйлийн 1 дэх заалтыг ор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/ 8 дугаар зүйлийн 1 дэх заалт:

"1/ шинжлэх ухаан, утга зохиол, урлагийн үтээл зохиогч, шинэ бүтээл, оновчтой санал гаргагч, загвар зохион бүтээгч нарын шагнал болон адилтгах бусад шагналын 5000000 хүртэлх төгрөгийн орлогод 5 хувиар, 5000001, түүнээс дээш төгрөгийн орлогод 10 хувиар;"

4 дүгээр зүйл. Хүн амын орлогын албан татварын хуулийн 9 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн "36000" гэснийг "48000"; 10 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн "1000" гэснийг "10000" гэж тус тус өөрчилсүгэй.

5 дугаар зүйл. Хүн амын орлогын албан татварын хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн "болон түр", 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалтын "Тэтгэмжийн хуулийн дагуу олгож байгаа хөдөлмөрийн чадвар түр алдсан, жирэмсний болон амаржсаны тэтгэмжээс бусад тэтгэмж, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай болон Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн дагуу олгож байгаа оршуулгын тэтгэмж", мөн зүйлийн 4 дэх заалтын "тэтгэвэр," гэснийг тус тус хассугай.

6 дугаар зүйл. Энэ хуулийг 2001 оны 10 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА **Л.ЭНЭБИШ**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2001 оны 6 дугаар сарын 29-ний өдөр

Улаанбаатар хот

НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 3, 4, 8, 9 дүгээр зүйлд дор дурдсан агуулгатай хэсэг, заалт нэмсүгэй:

1/ 3.1.9; 3.1.10 дахь заалт:

"3.1.9. "нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгч болсон эдэр" гэж нэмэгдсэн өртгийн албан татвар ногдох бараа үйлдвэрлэх, ажил, үйлчилгээ үзүүлэн орлого олж байгаа иргэн, хуулийн этгээдийн уг үйл ажиллагааны борлуулалтын орлогын хэмжээ 10.0 сая төгрөгт хүрсэн өдрийг;

3.1.10. "гадаад улсын Засгийн газар, төрийн бус байгууллага, олон улсын болон буяны байгууллагаас хүмүүнлэгийн болон буцалтгүй тусламжаар авсан бараа" гэж давагдашгүй хүчин зүйл болон түүнтэй адилтгах бусад гамшигийн улмаас учирсан гарз, хохирлыг арилгахад зориулсан болон Монгол Улсын Засгийн газраас гадаад улсын Засгийн газар, олон улсын байгууллагатай байгуулсан Монгол Улсын Олон улсын гэрээний дагуу хариу төлбөргүй илгээсэн бараг; Буцалтгүй болон хүмүүнлэгийн тусламжийн хүрээнд гадаад улсын Засгийн газар, олон улсын байгууллагаас өгсөн санхүүжилт /менгөн хөрөнгө/-ээр дотоодын зах зээлээс худалдан авч байгаа бараа, ажил, үйлчилгээ үүнд нэгэн адил хамаарна."

2/ 4.7; 4.8; 4.9 дэх хэсэг:

"4.7. Иргэн хуулийн этгээдэд эрхлэн гүйцэтгэж байгаа үйл ажиллагааных нь хувьд энэ хуулийн 5, 9 дүгээр зүйлд заасны дагуу татвар ногдуулах, татвараас чөлөөлөхөд төрийн захиргааны эрх бүхий байгууллагаас батална "Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал"-ыг баримтална.

4.8.Нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгчөөр бүртгүүлсэн иргэн, хуулийн этгээдийн бүртгүүлснээс хойшхи тухайн нэг жилийн хугацааны татвар ногдох орлогын хэмжээ 10.0 сая төгрөгт хүрээгүй нь аж ахуйн нэгж, байгууллагын хувьд санхүүгийн тайлангаар, иргэний хувьд орлого, татвар тодорхойлох хуудсаар нотлогдсон бөгөөд дараагийн жилүүдэд уг орлогын хэмжээ 10.0 сая төгрөгт хүрэхгүй нөхцөлд харьяалах татварын албань түүнийг татвар төлөгчийн бүртгэлээс хасч, гэрчилгээг хураана. Татвар төлөгчийг бүртгэлээс хассан нь дахин бүртгүүлэхгүй байх үндэслэл болохгүй.

4.9.Үндэсний татварын ерөнхий газар улсын хэмжээнд нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгчөөр бүртгэсэн болон бүртгэлээс хассан аж ахуйн нэгж, байгууллага, иргэний нэрийн жагсаалтыг сар бүр хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлж байна."

3/ 8.2 дахь хэсэг:

"8.2. Энэ хуулийн 8.1 дэх хэсэг нь гадаадын аж ахуйн нэгж, байгууллага, иргэнтэй гэрээ хийж, экспортын үйл ажиллагааг хариуцан гүйцэтгэж байгаа, нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгчөөр бүртгүүлсэн иргэн, хуулийн этгээдэд хамаарна."

4/ 9.1.13 дахь заалт; 9.5 дахь хэсэг:

"9.1.13. Аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхлэгч байгууллага /туроператор/-ын гадаадын жуулчдад үзүүлсэн үйлчилгээ;

9.5.Энэ хуулийн 9.2.3-т заасан татварын чөлөөлөлтийг гадаадын дипломат төлөөлөгчийн болон консулын газарт эдлүүлэхдээ төлсөн татварыг нь буцаан олгох зарчмыг баримтална."

2 дугаар зүйл. Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд дор дурьдсан агуулгатай 13^1 дугаар зүйл нэмсүгэй:

"**13^1 дугаар зүйл.** Нэмэгдсэн өртгийн албан татварын хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага

13^1.1. Энэ хуулийн 4.2; 4.3-т заасны дагуу татвар төлөгчөөр бүртгүүлэл зохих иргэн, хуулийн этгээд харьяалах татварын албанд бүртгүүлж, гэрчилгээ авааг үй бөгөөд бүртгүүлэл зохих хугацаанаас хойш үйл ажиллагаа явуулан орлого олж байсан нь тогтоогдвол бүртгүүлээгүй хугацаанд

олсон нэмэгдсэн өртгийн албан татвар ногдох орлогын дүнгийн 8 хувьтай тэнцэх торгууль ногдуулна.

13¹.2. Нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгчөөр бүртгүүлж, гэрчилгээ авааруй иргэн, хуулийн этгээд өөрийн борлуулж байгаа бараа, ажил, үйлчилгээндээ уг татварыг ногдуулан түүнийг бусдаас нэхэмжлэн авч хууль бусаар нэмэгдэл орлого олсон нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол түүний бусдаас нэхэмжилж авсан татварыг төсөвт нөхөн төлүүлж, нэхэмжилж авсан өдрөөс хойшхи хоног тутамд нөхөн төлүүлсэн татварын дүнгээс бодож 1 хувийн хүү ногдуулна."

3 дугаар зүйл. Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 1.1-ийн "импортоор авсан" гэсний дараа "болон экспортолсон"; 4 дүгээр зүйлийн гарчгийн "бүртгэх," гэсний дараа "бүртгэлээс хасах"; 4.1-ийн "импортолж байгаа" гэсний дараа "болон экспортолж байгаа"; "түүнчлэн" гэсний дараа "аливаа"; 9.1.4-ийн "үйлчилгээ;" гэсний дараа "Энэ нь эм, эм бэлдмэл, эмнэлгийн багаж, техник хэрэгсэл үйлдвэрлэх, худалдан борлуулахад хамаарахгүй."; 9.2.3-ын "консульн газрын" гэсний дараа "албан ажлын"; 9.2.9 дэх заалтын дараа "болон заалт тухайн төрлийн анхдагч түүний эд үйлдвэрлэгчид хамаарна."; 9.2.11-ийн "борлуулах" гэсний дараа "Энэ заалт худалдан борлуулах зориулалтаар шинээр барьж байгуулсан орон сууцны зориулалттай байр буюу түүний хэсэгт хамаарахгүй."; 11.3-ын "бараа," гэсний дараа "ажил"; 13.1-ийн "төлж," гэсний дараа "батлагдсан маягтын дагуу"; "тайлангаа" гэсний дараа "гарган" гэж тус тус нэмсүгэй.

4 дүгээр зүйл. Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 4, 10, 11 дүгээр зүйлийн дарааҳь хэсэг, заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/ 4.3 дахь хэсэг:

"4.3. Энэ хуулийн 5.1.4 болон 9 дүгээр зүйлд зааснаас бусад үйл ажиллагаа эрхэлж байгаа иргэн, хуулийн этгээдийн өргөдлийг хүлээн авснаас хойш ажлын 3 өдөрт багтаан нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгчөөр бүртгэж, гэрчилгээ олгоно. Нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгчийн гэрчилгээний загварыг Үндэсний татварын ерөнхий газрын дарга батална."

2/ 10.1 дэх хэсэг:

"10.1. Татвар төлөгчөөр бүртгүүлсэн иргэн, хуулийн этгээдийн орлогод нэмэгдсэн өртгийн албан татвар ногдуулж эхлэх хугацааг татварын албанаас гэрчилгээ олгосон өдрөөс эхлэн тооцох бөгөөд харин уг татварыг ногдуулах тухайн борлуулалтын хувьд дор дурдсан үйлдлийн аль түрүүнд хийгдсэн өдрөөр татвар ногдуулах хугацаг тогтооно:"

3/ 11.1; 11.5 дахь хэсэг:

"11.1. Энэ хуулийн 4 дүгээр зүйлд заасны дагуу татвар төлөгчөөр бүртгүүлсэн иргэн, хуулийн этгээдийн бүртгүүлснээсээ хойшхи хугацаанд мөн хуулийн 5, 6 дугаар зүйлд зааснаар ногдуулж төлсөн дор дурдсан нэмэгдсэн өртгийн албан татварыг түүний төсөвт төлөх нэмэгдсэн өртгийн албан татвараас хасч тооцно:

11.5.Татварын алба татвар төлөгчийн төсөвт илүү төлсөн нэмэгдсэн өртгийн албан татвар, гадаадын дипломат төлөөлөгчийн болон консульн газрын төсөвт төлсөн нэмэгдсэн өртгийн албан татварыг тухайн байгууллага татварын албатай тооцоо хийснээс хойш ажлын 15 өдрийн дотор хянаж баталгаажуулан төсөөс буцаан олгуулах асуудлыг санхүү, эдийн засгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад уламжлан шийдвэрлүүлнэ."

5 дугаар зүйл. Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 4.2-ын "30 хоногийн" гэснийг "ажлын 10 өдрийн", 11.8-ын "Сангийн сайд" гэснийг "санхүү, эдийн засгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн"; 12.4-ийн "Сангийн яаманд" гэснийг "санхүү, эдийн засгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад", 12.2-ын "3 хоногийн" гэснийг "ажлын 3 өдрийн"; 12.3-ын "3 хоногийн дотор" гэснийг "ажлын 3 өдөрт багтаан"; 13.1-ийн "15-ны" гэснийг "10-ны" гэж тус тус өөрчилсүгэй.

6 дугаар зүйл. Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 4.5 дахь хэсгийг хассугай.

7 дугаар зүйл. Энэ хуулийг 2001 оны 10 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА **Л.ЭНЭБИШ**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2001 оны 6 дугаар сарын 29-ний өдөр **Улаанбаатар хот**

АЖ АХУЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг "19.1. Энэ хуулийг 2002 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө." гэж өөрчлөн найруулсугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2001 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Л.ЭНЭБИШ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2001 оны 6 дугаар сарын 14-ний өдөр **Дугаар 57** **Улаанбаатар хот**

Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал батлах тухай

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг хавсралтын ёсоор батлагдсугай.

2. Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг батлагдсантай холбогдуулан дор дурдсан арга хэмжээг хэрэгжүүлэхийг Засгийн газар /Н.Энхбаяр/-т даалгасугай.

1/ Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг хэрэгжүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх саналыг, бүс бүрийн хөгжлийн дунд хугацааны стратеги, удирдлагын ерөнхий загварын төслийг боловсруулж Улсын Их Хурлын 2001 оны намрын чуулганд өргөн барих;

2/ бүсүүдийн төв, Монгол Улсын хотуудын зэрэглэлийн асуудлыг судалж, тодорхой санал боловсруулан Хот тосгоны эрх зүйн байдлын тухай хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийн хамт Улсын Их Хурлын 2001 оны намрын ээлжит чуулганд өргөн мэдүүлэх;

3/ бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг хэрэгжүүлэх арга хэмжээнд шаардагдах зардлын эх үүсвэрийг эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх жил бүрийн үндэсн чиглэл, улсын төвлөрсөн төсөвт тусган шийдвэрлэж байх.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Л.ЭНЭБИШ

Монгол Улсын Их Хурлын 2001 оны 57 дугаар тогтоолын хавсралт

МОНГОЛ УЛСЫН БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг. Оршил

Эх газрын эрс тэс уур амьсгалтай, экологийн эмзэг орчин бүхий уул, тал хээр, говь цөл хосолсон өргөн уудам нутагт Монгол Улсын цөөн хүн ам эртнээс наашаруу сийрэг суурьшин, бэлчээрийн мал аж ахуй голлон эрхэлж нутаг усныхнаараа нэг нэгнээ дэмжин амьдарч, "нүүдлийн" гэж нэрлэгдсэн нэн өвөрмөц зан заншил, ахуй, соёлыг бүтээн, уе үеийнхэндээ залгамжлуулж ирсэн нь байгаль, цаг уурын хүчтэй, өөрчлөлтөд дасан зохицохыг эрмэлзсэн жам ёсны хандлага байв. XX зууны 30-аад оноос эхлэн Монгол Улс аж үйлдвэр, тариалангийн салбарыг шинээр үүсгэн, хөдөөгийн хүн амд үйлчлэх зориулалттай зам харилцаа, сургууль, эмнэлэг, соёлын газар бүхий хот, тосгоныг олноор байгуулах болсон байна. Улаанбаатар, Дархан, Эрдэнэт хот, аймгийн бусад төвүүдийг үүсгэн хөгжүүлсэн нь монголчуудын амьдралын хэв маягийг суурин соёл иргэншлийн эзлэлтоор баяжуулж, үндэсний эдийн засаг, соёлын дэвшлийг түргэтгэхэд чухал үүрэг гүйцэтгэж иржээ. Эдгээр хот, суурин нь Монгол улсад ардчилал зах зээлийн харилцаа хөгжих эхлэлийг тавьж, монгол хүн өмчийн жинхэнэ эзэн болж, ажиллаж амьдрах, сурч боловсрох эрхээ чөлөөтэй сонгох орчин болж байна.

Нөгөө талаас үйлдвэр хөгжүүлэх, хот байгуулах ажлыг байгаль орчны даац, чадавх, бэлчээрийн мал аж ахуйд түшиглэсэн хүн амын

нүүдлийн хэв шинжийн нутагшилтын онцлогтой сайтар уялдуулж оновчтой зохион байгуулж ирээгүйгээс ой, ус, бэлчээрийн ургамал, ан амьтны нөөц хомсдож, орон нутгийн олон хот суурин тодорхой чиг үүрэггүй орхигдож, байгаль орчин, нийгмийн хөгжлийн тэнцэл алдагдах хандлагатай болсон байна.

Хүн ам, үйлдвэр, үйлчилгээний газрууд Улаанбаатар, Дархан, Эрдэнэт хот болон гол төмөр замын дагуух бус нутагт хэт бөөнөрсөн нь хүн амын амьдрах орчны чанар байдлыг муутган, нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд төвөг учруулж, ажилгүйдэл, ядуурал ихсэхэд нөлөөлж байна.

Гэтэл дээрх гурван хот, Төв, Сэлэнгэ аймгийн нутгийг оролцуулахгүйгээр тус улсын газар нутгийн 92,1, малын тооны 89,6, усны нөөцийн 80,7, ойн нөөцийн 73,4 хувь, эрдсийн баялаг болон биологийн төрөл зүйлийн арвин нөөц бүхий бусад аймаг зах зээлийн харилцаанд жинхэнэ утгаараа шилжиж чадаагүй, хөгжлийн түвшнээр хоцрогдуй байдалтай болсон байна. Энэ нь хөдөөгийн хүн амтөв, суурин газар руу олноор шилжин нүүдэллэх үндэсн шалтгаан болж байна.

Орон нутгийн хөгжлийн хоцрогдуй байдал нь Монгол Улсын эдийн засгийг газар зүйн байрлалынх нь дагуу гадаад орнуудтай холбон хөгжүүлж, гадаад хамтын ажиллагааны үр өгөөжийг нэмэгдүүлэх боломжийг ч хязгаарлаж байна.

Эдийн засаг, нийгмийн хөгжлийн нутаг дэвсгэрийн тэнцвэргүй байдлыг бууруулах явдал Монгол Улс XXI зууны тогтвортой хөгжлийн замд дэвшин орох нэн чухал үүтвар нөхцөл мөн.

Аймаг, сумдын аж ахуйн бие даасан байдлыг тэдгээрийн дотоодын нөөцөөр хангах бололцоогүй бөгөөд улсын хөрөнгийг засаг захиргааны олон жижиг нэгжид тараах хуваарилах нь үр ашиггүй болохыг өмнөх түүхийн сургамж, зах зээлийн өнөөгийн шинэ нөхцөл байдал харуулж байна.

Монгол Улсын Үндэсн хуулийн "Төр нь үндэсний аюулгүй байдал, аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулна" гэсэн заалтыг үндэслэл болгон боловсруулсан "Монгол Улсын Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал"-д Монгол Улсыг бүсчлэн хөгжүүлэх /цаашид "бүсчилсэн хөгжил" гэх/ арга замыг боловсруулж, бүсчлэлээр дамжуулан нутаг дэвсгэрийн хөгжлийн тэнцвэржийг хангах төрийн байгуулалт, эдийн засаг, нийгэм соёл, хүн амын нутагшилт, хот байгуулалт, гадаад хамтын ажиллагааны таатай орчныг бүрдүүлэх, эдийн засгийн бүсүүдийн хүрээнд бүс нутаг-хот байгуулалтын уялдаат хангах замаар аймаг, орон нутгийн хөгжлийг дэмжих төрийн бодлого, зохицуулалтын тогтолцоог бий болгох чиглэл, үйл ажиллагааны зарчмын үндсийг тодорхойлж байна.

Хоёр. Бүсчилсэн хөгжлийн үндэслэл

2.1. Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын эрхэм зорилго нь тус улсын газар, түүний баялаг, газар тариалан, мал аж ахуйн гараltай түүхий эдийн нөөц, оюуны чадавхийг байгаль орчны даацад зохицуулан оновчтой ашиглах үндэсн дээр хүн амын, үйлдвэрлэлийн өнөөгийн зохисгүй бөөнөрлийг задалж, хот, хөдөөгийн хөгжлийн ялгаа, аймаг, бүс нутаг хоорондын тэгш бус, тэнцвэргүй байдлыг багасгаж хөгжлийн түвшинг ойртуулах, үндэсний эдийн засаг, нийгмийн дэвшлийг түргэтгэх дотоод, гадаад таатай орчныг бүрдүүлэхэд оршино.

2.2. Эрхэм зорилгыг хэрэгжүүлэхэд байгаль орчиндоо зохицсон бэлчээрийн мал аж ахуйн орон зайн зохион байгуулалтын дэвшилтэй бүхнийг орчин үеийн суурин сооль иргэншлийн элоптой зүй зохистой хослуулах зарчмыг баримтална.

2.3. Эрхэм зорилгод хүрэхийн тулд дараахь зорилтыг хэрэгжүүлэх явдлыг тэргүүлэх ач холбогдолтой гэж үзнэ:

2.3.1. **төрийн байгуулалтын хүрээнд:** бүс нутгийг тэнцвэртэй хөгжүүлэх үндэсний нийтлэг эрх ашгийг, аймаг, нийслэл, хот, тосгон, сум, аж ахуйн нэгж, байгуулагын хууль ёсны ашиг сонирхолтой хосолж, засаг захиргаа-нутаг дэвсгэрийн байгууламжийг цаашид боловсронгуй болгох эдийн засаг, зохион байгуулалт, нийгэм-сэтгэл зүйн орчныг бүрдүүлэх.

2.3.2. **эдийн засгийн хүрээнд:** тухайн бүс дотроо аймаг, сум бүр голлон эрхлэх аж ахуйн чиглэлээ зөв тогтоон, өөр хоорондоо хоршин хөгжих бизнесийн орчныг бүрдүүлэх, дотоод, гадаад зах зээлтэй зохистой холбоо тогтоож, аймаг, бүс нутаг хоорондын хөгжлийн түвшинг ойртуулах, тэгш бус байдлыг багасгах, эдийн засгийн өсөлт, үр ашгийг тогтвортой нэмэгдүүлэх нөхцөлийг хангах.

2.3.3. **нийгэм, соёлын хүрээнд:** хүн ам тухайн нутагтаа тогтвор, суурьшилтай ажиллаж, амьдрах, сурч боловсрох, эрүүл мэндийн үйлчилгээ хүртэх, мэдээлэл авах эрхээ чөлөөтэй эдлэх, аймаг, орон нутгийнхаа амьдралд идэвхтэй, эрх тэгш хамтран оролцох, улмаар хөдөөгийн хүн амын хөдөлмөр, нийгмийн хамгаалал, эрүүл мэнд, боловсрол, соёл, урлаг, мэдээлэл, ахуйн үйлчилгээний тогтолцоог бэхжүүлж, бүс нутгийн жарьцангуй жигд хөгжлийг хангах нөхцөлийг бүрдүүлэх.

2.3.4. **байгаль орчныг хамгаалах жүрээнд:** бүс нутгийн хөгжлийг тэнцвэржүүлэх

үүднээс тухайн бүсийнхээ байгалийн баялгийн нөөцийг ашигласны эцсийн үр өгөөжийг адил тэнцүү хүртэх, байгаль орчныг хамгаалах нийтлэг асуудлыг аймаг, сум, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн хамтын хүчээр шийдвэрлэж экологийн тэнцвэртэй байдлыг хангах нөхцөлийг бүрдүүлэх.

2.3.5. **хүн амын нутагшилт, хот байгуулалтын хүрээнд**: тухайн бүсийн хэмжээнд хот, тосгон, хөдөөгийн хүн амын нутагшилт, суурьшлын харилцан уялдсан тогтолцоог бүрдүүлж, нутаг дэвсгэрийн тэнцвэрт хөгжлийг тэтгэх чадвар бүхий бүс нутаг, хотжилтын нэгдмэл орчныг бий болгох.

2.3.6. **гадаад хамтын ажиллагааны хүрээнд**: түс орны тээвэр-газар зүйн байрлалын дагуу бүс нутгуудыг олон улсын худалдаа-эдийн засгийн суљжээнд зохистой холбож, орон нутгийн болон үндэсний хөгжлийг түргэтгэх гадаад харилцааны боломжийг бүрэн дүүрэн ашиглах нөхцөлийг хангах.

Гурав. Гол үзэл санаа

3.1. Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын зорилго, зорилтыг хангах үндэсэн арга зам нь Монгол Улсад эдийн засгийн бүсчлэл тогтоож, түүгээр дамжуулан бүс нутаг, хот, хөдөөгийн хөгжлийн нэгдмэл болон харьцангуй бие даасан тогтолцоонд суурилсан бүс нутгийн эдийн засаг, нийгмийн цогцолборуудыг бүрдүүлэх явдал мөн.

3.2. Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын дор дурдсан нэр томъёог дараахь утгаар ойлгоно:

3.2.1. "эдийн засгийн бүсчлэл" гэж бүсчилсэн хөгжлийн зорилгод нийцүүлэн Монгол Улсын нутаг дэвсгэрийг дотоод зах зээл хөгжих, гадаад зах зээлтэй зохистой холбох газар зүйн байрлалын боломж, аймаг, сумдын аж ахуй, соёлын уламжлалт харилцаа холбоо, эдийн засаг, нийгмийн хөгжлийн зорилтын нийтлэг байдал, байгаль, түүхий эдийн нөөц, оюуны чадавхийг засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж болон салбар хоорондын хамтын ажиллагааны хүрээгээр бүрэн зохистой хоршин ашиглах боломж зэргээр нь эдийн засгийн бүсүүд болгон зохион байгуулж, эдийн засаг, дэд бүтцийн хөгжлийг уг бүсүүдээр зохицуулах үйл ажиллагаа;

3.2.2. "эдийн засгийн бүс" гэж нутаг дэвсгэрийн хөгжлийн тэнцвэрийг хангах зорилгоор үндэсний хэмжээнд, бүс нутгийн хөгжлийг түргэтгэх, тодорхой нутгийн түвшинд эдийн засгийг төрөөс зохицуулах нийтлэг болон ялгавартай бодлого явуулах шаардлагыг харгалзан тогтоосон нутаг дэвсгэрийн зааг хүрээг;

3.2.3. "бүс нутаг" гэж аймаг, сум, нийслэл, дүүрэг, хот, тосгоны хоорондын нийгэм, эдийн засгийн харилцаа холбоо, тусгай хамгаалалттай газар нутаг, тэдгээрийн орчны бүс, хүн амын нутагшилт, хөдөө аж ахуй, аялал жуулчлал болон аж ахуйн бусад салбар /салбар хоорондын/-ын уялдаа холбооны орон зайн хөгжил. байршлын хүрээг хамарсан Монгол Улсын нутаг дэвсгэрийн тодорхой хэсэг буюу эдийн засаг, нийгмийн цогцолборыг;

3.3. Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын зорилго, зорилтыг эдийн засгийн бүс, бүс нутаг, хот-хөдөөгийн хөгжлийн нэгдмэл тогтолцооны хүрээнд хэрэгжүүлэх зайлшгүй шаардлага нь байгаль орчны даац, чадавх, түүнд зохицуулан нүүдлийн аж ахуй, соёлын өв уламжлалыг хадгалан хөгжүүлэх үндэсний хэрэгцээ, хот суурин, дэд бүтцийн оновчтой суљжээнд үндэслэн орчин үеийн соёл, иргэншлийн олоотыг бүтээлчээр хөгжүүлэн нийгмийн дэвшлийг түргэтгэх, дэлхийн нийтлэг хандлага зэргийг хамтад нь бодолцсон Монгол Улсын тогтвортой хөгжлийн стратегиас урган гарч байна.

3.4. Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын зорилтыг хэрэгжүүлэхийн тулд улсын хэмжээнд, эдийн засгийн бүс, бүс нутаг, хот-хөдөөгийн хөгжлийн харилцан уялдсан нэгдмэл тогтолцоо, эдийн засгийн бүсүүдийн хэмжээнд, бүс нутаг, хот-хөдөөгийн хөгжлийн харьцангуй бие даасан тогтолцоог бүрдүүлэх шаардлагатай бөгөөд энэ үйл явцыг төрөөс нэгдсэн болон нутаг дэвсгэрийн ялгавартай бодлогоор дэмжин зохицуулна.

3.5. Бүсүүдийн хүрээнд эдийн засгийн бүс, бүс нутаг, хот-хөдөөгийн хөгжлийн харьцангуй бие даасан тогтолцоог бүрдүүлэхдээ, алслагдсан, говийн түүнчлэн сул хөгжилтэй бүс нутгийн хөгжлийг дэмжихийн хамт бүс нутгийн аж ахуйн бие даасан байдал, үндэсний эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангахад гол нөлөөтэй, хөгжлийн ирээдүй сайтай бүс нутаг, хот сууринг төрүүн эзэжинд сонгон хөгжүүлж, түүнд ойр байгаа бусад нутгийг татан оролцуулах чиглэл бариматлна.

3.6. Эдийн засгийн бүсүүдийн хуваарийг тогтоохдоо, **нэгдүгээрт:** аймаг, орон нутгийн хүн амын аж байдлын түвшний ялгаа. түүнийг жигдрүүлэх асуудлыг тухайн бүсийн хүрээнд шийдвэрлэх дотоод, гадаад зах зээлийн болон төрийн зохицуулалтын боломж, газар, түүний баялгийг хамгаалах, ашиглах зээмшил зохимжит чиг хандлага зэргийг бодолцсон нийгэм, экологийн хүчин зүйлсийн; **хоёрдугаарт:** аймаг, сум, аж ахуйн нэгж, байгууллага хоорондын хоршил холбооңд түшиглэн тухайн бүсийн хүн амын хэрэгцээг хангах, байгаль орчныг хамгаалах шаардлагад зохицон үйлдвэрлэл, үйлчилгээний зохистой бүтэц бүхий дотоод, гадаад зах зээлд өрсөлдөх чадвартай нэг

буюу хэд хэдэн бүтээгдэхүүнээр улсын хэмжээнд төрөлжсөн, бүс нутгийн аж ахуйн бие даасан цогцолборууд бүрдэх ирээдүйн төлөвийг баримжаалсан эдийн засаг, зэс үзэлийн хүчин зүйлсийн; **гуравдугаарт:** хот, тосгоны зэрэглэл тогтоох, тэдгээрийн дотроос хөдөөгийн хүн амын амьдралыг бүс нутгийн дотоод, гадаад орчинтой дэд бүтцийн сулжээгээр зохистой холбон зохион байгуулах боломжтой, ирээдүй сайтай байршсан хот, тосгоныг бүсийн, сум дундын буюу бүлэг суурингийн төв болгон сонгон хөгжүүлэх нөхцөлийг харгалзсан дэд бүтэц, хот байгуулалтын хүчин зүйлсийн аргуудыг хослон хэрэглэнэ.

3.7. Эдийн засгийн бүсчлэлийн хүрээнд эдийн засгийн бүс, бүс нутаг, хот-хөдөөгийн хөгжлийн нэгдмэл тогтолцоог бүрдүүлэх гол орчин нь Монгол Улсын хөгжлийн салбарын болон нутаг дэвсгэрийн зохион байгуулалт мөн.

3.8. Дэд бүтцийн хэвтээ, босоо тэнхлэгүүдийг нутаг дэвсгэрийн болон салбарын дараахь бүрдэл хэсгүүдтэй байхаар зохион байгуулахыг зохистой гэж үзнэ:

3.8.1. хэвтээ тэнхлэгийг аймаг, сум, нийслэл, дүүрэг, хот, тосгон, бүсийн төвүүд, худалдаа-эдийн засгийн чөлөөт бүсүүд, ашигт малтмал олборлолт, боловсруулалтын болон аялал жуулчлалын бүс нутгууд, түргэн хөгжих ирээдүйтэй бусад бүс нутаг, тэдгээрийг улс орны дотоод, гадаад зах зээлтэй холбосон эрчим хүч, зам харилцаа, орчин үеийн холбоо, мэдээлэл, бөөний худалдааны сулжээ хамарсан нутаг дэвсгэрийн бүрдэл хэсгүүдтэй;

3.8.2. босоо тэнхлэгийг хувийн хэвшилд түшиглэн зах зээлд өрсөлдөн тогтвортой хөгжих чадвар бүхий аж ахуйн нэгж, байгууллагын тогтолцоо, тэдгээрийн дотоод, гадаад хүрээний үйлдвэрлэл, үйлчилгээний технологийн дагналт, хоршилт, банк санхүү, удирдлага, төлөвлөлт, зохион байгуулалт, бүртгэл, мэдээлэл, тооцооллын урсгал, хүрээлэн байгаа орчны зохицолдоог хамарсан салбарын бүрдэл хэсгүүдтэй.

3.9. Эдийн засгийн бүс, бүс нутаг, хот-хөдөөгийн хөгжлийн харьцангуй бие даасан тогтолцоог өөр хооронд нь болон улмаар гадаад зах зээлтэй зохистой холбож, үндэсний болон бүс нутгийн аж ахуйн бие даасан байдлыг хангах явдлыг үндэсний аюулгүй байдлын чухал хүчин зүйл гэж үзнэ.

3.10. Үндэсний аюулгүй байдлыг хангах үүднээс эдийн засгийн бүс, бүс нутаг, хот-хөдөөгийн хөгжлийн тогтолцооны уялдаа холбоог дор дурдсан зарчимд нийцүүлэн зохион байгуулна:

3.10.1. эдийн засгийн бүсүүдийн тухайд, тухайн бүсийн улс орны эдийн засагт оруулах хувь нэмэр, тэрчлэн гадаад харилцааны боломжийг нэмэгдүүлэхэд оруулах хувь нэмрийг адил тэнцүү байлгах хандлагаар нутаг дэвсгэрийн хөгжлийн тэнцвэрийг хангах;

3.10.2. бүс нутгийн хувьд нутаг дэвсгэрийн болон салбар хоорондын уялдаа холбоог гүнзгийрүүлэх замаар эдийн засгийн тухайн бүсийн хүрээнд аймаг, нийслэлийн аж ахуйн бие даасан байдлыг дээшлүүлэх;

3.10.3. хүн амын нутагшилт, суурьшилтын олон төвтэй тогтолцоог бүрдүүлж, суурин бөлөн нүүдлийн амьдралын хэв маягийг оновчтой хослох.

3.11. Монгол Улсад бүс, бүс нутаг, хот байгуулалтын тогтолцоог өөр хооронд нь болон улс орны дотоод, гадаад орчинтой холбогч гол шижим нь дэд бүтцийн сулжээг өргөтгөн сайжруулах явдал мөн.

3.12. Дэд бүтцийн сулжээг өргөтгөн сайжруулахад дор дурдсан нөхцөлийг харгалзана:

3.12.1. эдийн засгийн бүсүүдийн хүрээгээр дотоод зах зээлд болон улс хооронд дамжин өнгөрөх ачаа урсгалын эрчим;

3.12.2. нээлттэй гадаад харилцаа өргөжихийн хэрээр иргэд бүсүүдийн хооронд болон дотоод, гадаадад зорчин явах хэрэгцээ;

3.12.3. дэлхийн хөгжингүй орнуудаас алслагдсан, далайд гарцгүй эх газрын байрлалтай, орон зайн саадыг гэтлэх өртөг зардал ихтэй, ачаа үүсэл, шингээлт багатай Монгол Улсын нөхцөлд агаарын тээврийг эрчимтэй хөгжүүлэх шаардлага;

3.12.4. эдийн засгийн хөгжлийн үр ашгийг дээшлүүлэх, улс хоорондын болон бүс нутаг хоорондын тогтвортой уялдаа холбоог хангахтай холбогдон төмөр замын сулжээг өргөтгөх хэрэгцээ:

3.12.5. гадаад орны тусламж, дэмжлэг, дотоодын хүч нөөцөд түшиглэн нийслэл, бүсийн төв, чөлөөт бүсүүдээр дамжуулан Монгол Улсын газар нутгийг олон улсын хамтын ажиллагааны бүс нутгуудтай холбож, үндэсний эдийн засгийн өсөлтийн хурдыг нэмэгдүүлэх боломж, орон нутгийг бага зардлаар холбож нутаг дэвсгэрийн дотоод тэнцвэрийг хангах шаардлага зэргийг харгалзан автотээврийн хөндлөн болон гол төмөр замын дагуух авто замыг тэргүүн ээлжинд сайжруулах шаардлага;

3.12.6. авто замын төрөл, чиглэл, үйлчлэх хүрээг сонгох нь бүс нутгийн байгаль цаг уурын өөрчлөлт, газар ашиглах, эзэмших чиг хандлага, байгалийн баялгийг хамтран ашиглах гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын сонирхолоос улам бүр хамаарч байгаа өнөөгийн нөхцөл байдал;

3.12.7. аймаг, бүс нутгийн аж ахуйн бие даасан байдал, тэдгээрийн хоорондын уялдаг сайжруулах, хүн амын шилжих хөдөлгөөнийг зохистой болгоход эрчим хүч, нийгмийн үйлчилгээний болон банк, санхүү, бөөний худалдаа, холбоо, мэдээллийн бүс нутгийн сүлжээг нэн түрүүнд байгуулах шаардлага;

3.12.8. олон улсын байгууллага, гадаад орны дэмжлэгээр Монгол Улсыг улс хоорондын ач холбогдолтой дэд бүтцийн сүлжээнд холбох явдлыг стратегийн ач холбогдолтой гэж үзэхийн хамт, ийнхүү холбогдсон тохиолдолд уг сүлжээний ашиглалтыг Монголын талаас хариуцах чадвар, үүрэг, хариуцлагыг дээшлүүлэх бололцоо, нөхцөл.

3.13. Нийслэл хот нь засаг захиргааны болон соёл, шинжлэх ухаан, мэдээллэл, гадаад харилцааны байгууллагууд зонхилон байрласан харьцангуй цөөн үүн амтай, экологийн эрүүл орчинтой, архитектурын зохиомж сайтай, нийгмийн харилцааны гол төв болохуйц зохистой байршилтай болж байгаа зэрэг орчин үеийн дэлхий нийтийн өөрчлөлтийн түгээмэл хандлагыг харгалзан Монгол Улсын нийслэлийн байршил, чиг үүргийг оновчтой тогтоох асуудлыг бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал хэрэгжих орчинтой холбон зохистой шийдвэрлэнэ.

3.14. Аймаг, нийслэл нь төрийн нэгдсэн бодлоготой уялдсан хүн амын амьдрах экологи, нийгмийн таатай орчныг бүрдүүлэх, зах зээлд өрсөлдөх чадвар бүхий үйлдвэрлэл, үйлчилгээг сонгон хөгжүүлэх, хот, дүүрэг, тосгон, сум, багийн хоорондын аж ахуйн хоршилт, дэд бүтцийн уялдааг хангах зэрэг бүс нутгийн хөгжлийн нийтлэг асуудлыг шийдвэрлэхэд орон нутгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, төрийн болон нутгийн захиргаа, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн хамтын хүч чармайлтыг нэгтгэн зохион байгуулах шаардлагатай бөгөөд энэ зорилгоор нутаг дэвсгэрээ /сум, дүүргээ/ бүсчлэн хөгжүүлэх явдлыг бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын бүрэлдэхүүн хэсэг гэж үзнэ.

3.15. Эдийн засгийн бүсчлэлийн хүрээнд эдийн засгийн бүс, бүс нутаг-хот байгуулалтын нэгдмэл тогтолцоо бүрэлдэж, улс үндэсний хөгжлийг түргэтгэх нутаг дэвсгэрийн зохион байгуулалтын дотоод, гадаад орчин сайжрахын хирээр аймаг, сум, нийслэл, дүүрэг, хот, тосгон хоорондын харилцаа холбоо бэхжих Монгол Улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн одоогийн байгууламжийг ардчилал, зах зээлийн нөхцөлд зохицуулан боловсронгуй болгож эхэлнэ.

3.16. Монгол Улс бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг дэвшүүлэхдээ эдийн засгийн бүсүүдээр дамжуулан аймаг, орон нутгийг гадаад зах зээлтэй холбон олон улсын хамтын ажиллагааны үр өгөөжийг нэмэгдүүлэхийг зорихын хамт, өргөн уудам газар нутаг, эрдсийн болон мал аж ахуйн гаралтай түүхий эдийн нөөц, хүн амын оюуны чадавх, биологийн төрөл зүйл, түүх соёлын өв сангаа тогтвортой хөгжлийн зорилгод зохистой ашиглах боломжтойгоо нээн харуулж, хүн төрөлхтний хөгжлийн нийтлэг сонирхол, хэрэгцээг хангахад өөрийн хувь нэмрээ оруулахыг эрмэлзэнэ.

Дөрөв. Бүсчилсэн хөгжлийг дэмжих төрийн зохицуулалт

4.1. Бүсчилсэн хөгжлийг төрөөс дэмжих бодлогын гол чиглэл нь Улаанбаатар, Дархан, Эрдэнэт хот, тэдгээрийн орчмын нутгийг ач ам, үйлдвэрлэл, үйлчилгээний хэт бөөгнөрөл, удирдлагын төвлөрөл, экологийн тэнцлийн алдагдлыг сааруулж, бүсүүдийн хөгжлийн түвшинг эрэмбэ дараатай дээшлүүлэх явдал юм.

4.2. Бодлогын гол чиглэлийг хэрэгжүүлэх үндэсн арга хэрэглүүр болгон Монгол Улсад эдийн засгийн Баруун, Хангайн, Төвийн, Зүүн гэсэн дөрвөн бүсийг тогтоож, Улаанбаатар хотыг бие даасан бүсийн жишээр хөгжүүлнэ.

4.3. Монгол Улсын эдийн засгийн бүс бүрд хамаарах аймгуудын ерөнхий хувааригч дарааҳь байдлаар тогтоож, хөгжлийн тухайн үеийн нөхцөл байдалтай уялдуулан уг хуваарийг үян хатан өөрчилж байна:

4.3.1. **баруун бүсэд:** Баян-Өлгий, Говь-Алтай, Завхан, Увс, Ховд;

4.3.2. **хангайн бүсэд:** Архангай, Баянхонгор, Булган, Орхон, Өвөрхангай, Хөвсгөл;

4.3.3. **төвийн бүсэд:** Говь-Сүмбэр, Дархан-Уул, Дорноговь, Дундговь, Өмнөговь, Сэлэнгэ, Төв;

4.3.4. **зүүн бүсэд:** Дорнод, Сүхбаатар, Хэнтий.

4.3.5. **Улаанбаатарын бүсэд:** нийслэл хот, түүний дүүргүүдийн нутаг дэвсгэр, хот орчмын бүсийн дагуул хотууд тус тус орно.

4.4. Монгол Улсын аймгууд нь байгаль орчны даац, хүн, малын байршил, эдийн засаг, нийгмийн зориптоороо харьцангуй ойролцоо шинж төлөвтэйг харгалзан эдийн засгийн бүсүүдэд аж ахуйн дараахь салбарыг нийтлэг байдлаар хөгжүүлнэ:

4.4.1. мал аж ахуй;

4.4.2. хөнгөн, хүнсний үйлдвэр;

4.4.3. уул уурхайн олборлох, боловсруулах үйлдвэр;

4.4.4. барилга, барилгын материалын үйлдвэр;

4.4.5. оюуны багтаамж ихтэй үйлдвэрлэл, үйлчилгээ;

4.4.6. аялал жуулчлал, амралт, рашаан сувилал;

4.4.7. үйлдвэрлэл, нийгмийн үйлчилгээний дэд бүтцийн салбарууд;

4.4.8. зах зээлийн дэд бүтцийн бүрдэл хэсгүүд.

4.5. Бүсүүдийн байгаль, түүний эдийн нөөц, оюуны чадавхийг харгалзан **баруун бүсэд:** бэлчээрийн мал аж ахуй, усалгаатай тариалан, жижиг, дунд боловсруулах үйлдвэрийг; **хангайн бүсэд:** бэлчээрийн мал аж ахуй, газар тариалан, аялал жуулчлал, амралт, сувилал, жижиг дунд үйлдвэр, уул уурхайн олборлох, боловсруулах үйлдвэр; мод боловсруулах үйлдвэрийг; **төвийн бүсэд:** бэлчээрийн болон эрчимжсэн мал аж ахуй, газар тариалан, уул уурхайн олборлох, боловсруулах үйлдвэр, жижиг, дунд үйлдвэр, аялал жуулчлал, амралт сувиллын үйлчилгээ, оюуны багтаамж ихтэй бусад үйлдвэрлэл, үйлчилгээг; **зүүн бүсэд:** уул уурхайн олборлох, боловсруулах үйлдвэр, эрчимжсэн газар тариалан, мал аж ахуй, жижиг, дунд үйлдвэр, аялал жуулчлалыг; **Улаанбаатарын бүсэд:** оюуны багтаамж ихтэй бүх төрлийн үйлдвэр, үйлчилгээ, олон улсын банк санхүүгийн сүлжээг тус тус тэргүүлэх чиглэл болгон хөгжүүлнэ.

4.6. Дэд бүтцийн босоо тэнхлэгүүдийг өмнөд- умардын, хэвтээ тэнхлэгийг өрнө- дорнын бүс нутгийн орнуудтай холбож олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлнэ.

4.7. Бүсчилсэн хөгжлийн зорилго, зорилтыг дараахь бодлогоор дэмжин хэрэгжүүлнэ:

4.7.1. **төрийн байгуулалтын хүрээнд:**.

4.7.1.а. бүсчилсэн хөгжлийг төрөөс дэмжих эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлэх;

4.7.1.б. бүсийн болон бүс нутгийн хөгжлийн стратегийг тодорхойлж, тэдгээрийг хэрэгжүүлэх төлөвлөлт, удирдлага, зохион байгуулалтын тогтолцоог боловсронгуй болгох;

4.7.1.в. бүсийн хөгжлийг төсөв, татвар, хөрөнгө оруулалт, мөнгө зээлийн бодлогоор дэмжих;

4.7.1.г. бүс нутагт банк, санхүү, даатгалын тогтолцоог бүрдүүлэх;

4.7.1.д. бүс нутгийн хөгжлийг дэмжих үйл ажиллагааг аж ахуйн нэгж, байгууллага, иргэд, гадаадын хөрөнгө оруулагчдын оролцоог дэмжин урамшуулах;

4.7.1.е. бүс нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжлийн нийтлэг зорилтыг шийдвэрлэхэд аймаг, нийслэл, хот, тосгоны хамтын ажиллагааг өргөжүүлэх;

4.7.1.ж. бүсчилсэн хөгжлийн асуудлаар төв, орон нутгийн төрийн захиргааны байгууллага хоорондын ажлын уялдаа, харилцан мэдээлэл, зохицуулалтыг хангах;

4.7.1.з. бүс нутаг, хот байгуулалтын судалгаа, шинжилгээ, сургалт, сурталчилгааны ажлыг хөхүүлэн дэмжих;

4.7.1.и. бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал хэрэгжих орчинтой уялдуулан засаг захиргаа нутаг дэвсгэрийн байгууламжийг боловсронгуй болгох;

4.7.2. **эдийн засгийн байгуулалтын хүрээнд:**

4.7.2.а. бүс нутгийн байгаль орчны даац, чадавхийг бүрэн зохистой ашиглах, орон нутгийн хүн амын хөдөлмөрийн дадлага, чадварыг дээшлүүлэх шаардлагад зохицсон жижиг, дунд үйлдвэрлэлийн суурийг бүрдүүлэх;

4.7.2.б. дэлхийн зах зээлийн болон дотоодын хэрэгцээг харгалзан бүсүүдийн хүрээнд импортыг орлох, гадаад зах зээлд өрсөлдөх чадвар бүхий олон улсын стандартад нийцсэн, экологийн хувьд цэвэр бүтээгдэхүүн, ажил,

үйлчилгээг дэмжин хөгжүүлэх;

4.7.2.в. алслагдсан, говийн түүнчлэн сул хөгжилтэй бүс нутгийг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх;

4.7.2.г. тухайн бүсийн хүрээнд аймаг, нийслэл, хот, тосгоны хоорондын, салбар хоорондын аж ахуйн хоршилт, хослолыг дэмжин хөгжүүлэх;

4.7.2.д. сумын хөгжлийн хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх;

4.7.2.е. бүсүүдэд дотоод, гадаадын аж ахуйн нэгж, байгууллага шинээр байгуулах буюу өөрийн салбар, нэгжээ байгуулж ажиллахыг хөхүүлэн дэмжих;

4.7.2.ж. бүсийн төвүүдийг хооронд нь болон бусад хот, тосгонтой холбосон эрчим хүч, зам барилга, холбоо, мэдээллийн технологийн дэд бүтэц, сум дундын бөөний худалдааны сүлжээ байгуулах ажлыг төрөөс дэмжих;

4.7.2.з. бүсүүдийг хооронд нь болон гадаад улс орнуудтай холбосон хөндлөн гол зам барьж байгуулах үндэсний хөдөлгөөн өрнүүлэх;

4.7.3. **байгаль орчныг хамгаалах хүрээнд:**

4.7.3.а. нийгмийн хөгжлийг байгаль орчны даац чадавхтай тэнцэлтэй уялдуулахад чухал ач холбогдол бүхий бүсийн болон бүс нутгийн төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх;

4.7.3.б. уур амьсгалын өөрчлөлт, цөлжилт, байгалийн гамшгийн болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх, тэдгээрийн үр дагаврыг арилгахтай холбогдсон хяналт, мэдээлэл, тусламжийн бүс нутгийн сүлжээ бүрдүүлэх;

4.7.3.в. байгалийн баялгийг нөхөн сэргээх, хүн амын амьдрах орчны аюулгүй байдлыг хангахтай холбогдсон аймаг, сум дундын ач холбогдол бүхий нийтлэг арга хэмжээг санхүүжүүлэх нэмэлт эх үүсвэрийг бий болгох асуудлыг судлан шийдвэрлэх;

4.7.3.г. бүс нутгийн байгалийн баялгийн нөөцийг хэмнэлттэй ашиглах, нөхөн сэргээх, амьдрах орчинд хал багатай дэвшилтэт арга технологи-нэвтрүүлэх. шилжүүлэх үйл ажиллагааг дэмжин урамшуулах;

4.7.3.д. тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийг бүс нутаг, хот, тосгоны хөгжлийн чиг хандлагатай уялдуулан боловсронгуй болгох;

4.7.3.е. бүсийн хүрээнд байгалийн баялгийн нөөц ашигласны эцсийн үр өгөөжийг бүс нутаг бүрийн байгалийн нөөцийн хүрэлцээ, газрын үржил шим, зах зээлийн байрлалаас хамааралгүйгээр тухайн бүсийн аймаг, сумд адил тэнцүү хүртэх орлого хуваарилалтын зохистой тогтолцоог бүрдүүлэх;

4.7.3.ж. бүс нутгийн хөгжлийн асуудлыг байгаль орчны даац, нөөц баялгийн экологи-эдийн засгийн үнэлгээ, төлбөр, тооцооны үндсэн дээр шийдвэрлэх чадвар бүхий бүсийн байгаль орчны төлөвлөлт, удирдлагын бие даасан тогтолцоог бүрдүүлэх;

4.7.3.з. бүсийн хүрээнд тодорхой газар нутгийг гадаадын сонирхогч улс орон, гадаадын хөрөнгө оруулагчдад гэрээний үндсэн дээр урт хугацаагар түрээслэн ашиглуулж байгаль орчин, хөгжлийн асуудлыг иж бүрэн шийдвэрлэх нөхцөлийг хангах;

4.7.4. **нийгэм, соёлын хүрээнд:** .

4.7.4.а. бүсүүдэд их сургууль, коллежийн салбар, судалгаа, мэдээллийн болон сургалтын төвүүд байгуулахыг дэмжиж тухайн бүс нутгийн хөгжлийн чиглэлтэй уялдсан боловсрол, шинжлэх ухааны шинэ хэв шинж бүхий тогтолцоо бүрдүүлэх;

4.7.4.б. оношлогоо, эмчилгээний бүсийн болон бүс нутгийн төрөлжсөн төвүүдийг байгуулахын хамт, сум дундын эмнэлгийн үйлчилгээний чанар, хүртээмжийг дэзшлүүлэхэд чиглэсэн эдийн засгийн хөшүүргийг боловсруулж хэрэгжүүлэх;

4.7.4.в. хөдөөгийн хүн амын ядуурлыг бууруулах, ажил эрхлэлтийг дэмжих сум дундын зориулалтын санхүүгийн механизм бий болгох, алслагдсан болон говийн бүс нутагт ажлын байр бий болгосон хөрөнгө оруулагчдыг татварын бодлогоор урамшуулах;

4.7.4.г. хүн амын амьжиргээны доод түвшин, нийгмийн даатгалын шимтгэлийг бүс нутгийн ялгавартай тогтоох;

4.7.4.д. алслагдсан болон говь нутагт ажиллаж байгаа төрийн албан хаагч, багш, эмч нарт цалин хөлсний нэмэгдэл урамшуулал олгох, амьдралын нөхцөлийг нь сайжруулах, тогтвор суурьшилтай аж төрөхөд нь дэмжлэг үзүүлэх;

4.7.4.е. хүн амын хүнсний хэрэглээний нормыг тогтоож, хүнсний хангамжийг сайжруулах, аюулгүй байдлыг хангах арга хэмжээг бүс нутгийн бодлогод тусган хэрэгжүүлэх;

4.7.4.ж. мэргэжлийн соёл, урлагийн байгууллагыг хот, хөдөөгийн хүн амд үйлчлэх төрөл, хүрээгээр нь бүсчлэн байгуулж, үндэстэн, угсаатны соёл, ёс заншлыг хадгалж өвлүүлэхийн хамт, үндэстэн хоорондын соёл, урлагийн харилцааг хөгжүүлэх таатай орчныг бүрдүүлэх;

4.7.4.з. тухайн бүсийн хүрээнд хот, хөдөөгийн хүн ам амьдрах арга ухаан, хөдөлмөрлөх дадлага, туршлагаа харилцан солилцох, уугуул нутгаа хөгжүүлэх талаар орон нутгийн байгууллага, төрийн бус байгууллагууд хамтран ажиллах явдлыг хөхүүлэн дэмжих.

4.7.5. **хүн амын нутагшил, хот байгуулалтын хүрээнд:**

4.7.5.а. бүс нутаг, хот-хөдөөгийн хөгжлийн нэгдмэл тогтолцоо бүрдүүлэх агуулгаар "Хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг" боловсруулж, шийдвэрлүүлэн хэрэгжүүлэх;

4.7.5.б. бүс нутгийн хөгжлийн үндсэн чиглэл, орон нутгийн байгаль, цаг уурын онцлог, хүн амын тоо, түүх, соёлын уламжлал, хот, хөдөөгийн хүн амд үйлчлэх хүрээ зэргийг харгалзан Монгол Улсын хот, тосгоны зохистой хэмжээ, бүтцийн загварыг боловсруулж, хот, тосгоныг үе шаттайгаар сэргээн хөгжүүлэх;

4.7.5.в. бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын зорилтыг хэрэгжүүлэх шаардлагын дагуу бүсийн төв болгон хөгжүүлэх хотуудын ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж, хэрэгжүүлэхэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх;

4.7.5.г. Улаанбаатарын болон бусад бүсийн хэмжээнд Улаанбаатар хотын хүн ам, үйлдвэрлэл, үйлчилгээний бөөгнөрлийг задлах зохистой чиглэл, хотын оршин суугчдын амьдрах орчны чанар, аюулгүй байдлыг хангах, хотын газрыг үр ашигтай ашиглах, инженерийн шугам сүлжээ, замын байгууламжийг шинэчлэх шаардлагыг бодолцон нийслэл хотын хөгжлийн стратеги, ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж, хэрэгжүүлэх үйл ажиллагаанд төр, иргэн, аж ахуйн нэгж байгууллагын хамтын хүч чармайлтыг нэгтгэн зохион байгуулах;

4.7.5.д. эрх зүй, эдийн засаг, нийгэм сэтгэл зүйн зохих нөхцөлийг бүрдүүлсний үндсэн дээр Монгол Улсын нийслэлийг Улаанбаатар хотоос тус улсын нутаг дэвсгэрийн төв хэсэгт шилжүүлэн байршуулах асуудлыг иж бүрнээр судалж 2020 он хүртлэх хугацаанд шийдвэрлэх;

4.7.5.е. улсын хэмжээнд эдийн засгийн бүсчлэл, хот байгуулалтын стратегийн удирдлага, төлөвлөлтийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлж, эдийн засгийн бүсүүдийн хэмжээнд, нутаг дэвсгэр зохион байгуулалтын товчоод байгуулах ажлыг дэмжих;

4.7.6. **гадаад хамтын ажиллагааны хүрээнд:**

4.7.6.а. Монгол Улсын нутаг дэвсгэрийг **зүүн бүсэд:** Чойбалсан-Эрээнцав, Чойбалсан-Сүмбэр-Рашаантын чиглэлээр Азийн орнуудын авто болон төмөр замын сүлжээнд холбож улмаар Зүүн хойт Азийн хамтын ажиллагааны "Түмэн гол" хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд идэвхтэй оролцож,Ази Номхон далайн орнуудтай харилцах гарц нээх; **төвийн бүсэд:** Алтанбулаг-Сүхбаатар-Улаанбаатар-Сайншанд-Замын үүдийн чиглэлээр Азийн авто болон төмөр замын олон улсын сүлжээнд холбожАзи-Европыг дамжсан улс хоорондын худалдаа-тээвэрийн харилцааны гол талбар болгох; **баруун бүсэд:** Цагаан нуур, Хандгайт, Арц суурь, Булган, Бургастайн чиглэлээр ОХУ, БНХАУ-ын худалдаа-эдийн засгийн сүлжээнд холбох зорилтыг үе шаттай хэрэгжүүлэх, цаашид Таван богдын

шилийн чиглэлээр улсын хөндлөн гол тэнхлэгийг Дундад Ази, Ойрхи Дорнодын орнуудтай холбох боломжийг судлах; **хангайн бүсэд:** Бага -Илэнх, Ханх, Тэшиг, Шивээ хүрэнгийн чиглэлээр ОХУ, БНХАУ-тай худалдаа, эдийн засгийн суурьшэнд холбогдох зорилтыг үе шаттайгаар хэрэгжүүлэх;

4.7.6.б. эхний ээлжинд ОХУ-тай хил залгаа "Алтанбулаг" /Сэлэнгэ аймаг/, "Цагааннуур" /Баян-Өлгий аймаг/, БНХАУ-тай хил залгаа "Замын-Үүд" /Дорноговь аймаг/ боомтод түшиглэн худалдаа, гаалийн тусгай /чөлөөт/ бүсүүд байгуулж, олон улсын жишгийн дагуу уг бүсүүдийн хүрээнд дотоод, гадаадын худалдаа эрхлэгчид, хөрөнгө оруулагчид хөрилцан ашигтай, хамтран ажиллах бизнесийн орчныг бүрдүүлэх, зохих түршлага бүрдмэгц Монгол Улсын нутаг дэвсгэрийн гүнд тусгай /чөлөөт/ бүсийг зохистой төрөл, чиглэлээр байгуулах ажлыг өргөжүүлэх;

4.7.6.в. өрнө, дорно, өмнөд, умардын орнуудтай төмөр замаар холбогдох асуудлыг сонирхогч улс орнуудын оролцоотойгоор хамтран судлах;

4.7.6.г. гадаадын сонирхогч орнууд болон гадаадын хөрөнгө оруулагчидтай хамтран Монгол Улсын тодорхой бүс нутгийг хөгжүүлэх иж бүрэн арга хэмжээний хөтөлбөр боловсруулж, түүнийг хэрэгжүүлэх хүрээнд олон улсын банк, санхүү, мэдээллэл, технологийн өндөр үр ашигтай тогтолцоог тогтвортой ашиглах нөхцөлийг бүрдүүлэх;

4.7.6.д. бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын зорилтын хэрэгжилтийг гадаад харилцааны олон сувгаржит бодлогоор дэмжих арга, хөшүүргийг тогтоож, дэлхийн хөгжингүй орнуудаас Монгол Улсад үзүүлж байгаа дэмжлэг, эдийн засгийн хамтын ажиллагааны боломжийг бүс нутгуудын хүрээнд өргөжүүлэн гүнзгийрүүлэх.

Тав. Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын зорилтыг хэрэгжүүлэх үе шат

5.1. Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын зорилго, зорилт нь дараахь үе шатыг дамжин хэрэгжинэ:

5.1.1. 2001-2005 он хүртэлх хугацаанд, эдийн засгийн бүсүүдээр бүс нутгийн хөгжлийг дэмжих эрх зүйн зохицуулалтыг бий болгож, бүсийн хөгжлийн тэргүүлэх чиглэлийг тогтоон, тэдгээрийг улс орны дотоод, гадаад зах зээлд холбох зорилго бүхий хөндлөн гол тэнхлэгийн авто зам буюу "Мянганы зам"-ыг байгуулж эхлэх ба гол төмөр замын дагуу тавьж байгаа хатуу хучилттай авто замыг үргэлжлүүлэн дуусгаж, түүнд хөжлийн ирээдүй сайтай зарим бүс нутаг, хот суурины холбох замаар бүсчилсэн хөгжлийн үндсийг тавина.

Алслагдсан, говийн түүнчлэн сул хөгжилтэй бүс нутгуудын нийгмийн дэвшлийг түргэтэх хөтөлбөр боловсруулж, хэрэгжилтийг дэмжин зохион байгуулна.

Газар зүйн байрлалын боломж, байгаль, эдийн засгийн чадавх сайтай бүс нутгуудыг сонгон тогтоож, үйлдвэрлэл, үйлчилгээний дэд бүтцийн нь хамт түргэн хурдацтай хөгжүүлэх зорилтыг хэрэгжүүлж эхэлнэ.

Бүсчилсэн хөгжлийн бодлогын хүрээнд сум, орон нутгийг хөгжүүлэх хөтөлбөр боловсруулж орон нутагт жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүлэх, хүн амын нийгэм, соёл, ахуйн үйлчилгээг сайжруулах, эрчим хүчний болон бөөний худалдааны суурьшэ байгуулах ажлыг дэмжин хэрэгжүүлж эхэлнэ.

5.1.2. 2010 он хүртэлх хугацаанд Мянганы зам байгуулах ажлыг эрчимтэй үргэлжлүүлэн бүсийн төвүүдийг хооронд нь холбож, тэдгээрийн зах зээлд сум, орон нутгууд хүн амын нийгэм, соёл, боловсролын үйлчилгээний зохистой хүрээгээр татагдан хөгжих орчныг бүрдүүлнэ. Бүсүүдийн хүрээнд аймаг, сум, хот, тосгоны хоорондын, салбар хоорондын банк, санхүү, технологийн болон удирдлагын мэдээллийн уялдаа холбоог сайжруулж, бүс нутгууд олон улсын худалдаа-эдийн засгийн хамтын ажиллагаанд биеэ даан оролцох зохистой чиглэлийг тогтоон хөгжүүлнэ;

5.1.3. 2010 оноос хойшхи 10 жилд бүсүүдийн хүрээнд бий болсон бүс нутаг хот байгуулалтын нэгдмэл тогтолцоо, бүс хоорондын болон улс хоорондын аж ахуйн хоршилт, дэд бүтцийн сүлжээнд үндэслэн аймаг, бүс нутгийн аж ахуйн бие даасан байдлыг дээшлүүлэх, бүс нутгийн эдийн засаг, нийгмийн тэнцвэрт хөгжлийг хангах, улмаар үндэсний эдийн засаг, нийгмийн дэвшлийг түргэтэгх нутаг дэвсгэрийн бүтэц зохион байгуулалтын дотоод, гадаад төөтай орчин бүрдэж эхэлнэ.

Монгол Улсын Их Хурлын 2001 оны 61 дүгээр тогтоолын хавсралт

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ ДЭГ

(Төгсгөл. Түрүүч нь "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн №27-д бий)

Хорь.Улсын төвлөрсөн төсвийн төслийг хэлэлцэж, батлах

20.1. Засгийн газраас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн улсын төвлөрсөн төсвийн төслийг Байнгын хороод эрхэлсэн асуудлынхаа хүрээнд салбарын төсвийн төслийн талаар нарийвчилсан задаргаа, мэдээ, судалгаа, тооцоо гаргуулан авч хянана. Шаардлагатай бол ажлын хэсэг байгуулан ажиллуулж, Байнгын хорооны дүгнэлтийг бэлтгэнэ.

20.2. Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанаар улсын төвлөрсөн төсвийн төслийг 4 үе шаттайгаар хэлэлцэж батална.

Нэг дэх хэлэлцүүлгээр улсын төвлөрсөн төсвийн төслийг хэлэлцэх үед Засгийн газрын гишүүд, төсвийн ерөнхийлөн захирагчид, төвлөрүүлэн захирагчдыг байлцуулан асуулт, хариулт явуулж, санал, шүүмжлэл гаргана. Төсвийн төслийн талаар гишүүд үг хэлж, санал гаргасны дараа төслийг зохих Байнгын хороонд шилжүүлнэ.

Хоёр дахь хэлэлцүүлгээр Улсын Их Хурлын бүх Байнгын хороо, нам, эвслийн бүлэг, Төсвийн зарлагын хяналтын дэд хороо санал, дүгнэлтээ, Улсын Их Хурлын гишүүд тусгай саналтай бол түүнийгээ бичгээр Төсвийн байнгын хороонд урьдчилан ирүүлнэ. Төсвийн байнгын хороо эдгээр саналыг нягтлан үзэж дүгнэлтдээ тусгана.

Улсын Их Хурлын Байнгын хороо, нам, эвслийн бүлэг, Төсвийн зарлагын дэд хорооны дүгнэлт, Улсын Их Хурлын гишүүний гаргасан тусгай саналыг Төсвийн байнгын хорооны дүгнэлтийн хамт Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанд сонсгоно. Санал, дүгнэлтийг сонссоны дараа гишүүд үг хэлж болно.

Гаргасан саналын дагуу санал хураалт явуулж, улсын төвлөрсөн төсвийн төслийг гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр зохих Байнгын хороонд шилжүүлнэ.

Гурав дахь хэлэлцүүлгээр Төсвийн байнгын хороо хөрдүгээр хэлэлцүүлгээр төсөлд орсон өөрчлөлтүүдийг тусгаж, танилцуулгын хамт Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанд оруулна. Хоёр дахь хэлэлцүүлгээр санал хурааж шийдвэрлэсэн асуудлаар Төсвийн байнгын хорооны саналаар Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанаар дахин санал хурааж болно.

Дөрөв дэх хэлэлцүүлгээр улсын төвлөрсөн төсвийн тухай хуулийн төслийг зүйл, заалт бүрээр хэлэлцэж батална.

Монгол Улсын тухайн жилийн төвлөрсөн төсвийн тухай хуулийн эцсийн найруулгыг Улсын Их Хурал сонсоно.

20.3. Улсын төвлөрсөн төсвийн төсөлд тодотгол хийх асуудлыг энэ журмын дагуу хэлэлцэн шийдвэрлэнэ.

20.4. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгасан хөрөнгө, санхүүгийн эх үүсвэр шаардсан асуудлыг хэлэлцэхдээ энэ журмын дагуу хэлэлцэж болно.

Хорин нэг.Төсөл хэлэлцэх, батлах үе шат

21.1. Улсын Их Хурлын төсөл хэлэлцэх, батлах үйл ажиллагаа дараахь үе шаттай хэрэгжинэ.

Нэгдүгээр үе шат:

1/ нам, эвслийн бүлэг, зохих Байнгын хорооны хуралдаанаар төслийг Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх эсэх тухай дүгнэлт гаргах;

2/ Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанаар төслийг хэлэлцэх эсэх тухай санал хураалт явуулах.

Хоёрдугаар үе шат:

1/ нам, эвслийн бүлэг, Байнгын хорооны хуралдаанаар төслийг хэлэлцэж дүгнэлт гаргах;

2/ Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанаар төслийн анхны хэлэлцүүлэг явуулах;

Гуравдугаар үе шат:

1/ анхны хэлэлцүүлгээр шийдвэрлэсэн асуудлыг тусгаж төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэх;

2/ Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанаар төслийн эцсийн хэлэлцүүлэг явуулах;

3/ төслийг батлах.

Дөрөвдүгээр үе шат:

1/ эцсийн хэлэлцүүлгээр шийдвэрлэсэн

асуудлыг түсгаж хууль, тогтоолын эцсийн найруулгыг бэлтгэх;

2/ Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанаар хууль, тогтоолын эцсийн найруулгатай танилцах;

3/ шийдвэрийг ёсчлох;

4/ Ерөнхийлөгч Улсын Их Хурлын шийдвэрт хориг тавьсан бол түхайн асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх.

21.2. Төсөл хянан хэлэлцэх явцад Улсын Их Хурал, эсхүл түүний Байнгын хороо ажлын хэсэг байгуулж болно.

21.3. Хууль санаачлагч нь зохих Байнгын хорооны хуралдаанаар эцсийн хэлэлцүүлэг хийхээс өмнө төслөө татан авч болно.

Хорин хоёр. Байнгын хороогоор төсөл урьдчилан хэлэлцэх

22.1. Төслийг зохих Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх бөгөөд Улсын Их Хурлын гишүүн харьяалагдах Байнгын хорооны хуралд таслах эрхтэй, бусад Байнгын хорооны хуралд таслах эрхгүйгээр оролцоно. Байнгын хорооны хуралд Улсын Их Хурлын гишүүн санал, дүгнэлт гаргах, саналаа хураалгах, тухайн асуудлаар цөөнх болж зарчмын зөрүүтэй саналаа Байнгын хорооны дүгнэлтэд тусгуулах эрхтэй.

22.2. Байнгын хорооны хуралдааны тухайн төслийн талаар хууль санаачлагчид асуулт тавьж, хариулт авч болно. Асуулт, хариулт үргэлжлэх хугацаагаар хуралдаан даргалагч тогтооно.

22.3. Хэрэв уг төслийг батласнаар тухайн санхүүгийн жилийн улсын төсвийн зарлагын хэмжээ нэмэгдэхээр байвал энэ тухай Засгийн газрын санал, дүгнэлтийг заавал сонсоно.

22.4. Байнгын хорооны хуралдааныг тухайн Байнгын хорооны дарга даргална. Төслийн талаар бусад Байнгын хороо, Улсын Их Хурлын гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй саналыг зохих Байнгын хороо дүгнэлтдээ хамтатган тусгана.

22.5. Төсөл хэлэлцэхэд биечлэн оролцох боломжгүй Улсын Их Хурлын гишүүн санал дүгнэлтээ зохих Байнгын хороонд бичгээр урьдчилан гаргаж өгөх бөгөөд түүнийг Байнгын хорооны хуралдааныг заавал танилцуулж хэлэлцүүлнэ.

22.6. Хэрэв Ерөнхийлөгч түхайн төсөлтэй холбогдуулан бичгээр санал ирүүлбэл түүнийг Байнгын хорооны хуралдааныг заавал танилцуулж хэлэлцүүлнэ.

22.7. Байнгын хорооны хуралдаанаар Улсын Их Хурлд өргөн мэдүүлсэн төслийг талаар санал хураалт явуулсны үндсэн дээр уг төслийг нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх шаардлагатай эсэх талаар дүгнэгт гаргаж, түүнийг нэгдсэн хуралдааны илтгэх гишүүнийг томилно.

Улсын Их Хурлын нэгдсэн хуралдааны хэлэлцэхээр шийдвэрлэсэн төслийг Байнгын хороо анхны хэлэлцүүлэгт бэлтгэн, төслийн талаар дүгнэлт гаргаж, түүнийг нэгдсэн хуралдааны илтгэх гишүүнийг томилно.

Байнгын хороо төслийг нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэхээр шийдвэрлэсэн дүгнэлттээ төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн дүгнэлттэй хамтатган гаргаж болно.

22.8. Төслийг зохих Байнгын хороодын хамтарсан хуралдаанаар хэлэлцэж болох бөгөөд нэгдсэн дүгнэлт гаргаж болно.Байнгын хороодын хамтарсан хуралдааны ирцийг тус хороодын нийт гишүүний олонхи нь ирснээр хүчин төгөлдөрт тооцож, асуудлыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонхийн саналаар шийдвэрлэнэ. Хэлэлцсэн асуудлаар тогтоол гаргавал Байнгын хороодын дарга нар хамтран гарын үсэг зурж ёсчилно.

22.9. Хэрэв нэг асуудлаар хоёр буюу түүнээс дээш төсөл байгаа бол хууль санаачлагчийн зөвшөөрснөөр зохих Байнгын хороо тэдгээрийг нэгтгэн зохицуулж, нэг төсөл болгон Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанд хэлэлцүүлж болно.

Хэд хэдэн төслийг нэгтгэхийг хууль санаачлагч зөвшөөрөөгүй бол Байнгын хороо тэдгээр төслийн талаар нэг бүрчлэн дүгнэлт гаргана.

Хууль санаачлагчийн зөвшөөрөлгүйгээр төсөлд нэмэлт, өөрчлөлт оруулж болохгүй.

22.10. Хууль санаачлагч, зохих Байнгын хороо болон бусад Байнгын хороо зарчмын зөрүүтэй саналаар зөвшилцөлд хүрэхийн тулд шинжээч томилон дүгнэлт гаргуулах, Засгийн газрын холбогдох гишүүний болон бусад албан тушаалтны санал сонсох зэргээр ажиллаж болно.

22.11. Төслийн анхны хэлэлцүүлгийн явцад Байнгын хорооноор дэмжигдсэн гишүүний санал нь бусад хуульд өөрчлөлт оруулахаар бол өөрчлөлт оруулах хуулийн төслийг уг санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн санаачлан боловсруулж хамтад нь хэлэлцүүлж болно.

22.12. Байгнын хорооны хуралдаанд хуралдах хуваарьгүй үед Байгнын хорооны хуралдаанаар зайлшгүй хэлэлцэх яаралтай асуудал гарвал түүний талаар тухайн Байгнын хорооны гишүүдээс бичгээр санал авч болно. Харин Байгнын хорооны хуралдааны хуваарьтай үед бичгээр санал авахыг хориглоно.

Хорин гурав. Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанаар төсөл хэлэлцэх

23.1. Улсын Их Хурал Үндсэн хуулийн хорин зургадугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан хууль санаачлагчаас өргөн мэдүүлж, чуулганы хуралдаанаар хэлэлцэхээр шийдвэрлэж, хэлэлцэх асуудлын төлөвлөгөөнд оруулан батална төслийг хэлэлцэнэ.

23.2. Ерөнхийлөгчийн хориг, Ерөнхийлөгчөөс Улсын Их Хуралд хандаж гаргасан илгээлт, Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт, Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын ажлын дүн, тайлан сонсох, түүний удирдлагыг томилох, чөлөөлөх, Монгол Улсын олон улсын гэрээг соёрхон батлахаас бусад асуудлаар чуулганы хуралдааны хэлэлцэх асуудлын төлөвлөгөөнд ороогүй төслийг Улсын Их Хурлаар хэлэлцүүлэхээр тухайн чуулганы явцад өргөн мэдүүлбэл Төрийн байгуулалтын байнгын хороо, зохих Байнгын хорооны дүгнэлтийг харгалзан түүнийг чуулганаар хэлэлцэх эсэхийг Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанд оролцсон нийт гишүүний олонхийн саналаар шийдвэрлэнэ.

23.3. Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн төслийг чуулганы хуралдаанаар хэлэлцэх, эсхүл буцаах асуудлыг шийдвэрлэхдээ:

23.3.1. төслийн талаар хууль санаачлагчийн илтгэлийг сонсоно. Илтгэлтэй холбогдуулж гишүүд асуулт асууж, хариулт авч болно;

23.3.2. Байгнын хороо, нам, эвслийн бүлгийн дүгнэлтийг сонсоно;

23.3.3. төслийг чуулганы хуралдаанаар хэлэлцэх эсэх талаар санал хураалт явуулна;

23.3.4. хэрэв энэ дэгийн 22.9-д заасны дагуу хэд хэдэн төслийн талаар Байгнын хорооноос нэг бүрчлэн дүгнэлт гаргасан бол аль төслийг нь сонгон анхны хэлэлцүүлэгт оруулах тухай санал хураалт явуулна.

Төслийг Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх шаардлагагүй гэж үзвэл төслийг буцаах тогтоол батална. Уг тогтоолд төслийг буцаах болсон үндэслэлийг заасан байвал зохино.

23.4. Чуулганаар хэлэлцэхээр тогтсон төслийг дүгнэлт, холбогдох бусад баримт бичгийн хамт Улсын Их Хурлын гишүүдэд уг төсөл хэлэлцэх эхлэхээс долоо хоногийн өмнө зохих Байгнын хороо эрхлэн тараана. Төсөл оллурулах, тараах ажлыг Улсын Их Хурлын Тамгын газар /цаашид "Тамгын газар" гэх/ эрхэлнэ.

23.5.Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулахдаа дараахь журмыг баримтална:

23.5.1. зохих Байгнын хорооны дүгнэлтийг танилцуулах хугацаа 15 минутаас илүүгүй байна. Дүгнэлтэд уг төслийн үзэл баримтлал төрийн бодлогод нийцэж байгаа эсэх, төсөл хууль тогтоомжийн бичлэгийн техник, хэл зүйн шаардлагыг хангасан эсэх болон төслийн зүйл, заалтын талаар зарчмын өөр саналтай бол үндэслэл, шалтгааныг заана.

Зохих Байгнын хороо төсөлд оруулах нэмэлт, өөрчлөлт болон Улсын Их Хурлын гишүүний зарчмын зөрүүтэй саналыг томъёолж бүх гишүүдэд тараасан байна;

23.5.2. Байгнын хорооны дүгнэлтийн дараа Улсын Их Хурал дахь нам, эвслийн бүлгийн дүгнэлтийг сонсоно. Дүгнэлтийг бүлгийн ахлагч, эсхүл тухайн асуудлыг хариуцаж байгаа бүлгийн аль нэг гишүүн танилцуулна.

Нам, эвслийн бүлгийн дүгнэлтийг танилцуулах хугацаа тус бүр 10 минутаас илүүгүй байна.

Улсын Их Хурлын гишүүн хэлэлцэж байгаа асуудлаар үг хэлэх, тайлбар хийхдээ энэ дэгийн 1.3.2-т заасан хугацааг баримтлах бөгөөд санал, дүгнэлтээ Байгнын хорооны болон нам, эвслийн бүлгийн дүгнэлтэд тусгуулж урьдчилан тараасан байна;

23.5.3. төслийн талаар гарсан зарчмын зөрүүтэй санал гэдэгт:

а/ Байгнын хорооноос санал нэгтэй буюу олонхийн саналаар оруулахаар шийдвэрлэсэн төсөлд тусгагдаагүй санал;

б/ зохих Байгнын хорооны хуралдаанаар хэлэлцэж зөвшилцөлд хүрээгүй Улсын Их Хурлын гишүүний санал;

в/ Улсын Их Хурал дахь олонхи, цөөнхийн нам, эвслийн бүлгээс зарчмын гэж үзэж дүгнэлтдээ тусгасан саналыг ойлгоно.

Зарчмын зөрүүтэй санал гаргасан гишүүд уг саналынхаа талаар тайлбар хэлж болох бөгөөд түүнийг дэмжсэн болон эсрэг саналтай тус бүр нэг гишүүн үг хэлж болно;

23.5.4. Улсын Их Хурлын гишүүн Байгын хорооны дүгнэлтэд тусгуулсан зарчмын зөрүүтэй саналаа бичгээр томъёолж урьдчилан өгсөн байна. Харин найруулгын чанартай засварыг ажлын хэсэгт өгнө.

Зарчмын зөрүүтэй саналуудыг нэгтгэж хуралдаан даргалагчид бэлтгэн өгөх асуудлыг Тамгын газар хариуцна;

23.5.5. хуралдаан даргалагч зарчмын зөрүүтэй асуудал бүрээр санал хураалгана. Тэгэхдээ зарчмын зөрүүтэй асуудлыг ямар хувилбараар шийдвэрлэх саналтай байгаа, эсхүл уг асуудлаарх төслийн заалтыг дахин гүйцэн боловсруулж саналыг сонсохын аль нэгээр хэлэлцүүлж, гишүүдийн олонхийн саналаар шийдвэрлэнэ;

23.5.6. хэрэв Ерөнхийлөгч хэлэлцэж байгаа төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлд илгээлт, санал ирүүлсэн бол түүнийг Улсын Их Хурлын гишүүдэд урьдчилан тараж танилцуулсан байна. Ерөнхийлөгчийн саналыг санал хураалт явуулж шийдвэрлэнэ.

Хуралдаан даргалагч зарчмын зөрүүтэй асуудлаар санал хураалгахдаа санал хураах цагийг тогтоож, нийт гишүүдэд зарлаж болно. Хэрэв санал хураах цагийг товлон зарласан бол Улсын Их Хурлын гишүүн өөрийн биеэр хүрэлцэн ирж санал хураалтад оролцоно;

23.6. Улсын Их Хурлын гишүүн нь зөвхөн хэлэлцэж байгаа асуудалтай холбоотой горимын санал гаргах хүсэлт тавьж болно. Хуралдаан даргалагч горимын саналыг сонсож, шаардлагатай бол түүгээр санал хураалгана.

23.7. Зарчмын зөрүүтэй асуудлаар санал хураасны дараа дараахь шийдвэрийн аль нэгийг санал хураж шийдвэрлэнэ:

а/ төслийг бүхэлд нь эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэх;

б/ төслийг хууль санаачлагчид буцаах. Энэ тохиолдолд Улсын Их Хурал төслийг хууль санаачлагчид буцаах тогтоол батална.

23.8. Анхны хэлэлцүүлгийн явцад төслийн талаар зарчмын зөрүүтэй санал гараагүй түүнчлэн уг төслийг батлах санал гарсан бол түүний эцсийн хэлэлцүүлгийг шууд явуулж болно.

23.9. Улсын Их Хурал төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр зохих Байнгын хороонд шилжүүлэхдээ дэмжигдсэн саналын дагуу төслийг зарчмын хувьд өөрчлөх, найруулах үүрэг бүхий Улсын Их Хурлын болон хууль санаачлагчийн хамтарсан ажлын хэсэг байгуулж болно.

23.10. Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэж, хэлэлцүүлэхээр оруулах хугацаог төсөл боловсруулах ажлын хэмжээ, шаардлагыг харгалзан хуралдаан даргалагч тогтооно.

23.11. Анхны хэлэлцүүлгээр шийдвэрлэсэн асуудлыг төсөлд тусгаж эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэх ажлыг дараахь үе шаттай хэрэгжүүлнэ:

23.11.1. төслийг хууль санаачлагч, зохих Байнгын хороо хариуцаж ажлын хэсэгт эцэслэн боловсруулна;

23.11.2. төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэн дүгнэлт гаргасан зохих Байнгын хороо анхны хэлэлцүүлгээр шийдвэрлэсэн байдлыг үндэслэн Улсын Их Хурлын гишүүний болон хууль санаачлагчийн томъёолж өгсөн санал бүрийг хянан үзэж төсөлд зохих нэмэлт, өөрчлөлт оруулж, хууль тогтоомжийн бичлэгийн техник, хэл зүй, найруулгын талаас нь нягтлан зохих танилцуулга бэлтгэнэ.

23.11.3. хэрэв Ерөнхийлөгч тухайн төслийн анхны хэлэлцүүлгээр шийдвэрлэсэн асуудалтай холбогдуулан санал бичгээр ирүүлбэл зохих Байнгын хороо хэлэлцэж, энэ тухай танилцуулгадаа тусгана.

23.12. Төслийн эцсийн хэлэлцүүлэг явуулахдаа дараахь жүрмыг бариманлна:

23.12.1. төслийн талаар зохих Байнгын хорооны танилцуулга хийх хугацаа 10 минутаас илүүгүй байна;

23.12.2. зохих Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан асуулт, хариулт явуулж болно;

23.12.3. эцсийн хэлэлцүүлгийн явцад дараахь асуудлаар санал хураж болно:

а/ энхий хэлэлцүүлгийн үед гүйцэн боловсруулахаар шийдвэрлэсэн төслийн зүйл, заалт байгаа бол;

б/ энхий хэлэлцүүлгээр санал хурааж шийдвэрлэсэн боловч уг асуудлаар дахин санал хураах шаардлагатай гэсэн зохих Байнгын хорооны саналыг чуулганы хуралдаанд оролцон гишүүдийн гуравны нэг нь дэмжсэн бол;

в/ төслийн аль нэг зүйл, заалт хүчин төгөлдөр дагаж мөрдөж байгаа хууль болон уг төслийн бусад зүйл, заалттай зөрчилдөж байна гэж

зохих Байгын хороо болон Хууль зүйн байгын хороо үзсэн бол дээрх асуудал тус бүрээр санал хураж шийдвэрлэнэ;

23.12.4. санал хураалгахын өмнө тухайн саналыг гаргасан Улсын Их Хурлын гишүүн, тайлбар өгөх буюу үг хэлж болно. Тайлбар өгч, үг хэлсэн хүмүүстэй ижил тооны гишүүд хуралдаан даргалагчийн зөвшөөрснөөр дээрх саналын эсрэг үг хэлж болно;

23.12.5. эцсийн хэлэлцүүлэг дууссаны дараа төслийг бүхэлд нь батална. Төслийг бүхэлд нь батлах санал хураалтын цагийг хуралдаан даргалагч товлон зарлаж болно.

Хэрэв төслийг бүхэлд нь батлаагүй бол төслийг хууль санаачлагчид буцаана.

23.13. Шаардлагатай гэж үзвэл эцсийн хэлэлцүүлгээр батална.

23.14. Эцсийн хэлэлцүүлгээр батална хууль, тогтоолын эцсийн найруулгыг хэлэлцүүлэг дуусснаас хойш ажлын 6 өдрөт багтаан Улсын Их Хуралд танилцуулна. Эцсийн найруулгыг танилцуулах ажлыг Ерөнхий нарийн бичгийн дарга хариуцна.

Хорин дөрөв. Байгын хорооны хуралдаанд санал хураалт явуулах журам

24.1. Байгын хорооны хуралдаанд санал хураалт явуулахаа төслийн томъёоллоор санал хураалт явуулна. Энэ тохиолдолд Ерөнхийлөгч, нам, эвслийн бүлэг, Улсын Их Хурлын гишүүний саргасан санал хажуугийн саналд тооцогдоно.

24.2. Байгын хорооны хуралдаанаар тухайн асуудлаар санал хураалт явуулсны дараа цөөнх болсон, эсхүл цөөнхийг төлөөлсөн 3 хүртэл гишүүн тайлбар хэлж болно. Хэрэв цөөнх дахин санал хураалгахыг хүсвэл эхний санал хураалтаар олонхийн дэмжлэг авсан саналын томъёоллоор дахин санал хураалт явуулна.

Эхний 2 санал хураалтад нэг томъёолол 2 удаа олонхийн дэмжлэг авсан бол уг томъёоллыг тухайн Байгын хорооны саналд тооцно.

Хэрэв эхний санал хураалтад олонхийн дэмжлэг авсан томъёолол 2 дахь санал хураалтад олонхийн дэмжлэг авч чадаагүй бол 2 дахь санал хураалтад цөөнх болсон, эсхүл цөөнхийг төлөөлсөн 3 хүртэл гишүүн тайлбар хэлж болно.

Хэрэв цөөнх дахин санал хураалгахыг хүсвэл 2 дахь санал хураалтаар дэмжигдсэн саналын томъёоллоор дахин нэг удаа санал хураалт явуулж, олонхийн санал авсан томъёоллыг тухайн Байгын хорооны саналд тооцно.

24.3. Санал тэнцвэл дахин нэг удаа санал хураалгана.Хэрэв санал дахин тэнцвэл хуралдаан даргалагч хоёр талаас тус бүр нэг гишүүний тайлбарыг сонсгоно. Санал дахин тэнцвэл төслийн томъёоллыг Байгын хороо дэмжсэнд тооцно.

Хорин тав.Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанд санал хураалт явуулах журам

25.1. Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанд төслийн талаар санал хураалт явуулахдаа Байгын хорооны гишүүдийн олонхийн дэмжлэг авсан зарчмын зөрүүтэй саналыг уг саналын томъёоллоор, харин Байгын хорооноос олонхийн дэмжлэг аваагүй саналыг төслийн томъёоллоор санал хураалгана.

Санал хураалгахын өмнө зарчмын зөрүүтэй санал гаргасан гишүүд уг саналынхаа талаар тайлбар хэлж болох бөгөөд түүнийг дэмжсэн болон эсрэг саналтай тус бүр нэг гишүүн үг хэлж болно.

25.2. Үндсэн хууль, бусад хууль болон энэ дэгд өөрөөр заагаагүй бол Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанд санал хураалт явуулахдаа хуралдаанд оролцсон нийт гишүүний олонхийн саналаар уг асуудлыг шийдвэрлэнэ.

Үндсэн хууль, бусад хуулыг нууц санал хураалт явуулж шийдвэрлэхээр зааснаас бусад тохиолдолд санал хураалтыг илээр явуулна. Ил санал хураалтыг гар өргөж, эсхүл цахим тоолуураар, харин нууц санал хураалтыг санал хураах хуудсаар, эсхүл цахим тоолуур ашиглан явуулна.

25.3. Улсын Их Хурлын гишүүн тухайн өдрийн нэгдсэн хуралдаанд ирцээ бүртгүүлсэн бол хүндэтгэн үзэх шалтгаантайгаас бусад тохиолдолд санал хураахад заавал оролцоно. Хууль заасан журмын дагуу санал хураах нэгэнт батлагдсан хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийг санал хураах үед байгаагүй гэсэн шалтгаанаар Улсын Их Хурлын гишүүн дахин хэлэлцүүлэх эрх эдлэхгүй.

25.4. Улсын Их Хурлын гишүүн зөвхөн "зөвшөөрсөн", "татгалзсан" гэсэн 2 саналын аль нэгийг өгнө. Хуралдаанд оролцож байгаа боловч санал өгөхгүй байгаа гишүүнийг татгалзаж байгаад тооцно.

25.5. Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаан дээр Улсын Их Хурлын гишүүн хүний санал хураалгаж байгаа асуудлаар нэрээр нэг удаа санал өгнө.

25.6. Улсын Их Хурлын гишүүн дараахь тохиолдолд санал хураалтанд таслах эрхтэй оролцохгүй:

25.6.1. өөрийг нь Улсын Их Хурлын дарга, дэд дарга, Байнгын болон дэд хорооны дарга, Засгийн газрын гишүүнд нэр дэвшүүлж сонгох санал хураалт;

25.6.2. өөрийнх нь харьяалагдагуй, зөвлөх эрхтэй оролцок байгаа Байнгын хорооны хуралдааны санал хураалт ;

25.6.3. өөрийнх нь бүрэн эрхийг түдгэлзүүлэх, гишүүнээс чөлөөлөх, эгүүлэн татах эсэх асуудлаар хуваах санал хураалт;

25.6.4. өөрийг нь гэмт хэрэгт холбогдсон эсэх асуудлыг шалгах зөвшөөрлийг эрх бүхий байгууллагад олгох асуудлаар хураах санал хураалт;

25.6.5. холбогдох байгууллагад өөрийг нь сэжигтнээр албадан саатуулах, сэжигтнээр болон яг сонгосноы дараа цагдан хорих, өөрт нь шүүхийн хүрмаар захиргааны шийтгэл ногдуулах, гэр, албан өрөө, биед нь нэгжлэг хийхийг зөвшөөрөх эсэх асуудлаар явуулах санал хураалт;

25.6.6. Засгийн газрын бүрэлдэхүүнд оруулсан Улсын Их Хурлын гишүүн нь Засгийн газарт итгэл хүлээлгэх, түүнийг огцруулах асуудлаар явуулах санал хураалт.

Хорин зургаа. Улсын Их Хурлын шийдвэрийг ёсчлох, нийтлэх, мэдээлэх

26.1. Улсын Их Хурал хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн эцсийн найруулгатай танилцсанаас хойш ажлын 3 өдрийн дотор Улсын Их Хурлын дарга уг шийдвэрт гарын үсэг зурж ёсчилно.

26.2. Улсын Их Хурлын шийдвэрийг ёсчилсноос хойш 24 цагийн дотор Ерөнхийлөгчид илгээнэ.

26.3. Улсын Их Хурал өөр хугацаа тогтоогоогүй бол шийдвэрийг ёсчилж илгээснээс хойш Ерөнхийлөгч ажлын 5 өдөрт багтаан тухайн хууль, бусад шийдвэрт бухэлд нь буюу зарим хэсэгт нь хориг тавьсан бол түүнийг хэлэлцэх асуудлын дараалал харгалзахгүйгээр тэргүүн ээлжинд хэлэлцэж чуулганы хуралдаанд оролцон гишүүдийн гуразны хоёр нь хоригийг хүлээн зөвшөөрөөгүй бол Улсын Их Хурлын тухайн шийдвэр хэвээр үлдэнэ.

26.4. Ерөнхийлөгч Улсын Их Хурлын чуулган ажлаа дууссаны дараа Улсын Их Хурлын шийдвэрт хориг тавьсан бол Улсын Их Хурал ээлжит бус чуулганаар хэлэлцэн шийдвэрлэж болно. Ерөнхийлөгчийн хоригийг Улсын Их Хурлын ээлжит бус чуулганаар хэлэлцэн шийдвэрлээгүй бол дараагийн ээлхит чуулганаар эхний ээлжинд хэлэлцэн шийдвэрлэнэ.

26.5. Улс сронд онцгой нөхцөл байдал бий болсон, эсхүл Улсын Их Хурлын чуулганы ажиллагаа өндөрлөх гэж байгааг харгалзан Ерөнхийлөгчийн хориг тавих хугацааг Улсын Их Хурал тогтоон өгч болно.

26.6. Улсын Их Хурлын тухайн шийдвэрт өөрөөр заагаагүй бол уг шийдвэр албан ёсоор нийтлэгдсэнээс хойш 10 хоногийн дараа хүчин төгөлдөр болно.

26.7. Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийг "Төрийн мэдээлэл" эмхтгэлд албан ёсоор нийтэлнэ.

26.8. Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийг хэвлэн, мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлэхдээ "Төрийн мэдээлэл" эмхтгэлд нийтэлсэн албан ёсны эхийг баримтлах бөгөөд иинхүү дамжуулан нийтэлснийг албан ёсны бус гэж үзнэ.

26.9. Улсын Их Хурлын чуулганы явцын тухай олон нийтэд сонордуулах албан ёсны мэдээллийг зөвхөн Тамгын газар хариуцан нийтлүүлнэ.

26.10. Улсын Их Хурлын чуулганы хуралдааны тэмдэглэлийг Улсын Их Хурлын номын санд тавина.

26.11. "Төрийн мэдээлэл" эмхтгэлд хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэр, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын тогтоол, Үндсэн хуулийн цэцийн шийдвэр, хуулийн талаархи Улсын дээд шүүхийн албан ёсны тайлбар, яам, агентлагаас гаргасан нийтээр дагаж мөрдөх эрх зүйн хэм хэмжээ тогтоосон актыг бүрэн эхээр нь нийтэлнэ.

26.12. "Төрийн мэдээлэл" эмхтгэлийг хэвлэн нийтлэх ажлыг Улсын Их Хурлын Тамгын газар хариуцаж долоо хоног тутам гаргана.

Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга нь тус эмхтгэлийн эрхлэгч байх бөгөөд түүнийг хэвлэн нийтлэх хугацаа, журмыг тогтооно.

Хорин долоо. Улсын Их Хурлын чуулганы хуралдааны тэмдэглэл хөтлөх, түүнийг ашиглах, хадгалах

27.1. Улсын Их Хурлын чуулганы хуралдааны явцын тэмдэглэлийг гараар болон соронзон хальсанд нэгэн зэрэг бичнэ. Шаардлагатай гэж үзвэл хуралдааны явцын талаар дуутай дурс бичлэг хийж хадгална.

27.2. Хуралдааны явцын тэмдэглэлд дараахь баримт бичгийг заавал хавсаргана:

27.2.1. тухайн өдрийн хуралдаанаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөө, урилгаар оролцсон болон байлцсан хүмүүсийн нэр, албан тушаал;

27.2.2. хуралдаанаар хэлэлцсэн хууль, бусад шийдвэрийн төсөл /хувилбарууд/ тэдгээрийн танилцуулга, дүгнэлт, санал;

27.2.3. хэлэлцэж байгаа асуудлаар Улсын Их Хурлын гишүүнээс бусад гишүүдэд тараасан санал;

27.2.4. хуралдааны явцад Улсын Их Хурлын гишүүдэд сонордуулсан өргөх бичиг, мэдэгдэл, цахилгаан утас;

27.2.5. хуралдааны явцад хэлэлцсэн, сонордуулсан, тараасан бусад баримт бичиг;

27.2.6. гишүүн тусгайлан тэмдэглүүлэхээр өөрөө бичсэн зүйл.

27.3. Хуралдааны явцын тэмдэглэлийг гараар бичихдээ дараахь зүйлийг заавал тусгана:

27.3.1. хуралдаан эхэлсэн, завсарласан, дууссан болон асуудлыг хэлэлцэж эхэлсэн, дууссан он, сар, өдөр, цаг, минут;

27.3.2. ямар асуудал, хаанаас, хэн төлөөлж оруулсан тухай товч томъёолол;

27.3.3. хэлэлцэж байгаа асуудалтай холбогдсон асуулт, хариулт, гаргасан санал, шүүмжлэл, хэлсэн үг;

27.3.4. санал хураалтын дүн /тоо, хувиар/, хэрэв нэрээр санал хураавал Улсын Их Хурлын гишүүн нэг бүрийн нэр, өгсөн санал;

27.3.5. ирц /тоо, хувиар/, байхгүй гишүүний нэр, шалтгаан;

27.3.6. хуралдаанд хоцорч ирсэн, чөлөө авсан, өвчтэй байсан, тасалсан, хуралдааны даргын зөвшөөрөлгүй гарч явсан гишүүний нэр, цаг минут;

27.3.7. гишүүний тусгайлан тэмдэглүүлэхээр хэлсэн үг.

27.4. Гишүүний хуралдаанд хэлсэн үгийг тодорхой бичих бөгөөд тусгайлан тэмдэглүүлсэн зүйлийг тухайн гишүүнд хянуулж гарыг үсэг зуруулна.

27.5. Улсын Их Хурлын гишүүн хүсвэл өөрийн болон бусдын хэлсэн үгийн бичлэгтэй танилцаж болно.

27.6. Гаргасан шийдвэрийг төслийн хувилбарын хамт гар тэмдэглэлд хэлэлцсэн дараалаар нь дугаарлан заавал хавсаргана.

27.7. Улсын Их Хурлын чуулганы хуралдааны явцын тэмдэглэлтэй Ерөнхий нарийн бичгийн дарга танилцаж гарын үсэг зурна.

Хорин найм. Хуралдааны явцын гар тэмдэглэл, соронзон болон дуутай дүрс бичлэг ашиглах, хадгалах

28.1. Хуралдааны явцын гар тэмдэглэл, соронзон бичлэгийг Улсын Их Хурлын чуулганы материал бэлтгэж хэвлүүлэх, хэвлэл, мэдээллийн байгууллагад лавлагаа өгөх, маргаантай асуудал шийдвэрлэхэд ашиглуулна.

28.2. Хуралдааны явцын гар тэмдэглэл, соронзон болон дуутай дүрс бичлэгийг Улсын Их Хурлын гишүүд, Ерөнхий нарийн бичгийн дарга, Тамгын газрын ажилтан шууд, бусад байгууллагын албан тушаалтанд Ерөнхий нарийн бичгийн даргын зөвшөөрлөөр үзүүлж, сонсгоно.

28.3. Хуралдааны явцын гар тэмдэглэл, соронзон болон дуутай дүрс бичлэгийг Улсын Их Хурлын гишүүд болон Тамгын газрын ажилтнуудад 7 хоног хүртэлх хугацаагаар ашиглуулах бөгөөд зөвшөөрөлгүй олшруулах, хувилахыг хориглоно. Харин бусад байгууллагын албан тушаалтанд архивын ажилтны дэргэд үзүүлж, сонсгоно.

28.4. Хуралдааны явцын гар тэмдэглэл, соронзон болон дуутай дүрс бичлэгийг Тамгын газрын архивт хадгална. Энэ тухай журмыг Ерөнхий нарийн бичгийн дарга тогтоно.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2001 оны 6 дугаар сарын 28-ны өдөр **Дугаар 62** **Улаанбаатар хот**

Төрийн захиргааны албаны зөвлөлийн орон тооны гишүүдийг томилох тухай

Монгол Улсын Төрийн албаны тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Шүүхийн ерөнхий зөвлөлөөс дэвшүүлсэн саналыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Төрийн захиргааны албаны зөвлөлийн орон тооны гишүүнээр Жамбын Норовсамбуу, Намжилдоогийн Чадраабал нарыг томилсугай.

2.Төрийн захиргааны албаны зөвлөлийн дарга, гишүүнийг шинээр томилох хүртэл хугацаанд Ж.Норовсамбуугд Төрийн захиргааны албаны зөвлөлийн даргын, Х.Шаандарт Төрийн захиргааны албаны зөвлөлийн гишүүний үүрэгт ажлыг түс түс гүйцэтгэж байхыг даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА **Л.ЭНЭБИШ**

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2001 оны 6 дугаар сарын 29-ний өдөр | Дугаар 63 | Улаанбаатар хот

Аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг буцаах тухай

Монгол Улсын Их Хурлын хуралдааны дэгийн хуулийн 40 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Засгийн газраас өргөн мэдүүлсэн Аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг дахин боловсруулахаар хууль санаачлагчид буцаасугай.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА Л.ЭНЭБИШ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2001 оны 6 дугаар сарын 29-ний өдөр | Дугаар 64 | Улаанбаатар хот

2001 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай

Монгол Улсын Их Хурлын хуралдааны дэгийн хуулийн 5 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 40 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхийлөгч, Засгийн газар, Байнгын хороодоос өргөн мэдүүлсэн саналыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Их Хурлын 2001 оны намрын ээлжит чуулганаар Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн болон хуулиар хугацаа заажхэлэлцэх дараахь асуудлыг хэлэлцэхээр төлөвлөсүгэй:

1/ Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2002 онд хөгжүүлэх Үндэсэн чиглэл;

2/ 2002 онд төрөөс мөнгөний бодлогын талаар баримтлах үндсэн чиглэл;

3/ Монгол Улсын 2002 оны төвлөрсөн төсвийн тухай хуулийн төсөл;

4/ Монгол Улсын 2000 оны төвлөрсөн төсвийн гүйцэтгэл батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл;

5/ Авилгалын эсрэг хуулийн төсөл;

6/ Авилгалтай тэмцэх Үндэсний хөтөлбөрийн төсөл;

7/ Зэвсэгт хүчний тухай хуулийн төсөл;

8/ Үндэсний аюулгүй байдлын тухай хуулийн төсөл;

9/ Газрын багц хуулийн төсөл;

10/ Зарим хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд;

11/ Бусад.

2. Улсын Их Хурлын чуулганы хэлэлцүүлгийн шатанд байгаа дараахь хууль тогтоомжийн төслийг 2001 оны намрын ээлжит чуулганаар үргэлжлүүлэн хэлэлцэхээр тогтсугай:

1/ Эрүүгийн хуулийн төсөл;

2/ Иргэний хэргийг шүүхэд шийдвэрлэх тухай хуулийн төсөл;

3/ Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн төсөл;

4/ Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн төсөл;

5/ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн төсөл;

6/ Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай хуулийн төсөл /шинэчилсэн найруулга/;

7/ Харилцаа, холбооны тухай хуулийн төсөл;

8/ Төсвийн байгууллагын удирдлага, санхүүгийн тухай хуулийн төсөл.

3. Улсын Их Хурлаас хэлэлцэхээр шийдвэрлэсэн болон шаардлагатай гэж үзсэн хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийг төсөл санаачлагчаас 2001 оны 9 дүгээр сарын 20-ны дотор Улсын Их Хуралд өргөн мэдүүлбэл энэ оны намрын ээлжит чуулганы хэлэлцэх асуудлын дараалалд оруулахыг Улсын Их Хурлын даргад зөвшөөрсүгэй.

4.Намрын чуулганаар хэлэлцэх асуудлыг чуулганаар хэлэлцүүлэх бэлтгэл ажлыг Байнгын хороодын дарга нар болон Тамгын газар /Д.Батбаатар/-т даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА Л.ЭНЭБИШ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2001 оны 6 дугаар сарын 29-ний өдөр | Дугаар 65 | Улаанбаатар хот

Монгол Улсын Их Хурлын 2000 оны 49 дүгээр тогтоолд нэмэлт оруулах тухай

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь: оны 49 дүгээр тогтоолын "4.0 тэрбум" гэсний дараа "төгрөг, малжуулахад 2 тэрбум" гэж нэмсүгэй.

Монгол Улсын 2001 оны төвлөрсөн төсвийн тэнцлийн талаархи Монгол Улсын Их Хурлын 2000

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Л.ЭНЭБИШ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2001 оны 6 дугаар сарын 25-ны өдөр | Дугаар 01 | Улаанбаатар хот

Элчин сайдыг эгүүлэн татах, томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5, Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг баримтлан ЗАРЛИГ болгох нь:

1. Монгол Улсаас Арабын Бүгд Найрамдах Египет Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Кадырын Сайрааныг эгүүлэн татсугай.

2. Монгол Улсаас Арабын Бүгд Найрамдах Египет Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Чойжилжавын Болдыг томилсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2001 оны 6 дугаар сарын 25-ны өдөр | Дугаар 02 | Улаанбаатар хот

Элчин сайдыг эгүүлэн татах, томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5, Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг баримтлан ЗАРЛИГ болгох нь:

Готовын Луузанг эгүүлэн татсугай.

2. Монгол Улсаас Бүгд Найрамдах Итали Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Чулууны Батжаргалыг томилсугай.

1. Монгол Улсаас Бүгд Найрамдах Итали Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2001 оны 6 дугаар сарын 25-ны өдөр | Дугаар 03 | Улаанбаатар хот

Дитрих Неллеr "Найрамдал" медаliар шагнах тухай

Монгол Улс, ХБНГУ-ын хамтын ажиллагааг хөгжүүлэх, манай улсын эрх зүйн шинэтгэлийг гүнзгийрүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Германы техникийн хамтын ажиллагааны нийгэмлэгийн "Монгол улсын эдийн засгийн эрх зүйн шинэчлэл" төслийн зохицуулагч Дитрих Неллерт "Найрамдал" медаliар шагнасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2001 оны 6 дугаар сарын 25-ны өдөр | Дугаар 04 | Улаанбаатар хот

БНЭУ-ын зарим иргэнийг одон, медалиар шагнах тухай

Монгол Улс, Бүгд Найрамдах Энэтхэг Улсын хоорондын харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж БНЭУ-ын иргэн, элчин сайд Кушок Бакула-г "Алтан гадас" одонгоор, БНЭУ-ын Хүний хөгжлийн сайд, Шинжлэх ухаан технологийн сайд М.М.Жоши, БНЭУ-ын Жавахарлал Неругийн Их сургуулийн Төв ази, Гималайн судлалын төвийн эрхлэгч К.Варикоо нарыг "Найрамдал" медалиар тус тус шагнасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ **Н.БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2001 оны 6 дугаар сарын 27-ны өдөр | Дугаар 05 | Улаанбаатар хот

Зарим шүүгчийг чөлөөлөх тухай

Монгол Улсын "Шүүхийн тухай" хуулийн 51 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 5-д заасныг баримтлан, Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн ЗАРЛИГ болгох нь:

Мэргэшлийн түвшин, ажил хэргийн чадварын хувьд шүүгчээр ажиллах боломжгүй тухай Шүүгчийн мэргэшлийн хороо дүгнэлт гаргасан тул Лодонгийн Насан-Өлзийг Дархан - Уул аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчийн албан тушаалаас чөлөөлсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ **Н.БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2001 оны 6 дугаар сарын 27-ны өдөр | Дугаар 06 | Улаанбаатар хот

Б.Доржготовыг Улсын дээд шүүхийн шүүгчээр томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн тавин нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэг, "Шүүхийн тухай" хуулийн 6 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг тус тус баримтлан, Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн ЗАРЛИГ болгох нь:

Баасангийн Доржготовыг Монгол Улсын дээд шүүхийн шүүгчийн албан тушаалд томилсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ **Н.БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2001 оны 6 дугаар сарын 27-ны өдөр | Дугаар 07 | Улаанбаатар хот

Р.Жамъянчойжилыг Улсын дээд шүүхийн Иргэний хэргийн танхимын тэргүүн шүүгчээр томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн тавин нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэг, "Шүүхийн тухай" хуулийн 24 дүгээр зүйлийн 5 дахь хэсгийг тус тус баримтлан ЗАРЛИГ болгох нь:

Рэгзэнгийн Жамъянчойжилыг Монгол Улсын дээд шүүхийн Иргэний хэргийн танхимын тэргүүн шүүгчийн албан тушаалд томилсугай.


МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ **Н.БАГАБАНДИ**

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Хаяг: «Төрийн мэдээлэл» эмхтгэлийн зөвлөл

Улаанбаатар-12 ☎ 329612
Төрийн ордон Индекс 14003

Улсын Их Хурлын Тамгын газрын Хэвлэх хэсэгт хэвлэв.

☎ 329487





ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 29 (216)

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ:

- *Хөтөлбөрийг шинэчлэн батлах тухай*
- *Зарим байгууллагын байршлын тухай*
- *Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар

Улаанбаатар хот
2001 он

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот 2001 оны долдугаар сарын 28 №29 (216)

Гарчиг

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

374. Хөтөлбөрийг шинэчлэн батлах тухай	Дугаар 108	753
375. Хөтөлбөр батлах тухай	Дугаар 114	764
376. Зарим байгууллагын байршлын тухай	Дугаар 115	775
377. Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	Дугаар 116	775

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 5 дугаар сарын 10-ны өдөр | **Дугаар 108** | **Улаанбаатар хот**

Хөтөлбөрийг шинэчлэн батлах тухай

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний 182 дугаар зүйлийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Өрхийн амьжиргааны чадавхийг дэмжих Үндэсний хөтөлбөр"-ийг 1 дүгээр хавсралт ёсоор шинэчлэн батлалсугай.

2. Өрхийн амьжиргааны чадавхийг дэмжих Үндэсний хорооны бүрэлдэхүүнийг 2 дугаар хавсралт, Үндэсний хорооны дүрмийг 3 дугаар хавсралт ёсоор тус тус батлалсугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Засгийн газрын комисс, Үндэсний зөвлөл, хороо, ажлын хэсгийн тухай" Засгийн газрын 1996 оны 9 дүгээр сарын 20-ны өдрийн 238 дугаар тогтоолын 2 дугаар зүйл, "Нийгмийн халамжийн удирдлага, зохион байгуулалтын талаар авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 1997 оны 2 дугаар сарын 28-ны өдрийн 59 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт, "Өрхийн амьжиргааны чадавхийг дэмжих Үндэсний хөтөлбөр батлах тухай" Засгийн газрын 2000 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн 93 дугаар тогтоолын 1, 5 дугаар зүйлийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

НИЙГМИЙН ХАМГААЛАЛ, ХӨДӨЛМӨРИЙН САЙД **Ш.БАТБАЯР**

ЗАЛРУУЛГА

"Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2001 оны 25 дугаарт нийтлэгдсэн "Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай хууль"-ийн шинэчлэгдсэн найруулгын 4.5.2-ын "15.1.2," гэснийг "15.2.1,", 10.1.12-ын "импортлох" гэсний дараа таслал, 4.4.1-ийн "норматив" гэсний дараа "батлах", 15.1.7-ийн "хяналтын" гэсний дараа "төв" гэж нэмж, 12.7-гийн "12.6-д" гэсний дараахь "хэсэгт", 13.1.5-ын "асуудлаар, . . . шүүхээр" гэснийг хасаж хэрэглэнэ үү.

УИХ-ЫН ТАМГЫН ГАЗАР

Засгийн газрын 2001 оны 108 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

ӨРХИЙН АМЬЖИРГААНЫ ЧАДАВХИЙГ ДЭМЖИХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР

Нэг.Нийтлэг үндэслэл

1. Амьжиргааны өнөөгийн байдал, түлгамдсан асуудал

Амьжиргааны байдал буюу орлогын түвшингээрээ нийт хүн ам нь нэн ядуу, ядуу, ядуу бус бага орлоготой, дунд зэргийн орлоготой, чинээлэг гэсэн таван бүлэгт хуваагдаж байна. Үндэсний статистикийн газраас 1998 онд явуулсан хүн амын амьжиргааны түвшний түүвэр судалгааны дүнгээс үзэхэд ядуу, нэн ядуучууд нийт хүн амын 35.6 хувийг, ядуу бус бага орлоготой хүмүүс 27.0 хувийг тус тус эзэлж байжээ.

*Хүн амын амьжиргааны түвшин**

№	Амьжиргааны түвшин		Хүн амд эзлэх хувь
1	Нэн ядуу		19.7
2	Ядуу		15.9
3	Ядуу бус	бага орлоготой	27.0
4		дунд зэргийн орлоготой	21.9
5		чинээлэг	15.5
	Дүн		100.0

Хүн амын амьжиргааны түвшинд хөдөлмөр эрхлэлтийн байдал зонхилох нөлөөтэй юм.

Улсын дунджаар хөдөлмөрийн насны хүн амын 65 хувь нь ажил эрхлэж, 15.4 хувь нь хөдөлмөр эрхлээгүй байна.

Хот, суурин газрын хөдөлмөрийн насны ядуу хүн амын 27.3-38.8 хувь нь ажилгүй байгаа нь улсын дунджаас 11.9-23.4 нэгжээр өндөр байна. Түүнчлэн хөдөлмөр эрхлэж байгаа ядуучууд цөөнгүй байна. Дээрх судалгаанд дүнгээс үзэхэд хотод нэн ядуучуудын 37.6 хувь, ядуучуудын 48.3 хувь, ядуу бус бага орлоготой хүмүүсийн 49.2 хувь, хөдөөд нэн ядуучуудын 58.4 хувь, ядуучуудын 79.6 хувь, ядуу бус бага орлоготой хүмүүсийн 83.3 хувь нь тус тус хөдөлмөр эрхлэж байна.*

Үүнээс үзэхэд Монголд хөдөлмөр эрхлэх боломж хомс, орлогын түвшин доогуур байгаагаас орлогын ядуурал зонхилж байна.

Хүн амын амьжиргааны байдал хот болон хөдөөд ялгаатай байна.

Хүн амын ядуурлын түвшин хотод 39.4 хувь, үүнээс Улаанбаатарт 34.1, аймгийн төвүүдэд 45.1, хөдөөд 32.0 хувь байна.

Хүн амын амьжиргааны эх үүсвэр харилцан адилгүй байна.

Улсын дунджаар хүн амын орлогын гуравны нэг нь цалин, тэтгэвэр, тэтгэмж, шагнал урамшуулал, 20 гаруй хувь нь хөдөө аж ахуйн болон хөдөө аж ахуйн бус үйлдвэрлэлийн орлогоос, 30 хувь нь өрхийн хувийн аж ахуйгаас, 10 хувь нь бусдаас үнэгүй авсан хэрэглээнээс бүрдэж байгаа ч энэ нь өрхийн байршлаас ихээхэн хамаардагийг Хүн амын амьжиргааны түвшний түүвэр судалгааны дүн харууллаа. Тухайлбал, хот, суурин газрын хүн амын орлогын 40-60 хувийг цалин, тэтгэвэр, тэтгэмж эзэлж байхад хөдөөгийн хүн амын орлогын денгээ 7 хувийг цалин, тэтгэвэр, тэтгэмж, 60-аад хувийг өрхийн аж ахуйн орлого эзэлж байна. Харин ядуу хүмүүсийн орлогын гол эх үүсвэр нь цалин, тэтгэвэр, тэтгэмж байна.

Өрхийн байршлаас хамаарахгүйгээр ядуурал гол төлөө ам бүл олонтой болон өрхийн тэргүүлэгч нь эмэгтэйчүүд бүхий өрх илүү өртжээ. Тухайлбал, нэн ядуу өрхийн 24.6 хувь, ядуу өрхийн 18.3 хувийг өрхийн тэргүүлэгч нь эмэгтэйчүүд бүхий өрх эзэлж байна.

Амжиргааны түвшин, өрхийн байршил нь хүн амын нийгмийн үйлчилгээнд тэгш бус байдлыг бий болгож байна.

Чинээлэг өрхүүдтэй харьцуулахад эрүүл мэндийн салбарын үйлчилгээг ядуу өрхүүд бага хүртэж байна. Эрүүл мэндийн үйлчилгээний сарын

---

* Хүн амын амьжиргааны түвшний түүвэр судалгаа 1998 он, хуудас 43

* ҮСГ, Хүн амын АТТС, хуудас 34

дундаж зардлыг хэрэглээний түвшингээр авч үзвэл нэн ядуу бүлгийн нэг хүнд ногдох эрүүл мэндийн үйлчилгээний зардал хамгийн өндөр орлоготой хэсгийнхний зардлаас 9 дахин бага байгаагаас гадна ядуу хүний эмнэлэгт хандах давтамж буурсан байна.

Амьжиргааны доод түвшингээс доогуур орлоготой өрхийн иргэд хоол хүнсний байгнын хомсдолд орж, өлмөн эзлмэн байдалд аж төрж байна. Монгол хүний өдөрт хэрэглэх хоол тэжээлийн илчлэгийн зохистой нормыг 2900 калори гэж тогтоосон байхад ядуу өрхийн гишүүд өдөрт дунджаар 1784 калори авч байна. Эмзэг бүлгийн өрхийн амьжиргааны өнөөгийн байдал нь "ядуурал-өлсгөлөн-өвчин" гэсэн гинжин холбоог үүсгэж байна.

Ядуу амьдралтай өрхийн хүүхдэд боловсрол олгох, мэргэжил эзэмшүүлэхэд ихээхэн бэрхшээл учирч байна.

Судалгаанаас үзэхэд эдгээр өрхийн 8-15 насны хүүхдийн сургууль хамрагдалтын түвшин 87,3 хувь, сургууль завсардалт 9,3 хувь байна. Сургууль завсардалт хөдөө илүү байгаа бөгөөд сургууль завсардсан хүүхдүүдийн 43,8 хувь нь амьдралын гачигдал, ажил эрхлэх шаардлагын улмаас сургуульд хамрагдаагүй гэжээ.

Ядуурлын улмаас хүүхдийнхээ хувцас, хичээлийн хэрэгсэл хүдалдан авч чадахгүй байгаа өрхийн тоо есч, хөдөө орон нутагт ядуу өрх хүүхдийнхээ байр, хоолны зардлыг төлж чадахгүй болсон ээрэг нь сургууль завсардалт есөхөд нөлөөлж байна. Ядуу, нэн ядуу өрхийн сургуулиас гадна байгаа хүүхдийн эзлэх хувь хэмжээ чинээлэг өрхийнхээс бараг 2 дахин их байна. Ядуу, нэн ядуу өрхийн хүүхдийн 19.2 хувь нь сургуулиа орхисон, эсхүл сургуульд огт ороогүй байхад чинээлэг өрхийн хүүхдийн хувьд энэ үзүүлэлт 10.4 хувь байна.

Хүн амын амьжиргааны түвшингийн түүвэр судалгааны дүнгээс үзэхэд өрхийн орлогоос боловсролд зарцуулж байгаа зардал нь 1998 онд 1995 оныхоос 4-5 дахин нэмэгдсэн байна. Өрхийн орлогоос их сургууль, коллежид зориулан зарцуулах зардал жилд ойролцоогоор 330 орчим иянган төгрөг байгаа ч хөдөөгийн ерх хотын өрхтэй карьцуулахад 30 хувиар илүү зардал гаргадаг байна. Түүнчлэн чинээлэг ерх ядуу өрхтэй карьцуулахад боловсролын үйлчилгээнд илүү камрагдаж байна. Тухайлбал, чинээлэг өрх сургуулийн хүүхдийн зардалд ядуу ерхөөс 6 дахин их зардал гаргаж байна.

2. Амьжиргааны түвшинг дээшлүүлэх алаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, үр дүн, үргамж

Монгол Улсын Засгийн газар 1994-2000 нд Ядуурлыг бууруулах үндэсний хөтөлбөрийг өвлөрлийг сааруулах замуун, олон нийтийн ролцоонд тулгуурлан гадаад орон, олон улсын байгууллагын дэмжлэгтэйгээр хэрэгжүүлснээр нийгмийн амьдралд шилжилтийн үеийн сөрөг үр дагавар болж гарч ирсэн ядуурлын асуудлыг бодлогын хэмжээнд тодорхойлж, чиглэсэн зорилго, зорилт бүхий үйл ажиллагаа явуулах, ядуу хүмүүсийн гутранги сэтгэл зүйг өөрчилж, хийж бүтээснээрээ амьдралаа өөрөө өөд нь татах үзэл бодлыг төлөвшүүлэхэд эерэг нөлөө үзүүлж, ядуурлын хамралтын хүрээг өргөжүүлэхгүй байх, улмаар ядуурлыг бууруулахад төрийн болон төрийн бус байгууллага, иргэдийн анхаарал, хүчийг төвлөрүүлж өгсөн юм.

Ядуурлыг бууруулах үндэсний хөтөлберийн хүрээнд эмзэг бүлгийн орлого нэмэгдүүлэх, хөдөө орон нутагт нийгмийн дэд бүтцийг хөгжүүлэх замаар ажлын түр байр бий болгох, сургуулийн өмнөх болон суурь боловсролыг дэмжих, хөдөөгийн хүн амын эрүүл мэндийн суурь үйлчилгээг сайжруулах, насанд хүрсэн тахир дутуу иргэдэд мэргэжил эзэмшүүлэх, тэднийг орлого нэмэгдүүлэх үйл ажиллагаанд хамруулах болон тахир дутуу хүүхдэд боловсрол олгох зэрэг 12 мянга гаруй жижиг төсөл хэрэгжлээ.

Үүний үр дүнд 66 мянга гаруй байнгын болон ажлын түр байр бий болж, сургуулийн өмнөх насны 16.5 мянган хүүхэд цэцэрлэгт шинээр хамрагдаж, хөдөөгийн сумын дунд сургуулийн хичээлийн болон дотуур байрны гэрэлтүүлэг, халаалтын систем, 167 сумын хүн эмнэлгийн барилгын болон халаалтын системийн засвар, тохижилтын ажил хийгдэж, 86 багийн бага эмчийг унаатын морь, тэмээ болон эмнэлгийн багаж хэрэгслээр хангаж, алслагдсан 219 сумын хүн эмнэлэг түргэн тусламжийн автомашинтай болжээ. Мөн 1500 гаруй малчин өрхэд 90 гаруй мянган толгой малыг гэрээний үндэсэн дээр өгч малжуулсан байна.

Гэвч ядуурлыг бууруулахад чиглэсэн төрийн байгууллагын бодлого болон үйл ажиллагааны үялдаа холбоог хангах, мэдээлэл, судалгаа, сургалт,сурталчилгааны нэгдсэн тогтолцоо бий болгох, ядуу хүмүүсийг амьдрах арга ухаанд сургаж мэргэжил, үр чадвар ээзмшүүлэх, ядуурлыг бууруулах сангаас олгосон ээзлийн үр дүн, эргэн төлөлтийг тооцох, хяналтыг сайжруулах талаар дутуу анхаарснаас үг хөтөлберийн хэрэгжилтийн явц сааруулах, хүлээсэн үр дүнд хүрч чадаагүй нь даралгийн шатны ажилд томоохон сургамж болж байна.

Иймд 1994-2000 онд хэрэгжүүлсэн Ядуурлыг бууруулах үндэсний хөтөлберийн ололт амжилт, алдаа сургамж дээр үндэслэн түүний дараагийн шатны зорилт болгон Өрхийн амьжиргааны чадавхийг дэмжих үндэсний хөтөлбөр /цаашид "хөтөлбөр" гэх/-ийг Засгийн газраас батлан гаргаж байна.

Хоёр.Хөтөлбөрийн үндсэн зорилго, зарчим

3.Хүний хөгжлийн хүчин зүйл, чадавхийг дэмжин хөгжүүлэхэд шаардагдах эдийн засаг, нийгмийн зайлшгүй үйлчилгээний хүрээг өргөжүүлэх замаар нэн ядуу болон ядуу өрхийг ядуурлаас гаргах, ядуу бус бага орлоготой өрхийг ядууралд орохоос урьдчилан сэргийлэх нь хөтөлбөрийн үндсэнзорилго болно.

4.Хөтөлбөрийг дор дурдсан үндсэн зарчим дээр тулгуурлан хэрэгжүүлнэ:

а/хөтөлбөрийн хүн амын бүлгийн болон өрхийн онцлог байдалд тохирсон ядуурлыг бууруулах ялгаварт бодлого, арга хэмжээ авах;

б/өрхийн бүх хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллага, иргэд, олон нийтийн оролцоог нэмэгдүүлж, тэдгээрийн үйл ажиллагааны уялдаа холбоог хангах;

в/хөрөнгийн зарцуулалт, бүрдүүлэлтэд орон нутгийн оролцоог нэмэгдүүлж, төвлөрлийг сааруулах;

г/хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа улс, орон нутгийн хөгжлийн бодлого, бусад хөтөлбөртэйуялдуулан зохицуулах;

д/санхүүгийн эх үүсвэр, зээлийн хөрөнгийг үр ашигтайгаар хуваарилан зарцуулахх;

е/жендерийн асуудлыг харгалзахх;

ж/үйл ажиллагааны ил тод байдлыг хангах, мэдээллийн урсгалыг сайжруулах.

Гурав.Хөтөлбөрийн хамрах хүрээ, зорилт үйл ажиллагааны үндсэн чиглэл

А.Нийгмийн хүрээ

5.Эрүүл мэндийн үйлчилгээг сайжруулах талаар шийдвэрлэх зорилт:

Эрүүл мэндийн суурь тусламжийн хүртээмж, чанарыг сайжруулан, алслагдсан нутагт хүрч үйлчлэх боломжийг нэмэгдүүлснээр эх, нялхсын эндэгдэл, халдварт өвчний гаралтыг бууруулахад нөлөөлнө.

6. Хэрэгжүүлэх арга хэмжээ:

а/хүмүн болон өрхийн эмнэлэг, эхчүүдийн төрөхийн өмнөх байрыг засварлах, тохижуулах, халаалт, цахилгааны эх үүсвэрийн асуудлыг шийдвэрлэхэд туслалцаа үзүүлэх;

б/сум, баг, өрхийн эмч нарыг унаа, эмнэлгийн анжны тусламжийн эм, багаж хэрэгслээр хангахад дэмжлэг үзүүлэх;

в/5 хүртэл насны хүүхдийн хоол тэжээлийн хөнгөмж, бүтцийн чанарыг сайжруулахад дэмжлэг үзүүлэх;

г/ядуу, эмзэг бүлгийн иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх,, эх хүүхдийн зохистой хооллолтын талаар сургалт, сурталчилгаа явуулахад дэмжлэг үзүүлэх.

7. Боловсролын хамрах хүрээг өргөжүүлэх талаар шийдвэрлэх зорилт:

Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тогтолцоог бэхжүүлэх, сургалтад хамрагдах ядуу ерх, эмзэг бүлгийн хүүхдийн тоог нэмэгдүүлэх, сургууль завсардалтыг багасгах, ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад бизнесийн мэдлэг, хэрэглээний чадвар олгоход дэмжлэг үзүүлнэ.

8. Хэрэгжүүлэх арга хэмжээ:

а/цэцэрлэг, зээлжийн бүлэг, зуны сургалт зэрэгт амьжиргааны доод түвшингээс бага орлоготой өрхийн сургуулийн өмнөх насны хүүхдийн хамрагдалтыг нэмэгдүүлэхэд туслах;

б/малчдын хүүхдийг сургууль бэлтгэх, тэдгийг хөгжүүлэх чиглэлээр богино хугацааны төвлөрсөн бэлтгэл сургалт зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх;

в/эмзэг бүлгийн өрхийн сургуулийн насны хүүхдийг хувцас, хичээлийн хэрэгслээр хангахад туслах;

г/сургууль завсардсан хүүхдэд боловсрол нөхөн олгох хэлбэрийг дэмжих, хичээлийн болон дотуур байрыг засварлах, халаалт, цахилгааны эх үүсвэрийг шийдвэрлэх, холимог бүлгийн сургууль зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх;

д/бизнес, зах зээлийн мэдлэг, хэрэглээний чадвар олгох албан бус сургалт зохион байгуулах нөхцөл бүрдүүлэхэд туслах;

е/цэцэрлэг, сургуулийн туслах аж ахуйг хөгжүүлэхэд дэмжлэг өгөх.

9. Тахир дутуу иргэдийг дэмжих зорилт:

Тахир дутуу иргэдээр тохирсон хөдөлмөр эрхлүүлэх, тэдгээрийн хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулах, боловсрол, мэргэжил олгох зэргээр амьжиргааны эх үүсвэртэй болгож орлогыг нь нэмэгдүүлэхэд тусална.

10. Хэрэгжүүлэх арга хэмжээ:

а/тахир дутуу иргэдийн нарийвчилсан бүртгэл судалгааг тэв орон нутгийн хэмжээнд явуулж, тэдний боловсрол, орлого, амьжиргааны түвшинг тодорхойлох;

б/хөдөлмөрийн насны, хөдөлмөрлөх боломжтой тахир дутуу иргэдэд мэргэжил эзэмшүүлэх, тохирсон хөдөлмөр эрхлүүлэх ажлын байр бий болгох, хөдөлмөрлөх нөхцөлийг нь сайжруулахад туслалцаа дэмжлэг үзүүлэх;

в/тахир дутуу хүүхдийг цэцэрлэг,

сургуульд хамруулах, ердийн хүүхэдтэй хамт сурч хүмүүжих нөхцөлийг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

г/бие эрхтэний согоггой тахир дутуу хүүхдэд сургалтын нөхцөл бүрдүүлэх зорилгоор тусгай анги танхим байгуулж тоног төхөөрөмжөөр тоноглох, зориулалтын хичээлийн хэрэглэлээр хангах талаар сургуулиудад дэмжлэг үзүүлэх.

Б.Эдийн засгийн хүрээ

11. Ажлын байр бий болгох талаар шийдвэрлэх зорилт:

Хөдөлмөрийн насны, хөдөлмөрийн чадвартай ажилгүй иргэдэд ажлын байр, орлогын байгныи эх үүсвэр бий болгож, бизнесийн үйл ажиллагаа тасралтгүй явуулах боломжийг бүрдүүлнэ.

12.Хэрэгжүүлэх арга хэмжээ:

а/амьжиргааны түвшингээс доогуур орлоготой, хөдөлмөрийн чадвартай иргэдэд зориулсан байнгын ажлын байр бий болгоход туслалцаа үзүүлэх;

б/сумдад соёл, ахуйн үйлчилгээний цэг, салбарыг сэргээх, шинээр зохион байгуулах замаар ажлын байр бий болгох асуудлыг шийдвэрлэхэд туслах;

в/Засгийн газраас тэргүүлэх ач холбогдол өгсөн салбарт хийгдэх хөдөлмөр зарцуулалт ихтэй, цаг үеийн шинж чанартай, богино хугацааны нийтийг хамарсан ажлыг дэмжихэд чиглэсэн түр ажлын байр олноор бий болгох;

г/орон нутгийн эрэлт хэрэгцээг хангах жижиг бизнесийг төрөл бүрийн хэлбэрээр хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх.

13. Жижиг зээлийн үйлчилгээг хөгжүүлж иргэдийн хувираа хөдөлмөр эрхлэлтийг дэмжих талаар шийдвэрлэх зорилт:

Орон нутагт мөнгөний эргэлтийг сайжруулах, жижиг үйлдвэрлэл, үйлчилгээг хөгжүүлэх, иргэд хувираа хөдөлмөр эрхлэх, зээл, санхүүгийн дэмжлэг авах боломжийг нэмэгдүүлнэ.

14. Хэрэгжүүлэх арга хэмжээ:

а/жижиг зээлийг үе шаттайгаар, тодорхой урамшуулагч хөшүүрэгтэйгээр олгох;

б/зээлийн эргэлтийн сан бий болгох, түүнийг эрсдэлээс хамгаалах;

в/хадгаламж зээлийн хоршоо, дундын сан байгуулах санал, санаачилгыг дэмжиж өрнүүлэх;

г/ногоон хувьсгал, цагаан хувьсгал үндэсний хөтөлбөрийн шугамаар өрхийн аж ахуйг хөгжүүлэх.

15. Огт малгүй буюу цөөн малтай өрхийг малжуулах талаар шийдвэрлэх зорилт:

Нэн ядуу, ядуу болон бага орлоготой өрхийг мал маллагааны арга барилд сургаж малжуулна.

16. Хэрэгжүүлэх арга хэмжээ:

а/олон малтай /мянгат малчин гэх мэт/ өрхтэй гэрээ байгуулан ядуу иргэдийг туслах малчнаар ажиллуулах, багш шавийн барилдлагаа бий болгох арга хэлбэрийг хөгжүүлэн дэмжих;

б/тодорхой нөхцөл, болзлын үндсэн дээр цөөн малтай өрхийг малжуулах үйл ажиллагаанд өргөнөөр хамруулах;

в/огт малгүй ядуу өрхөд мал худалдан авч өгч гэрээгээр тодорхой хугацаанд үр төлөөр нь малжуулах арга хэмжээ авах.

В. Байгаль орчны хүрээ

17. Байгаль орчны хүрээнд шийдвэрлэх зорилт:

Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх замаар ерх бүр эрүүл орчинд амьдарч, ажиллах нөхцөлийг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

18. Хэрэгжүүлэх арга хэмжээ:

а/худаг сэргээх, засварлах, шинээр гаргах, булаг шандын усыг бохирдлоос хамгаалах ажлыг мэргэжлийн байгууллага, хүмүүстэй хамтран зохион байгуулах, энэ ажилд ажилгүй, ядуу болон бага орлоготой хүмүүсийг татан оролцуулах;

б/хот суурин газрын тохижилт үйлчилгээ, зүлэгжүүлэлт, цэцэрлэгжүүлэлтийн ажлыг тухайн орчны оршин суугч ядуу, бага орлоготой хүмүүсийг оролцуулан зохион байгуулах;

в/шатсан ой цэвэрлэж түлшний мод бэлтгэх, мод, бут, сөөг тарих замаар түүнийг нөхөн сэргээх, жимс, жимсгэнэ тариалах, ховор амьтад гаршуулан үржүүлэх, цөлжилтөөс хамгаалах зэрэг ажилд ажилгүй, ядуу иргэдийг хамруулах;

г/хот, суурин газрын агаар болон орчны бохирдлыг бууруулах, хог хаягдлыг устгах, дахин боловсруулах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх;

д/байгаль орчинтой зүй зохистой харьцах, түүнийг хамгаалах экологийн боловсрол,

хүмүүжил олгох байгаль орчинд хохирол учруулахгүйгээр өөрийн амьжиргаагаа сайжруулах талаарх сургалтыг иргэдийн дунд зохион байгуулах, энэ чиглэлээр иргэдээс гаргасан санал, гомдлыг шалгах, нийтэд сурталчилахад дэмжлэг үзүүлэх.

Г. Мэдээлэл судалгаа, сургалт сурталчилгааны хүрээ

19. Өрхийн амьжиргааны байдлын мэдээллийн сүүлээг бий болгох талаар шийдвэрлэх зорилт:

Төр, засгийн бодлого, хөтөлбөрүүд, тэдгээрийн хүн амын амьжиргаанд нөлөөлж буй байдлыг үнэлж дүгнэх, амьжиргааны түвшний өөрчлөлтөд судалгаа хийж мэдээллээр хангах тогтолцоо бүрдүүлэх.

20. Хэрэгжүүлэх арга хэмжээ:

а/Мэдээлэл, судалгааны бие даасан нэгж /төв/-ийг байгуулах, нийгмийн хамгааллын мэдээллийн сүлжээнд тулгуурласан мэдээллийн төвийг орон нутагт бий болгох;

б/орон нутагт нэн ядуу, ядуу болон бага орлоготой өрх, иргэдийг тодорхойлох арга зүйлээр болон судлуулан мөрдүүлэх, судалгаа явуулж, тэдгээрийн бүртгэл гарган байдлыг тандах;

в/хөтөлбөрийн хүрээнд болон хөтөлбөртэй холбоотой чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, төрийн бус болон бүяны байгууллага, иргэдийн талаарх мэдээллийг нэгтгэн сурталчилах, түүнд хэвлэл, мэдээллийн хэрэгсэл, интернетийн сүлжээг ашиглах;

г/хууль тогтоомжийн талаарх сурталчилгааг тогтмолжуулж, байгууллага, иргэдийг хэрэгцээт гарын авлага, материалаар хангах;

д/зээлийн эргэлтийн сангийн байдалд хяналт тавих, үнэлгээ хийх, үнэн зөв мэдээллээр хангах;

е/өрхийн бий болгож байгаа ажлын байрны талаарх мэдээллийг статистик мэдээлэлд оруулах.

21. Амьдрах арга ухааны болон мэргэжлийн боги но хүгацааны сургалтын талаар шийдвэрлэх зорилт:

Амьжиргааны доод түвшингээс бага орлоготой, хөдөлмөрийн насны, хөдөлмөрийн чадвартай иргэдэд амьдрах арга ухааны үндсэн мэдлэг болон түүнтэй мэргэжил олгох, мэргэжил дээшлүүлэх боги но хүгацааны сургалт зохион байгуулна.

22. Хэрэгжүүлэх арга хэмжээ:

а/орон нутагт мэдээлэл судалгаа, сургалт сурталчилгааны төвийг бий болгон ажиллуулахад дэмжлэг үзүүлэх;

б/орон нутгийн түвшинд сургалтын эрэлт, хэрэгцээг тодорхойлох, ажлын байрны эрэлт, хэрэгцээтэй уялдуулан мэргэжлийн сургалт явуулах;

в/мэргэжлийн сургалт зохион байгуулах арга зүйг боловсронгуй болгож, багшлах боловсон хүчнийг давтан болон шинээр бэлтгэх;

г/иргэдийн хууль эрх зүйн болон техник, технологи, эдийн засгийн боловсролыг дээшлүүлэх;

д/мэргэжлийн боги но хүгацааны болон амьдрах арга ухааны сургалтыг зохион байгуулах чадвартай аж ахуйн нэгж, байгууллага. Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвүүд, төрийн бус байгуулагын материаллаг баазыг түшиглүүлэн сургалт явуулах, тэдгээрийн материаллаг баазыг нь бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

е/мэдээлэл судалгаа, сургалт, сурталчилгааны төвүүдэд ахмадуудыг өөрсдийнх нь хүсэлтийн дагуу сонгон шалгаруулж ажиллуулах, тэдний мэдлэг, чадвар, ажил амьдралын туршлагыг амьдрах ухааны болон мэргэжлийн боги но хүгацааны сургалтад өргөн ашиглах.

Дөрөв. Олон нийтийн оролцоо

23. Өрхийн амьжиргааны чадавхийг дээшлүүлэхэд олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх талаар шийдвэрлэх зорилт:

Өрхийн амьжиргааны чадавхийг сайжруулах, ядуурлыг бууруулах ажилд олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх замаар дотоод нөөц бололцоогоо илруүлэн бүрэн ашиглаж, өмчийн бүх хэвшлийн аж ахуйн нэгж, төрийн бус байгуулага, иргэдийн саналчилга, үйл ажиллагаат дэмжиж эрчимжүүлнэ.

24. Өмчийн бүх хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагын оролцоо:

а/үйлдвэрлэлээ өргөтгөж, ажлын байр нэмэгдүүлэх талаар аж ахуйн нэгж, байгууллагаас саналчилга гаргах;

б/ажиллагсдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх зорилгоор үйлдвэрлэлийн цэвэр ашгаас нийгмийн хөгжлийн сан, цэцэрлэг, ясли, амралт сувилал байгуулах, туслах аж ахуйн хөгжүүлэх, орон сууц барих хөдөлгөөнийг өрнүүлэх;

в/ажиллагсдын мэдлэг,боловсролын түвшин, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэхэд байнга анхаарах, давтан сургах, мэргэшүүлэх;

г/ажиллагсдын хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн нөхцөлд онцгой анхаарах, тэднийг эрүүл мэндийн болон бусад даатгалд бүрэн хамруулах;

д/хөдөлмөрийн хуулийн хэрэгжилтийг үйл ажиллагаандаа мөрдөх, хүмүүст ажлын байр бий болгох;

е/сул чөлөөтэй ажлын байранд амьжиргааны доод түвшингээс бага орлоготой иргэдийг авч ажиллуулах санаачилга гарган тэдний амьжиргааг дээшлүүлэх талаар бодит туслалцаа үзүүлэн аж ахуйн нэгж, байгууллагыг нийтэд мэдээлж сурталчлах.

25.Төрийн бус байгууллагын оролцоо:

а/амьжиргааны доод түвшингээс доогуур орлоготой өрхийн гишүүдийг нийгмээс асруулагчид бишгүй улс орнуудаас эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулах чадвартай болгоход чиглэсэн үйл ажиллагаа явуулах, амьдрах арга ухаан, хөдөлмөр эрхлэх арга барилд сургах сургалт зохион байгуулах;

б/иргэд зээл, тусламж авах, хөдөлмөр эрхлэхэд нь туслах, зуучлах, тэдэнд зөвлөгөө өгөх зэргээр туслалцаа үзүүлэх;

в/олон нийтийн саналыг бодлого судлах, эрэлт хэрэгцээг тодорхойлох талаар судалгаа хийх, өрхийг дэмжих чиглэлийн тесөл боловсруулж хэрэгжүүлэх талаар санаачилга гаргах;

г/Засгийн газар, төрийн бус байгууллагын түншлэлийг өргөжүүлж нийгмийн халамж, асрамжийн үйлчилгээг нэмэгдүүлэх, хүний хөгжлийг тэтгэхэд чиглэсэн төрийн гүйцэтгэх байгууллагын зарим чиг үүргийг сонгон шалгаруулалтаар төрийн бус байгууллагаар гэрээний үндэсэн дээр гүйцэтгүүлэх хэлбэрийг ашиглах.

Тав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа, удирдлага, зохион байгуулалтын бүтэц, санхүүжилт,механизм

26.Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа:

а/өрхийн амьжиргааны чадавхийг дэмжих үндэсний хөтөлбөрийг 2001-2006 онд 2 үе шаттайгаар 6 жилийн хугацаанд хэрэгжүүлнэ;

б/эхний үе шат нь 2001-2003 он байх бөгөөд дунд хугацааны үнэлгээгээр хөтөлбөрт тодотгол хийж нэмэлт, өөрчлөлт оруулж болно. Хоёрдахь үе шат нь 2004-2006 онд үргэлжлэн явагдаж хөтөлбөрийн үр дүнг тооцно.

27. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалтын бүтэц

а/хөтөлбөрийн удирдах дээд байгууллага нь Өрхийн амьжиргааны чадавхийг дэмжих Үндэсний хороо /цаашид "Үндэсний хороо" гэх/ байна. Үндэсний хороог Ерөнхий сайд удирдана;

б/Үндэсний хороо нь орон тооны бус байгууллага бөгөөд төрийн захиргааны болон төрийн бус байгууллага, нийгмийн чиглэлийн үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэгч байгууллага, эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагын төлөөлөгчдөөс бүрдэнэ;

в/Үндэсний хороо нь хөтөлбөрийн хэрэгжилтийг улс орны нийгэм, эдийн засгийн бодлого, хүний хөгжлийн асуудлаархи бусад хөтөлбөртэй уялдуулан цогцолбор үйл ажиллагаа явуулна;

г/орон нутгийн түвшинд хөтөлбөрийн хэрэгжилтийг хариуцсан орон тооны бус зөвлөлийг Засаг даргаар ахлуулан холбогдох байгууллагын төлөөлөлтэйгээр байгуулж ажиллуулна;

д/өрхийн амьжиргааны чадавхийг дэмжих Үндэсний хорооны өдөр тутмын үйл ажиллагаа Өрхийн амьжиргааны чадавхийг дэмжих хөтөлбөрийн газар /цаашид "хөтөлбөрийн газар" гэх/ гардан зохион байгуулж, төв, орон нутгийн байгууллагыг мэргэжлийн удирдлага, дотоодын хяналтаар хангана;

е/орон нутгийн зөвлөл, хөтөлбөрийн газрын дүрэм, үйл ажиллагааны чиглэлийг Үндэсний хорооо батална;

ж/ямад нь хөтөлбөрийн хүрээнд эрхэлсэн асуудлын чиглэлээр бодлого боловсруулан Үндэсний хороотой зөвшилцөн үйл ажиллагааны уялдаа холбоог хангаж хэрэгжүүлнэ;

з/хөтөлбөрт туслагдсан бодлогын шинжтэй арга хэмжээг зохион байгуулах, хөрөнгө санхүүжилт олгохтой холбогдсон баримт бичгийн төслийг хөтөлбөрийн хэрэгжилтэд оролцож байгаа төслийг хөтөлбөрийн хэрэгжилтэд оролцож байгаа захиргааны төв байгууллагаас Засгийн газарт оруулж шийдвэрлүүлэх бөгөөд тэдгээрийн хэрэгжилтийг зохион байгуулах үүргийг Үндэсний хорооны удирдлагын дор Хөтөлбөрийн газар, төслийн нэгжүүд хариуцан гүйцэтгэнэ;

и/Үндэсний хорооны дэргэд судалгааны нэгж, зөвлөлдөх хэсэг ажиллаж болно. Судалгааны нэгжийн бүрэлдэхүүнийг төрийн захиргааны болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн байгууллагын төлөөлөгчид, эрдэм шинжилгээний ажилтнууд, төслийн мэргэжилтнүүдийн төлөөллийг оролцуулан Үндэсний хороо батална;

к/судалгааны нэгж нь ядуурал болон эдийн засаг, нийгмийн асуудлын харилцан хамаарлыг төр, засгийн бодлого, хөтөлбөрүүдийн хэрэгжилт, үйл ажиллагаатай уялдуулан судалж, тэдгээрийн өөр хоорондын эерэг болон сөрөг нөлөөллийг цогцолбороор авч үзэж мэдээллээр хангах чиглэлээр ажиллана;

л/аймаг, нийслэл, дүүрэгт хөтөлбөрийн хэрэгжилтийн асуудлыг хариуцан орон тооны ажилтан байна. Сумдад хөтөлбөрийн хэрэгжилтийг Засаг даргын Тамгын газрын эрүүл мэнд, хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал хариуцсан ажилтан хариуцна. Цаашид сумдад бие даасан бүтэц бий болгоход анхаарна.

28. Хөтөлбөрийн санхүүжилт:

Өрхийн амьжиргааны чадавхийг дэмжих үндэсний хөтөлбөрийн санхүүжилтийг дараахь эх үүсвэрээс бүрдүүлнэ:

а/орон нутагт бий болсон зээлийн эргэлтийн сан;

б/улс, орон нутгийн төсвөөс олгох хөрөнгө;

в/хандивлагч орон, олон улсын байгууллагын зээл, тусламж;

г/төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн санаачилгаар бүрдүүлэх зээл, тусламж, хандивын хөрөнгө;

д/хөрөнгийн бусад эх үүсвэр.

29.Хөтөлбөрийг хэрэгжүүлэх механизм.

Хөтөлбөрийн хүрээнд арга хэмжээг ядуурлыг бууруулах нэгдсэн сангийн механизмаар хэрэгжүүлнэ. Ядуурлыг бууруулах нэгдсэн сан, түүний дэд сангийн дүрэм, зааврыг шинэчлэн боловсруулж мөрдөнө.

Зургаа.Хөтөлбөрийн үр дүн, хяналт, мониторинг

30. Хөтөлбөрийн үр дүн:

а/төрийн захиргааны төв, орон нутгийн бүх шатны байгууллага, өмчийн бүх хэвшлийн аж ахуйн нэгж, айл өрх, иргэд, төрийн бус байгууллагын оролцоо, хамтын хүчин чармайлт, нэгдмэл үйл ажиллагаа, гадаад орон, олон улсын байгууллагын дэмжлэг туслалцааны үр дүнд хөтөлберт дэвшүүлсэн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлснээр амьжиргааны доод түвшингээс бага орлоготой өрхийн тоо 1999 онтой харьцуулахад 2003 оны эцэст 40, 2006 оны эцэст 60 хувиар тус тус буурсан байх;*

б/нийт өрхийн 80-аас доошгүй хувь нь амьжиргаанд нэн тэргүүний хэрэгцээгээ хангахад шаардагдах орлогын эх үүсвэртэй болсон байх;

в/орон нутагт мэдээлэл, сургалт, судалгаа, суртачилгаанд төв, мэдээллийн сүлжээ бий болсноор тодорхой мэргэжилгүй, боловсрол багатай, хөдөлмөрийн насны 300 мянган иргэдийг төрөл бүрийн сургалтад хамруулах.

31. Хөтөлбөрийн хяналт, мониторинг:

а/хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт, мониторинг хийх үүргийг сум, дүүрэг, аймаг, нийслэлийн зөвлөл, төрийн захиргааны төв байгууллагын мэдээлэл, үнэлгээ, хяналт, шинжилгээний албад хариуцна;

б/хөтөлбөрийн хяналт, мониторингийн үйл ажиллагаанд дэвшилтэт аргыг хэрэглэж, олон нийт, төрийн бус байгууллагыг өргөнөөр оролцуулна;

в/хөтөлбөрийн хэрэгжилтэд хөндлөнгийн хяналт хийх нөхцөлийг бүрдүүлнэ.

Долоо. Хөтөлбөрийн хэрэгжилтийг дүгнэх шалгуур үзүүлэлтүүд

32. Үндсэн шалгуур үзүүлэлт:

а/ядуурлын хамралтын хүрээ,нэн ядуурлын зэлэх хувь;

б/ядуурлын гүнзгийрэлтийн индекс, ялгааны индекс;

в/бага орлоготой иргэдийн хүн амд эзлэх хувийн жин.

33. Эрүүл мэндийн арга хэмжээг үнэлэх үзүүлэлт:

а/эх, нялхсын эндэгдлийн бууралтын хувь;

б/материаллаг бааз, үйлчилгээний орчин нь сайжирсан эмнэлгийн тооны өсөлт;

в/сум, баг, өрхийн эмнэлэгт олгосон түргэн тусламжийн унааны тоо;

г/эрүүл мэндийн төрөлжсөн болон нарийн мэргэжлийн үйлчилгээнд хамрагдсан ядуу өрх, эмэгт бүлгийн иргэдийн тоо, давтамж.

34. Боловсролын талаар хэрэгжүүлэх арга хэмжээг үнэлэх үзүүлэлт:

** 1999 онд ядуурлын статистикийн албан ёсны мэдээ байхгүй тул Үндэсний статистикийн газрын 1998 оны "Амжиргааны түвшний түүвэр судалгаа"-ны дүнг суурь үзүүлэлт болгон тооцсон.*

а/цэцэрлэгт шинээр хамрагдсан хүүхдийн тоо, үүнд ядуу, тахир дутуу болон эмээр бүрэлгийн хүүхдийн эзлэх хувь;

б/сургууль завсардалтын хувь, үүнээс ядуу болон малчдын хүүхдийн сургууль завсардалтын хувь;

в/материаллаг бааз, туслах ах ахуй нь сайжирсан цэцэрлэг, сургуулийн тооны өсөлт;

г/бие, эрхтэний согогтой хүүхдэд зориулсан сургалтын тоног төхөөрөмжөөр хангагдсан сургуулийн тоо.

35. Ажлын байр бий болгох чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээг үнэлэх үзүүлэлт:

а/бүрдүүлсэн санхүүгийн эх үүсвэр,хөрөнгийн хэмжээ;

б/бий болгосон түр ажлын байрны тоо, үүнд эмэгтэйчүүд, тахир дутуу иргэдийн эзлэх хувь;

в/бий болгосон байнгын ажлын байрны тоо, үүнд эмэгтэйчүүд, тахир дутуу иргэд ажиллаж байгаа ажлын байрны тоо;

г/байнгын орлоготой болсон ядуу өрх, иргэдийн тоо.

36. Нийтийг хамарсан ажлын үр дүнг дүгнэх үзүүлэлт:

а/засварласан гүүрийн тоо, замын уртын хэмжээ;

б/цэвэрлэсэн хур хог, талбайн хэмжээ;

в/сэргээн засварласан нийтийн ахуйн үйлчилгээний цэгийн тоо.

37. Санхүүгийн жижиг зээлийн үйлчилгээ хөгжүүлж, хувираа хөделмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээг үнэлэх үзүүлэлт:

а/бүрдүүлсэн нийт жижиг зээлийн сангийн хэмжээ;

б/шинээр байгуулагдсан санхүү, зээлийн үйл ажиллагаа явуулдаг банкны бус нэгжийн тоо;

в/зээл олгож бизнесийн үйл ажиллагаат нь урамшуулан дэмжсэн иргэдийн тоо, үүнд эмэгтэйчүүд, өрх толгойлсон эхчүүд, тахир дутуу иргэдийн эзлэх хувь.

38. Малгүй болон цөөн малтай иргэдийг малжуулах арга хэмжээг үнэлэх үзүүлэлт:

а/шинээр малтай болж мал маллагааны арга ухаанд суралцсан өрхийн тоо;

б/малжуулсан цөөн малтай өрхийн тоо, үүнд эмэгтэйчүүд, өрх толгойлсон эхчүүд, тахир дутуу иргэдийн эзлэх хувь;

в/малын тоо, малжуулах арга хэмжээнд зарцуулсан хөрөнгийн хэмжээ.

39. Байгаль орчныг хамгаалах арга хэмжээг үнэлэх үзүүлэлт:

а/шинээр гаргасан болон сэргээн засварласан худаг, булаг шандын тоо, ажилласан нэн ядуу, ядуу болон бага орлоготой хүмүүсийн тоо;

б/нөхөн сэргээсэн ойн талбайн хэмжээ /метр кв/, ажилласан нэн ядуу, ядуу болон бага орлоготой хүмүүсийн тоо;

в/шинээр цэцэрлэгжүүлсэн, тохижуулсан талбайн хэмжээ /метр кв/, ажилласан нэн ядуу, ядуу болон бага орлоготой хүмүүсийн тоо.

40. Судалгаа, мэдээллийн сүлжээг боловсронгуй болгох арга хэмжээг үнэлэх үзүүлэлт:

а/хүн амын амьжиргааны түвшин, ядуурлыг бууруулах бодлогын хэрэгжилтийн талаар явуулсан судалгааны тоо;

б/бий болсон мэдээллийн сүлжээ, мэдээллийн сангийн урсгалын байдал, мэдээллээр хангагдсан иргэд, аж ахуйн нэгжийн тоо.

41. Амьдрах арга ухааны болон мэргэжлийн богино хугацааны сургалт явуулах арга хэмжээг үнэлэх үзүүлэлт:

а/үйл ажиллагаа явуулж буй мэдээлэл судалгаа, сургалт сурталчилгааны төвийн тоо;

б/мэргэжил, ур чадвар, амьдрах арга ухааны сургалтад хамрагдсан иргэдийн тоо, үүнд эмэгтэйчүүд, өрх толгойлсон эхчүүд, тахир дутуу иргэдийн эзлэх хувь.

42. Олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх арга хэмжээг үнэлэх үзүүлэлт:

а/иргэдийн амьжиргааны чадавхийг дэмжихэд хувь нэмрээ оруулсан аж ахуйн нэгжийн тоо, зарцуулсан хөрөнгийн хэмжээ;

б/хөтөлбөрийн үйл ажиллагаанд хамрагдсан төрийн бус байгууллагын тоо, зарцуулсан хөрөнгийн хэмжээ;

в/хөтөлбөрийн үйл ажиллагаанд хамрагдан түүнийг хэрэгжүүлэхэд хувь нэмрээ оруулсан нийт өрх, иргэдийн тоо, үр шимийг хүртсэн өрх, иргэдийн тоо, зарцуулсан хөрөнгийн хэмжээ.

Засгийн газрын 2001 оны 108 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

ӨРХИЙН АМЬЖИРГААНЫ ЧАДАВХИЙГ ДЭМЖИХ ҮНДЭСНИЙ ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН

Дарга - Монгол Улсын Ерөнхий сайд

Дэд дарга: - Санхүү, эдийн засгийн сайд;
-Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд.

Гишүүд:
-Эрүүл мэндийн сайд;
-Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд;
-Хүнс, хөдөө аж ахуйн дэд сайд;
-Дэд бүтцийн дэд сайд;
-Байгаль орчны дэд сайд;
-Үйлдвэр, худалдааны дэд сайд;
-Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга;
-Гадаад хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;
-Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;
-Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга;
-Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамны Стратегийн төлөвлөлтийн газрын дарга;
-Шинжлэх ухааны академийн дэд ерөнхийлэгч /өөртэй нь тохиролцсоноор/
-Үндэсний статистикийн газрын дарга /өөртэй нь зөвшилцсөнөөр/;
-Төрийн бус 3 байгууллагын төлөөлөл.

Нарийн бичгийн дарга -Өрхийн амьжиргааны чадавхийг дэмжих хөтөлбөрийн газрын захирал.

Засгийн газрын 2001 оны 108 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт

ӨРХИЙН АМЬЖИРГААНЫ ЧАДАВХИЙГ ДЭМЖИХ ҮНДЭСНИЙ ХОРООНЫ ДҮРЭМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1. Энэхүү дүрмийн зорилго нь Өрхийн амьжиргааны чадавхийг дэмжих Үндэсний хороо /цаашид "Үндэсний хороо" гэх/-ны зохион байгуулалт, бүрэн эрх, үйл ажиллагааны зарчим, тус хорооноос ядуурлыг бууруулах асуудлаар нутгийн захиргааны болон дотоод, гадаадын байгууллагатай ажиллахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2. Үндэсний хороо нь "Өрхийн амьжиргааны чадавхийг дэмжих Үндэсний хөтөлбөр" /цаашид "хөтөлбөр" гэх/-ийг хэрэгжүүлэх ажлыг улсын хэмжээнд зохицуулах, нэгдсэн удирдлагаар хангах, хяналт тавих, биелэлтийг нь хангуулах, ядуурлыг бууруулах болон хөтөлбөрийн үйл ажиллагаанд оролцохыг эрмэлзэсэн төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн үүсгэл санаачилгыг дэмжих, тэдгээрийн ядуурлыг бууруулах чиглэлээр хийж буй ажлыг уялдуулан зохицуулах, хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий орон тооны бус байгууллага мөн.

Хоёр.Үндэсний хорооны удирдлага, зохион байгуулалт, бүрэлдэхүүн

3. Үндэсний хорооны бүрэлдэхүүнийг Засгийн газраас батлах бөгөөд уг хороо нь хөтөлбөрийн хэрэгжилтийг Засгийн газрын өмнө хариуцна.

4. Үндэсний хорооны бүрэлдэхүүнд төрийн байгууллагаас гадна эрдэм шинжилгээ, судалгааны болон төрийн бус байгууллагын төлөөлөгчдийг оролцуулна.

5.Үндэсний хорооны бүрэлдэхүүнд төрийн бус байгууллагаас 3 төлөөлөл байх бөгөөд эдгээр байгууллага нь жил бүр ээлжлэн солигдох зарчмаар ажиллана. Төрийн бус байгууллагын төлөөллийг Үндэсний хороо шийдвэрлэнэ.

6. Үндэсний хороо нь улирал тутам нэгээс доошгүй удаа хуралдах бөгөөд ээлжит бус хуралдааныг хорооны дарга зарлан хуралдуулж болно.

7. Үндэсний хорооны хуралдаан гишүүдийн ердийн олонхи хүрэлцэн ирснээр хүчин төгөлдөрт тооцогдох бөгөөд асуудлыг хуралдаанд оролцсон гишүүдийн ердийн

олонхийн саналаар шийдвэрлэнэ. Санал тэнцсэн тохиолдолд асуудлыг хуралдаан даргалагчийн саналаар шийдвэрлэнэ.

8. Үйл ажиллагааныхаа хүрээний асуудлаар Үндэсний хороо нь тогтоол гаргана.

9. Үндэсний хорооны ажлын албаны үүргийг Өрхийн амьжиргааны чадавхийг дэмжих хөтөлбөрийн газар гүйцэтгэнэ.

10. Үндэсний хорооны хурлаар хэлэлцүүлэх асуудлын төсөл нь урьдчилан нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнээр хянагдаж зөвшөөрөгдсөн байна.

Энэхүү шаардлагыг хангаагүй асуудлыг Үндэсний хорооны хурлаар хэлэлцэхгүй.

11. Үндэсний хороо нь тогтоосон журмын дагуу тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

Гурав. Үндэсний хорооны бүрэн эрх

12. Үндэсний хороо нь дор дурдсан үүрэгтэй байна:

а/хөтөлбөрийн хүрээнд жил бүр хэрэгжих арга хэмжээний тодотгосон төлөвлөгөөг хийж, эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх тухайн жилийн үндэсэн чиглэл, улсын төвлөрсөн төсөвт тусгуулж санхүүгийн эх үүсвэр /гадаад, дотоод/-ээр хангуулах ажлыг зохион байгуулах;

б/хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнг хянаж холбогдох тодотгол, өөрчлөлт оруулах;

в/Ядуурлыг бууруулах нэгдсэн сангаас аймаг, нийслэлийн Ядуурлыг бууруулах санд оруулах хөрөнгийн жил, улирлын хуваарийг хэлэлцэн шийдвэрлэх;

г/хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд зориулан улс, орон нутгийн төсвөөс олгосон хөрөнгө, дотоод, гадаадын хандивлагчдын зээл, тусламжийн зарцуулалт, ашиглалтад хяналт тавих, дэд төслүүдийн хэрэгжилтийг хангуулах талаар шаардлагатай арга хэмжээг авч шуурхай удирдлагаар хангах;

д/Ядуурлыг бууруулах нэгдсэн болон дэд сангийн үйл ажиллагаат уялдуулах;

е/Өрхийн амьжиргааны чадавхийг дэмжих хөтөлбөрийн газар, аймаг, нийслэл, сум, дүүргийн Өрхийн амьжиргааны чадавхийг дэмжих зөвлөлийн ажлын тайлан, хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн, сангийн хуваарилалт, ашиглалт, зарцуулалтын байдлыг хэлэлцэж холбогдох арга хэмжээ авах;

ж/Өрхийн амьжиргааны чадавхийг дэмжих хөтөлбөрийн газар, аймаг, нийслэл, дүүргийн Өрхийн амьжиргааны чадавхийг дэмжих зөвлөлийн нарийн бичгийн дарга нарын цалингийн сан, үйл ажиллагааны зардлын төсвийг хянаж, Санхүү, эдийн засгийн яамаар батлуулах;

з/хөтөлбөрийн хэрэгжилт, түүний үр дүнгийн талаар Засгийн газар, хандивлагч орнууд, олон улсын холбогдох байгууллагад тайлагнах;

и/ядуурлыг бууруулах чиглэлээр асуудал дэвшүүлэх, хандивлагч орон, олон улсын байгууллагатай гэрээ, хэлэлцээр байгуулахад санал өгөх, ажлаа салбарын яамдын бодлоготой уялдуулах;

к/хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд Засгийн газрын болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, иргэдийг ерөн оролцуулах боломжийг бүрдүүлэх, тэдгээрийн оролцоог нэмэгдүүлэх арга хэмжээ авах.

13. Үндэсний хороо нь дор дурдсан эрхтэй байна:

а/Ядуурлыг бууруулах сангийн хөрөнгийг хуваарилах, захиран зарцуулах, хяналт тавих;

б/ядуурлыг бууруулах сангаас холбогдох төслийг санхүүжүүлэх дүрэм, зааврыг батлах;

в/Өрхийн амьжиргааны чадавхийг дэмжих хөтөлбөрийн газар, аймаг, нийслэл, сум, дүүргийн Өрхийн амьжиргааны чадавхийг дэмжих зөвлөлөөс иргэдийн санал, гомдлыг хүлээн авч шийдвэрлэж байгаа байдалд хяналт тавьж, холбогдох арга хэмжээ авч хэрэгжүүлэх;

г/үйл ажиллагааны хүрээнд шаардагдах мэдээ, судалгааг холбогдох яам, агентлаг, нутгийн захиргааны байгууллагаас гаргуулан авах;

д/орон нутгийн зөвлөл, Өрхийн амьжиргааны чадавхийг дэмжих хөтөлбөрийн газрын дүрэм, жилийн ажлын төлөвлөгөөг батлах;

е/нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй зөвшилцөн хөтөлбөрийн газрын захирлыг томилох, чөлөөлөх.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 5 дугаар сарын 23-ны өдөр | Дугаар 114 | Улаанбаатар хот

Хөтөлбөр батлах тухай

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Арьс, шир" дэд хөтөлбөрийг 1 дүгээр хавсралт, хөтөлбөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 2 дугаар хавсралт ёсоор тус тус батлуулсугай.

2. "Арьс, шир" дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авч, биелэлтэд хяналт тавин ажиллаж, үр дүнг жил бүрийн 3 дугаар сард багтаан Засгийн газарт тайлагнаж байхыг Үйлдвэр, худалдааны сайд Ч.Ганзориг, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан хөрөнгийг 2002 оноос эхлэн жил бүр улсын төвлөрсөн төсөвт тусган санхүүжүүлж, гадаад орон, олон улсын зээл, тусламжийн хөрөнгийг татан оролцуулах арга хэмжээ авахыг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаан, Үйлдвэр, худалдааны сайд Ч.Ганзориг нарт даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

ҮЙЛДВЭР, ХУДАЛДААНЫ САЙД **Ч.ГАНЗОРИГ**

Засгийн газрын 2001 оны 114 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт

"АРЬС, ШИР" ДЭД ХӨТӨЛБӨР

Нэг. Салбарын өнөөгийн байдал

а/ Түүхий эдийн нөөц

Манай улс 2000 оны байдлаар 6.9 сая ширхэг арьс, ширэн түүхий эд бэлтгэх нөөцтэй байна. Үүний 49.2 хувь буюу 3.4 сая ширхгийг хонины арьс, 27.5 хувь буюу 1.9 сая ширхгийг ямааны арьс, 10.1 хувь буюу 0.7 сая ширхгийг үхрийн шир, 6.1 хувь буюу 0.4 сая ширхгийг адуу, тэмээний шир, 1.4 хувь буюу 0.1 сая ширхгийг тарваганы арьс, 5.4 хувь буюу 0.36 сая ширхгийг бусад төрлийн арьсан түүхий эд эзэлж байна.

2000 оныг 1989 онтой харьцуулахад хонь 458, тэмээ 236 мянган толгойгоор хорогдож, үхэр 395, адуу 450 мянга, ямаа 5.2 сая толгойгоор өсжээ.

Үүнтэй уялдан түүхий эд бэлтгэлийн хэмжээ 2000 онд 1989 оныхоос 1.4 хувиар, үүний дотор ямааны арьсных 19, үхрийн ширнийх 33.4, адууны ширнийх 68.6, тэмээний ширнийх 11.6 хувиар өсөж, хонины арьсных 19.0, тарваганы арьсных 88.7 хувиар буурчээ.

б/ Хүч чадлын ашиглалт

Арьс ширний үйлдвэрийн салбарт 1989 онд арьс, шир боловсруулах, бэлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх чиглэлийн 13 үйлдвэр ажиллаж, жилдээ 610 мянган ширхэг адуу, үхрийн шир, 4.0 сая ширхэг хонь, ямааны арьс, 1.0 сая ширхэг ангийн үс боловсруулж, 250 гаруй мянган ширхэг савхин хувцас, 180 мянган ширхэг нэхий болон тарваган дээл үйлдвэрлэн нийт бүтээгдэхүүний 90 гаруй хувийг экспортлож байв.

2000 онд нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэл 1989 оныхоос 99 хувиар буурчээ.

1990 оноос өнөөг хүртэлх хугацаанд үхрийн шир, хонь, ямааны арьс боловсруулах чиглэлийн 24, ангийн үс боловсруулах чиглэлийн 4, савхи, нэхий эдлэлийн 10, бүгд 48 жижиг, дунд үйлдвэр шинээр байгуулагдаж, жилдээ 7.9 сая ширхэг төрөл бүрийн арьсанд анхан шатны боловсруулалт хийх хүч чадал суурилагдан боловч үйл ажиллагаагаа ямар нэг хэмжээгээр үргэлжүүлж байгаа томоохон үйлдвэрүүдийн хүч чадлын ашиглалт 10 хувьд хүрэхгүй байна.

Түүнчлэн анхан шатны боловсруулалтын хүч чадал одоо байгаа түүхий эдийн нөөцөөс 12.6 хувиар давжээ.

Монгол Улсын экспортын бүтээгдэхүүний үйлдвэрлэлд томоохон байр суурь эзэлж байсан савхин болон үслэг эдлэлийн үйлдвэр, гутлын үйлдвэр, улны ширний үйлдвэр, үйлдвэрүүдийн хатуу хаягдал боловсруулах зориулалт бүхий халимаан цавууны үйлдвэр, завод ноос угаах үйлдвэрийн үйл

ажиллагаа бүрэн зогсоод байна.

в/ Байгаль орчин, экологи

Арьс, шир боловсруулах үйлдвэрүүд нь 30 гаруй төрлийн химийн бодисыг ашиглан үйлдвэрлэл явуулдаг, байгаль, экологийн асуудлаар олон нийтийн анхаарлын төвд байдаг салбарын нэг юм.

Үйлдвэрээс гарсан бохир ус урьдчилан цэвэрлэх байгууламжаар дамжин төвийн цэвэрлэх байгууламжид очдог. Цэвэрлэх байгууламжийг 1972 онд байгуулснаас хойш өнөөг хүртэл техник, технологийн шинэчлэлт хийгээгүйгээс уг байгууламжийн цэвэрлэх чадвар буурч, бохир усны найрлага дахь химийн хэмжээ стандартын зөвшөөрөгдөх үзүүлэлтээс давах болов. Тухайлбал: 1999, 2000 онуудад хийсэн шинжилгээний дүнгийн түүвэр судалгаанаас үзэхэд урьдчилан цэвэрлэсэн бохир усны найрлага дахь сульфидийн хэмжээ зөвшөөрөгдөх үзүүлэлтээс 1.6, гурван валенттай хромын хэмжээ 1.3, азотын хэмжээ 10.7 хувиар дээгүүр гарсан нь байгаль орчин, экологид хортой нөлөө үзүүлэхээр байна.

Технологийн бохир усанд Стандартын шаардлагаар 34 үзүүлэлтээр шинжилгээ хийх ёстой боловч энэ шаардлагыг хангахуйц лаборатори манай улсад байхгүй байгаа нь усны цэвэрлэгээний түвшинг бүрэн тодорхойлж чадахгүй байна.

Арьс ширний үйлдвэрүүдийн газар доорхи инженерийн шугам, сүлжээний эзэмшил, харьяалал тодорхойгүйгээс засвар үйлчилгээ олон жилээр хийгдээгүй, улмаар шугам хоолой элэгдэж, түүний нүх сүвээр шүүрсэн бохир ус хөрсөнд шингэж, хөрс шимгүй болох, хатах зэрэг гэмтэл үүсэж байна.

Боловсруулах үйлдвэрүүдээс гарсан шар мах, год, могоон зоргодол их хэмжээгээр ил задгай хаягдаж, байгаль орчныг бохирдуулж байна.

Ер нь сүүлийн үед олон жижиг аж ахуйн нэгж, түүний дотор гадаадын хөрөнгө оруулалттай үйлдвэрүүд зориулалтын бус байранд, инженерийн шугам сүлжээгүй газар арьс ширний анхан шатны боловсруулалтыг хийж байгаа нь байгаль орчныг хамгаалахад сөрөг нөлөө үзүүлж байгаа анхаарах шаардлагатай байгаа юм.

г/ Ажлын байрны эрүүл ахуй, хөдөлмөрийн нөхцөл

Үйлдвэр, аж ахуйн нэгжүүд нь химийн хорт бодисыг нойтон шалтай зориулалтын бус байранд түүхий эд, материалын хамт хадгалж байна.

Үүнээс үүдэн ажлын байрны бүсийн агаарын хэм эрүүл ахуйн зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс 3-5 дахин бага, хүйтэн, харьцангуй чийглэг нь 10-25 хувиар их байгаа явдал мэргэжлээс шалтгаалах өвчнөөр өвчлөгсдийн тоо нэмэгдэхэд хүргэж байна.

Энэ салбарт 2000 оны байдлаар үйлдвэр, аж ахуйн нэгжүүд жилдээ нэг хүнд дунджаар 12 мянган төгрөгийн өртөг бүхий хөдөлмөр хамгааллын хувцас, багаж хэрэгсэл олгожээ. Энэ нь зах зээлийн өнөөгийн халшаар зөвхөн нэг хос ажлын хувцас худалдан авах өртөг юм. Үүнээс үзэхэд ажиллагсад амьсгалын болон арьс салстыг хамгаалах хэрэгсэл хэрэглэх боломж бага, үйлдвэрүүдэд осол, хурц хордлого гарч болзошгүй байна.

д/ Өрсөлдөх чадвар

Зах зээл дэх Монгол Улсын байр суурь.

Арьс, ширэн түүхий эд нийлүүлж, боловсруулж дэлхийн зах зээлд гаргадаг улсуудын тоонд Европын Холбооны орнууд, АНУ, Австрали, Шинэ Зеланд, ОХУ, БНХАУ, Энэтхэг, БНСУ, Монгол Улс багтаж байна.

Дээрх орнууд 2000 онд 85.0 тэрбум америк долларын арьс, ширэн бүтээгдэхүүн үйлдвэрлэсний 37.3 хувийг АНУ, 37.0 хувийг Европын Холбооны орнууд, 10 хувийг Австрали, үлдсэн хувийг Шинэ Зеланд, ОХУ, БНХАУ, БНСУ, Монгол Улс эзэлж байна. Харин экспортын хувьд БНХАУ, Энэтхэг Улс, АНУ, Бразиль, Итали, БНСУлс тэргүүлж байна.

Зүүн өмнөд Азийн эдийн засгийн хямралын нөлөөгөөр тухайн тивийн орнуудаас экспортлох түүхий эдийн хэмжээ 1995-1998 онуудад 23-32 хувиар буурсан байхад манай улсын хувьд энэ нь 2000 онд 1989 оныхоос 37.7, үүнээс боловсруулаагүй хонины арьсны экспорт 92.0, ямааны арьсны экспорт 64.5, үхрийн ширний экспорт 89.3 хувиар өсжээ.

Үүнтэй уялдан түүхий эдийн боловсруулалтын түвшин 2000 онд 1989 оныхоос 86.4 хувиар буурсан дүн гарч байна.

Монголын арьс, ширэн

бүтээгдэхүүний экспорт 1995 онд 3.8 сая ам.доллар байсан бол 2000 онд 3.2 сая ам.доллар болж бэлэн бүтээгдэхүүний экспорт 15.8 хувиар буурчээ.

Бүтээгдэхүүний чанарын түвшин

Арьс ширний анхан шатны боловсруулалтын үйлдвэрийн зориулалт өөрчлөгдөж, түүхий эдэд газар дээр нь чанарын хамгаалалт хийх явдал үгүй болсон байна.

Түүхий эд бэлтгэлийн нэгдсэн систем задран унасан нь арьсны амьдын болон бэлтгэлийн гэмтлийг нэмэгдүүлэх боллоо.

Хонь, ямааны арьсны амьдын гэмтэл 2000 онд 1992 оныхоос 2 дахин, түүхий эдийн бэлтгэлийн үед гардаг механик гэмтэл 17.8 хувиар өсжээ.

Том мал, бодын ширийг хүндийн жингээр бус уртын хэмжээгээр авдаг стандартын бус арга давамгайлах болж, ширний талбайг ихэсгэх зорилгоор зүсэж хэрчих, сунгах, татах зэргээр хөрсөнд механик гэмтэл үүсгэх болов.

Мал хувьд шилжих малын өвчин, эмгэггэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажиллагаа орхигдсон нь арьс, ширэн түүхий эдийн чанар муудах, амьдын гэмтэл ихсэхэд нөлөөлж байна. Манай улсын хувьд арьс, ширэн түүхий эдийн амьдын болон механик гэмтэл бусад орныхоос харьцангуй их, талбайн ашиглалт муу байна.

Арьс, ширэн эдлэлийн чанар нь түүхий эд болон боловсруулалтад ашиглаж буй химийн бодис, материалын чанараас шууд хамаардаг. Боловсруулах үйлдвэрүүдийн санхүү, эдийн засгийн чадавхи сулаас өндөр чанартай, олон улсын стандартад нийцсэн химийн материал, бодис худалдан авч үйлдвэрлэлд ашиглах боломж бага байна.

2000 онд 16.9 мянган америк долларын химийн бодис, материалыг гадаадаас худалдан авсны 45.0 хувийг БНХАУ, 29.6 хувийг БНСУ, 25.4 хувийг бусад орноос импортолжээ. Үүнээс үзэхэд дэлхийн зах хээлд нэр хүндтэй химийн үйлдвэрүүдийн бүтээгдэхүүнийг манай улс ашиглаагүй байна.

Арьс шир боловсруулах үйлдвэрүүдийн бүтээгдэхүүний чанар, техник, технологийн түвшин, менежментийн үйл ажиллагаат сайжруулахад дэмжлэг үзүүлэх зорилгоор хэрэгжүүлж буй "Жижиг, дунд үйлдвэрт зөвлөгөө өгөх алба" төслийн хүрээнд "Булигаар", "Монгол шевро" болон зарим жижиг, дунд үйлдвэрүүд дээр хийсэн бүтээгдэхүүний чанар сайжруулах туршилтын ажлын үр дүнгээс үзэхэд сайн чанарын химийн бодис ашиглан технологийн горимыг чандлан мөрдөж үйлдвэрлэл явуулбал монголын арьсан бүтээгдэхүүний чанар олон улсын стандартад нийцэх боломж байна.

Гэвч боловсруулсан зарим нэр төрлийн арьсны өнгө янзалгаа, будгийн тогтвор, олон нугаралт зэрэг үзүүлэлт тэр бүр зах зээлийн шаардлага хангахгүй тал байна.

Бүтээгдэхүүний зах зээл

Дэлхийн арьс, шир боловсруулах салбарын үйлдвэрүүд арьс, ширийг автомашин, мебель, гутал, хувцас, жижиг эдлэл, гоёлын бүтээгдэхүүн хийхэд зориулан боловсруулж байна. Ялангуяа Европын орнууд, түүний дотор ХБНГУ, Азийн орнуудаас Япон Улс мебелийн, Итали Улс гутлын, БНСУлс хувцасны зориулалттай арьс боловсруулахад тэргүүлэх байр эзлэх болов.

Монгол Улс арьс, ширийг гутлын их бие, ул, бэлэн хувцасны зориулалтаар боловсруулж байна.

Арьс, ширэн эдлэлийг бүтээгдэхүүний чанарын түвшинээр нь дээд, дунд, доод гэж ангилдаг. Дээд зэргийн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг орнуудын тоонд Итали, ХБНГУ, АНУ, Япон Улс багтах бөгөөд дунд зэргийн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг орнуудад БНСУ зэрэг Азийн орнууд орж байна. 1990 оны түвшинд манай улс дунд зэргийн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг орнуудын эгнээнд байсан бөгөөд одоогоор доод түвшинд шилжин орох хандлага бий болоод байна.

Манай улсын түүхий эдийн нөөц, төрөл, чанар, онцлогоос үзэхэд хувцасны зориулалтын арьсны үйлдвэрлэлийг түлхүү хөгжүүлэх нь илүү ур дүнтэй байна. Монгол хонь, ямааны арьс нь хувцасны савхи үйлдвэрлэхэд илүү тохиромжтой, дэлхийн зах зээлд жилд 60.0-70.0 сая ширхэг энэ төрлийн боловсруулсан арьсны хэрэгцээ байдаг. Монгол улс дээрх хэрэгцээний 11.4-13.3 хувийг үйлдвэрлэх боломжтой байна.

Үйлдвэр, аж ахуйн нэгжийн санхүү, эдийн засгийн чадавхи

1990 оноос хойш салбарын үйлдвэрүүдийн 90 гаруй хувь нь хувьд шилжсэн

хэдий ч манай улсын банк, санхүүгийн системийн хямрал үйлдвэрлэгчдэд хүчтэй нөлөө үзүүлэв.

Банкны зээл хомс, хүү өндөр, хугацаа богино байгаагаас шалтгаалан үйлдвэрлэл явуулах, техник, технологийг шинэчлэх боломж бага байв. Түүхий эдээ худалдан авах чадваргүй болсны зэрэгцүэ дотоодын зах зээлийг импортын бараа, бүтээгдэхүүн эзэлж, бүтээгдэхүүний үйлдвэрлэл 1990 оноос өнөөг хүртэл жилээс жилд буурч байлаа.

Хоёр. Арьс, ширний үйлдвэрийн салбарын эрхэм зорилго, хөгжлийн стратеги

Арьс, ширний үйлдвэрийн салбарын эрхэм зорилго нь байгшн нөхөн сэргээгдэг түүхий эдийг түүний бүтэц, чанар, онцлогт тохирсон, экологид халгүй, дэвшилтэт технологиор иж бүрэн боловсруулж, бүтээгдэхүүний чанарыг олон улсын зах зээлийн шаардлагад нийцүүлэх, ерөлдөх чадварыг дээшлүүлэх замаар салбарын тогтвортой хөгжлийг ханагаа оршино.

Эрхэм зорилгыг хэрэгжүүлэх арьс, ширний салбарын үйлдвэрийн хөгжлийн стратеги нь дараахь чиглэлээс тогтоно:

а/бодлогын сонголтоор хөгжүүлэх үйлдвэр;

б/зах зээлийн сонголтоор хөгжүүлэх үйлдвэр.

Бодлогын сонголтоор хөгжүүлэх үйлдвэрт боловсруулах, хоёрдогч түүхий эд ашиглах үйлдвэр, зах зээлийн сонголтоор хөгжүүлэх үйлдвэрт эцсийн бэлэн бүтээгдэхүүний үйлдвэр орно.

Хөгжлийн стратегийн ойрын хугацааны зорилт нь "Арьс, шир" дэд хөтөлбөрийн хүрээнд 2001-2004 онд хэрэгжүүлэх арга хэмжээгээр тодорхойлогдох бөгөөд хэтийн хөгжлийн чиглэл нь эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, экспортыг нэмэгдүүлэх бодлого байна.

Гурав. Хөтөлбөрийг боловсруулах үндэслэл

1. "Арьс, шир" дэд хөтөлбөрийг боловсруулах үндэслэл нь Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын эдийн засаг, ниймийг хөгжүүлэх үндэсн чиглэл, "Аж үйлдвэрийг сэргээх, хөгжүүлэх" Засгийн газрын бодлого, "Шинжлэх ухаан, технологийг 2010 он хүртэл хөгжүүлэх Засгийн газрын хөтөлбөр" болно.

Дөрөв. Хөтөлбөрийн зорилго, зорилт

2. Хөтөлбөрийн зорилго нь арьс, ширний үйлдвэрийн салбарын хөгжлийн эрхэм зорилго, хөгжлийн стратегитай уялдуулан хүч чадлын ашиглалтыг дээ дараатай нэмэгдүүлж, салбарын эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэхэд чиглэнэ.

3. Хөтөлбөрийн зорилгыг хэрэгжүүлэх хүрээнд дараахь зорилтыг шийдвэрлэнэ. Үүнд:

а/түүхий эдийн чанарыг сайжруулах зорилгоор "Арьс, шир" дэд хөтөлбөрийг "Малын эрүүл мэнд", "Малын чанар, үржлийн ажил, үйлчилгээг сайжруулах" хөтөлбөрүүдтэй уялдуулан хэрэгжүүлэх;

б/түүхий эд бэлтгэлийг ноос, ноолуур, мах боловсруулах үйлдвэрүүдтэй хоршин зохион байгуулж, Бөөний худалдаа сүлжээгээр түүхий эд бэлтгэх систем тогтоох;

в/үйлдвэрүүдийн хүч чадлын ашиглалтыг дээшлүүлж, тогтвортой ажиллагааг ханган эрх зүй, эдийн засгийн таатай орчин бүрдүүлэх;

г/салбарын үйлдвэрүүдийн менежментийг сайжруулах, техник, технологийг шинэчлэх, түүхий эдийн боловсруулалтын түвшинг дээшлүүлэх, бүтээгдэхүүний чанарыг олон улсын зах зээлийн шаардлагад нийцүүлэх замаар үйлдвэрлэл, экспортыг нэмэгдүүлж, салбарын ерөлдөх чадварыг сайжруулах;

д/байгаль орчин, хүний эрүүл мэндэд халгүй технологийг үйлдвэрлэлд нэвтрүүлж, экологийн цэвэр бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлэх.

Тав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд баримтлах зарчим

4. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үндсэн зарчим нь төр болон салбарын мэргэжлийн холбоод, шинжлэх ухаан, төрийн бус байгуулага, үйлдвэр, аж ахуйн нэгж, бизнес эрхлэгчдийн хамтын ажиллагаа юм.

5. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ салбарын эрхэм зорилго, зах зээлийн хөгжлийн чиг хандлагатай уялдуулан дараахь зарчмыг баримтална. Үүнд:

а/малын элдэв паразит халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг эрчимжүүлэхэд хөдөө аж ахуйн салбарын байгуулагуудтай хамтран ажиллах, мах болон арьс, шир боловсруулах үйлдвэрүүдийн уялдаг хөгжүүлэх, түүхий эдийн чанарын хамгаалалтыг

технологийн дагуу хийх ажлыг зохион байгуулах замаар түүний эдийн чанарыг сайжруулах;

б/төвлөрсөн цэвэрлэх байгууламж, дэд бүтцийг түшиглэн анхан шатны боловсруулалтын чиглэлийн үйлдвэрийг хөгжүүлэх;

в/гутал, хувцасны зориулалттай арьс, шир боловсруулах чиглэлээр урьд өмнө бий болсон хүч чадлын ашиглалтыг дээшлүүлэх;

г/арьс, ширэн бүтээгдэхүүний зах зээлийн тандалт судалгааг өргөжүүлж, түүнд үндэслэн шинэ нэр төрлийн эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, экспортыг нэмэгдүүлэх;

д/түүхий эдийн бэлтгэл, үйлдвэрлэл, борлуулалтын хэлхээг ашиглаж бүтээгдэхүүний чанарт тохирсон зах зээлийн нэгдсэн тогтолцоог хөгжүүлэх, үйлдвэр, аж ахуйн нэгж, бизнес эрхлэгчдийн үйл ажиллагааг түүний эдээ бүрэн боловсруулахад чиглүүлэх.

Зургаа. Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ

6. Хөтөлбөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээг хавсралтаар үзүүлэв.

7. Эдгээр арга хэмжээ нь хөтөлбөрийн нэг болон хоёрдугаар үе шатны зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэх бөгөөд гуравдугаар үе шатны зорилтыг тухайн үеийн нөхцөлд тохируулан боловсруулж, холбогдох арга хэмжээг тодотгох замаар хөтөлбөрийн зорилтын хэрэгжилтийг ханган.

Долоо. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт, хяналт

8. Хөтөлбөрийн зорилтын хэрэгжилтийг ханган арга хэмжээг Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндэсэн чиглэл, улсын төсөвт жил бүр тусгах замаар улсын хэмжээнд Үйлдвэр, худалдааны сайдын, орон нутагт аймаг, нийслэлийн Засаг даргын удирдлагын дор зохион байгуулна.

9. Хөтөлбөрт заасан арга хэмжээг холбогдох яам, байгууллагын удирдах хүмүүс хариуцан хэрэгжүүлэх бөгөөд биелэлтэд нь Үйлдвэр, худалдааны сайд хяналт тавина.

10. Үйлдвэр, худалдааны сайд нь хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний биелэлтийг холбогдох байгууллагуудаас улирал тутам авч нэгтгэн үр дүнг жил бүрийн 3 дугаар сард Засгийн газарт тайлагнана.

11. Хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган зорилгоор Үйлдвэр, худалдааны сайд нь холбогдох байгууллагын төлөөллийг оролцуулсан ажлын хэсэг байгуулан ажиллаж болно.

Найм. Хөтөлбөрийн санхүүжилт

12. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дор дурдсан санхүүгийн эх үүсвэрийг ашиглана:

а/улсын төсөв;

б/орон нутгийн төсөв;

в/гадаад орон,олон улсын байгууллагын зээл,тусламж;

г/үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн өөрийн хөрөнгө;

д/бусад.

Ес. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа

13. Хөтөлбөрийг 2001-2010 онуудад дараахь үе шаттайгаар хэрэгжүүлнэ:

Нэгдүгээр үе шат 2001-2003. Салбарын тулгамдсан асуудлыг шийдвэрлэж, боловсруулах үйлдвэрүүдийн хүч чадлын ашиглалтыг дээшлүүлэн үйлдвэрлэлийг хэвийн өсөлттэй явуулах нөхцөлийг бүрдүүлэх.

Хоёрдугаар үе шат 2004-2006. Түүхий эд, хагас бэлэн бүтээгдэхүүний боловсруулалтын түвшинг ахиулж, эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, экспортыг дэс дараатай нэмэгдүүлэх.

Гуравдугаар үе шат 2007-2010. Арьс, ширэн түүхий эдийн нөөцийг бүрэн ашиглах, бүтээгдэхүүний чанарыг олон улсын зах зээлийн түвшинд хүргэх, байгаль орчинд халгүй технологийг үйлдвэрлэлд нэвтрүүлж, экологийн хувьд цэвэр бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх замаар өрсөлдөх чадварыг дээшлүүлж, салбарын хөгжлийн стратегийн эрхэм зорилгыг ханган.

Арав.Хөтөлбөрийг хэрэгжүүлснээс гарах үр дүн

14. Хөтөлбөрийн нэг болон хоёрдугаар үе шатны зорилтыг хэрэгжүүлснээр дараахь үр дүнд хүрнэ:

а/арьс, ширний салбарын бүтээгдэхүүний үйлдвэрлэл 2004 он гэхэд 1999 оныхоос дүнджаар 24.0 хувиас доошгүй өсөх;

б/боловсруулсан арьс, шир, бэлэн бүтээгдэхүүний экспорт 2004 онд 1999 оныхоос 30, улсын нийт экспортод тус салбарын эзлэх хувь 38 хувиас доошгүйгээр тус тус нэмэгдэх;

в/боловсруулах үйлдвэрүүдийн хүч чадлын ашиглалт 27.6, эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрүүдийн хүч чадлын ашиглалт 20.0 хувиар өсөж, салбарын хэмжээнд ажилгүйдэл 23.8 хувиар буурах.

"АРЬС, ШИР" ДЭД ХӨТӨЛБӨРӨӨР ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

№	Зорилт	Арга хэмжээ	Хугацаа	Санхүүжилт, сая төгрөг					Хариуцах байгууллага
				2002	2003	2004	Дүн	Эх үүсвэр	
1	Түүхий эдийн чанарыг сайжруулах зорилгоор "Арьс, шир" дэд хөтөлбөрийг "Малын эрүүл мэнд", "Малын чанар, үржлийн ажил, үйлчилгээг сайжруулах" хөтөлбөрүүдтэй уялдуулан хэрэгжүүлэх	1/Мах боловсруулах томоохон үйлдвэрүүдийн хүч чадлын ашиглалтыг сайжруулах, орон нутагт жижиг үйлдвэр байгуулахыг дэмжих замаар малыг үйлдвэрийн аргаар нядлах ажлыг зохион байгуулах	2001-2004	-	-	-	-	-	ҮХЯ, ХХААЯ
		2/"Арьс, ширний анхан шатны тордолтын сургалт, судалгаа" төсөл хэрэгжүүлэх	2002-2004	204.5	204.5	-	409.0	Олон улсын байгууллагын техникийн тусламж	ҮХЯ, СЭЗЯ
		3/Мал аж ахуйн гаралтай түүхий эдийг худалдах төрөлжсөн захын ажлын байрны түвшинг тогтоох шалгуур боловсруулж, эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны шаардлагын дагуу ажиллуулах	2002-2004	-	-	-	-	-	ҮХЯ, ХХААЯ, ЭМЯ
2	Түүхий эд бэлтгэлийг нооц, ноолуур, мах боловсруулах үйлдвэрүүдтэй хоршин зохион байгуулж, Бөөний худалдаа сүлжээгээр бэлтгэх систем тогтоох	1/Түүхий эдийг биржээр дамжуулан худалдах, худалдан авах журамд шилжих	2001	-	-	-	-	-	ҮХЯ
		2/"Хедөө худалдаа" төсөл хэрэгжүүлэх	2002-2004	146.3	146.4	-	292.7	Олон улсын байгууллагын техникийн тусламж	ҮХЯ, СЭЗЯ
		3/Махны үйлдвэрээс гарсан арьс, ширийг боловсруулах үйлдвэрт өгөх худалдааны сүлжээ бий болгох ажлыг зохион байгуулах	2001-2004	-	-	-	-	-	ҮХЯ, ХХААЯ
		4/Арьс, ширэн түүхий эдийн бэлтгэлийн стандартыг хянаж, шинэчлэх	2001-2002	-	-	-	-	-	ҮХЯ, СХЗҮТ

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ
2001 он, №29 (216)

		5/Арьс, ширэн түүхий эдийг мал эмнэлэг, ариун цэвэр болон чанарын батлагаажуулалтыг эхлэлээс нь үндэслэн экспортлох журам тогтоох	2001-2004	-	-	-	-	-	УХЯ, СХЭҮТ
3	Салбарын үйлдвэрүүдийн хүч чадлын ашиглалтыг дээшлүүлэх, ажилгаагаа хэвтэх эрх олгох, эдийн засгийн төвтэй орчин бүрдүүлэх	1/ОХУ-д төлөх урсгал ерөнд болзвэрүүлсэн арьс, шир, савхий болон үслэг эдлэл нийлүүлэх боломжийг судалж шийдвэрлэх	2001-2004	-	-	-	-	-	УХЯ, СЭЗЯ, УГЕГ
		2/Дотоодын үйлдвэрлэгчдийн бүтээгдэхүүний үнэлэгдэхүй, дотоод зах зээлийн ашиглалтыг сайжруулах зорилгоор төрийн болон орон нутгийн ёмөийн хөрөнгөөр худалдан авах барааг, хөрөнгөө худалдан авах үйлчилгээний гүйцэтгэгч аймаг, нийслэл хүүхэд хөгжлийг сонгох, нийлүүлэгч аж ахуйн нэгжийг, өөрөөлөгт орлогтой судалж боловсруулах	2002	-	-	-	-	-	УХЯ, СЭЗЯ
		3/Арьс, ширэн эдлэлийн жилийн дүнд үйлдвэрлэх орон нутаг үүсгэн эдийн засгийн хэлхээгүйг механизмыг бүрдүүлж хэрэгжүүлэх	2002-2004	-	-	-	-	-	УХЯ, Архангайн банк, аймаг нийслэлийн Засаг дарга
		4/Үндэсний болон хөдөө орон нутгийн хэрэгцээнд зохицсон гутлын хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлээр ханган зөрөө хэмжээ дэс дараатай авч хэрэгжүүлэх	2001-2004	-	-	-	-	-	УХЯ
		5/Үйлдвэр, аж ахуйн нэгжийн эргэлтийн хөрөнгийн санг нэмэгдүүлэх зорилгоор үнэт цаас гаргах ажлыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх	2002-2004	-	-	-	-	-	Хөрөнгийн бирж СЭЗЯ
		6/Салбарын болон үслэг эдлэлийн зах зээлийн чиг хандлагыг судлалын үндсэн дээр мэдээлэл солилцон үйлдвэрлэгчдэд хүргэх ажлыг тогтмолжуулах	2002-2004	-	-	-	-	-	УХЯ, ГХ ХОА, ТИС

4	Салбарын үйлдвэрүүдийн менежментийн сайжруулах, техник, технологийг шинэчлэх, түүний эдийн бусдруулалтын гүйцэтгэх дэлгэцүүлэх, бүтээгдэхүүний чанарыг олон улсын зах зээлийн шаардлагад нийцүүлэх үйлдвэрлэл, нэмэгдүүлж, ерөнхий сайжруулах чадварыг	1/Салбарын үйлдвэрүүдийн техник, технологийг шинэчлэх чиглэлээр тесеп зэрэгжүүлэх.	2002-2004	-	-	-	-	-	ҮХЯ
	2/Салбарын эрдэм шинжилгээний байгууллагын лабораторийн тоног тоноглолыг шинэчлэх, асуудлаар НҮБ-ын үйлдвэрийн хөгжлийн байгууллага (ЮНИДО)-тай хамтран ажиллах.	2002-2004	-	-	-	-	-	-	ҮХЯ, ГХЯ
	3/Арьс, ширэн түүхий эдийн бүтэц, шинж чанарын онцлог, хэмжээ, байгаль орчинд халтүй дарааль технологийн бий болгох, үйлдвэрлэлд нэвтрүүлэх.								
	а)дөнгөн идээлэгдэх хэрэгсэл болоогүй арьс, ямаагаа арьс (wet blue)	2002	10.0	-	10.0	Улсын төсөв			ҮХЯ, БСШУЯ
	б)дөнгөн бус идээлэгдэх хэрэгсэл болоогүй арьс, ямаагаа арьс (wet white)	2002	-	5.0	5.0	Улсын төсөв			ҮХЯ, БСШУЯ
	в)бүрэн бүдэгдэй болон бүдэгдүй хэрэгсэл болоогүй үхэр, хонь, ямаагаа арьс (crust)	2004	5.0	-	5.0	Улсын төсөв			ҮХЯ, БСШУЯ
	г)хүнцэлгүй зориулалтаар болоогүй үхэр, ямаа, үхэр, зээрийн арьс	2003	-	20.0	20.0	Улсын төсөв			ҮХЯ, БСШУЯ
	д)бөөлийн гүтлын зориулалтын арьс	2003	-	10.0	10.0	Улсын төсөв			ҮХЯ, БСШУЯ
	е)Үүнд ширний зориулалтын арьс	2003	-	10.0	10.0	Улсын төсөв			ҮХЯ, БСШУЯ

		ж/жижиг эдлэлийн арьс	2003	-	20.0	-	20.0	Улсын төсөв	ҮХЯ, БСШУЯ
		з/идээлсэн нэхий	2004	-	-	5.0	5.0	Улсын төсөв	ҮХЯ, БСШУЯ
		и/тарвага, хурга, ишигний идээлсэн арьс	2004	-	-	5.0	5.0	Улсын төсөв	ҮХЯ, БСШУЯ
		к/ангийн зөөлөн үслэг арьс	2004	-	-	20.0	20.0	Улсын төсөв	ҮХЯ, БСШУЯ
		л/жижиг эдлэлийн үслэг	2004	-	-	8.0	8.0	Улсын төсөв	ҮХЯ, БСШУЯ
		4/Түүхий эд, боловсруулсан арьс, шир, савхин болон үслэг эдлэлийн чанарыг тодорхойлох аргачлалын стандартыг хянаж, олон улсын стандартад нийцүүлэх	2003-2004	-	-	-	-	-	ҮХЯ, СХЗҮТ
		5/Арьс, шир судлал, техник технологийг боловсронгуй болгох, бүтээгдэхүүний чанарыг сайжруулахад чиглэсэн зөвлөлгөө өгөх тевийг байгуулан ажиллуулж, үйлдвэрлэгч, бизнес эрхлэгч, шинжлэх ухааны байгууллагын уялдаа холбоог бэхжүүлэх	2001-2004	-	-	-	-	-	ҮХЯ, БСШУЯ, ТИС
		6/Салбарын мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх системийг хөгжүүлж, өндөр хөгжилтэй оронд суралцуулах, туршлага судлуулах, гадаад, дотоодын сургалт, семинар, зөвлөлгөөнд хамруулах бодлогыг хэрэгжүүлэх	2001-2004	-	-	-	-	-	ҮХЯ, БСШУЯ, ГХЯ, ТИС
		7/Үйлдвэр, аж ахуйн нэгжүүдийг олон улсын үзэсгэлэн яармагт оролцуулж, бүтээгдэхүүнийг нь сурталчлах, үзэсгэлэн худалдаа зохион байгуулах ажлыг өргөжүүлэх							ҮХЯ, МХАҮТ

5	Байгаль орчин, хүний эрүүл мэндэд халтай технологий дэлхийн жишигт нийцүүлэн цэвэр, ногоон үйлдвэрлэлийг нэвтлэхтэх	1/НҮБ-ын техникийн хамтын ажиллагааны хүрээнд хэрэжиж буй "Гүн 21" төсөл арьс, шаргий үйлдвэрийн хаягдлыг боловсруулах технологийн туршилт ашиглах цаашид авах арга замыг тодорхойлох, холбогдох ажлыг зохион байгуулах			2002-2004	-	-	-	БОЯ, УХЯ
		2/Арьс, шаргий үйлдвэрүүдийн бохир ус цэвэрлэх зоорилгатай "Харгиа" ХХК-ийн үйлдвэрүүдийн үйл ажиллагаа жигд хангах, уялдаа холбоог сайжруулах чиглэлээр арга хэмжээ авах			2001-2004	-	-	-	УХЯ, СЭЗЯ, БОЯ, ТӨХ
		3/"Харгиа" ХХК-ийн техник, тоног төхөөрөмжийг шинэчлэх	2002-2004	200.0	200.0	200.0	600.0	Хөнгөлөлттэй зээл	Арилжааны банк, "Харгиа" ХК
		4/Эдийн засгийн хамтын нийгэмлэг (хүүчин нэрээр)-ийн гишүүн орнуудын техникийн хамтын ажиллагааны хүрээнд түслэмжээр орж ирсэн арьс, шаргий үйлдвэрийн цэвэрлэх байгууламжийн 150 сая төгрөгийн ортег бүхий тоног төхөөрөмжийн өмчлөлийн асуудлыг шийдвэрлэх			2001-2004	-	-	-	УХЯ, СЭЗЯ, ТӨХ
		5/Бохир усны байгууламжид эрүүл ахуй, халдвар судлалын хяналт тавих	2002-2004	-	-	-	-	-	ЭМЯ, УХЯ
		6/Арьс, шаргий үйлдвэрүүдийн ажлын байрны эрүүл ахуй, хөдөлмөрийн аюулгүй байдлын стандартыг боловсруулж мөрдүүлэх	2002	-	-	-	-	-	УХЯ, ЭМЯ, НХХЯ
		7/Боловсруулах үйлдвэрлэлд эргүүлэн ашиглах технологийг судалж хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх	2002-2004	-	-	-	-	-	УХЯ, БОЯ

		8/Бохир усны найрлагыг үйлдвэр бүрээр тогтоож, хүлээн авах, хянах журам тогтоох		2002	-	-	-	-	-	ҮХЯ, БОЯ, "Харгиа" ХК
		9/Үйлдвэрлэл эрхлэгчдийн дунд "Байгаль орчныг хамгаалах талаархи хяналт, шинжилгээ, үнэлгээ" сэдвээр сургалт зохион байгуулах		2001-2004	-	-	-	-	-	ҮХЯ, БОЯ, БСШУЯ
		10/Химийн бодис ашиглах, хадгалах нийтлэг журмыг үйлдвэр бүр дээр мөрдөх ажлыг зохион байгуулах, химийн бодис, материалын тооллогыг 2 жил тутам явуулж, үр дүнг холбогдох байгууллагуудад хүргүүлэх		2001-2004	-	-	-	-	-	ҮХЯ, БОЯ, БХЯ
		11/"Экологийн цэвэр бүтээгдэхүүн үйлдвэрлэгч", "Байгаль орчинд халгүй технологи нэвтрүүлэгч" үйлдвэрийг шалгаруулж, урамшуулах ажлыг зохион байгуулах		2002-2004	-	-	-	-	-	ҮХЯ, БОЯ
6	Хөтөлбөрийн зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг судалчлах			2001-2004	0.4	0.4	0.4	1.2	Улсын төсөв	ҮХЯ, СЭЗЯ
			ДҮН		566.2	611.3	243.4	1420.9		
		Үүнээс	Улсын төсөв		15.4	60.4	43.4	119.2		
			Техникийн тусламж		350.8	350.9	-	701.7		
			Хөнгөлөлттэй зээл		200.0	200.0	200.0	600.0		

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 5 дугаар сарын 24–ний өдөр Дугаар 115 **Улаанбаатар хот**

Зарим байгууллагын байршлын тухай

Төрийн ордны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасныг үндэслэн Улсын Их Хурлын 2001 оны 15 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Төрийн өмчийн I байранд Сонгуулийн ерөнхий хороо, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн ажлын алба, Үндсэн хуулийн цэц, Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комисс, Хүний эрхийн үндэсний комисс, Төрийн ордонд байрлаж байгаа олон улсын болон гадаадын төслийн байгууллагуудыг Улсын Их Хурлын 2001 оны 15 дугаар тогтоолд заасан хугацаанд багтаан байрлуулсугай.

2. Энэ тогтоолын 1 дүгээр зүйлд заасан байгууллагуудыг Төрийн ордноос нүүлгэн шилжүүлэх болон тэдгээрийн орох өрөө, тасалгааг засвар хийхэд шаардагдах хөрөнгө гаргахыг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаанд үүрэг болгосугай.

3. Төрийн захиргааны байгууллагуудын байршил, ажлын эмх цэгц, зохион байгуулалтыг дээшлүүлэх, нэгдсэн үйлчилгээнд хамруулах, зардал хэмнэх зорилгоор Засгийн газрын агентлагуудыг энэ оны 10 дугаар сард багтаан нэг дор төвлөрүүлэн байршуулах арга хэмжээ авахыг Төрийн өмчийн хороо (Л.ПҮРЭВДОРЖ)-нд даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

ЗАСГИЙН ГАЗРЫН ГИШҮҮН, ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА **Ө.ЭНХТҮВШИН**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 5 дугаар сарын 30–ны өдөр Дугаар 116 **Улаанбаатар хот**

Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.Засгийн газрын 1998 оны 15 дугаар тогтоолоор батлагдсан “Цэргийн албыг дүйцүүлэн хаах журам”-ын зарим зүйл, заалтад дор дурдсан нэмэлт, өөрчлөлт оруулсугай:

а/2 дугаар зүйлд “... Байгалийн гамшигтай тэмцэх салбар” гэснийг “Аврах отряд (аврах салбар)” гэж өөрчлөх;

б/9 дүгээр зүйлд “...сум, хорооны Засаг даргын тодорхойлолт, аймаг, дүүргийн Засаг даргын саналыг үндэслэн” гэснийг “сум, дүүргийн Засаг даргын тодорхойлолт, аймаг, нийслэлийн Засаг даргын саналыг үндэслэн” гэж өөрчлөх;

в/12 дугаар зүйлийн “д” заалтад “...ажил гүйцэтгэх” гэсний дараа “байгаль орчныг нөхөн сэргээх” гэж нэмэх;

г/12 дугаар зүйлд “улс орны хэмжээнд хэрэгжүүлж буй нийгэм, эдийн засгийн зохион байгуулалттай бүтээн босголтын ажилд оролцох” гэсэн “е” заалт нэмэх;

д/13 дугаар зүйлд “Батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага цэргийн албыг дүйцүүлэн хаах асуудлын зохион байгуулалт, явцад хяналт тавина.” гэж нэмэх;

е/25 дугаар зүйлийн “а” заалтын “...2 дугаар сард...” гэснийг “1 дүгээр сарын эхний 10 хоногт” гэж өөрчлөх;

ж/27 дугаар зүйлийн “б” заалтын “...алба хаах хуудас...” гэснийг “...цэргийн албыг дүйцүүлэн хаах иргэний тооцооны хуудас...” гэж өөрчлөх.

2. Цэргийн албыг дүйцүүлэн хаах иргэний алба хаах хуудасны маягтыг хавсралт ёсоор батлсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙД **Ж.ГҮРРАГЧАА**

Засгийн газрын 2001 оны 116 дугаар тогтоолын хавсралт

нүүрэн тал **өвөр тал**



Дугаар .....

Овог .....

Нэр.....

/цол, гарын үсэг, нэр/

Төрсөн .....*он*.....*сар*.....*өдөр*
Иргэний үнэмлэхний дугаар.....
Регистрийн дугаар.....
Цэргийн албыг дүйцүүлэн хаах журмын.....дугаар заалтыг үндэслэн цэргийн дүйцүүлэх албанд татав.

ЦЭРГИЙН АЛБЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХААХ ИРГЭНИЙ ТООЦООНЫ ХУУДАС

.....аймаг/нийслэл/-ийн
ЦИХШ-ын дарга.....

.....*он*.....*сар*.....*өдөр*

АЛБА ХААСАН БАЙДАЛ

огноо	гүйцэтгэсэн сургууль цугларалтын нэр	Ажилласан хоног
1	2	3

Алба хаалгасан байгууллагын тодорхойлолт

.....
.....
.....
.....
..... *сум/дүүрэг/-ын засаг дарга*
.....
. . он . . . сар . . . өдөр

Цэргийн албыг дүйцүүлэн хаах журмын ..... дугаар заалтыг үндэслэн дүйцүүлэх албанаас халав.

.....аймаг/нийслэл/-ийн
ЦИХШ-ын дарга.....

.....*он*.....*сар*.....*өдөр*

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Хаяг: «Төрийн мэдээлэл» эмхтгэлийн эвлэл

Улаанбаатар-12 ☎ 329612
Төрийн ордон Индекс 14003

Улсын Их Хурлын Тамгын газрын
Хэвлэх хэсэгт хэвлэв.

☎ 329487



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 30 (217)

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ:

- *Монгол Улсын хөдөлмөрийн баатар, ардын болон гавьяат цол хүртээж, одон, медалиар шагнасан тухай*

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ:

- *Хөтөлбөр батлах тухай*
- *Үндэсний хөтөлбөр батлах тухай*
- *Жагсаалт батлах тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар

Улаанбаатар хот
2001 он

ШИНЭЧЛЭХ ЭРХИЙН ТӨВ

№ 30 (312)

ХОЛ ХҮСЭЛ ЕВДХИЙГӨӨРӨӨ ЗАЛИЛ

ХОЛ ХҮСЭЛ ЗӨВШӨӨРӨЛ ГАЗРЫН ТОЛГОЙ:

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот 2001 оны наймдугаар сарын 4 №30 (217)

Гарчиг

Нэг. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

378. Домбооны Аюурт Монгол Улсын хөдөлмөрийн баатар цол хүртээх тухай Дугаар 08 777
379. Цэрэнгийн Цэвээнд Монгол Улсын ардын багш цол хүртээх тухай Дугаар 09 778
380. Зарим хүнд Монгол Улсын гавьяат цол хүртээх тухай Дугаар 10 778
381. Зарим хүнд Монгол Улсын гаьяат цол хүртээх тухай Дугаар 11 780
382. Зарим хүнийг одон, медалиар шагнах тухай Дугаар 13 781
383. Ванчигийн Гомбосүрэн, Бямбажавын Болдсүх нарыг "Шударга журам" медалиар шагнах тухай Дугаар 14 782
384. Зарим албан тушаалтанд зэрэг дэв олгох тухай Дугаар 15 783
385. Шинэнгийн Энхбатад Монгол Улсын гавьяат хуульч цол хүртээх тухай Дугаар 16 783
386. Жамаажавын Нүрдэнд Монгол Улсын гавьяат тээвэрчин цол хүртээх тухай Дугаар 17 783
387. Очирын Одгэрэлд Монгол Улсын гавьяат тамирчин цол хүртээх тухай Дугаар 18 783

Хоёр. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

388. Хөтөлбөр батлах тухай Дугаар 119 784
389. Үндэсний хөтөлбөр батлах тухай Дугаар 120 789
390. Жагсаалт батлах тухай Дугаар 122 795

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2001 оны 7 дугаар сарын 05-ны өдөр **Дугаар 08** **Улаанбаатар хот**

Домбооны Аюурт Монгол Улсын хөдөлмөрийн баатар цол хүртээх тухай

Барилгын байгууллагад санаачилга, үр бүтээлтэй ажиллаж мэргэжлийн өндөр ур чадвар эзэмшин, олон барилга байгууламжийн цахилгааны угсралтын ажлыг хугацаанд нь чанартай гүйцэтгэх, залуу барилгачдыг ажилд нь дадлагажуулан сургахад оруулж байгаа дорвитой хувь нэмрийг нь үнэлж, Монгол Ардын хувьсгалын 80 жилийн ойг тохиолдуулан Улаанбаатар хотын цахилгаан автоматик угсралтын "Монтёр" ХХК-ийн цахилгаанчин Домбооны Аюурт Монгол Улсын хөдөлмөрийн баатар цол хүртээж, Сүхбаатарын одон, "Алтан соёмбо" тэмдгээр шагнасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ **Н. БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2001 оны 7 дугаар сарын 05-ны өдөр | Дугаар 09 | Улаанбаатар хот

Цэрэнгийн Цэвээнд Монгол Улсын ардын багш цол хүртээх тухай

Ерөнхий боловсролын сургуульд олон жил санаачилга, үр бүтээлтэй ажиллаж, мэргэжлийн өндөр ур чадвар эзэмшин сургалтад дэвшилтэт аргуудыг нэвтрүүлж, өсвөрийн залуу үеийг сурган хүмүүжүүлэх, залуу багш нарыг дагалдуулан сургахад оруулж байгаа дорвитой хувь нэмрийг нь үнэлж, Монгол Ардын хувьсгалын 80 жилийн ойг тохиолдуулан Нийслэлийн 10 жилийн лабораторинэгдүгээр дунд сургуулийн бага ангийн багш Цэрэнгийн Цэвээнд Монгол Улсын ардын багш цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ **Н. БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2001 оны 7 дугаар сарын 05-ны өдөр | Дугаар 10 | Улаанбаатар хот

Зарим хүнд Монгол Улсын гавьяат цол хүртээх тухай

Хөдөө аж ахуй, аж үйлдвэр, барилга, авто тээвэр, авто зам, холбоо, үйлчилгээ, боловсрол, эрүүл мэнд, соёл урлаг, биеийн тамир спорт, байгаль орчин, хууль зүй, шинжлэх ухааны салбарт олон жил идэвх санаачилга, үр бүтээлтэй ажиллаж улс орноо хөгжүүлэхэд оруулж байгаа бодитой хувь нэмрийг нь үнэлж Монгол Ардын хувьсгалын 80 жилийн ойг тохиолдуулан дор дурдсан хүмүүст Монгол Улсын гавьяат цол хүртээсүгэй.

Монгол Улсын гавьяат малчин цолоор:

1. Цамбажавын Шарав - Баянхонгор аймгийн Галуут сумын малчин
2. Дүгэрийн Лхагва - Ховд аймгийн Чандмань сумын малчин

Монгол Улсын аж үйлдвэрийн гавьяат ажилтан цолоор:

1. Хишигтийн Адилбиш - Улаанбаатар хотын II цахилгаан станцын уурын зуухны засварчин
2. Туваанжавын Гантөмөр - Говь-Алтай аймгийн Халиун сумын үйлдвэрлэл худалдааны "Ентүм" ХХК-ийн захирал

Монгол Улсын гавьяат уурхайчин цолоор:

Лувсаншаравын Пүрэв-Очир - Дархан-Уул аймгийн "Шарын гол" ХК-ийн бульдозерчин

Монгол Улсын гавьяат барилгачин цолоор:

Бадамын Лувсан - Авто замын газрын зөвлөх

Монгол Улсын гавьяат тээвэрчин цолоор:

Заяагийн Нямсүрэн - Нийслэлийн "Авто тээвэр тав" ХК-ийн жолооч

Монгол Улсын гавьяат холбоочин цолоор:

Рэнчингийн Гаябазар - "Монголын цахилгаан холбоо" ХК-ийн техникч

Монгол Улсын үйлчилгээний гавьяат ажилтан цолоор:

Гүнжидийн Хайсандай - "Улаанбаатар" зочид буудлын ресторан дарга

Монгол Улсын гавьяат зоотехникч цолоор:

Доржийн Больхорлоо - Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн эвлэлээ ажилтан

Монгол Улсын гавьяат багш цолоор:

1. Худэрийн Гэндарам - ХААИС-ийн малын тэжээллэг, хадлан бэлчээрийн тэнхмийн эрхлэгч
2. Янжингийн Цэдэнбал - Нийслэлийн Баянгол дүүргийн "Эрдмийн ундраа" цогцолбор сургуулийн математикийн багш
3. Дүгэрийн Ренчин - Хэнтий аймгийн Хэрлэн сумын нэгдүгээр сургуулийн биеийн тамирын багш

Монгол Улсын хүний гавьяат эмч цолоор:

1. Намхай-Очирын Нямдаваа - Хавдар судлалын төвийн эвлэлээ их эмч
2. Пүүшийн Сагараажав - Дархан-Уул аймгийн уламжлалт анагаах ухааны "Оточ манал" эмнэлгийн ерөнхий эмч, захирал
3. Насангийн Очиржанцан - Архангай аймгийн Нэгдсэн эмнэлгийн эм бэлдмэлийн тасгийн эрхлэгч, нойрсуулагч эмч
4. Дугарсүрэнгийн Цэнд-Аюуш - Өвөрхангай аймгийн Арвайхээр сумын "Чин мэнд" хувийн эмнэлгийн эвлэлээ их эмч

Монгол Улсын эрүүлийг хамгаалахын гавьяат ажилтан цолоор:

1. Гончигийн Доржханд - Сэтгэцийн эмгэгийн клиникийн эмнэлгийн ерөнхий эмч
2. Дагдангийн Долгорцэнд - Өмнөговь аймгийн Нэгдсэн эмнэлгийн эмчилгээ чанарын хяналтын менежер

Монгол Улсын гавьяат жүжигчин цолоор:

1. Хайчинхүүгийн Үнэнхүү - Сонгодог урлагийн академик театрын гоцлол дуучин
2. Даваасамбуугийн Дагийсүрэн - Сэлэнгэ аймгийн ардын дуу, бүжгийн "Сэлэнгийн долгио" чуулгын гоцлол дуучин
3. Жамъянгийн Дүнжмаа - Дундговь аймгийн Хөгжимт драмын театрын гоцлол дуучин
4. Цэнддоогийн Оюунцэцэг - Говь-Алтай аймгийн Ардын дуу, бүжгийн "Алтай" чуулгын гоцлол дуучин

Монгол Улсын соёлын гавьяат зүтгэлтэн цолоор:

Найдангийн Цагаач - Анагаах ухааны их сургуулийн номын сангийн эрхлэгч

Монгол Улсын гавьяат тамирчин цолоор:

Шагжсүрэнгийн Даваахүү - Орхон аймгийн уул уурхайн баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрийн дэргэдэх "Хан гарьд" спорт клубийн багш, арга зүйч

Монгол Улсын байгаль орчны гавьяат ажилтан цолоор:

Ядамын Шаравдорж - Хөвсгөл аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн захирал

Монгол Улсын гавьяат хуульч цолоор:

Даржаагийн Зундуй - "Их засаг" их сургуулийн тэнхмийн эрхлэгч

Монгол улсын шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн цолоор:

Дагвын Бадгаа - ШУА-ийн Хими, хими-технологийн хүрээлэнгийн захирал

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2001 оны 7 дугаар сарын 05-ны өдөр | Дугаар 11 | Улаанбаатар хот

Зарим хүнд Монгол Улсын гавьяат цол хүртээх тухай

Хөдөө аж ахуй, үйлдвэр, барилга, тээвэр, боловсрол, эрүүл мэнд, соёл урлаг, байгаль орчны салбарт олон жил идэвх санаачилга, үр бүтээлтэй ажиллаж улс орноо хөгжүүлэхэд оруулж байгаа бодитой хувь нэмрийг нь үнэлж, дор дурдсан хүмүүст Монгол Улсын гавьяат цол хүртээсүгэй.

Монгол Улсын гавьяат малчин цолоор:

1. Гунаажавын Цэрэндаш - Завхан аймгийн Тудэвтэй сумын малчин
2. Гянын Дамдиндорж - Өвөрхангай аймгийн Хайрхандулаан сумын малчин

Монгол Улсын аж үйлдвэрийн гавьяат ажилтан цолоор:

1. Раднаагийн Дашдэлэг - Нийслэлийн "Булигаар" ХК-ийн ажилтан
2. Бадарчийн Ёндонжамц - Нийслэлийн үйлдвэрлэл, худалдааны "Говь" ХК-ийн гүйцэтгэх захирал
3. Лувсангийн Хашхүү - Нийслэлийн Дулааны шугам сүлжээний газрын хэлтсийн дарга

Монгол Улсын гавьяат уурхайчин цолоор:

1. Жигжидийн Хишигт - Нийслэлийн "Багануур" ХК-ийн ахлах инженер
2. Шаябайн Зулан - Баян-Өлгий аймгийн нүүрсний "Хотгор" ХК-ийн засварчин

Монгол Улсын гавьяат барилгачин цолоор:

1. Равдангийн Зинамидэр - Нийслэлийн барилгын "Пума" ХХК-ийн өрөгч, даамал
2. Даваажавын Өлзийхишиг - Нийслэлийн "Архитектур" нэгдлийн захирал

Монгол Улсын гавьяат тээвэрчин цолоор:

Дашийн Намхайдорж - Хилийн цэргийн 0119 дугээр ангийн жолооч

Монгол Улсын хөдөө аж ахуйн гавьяат механикжуулагч цолоор:

Кажибайн Тлеухан - Сэлэнгэ аймгийн Цагааннуур сумын "Сэлэнгэ-Тариа" ХХК-ийн захирал

Монгол Улсын гавьяат багш цолоор:

1. Жамъянгийн Нямсүрэн - Санхүү, эдийн засгийн дээд сургуулийн зөвлөх багш
2. Намжилын Даваажав - Нийслэлийн "Монгени" цогцолбор сургуулийн зүргийн багш
3. Сунгаравын Болд - Дархан-Уул аймгийн математик-байгалийн шинжлэлийн гүнзгийрүүлсэн сургалттай YII сургуулийн захирал
4. Тамжавын Гаваа - Төв аймгийн Зуунмод сумын IY сургуулийн зөвлөх багш, номын санч
5. Чоймболын Тогоохүү - Өмнөговь аймгийн Даланзадгад сумын "Эрдмийн гэгээ" сургуулийн захирал

Монгол Улсын хүний гавьяат эмч цолоор:

1. Дамдингийн Авирмэд - Анагаах ухааны хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан, их эмч
2. Довчингомбын Товуусүрэн - Баянхонгор аймгийн байгалийн голомтот халдварт өвчинтэй тэмцэх газрын дарга

3. Авзайн Сампил - Хэнтий аймгийн Хэрлэн сумын "Мэлмий" нүдний хувийн эмнэлгийн их эмч

Монгол Улсын эрүүлийг хамгаалахын гавьяат ажилтан цолоор:

1. Жамбын Эрхэмбаяр - Нийслэлийн Баянгол дүүргийн Эрүүл мэндийн нэгдлийн захирал
2. Балжиннямын Намбар - Оргил рашаан сувиллын зөвлөх эмч

Монгол Улсын гавьяат жүжигчин цолоор:

1. Гэндэнпилийн Явгаан - Чөлөөт уран бүтээлч, дуучин, хөөмийч
2. Гомбожавын Рина - Дорнод аймгийн Хөгжимт драмын театрын гоцлол дуучин
3. Доржбалын Жанцанчой - Төв аймгийн Хөгжимт драмын театрын хөгжимчин, ерөөлч магтаалч
4. Эжээгийн Тойвгоо - Увс аймгийн Хөгжимт драмын театрын хөөмийчин
5. Равдансэдийн Лхамжав - Хөвсгөл аймгийн Хөгжимт драмын театрын гоцлол дуучин
6. Жамбалын Ёндонжамц - Дорноговь аймгийн "Саран хөхөө" театрын гоцлол дуучин

Монгол Улсын байгаль орчны гавьяат ажилтан цолоор:

Жачингийн Цэрэндэлэг - Байгаль орчны яамны улсын экспертизийн хэлтсийн дарга, Байгаль орчныг хамгаалах нийгэмлэгийн ерөнхийлөгч

Монгол Улсын соёлын гавьяат зүтгэлтэн цолоор:

Гангийн Жанчив - Монголын радиогийн хариуцлагатай редактор

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2001 оны 7 дугаар сарын 09-ний өдөр **Дугаар 13** **Улаанбаатар хот**

Зарим хүнийг одон, медалиар шагнах тухай

Улсыг аюулаас хамгаалах албанд олон жил дурдсан хүмүүсийг одон, медалиар шагнасугай.
санаачилга, үр бүтээлтэй ажиллаж байгаа дор

ХӨДӨЛМӨРИЙН ГАВЬЯАНЫ УЛААН ТУГИЙН ОДОНГООР:

1. Ядамсүрэнгийн Батсуурь - Тагнуулын ерөнхий газрын хэлтсийн дарга, газрын орлогч
2. Хумбын Загдрагчаа - Тагнуулын ерөнхий газрын дээд сургуулийн захирал

ЦЭРГИЙН ГАВЬЯАНЫ УЛААН ТУГИЙН ОДОНГООР:

1. Дугаржавын Гантөмөр - Тагнуулын ерөнхий газрын хэлтсийн орлогч дарга
2. Дуламсүрэнгийн Жанцанбадгар - Тагнуулын ерөнхий газрын Хөвсгөл аймаг дахь хэлтсийн дарга
3. Самдангийн Элбэг - Тагнуулын ерөнхий газрын салбар хэлтсийн дарга

ЦЭРГИЙН ГАВЬЯАНЫ ОДОНГООР:

1. Норовдоржийн Александр - Тагнуулын ерөнхий газрын Өмнөговь аймаг дахь газрын дарга
2. Лувсан-Очирын Батбаатар - Тагнуулын ерөнхий газрын газрын дарга
3. Дамбажанцангийн Батбаяр - Тагнуулын ерөнхий газрын Барилга засварын ангийн ерөнхий ин женер
4. Биндэрийн Бямбасүрэн - Төрийн тусгай хамгаалалтын газрын ахлах байцаагч
5. Хүрлээгийн Ганзүрх - Тагнуулын ерөнхий газрын хангалт үйлчилгээний хэлтсийн дарга

6. Жамбаажавын Дамдиндорж	Тагнуулын ерөнхий газрын Сөрөх тагнуулын газрын орлогч, хэлтсийн дарга
7. Дагварэнцэнгийн Дамдинхүү	Тагнуулын ерөнхий газрын 4 дүгээр хэлтсийн ахлах ажилтан
8. Будрагчаагийн Дашдаваа	Төрийн тусгай хамгаалалтын газрын хэлтсийн дарга
9. Доржийн Дэлгэрсайхан	Тагнуулын ерөнхий газрын Баян-Өлгий аймаг дахь газрын дарга
10. Шатарын Мэлс	Тагнуулын ерөнхий газрын Сөрөх тагнуулын газрын тасгийн дарга
11. Гомбожамцын Мягмарсүрэн	Тагнуулын ерөнхий газрын архив, бүртгэлийн албаны орлогч дарга
12. Жамъяндоржийн Нямдагва	Төрийн тусгай хамгаалалтын газрын хамгаалалтын дэд ажилтан
13. Лувсангийн Орсоо	Тагнуулын ерөнхий газрын 4 дүгээр хэлтсийн ахлах ажилтан
14. Ерэнтэйн Очир	Тагнуулын ерөнхий газрын хэлтсийн дарга
15. Доржийн Ринчин	Тагнуулын ерөнхий газрын Мөрдөн байцаах хэлтсийн дарга
16. Чулуунбатын Хишигт	Тагнуулын ерөнхий газрын Аюулгүй байдлыг хангах албаны ерөнхий жижүүр
17. Доржготовын Чимэд-Юндэн	Тагнуулын ерөнхий газрын дэд дарга, Төрийн тусгай хамгаалалтын газрын дарга
18. Балдангийн Эрдэнэхуяг	Тагнуулын ерөнхий газрын Сөрөх тагнуулын газрын ахлах ажилтан

ХӨДӨЛМӨРИЙН ХҮНДЭТ МЕДАЛИАР:

1. Оргодолын Алтанхуяг	Тагнуулын ерөнхий газрын Сөрөх тагнуулын газрын ахлах ажилтан
2. Дааяагийн Бат	Тагнуулын ерөнхий газрын ахлах ажилтан
3. Шагдарын Батдорж	Тагнуулын ерөнхий газрын Аюулгүй байдлыг хангах албаны ахлах ажилтан
4. Бариаширын Батдэлгэр	Тагнуулын ерөнхий газрын Төрийн захиргаа, төлөвлөлт, шинжилгээ, үнэлгээ, хяналтын газрын ахлах ажилтан
5. Нацагдоржийн Батдэлгэр	Тагнуулын ерөнхий газрын 4 дүгээр хэлтсийн тасгийн дарга
6. Хорлоогийн Батсуурь	Төрийн тусгай хамгаалалтын газрын зөвшөөрлийн ажилтан
7. Түдэвбазарын Баярбаясгалан	Тагнуулын ерөнхий газрын Гадаад тагнуулын газрын ахлах ажилтан
8. Гэндэнгийн Бямбаа	Тагнуулын ерөнхий газрын Хангалт, үйлчилгээний хэлтсийн орлогч дарга
9. Жамъянсүрэнгийн Ганбаатар	Тагнуулын ерөнхий газрын санхүүгийн албаны дарга, ерөнхий нягтлан бодогч
10. Балдансүрэнгийн Долгорханд	Тагнуулын ерөнхий газрын 5 дугаар хэлтсийн ажилтан
11. Лувсангийн Жаргалсайхан	Тагнуулын ерөнхий газрын газрын авто баазын жолооч
12. Баширын Кептилеу	Тагнуулын ерөнхий газрын Замын-Үүд дэх газрын ахлах ажилтан
13. Дашбазарын Нямцэрэн	Тагнуулын ерөнхий газрын 5 дугаар хэлтсийн ажилтан
14. Самбуугийн Сугар	Тагнуулын ерөнхий газрын Сөрөх тагнуулын газрын ажилтан
15. Гомбын Төмөрсүх	Төрийн холбооны газрын дарга
16. Батандэлгэрийн Хүрэлбаатар	Тагнуулын ерөнхий газрын авто баазын жолооч

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2001 оны 7 дугаар сарын 09-ний өдөр Дугаар 14 Улаанбаатар хот

Ванчигийн Гомбосүрэн, Бямбажавын Болдсүх нарыг "Шударга журам" медалиар шагнах тухай

Эр зориг, авхаалж самбаа гарган үерийн уснаас хүмүүсийн амь аварч, иргэний үүргээ нэр төртэй биелүүлсэн Говь-Алтай аймгийн Цээл сумын "Бүрэн" хоршооны эзэн Ванчигийн Гомбосүрэн, "Дэвшилтэй" хоршооны жолооч-механикч Бямбажавын Болдсүх нарыг "Шударга журам" медалиар шагнасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2001 оны 7 дугаар сарын 09–ний өдөр | Дугаар 15 | Улаанбаатар хот

Зарим албан тушаалтанд зэрэг дэв олгох тухай

Монгол Улсын Их Хурлын 2001 оны 6 дугаар сарын 7-ны өдрийн 50 дугаар тогтоолыг үндэслэн ЗАРЛИГ болгох нь:

Хүний эрхийн үндэсний комиссын дарга Сүрэнгийн Цэрэндоржид төрүүн түшээ, мөн комиссын гишүүн Гүүширийн Далайжамц, Жадамбын Дашдорж нарт дэд түшээ зэрэг дэв олгосугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2001 оны 7 дугаар сарын 17–ны өдөр | Дугаар 16 | Улаанбаатар хот

Шинэнгийн Энхбатад Монгол Улсын гавьяат хуульч цол хүртээх тухай

Цагдаагийн төв, орон нутгийн байгууллагад олон жил санаачилга, үр бүтээлтэй ажиллаж, хариуцсан цагдан сэргийлэх анги, хэлтсийн ажлыг чадварлаг зохион байгуулан материаллаг баазыг бэхжүүлэх, гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, илрүүлэх, нийгмийн хэв журмыг хамгаалах үйлсэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Нийслэлийн Баянгол дүүргийн Засаг даргын дэргэдэх Цагдаагийн хэлтсийн дарга, цагдаагийн хурандаа Шинэнгийн Энхбатад Монгол Улсын гавьяат хуульч цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2001 оны 7 дугаар сарын 17–ны өдөр | Дугаар 17 | Улаанбаатар хот

Жамаажавын Нүрдэнд Монгол Улсын гавьяат тээвэрчин цол хүртээх тухай

Цагдаагийн байгууллагад олон жил үр бүтээлтэй ажиллаж, хариуцсан машин техникийн эдэлгээний хугацаат үртасгаж, цагдаагийн төрөл бүрийн мэргэжлийн албадад шуурхай үйлчлэн гэмт хэрэг илрүүлэх, нийгмийн хэв журмыг хамгаалахад оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Цагдаагийн ерөнхий газрын Авто баазын жолооч, цагдаагийн ахлах ахлагч Жамаажавын Нүрдэнд Монгол Улсын гавьяат тээвэрчин цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2001 оны 7 дугаар сарын 17–ны өдөр | Дугаар 18 | Улаанбаатар хот

Очирын Одгэрэлд Монгол Улсын гавьяат тамирчин цол хүртээх тухай

Бөхийн самбо, жудо барилдааны дэлхий, тив, олон улсын болон улсын аварга шалгаруулах тэмцээнд тогтмол оролцож, спортын өндөр амжилт гаргасныг нь үнэлж Цагдаагийн ерөнхий газрын биеийн тамир, спортын "Хүч" хорооны тамирчин, цагдаагийн ахмад Очирын Одгэрэлд Монгол Улсын гавьяат тамирчин цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 6 дугаар сарын 5–ны өдөр | Дугаар 119 | Улаанбаатар хот

Хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлберийг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Сургуулийн өмнөх боловсрол-2" үндэсний хөтөлберийг хавсралт ёсоор батлуулсугай.

2. Хөтөлберт дэвшүүлсэн зорилтуудыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шаардагдах зардлыг эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх жил бүрийн үндсэн чиглэл, улсын төсөвт тусган ажиллахыг Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд А.Цанжид, Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаан нарт тус тус үүрэг болгосугай.

3. Хөтөлберийн хэрэгжилтийг зохион байгуулж, түүний биелэлтэд хяналт тавин дүгнэж ажиллахыг Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд А.Цанжидад даалгасугай.

4. Хөтөлберт тусгагдсан зорилтыг нутаг дэвсгэртээ хэрэгжүүлэх дэд хөтөлбер, төлөвлөгөө боловсруулж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙД А.ЦАНЖИД

Засгийн газрын 2001 оны 119 дүгээр тогтоолын хавсралт

"СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛ-2" ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР

Нэг. Хөтөлберийн үндэслэл

Хүүхдийн боловсрол эзэмших эрх болон тэдний бие бялдар, танин мэдэхүй, нийгмийн хэрэгцээг төрсөн цагаас нь эхлэн бүрэн хангах асуудал НҮБ-ын Ерөнхий Ассамблейн чуулганаар батлагдсан Хүүхдийн эрхийн конвенц, бүх нийтийн боловсролын асуудлаар болсон Жомтиены бага хурлын баримт бичигт тусгагдсан байдаг. Олон улсын хэмжээнд хэрэгжиж буй бүх нийтийн боловсролын талаарх Дакарын бага хурлын тунхаглалд бага насны хүүхдэд тавих нийгмийн анхаарал халамжийг нэмэгдүүлэх асуудал тусгалаа олжээ.

Харьцангуй өргөн уудам нутаг дэвсгэртэй, нүүдлийн болон суурин соёл иргэншилт хосолсон, нийт хүн амын 17 орчим хувийг сургуулийн өмнөх насны хүүхэд эзэлдэг бөгөөд тэдгээр нь ихэвчлэн 8 настай сургуульд ордог манай орны хувьд хүүхдэд сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэх бодлогыг оновчтой хэрэгжүүлэх нь нэн чухал ач холбогдолтой юм.

Хүүхдийг хэдийчинээ бага насанд нь боловсрол, эрүүл мэнд, хоол тэжээл, сэтгэл зүй, өсөлт хөгжил зэрэг бүх төрлийн нийгмийн халамж, үйлчилгээнд хамруулбал бага боловсролын хамран сургалт, чанарын амжилтыг дээшлүүлэх, улмаар хүүхэд сургууль завсардах, өвчлөх, ядуурал, гэмт хэрэгт холбогдох нь багасдаг байна. Тухайлбал, манай оронд хийсэн "Сурлагын амжилтын хяналт шинжилгээ" судалгаагаар бага ангийн сурагчдын сурлагын амжилт нь тэдний сургуулийн өмнөх боловсролд хамрагдсан хугацаанаас хамааралтай болох нь тогтоогдсон юм.

Монгол Улсын Засгийн газраас "Сургуулийн өмнөх боловсрол" үндэсний хөтөлберийг баталж 1995-2000 онд хэрэгжүүлснээр тодорхой үр дүнд хүрсэн. Энэ хугацаанд сургуулийн өмнөх боловсролын хамран сургалт 13,3 хувиар нэмэгдэж, сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд сургуулийн өмнөх насны хүүхдийн 37,7 хувь нь хамрагдсан байна. Мөн олон улсын байгууллагын санхүүжилтээр хэрэгжсэн төсөл, хөтөлберийн хүрээнд хүүхдийн цэцэрлэгийн 26 хувь нь барилга, халаалтын системдээ засвар үйлчилгээ хийсэн. 23 хувь нь туслах аж ахуйтай болсон, нийт багш, мэргэжилтний 75 хувь нь мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагдсан, сургуулийн өмнөх боловсролын ач холбогдлын талаар нийгэмд зөрүү хандлага төлөвшсөн зэргийг дурдаж болох юм.

Гэвч хүн амын амьжиргааны түвшин доогуур, ядуурал буурахгүй байгаа, хөдөөгийн малчдын хүүхдэд үзүүлэх боловсролын үйлчилгээний оновчтой тогтолцоо бүрдээгүй зэргээс шалтгаалан сургуулийн өмнөх насны нийт хүүхдийн 62 орчим хувь нь сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээний аль нэгэн хэлбэрт хамрагдахгүй байна. Өөрөөр хэлбэл 3-7 насны 3 хүүхэд тутмын 2 нь сургуулийн өмнөх боловсролын байгууллагад хамрагдаж чадахгүй байна.

Сүүлийн жилүүдэд төсвийн хүрэлцээгүй байдал, хөрөнгө оруулалт дутагдсанаас хүүхдийн нийт цэцэрлэгийн 51,6 хувьд их засвар хийх, сургалтын орчныг нь сайжруулах шаардлага бий болжээ.

Хүн амын ядуу хэсэгт үзүүлэх нийгмийн үйлчилгээг сайжруулахтай холбогдуулан сургуулийн өмнөх боловсролд хамрагдах хүүхдийн тоог нэмэгдүүлэх, сургалтын шинэ арга, хэлбэрийг нэвтрүүлэх зорилт тулгарч байна.

Сургуулийн өмнөх боловсролыг хөгжүүлэхэд хандивлагчид, дотоодын болон олон улсын байгууллага, гадаад орнууд, иргэд ергөөгөр оролцох сонирхол төрүүлэх, тэдний туслалцаа, дэмжлэгийг нэгдсэн бодлогоор уялдуулан зохицуулах хэрэгтэй байна.

Ийнхүү сүүлийн жилүүдэд сургуулийн өмнөх боловсролд гарсан эерэг үр дүнг тогтворжуулах, сургуулийн өмнөх боловсролын талаар төрөөс баримтлах бодлого, чиглэлийг улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн бодлоготой уялдуулан шинээр тодорхойлох шаардлага тавигдаж байна.

Хоёр. Хөтөлбөрийн зорилго

Эрхэм зорилго

Хүүхдийн эрхийг эрхэмлэн тэдний хөгжих тэгш эрхийг хангах замаар сургуулийн өмнөх насны хүүхдэд боловсрол эзэмшүүлэх, сургуульд бэлтгэх таатай орчин бүрдүүлэхэд энэхүү хөтөлбөрийн эрхэм зорилго оршино.

Гол зорилго

Монгол Улсын боловсролын салбарын хөгжлийн бодлого, стратегид нийцүүлэн төрийн болон төрийн бус байгууллага, гэр бүл, олон нийтийн дэмжлэг, оролцоо, идэвхтэй хамтын ажиллагааг нэмэгдүүлэх замаар сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээний хүртээмж, чанар, үр ашгийг дээшлүүлнэ.

Гурав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа

Энэхүү хөтөлбөрийг дунд хугацаанд буюу 2001–2007 онд хэрэгжүүлнэ.

Дөрөв. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх зарчим

- Монгол Улсын нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх талаар гарсан стратегийн бодлогод нийцүүлэх хууль эрхийн актууд, Засгийн газрын болон олон улсын хөтөлбөр хэрэгжүүлэх үйл ажиллагаатай нягт уялдуулах.
- Төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэд, гадаадын хандивлагч, сонирхогч бүх талуудыг оролцох өргөн боломжоогоор хангах.
- Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг үндэсний болон орон нутгийн түвшинд гүйцэтгэхэд оршино.

Тав. Хөтөлбөрийн санхүүжилт

- Улсын төвлөрсөн болон орон нутгийн төсөв
- Гадаад орон, олон улсын байгууллагын хандив, тусламж
- Төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн хандив, тусламж
- Өөрийн үйлчилгээний орлого
- Бусад эх үүсвэр.

Зургаа. Хөтөлбөрийн зорилтууд

6.1. Сургуулийн өмнөх боловсролын бодлого зохицуулалт, менежментийн тогтолцоог сайжруулах

6.2. Сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэх сургалтын агуулгын стандартыг боловсруулах, түүний шаардлагыг хангахуйц сургалтын технологийг хөгжүүлэх

6.3. Сургалт, судалгаа, хөрөнгө оруулалтыг идэвхтэй хорших замаар сургуулийн өмнөх боловсролын боловсон хүчний мэргэжлийн чадавхийг дээшлүүлэх

6.4. Сургалтын олон хувилбарт үр ашигтай хэлбэрийг нэвтрүүлж, сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээний оновчтой тогтолцоо бүрдүүлэх

6.5. Сургуулийн өмнөх насны хүүхдийн сурапцах орчныг сайжруулахад чиглэсэн хөрөнгө оруулалт хийх, санхүүжилтийн механизмыг боловсронгуй болгох.

Долоо. Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа

7.1. Сургуулийн өмнөх боловсролын бодлого зохицуулалт, менежментийн тогтолцоог сайжруулах

7.1.1. Хөтөлбөрийн хэрэгжилтийг улсын хэмжээнд стратегийн удирдлага, төлөвлөлтөөр хангах, зохион байгуулах, зохицуулах, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хариуцна. Үндэсний түвшинд хөтөлбөрийн хэрэгжилтийг нэгдсэн зохицуулалтаар хангах үүрэг бүхий орон тооны бус "Бодлого зохицуулалтын зөвлөл"-ийг

боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэд ажиллуулна.

7.1.2. "Сургуулийн өмнөх боловсрол–2" үндэсний хөтөлбөрийг улсын хэмжээнд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, холбогдох яамдтай хамтран боловсруулж хэрэгжүүлнэ.

7.1.3. Орон нутагт хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаат стратегийн удирдлага, төлөвлөлтөөр хангах, уялдуулан зохицуулах, хяналт тавих үүрэгтэй аймаг, нийслэлийн салбар зөвлөл ажиллана. Салбар зөвлөлийг тухайн аймаг, нийслэлийн Засаг дарга удирдана.

7.1.4. Нутаг дэвсгэртээ хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг сум, дүүрэг, баг, хорооны Засаг дарга, цэцэрлэгийн захирлэгч хариуцна.

7.1.5. Аймаг, нийслэлд хөтөлбөр хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, захиргааны болон арга зүйн удирдлагаар хангах үүргийг аймаг, нийслэлийн нийгмийн хөгжлийн бодлогын хэлтэс, мэргэжлийн удирдлагаар хангах үүргийг боловсрол, соёлын төв, сургуулийн өмнөх боловсролын байгууллагууд тус тус эрхлэн гүйцэтгэнэ.

7.1.6. Сургуулийн өмнөх боловсролын бодлого хэрэгжилтийн мэдээллэл солилцооны сүлжээ бий болгон ашиглана.

7.1.7. Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын өөрийн удирдлагыг хөгжүүлж, чадавхийг нь бэхжүүлэх, дотоодын, хөндлөнгийн, мэргэжлийн үнэлгээний хэлбэрүүдийг нэвтрүүлнэ.

7.2. Сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэх сургалтын агуулгын стандартыг боловсруулах, түүний шаардлагыг хангахуйц сургалтын технологийг хөгжүүлэх

7.2.1. Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас батлагдсан сургалтын үлгэрчилсэн хөтөлбөрийг хэрэгжүүлэх, сургалтын агуулга, арга зүйг үян хатан, олон хувилбартай болгох зорилгоор орон нутгийн түвшинд сургалтын дэд хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлэх чадавхийг бий болгоно.

7.2.2. Сургуулийн өмнөх болон бага боловсролын залгамж холбоог тодорхойлж, агуулгын стандарт, сургалтын хөтөлбөрүүдэд тусган хэрэгжүүлнэ.

7.2.3. Сургалтын арга зүй, технологийн удирдлагын асуудлыг сургуулийн өмнөх боловсролын байгууллагын түвшинд шийдвэрлэдэг болгоно.

7.2.4. Сургуулийн өмнөх насны хүүхдэд боловсрол эзэмшүүлэх сургалтын арга, хэлбэрүүдэд үнэлгээ өгч, оновчтой хувилбарыг сонгон хэрэгжүүлнэ.

7.2.5. Зайны сургалтаар цэцэрлэгт хамрагдаагүй хүүхдийг гэр бүлд нь хөгжүүлэх, боловсрол эзэмшүүлэх ажлын хэлбэр, агуулга, арга зүй, хэрэглэгдэхүүнийг боловсронгуй болгоно.

7.2.6. Сургуулийн өмнөх насны монгол хүүхдийн бие бялдар-сэтгэцийн хөгжил, нийгэмшлийн судалгааг өргөжүүлэхэд чиглэсэн төсөл хэрэгжүүлэх, төрийн болон төрийн бус байгууллагын судалгааны үр дүнг хэвлэн нийтлэх, нэвтрүүлэхэд туслалцаа үзүүлнэ.

7.3.Сургалт, судалгаа, хөрөнгө оруулалтыг идэвхтэй хорших замаар сургуулийн өмнөх боловсролын боловсон хүчний мэргэжлийн чадавхийг дээшлүүлэх

7.3.1. Мэргэжлийн байгууллагууд өөрсдийн дотоод болон гадаад нөөц болоцоонд тулгуурлан сургуулийн өмнөх боловсролын багш, удирдах ажилтныг бэлтгэх, давтан сургах, мэргэжлийг дээшлүүлэх ажлыг зохион байгуулна.

- Жил бүр тусгай дунд боловсролтой багш, мэргэжилтний 5 хувийг боловсролын зэрэг ахиулах сургалтад хамруулна.
- Мэргэжлийн бус багшийн эзлэх хувийн жинг 2 хувь хүртэл бууруулна.
- Жил бүр цэцэрлэгийн удирдах ажилтны 10 хувийг мэргэжил дээшлүүлэх сертификатын сургалтад хамруулна.
- Багш нар орон нутагтаа болон ажлын байрандаа тасралтгүй бие даан мэргэжлээ дээшлүүлэх сургалтын хэлбэрүүдийг дэмжинэ.
- Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын багшаас бусад мэргэжилтэн /тогооч, эмч, туслах багш г.м/-ийг сургалтад үе шаттай хамруулна.
- Орон нутгийн боловсрол, соёлын төвийн сургуулийн өмнөх боловсрол хариуцсан мэргэжилтнүүдийг компьютерээр хангаж, электрон шуудантай холбоно.
- Орон нутгийн боловсрол, соёлын төвийг түшиглэн багш, мэргэжилтнүүдийн бие даан ашиглах гарын авлага, номын фондыг бүрдүүлж, мэдээллийн сан бий болгоно.

7.3.2.Багш, удирдах ажилтан бэлтгэх, давтан сургах сургалтын агуулга, технологийг шинэчилнэ.

- Багш бэлтгэх сургуульд нэг суралцагчид ногдох сургалтын хэрэглэгдэхүүнийг нэмэгдүүлэх, сайжруулахад чиглэсэн хөрөнгө оруулалт хийнэ.
- Багш бэлтгэх сургуулийн сургалтын хөтөлбөрийг сургуулийн өмнөх боловсролын агуулгын стандартын шинэчлэлттэй уялдуулан боловсронгуй болгоно.
- Багшлах бүрэлдэхүүний мэргэжлийн чадавхийг дээшлүүлнэ.
- Багш, суралцагчдыг мэргэжлийн сурах бичиг, сургалтын материалаар хангана.

7.3.3.Сургуулийн өмнөх боловсролын багш, мэргэжилтнийг гадаад оронд бэлтгэх, олон улсын хурал, сургалт, семинарт хамруулах үйл ажиллагааг дэмжинэ.

7.4.Сургалтын олон хувилбарт үр ашигтай хэлбэрийг нэвтрүүлж, сургуулийн өмнөх боловсролын оновчтой тогтолцоо бүрдүүлэх

7.4.1. Сургуулийн өмнөх боловсролын сургалтад хамрагдаж чадахгүй байгаа хөдөөгийн малчдын болон нийгмийн эмзэг бүлгийн хүүхдийг хөгжүүлэх, боловсрол эзэмшүүлэх сургалтын үйл ажиллагааны оновчтой хэлбэрийг дэмжих замаар тэдний боловсролын үйлчилгээнд хамруулна.

- Нийгмийн халамж, дэмжлэг шаардлагатай ядуу, нэн ядуу өрхийн бага насны хүүхдийн судалгаа гаргаж, тэдэнд дэмжлэг, туслалцаа үзүүлнэ.
- Тусгай хэрэгцээтэй бага насны хүүхдийг сургуулийн өмнөх боловсролын сургалтад үе шаттайгаар хамруулж, тэдний сурах хэрэгцээг хангахад чиглэсэн орчин бүрдүүлэх цогц арга хэмжээ авна.
- Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын үйл ажиллагаанд төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж болон иргэдийн оролцоо, хамтын ажиллагааны оновчтой хувилбаруудыг судлан нэвтрүүлнэ.

7.4.2. Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн өмчид суурилсан төрийн өмчийн бус сургуулийн өмнөх боловсролын байгууллагад төрөөс эдийн засгийн урамшуулал, дэмжлэг үзүүлэх механизмыг бий болгоно.

- Сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээ үзүүлж байгаа төрийн өмчийн бус боловсролын байгууллагад нэг хүүхдэд ногдох норматив зардлаар улсын төсвөөс санхүүжих бололцоог бүрдүүлж, үе шаттайгаар хэрэгжүүлнэ.
- Төрийн өмчийн бус сургуулийн өмнөх боловсролын байгууллагын мэргэжилтнийг мэргэжил дээшлүүлэх сургалтад бүрэн хамруулж, тэдний судалгааны ажил гүйцэтгэхэд нь дэмжлэг үзүүлнэ.
- Төрийн өмчийн байгууллагын ашиглагдаагүй барилга, байгуламжийг төрийн өмчийн бус сургуулийн өмнөх боловсролын байгууллага, иргэдэд зориулалтын дагуу ашиглуулах арга хэмжээг авна.
- Төрийн өмчийн бус сургуулийн өмнөх боловсролын байгууллагыг гадаад болон дотоодын төслүүдэд тэгш хамрагдах бололцоог хангана.

7.4.3. Ерөнхий боловсролын сургуулийн бүтцийг шинэ тогтолцоонд шилжүүлэхтэй холбогдуулан хүүхдийн цэцэрлэг, сургуулийн бүтцийн уялдаа холбоог судалж, шийдвэр гарган хэрэгжүүлнэ.

7.5.Сургуулийн өмнөх насны хүүхдийн суралцах таатай орчныг сайжруулахад чиглэсэн хөрөнгө оруулалт хийх, санхүүжилтийн механизмыг боловсронгуй болгох

7.5.1. Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын сургалтын орчны стандартыг боловсруулан мөрдүүлж, үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

7.5.2. Сургуулийн өмнөх боловсролын төрийн өмчийн байгууллагын барилга байгууламжийн ашиглалтыг сайжруулах, засварлах, шинээр барих ажлыг дотоод, гадаадын санхүүгийн нөөц бололцоонд тулгуурлан дэс дараатай хэрэгжүүлнэ.

- Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын үндсэн хөрөнгийн судалгаа гарган мэдээллийн нэгдсэн сантай болгоно.
- Одоо ашиглагдаж байгаа цэцэрлэгийн барилгын ашиглалтыг 12 хувиар нэмэгдүүлнэ.
- Хөдөөгийн хүүхдийн ердийн халаалттай цэцэрлэгийг бага оврын халаалтын системд шилжүүлнэ.
- 1980 оноос өмнө ашиглалтад орсон хүүхдийн цэцэрлэгийн 40 хувьд их засвар хийнэ.
- Жил бүр 3-аас доошгүй цэцэрлэгийн барилгыг шинээр барина.

7.5.3. Төрийн болон төрийн бус байгууллага, иргэд, аж ахуйн нэгжийн үүсгэл санаачилгыг дэмжих, тэдэнтэй идэвхтэй хамтран ажиллах замаар сургуулийн өмнөх насны хүүхдэд зориулсан тоглоом наадгай, сургалтын хэрэглэгдэхүүний үйлдвэрлэл, ханган жийг сайжруулна.

- Сургуулийн өмнөх насны хүүхдэд зориулсан тоглоом, сургалтын хэрэглэгдэхүүний жагсаалт, каталог боловсруулан хэвлүүлж түгээнэ.
- Гарын доорхи материалаар тоглоом, сургалтын хэрэглэгдэхүүн хийх арга барил эзэмшүүлэх үйлдвэрлэгч, багш, гэр бүлд зориулсан сургалтуудыг зохион байгуулна.
- Сургуулийн өмнөх насны хүүхдэд зориулан стандартын шаардлага хангасан тоглоом, сургалтын хэрэглэгдэхүүн үйлдвэрлэн борлуулдаг иргэд, аж ахуйн нэгжийг сурталчлах, тэдний үйл ажиллагааг дэмжих ажлыг зохион байгуулна.
- Тоглоом наадгай, сургалтын хэрэглэгдэхүүний үйлдвэрлэлийн чиглэлээр мэргэжилтэн бэлтгэнэ.
- Тоглоом наадгай, сургалтын хэрэглэгдэхүүний жижиг үйлдвэрийг төв, орон нутагт гадаадын зээл, тусламжаар байгуулах арга хэмжээ авна.

7.5.4. Сургуулийн өмнөх боловсролын байгууллагуудад дотоод, гадаадын төслийн нөөц бололцоонд тулгуурлан орлого нэмэгдүүлэхэд чиглэсэн туслах аж ахуй эрхлэх, өөрийн хэрэгцээг хангах жижиг төслүүд хэрэгжүүлнэ.

7.5.5. Сургуулийн өмнөх боловсролын санхүүжилтийг олон эх үүсвэртэй болгож, төрийн санхүүжилтийг үр ашигтай зарцуулах эрх зүйн орчин бүрдүүлнэ.

- Нэгж хүүхдэд сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэхэд ногдох хувьсах зардлаар санхүүжүүлэх зарчимд шилжинэ.

Найм. Хөтөлбөрийн шалгуур

- Сургуулийн өмнөх боловсролд хамрагдах хүүхдийн тоог 62 хувьд хүргэсэн байх:

Хамрагдах хэлбэр	2000-2001 он	2001-2002 он	2002-2003 он	2003-2004 он	2004-2005 он	2005-2006 он	2006-2007 он
Цэцэрлэгт	32%	33,6%	35,2%	36,8%	38,4%	40%	41%
СӨБ-ын сургалтуудад	5,7%	8,1%	10,9%	13,7%	16,6%	19,6%	21 %
Бүгд	37,7%	41,7%	46,1%	50,5%	55%	59,6%	62 %

- Нийгмийн халамж, дэмжлэг шаардлагатай хүүхдийн сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамрагдалтын хувь өссөн байдал:

Жил	2000-2001 он	2001-2002 он	2002-2003 он	2003-2004 он	2004-2005 он	2005-2006 он	2006-2007 он
СӨБ-ын хамрагдалт	37,7%	41,7%	46,1%	50,5%	55%	59,6%	62,0%
СӨБ-ын хамрагдалтад нийгмийн халамж дэмжлэг шаардлагатай бага насны хүүхдийн эзлэх хувь	4,5 %	4,9%	5,3%	5,7%	6,1%	6,5%	6,9%

- Хүний нөөцийн мэргэжлийн чадавхи сайжирсан байдал,
- Төрийн өмчийн бус сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэх байгууллага, түүнд хамрагдсан хүүхдийн тоог 2 дахин нэмэгдүүлсэн байх,
- Сургуулийн өмнөх боловсролын санхүүжилтийн өсөлт,
- Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын сургалтын орчны стандартын шаардлагыг хангасан байгууллагын эзлэх хувь өссөн байдал,
- Сургуулийн өмнөх боловсролын агуулгын стандарт, түүнийг хэрэгжүүлэх сургалтын технологийн шинэчлэл.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 6 дугаар сарын 5–ны өдөр | Дугаар 120 | Улаанбаатар хот

Үндэсний хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Бага, дунд боловсролын багш бэлтгэх, мэргэжил дээшлүүлэх Үндэсний хөтөлбөр"-ийг 1 дүгээр, "Бага, дунд боловсролын багш бэлтгэх, мэргэжил дээшлүүлэх Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны 2001-2004 оны төлөвлөгөө"-г 2 дугаар хавсралт ёсоор тус тус батлалсугай.

2. Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулж, биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд А.Цанжид, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Үндэсний хөтөлбөрт тусгасан зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шаардагдах зардлыг эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, улсын төсөвт тусган ажиллахыг Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд А.Цанжид, Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаан нарт үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙД **А.ЦАНЖИД**

Засгийн газрын 2001 оны 120 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

БАГА, ДУНД БОЛОВСРОЛЫН БАГШ БЭЛТГЭХ, МЭРГЭЖИЛ ДЭЭШЛҮҮЛЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР

Нэг. Хөтөлбөрийн нийтлэг үндэслэл

1. Монгол Улсын боловсролын шинэчлэлийг гүнзгийрүүлэх, боловсролын үйлчилгээний чанарыг сайжруулах, сургалтыг иргэд, суралцагчдын эрэлт хэрэгцээнд нийцүүлэх, багш бэлтгэх сургалтын агуулга, арга зүйг боловсронгуй болгох, тэдний мэргэжлийг дээшлүүлэх оновчтой тогтолцоо бүрдүүлэх шаардлага нийгмийн хөгжлөөс урган гарч байна.

Орчин үед багш хүн сургалтын үр дүнг сайжруулахын төлөө байнга судалгаа шинжилгээ хийж, хүмүүс /сурагч, эцэг эх гэх мэт/ -тэй ажиллаж байдаг судлаач байхын зэрэгцээ сургалтын хэрэглэгдэхүүн, заах арга, сургалтын арга зүйг боловсронгуй болгож байдаг технологич, сургалтыг үр ашигтай зохион байгуулагч менежер байх шаардлага тавигдаж байна. Багшид тавигдах эдгээр шинэ шаардлагыг энэхүү үндэсний хөтөлбөрт тусган боловсруулсан болно.

Боловсролын үйлчилгээний чанарыг шинэ шатанд гаргах, багш бэлтгэх, мэргэжил дээшлүүлэх тогтолцоог боловсронгуй болгох, хот, хөдөөгийн сургуулийг мэргэжлийн чадварлаг багшаар жигд хангах, тэдний тогтвор суурьшилтай ажиллуулах, идэвх санаачилгыг дэмжиж, мэргэжлээ тасралтгүй дээшлүүлэх шаардлагыг хангахад энэхүү Үндэсний хөтөлбөрийн ач холбогдол оршино.

Хоёр. Хөтөлбөрийн зорилго

2. Бага, дунд боловсролын багш бэлтгэх, тэдний мэргэжлийг тасралтгүй дээшлүүлэх, багш хүн байнга хөгжиж байх шинэ тогтолцоог бүрдүүлэхэд оршино.

Гурав. Хөтөлбөрийн зорилтууд

3. Хөтөлбөрийн зорилгыг хэрэгжүүлэхийн тулд дор дурдсан зорилтуудыг дэвшүүлж байна:

3.1 Багш бэлтгэх тогтолцоог шинэчлэх.
3.2 Багш нарын мэргэжил дээшлүүлэх үеэн хатан, төвлөрсөн бус тогтолцоог түншлэлд тулгуурлан төлөвшүүлэх.
3.3 Багш бэлтгэх, мэргэжил дээшлүүлэх сургалтын орчныг бэхжүүлэх, санхүүжилтийн механизмыг боловсронгуй болгох.
3.4 Багшийн ажлын үнэлгээг боловсронгуй болгох, тэдний идэвхтэй үйл ажиллагааг дэмжих механизм бүрдүүлэх.

Дөрөв. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд баримтлах зарчим

4.1 Монгол Улсын нийгэм, эдийн засгийн бүсчилсэн хөгжлийн бодлого, нийгмийн хөгжлийн хандлага, суралцагчдын хэрэгцээтэй уялдсан байх.

4.2 Боловсролын хууль тогтоомж, эрхэм зорилго, стратегийн зорилт, хөгжлийн чиг хандлагад нийцсэн байх.

4.3 Нээлттэй, хуртэзмжтэй, уян хатан байх.

4.4 Төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэд зэрэг сонирхогч бүх талын бодит оролцоог хангасан байх.

4.5 Олон улсын жишиг, үндэсний онцлогтой нийцсэн байх.

Тав. Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа

5.1 Багш бэлтгэх тогтолцоог шинэчлэх

5.1.1 Багшийн хүрэлцээ, хангамж, тогтвор суурьшилтай ажиллах шаардлага зэргийг харгалзан орон нутгийн захиалгад үндэслэн багш бэлтгэдэг сургуулиудын элсэлтийг төлөвлөх, зохион байгуулах шинэ аргачлал боловсруулан хэрэгжүүлэх.

5.1.2 Багш бэлтгэх загварыг шинэчлэн, хэд хэдэн хичээл заах чадвар бүхий багш бэлтгэх, боловсрол судлалын хичээлийн стандарт, кредит цагийн доод хэмжээг тогтоосон сургалтын цөм агуулга хөтөлбөрийг шинэчлэн боловсруулж хэрэгжүүлэх.

5.1.3 Багш бэлтгэх сургалтын хөтөлберт тусгай сурганы боловсролын агуулгыг нэмж тусгах.

5.1.4 Багш бэлтгэдэг их сургууль, коллежид анги нээх замаар тусгай хэрэгцээт боловсролын багш бэлтгэх.

5.2 Багш нарын мэргэжил дээшлүүлэх уян хатан, төвлөрсөн бус тогтолцоог түшлэлд тулгуурлан төлөвшүүлэх

5.2.1 Багш нарын мэргэжлийг үндэсний хэмжээнд, орон нутагт, ажлын байранд гэсэн 3 түвшинд сургалтын олон хувилбар бүхий хөтөлбөр / модуль/-еөр тэдний сонирхол, хэрэгцээнд тулгуурлан тасралтгүй дээшлүүлэх тогтолцоог бүрдүүлэх.

5.2.2 Орон нутаг дахь боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн байгуулагыг түшиглэн багш нарын мэргэжил дээшлүүлэх бүсийн төвүүд байгуулан ажиллуулах.

5.2.3 Зайны болон албан бус сургалтаар багш нарын мэргэжил дээшлүүлэх агуулга, хөтөлбөр, арга зүйг боловсруулан хэрэгжүүлэх.

5.2.4 Багш нарын мэргэжил дээшлүүлэхэд төрийн бус болон олон улсын байгуулагаа, олон нийт, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх.

5.3 Багш бэлтгэх, мэргэжил дээшлүүлэх сургалтын баазыг бэхжүүлэх, санхүүжилтийн механизмыг боловсронгуй болгох

5.3.1 Багш бэлтгэдэг сургуулиудын сургалтын агуулгын болон орчны стандартыг боловсруулан мөрдүүлэх.

5.3.2 Аймаг, нийслэлийн боловсрол, соёлын төв, мэргэжил дээшлүүлэх бүсийн төв, багш бэлтгэдэг их сургууль, коллежийн сургалт, судалгааны баазыг бэхжүүлэх хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх.

5.3.3 Багш нарыг мэргэжлээ тасралтгүй дээшлүүлэхэд зориулж гарын авлага, сургалтын материал боловсруулан хэвлүүлж түгээх, мэргэжлийн мэдээлэл, туслалцаа авах боломж, нөхцөлийг сайжруулах.

5.4 Багшийн ажлын үнэлгээг боловсронгуй болгох, тэдний идэвхтэй арга, үйл ажиллагааг дэмжих механизм бүрдүүлэх

5.4.1 Багшийн ажлыг бодитой үнэлэх нөхцөл бүрдүүлэх:

- Багш үйл ажиллагаандаа үнэлгээ өгөх болон багшийн үйл ажиллагаанд мэргэжлийн үнэлгээ өгөх цогцолбор үзүүлэлт боловсруулан мөрдүүлэх;
- Багшийн үйл ажиллагааг үнэлэхэд эцэг, эх, сонирхлын бүлгийн оролцоог нэмэгдүүлэх.

5.4.2 Багшийн идэвхтэй үйл ажиллагааг дэмжих арга, хэлбэрийг боловсронгуй болгох:

- Үйл ажиллагааны үр дүн, бүтээлч байдал, мэргэжлийн түвшин, ур чадварыг харгалзан багшид нэмэгдэл олгох асуудлыг боловсронгуй болгох.
- Багш нарыг тогтвор суурьшилтай ажиллуулах асуудал боловсруулж хэрэгжүүлэх.

Зургаа. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт, хяналт

Хөтөлбөрийн зорилт, үйл ажиллагаа, арга хэмжээг хэрэгжүүлэхэд багш бэлтгэх, тэдний

мэргэжил дээшлүүлэх үйл ажиллагаанд оролцогч субъектүүд дараахь байдлаар оролцоно. Үүнд:

- Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд хийх хяналт-шинжилгээ, үнэлгээг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, мэргэжил арга зүйн удирдлагаар хангах асуудлыг Боловсролын хүрээлэн, Боловсролын хөгжлийн сургууль эрхэлнэ;
- Үндэсний хөтөлбөрийг орон нутгийн түвшинд хэрэгжүүлэхэд аймаг, нийслэлийн Засаг дарга захиргааны удирдлагаар, боловсрол, соёлын төв мэргэжлийн удирдлагаар хангаж, арга зүйн туслалцаа үзүүлнэ;
- Төрийн болон төрийн өмчийн бус их сургууль, коллеж нь багш бэлтгэх, давтан бэлтгэх ажлыг хэрэгжүүлэх бөгөөд багш нарын мэргэжлийг ажлын байранд нь тасралтгүй дээшлүүлэх үйл ажиллагааг сургууль, боловсролын байгууллага зохион байгуулна.

Долоо. Хөтөлбөрийн санхүүжилт

Багш бэлтгэх, мэргэжил дээшлүүлэх үндэсний хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэхэд санхүүгийн дор дурдсан эх үүсвэрүүдийг ашиглана:

- Улсын төвлөрсөн болон орон нутгийн төсөв
- Гадаадын зээл, тусламжийн хөрөнгө
- Сургуулийн өөрийн хөрөнгө
- Хандивын хөрөнгө
- Сургалтын төрийн сангийн зээл
- Төслийн санхүүжилтийн хөрөнгө
- Бусад эх үүсвэр

Хөтөлбөрт тусгагдсан багш нарын мэргэжил дээшлүүлэх бүсийн төвүүдийн үйл ажиллагааны зардал төсвийн хөрөнгөөр хийгдэнэ.

Орон нутгийн өрөнхий боловсролын сургуулийн багш нарын мэргэжил дээшлүүлэх арга хэмжээнд улсын төсвөөс олгох хөрөнгийг тухайн сургуулийн жилийн төсөвт тусгаж байх тогтолцоонд шилжүүлнэ.

Найм. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа

Хөтөлбөрийг 2 үе шаттай хэрэгжүүлнэ.

- I үе шат 2001-2004 он
- II үе шат 2005-2010 он

Ес. Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр хүрэх үр дүн

- Багш бэлтгэх сургуулиудын сургалтын чанар дээшилнэ,
- Багшийн мэргэжил дээшлүүлэх төвлөрсөн бус тогтолцоо бүрэлдэж, үйл ажиллагаа нь жигдрэн, үр ашиг нь нэмэгдэнэ,
- Багш нарын мэргэжлийн бэлтгэл, ур чадвар дээшилж, суралцагчдын сурлагын амжилт, чанар ахина.
- Хөдөөгийн сургуулийн багшийн хүрэлцээ, хангамж сайжирна,
- Багш бэлтгэх, мэргэжил дээшлүүлэх сургалтын материаллаг бааз бэхжиж, санхүүжилтийн тогтвортой эх үүсвэртэй болно.

Арав. Хөтөлбөрийн хэрэгжилтийг үнэлэх шалгуур

Боловсролын салбарын тогтвортой хөгжлийг хангах үндэс болсон багш бэлтгэх, тэдний мэргэжлийг дээшлүүлэх сургалтын чанарын өөрчлөлтийг үнэлэхэд дараахь шалгуур үзүүлэлтийг ашиглана:

- Өрөнхий боловсролын сургуулийн төгсөгчдөөс багш бэлтгэх сургуулиудад суралцах хүүхдийн тооны өсөлт, элсэгчдийн чанарын түвшин;
- Хэд хэдэн хичээл заах чадвартай багш бэлтгэх сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийн түвшин;
- Бага, дунд боловсролын мэргэжлийн багшийн хангалт /хотод 96 хувь, хөдөөд 94 хувьд хүрсэн байна/;
- Үйл ажиллагаа нь тогтворжсон бүсийн төвийн тоо;
- Багш мэргэжлээр төгсөгчдийн мэргэжлийн ажил эрхлэлтийн түвшин /70 хувьд хүргэнэ/;
- Өрөнхий боловсролын сургуульд суралцагчдын мэдлэг, чадварын түвшин ахисан байдал.

Засгийн газрын 2001 оны 120 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

"БАГА, ДУНД БОЛОВСРОЛЫН БАГШ БЭЛТГЭХ, МЭРГЭЖИЛ ДЭЭШЛҮҮЛЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР"-ИЙГ 2001-2004 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Зорилт	Хэрэгжүүлэх ажил	Хугацаа	Улсын төсөв	Бусад эх үүсвэр	Хариуцах байгууллага
Багш бэлтгэх тогтолцоог шинэчлэх	Багшийн хүрэлцээ, хангамжийг харгалзан орон нутгийн захиалгад үндэслэж багш бэлтгэх суруулиудын жил бүрийн элсэлтийг зохицуулах аргачлал боловсруулан хэрэгжүүлэх	2001- 2004 он	-	-	БСШУЯ
	Багш бэлтгэх сургалтын цем хөтөлбөрийг шинэчлэн боловсруулж мөрдүүлэх /багшийн загвар, хэд хэдэн хичээл чадвартай багш/	2002-2003 он	Улсын төсөвт тусгана	-	БСШУЯ, Багш бэлтгэдэг сургуулиуд
	Хичээлийн жилийн бүтцийн өөрчлөлтэй холбогдуулан цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багш бэлтгэх, давтан бэлтгэх, сургалтын залгамж холбоог сайжруулах, сургалтын агуулгыг шинэчлэх асуудлыг боловсруулах	2001-2003 он	Жил бүр 20 сая төгрөг	60 сая төгрөг	БСШУЯ, БХС, Багш бэлтгэдэг сургуулиуд
	Багш бэлтгэх сургалтын хөтөлбөрт тусгай сурганы боловсролын агуулгыг тусгах, багш бэлтгэдэг их сургууль, коллежид анги нээх замаар тусгай хэрэгцээт боловсролын багш бэлтгэх	2004 он	22.4 сая төгрөг		БСШУЯ, УБИС, БК

Багш нарын мэргэжил дээшлүүлэх, давтан бэлтгэх уян хатан төвлөрсөн бус тогтолцоог түшлэлд тулгуурлан төлөвшүүлэх	Багшийн мэргэжлийг үндэсний хэмжээнд орон нутагт, ажлын байранд гэсэн 3 түвшинд сургалтын олон хувилбар бүхий хөтөлбөр /модуль/-еер багш нарын сонирхол, хэрэгцээнд тулгуурлан тасралтгүй дээшлүүлэх хүрээнд мэргэжил дээшлүүлэх сургалтын агуулга, арга зүйг жанах 15-25 хүний бүрэлдэхүүнтэй шинжээчийн хэсэг байгуулах, түүний ажиллах журмыг боловсруулж мөрдүүлэх	2002-2004 он	-	-	БСШУХА, БСШУЯ, Боловсролын хөгжлийн сургууль
	Орон нутаг дахь боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн байгууллагыг түшиглэн багш нарын мэргэжил дээшлүүлэх бүсийн төвүүдийг байгуулах судалгаа хийж, бүсийн төвүүд байх аймгийг сонгох, материаллаг баазыг бэхжүүлэх	2002-2004 он	64.0 сая төгрөг	226 сая төгрөг	БСШУЯ, БСХХХА, Олон улсын байгууллагууд
	Цацаргэг, ерөнхий боловсролын сургуулийн багшийг давтан бэлтгэх чиглэл, хөтөлбөр боловсруулах	2001-2004 он	610.4 сая төгрөг	-	БСШУЯ, УБИС, БК, СХУК
	Зайнаас болон албан бус сургалтаар багш нарын мэргэжил дээшлүүлэх агуулга, хөтөлбөр, арга зүйг боловсруулан хэрэгжүүлэх. Багш нарын мэргэжлийг зайны сургалтаар дээшлүүлэхэд чиглэгдсэн тесеп боловсруулж хэрэгжүүлэх, хэрэгжилт бүй төслийг дэмжих	2001-2004 он	-	300 сая төгрөг	НҮБ-ын Хүүхдийн сан

Багш бэлтгэх, мэргэжил дээшлүүлэх сургалтын орчныг бэхжүүлэх, санхүүжилтийн механизмыг боловсронгуй болгох	Багш бэлтгэдэг сургуулиудын сургалтын агуулгын болон орчны стандартыг боловсруулан мөрдүүлэх	2002 он	3.4 сая төгрөг	-	БСШУЯ
	Аймаг, нийслэлийн боловсрол, соёлын төв, мэргэжил дээшлүүлэх бүсийн төв, багш бэлтгэх их сургууль, коллежийн сургалт, судалгааны баазыг бэхжүүлэх зорилгоор /компьютер, хувилагч машин зэрэг техник хэрэгсэл авах/ хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх	2001-2004 он	Жил бүр 6 байгууллагад 100 сая төгрөг	841 сая төгрөг	БСШУЯ, БСХХХА
	Багш нар мэргэжлээ тасралтгүй дээшлүүлэхэд зориулж гарын авлага, сургалтын материал боловсруулан хэвлүүлж түгээх, мэргэжлийн мэдээлэл, туслалцаа авах боломжийг сайжруулах	2002-2004 он	Жилд 10 сая төгрөг	500 сая төгрөг	БСШУЯ, ЮНИСЕФ, ЮНЕСКО
Багшийн ажлын үнэлгээ, идэвхжүүлэх арга механизмыг боловсронгуй болгох	Багшийн ажлыг бодитой үнэлэх журмыг шинэчлэн боловсруулж мөрдүүлэх /өөрийн үнэлгээ болон хөндлөнгийн үнэлгээ/	2002-2004 он	-	-	СЭЗЯ, БСШУЯ
	Багшийн үйл ажиллагаа, бүтээлч байдлыг нь үнэлэх үндсэн дээр багшид нэмэгдэл олгох механизмыг боловсронгуй болгох	2002-2004 он	-	-	СЭЗЯ, БСШУЯ
	Багш нарыг тогтвор суурьшилтай ажиллуулах асуудал боловсруулж хэрэгжүүлэх	2003-2004 он	-	-	СЭЗЯ, БСШУЯ, ДБЯ
Нийт			1387.7 сая төгрөг	1927.0 сая төгрөг	

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 6 дугаар сарын 6-ны өдөр | Дугаар 122 | Улаанбаатар хот

Жагсаалт батлах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэгч сонгох журмын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэгч сонгох журмын тухай хууль үйлчлэхгүй батлан хамгаалах, үндэсний аюулгүй байдлыг хангахтай холбогдсон тусгай зориулалтын байгууламж, техник, тоног төхөөрөмж, галт зэвсэг болон үйлчилгээний жагсаалтыг хавсралт ёсоор батална.

2. Энэхүү жагсаалтад дурдсан бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд хэмнэлттэй, үр ашигтай, шударга явуулж байхыг холбогдох сайд, дарга нарт үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН САЙД Ч.УЛААН

Засгийн газрын 2001 оны 122 дугаар тогтоолын хавсралт

БАТЛАН ХАМГААЛАХ БА ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХТАЙ ХОЛБОГДСОН ТУСГАЙ ЗОРИУЛАЛТЫН БАЙГУУЛАМЖ, ТЕХНИК, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ, ГАЛТ ЗЭВСЭГ БОЛОН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЖАГСААЛТ

I. Хуулиар Монгол Улсын төрийн нууцад хамааруулсан бараа, ажил, үйлчилгээ.

II. Нийгмийн хэв журам хангах салбарт:

1. Тагнуулын ажлын техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, тэдгээрт хийх засвар, үйлчилгээ;

2. Тагнуулын байгууллагын аюулгүй байдлыг хангах чиглэлээр ашиглах дохиолол хамгаалалтын техник хэрэгсэл, программ, галт зэвсэг, сум, бусад хэрэгсэл, тэдгээрт хийх засвар, үйлчилгээ;

3. Тагнуулын ерөнхий газрын тусгай бэлтгэл, зориулалт бүхий нэгжийн үндсэн ажилтай холбоотой техник, тоног төхөөрөмж, галт зэвсэг, сум, бусад хэрэгсэл, тэдгээрт хийх засвар, үйлчилгээ;

4. Төрийн холбоо, тусгай хамгаалалт, гүйцэтгэх ажилд ашиглах зориулалтаар тоноглогдсон автомашин, тээврийн бусад хэрэгсэл, архивын нууц материал хадгалах, хамгаалах, ашиглах зориулалт бүхий тоног төхөөрөмж, тэдгээрт хийх засвар, үлчилгээ;

5. Төрийн холбоо, мэдээллийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр ашиглах техник хэрэгсэл, тусгай программ хангамж,

тэдгээрт хийх засвар, үйлчилгээ;

6. Тагнуулын ерөнхий газрын төв болон түүний харьяа салбар, нэгжийн байр, тагнуулын үйл ажиллагааны зориулалт, халхавчаар ашиглах байр, орон сууц барих, засвар, үйлчилгээ хийх;

7. Хилийн цэрэг, цагдаа, шүүхийн шийдвэр биелүүлэх байгууллагын тусгай зориулалтаар тоноглогдсон тоног төхөөрөмж, техник хэрэгсэл, тэдгээрт хийх засвар, үйлчилгээ;

8. Хилийн цэрэг, цагдаа, шүүхийн шийдвэр биелүүлэх байгууллагын галт зэвсэг, тусгай хэрэгсэл, тэдгээрт хийх засвар, үйлчилгээ;

9. Хилийн хороо, суман, харуулын усан хангамжийн байгууламжууд, уст цэгийн угсралт, засвар болон гадна дулааны ажил.

Ш.Батлан хамгаалах салбарт:

1. Иргэний хамгаалалтын удирдлагын хоргодох байр, байгууламж;

2. Цэрэг, иргэний давхар зориулалттай дэд бүтцийн объект;

3. Цэргийн зэвсэг, техник хэрэгсэл, сэлбэг материал, тэдгээрт хийх засвар, үйлчилгээ;

4. Хуягт танкийн техник болон байлдаааны машин, артиллери, минометын болон буудлагын зэвсэг;

5. Цэргийн тусгай зориулалтаар тоноглогдсон тоног төхөөрөмж, техник хэрэгсэл, тэдгээрт хийх засвар, үйлчилгээ;

6. Цэргийн тусгай зориулалттай шатахууны техник хэрэгсэл, тэдгээрт хийх засвар, үйлчилгээ;

7. Цэргийн тусгай зориулалттай хүнсний техник, тоноглол, тэдгээрт хийх засвар, үйлчилгээ;

8. Цэргийн зориулалттай пуужин, галт хэрэгсэл, тэсрэх болон химийн бодис;

9. Зэвсэглэл, техникийн тусгай зориулалттай түлш, тос, шингэн болон консервацийн материал;

10. Цэргийн сургалтын дууриалган үзүүлэх болон дадлагын техник хэрэгсэл, тэдгээрт хийх засвар, үйлчилгээ.

IY. Төсвийн урсгал зардлын хэрэглэгч, нийлүүлэгчийн хооронд тусгай гэрээгээр зохицуулагдаж буй зардал:

-гэрэл цахилгаан;
-түлш, халаалт;
-шуудан, холбоо;
-цэвэр, бохир ус.

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Хаяг: «Төрийн мэдээлэл» эмхтгэлийн зөвлөл

Улаанбаатар-12 ☎ 329612
Төрийн ордон Индекс 14003

Улсын Их Хурлын Тамгын газрын
Хэвлэх хэсэгт хэвлэв.

☎ 329487



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 31 (218)

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ:

- *Зарим хүнийг одон, медалиар шагнах тухай*
- *Элчин сайдыг томилох тухай*

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ:

- *Улсын хяналтын дүрэм батлах тухай*
- *Дүрэм батлах тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар

Улаанбаатар хот
2001 он

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот 2001 оны наймдугаар сарын 11 №31 (218)

Гарчиг

Нэг. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

391. Зарим хүнийг одон, медалиар шагнах тухай Дугаар 19 797

392. Элчин сайдыг томилох тухай Дугаар 22 804

393. В.Н.Шетининг "Алтан гадас" одонгоор шагнах тухай Дугаар 24 804

394. Г.Залмыг "Алтан гадас" одонгоор шагнах тухай Дугаар 25 804

Хоёр. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

395. Улсын хяналтын дүрэм батлах тухай Дугаар 123 804

396. Дүрэм батлах тухай Дугаар 124 810

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2001 оны 7 дугаар сарын 17-ны өдөр **Дугаар 19** **Улаанбаатар хот**

Зарим хүнийг одон, медалиар шагнах тухай

Цагдаагийн байгууллагад олон жил идэвх зүтгэл, үр бүтээлтэй ажиллаж байгаа дор дурдсан хүмүүсийг одон, медалиар шагнасугай.

СҮХБААТАРЫН ОДОНГООР

Сангийн Саадэлэг - Орхон аймгийн Засаг даргын дэргэдэх Цагдаагийн газрын дарга, цагдаагийн хурандаа

ЦЭРГИЙН ГАВЬЯАНЫ УЛААН ТУГИЙН ОДОНГООР

1. Чимэддоржийн Амарболд - Цагдаагийн ерөнхий газрын дарга, хошууч генерал

2. Пүрэвийн Багадэлгэр - Дундговь аймгийн Засаг даргын дэргэдэх Цагдаагийн хэлтсийн мөрдөн байцаах тасгийн дарга, цагдаагийн дэд хурандаа

3. Шуурайн Батсүх - Нийслэлийн Сүхбаатар дүүргийн Засаг даргын дэргэдэх Цагдаагийн хэлтсийн дарга, цагдаагийн хурандаа

4. Жаалавын Бумнанжид - Цагдаагийн ерөнхий газрын Мөрдөн байцаах газрын дарга, цагдаагийн хурандаа

5. Мядагийн Ганхүү - Цагдаагийн ерөнхий газрын Эрүүгийн цагдаагийн газрын дарга, цагдаагийн хурандаа

6. Даваагийн Дорж - Сэлэнгэ аймгийн Засаг даргын дэргэдэх Цагдаагийн газрын дарга, цагдаагийн хурандаа

7. Хяраадайн Доржпалам - Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн ажлын албаны ахлах референт, цагдаагийн хурандаа

8. Чимэдийн Сүхбат - Говьсүмбэр аймгийн Засаг даргын дэргэдэх Цагдаагийн хэлтсийн дарга,

цагдаагийн дэд хурандаа

9. Данзангийн Цог - Цагдаагийн Ерөнхий газрын Тамгын газрын дарга, цагдаагийн хурандаа

10. Зандансүрэнгийн Эрдэнэбилэг - Дархан-Уул аймгийн Засаг даргын дэргэдэх Цагдаагийн газрын тасгийн дарга, цагдаагийн дэд хурандаа

ХӨДӨЛМӨРИЙН ГАВЬЯАНЫ УЛААН ТУГИЙН ОДОНГООР

1. Данзангийн Сандаг-Очир - Цагдаагийн ерөнхий газрын дэд дарга, цагдаагийн хурандаа

2. Санжхүүгийн Цэвээнлхазал - Цагдаагийн ерөнхий газрын Авто баазын дарга, цагдаагийн хурандаа

ЦЭРГИЙН ГАВЬЯАНЫ ОДОНГООР

1. Цэвэгмидийн Амгаланбаяр - Цагдаагийн ерөнхий газрын Замын цагдаагийн газрын дарга, цагдаагийн хурандаа

2. Жамбалжавын Баатаржав - Цагдаагийн ерөнхий газрын боловсон хүчин, сургалт, арга зүйн хэлтсийн дарга, цагдаагийн дэд хурандаа

3. Банзрагчийн Батболд - Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Засаг даргын дэргэдэх Цагдаагийн хэлтсийн эрүүлийн цагдаа, цагдаагийн ахлах ахлагч

4. Гадинагийн Батжаргал - Нийслэлийн Баянзүрх дүүргийн Засаг даргын дэргэдэх Цагдаагийн хэлтсийн эрүүлжүүлэх байрын дарга, цагдаагийн дэд хурандаа

5. Дамбадаржаагийн Батмөнх - Нийслэлийн Баянзүрх дүүргийн Засаг даргын дэргэдэх Цагдаагийн хэлтсийн ахлах байцаагч, цагдаагийн ахмад

6. Доржийн Баттөмөр - Дундговь аймгийн Засаг даргын дэргэдэх Цагдаагийн хэлтсийн жижүүрийн офицер, цагдаагийн ахлах дэслэгч

7. Төмөрийн Баттөр - Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын дэргэдэх Цагдаагийн хэлтсийн цагдаа, цагдаагийн ахлах ахлагч

8. Дашдондовын Батчулуун - Нийслэлийн Сүхбаатар дүүргийн Засаг даргын дэргэдэх Цагдаагийн хэлтсийн дэд дарга, цагдаагийн дэд хурандаа

9. Тойжамцын Батчулуун - Булган аймгийн Засаг даргын дэргэдэх Цагдаагийн хэлтсийн дарга, цагдаагийн хурандаа

10. Гэндэндаржаагийн Баянжаргал - Дотоодын цэргийн 05 дугаар ангийн жолооч, ахлах ахлагч

11. Цэрэндоржийн Баярсайхан- Нийслэлийн Багануур дүүргийн Засаг даргын дэргэдэх Цагдаагийн хэлтсийн дэд дарга, цагдаагийн дэд хурандаа

12. Сүндэвийн Баярхүү - Нийслэлийн Багануур дүүргийн Засаг даргын дэргэдэх Цагдаагийн хэлтсийн ахлах байцаагч, цагдаагийн дэд хурандаа

13. Баатарын Болдбаатар - Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын дэргэдэх Цагдаагийн хэлтсийн дарга, цагдаагийн дэд хурандаа

14. Нацагдоржийн Бямбаа - Сэлэнгэ аймгийн Засаг даргын дэргэдэх Цагдаагийн газрын цагдаа, цагдаагийн ахлах ахлагч

15. Пандийн Бямбаа - Өмнөговь аймгийн Засаг даргын дэргэдэх Цагдаагийн хэлтсийн дарга, цагдаагийн дэд хурандаа

16. Сундуйн Ганхүү - Цагдаагийн академийн ахлах багш, цагдаагийн хурандаа

17. Доржготовын Гинжбаатар - Сэлэнгэ аймгийн Засаг даргын дэргэдэх Цагдаагийн газрын ахлах төлөөлөгч, цагдаагийн дэд хурандаа

18. Цэрэндоржийн Гомбодорж - Улаанбаатар хотын Дипломат болон банкны байгууллагуудын хамгаалалт, шөнийн эргүүлийн 808 дугаар ангийн эргүүлийн ахлах офицер, цагдаагийн хошуу

19. Ичинноровын Гүнсэн - Цагдаагийн ерөнхий газрын хэв журмын хэлтсийн дарга, цагдаагийн дэд хурандаа

20. Жамцын Даваасамбуу - Дорнод аймгийн Засаг даргын дэргэдэх Цагдаагийн газрын цагдаа, цагдаагийн ахлах ахлагч

21. Сэрдсүрэнгийн Даваасүрэн - Дорноговь аймгийн Засаг даргын дэргэдэх Цагдаагийн газрын Замын-Үүд дэх цагдаагийн тасгийн дарга, цагдаагийн дэд хурандаа

22. Банзрагчийн Даваахүү - Нийслэлийн Баянгол дүүргийн Засаг даргын дэргэдэх Цагдаагийн хэлтсийн жолооч, цагдаагийн ахлах ахлагч

23. Даваасүрэнгийн Дагвадорж - Цагдаагийн ерөнхий газрын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хэлтсийн дарга, цагдаагийн дэд хурандаа

24. Бямбын Дорж - Нийслэлийн Хан-Уул дүүргийн Засаг даргын дэргэдэх Цагдаагийн хэлтсийн дэд дарга, цагдаагийн дэд хурандаа

25. Арьхадын Доржготов - Цагдаагийн академийн лабораторийн эрхлэгч, цагдаагийн дэд хурандаа

26. Борын Дорлиг - Нийслэлийн Багануур дүүргийн Засаг даргын дэргэдэх Цагдаагийн хэлтсийн мөрдөн байцаах тасгийн дарга, цагдаагийн дэд хурандаа

27. Лэгшидрэнцэнгийн Дэмбэрэл - Архангай аймгийн Засаг даргын дэргэдэх Цагдаагийн хэлтсийн хэв журмын тасгийн дарга, цагдаагийн дэд хурандаа

28. Чойн Жагварал - Нийслэлийн Баянзүрх дүүргийн Засаг даргын дэргэдэх Цагдаагийн хэлтсийн хэрэг бүртгэгч, цагдаагийн ахмад

29. Зардыханы Жайсан - Баян-Өлгий аймгийн Засаг даргын дэргэдэх Цагдаагийн хэлтсийн эрүүгийн ахлах төлөөлөгч, цагдаагийн дэд хурандаа

30. Бадарын Жаргал - Завхан аймгийн Засаг даргын дэргэдэх Цагдаагийн хэлтсийн ахлах байцаагч, цагдаагийн дэд хурандаа

31. Долгорын Загдаа - Цагдаагийн ерөнхий газрын Эргүүл хамгаалалтын 801 дүгээр хорооны офицер, цагдаагийн ахлах ахлагч

32. Баатарын Иванов - Увс аймгийн Засаг даргын дэргэдэх Цагдаагийн хэлтсийн замын цагдаагийн тасгийн дарга, цагдаагийн дэд хурандаа

33. Жамцын Лхагвасүрэн - Ховд аймгийн Засаг даргын дэргэдэх Цагдаагийн хэлтсийн эрүүлжүүлэх байрын дарга, цагдаагийн хошууч

34. Ойдовын Лхагвасүрэн - Дорнод аймгийн Засаг даргын дэргэдэх Цагдаагийн газрын дэд дарга, цагдаагийн дэд хурандаа

35. Дугаржавын Майсүрэн - Нийслэлийн Хан-Уул дүүргийн Засаг даргын дэргэдэх Цагдаагийн хэлтсийн дарга, цагдаагийн хурандаа

36. Намжилын Нямхүү - Сэлэнгэ аймгийн Засаг даргын дэргэдэх Цагдаагийн газрын хэсгийн төлөөлөгч, цагдаагийн ахмад

37. Самдангийн Оргодол - Цагдаагийн ерөнхий газрын Хяналт шалгалтын тусгай тасгийн зохион байгуулагч, цагдаагийн хошууч

38. Лувсандоржийн Очирхуяг - Улаанбаатар хотын дипломат болон банкны байгууллагуудын хамгаалалт, шөнийн эргүүлийн 808 дугаар ангийн захирагч, цагдаагийн хурандаа

39. Хорхойн Пүрэвсүрэн - Нийслэлийн Баянзүрх дүүргийн Засаг даргын дэргэдэх Цагдаагийн хэлтсийн ахлах байцаагч, цагдаагийн ахмад

40. Намсрайн Саруул - Нийслэлийн Засаг даргын дэргэдэх Цагдаагийн газрын тасгийн дарга, цагдаагийн дэд хурандаа

41. Лувсандоржийн Сэлэнгэ - Дархан-Уул аймгийн Засаг даргын дэргэдэх Цагдаагийн газрын хэсгийн байцаагч, цагдаагийн ахмад

42. Даваагийн Сэсээр - Цагдаагийн ерөнхий газрын Замын цагдаагийн газрын Урьдчилан сэргийлэх хэсгийн дарга, цагдаагийн дэд хурандаа

43. Янжиндолгорын Төмөр-Очир - Өвөрхангай аймгийн Засаг даргын дэргэдэх Цагдаагийн хэлтсийн хэсгийн төлөөлөгч, цагдаагийн хошууч

44. Заяатхүүгийн Төрмандах - Цагдаагийн ерөнхий газрын Эрүүгийн цагдаагийн газрын дэд дарга, цагдаагийн дэд хурандаа

45. Зандраагийн Цогтжаргал - Цагдаагийн ерөнхий газрын Авто баазын цагдаа-жолооч, цагдаагийн ахлах ахлагч

46. Ванжилын Цэгмид - Нийслэлийн Баянгол дүүргийн Засаг даргын дэргэдэх Цагдаагийн хэлтсийн ахлах төлөөлөгч, цагдаагийн хошууч

47. Ишжамцын Цэдэн-Иш - Цагдаагийн ерөнхий газрын хэвлэлийн төлөөлөгч, цагдаагийн дэд хурандаа

48. Дагвадоржийн Чанцал - Сэлэнгэ аймгийн Засаг даргын дэргэдэх Цагдаагийн газрын Хөтөл дэх цагдаагийн тасгийн ахлах байцаагч, цагдаагийн хошууч

49. Чойжамцын Чулуун - Цагдаагийн ерөнхий газрын Улаанбаатар төмөр зам дахь Цагдаагийн хэлтсийн цагдаа, цагдаагийн ахлах ахлагч

50. Өлзийхүүгийн Чүлтэмбаяр - Цагдаагийн ерөнхий газрын Мөрдөн байцаах газрын Сонгинохайрхан дүүрэг дэх мөрдөн байцаах тасгийн дарга, цагдаагийн хошууч

51. Чалхаагийн Энх-Амгалан - Цагдаагийн ерөнхий газрын Санхүү, төлөвлөлт, үйлчилгээ хангамжийн газрын дарга, цагдаагийн хурандаа

52. Арилдийн Энхбаатар - Цагдаагийн ерөнхий газрын Шуурхай албаны хэлтсийн ерөнхий жижүүр, цагдаагийн дэд хурандаа

53. Дангаасүрэнгийн Эрдэнэ - Нийслэлийн Баянгол дүүргийн Засаг даргын дэргэдэх Цагдаагийн хэлтсийн тасгийн дарга, цагдаагийн дэд хурандаа

54. Дунийн Эрдэнэбаатар - Нийслэлийн Засаг даргын дэргэдэх Цагдаагийн газрын лабораторийн эрхлэгч, цагдаагийн дэд хурандаа

ХӨДӨЛМӨРИЙН ХҮНДЭТ МЕДАЛИАР

1. Нанзаддоржийн Адьяасүрэн - Архангай аймгийн Засаг даргын дэргэдэх Цагдаагийн хэлтсийн цагдаа-жолооч, цагдаагийн ахлах ахлагч

2. Дамдинсүрэнгийн Алтаннавч - Нийслэлийн Баянгол дүүргийн Засаг даргын дэргэдэх Цагдаагийн хэлтсийн ахлах байцаагч, цагдаагийн хошууч

3. Дэлэгчоймболын Амарсайхан - Цагдаагийн ерөнхий газрын Тамгын газрын зохион байгуулагч, цагдаагийн дэд хурандаа

4. Санжжавын Амарсайхан - Цагдаагийн ерөнхий газрын Замын цагдаагийн газрын Баянзүрх дүүрэг дах тасгийн цагдаа-зохицуулагч, цагдаагийн ахлах ахлагч

5. Бадамдоржийн Баасансүрэн - Нийслэлийн Налайх дүүргийн Засаг даргын дэргэдэх Цагдаагийн хэлтсийн дэд дарга, цагдаагийн хошууч

6. Гунгаагийн Бадарч - Интерполын Үндэсний төв товчооны нарийн бичгийн дарга, цагдаагийн хурандаа

7. Тлейханы Бакыт - Цагдаагийн ерөнхий газрын Эрүүгийн цагдаагийн газрын тасгийн дарга, цагдаагийн хошууч

8. Сономын Батболд - Ховд аймгийн Засаг даргын дэргэдэх Цагдаагийн хэлтсийн цагдаа, цагдаагийн ахлах ахлагч

9. Тогмидын Батболд - Цагдаагийн ерөнхий газрын дүрэмт хувцасны "Цагаан-Шонхор" компанийн захирал, цагдаагийн хошууч

10. Жадамбаагийн Батдорж - Сүхбаатар аймгийн Засаг даргын дэргэдэх Цагдаагийн хэлтсийн цагдаа, цагдаагийн ахлах ахлагч

11. Хүүгийн Батдэлгэр - Дорноговь аймгийн Засаг даргын дэргэдэх Цагдаагийн газрын дэд дарга, цагдаагийн хошууч

12. Диваагийн Батжаргал - Цагдаагийн ерөнхий газрын Эрүүгийн цагдаагийн газрын 2 дугаар хэлтсийн дарга, цагдаагийн дэд хурандаа

13. Лувсандоржийн Батнаст - Хэнтий аймгийн Засаг даргын дэргэдэх Цагдаагийн хэлтсийн цагдаа, цагдаагийн ахлах ахлагч

14. Дэндэвноровын Батсайхан - Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын дэргэдэх Цагдаагийн хэлтсийн хариуцлагатай жижүүр цагдаагийн хошууч

15. Лодонгийн Батсайхан - Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Засаг даргын дэргэдэх Цагдаагийн хэлтсийн хэсгийн дарга, цагдаагийн хошууч

16. Арилдийн Батсуурь - Дотоодын цэргийн 05 дугаар ангийн 812 дугаар тусгай салбарын захирагч, дэд хурандаа

17. Жанзайн Баттулга - Төв аймгийн Засаг даргын дэргэдэх Цагдаагийн газрын дэд дарга, цагдаагийн дэд хурандаа

18. Баасанхүүгийн Батчулуун - Булган аймгийн Засаг даргын дэргэдэх Цагдаагийн хэлтсийн цагдаа, цагдаагийн ахлах ахлагч

19. Өлзийбатын Батчулуун - Баянхонгор аймгийн Засаг даргын дэргэдэх Цагдаагийн хэлтсийн эргүүлийн цагдаа, цагдаагийн ахлах ахлагч

20. Цэрэнгийн Батчулуун - Увс аймгийн Засаг даргын дэргэдэх Цагдаагийн хэлтсийн дарга, цагдаагийн дэд хурандаа

21. Шурагийн Бат-Эрдэнэ - Дорноговь аймгийн Засаг даргын дэргэдэх Цагдаагийн газрын эрүүгийн ахлах төлөөлөгч, цагдаагийн ахмад

22. Өлзийхүүгийн Баянжаргал - Дархан-Уул аймгийн Засаг даргын дэргэдэх Цагдаагийн газрын лабораторийн эрхлэгч, цагдаагийн ахмад

23. Дамдинжавын Баяраа - Нийслэлийн Хан-Уул дүүргийн Засаг даргын дэргэдэх Цагдаагийн хэлтсийн дэд дарга, цагдаагийн дэд хурандаа

24. Жигжидийн Баярхүү - Нийслэлийн Засаг даргын дэргэдэх Цагдаагийн газрын хулгайн гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсийн дарга, цагдаагийн дэд хурандаа

25. Раднаажавын Болд - Цагдаагийн ерөнхий газрын Эрүүгийн цагдаагийн газрын ахлах төлөөлөгч, цагдаагийн дэд хурандаа

26. Дамбийжанцангийн Булган - Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын дэргэдэх Цагдаагийн хэлтсийн тасгийн дарга, цагдаагийн хошууч

27. Хандын Бумцэнд - Нийслэлийн Налайх дүүргийн Засаг даргын дэргэдэх Цагдаагийн хэлтсийн эдийн засгийн төлөөлөгч, цагдаагийн хошууч

28. Баатаржавын Бямбаа - Говьсүмбэр аймгийн Засаг даргын дэргэдэх Цагдаагийн хэлтсийн Замын цагдаагийн ахлах байцаагч, цагдаагийн ахмад

29. Сэнгийн Бямбадорж - Завхан аймгийн Засаг даргын дэргэдэх Цагдаагийн хэлтсийн цагдаа, цагдаагийн ахлах ахлагч

30. Төмөрийн Ганбаатар - Дундговь аймгийн Засаг даргын дэргэдэх Цагдаагийн хэлтсийн дэд дарга, цагдаагийн дэд хурандаа

31. Чүлтэмийн Ганбаатар - Нийслэлийн Хан-Уул дүүргийн Засаг даргын дэргэдэх Цагдаагийн хэлтсийн хэсгийн байцаагч, цагдаагийн ахмад

32. Дандарын Ганболд - Цагдаагийн ерөнхий газрын жижүүрийн албаны хэлтсийн цагдаа-жолооч, цагдаагийн ахлах ахлагч

33. Лувсан-Очирын Ганболд - Цагдаагийн ерөнхий газрын даргын даалгавар гүйцэтгэгч, цагдаагийн дэд хурандаа

34. Жигжидсүрэнгийн Даваа - Нийслэлийн Багануур дүүргийн Засаг даргын дэргэдэх Цагдаагийн хэлтсийн дэд дарга, цагдаагийн дэд хурандаа

35. Рэнжийбуугийн Дававаням - Цагдаагийн ерөнхий газрын хяналт шалгалтын тусгай тасгийн дарга, цагдаагийн хурандаа

36. Адьяагийн Даваасүрэн - Орхон аймгийн Засаг даргын дэргэдэх Цагдаагийн газрын дэд дарга, цагдаагийн дэд хурандаа

37. Паламын Дамдинсүрэн - Цагдаагийн ерөнхий газрын Авто баазын цагдаа-жолооч, цагдаагийн ахлах ахлагч

38. Жамбалдагвын Дариймаа - Дотоодын цэргийн 805 дугаар ангийн хэв журмын байцаагч, ахмад

39. Осорын Довдон - Цагдаагийн ерөнхий газрын туслах аж ахуйн дарга, цагдаагийн дэд хурандаа

40. Агваан-Ёндонгийн Догмид - Цагдаагийн ерөнхий газрын Улаанбаатар төмөр зам дахь Цагдаагийн хэлсийн мөрдөн байцаах тасгийн дарга, цагдаагийн хошууч

41. Хувдайн Долгормаа - Дархан-Уул аймгийн Засаг даргын дэргэдэх Цагдаагийн газрын бичиг хэргийн эрхлэгч, цагдаагийн ахлах ахлагч

42. Чамбаагийн Доржсүрэн - Цагдаагийн ерөнхий газрын Замын цагдаагийн газрын нийслэлийн хөдөлгөөн зохион байгуулалт, хяналт зохицуулалтын хэлтсийн ахлах байцаагч, цагдаагийн ахмад

43. Дашдуламын Жаалням - Цагдаагийн ерөнхий газрын Эрүүгийн цагдаагийн газрын ахлах төлөөлөгч, цагдаагийн хошууч

44. Цэдэвийн Жаргал - Төв аймгийн Засаг даргын дэргэдэх Цагдаагийн газрын хэсгийн төлөөлөгч, цагдаагийн ахмад

45. Нанжидын Жаргалсайхан - Цагдаагийн ерөнхий газрын Эргүүл хамгаалалтын 801 дүгээр хорооны цагдаа, цагдаагийн ахлах ахлагч

46. Будын Идэр - Цагдаагийн ерөнхий газрын Эргүүл хамгаалалтын 801 дүгээр хорооны дэд дарга, цагдаагийн дэд хурандаа

47. Цэгмидийн Лхагваа - Дундговь аймгийн Засаг даргын дэргэдэх Цагдаагийн хэлтсийн ахлах байцаагч, цагдаагийн ахмад

48. Шагдарсүрэнгийн Лхагвасүрэн - Нийслэлийн Баянгол дүүргийн Засаг даргын дэргэдэх Цагдаагийн хэлтсийн эрүүгийн ахлах төлөөлөгч, цагдаагийн хошуу

49. Баатарын Нарангэрэл - Цагдаагийн ерөнхий газрын Эрүүгийн Цагдаагийн газрын чиглэлийн ахлах төлөөлөгч, цагдаагийн хошуу

50. Санжаагийн Нарантуяа - Цагдаагийн ерөнхий газрын Авто баазын засварчин, цагдаагийн ахлах ахлагч

51. Хасбазарын Нарантуяа - Дотоодын цэргийн 805 дугаар ангийн тусгай салбарын захирагч, хошуу

52. Самдангийн Нармандах - Цагдаагийн академийн тэнхмийн эрхлэгч

53. Батсүрэнгийн Нямсүрэн - Орхон аймгийн Засаг даргын дэргэдэх Цагдаагийн газрын хэв журмын тасгийн дарга, цагдаагийн хошуу

54. Содномпилын Пионер - Цагдаагийн ерөнхий газрын Замын цагдаагийн газрын Сүхбаатар дүүрэг дэх тасгийн дарга, цагдаагийн дэд хурандаа

55. Сүрэнгийн Пүрэвдорж - Цагдаагийн ерөнхий газрын Мөрдөн байцаах газрын хэлтсийн дарга, цагдаагийн дэд хурандаа

56. Далхсүрэнгийн Ренчинсодном - Цагдаагийн ерөнхий газрын Замын цагдаагийн газрын хамгаалалтын тасгийн цагдаа-зохицуулагч, цагдаагийн ахлах ахлагч

57. Рэгзэндоржийн Рэнцэнбат - Нийслэлийн Хан-Уул дүүргийн Засаг даргын дэргэдэх Цагдаагийн хэлтсийн эрүүгийн төлөөлөгч, цагдаагийн ахмад

58. Догсомын Сайнбилэг - Говь-Алтай аймгийн Засаг даргын дэргэдэх Цагдаагийн хэлтсийн жижүүрийн ахлах офицер, цагдаагийн ахмад

59. Орломын Самбуу - Цагдаагийн академийн багш, цагдаагийн дэд хурандаа

60. Осорбайнийн Соронзонболд - Нийслэлийн Баянгол дүүргийн Засаг даргын дэргэдэх Цагдаагийн хэлтсийн эрүүлжүүлэх байрны дарга, цагдаагийн дэд хурандаа

61. Хорлоогийн Сугар - Сүхбаатар аймгийн Засаг даргын дэргэдэх Цагдаагийн хэлтсийн ахлах шинжээч, цагдаагийн хошуу

62. Доржийн Сундуйсүрэн - Архангай аймгийн Засаг даргын дэргэдэх Цагдаагийн хэлтсийн дарга, цагдаагийн хошуу

63. Лүндэгдамбын Сүхээ - Цагдаагийн ерөнхий газрын Цагдан хорих төвийн дарга, цагдаагийн хурандаа

64. Гунгаасамбуугийн Төмөрбаатар - Цагдаагийн ерөнхий газрын Тамгын газрын ахлах байцаагч, цагдаагийн дэд хурандаа

65. Гомбожавын Төрмөнх - Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Засаг даргын дэргэдэх Цагдаагийн хэлтсийн эрүүлжүүлэх байрын дарга, цагдаагийн ахмад

66. Мижидийн Тэгшжаргал - Дархан-Уул аймгийн Засаг даргын дэргэдэх Цагдаагийн газрын эдийн засгийн төлөөлөгч, цагдаагийн хошуу

67. Норслойн Тэгшээ - Увс аймгийн Засаг даргын дэргэдэх Цагдаагийн хэлтсийн цагдаа, цагдаагийн ахлах ахлагч

68. Норовын Ундарчнэмэх - Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Засаг даргын дэргэдэх Цагдаагийн хэлтсийн ахлах байцаагч, цагдаагийн хошуу

69. Лхамсүрэнгийн Хархүү - Нийслэлийн Засаг даргын дэргэдэх Цагдаагийн газрын захиргааны удирдлагын хэлтсийн дэд дарга,

цагдаагийн дэд хурандаа

70. Секений Хуат - Баян-Өлгий аймгийн Засаг даргын дэргэдэх Цагдаагийн хэлтсийн ахлах байцаагч, цагдаагийн хошууч

71. Чимэддоржийн Хуягбаатар - Сэлэнгэ аймгийн Засаг даргын дэргэдэх Цагдаагийн газрын Замын цагдаагийн байцаагч, цагдаагийн ахмад

72. Чимэдийн Чинбат - Цагдаагийн ерөнхий газрын Эрүүгийн цагдаагийн газрын онц хүнд, зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсийн тасгийн дарга, цагдаагийн хошууч

73. Содномцэрэнгийн Чинзориг - Говь-Алтай аймгийн Засаг даргын дэргэдэх Цагдаагийн хэлтсийн дарга, цагдаагийн хошууч

74. Баасанхүүгийн Цагаан - Хэнтий аймгийн Засаг даргын дэргэдэх Цагдаагийн хэлтсийн эрүүгийн ахлах төлөөлөгч, цагдаагийн хошууч

75. Цэдэндоржийн Цогбадрах - Дорнод аймгийн Засаг даргын дэргэдэх Цагдаагийн газрын цагдаа, цагдаагийн ахлах ахлагч

76. Жүгдэрийн Цогтбаатар - Цагдаагийн ерөнхий газрын Дипломат болон банкны байгууллагуудын хамгаалалт, шөнийн эргүүлийн 808 дугаар ангийн орлогч дарга, цагдаагийн дэд хурандаа

77. Дамдинжавын Цогтбаяр - Цагдаагийн ерөнхий газрын Мөрдөн байцаах газрын 2 дугаар хэлтсийн чиглэлийн ахлах мөрдөн байцаагч, цагдаагийн дэд хурандаа

78. Цэрэндэндэвийн Шараа - Нийслэлийн Баянгол дүүргийн Засаг даргын дэргэдэх Цагдаагийн хэлтсийн жолооч, цагдаагийн ахлах ахлагч

79. Самбуугийн Шинэдэнчил - Цагдаагийн ерөнхий газрын Замын цагдаагийн газрын Хан-Уул дүүрэг дэх тасгийн цагдаа-зохицуулагч, цагдаагийн ахлах ахлагч

80. Хүрэлсүхийн Энхжаргал - Төв аймгийн Засаг даргын дэргэдэх Цагдаагийн газрын дарга, цагдаагийн дэд хурандаа

81. Пүрэвжавын Энхнасан - Төв аймгийн Засаг даргын дэргэдэх Цагдаагийн газрын бичиг хэргийн эрхлэгч, цагдаагийн ахлах ахлагч

82. Цэрэнцэвээний Энхсайхан - Цагдаагийн ерөнхий газрын Улаанбаатар төмөр зам дахь Цагдаагийн хэлтсийн дарга, цагдаагийн дэд хурандаа

83. Дашпунцагийн Энхтүвшин - Цагдаагийн ерөнхий газрын Мөрдөн байцаах газрын Сонгинохайрхан дүүрэг дэх мөрдөн байцаах тасгийн ахлах мөрдөн байцаагч, цагдаагийн хошууч

84. Нониогийн Эрдэнэ - Увс аймгийн засаг даргын дэргэдэх Цагдаагийн хэлтсийн эрүүгийн ахлах төлөөлөгч, цагдаагийн хошууч

85. Галзагдын Эрдэнэбаатар - Нийслэлийн Баянзүрх дүүргийн Засаг даргын дэргэдэх Цагдаагийн хэлтсийн хэсгийн байцаагч, цагдаагийн хошууч

86. Баасандоржийн Эрдэнэчимэг - Цагдаагийн ерөнхий газрын нууцын бичээч-операторч, цагдаагийн ахлах ахлагч

87. Пагдын Эрдэнэчимэг - Цагдаагийн ерөнхий газрын Нийтийн хоол, худалдаа, үйлчилгээний төвийн дарга, цагдаагийн дэд хурандаа

88. Далайхүүгийн Ядамдорж - Дорнод аймгийн Засаг даргын дэргэдэх Цагдаагийн газрын дарга, цагдаагийн дэд хурандаа

89. Цогжоогийн Ядамжав - Цагдаагийн ерөнхий газрын Улаанбаатар төмөр зам дахь Цагдаагийн хэлтсийн салааны дарга, цагдаагийн ахлах дэслэгч

МОНГОЛ УЛСЫН

ЕРӨНХИЙЛӨГЧ **Н.БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2001 оны 7 дугаар сарын 23-ны өдөр **Дугаар 22** **Улаанбаатар хот**

Элчин сайдыг томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5, Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг тус тус баримтлан ЗАРЛИГ болгох нь:

Монгол Улсаас Тайландын Вант Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайдаар Лувсандоржийн Даваагивийг тохоон томилсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ **Н.БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2001 оны 7 дугаар сарын 27-ны өдөр **Дугаар 24** **Улаанбаатар хот**

В.Н.Щетининг "Алтан гадас" одонгоор шагнах тухай

Монгол Улс, ОХУ-ын найрсаг харилцаа, хамтын ажиллагаат хөгжүүлэн бэхжүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Монгол Улс, ОХУ-ын улсын хилийг шалгах хамтарсан комиссын Оросын хэсгийн дарга Валерий Николаевич Щетининг "Алтан гадас" одонгоор шагнасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ **Н.БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2001 оны 7 дугаар сарын 27-ны өдөр **Дугаар 25** **Улаанбаатар хот**

Г.Залмыг "Алтан гадас" одонгоор шагнах тухай

Монгол Улс, Нидерландын Вант Улсын харилцаа, эдийн засгийн хамтын ажиллагаат хөгжүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Нидерландын Вант Улсын Сангийн сайд Г.Залмыг "Алтан гадас" одонгоор шагнасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ **Н.БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 6 дугаар сарын 6-ны өдөр **Дугаар 123** **Улаанбаатар хот**

Улсын хяналтын дүрэм батлах тухай

Хүнсний тухай хуулийн 5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 9 дэх заалт, Ургамал хамгаллын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 3 дахь заалт, Таримал ургамлын үр, сортын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Хүнсний аюулгүй байдал, хөдөө аж ахуйн улсын хяналтын дүрэм"-ийг хавсралт ёсоор батлсугай.

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Улсын хяналтын дүрэм батлах тухай" Засгийн газрын 1995 оны 12 дугаар сарын 6-ны өдрийн 227 дугаар тогтоол, "Улсын хяналтын дүрэм батлах тухай" Засгийн газрын 1996 оны 5 дугаар сарын 3-ны өдрийн 109 дүгээр тогтоол, "Дүрэм батлах тухай" Засгийн газрын 1999 оны 9 дүгээр сарын 15-ны өдрийн 150 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН САЙД **Д.НАСАНЖАРГАЛ**

Засгийн газрын 2001 оны 123 дугаар тогтоолын хавсралт

ХҮНСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ХӨДӨӨ АЖ АХУЙН ҮЛСЫН ХЯНАЛТЫН ДҮРЭМ

Нэгдүгээр бүлэг

Нийтлэг зүйл

1. Энэ дүрмийн зорилго нь холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтэд мэргэжлийн хяналт тавих замаар малын удмын сан, эрүүл мэнд, ургамал, таримлын үр, сортыг хамгаалах, мал, амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний ариун цэвэр, хүнсний аюулгүй байдлыг хангуулж, улс орны нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжилд дэмжлэг үзүүлэхэд оршино.

2. Монгол Улсын нутаг дэвсгэрт хүнсний аюулгүй байдал, хөдөө аж ахуйн улсын хяналтыг Засгийн газрын тохируулагч агентлаг-Хүнсний аюулгүй байдал, хөдөө аж ахуйн улсын хяналтын алба, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын дэргэдэх мэргэжлийн хяналтын алба, улсын еренхий, ахлах байцаагч (цаашид "улсын байцаагч" гэх) нар хэрэгжүүлнэ.

3. Хүнсний аюулгүй байдал, хөдөө аж ахуйн хяналтын улсын байцаагч нь хүнс, хөдөө аж ахуйн салбарын мэргэжил эзэмшсэн, хянан шалгах ажлын дадлага туршлагатай байх бөгөөд хүнсний аюулгүй байдал, хөдөө аж ахуйн чиглэлийн хууль тогтоомж, тэдгээртэй нийцүүлэн эрх бүхий байгууллагаас гаргасан шийдвэрийг үйл ажиллагаандаа удирдлага болгон ажиллана.

4. Улсын байцаагч нь үнэмлэх, хувийн дугаар бүхий тэмдэг, лац, албан шаардлага, дүгнэлт, акт, торгуулийн хуудас хэрэглэнэ.

5. Хилийн хяналтын албанд ажиллах улсын байцаагч дүрэмт хувцас, бусад газарт ажиллах улсын байцаагч ажлын хувцас хэрэглэнэ. Дүрэмт болон ажлын хувцасны загварыг Хүнс, хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн сайд батална.

6. Хүнсний аюулгүй байдал, хөдөө аж ахуйн улсын хяналтад мал аж ахуй, мал эмнэлэг, ургамал хамгаалал, хорио цээр, таримал ургамал, хүнсний салбарын үйлдвэрлэл, ажил, үйлчилгээний бүх хүрээ хамрагдана.

Хоёрдугаар бүлэг

Хүнсний аюулгүй байдал, хөдөө аж ахуйн улсын хяналтын чиглэл

7. Хүнсний аюулгүй байдал, хөдөө аж ахуйн улсын хяналт дараахь чиглэлээр явагдана:

а/Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай, Ургамал хамгаллын тухай, Таримал ургамлын үр, сортын тухай, Хүнсний тухай, Эмийн тухай хууль болон бусад хууль тогтоомж, эрх бүхий байгууллагаас гаргасан стандарт, дүрэм, журмын хэрэгжилт;

б/Монгол Улсаас гадаад орнуудтай хүнсний аюулгүй байдал, мал эмнэлэг, мал аж ахуй, ургамал хамгаалал, хорио цээр, таримал ургамлын үрийн чанарын шаардлагын талаар байгуулсан гэрээ, хэлэлцээрийн биелэлт;

в/мал аж ахуй, ургамлын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний зах болон хүнсний бөөний худалдааны төв, нийтийн хоол, худалдааны газрын үйлчилгээнд тавигдах хүнсний аюулгүй байдлын шаардлагын хэрэгжилт.

8. Мал эмнэлгийн хяналтын улсын байцаагч нь энэ дүрмийн 7 дугаар заалтын "а", "б", "в"-д зааснаас гадна иргэн, албан тушаалтан, хуулийн этгээдийн хууль тогтоомжоор хүлээсэн дор дурдсан үүргийн биелэлтэд хяналт тавина:

а/мал, амьтанд халдварт өвчний шинж тэмдэг илэрсэн, гэнэт олноор үхсэн тохиолдолд орон нутгийн мал эмнэлгийн үйлчилгээний нэгж, удирдлагад 12 цагийн дотор мэдэгдэж холбогдох арга хэмжээ авах;

б/мал эмнэлгийн хорио цээр, хязгаарлалт тогтоох, мал, амьтны өвчинтэй тэмцэх, малын сэг зэмийг устгах талаар Засаг даргын гаргасан шийдвэр, түүний биелэлтийг хангах арга хэмжээг зохион байгуулах;

в/халдварт өвчин гарсан нутагт тогтоосон мал эмнэлгийн хорио цээрийн дэглэмийг биелүүлэх, өвчилсөн мал, амьтныг албадан устгах;

г/өвчнийг оношлох, эмчлэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээнд мал, амьтныг тогтоосон хугацаанд нь бүрэн хамруулах;

д/мал, амьтныг арчлах, маллах, тэжээх, үржүүлэх үеийн эрүүл ахуй, бэлчээр, хашаа, буц, уст цэгийн орчны ариун цэврийн талаар гарсан дүрэм, журам, зааврыг мөрдөх;

е/мал, амьтнаас хүнд, хүнээс мал, амьтанд дамжин халдварладаг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх;

ж/мал, амьтны халдварт өвчин улсын хилээр нэвтрэхээс сэргийлэх, хил орчмын нутгийн мал, амьтны шилжилт хөдөлгөөний зохицуулалт;

з/улсын хилээр нэвтрүүлэх мал, амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн, малын тэжээлд мал эмнэлэг, ариун цэврийн үзлэг, шинжилгээ хийлгэж, баталгаажуулах;

и/мал, амьтан болон тэдгээрийн мах, сүү, өндөг, үр, хөвөрөл үр, түүхий эд, тэжээл бэлтгэх, тээвэрлэх, хадгалах, боловсруулах, худалдаалахад мал эмнэлэг, ариун цэвэр, хорио цээрийн талаархи дүрэм, жүрмыг сахих;

к/мал, амьтан нядлах болон мал, амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн боловсруулах, хадгалах байгууламжийн зураг төсөл зохиох, барих, ашиглалтад оруулах мал эмнэлэг ариун цэврийн шаардлага, нөхцөлийг баримтлах;

л/мал, амьтанд зориулсан эм, биобэлдмэл, мал эмнэлгийн багаж, хэрэгслийг үйлдвэрлэх, хилээр нэвтрүүлэх, худалдах, хадгалах, тээвэрлэх, бүртгэхтэй холбоотой дүрэм, журам, заавар, стандартыг мөрдөх;

м/мал эмнэлэг, ариун цэврийн лабораториудын дээж хүлээн авах, шинжлэх, дүгнэлт гаргах, хариуг мэдээлэх;

н/ мал эмнэлгийн анхан шатны бүртгэл хөтлөх, мэдээ, судалгаа гаргах, мал, амьтны халдварт өвчин гарсан болон гарч болзошгүй нутаг дэвсгэрийн тухай Засаг дарга, дээд шатны байгууллагад мэдэгдэх;

о/улсын нөөцийн малын эм, биобэлдмэлийг хадгалах, нөхөн бүрдүүлэх, ашиглах, зарцуулах;

п/малын эмийн сангийн үйл ажиллагаанд өмчийн хэлбэр харгалзахгүйгээр хяналт шалгалт хийх.

9. Малын үржлийн хяналтын улсын байцаагч нь энэ дүрмийн 7 дугаар заалтын "а", "б", "в"-д зааснаас гадна иргэн, албан тушаалтан, хуулийн этгээдийн хууль тогтоомжоор хүлээсэн дор дурдсан үүргийн биелэлтэд хяналт тавина:

а/малын удмын сан хамгаалах, ашиг шим, үүлдэрлэг байдлыг сайжруулах;

б/гойд ашиг шимт малын үр, хөвөрөл үрийг малын генийн банкинд хадгалуулах, ашиглах, нөхөн сэлбэх, худалдах;

в/цөм сүрэг, гойд ашиг шимт малд таних тэмдэг, дугаар тавьж, үржлийн малын удмын болон үржил, ашиг шимийн бүртгэлийг хөтлөх;

г/гойд ашиг шимт болон цөм сүргийн мал хорогдсон, тэдгээрийг худалдах, арилжих, бэлэглэх зэргээр бусдад шилжүүлсэн бүртгэл;

д/сүрэг сэлбэх өсвөр хэзлтүүлэгчийг цөм сүргээс бойжуулж, орон нутгийн үйлчилгээний нэгжээр үзлэг, шинжилгээ хийлгэж, жишиг тэнцсэн эсэхийг магадласны дараа үржилд ашиглах, хэзлтүүлгийн нас гүйцсэн малыг нийлүүлэгт оруулах, эрүүл, баталгаажуулсан хэзлтүүлэгчийг үржилд ашиглах;

е/бэлчээрийн маллагаатай бог малыг жилд нэгээс илүү төллүүлэхгүй байх;

ж/цөм, сүргийн ашиг шимийн чиглэлийг өөрчлөх, үржлийн мал, түүний үр, хөвөрөл үрийг улсын хил нэвтрүүлэхдээ мал үржлийн улсын

хяналтын төв албанаас зөвшөөрөл авах;

з/цэвэр, эрлийз болон нутгийн шилмэл омгийн малын удмын санг хамгаалах, үржил ашиг шимт чанарыг бататган сайжруулах ажлыг тухайн шатны захиргааны байгууллагаас хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлэх;

и/сум, дүүргийн үйлчилгээний нэгж нь мал сүрэгт үзлэг, ангилалт хийх, цэм сүрэг, гойд ашиг шимт малд үржлийн бүртгэл хөтлөх, гэрчилгээжүүлэх, малын ашиг шимийн гарц, чанарыг сайжруулах чиглэлээр мэргэжлийн ажил, үйлчилгээ явуулах.

10. Ургамал хамгаалал, хорио цээрийн хяналтын улсын байцаагч энэ дүрмийн 7 дугаар заалтын "а", "б", "в"-д зааснаас гадна иргэн, албан тушаалтан, хуулийн этгээдийн хууль тогтоомжоор хүлээсэн дор дурдсан үүргийн биелэлтэд хяналт тавина:

а/иргэн, хуулийн этгээдийн эзэмшиж, ашиглаж байгаа эдэлбэр газар, зоорь, үтрэм, агуулахад үргамлын өвчин, хөнөөлт шавьж, мэрэгч амьтан, хог ургамал илэрсэн тохиолдолд холбогдох байгууллагад мэдэгдэж, тархахаас сэргийлсэн эсэх;

б/Засаг дарга ургамлын онц аюулт өвчин, хөнөөлт шавьж, мэрэгч амьтан, хог ургамал илэрвэл хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад мэдээлэх, ургамлын хорио цээр, хязгаарлалт тогтоох, ургамал хамгаалал, хорио цээрийн арга хэмжээг зохион байгуулж хэрэгжүүлэх;

в/улсын хилээр нэвтрүүлэх бүх төрлийн ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн, хөрс, хүлэр, ургамал хамгаалах бодис, хөрстэй ургамал, мод, модон материал, ургамлын гаралтай зүйлсээр хийсэн сав, баглаа боодолд ургамал хамгаалал, хорио цээрийн үзлэг хийх, баталгаажуулах;

г/бүх төрлийн ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн, үрийн болон хүнсний будаа, малын өвс, тэжээл, таримлын суулгац, мод, модон материалын хадгалалт, тээвэрлэлт, боловсруулалт, худалдаалалтын үеийн ариун цэвэр, хорио цээрийн дэглэмийн хэрэгжилт;

д/ургамал, үр, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн, ургамал хамгаалах бодис, малын тэжээл, суулгац зэргийг улсын хилээр нэвтрүүлэхэд зөвшөөрөл авах;

е/ургамал хамгаалах бодис, бордоо улсын хилээр нэвтрүүлэх, үйлдвэрлэх, худалдаалахад баримтлах дүрэм, журам, технологи, стандарт, зааврыг мөрдөх;

ж/ургамал хамгаалалын арга хэмжээний технологи, стандартыг мөрдөх;

з/ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн боловсруулах, хадгалах, худалдах газрын барилга байгууламжийн зураг төсөл зохиох, барих, ашиглалтад оруулахад мөрдөгдөх ургамал хамгаалал, хорио цээрийн шаардлага, нөхцөлийг баримтлах;

и/ургамлын хорио цээрийн лабораториудын шинжилгээ, дүгнэлт гаргах, хариуг мэдээлэх;

к/улсын нөөцийн ургамлын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг хадгалах, ашиглах, нөхөн бүрдүүлэх, зарцуулах;

л/бөөний худалдааны төв, хүнсний захуудын үйл ажиллагаанд тавигдах ургамлын хорио цээрийн дэглэмийн мөрдөлт.

11. Таримал ургамлын үр, сортын чанарын хяналтын улсын байцаагч энэ дүрмийн 7 дугаар заалтын "а", "б", "в"-д зааснаас гадна иргэн, албан тушаалтан, хуулийн этгээдийн хууль тогтоомжоор хүлээсэн дор дурдсан үүргийн биелэлтэд хяналт тавина:

а/хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын захиалга, гэрээгээр торгон үр үржүүлэх;

б/үрийн чанарын улсын стандарт хангасан, гарал үүсэл, үйлдвэрлэсэн технологи нь тодорхой, баталгаат сортын болон эрлийз үр борлуулах, бусдад шилжүүлэх, сорт солих, шинэчлэх;

в/таримал ургамлын удмын санг хадгалах, хамгаалах, зохион бүтээсэн сортыг

таримал ургамлын удмын сангийн хадгаламжид бүртгүүлж, хадгалуулах;

г/өөрийн үйлдвэрлэсэн үрийг үр, хорио цээрийн хяналтад хамруулах;

д/үрийн чанарын улсын стандарт хангасан үрийг улсын хилээр нэвтрүүлэх;

е/үрийн тариалангийн талбайд сортын хянан баталгаа хийлгэх;

ж/улсын үрийн нөөцөд чанарын стандарт хангасан үр бэлтгэх, нийлүүлэх;

з/тарих үрийн дээжид чанарын шинжилгээ хийх, баталгаажуулах, хариуг мэдээлэх, тайлагнах;

и/торгон болон сортын үр үйлдвэрлэл явуулахад тохиромжтой талбайг тодорхойлох, үр үржүүлгийн үйл ажиллагаанд шинжлэх ухааны ололт нэвтрүүлэхэд Засаг дарга дэмжлэг, туслалцаа үзүүлэх.

12. Хүнсний үйлдвэрлэлийн хяналтын улсын байцаагч энэ дүрмийн 7 дугаар заалтын "а", "б", "в"-д зааснаас гадна иргэн, албан тушаалтан, хуулийн этгээд хууль тогтоомжоор хүлээсэн дор дурдсан үүргийн биелэлтэд хяналт тавина:

а/хүнсний үйлдвэрлэлийг технологи, стандартын шаардлагын дагуу эрхлэх, бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлыг хангах;

б/хүнсний үйлдвэрлэл эрхлэхийн өмнө болон үйлдвэрлэлийн явцад технологи, стандарт, ариун цэврийн шаардлага хангасан тухай мэргэжлийн хяналтын эрх бүхий байгууллагын дүгнэлт гаргуулах;

в/мал, амьтны болон ургамлын гаралтай хүнсний түүхий эдийг бэлтгэхдээ тухайн нутаг дэвсгэрийн мал эмнэлэг, ургамлын хорио цээрийн эрх бүхий байгууллагаар магадлан шинжилгээ хийлгүүлэх;

г/шинээр үйлдвэрлэж байгаа хүнсний бүтээгдэхүүн нь стандарт, ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлага хангасан талаар мэргэжлийн хяналтын байгууллагаар дүгнэлт гаргуулсны дараа худалдах;

д/хүнсний бүтээгдэхүүнийг чанар, ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлагын дагуу савлах, шошголох, түүнд барааны тэмдэг, оноосон нэр, улсын стандарт, үйлдвэрлэсэн газар, огноо, тэжээллэг чанар, найрлага, хэрэглэх арга, хадгалах хугацаа, анхааруулгыг заасан байх;

е/хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэх, хадгалах, тээвэрлэх зориулалттай машин, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, сав, баглаа боодол, ариутгал, цэвэрлэгээний бодис нь чанар, аюулгүй байдлын шаардлага хангасан байх;

ж/хүнсний үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалттай барилга, байгууламжийг шинээр барих, өргөтгөх, шинэчлэх, тоног төхөөрөмжийг шинээр суурилуулах ажлыг хяналтын холбогдох байгууллагуудтай зөвшилцөн зураг төслийн дагуу гүйцэтгэх;

з/хүнсний үйлдвэрлэлд ашиглах өсгөвөр, хүнсний нэмэлт, эм, даавар болон шавьж, мэрэгчийн устгалын хор, цацраг идэвхит бодист мэргэжлийн хяналтын зохих байгууллагаар дүгнэлт гаргуулах;

и/согтууруулах ундааны үйлдвэрлэлийг эрх бүхий байгууллагын зөвшөөрөлтэйгээр зориулалтын төхөөрөмжөөр технологийн горимын шаардлага хангасан нөхцөлд хүнсэнд тохирох түүхий эд ашиглан явуулах, үйлдвэрлэл эрхлэх зөвшөөрлийг бусдад шилжүүлсэн, үйлдвэрлэлийн байршлыг өөрчилсөн зэрэг зөрчилтэй эсэх;

к/улсын нөөцийн хүнсний бүтээгдэхүүнийг хадгалах, ашиглах, нөхөн бүрдүүлэх, зарцуулах.

Гуравдугаар бүлэг

Хүнсний аюулгүй байдал, хөдөө аж ахуйн хяналтын улсын байцаагчийн эрх, үүрэг

13. Улсын байцаагч нь Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 9 дэх хэсэгт заасан нийтлэг бүрэн эрхээс гадна дор дурдсан эрх эдэлнэ:

а/Монгол Улсын нутаг дэвсгэрт мал, амьтны гоц халдварт болон ургамлын хорио цээртэй өвчин, хөнөөлт шавьж, мэрэгч амьтад, хог ургамал нэвтэрч, тархахаас урьдчилан сэргийлж, болзошгүй нөхцөл бий болсон тохиолдолд хилийн боомт болон аймаг, нийслэл, сум, дүүрэгт тэзэврийн хэрэгсэл, иргэдийн зорчих хөдөлгөөнийг түр хугацаагаар хориглох тухай саналыг төрийн захиргааны байгууллагад тавьж шийдвэрлүүлэх;

б/хорио цээр тогтоосон нутаг дэвсгэрээс зайлшгүй шаардлагаар гарах бол ариутгал, халдваргүйжүүлэлт хийлгэж, зөвшөөрөл олгох;

в/шалгалтаар илэрсэн зөрчил нь гэмт хэргийн шинжтэй бол холбогдох эрх бүхий байгууллагад шилжүүлэн шийдвэрлүүлэх;

г/хүн, мал, амьтан, ургамлын эрүүл мэндэд хортой нөлөө үзүүлэх хими, биологийн бодис, бэлдмэл, багаж, тоног хэрэгсэл, техникийг зөвшөөрөлгүйгээр хил нэвтрүүлсэн, ашигласан бол хууль тогтоомжийн дагуу шийдвэрлүүлэх;

д/үр ариутгалын технологи, зохион байгуулалтыг хянах, ариутгасан үрийг тариалаатаас өөр зориулалтаар ашиглахыг хориглох;

е/мал, амьтан, техникээр үр, суулгацын материалыг гэмтээсэн, бохирдуулсан, чанарыг алдагдуулсан бол гэм буруутай этгээдээр хохирлыг нөхөн төлүүлэх;

ж/тарих, борлуулах, хадгалах, шилжүүлэх үрэнд хийсэн чанарын шинжилгээ, баталгаажуулалт, сорт сорилт, туршилтын үр дүнг үнэлж дүгнэх;

з/үржлийн мал, амьтан, тэдгээрийн үр, хөврөл үр, малын эм, мал эмнэлгийн хэрэгсэл, ургамал хамгаалахад ашиглах бодисыг улсын хилээр нэвтрүүлэхэд зөвшөөрөл олгох;

и/баталгаажуулаагүй хэзлтүүлэгч, үр, хөврөл үр, таримал ургамлын үр, сортыг үйлдвэрлэл, үйлчилгээнд ашиглах, үүлдэрлэг байдал, таримал ургамлын сортын шинж чанарыг алдагдуулахад чиглэсэн үйл ажиллагааг түдгэлзүүлэх, таслан зогсоох;

к/шинээр бий болгосон үүлдэр, үүлдрийн болон үржлийн хэсэг, омог, хэвшлийн малыг хянан баталгаажуулах асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу төрийн захиргааны төв байгууллагад тавьж шийдвэрлүүлэх;

л/илгээмжээр нэвтрэх бүх төрлийн ургамал, үр, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн, тарьц, суулгац, хөрс, хөрстэй ургамал, мод, модон материалд үзлэг хийж, ашиглах зөвшөөрөл олгох;

м/хүний амь нас, эрүүл мэндэд шууд буюу шууд бусаар хохирол учруулж болзошгүй чанарын шаардлага хангахгүй, технологийн горим зөрчсөн бүтээгдэхүүн нийлүүлсэн, худалдсан, үйлдвэрлэсэн бол үйл ажиллагаат түр зогсоох, эсхүл бүрмөсөн хаж бараа, бүтээгдэхүүнийг улсын орлого болгох, бусад зориулалтаар ашиглах, устгах асуудлыг улсын ерөнхий байцаагчид тавьж шийдвэрлүүлэх.

14. Улсын байцаагч нь дорхи үүрэг хүлээнэ:

а/энэ дүрмийн 7, 8, 9, 10, 11, 12-т заасан чиглэлийн дагуу Хүнсний тухай, Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай, Ургамал хамгаллын тухай, Таримал ургамлын үр, сортын тухай, Эмийн тухай хууль болон түүнтэй нийцүүлэн гаргасан дүрэм, журам, заавар, стандарт зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, илэрсэн зөрчлийг арилгуулах арга хэмжээг шуурхай авах, хяналт шалгалтын үр дүнг мэдээлэх, сурталчлах;

б/хяналт шалгалтын чиглэлээр судалгаа, дүгнэлт хийж, зөрчил, дутагдлын шалтгаан нөхцөлийг тодорхойлон тэдгээрээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний чиглэл, баримтлах бодлогын төслийг боловсруулж шийдвэрлүүлэх, хэрэгжилтийг зохион байгуулж, хяналт тавих;

в/хяналт шалгалтын явцад илэрсэн зөрчил, дутагдлыг газар дээр нь таслан зогсоох, түүний шалтгаан нөхцөлийг судалж, арилгах талаар иргэн, албан тушаалтан, хуулийн этгээдэд үүрэг даалгавар өгөх, түүний биелэлтэд хяналт тавих;

г/хууль тогтоомжийг хэрэгжүүлэх талаар нутгийн захиргааны байгууллагаас зохиож байгаа ажлын явц, үр дүнд хяналт шалгалт хийж, үнэлэлт дүгнэлт өгөх, мэрэгжил арга зүйн зөвлөлгөөгөөр хангах;

д/холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн хийсэн шалгалт, гаргасан дүгнэлт, албан шаардлага, тоо баримтын үнэн зөвийг бүрэн хариуцах, шаардлагатай мэдээ тайлан, судалгааг зохих хугацаанд нь нэгтгэн гаргах;

е/илрүүлсэн зөрчилд тавьсан торгуулийг хуулийн хугацаанд нь багтаан улсын төсөвт оруулуулах;

ж/мал, амьтан, ургамлын гоц халдварт өвчин, хөнөөлт шавьж, хог ургамал, мэрэгч амьтад илэрвэл хязгаарлалт тогтоох.

Дөрөвдүгээр бүлэг

Бусад зүйл

15. Улсын байцаагчийн албан шаардлага, шийдвэрийг иргэн, албан тушаалтан, хуулийн этгээд хугацаанд нь биелүүлж, хариуг албан ёсоор мэдэгдэх үүрэгтэй.

16. Шалгуулсан иргэн, албан тушаалтан, хуулийн этгээд хяналт шалгалтын явцад хууль тогтоомж зөрчигдсөн, гаргасан шийдвэр үндэслэлгүй гэж үзвэл гомдлоо хяналт шалгалт хийсэн улсын байцаагчийн дээд шатны улсын байцаагчид гаргана. Гомдлыг хүлээн авсан улсын байцаагч нь 30 хоногийн дотор хянаж шийдвэрлэх бөгөөд энэ шийдвэрийг эс зөвшөөрвөл гомдлоо шүүхэд гаргах эрхтэй.

17. Улсын байцаагч хууль тогтоомж, энэ дүрмээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд Төрийн хяналт шалгалтын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээнэ.

18. Улсын байцаагч нь хууль тогтоомж, стандарт зөрчсөн, илэрсэн зөрчлийг арилгуулах талаар өгсөн албан шаардлагыг биелүүлээгүй гэм буруутай этгээдэд Монгол Улсын Төрийн хяналт шалгалтын тухай, Захиргааны хариуцлагын тухай, Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай, Хүнсний тухай, Эмийн тухай, Ургамал хамгаалллын тухай, Таримал ургамлын үр, сортын тухай болон холбогдох бусад хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 6 дугаар сарын 6-ны өдөр **Дугаар 124** **Улаанбаатар хот**

Дүрэм батлах тухай

Дипломат албаны тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Дипломат ажилтны сахилгын тусгай дүрэм"-ийг хавсралт ёсоор батлуулсугай.

2. Дүрмийг хэрэгжүүлж, биелэлтэд нь хяналт тавьж ажиллахыг Гадаад хэргийн сайд Л.Эрдэнэчулуунд даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

ГАДААД ХЭРГИЙН САЙД **Л.ЭРДЭНЭЧУЛУУН**

Засгийн газрын 2001 оны 124 дүгээр тогтоолын хавсралт

ДИПЛОМАТ АЖИЛТНЫ САХИЛГЫН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Дипломат ажилтанд сахилгын шийтгэл ногдуулахад Төрийн албаны тухай, Дипломат албаны тухай хууль болон энэхүү дүрмийг баримтална.

Хоёр. Дипломат ажилтны сахилгын шаардлага

2. Дипломат ажилтан нь Дипломат харилцааны тухай Венийн конвенцийг үйл ажиллагаандаа удирдлага болгон мөрдөхийн зэрэгцээ Төрийн албаны тухай хуулиар тогтоосон төрийн албан хаагчийн нийтлэг үүрэг, Дипломат албаны тухай хууль, хөделмөрийн дотоод журмаар хүлээсэн үүргээс гадна дараахь шаардлагыг сахин биелүүлнэ:

1/Дипломат ажилтны алдар хүнд, нэр төрийг өндөрт өргөн, өргөсөн тангарагтаа үнэнч байж, улс эх орныхоо эрх ашгийг дээдлэн төр, засгийн албан ёсны байр суурьт нийцэн үйл ажиллагаа явуулах;

2/Улс төрийн талаар төвийг сахиж, үзэл бодлоо илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, шашин шүтэх, эс шүтэх эрхээ эдлэхдээ албан тушаалдаа хүндэтгэлтэй хандан төрийн албан хаагчийн ёс зүйд харш үйлдэл, эс үйлдэл гаргахгүй байх;

3/Албан үүргээ биелүүлэхдээ хувийн эрх ашгийг улсын болон албан ажлын эрх ашгаас дээгүүр тавихгүй, амин хувийн эрх ашигтаа хөтлөгдөхгүй, хууль бус болон санхүүгийн ашиг сонирхлын нөлөө, авилгалд автахгүй байх;

4/Албан тушаалын давуутай тал, боломжийг хувийн зорилгоор ашиглах, аливаа этгээдийн өмнө ямар нэгэн үүрэг хүлээх байдалд өөрийгөө оруулж болзошгүй бэлэг, шагнал, урамшуулал авахыг цээрлэх;

5/Үндсэн ажил, албан үүргээсээ гадуур хуулиар зөвшөөрснөөс бусад ажил үүрэг гүйцэтгэхгүй байх;

6/Захирах, захирагдах ёсыг чанд сахих;

7/Удирдлагын санаа бодолд нийцэх эсэхийг үл харгалзан, тэдний гаргах шийдвэрээс үүдэн гарч болзошгүй серөг тал, үр дагаврыг хэлж анхааруулж байх;

8/Улсын нууцыг хадгалах, албан ёсны аливаа мэдээлэл болон албан үүрэгтэй нь холбогдож илэрхий болсон, эсвэл өөрт нь итгэмжлэн мэдэгдсэн төрийн болон байгууллага, хувь хүний нууцыг чанд хадгалж, албан ёсны мэдээллийг эрх бүхий албан тушаалтны зөвшөөрөлгүйгээр тараахгүй байх;

9/Ажил төрөлд холбогдолтой мэдээллийг нуун дарагдуулах буюу удирдлагаас шийдвэр гаргахад аливаа байдлаар саад учруулж, цаг алдуулах, байгууллагаас явуулж буй бодлогыг гуйвуулахыг цээрлэх;

10/Иргэд, байгууллагад үйлчилгээ үзүүлэхдээ танил тал харахгүй, тэдний ялгаварлахгүй хандан холбогдох хууль тогтоомжийг мөрдөж, хүнд суртал гаргах, чирэгдүүлэхийг цээрлэх, төр, олон түмний холбоог бэхжүүлж ажиллах;

11/Байгууллагын эд хөрөнгө, албан хэрэгцээний мэдээ, материал, мэдээллийн санг албаны бус зориулалтаар ашиглахыг цээрлэх;

12/Хүлээн авалт болон албан ёсны бусад арга хэмжээнд оролцох үедээ согтууруулах ундаанг хэтрүүлэн хэрэглэхийг цээрлэх;

13/Хилийн чанад дахь Дипломат төлөөлөгчийн газарт ажиллах томилолтын хугацаа нь дуусан дипломат ажилтнууд дуудсан хугацаанд эх орондоо бүрмөсөн буцан ирж ажлаа тайлагнаж байх.

Гурав. Удирдах албан тушаал хашиж буй дипломат ажилтны үйл ажиллагаанд хориглох зүйлүүд

3. Удирдах албан тушаал хашиж буй дипломат ажилтны үйл ажиллагаанд дараахь зүйлүүдийг хориглоно. Үүнд:

1/Монгол Улс, гадаад орнуудын төрийн байгууллагын хооронд харилцан тохиролцсон албан томилолт, Гадаад хэргийн яамны эрх бүхий албан тушаалтны зөвшөөрөлгүйгээр гадаад, дотоодын аж ахуйн нэгж, байгууллага, хувь хүний зардлаар эх орондоо болон гадаадад зорчих;

2/Гадаадад томилолтоор ажиллахдаа Монгол Улсын төрийн байгууламж болон төрийн өндөр албан тушаалтнуудын эсрэг агуулга бүхий үг хэлэх, ярилцлага өгөх, ийм утгатай

материалыг хэвлэлд өгөх, бусдаас уг үйл ажиллагааг явуулахыг шаардах;

3/Нийтэд тараах болон мэдээлэх ёсгүй нууц мэдээллийг ашиглан хувийн зорилгоор гэрээ, хэлцэл хийх, бусад хэлбэрээр ашиглах;

4/Тогтоосон хэмжээ, журмаас гадуур бэлэг дурсгалын зүйлс авах, эрх бүхий албан тушаалтны эвшөөрөлгүйгээр аж ахуйн нэгж, иргэн, улс төрийн нам болон төрийн бус байгууллагаас аливаа ергөмжлөл, шагнал авах;

5/Албан тушаалын байдлаа ашиглан удирдлагадаа ажилладаг эсхүл үйл ажиллагаанд нь хяналт тавьдаг ажилтнаар албан үүрэгтэй нь холбоогүй ажил үүрэг гүйцэтгүүлэх, хууль бус шаардлага тавих, өөртөө буюу бусдад ашиг хонжоо олгох үйлдэл, эс үйлдэл хийлгэхээр шахалт үзүүлэх.

Дөрөв. Сахилгын шийтгэлногдуулах үндэслэл, шийтгэлийн хэлбэр

4. Төрийн албаны тухай хуулийн 15, Дипломат албаны тухай хуулийн 11 дүгээр зүйл, энэ дүрмээр тогтоосон хэм хэмжээг зөрчсөн дипломат ажилтны үйлдэл, эс үйлдэл нь түүнд сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно. Дипломат ажилтны гаргасан сахилгын зөрчил нь зохих журмын дагуу шалгагдаж, нотлогдсон байвал зохино.

5. Сахилгын зөрчил гаргасан дипломат ажилтанд энэ дүрмийн 4-т заасан үндэслэлээр дараахь сахилгын шийтгэлийн аль нэгийг ногдуулна. Үүнд:

а/сануулах;

б/албан тушаалын цалингийн хэмжээг 6 сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах;

в/Дипломат төлөөлөгчийн газарт ажиллаж буй дипломат ажилтныг хугацаанаас нь өмнө эгүүлэн татах;

г/дипломат албанаас халах.

6. Сахилгын зөрчилийг илрүүлснээс хойш 1 сар, зөрчил гаргаснаас хойш 6 сарын хугацаа өнгөрсөн бол сахилгын шийтгэл ногдуулж болохгүй.

7. Дипломат ажилтанд ногдуулах сахилгын шийтгэл нь түүний гэм буруу, зөрчлийн шинж чанар, үр дагаварт тохирсон байвал зохино. Шаардлагатай тохиолдолд дипломат ажилтны гаргасан сахилгын зөрчлийг Гадаад хэргийн яам, Дипломат төлөөлөгчийн газраас тусгай комисс томилон шалгаж болно.

8. Дипломат ажилтан түүнд сахилгын шийтгэл ногдуулсан өдрөөс хойш 1 жилийн дотор сахилгын шийтгэл хүлээгээгүй бол түүнийг сахилгын шийтгэлүйд тооцно.

9. Дипломат ажилтан сахилгын шийтгэлийг үндэслэлгүй ногдуулсан, эсхүл ногдуулсан шийтгэл гаргасан зөрчилд нь тохироогүй гэж үзвэл Гадаад хэргийн яамны дэргэдэх Төрийн захиргааны албаны салбар зөвлөлд гомдол гаргаж болно. Гомдлыг салбар зөвлөлийн хурлаар хэлэлцэнэ.

Тав. Бусад асуудал

10. Яамны Төрийн нарийн бичгийн дарга болон нэгжийн удирдлага, Дипломат төлөөлөгчийн газруудын тэргүүн нар энэхүү дүрэм, байгууллагын дотоод дэг журмыг чанд биелүүлэхийг бусад дипломат ажилтнуудаас шаардах, түүнийг биелүүлэх нөхцөлийг бүрдүүлэх, гүйцэтгэлд нь хяналт тавьж хангуулах үүрэгтэй.

11. Яамны нэгжийн удирдлага, Дипломат төлөөлөгчийн газруудын тэргүүн нар ажилдаа хариуцлагагүй хандаж сахилгын зөрчил гаргасан хүмүүст сахилгын шийтгэл ногдуулах эрхтэй.

12. Дипломат ажилтнууд гаргасан зөрчлийнхөө талаар тайлбар гаргах эрхтэй.

13. Хариуцсан нэгжийнхээ дотор сахилга, дэг журам хангах талаар үр дүнтэй арга хэмжээ аваагүй, сахилгын зөрчлийг нуун дарагдуулсан удирдах албан тушаалтанд энэ дүрэм, холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

14. Сахилгын шийтгэл ногдуулсан шийдвэрийг үндэслэн Төрийн захиргааны удирдлагын газар тухайн ажилтны хувийн хэрэгт нь тэмдэглэл хийнэ.

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Хаяг: «Төрийн мэдээлэл» эмхтгэлийн эвлэл

Улаанбаатар-12 ☎ 329612
Төрийн ордон Индекс 14003

Улсын Их Хурлын Тамгын газрын Хэвлэх хэсэгт хэвлэв.

☎ 329487



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 32 (219)

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ:

- *И.И.Кудрявцевыг "Найрамдал" медалиар шагнах тухай*

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ:

- *Үзэл бариятлал батлах тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар

Улаанбаатар хот
2001 он

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот 2001 оны наймдугаар сарын 18 №32 (219)

Гарчиг

Нэг. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

397. И.И.Кудрявцевыг "Найрамдал" медалиар шагнах тухай Дугаар 30 813

Хоёр. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

398. Үзэл баримтлал батлах тухай Дугаар 125 813

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2001 оны 8 дугаар сарын 6-ны өдөр **Дугаар 30** **Улаанбаатар хот**

И.И.Кудрявцевыг "Найрамдал" медалиар шагнах тухай

Монгол Улс, Оросын Холбооны Улсын найрсаг харилцаа, архивын салбарын хамтын ажиллагааг хөгжүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж ОХУ-ын Архивын удирдах газрын зөвлөх мэргэжилтэн Иван Иванович Кудрявцевыг "Найрамдал" медалиар шагнасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ **Н.БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 6 дугаар сарын 11-ний өдөр **Дугаар 125** **Улаанбаатар хот**

Үзэл баримтлал батлах тухай

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлберт тусгагдсан банк, санхүүгийн салбарын бүтцийн өөрчлөлтийг эрчимжүүлэх зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Санхүүгийн салбарын шинэчлэлийн дунд хугацааны үзэл баримтлалыг хавсралт ёсоор батлсугай.

2. Үзэл баримтлалыг хэрэгжүүлэх ажлыг жил бүрийн нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэл болон төрөөс мөнгөний бодлогын талаар баримтлах чиглэлд тусгаж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаанд даалгаж, Монгол банкны ерөнхийлөгч О.Чулуунбат, Үнэт цаасны хорооны дарга С.Гүндэнбал нарт зөвлөсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН САЙД **Ч.УЛААН**

Засгийн газрын 2001 оны 125 дугаар тогтоолын хавсралт

МОНГОЛ УЛСЫН САНХҮҮГИЙН САЛБАРЫН ШИНЭЧЛЭЛИЙН ДУНД ХУГАЦААНЫ ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

1.ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮГИЙН САЛБАРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

1.1.Эдийн засгийн макро түвшний тэнцвэр

90-ээд оны сүүлийн хагаст явагдсан санхүү, эдийн засгийн цочир хямралын эсрэг Монгол Улсын төрөөс бодлогын чанартай хариу арга хэмжээ авах явдал дутагдалтай, үүний улмаас макро эдийн засгийн бодлого сулрах хандлагад орсон бөгөөд үүний гол үр дагавар нь:

- Төсвийн зардал ихээр нэмэгдэж, төсвийн орлого бүрдүүлэх, санхүүжүүлэх чадавхийг ноцтой сулруулсан;
- Гадаад урсгал дансны томоохон алдагдал үүсгэж, төлбөрийн тэнцлийг ихээхэн хүндрүүлсэн;
- Экспортын гол нэрийн бүтээгдэхүүн болох зэс, алт, ноолуурын үнэ огцом буурсан нь төсвийн урсгал дансны тэнцэл (ялангуяа, хуваридааны тэнцэл)-д муугаар нөлөөлсөн;
- Төсвийн орлогод татварын үүрэг идэвхгүй байдалд орж, улмаар Засгийн газрын төсвийн санхүүжилтийг гадаад, дотоод өрийг нэмэгдүүлэх, банкны зээлээр нөхөх аргаар түр аргацаах болсон;
- Засгийн газрын зээллэг ихэссэнээр бизнесийн хүрээнд зээлийн эрэлтийг хөөрөгдөн эх үүсвэрийг нь хомсдуулж, зээлийн хүүг өндөрсгөхөд хүргэсэн;
- Үйлдвэрлэл, бизнесийн салбарт мөнгөний хэт хомсдол үүссэнээр ажилгүйдэл, ядуурлын түвшин буурахгүй, харин ч нэмэгдэхэд нөлөөлөв.

Төсвийн урсгал тэнцэл сүүлийн хоёр жилд үлэмж алдагдалтай болж, төсвийн нийт алдагдал 1998, 1999 онуудад ДНБ-ий 10 хувиас давсан байна. 2000 оны хүлээгдэж байгаа гүйцэтгэлээр төсвийн урсгал тэнцлийн алдагдал ДНБ-ий 1.1 хувьтай, төсвийн нийт алдагдал 8,9 хувьтай тэнцэх хэмжээнд байх төлөвтэй байна.

Нэлээд аймаг, сум, улсын үйлдвэрийн газар, аж ахуйн нэгжийн хооронд аж ахуйн өглөг, авлага, цалин, тэтгэвэр, тэтгэмжийн өглөгийн урьд онуудаас дамжсан өр ихээр хуримтлагджээ.

Гадаад хуваридааны тэнцэл хүндэрч, гадаад хуваридааны алдагдал 1998 онд 155 сая, 1999 онд 113 сая ам.доллар болж байсан ба 2000 оны хүлээгдэж байгаа гүйцэтгэлээр уг алдагдал 121 сая ам.доллар болохоор байна.

Монгол Улс 2004 он гэхэд дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтийг 6 хувьд хүргэж, нэг хүнд ногдох орлогыг 2001-2004 онд дунджаар 16 хувиар нэмэгдүүлэн, үүнээс олох үр ашгийг иргэдэд нийтлэг хүртээх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд бодлогын алхмыг дараахь дарааллаар дэрвөн хүрээнд хийх зорилт тавьж байна. Үүнд:

- Макро эдийн засгийн тогтворжилтын хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлэх;
- Бүтцийн шинэчлэлтийг явуулж, Засгийн газрын хуримтлалыг нэмэгдүүлэх, төсвийн хөрөнгө оруулалт, түүний дотор улсын үйлдвэрийн газрын хөрөнгө оруулалт төрийн өмч хувьчлалын замаар олсон хөрөнгийн үр ашгийг сайжруулах;
- Санхүүгийн салбар, хуваридааны горим, газар зээмшлийн болон өмчлөлийн эрхийн тогтолцоонд шинэчлэлт явуулах замаар хувийн хуримтлалыг өсгөх, үр хуримтлалыг нийт эдийн засагт хөрөнгө оруулалт болгон ашиглах;
- Дотоодын бүх нөөцийг эдийн засгийн идэвхитэй хөдөлгөөнд оруулах замаар зах зээлийн бүхий л бололцоот арга хэрэгслийг ашиглан санхүүгийн нэмэлт эх үүсвэр бий болгож, эдийн засгийн өсөлтийг хангах шаардлага тавигдаж байна.

Бодлогын чанартай дээрх арга хэмжээг хэрэгжүүлэхэд аль алинд нь хамаарал бүхий санхүүгийн секторын шинэчлэл нэн түгээмэл бөгөөд чухал нөлөөтэй юм.

Санхүүгийн салбарын шинэчлэлийн үзэл баримтлалд юуны өмнө:

- Төсөв, татварын бодлого;
- Мөнгөний бодлого, банкны тогтолцоо;
- Банк бус байгууллагын санхүүгийн зуучлалын үйл ажиллагааны цар хүрээг өргөтгөх;
- Хөрөнгийн зах зээл, үнэт цаасны арилжаа;
- Төрөл бүрийн даатгалын үйлчилгээг

сайжруулах зэрэг асуудлуудыг хамруулав.

1.2.Санхүүгийн салбарын өнөөгийн байдал

2000 оны эцсийн байдлаар манай улсад 12 банк, 10 банк бус санхүүгийн байгууллага, 90 гаруй хадгаламж зээлийн хоршоо, 40 гаруй үнэт цаасны компани, 13 арилжааны даатгалын байгууллага, 64 валютын арилжааны цэг, 400 гаруй барьцаалан зээлдэх цэг үйл ажиллагаа явуулж байна. Үүний зэрэгцээ Ядуурлыг бууруулах хөтөлбөрийн хүрээнд төрийн бус байгууллагууд жижиг зээл, санхүүгийн үйл ажиллагаа эрхэлж байна. Санхүүгийн салбар нь бүтцийн хувьд төвлөрлийн эрсдэлийг агуулсан, төрийн өмчийн оролцоо өндөр, үйлчилж буй хууль тогтоомжийн уялдаа холбоо хангалттүй, нягтлан бодох бүртгэл болон хяналтын үйл ажиллагаа нь олон улсын стандартад нийцэхгүй, үр дүнг нэгтгэн тооцох тогтолцоо бүрдээгүй зэрэг сул талтай байна.

1.2.1.Мөнгөний бодлого тодорхойлолт ба бодлогын хэрэгжилт

1991 онд баталсан Банкны тухай хууль, Монгол банкны дүрмийн заалтыг хэрэгжүүлэхтэй уялдуулан 1993 оноос эхлэн Төрийн мөнгөний бодлогыг боловсруулж жил бүр УИХ-аар хэлэлцүүлэн баталж, мөрдүүлж ирэв.

УИХ-аас 1993-1996 онд баталсан Төрийн мөнгөний бодлогын гол зорилго нь мөнгөний тоон онолд тулгуурлан төгрөгийн ханш уналт, инфляцийн хэт өсөлтийг хязгаарлах арга хэмжээ авахад чиглэсэн юм. Үүний дүнд төгрөгийн ханш уналт аажмаар саарч 1996 оны эхний хагас гэхэд 1 ам доллар 560 төгрөгтэй тэнцэж байв. 1993 оны дундаас эхлэн валютын чөлөөт ханшийн тогтолцоонд шилжсэн.

Төгрөгийн ханш уналтын харьцангуй тогтворжилт нь эдийн засгийн өсөлттэй төдийлэн уялдаагүй, харин мөнгөний бодлогын шууд аргад тулгуурласан юм. Мөнгөний энэхүү бодлого нь хэдийгээр төгрөг, чөлөөт валютын харьцаанд төгрөгийн тоон орцын хэт өсөлтийг бууруулж чадсан ч гэсэн аж үйлдвэр, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг тогтворжуулах, бизнес эрхлэхэд зээлийн таатай орчныг бүрдүүлэх, төсвийн орлогыг бүрдүүлэхэд татварын орлогоог сайжруулахад төдийлэн наалтай нөлөөлөөгүй юм.

1992 оны сүүлчээс эхлэн Төв банкнаас банк хоорондын эх үүсвэрийн урсгалыг банк бүрээр хянах, заавал байлгах нөөцийн норматив тогтоох, иргэдийн хадгаламжийг үнэгүйдлээс хамгаалах үүднээс хүүгийн төвлөрсөн зохицуулалт хийх, төв банкны үнэт цаасны гүйлгээ эрхлэх, чөлөөт валюттай харьцах төгрөгийн ханшийг чөлөөтэй болгох зэрэг арга хэмжээ авсан.

Мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, банкны зээлийн үйл ажиллагааны талаар хэд хэдэн хуулиуд батална нь мөнгөний бодлогыг төрөөс явуулах эрх зүйн шинэ орчин болж өгсөн.

Монгол банкнаас төгрөгийн эх үүсвэргүйгээр Засгийн газрын нэрийн өмнөөс хийсэн их хэмжээний төлбөрийн өр авлагыг зохицуулах, түүнийг Төв банк, Засгийн газрын хооронд зааглан хариуцах, банкны нягтлан бодох бүртгэлийг олон улсын стандартад нийцүүлэх эхний алхмуудыг хийсэн юм.

1993-1996 онд явуулсан мөнгөний бодлогод дараахь доголдол байв. Үүнд:

- Банкны үйл ажиллагаа, түүний дотор зээллэгийн асуудалд Засгийн газар хөндлөнгөөс хууль бус оролцох замаар ХАА-н байгууллагад Засгийн газрын шахалт, нөлөөллөөр багагүй хэмжээний зээл олгосон нь "чанаргүй зээл" болж системийн төлбөрийн чадварт муугаар нөлөөлсөн.

- Төв банкнаас арилжааны банкуудад зээл олгох ажиллагаа зарим талаар хавтгайрсан ба уг зээлийн хүүг хэт өндөр тогтоож, түүнээс орсон хүүг Монгол банкны орлого болгож байсан нь нэгд, арилжааны банкууд зээлийн үйл ажиллагаанд тавих хяналтыг сулруулж, зээлийн эх үүсвэрийг төв банкнаас бэлэнчлэн авах; хоёрт, төв банкинд төлөхөөр амласан зээл, хүүг зарим банк төлөх боломжгүйд хүрч, улмаар дампуурах үндэс суурь тавигдахад ямар нэг хэмжээгээр нөлөөлсөн байна.

- Төв банкнаас арилжааны банкуудын үйл ажиллагааг үнэлэх шалгуур үзүүлэлт, хяналтын тогтолцоо боловсронгуй бус байсан учраас Хоршоо, Сэлэнгэ зэрэг банк 2-3 жил ажиллаад дампуурч эхэлсэн. Нөгөө талаар банкуудын удирдлагын чадвар сул, үйл ажиллагааны болон бусад эрсдэлээ зөв тодорхойлж чадаагүй нь дампуурахад нөлөөлсөн. Мөн Төв банкнаас зарим үйлдвэрлэлийн компани, аж ахуйд шууд зээлжүүлэлт хийсэн батална гаргасан, зарим арилжааны банкийг байгуулахад төв банкны хяналт тодорхой бус байсан зэрэг нь зарим серег үр дүн бий болгосон.

1997-2000 онд явуулсан төрийн мөнгөний бодлогын гол асуудал нь:

- Мөнгөний бодлогод төв банкны хяналтын шууд аргаас шууд бус аргад шилжих;

- Төв банкны үнэт цаас, Засгийн газрын

бондын ажиллагааг өргөжүүлэх замаар мөнгийг гүйлгээнд гаргах хэмжээг аль болох хязгаарлах;

· Төв банкнаас арилжааны банкинд олгох зээл, дахин зээлжүүлэлтийг багасгах;

· Арилжааны банкуудын үйл ажиллагааны шалгуурыг олон улсын стандартад бүрэн нийцүүлэх;

· Төлбөрийн чадваргүй болсон банкуудын эрх хүлээн авах эрх зүйн орчныг бүрдүүлж хэрэгжүүлэхэд чиглэж зарим үр дүнд хүрэв.

Сүүлийн 10 жилд төрийн мөнгөний бодлогын хүрээнд дампуурсан банкуудыг албадан татан буулгах, банкуудыг дахин хөрөнгөжүүлэх, чанаргүй активыг Засгийн газрын үнэт цаасаар солих, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, банкуудын удирдлага хяналтын аргыг дээшлүүлэх арга хэмжээнүүдийг авч, энэ чиглэлээр нийт 70 гаруй тэрбум төгрөгийн хөрөнгө зарцуулжээ. Үүний дүнд одоогийн байдлаар нийт банкны өөрийн хөрөнгийн хүрэлцээний нэгдсэн үзүүлэлт олон улсын жишгээс 2,5 дахин, төлбөр түргэн гүйцэтгэх чадварын үзүүлэлт байвал зохих хувь хэмжээнээс 3 дахин өндөр болсон байна. Гэхдээ банкны салбарын хямралаас шалтгаалж банкинд итгэх итгэл алдарсан, түүс салбарын эрх зүйн орчин нь банкууд үр ашигтай, тогтвортой ажиллах бололцоог бүрдүүлээгүй байна.

Мөн мөнгөний урсгалыг бодит эдийн засаг, үйлдвэрлэл, бизнес дэх мөнгөний эргэлттэй уялдуулах, төгрөгийн ханшийн харьцангуй тогтворжих хандлагыг хадгалах, арилжааны банкуудын төлбөрийн чадвар, үйл ажиллагаанд төрийн хяналтын механизмыг ашиглах, төсвийн зээлжүүлэлтэд оновчтой хязгаарлалт тавих замаар улсын санхүүгийн тэнцвэрийг сайжруулах, дотоод зах зээлд үндэсний мөнгөн тэмдэгтийн үүргийг бэхжүүлэхэд бүрэн чиглэж чадсангүй.

Мөнгөний бодлогын энэ доголдолтой тал нь үйлдвэрлэл, бизнесийн хүрээг шаардлагатай мөнгөөр хангах биш харин гол төлөв арилжааны банк дахь мөнгөний нөөцийг төв банкинд төвлөрүүлэх, мөн нөөцийг Засгийн газар зээлж, төсвийн урсгал зардлыг нөхөх зохицгий байдлыг бий болгов. Үүний улмаас бизнест шаардагдах мөнгөний эргэлтийг зохиомлоор ихэсгэж, зээлийн хүүг харьцангуй өндөр түвшинд хадгалах, банкууд арилжаа, бизнест мөнгө оруулахаасаа төв банк, Засгийн газрын үнэт цаас, бондын хүүгээр хялбар аргаар ашиг олох сонирхлыг төрүүлсэн юм.

Төв банкны бие даасан ажиллагаа суларч Засгийн газрыг аялдан дагалдах, зарим тохиолдолд төсвийн зардлыг санхүүжүүлэгчийн байр суурinaас хандах явдал гарсан байна. Эдийн засгийн нэг тал болох үйлдвэрлэл, бизнесийн хүрээнд нийлүүлэх мөнгө ийнхүү хязгаарлагдсан атал "Үйлдвэрлэлийн бус хүрээнд нийлүүлэх бүтээмжгүй" мөнгөний масс нэмэгдсэн нь 1997-1998 онуудад төгрөгийн ханш барагцаалсаар хөөрөгдсөн нөлөөлжээ.

1995-2000 онуудад УИХ-аас батлагдсан төрийн мөнгөний бодлогод тусгагдсан дараах томоохон зорилт биелэгдээгүй. Үүнд:

· Төлбөрийн тэнцлийг сайжруулах, улсын төсвийн бодлоготой мөнгөний бодлогыг нягт уялдуулах (1995);

· Иргэдийн мөнгөн хадгаламжийг эрсдэлээс хамгаалах оновчтой тогтолцоог бий болгох (1997);

· Засгийн газарт олгосон зээлийг хуулиар тогтоосон хэмжээнд хүртэл бууруулах арга хэмжээ авах (1998);

· Монгол банкнаас аж ахуйн нэгж, байгууллагад олгосон зээл, гаргасан баталгаа, эх үүсвэрүйгээр гүйцэтгэсэн гадаад төлбөрийн авлагыг барагдуулах, өрийг худалдах үйл ажиллагааны хяналт тогтоож хэрэгжүүлэх (1998, 1999);

· Банк хоорондын төлбөр тооцооны эрсдэлийг бууруулахад чиглэсэн техник зохион байгуулалтын арга хэмжээ авч, бэлэн бус төлбөр тооцооны сүлжээ, дэвшилтэт технологи нэвтрүүлэх (1999);

· Төв банк, Засгийн газар хоёрын хооронд үүссэн өр авлагын асуудлыг нэг мөр болгож шийдвэрлэх /1997-1999/

· Засгийн газрын бондыг нийтэд чөлөөтэй арилжаалах нөхцөлийг бүрдүүлэх, түүнийг хэрэгжүүлэх (2000) зэрэг томоохон зорилтууд бүрэн хэрэгжсэнгүй.

1.2.2. Банкуудын үндсэн үйл ажиллагаа, санхүү төлбөрийн чадвар

Улсын хэмжээнд Монгол банкнаас зөвшөөрөл авч үйл ажиллагаа эрхэлж буй 12 банк, 10 банк бус санхүүгийн байгууллага өөрийн харьяа 430 гаруй салбар, нэгжээрээ дамжуулан таван зуу гаруй мянган харилцагчдад зээл, мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо болон банкны бусад үйлчилгээг үзүүлж байна.

Банк, санхүүгийн системийн үндсэн үзүүлэлтүүдийг сүүлийн 4 жилээр тооцож,

харьцуулалт хийвэл дараахь байдалтай байна. Үүнд:

(хувь, тэрбум төгрөг)

	1997/XII	1998/XII	1999/XII	2000/XII
Мөнгөний нийлүүлэлт (М2)	170,0	167,2	220,2	258,8
Мөнгө	*49,7*	*56,4*	*87,3*	*130,7*
Бараг мөнгө	*120,3*	*110,8*	*132,9*	*128,4*
М2/ДНБ	20%	20%	24%	26%
Нийт актив	196,3	179,5	181,8	225,7
Нийт пассив	179,5	172,4	163,2	195,8
Өөрийн хөрөнгө	16,8	7,1	18,5	29,9
Өөрийн хөрөнгийн хүрэлцээ	12,5%	1,5%	20,3%	27,0%
Төлбөр түргэн гүйцэтгэх чадвар	39,4%	32,7%	56,4%	55,4%
Зээлийн өрийн үлдэгдэл	50,4	88,6	49,3	67,7
Үүнээс: чанаргүй зээл	*15,0*	*36,4*	*18,4*	*15,9*
Чанаргүй зээлийн хувь	*30%*	*41%*	*37%*	*23,5%*
Зээлийн болзошгүй эрсдэлийн сан				
Байвал зохих	*7,6*	*22,7*	*15,9*	*13,2*
Байгуулсан	*6,7*	*18,4*	*15,3*	*13,4*
ЗБЭС ба зээлийн харьцаа	15%	25%	32%	22%
Банкуудын ашигт ажиллагаа				
Өөрийн хөрөнгийн өгөөж	*8,4%*	*-59,6%*	*15,6%*	*45,6%*
Активын өгөөж	*0,6%*	*-6,6%*	*1,4%*	*4,3%*

2000 онд мөнгөний нийлүүлэлт, банкуудын актив, пассив, өөрийн хөрөнгө, төлбөрийн чадварын болон ашигт ажиллагааны үзүүлэлтүүд өмнөх жилүүдтэй харьцуулахад өсч, банкны системийн санхүүгийн байдал сайжирсан байна.

Үүнд 2000 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар системийн өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлт 27,0%; төлбөр түргэн гүйцэтгэх чадварын үзүүлэлт 55,4%; гадаад валютын эрсдэлийн үзүүлэлт 1,8% байгаа нь Монгол банк болон олон улсын хэмжээний стандартын байгуулагаас тогтоосон хязгаарлалтыг хангажээ.

Хэдийгээр системийн санхүү, төлбөрийн чадварыг тодорхойлох гол гол үзүүлэлтүүд ийнхүү байвал зохих хувь хэмжээнд байгаа боловч банкны систем нь бүтцийнхээ хувьд тодорхой сул талуудыг агуулсаар байна. Үүнд:

1. Банкуудын зээлийн өрийн үлдэгдлийн 23,5 хувь нь чанаргүй зээлд ангилагдсан.

2. Системийн активын 80 орчим хувь нь 3 банкинд, зээлийн өрийн үлдэгдлийн 60 гаруй хувь нь 2 банкинд, гадаадын банкин дахь харилцах хадгаламжийн 80 гаруй хувь 1 банкинд тус тус байршиж байгаа нь банкны систем энэ хэмжээгээр эрсдэлтэй байгааг илтгэнэ.

3. Банкны систем дэх төрийн өмчийн оролцоо өндөр хэвээр, төрийн эрх бүхий байгууллагуудаас, тухайлбал, Санхүү эдийн засгийн яам, Төрийн өмчийн хороонооос томилогдсон Төлөөлөн удирдах зөвлөл, хяналтын зөвлөлөөс тэдгээр банкуудын үйл ажиллагаанд тавих удирдлага, хяналт хангалтгүй. Тухайлбал:

а/өнөөгийн байдлаар Монгол банкнаас зөвшөөрөл авч үйл ажиллагаа явуулж буй 12 банкнаас төрийн өмчийн болон төрийн өмчийн оролцоотой 6 банк /Хадгаламжийн банк, Хөдөө аж ахуйн банк, Худалдаа, хөгжлийн банк, Улаанбаатар хотын банк, Шинэчлэл банк ба Монгол шуудан банк/ -уудад 2000 оны 12 дугаар сарын байдлаар банкны системийн нийт хадгаламжийн үлдэгдлийн 69.9 хувь, харилцах дансны үлдэгдлийн 81.7 хувь, Засгийн газрын харилцах хадгаламжийн үлдэгдлийн 91.0 хувь байршиж байна.

б/1990 оноос хойш 15 банк татан буугдсаны дотор төрийн өмчийн болон төрийн өмчийн оролцоотой 6 банк байлаа. Тэдгээрт иргэдийн хадгаламжийн 30.8 тэрбум төгрөг, харилцах дансны 57.5 тэрбум төгрөг, бүгд 88.3 тэрбум төгрөг байршиж байсан.

4. Зах зээлийн харилцааны оролцогч

(хувь, тэрбум төгрөг)

	1995	1996	1997	1998	1999	2000
Гадаад актив	25,4	43,3	66,4	26,1	41,7	58,9
Нийт активт эзлэх хувийн жин	25%	34%	36%	15%	20%	25,2%

5. ХОТШ, Сэргээн босголт, Хөдөө аж ахуй зэрэг олон тооны салбар нэгж бүхий банкуудын санхүү төлбөрийн чадвар алдагдсанаас хөдөө орон нутагт банкны үйлчилгээ үзүүлэх байгууллагуудын тоо эрс цөөрсөн. Хэдийгээр төрийн эрх бүхий байгууллагуудаас Хөдөө аж ахуйн банкийг дахин хөрөнгөжүүлж, Шуудан банк болон Хөгжлийн алтан санд хөдөө орон нутагт үйл ажиллагаа явуулах зевшөөрөл олгосон боловч эдгээр байгууллагуудаас үзүүлж буй банкны үйлчилгээ нь хөдөө орон нутгийн хэрэгцээг хангаж чадахгүй байгаа.

6. Зохих албадлагын арга хэмжээг санхүү

	АКТИВ	Хувь		ПАССИВ	Хувь
1	Касс дахь бэлэн мөнгө, бусад банкин дахь харилцах	19%	1	Банк хоорондын захаас татан төвлөрүүлсэн хөрөнгө	1%
2	Бусад банкинд байршуулсан хадгаламж	20%	2	Засгийн газрын харилцах, хадгаламж	13%
3	Төв банкны үнэт цаас	9%	3	Аж ахуйн нэгж, байгууллагын харилцах, хадгаламж	23%
4	Засгийн газрын үнэт цаас	19%	4	Иргэдийн харилцах хадгаламж	34%
5	Зээл (цэврээр)	24%	5	Бусад пассив	16%
6	Бусад актив	9%	6	Өөрийн хөрөнгө	13%
		100%			100%

Өнгөрсөн оны байдлаар банкуудын нийт пассивын 60 орчим хувийг хувийн хэвшлээс буюу аж ахуйн нэгж, байгууллага, иргэдээс татан төвлөрүүлсэн харилцах хадгаламж эзэлж байгаа боловч үүний 50 хүрэхгүй хувийг л зээл олголтод зарцуулжээ.

Банкны салбарын нийт активын 24 хувийг зээл эзэлж байна.

Санхүүгийн зуучлалын үр дүн ийнхүү муу байгаа нь дараахь хүчин зүйлээс шалтгаалсан болно. Үүнд:

а/цөөн тооны аж ахуйн нэгж, байгууллагуудыг эс тооцвол зээлдэгч этгээдүүдийн зээлжих чадвар сул;

этгээдүүд хөрөнгө мөнгөө далд инфляци, төгрөгийн ам доллартай харьцахханшны үналтаас хамгаалах зорилгоор төгрөгийг гадаад валютад хөрвүүлэх хандлага ажиглагдаж байгаа (Тухайлбал, банкуудын хувьд гадаад активын нийт активт эзлэх хувийн жин 1998-2000 онуудад огцом өссөн болохыг дараахь хүснэгтээс харж болно)

7. Банкуудын гүйцэтгэж буй санхүүгийн зуучлалын цар хүрээ нь хязгаарлагдмал байгаа. Банк болон банк бус санхүүгийн байгууллагын нэгдсэн тэнцлийн бүтцийг дараахь хүснэгтэд үзүүлэв:

төлбөрийн чадвар нь алдагдсан банкуудад хэрхэн авах талаар хууль тогтоомжид нарийн тусгаагүйгээс эдгээр банкуудын бүтцийг өөрчлөхөд гарч байгаа зардал эдийн засагт дарамт учруулж байсан байна. Тухайлбал, 1996 оноос хойш банкны бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээний хүрээнд 70 гаруй төрбэр төгрөг зарцуулсан нь дотоодын нийт бүтээгдэхүүний 8 орчим хувьд хүрсэн.

б/ зээлдэгч аж ахуйн нэгж, байгууллагуудын санхүүгийн тайлан мэдээний боловсруулалтын чанар хангалттүйгээс шалтгаалан банкууд оновчтой зөв шийдвэр гаргах боломж дутмаг;

в/дээрх шалтгааны улмаас ихэнх банкуудын зээлийн эрсдэлийг үнэлэх арга барил нь эдийн засгийн үр ашиг бус зөвхөн барьцаанд үндэслэсэн хэвээр байна;

г/засгийн газраас гаргасан үнэт цаас нь хөрвөх чадваргүйгээс Төв банк мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх үүднээс өөрөө үнэт цаас гарган арилжаалж байна. Энэ нь активаа эрсдэл багатай байршуулахын тулд Төв банкны үнэт цаасанд хөрөнгө оруулалт хийх сонирхлыг банкуудад бий болгож зээлийг харьцангуй бага олгох болсон.

1.2.3.Үнэт цаасны зах зээл

1990 онд байгуулагдсан Засгийн газар хувийн өмчид суурилсан эдийн засагтай болох стратегийн зорилтоо хэрэгжүүлэхийн тулд өмч хувьчлах ажлыг эхэлсэн нь хөрөнгийн зах зээлийн эх үүсвэрийг тавьсан билээ.

Үнэт цаасны зах зээлийн хөгжлийн эхний шатыг үндэсн 2 хэсэгт хуваж болно.Үүнд:

1. Томоохон үйлдвэр, аж ахуйн газрыг компанийн хэлбэрт оруулан, хувьцааг нь иргэдэд үнэгүй тараасан хөрөнгө оруулалтын эрхийн цэнхэр тасалбараар худалдаж, иргэд, хувьцаа эзэмшигчид болох ажиллагаа явагдсан 1991-1995 он буюу эхний үе:

Хувьцааг хөрөнгө оруулалтын эрхийн бичгээр худалдах үнэт цаасны анхдагч зах зээлийн анхны арилжаа Монголын хөрөнгийн бирж дээр 1992 оны 2 дугаар сарын 7-нд явагдаж эхэлснээс хойш 1995 оны 5 дугаар сар хүртэл 3 жил гаруй хугацаанд нийт 193 удаагийн арилжаагаар 475 компанийн 195,8 сая ширхэг хувьцааг арилжаалсан бөгөөд Монгол улсын нэг сая хоёр зуу гаруй мянган иргэн хувьцаа эзэмшигч болсон юм. Эдгээр 475 ХК-ийн 241-ийг бүрэн хувьчилж, 234 компанийн хувьцааны 5-90 хувь нь төрийн мэдэлд үлдсэн.

2. Хувьчлагдсан компаниудын хувьцааг иргэд хоорондоо бэлэн мөнгөөр худалдах арилжаа буюу үнэт цаасны хоёрдогч зах зээлийн үе:

Үнэт цаасны хоёрдогч зах зээл эхэлснээс хойшхи 5 жил гаруйн хугацаанд нийт дүнгээр 33,9 тэрбум төгрөгийн 151,8 сая гаруй ширхэг үнэт цаас арилжаалсан байна.

Өөрөөр хэлбэл өдерт дунджаар 30 гаруй сая төгрөгийн гүйлгээ хийж, 100 гаруй мянган ширхэг хувьцаа арилжаалж байна.

Гэхдээ энэ үзүүлэлт он, оноор нэлээд өндөр хэлбэлзэлтэй явж ирснийг хүснэгтээс харж болно (Хүснэгт 1).

ҮНЭТ ЦААСНЫ АРИЛЖААНЫ ГОЛ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Үзүүлэлтүүд	1995[1]	1995	1996	1997	1998	1999	2000
	95.08.28	Жилийн эцсээр					
1.Бүртгэлтэй компанийн тоо	476	463	457	435	430	418	413
2.Зах зээлийн үнэлгээ: сая төгрөгөөр сая ам.долл.	22814,7	12815,9 27,06	17961,0 25,90	43255,3 53,19	35858,4 39,83	34427,9 32,01	33008,0
3.Нэг ам. доллартай харьцах төгрөгийн ханш	450,83	473,62	693,51	813,16	902,00	1072,37	1100,0
4.Арилжаалсан үнэт цаас: сая төгрөгөөр сая ам.долл.		851,51 1,80	4156,51 6,00	12164,78 14,96	10756,00 11,95	3274,2 3,10	2720,0
5.Арилжаалсан үнэт цаас (мянган.ширхэг) нийт дүн		6583,96	24076,61	33659,86	33073,50	21446,7	32,9
өдрийн дундаж		78,38	102,02	133,04	130,71	85,10	14,3
6.Эргэлт (олон нийтэд арилжаалсан, хувь)		7,0	24,8	31,3	26,7	36,9	
7.ТОП-75 индекс		113,7	118,35	251,0	235,2	230,3	396,3
8.Хэрэглээний үнийн индекс (ХҮИ)		53,1	58,7	17,5	6,0	8,2	
9.ХҮИ: 1995 оныг суурь болгон тооцсон		100	144,6	174,2	184,7	243,0	
10.ТОП-75 индекс: 1995 оныг инфляцид үндэслэн тооцсон		-4,00	-68,40	+31,52	+2,37	+12,7	

[1] Хоёрдогч зах зээл эхэлсэн өдрөөс өмнөх үе

-МХБ-д арилжаалж буй үнэт цаасны зах зээлийн үнэлгээ, хувьцаа эзэмшигчдийн тоо, эзэмшигчдийн өмч гэсэн үзүүлэлтээр сагс бүрдүүлж ТОП-75 индекс тооцож хөрөнгийн зах зээлийн байдлыг мэдрэх гол хэмжүүр болгон нийтэд мэдээлж ирэв.

1998 оны 2 дугаар сар хүртэл 100-гаас доош нэгжээс эхэлсэн индекс дээд тал нь 402 нэгж хүрч оны эхээр 230 орчимд хэлбэлзэж байснаа одоо 400 гараад байна.

Хөрөнгийн биржид бүртгэлтэй хувьцаат компанийн тоо цөөрч байна. Энэ нь компаниуд нэгдэж нийлсэн, дампуурсан, мөн нэлээд компани хязгаарлагдмал хариуцлагатай компани болон өөрчлөн зохион байгуулагдсантай холбоотой. 1997-1998 онд үнэт цаасны арилжааны хэмжээ дээд цэгтээ хүрсэн бөгөөд 1999 оноос эхлээд эрс буурсан. Сүүлийн 5 жилээс 3 сарын хугацаанд үнэт цаас нь арилжаалагдаагүй хувьцаат компанийн тоог авч үзвэл:

5 жилд	4 жилд	3 жилд	2 жилд	1 жилд	6 сард	3 сард
1	1	3	10	35	83	161

Дээрх үзүүлэлтээс харахад одоо бүртгэлтэй байгаа нийт хувьцаат компанийн 39 хувийнх нь хувьцаа сүүлийн 3 сард арилжаалагдаагүй байна. Нийт үнэт цаасны 30 орчим хувь нь тогтмол идэвхтэй арилжаалагдаж, 31 хувь нь буюу 130-аад үнэт цаасны арилжаа дунд зэргийн түвшинд арилжаалагдаж байна.

Үнэт цаасны зах зээлийн идэвхжил буурч байгааг үнэт цаасны хэлшийн мэдээ харуулж байна. Тухайлбал: үнэт цаас нь арилжаалагдаж байгаа 403 компанийн 73 хувь буюу 290 гаруй компанийн хувьцааны дундаж ханш анхны нэрлэсэн үнэ болох 100 төгрөгнөөс доогуур байна. 70 хувь нь 100 төгрөгнөөс доогуур, үүний дотор 60 хувийнх нь 50 төгрөгнөөс доогуур байна. Ердөө л 9 компанийн үнэт цаасны ханш 500 төгрөгнөөс дээш байна.

Хувьцааны үнэ ханш, зах зээлийн нийт үнэлгээ буурч, үнэт цаасны зах зээл хумигдаж байгаа нь хэд хэдэн шалтгаантай:

1. Манайд үнэт цаасны зах зээл хөгжих макро эдийн засгийн таатай орчин бүрдээгүй, улс орны эдийн засаг, санхүүгийн өнөөгийн байдал нь үнэт цаас гаргах замаар санхүүжилтийн эх үүсвэр бий болгох, үнэт цаасаар хийх хөрөнгө оруулалтыг дэмжих чиглэлээр нөлөөлж чадахааргүй байна.

2. Биржид бүртгэлтэй компанийн тоо буурсан. Анх өмч хувьчлалаар үүссэн 475 компани бүртгэлтэй байсан бол одоо 413 компани бүртгэлтэй байгаа бөгөөд үүнээс 403 компанийн хувьцаа арилжаалагдаж байгаа.

3. Бүртгэлтэй компаниудын цэвэр хөрөнгийн хэмжээ, хувьцааны дансны үнэ болон зах зээлийн үнэ ханшийн хооронд бодитой уялдаа байхгүй. Энэ байдал нь мэдээллийн хомсодолоос үндсэндээ шалтгаалж байгаа.

4. Хувьцаат компаниудын санхүүгийн байдал, хүчин чадлын ашиглалт муу.

5. Ихэнх компанийн хувьцаа төвлөрсөн учраас том багц хувьцаа эзэмшигчид нь компанийн удирдлагыг бүрдүүлж байна. Бүрэн хувьчлагдсан 330 ХК-ийн 87 хувь нь 1-10 хүний өмчлөлд шилжжээ. Тэдгээр нь жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хөсөрдүүлэх болсон, жижиг хувьцаа эзэмшигчдийн эзэмшиж буй хувьцааны ханш унаж эрэлт буурсан.

   Хөрөнгийн биржийн төвлөрсөн хадгаламжид данс бүхий нийт 284000 харилцагчдын зөвхөн 1,3 мянга нь 65,6 сая ширхэг буюу нийт бүртгэлтэй хувьцааны 70 хувийг өмчилж байна.

6. Төрийн мэдлийн хувьцааг биржийн арилжаанаас гадуур дуудлага худалдаагаар худалдаж байгаа.

7. Хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах эрх зүйн орчин бүрэлдэн тогтож чадаагүй. Тухайлбал, Хөрөнгийн биржийн төвлөрсөн хадгаламжид хадгалагдаж буй үнэт цаас, мөнгөн хөрөнгийн хадгаламт, хамгаалалт найдваргүй байсны улмаас хувьцаа эзэмшигчдэд олгох ногдол ашиг болон хувьцаа худалдаж авахаар биржид шилжүүлсэн 1075 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийг дампуурсан банкуудад шилжүүлэн байршуулж алдсан байна. Энэ нь үнэт цаасны зах зээлд итгэх олон түмний итгэлийг алдагдуулахад хүргэлээ.

Өнгөрсөн хугацаанд нийт 39 ХК 11,2 төрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийхээр шинээр болон нэмж үнэт цаас гаргасан.

Гэхдээ үүнийг жинхэнэ утгаараа үнэт цаасаар хийсэн хөрөнгө оруулалт, Монгол Улсын үнэт цаасны зах зээлийн хөгжлийн шинэ үе шатны эхлэл гэж үзэх боломжгүй юм. Учир нь эдгээрийн нэг нь үнэт цаасны зах зээл дээр биржээр дамжиж нийтэд, чөлөөтэй арилжаалагдаагүй юм.

Эдгээр нь бүхэлдээ компанийн хувьцааны тодорхой багцыг эзэмшигчид компанид оруулсан

хөрөнгөө өмчлөх эрх болгон баталгаажуулахад чиглэгдсэн.

Төсвийн цаг зуурын хомсдолыг даван туулах, иргэд, байгууллагын сул чөлөөтэй мөнгөн хөрөнгийг татан авч мөнгөний эргэлтийг зохицуулах, банк санхүүгийн системээр дамждаггүй мөнгөний далд эргэлтийг сааруулах зорилгоор Засгийн газар 1996 онооос богино хугацаатай үнэт цаас гарган арилжаалж иржээ.

1996 онд 1144,2 сая төгрөгийн, 1997 онд 10300,0 сая төгрөгийн, 1998 онд 20146,5 сая төгрөгийн, 1999 онд 36735,3 сая төгрөгийн, 2000 оны 10 дугаар сарын 1-ний байдлаар 18930,0 сая төгрөгийн бонд тус тус арилжаалж, энэ хугацаанд нийт 200558,1 сая төгрөгийн үндсэн төлбөр, 2936,1 сая төгрөгийн хүүгийн төлбөрийг төлж барагдуулжээ.

Бондын борлуулалтын орлогын зонхилох хэсгийг төсвийн нэн шаардлагатай санхүүжилт цалин, тэтгэвэр тэтгэмж, аймаг орон нутагт олгосон татаас эзэлж байснаас үзэхэд бонд гаргах нь төсвийн цаг зуурын хүндрэлийг даван туулах, төвлөрсөн төсвийн алдагдлын зохих хэсгийг санхүүжүүлэхэд ашиглагдаж иржээ.

Үнэт цаасны тухай хууль болон Засгийн газрын бонд гаргах, арилжаалах журамд заасны дагуу бондыг бүртгүүлэгчийн, олон нийтэд сурталчилдагтүй байснаас иргэдийн гар дээр сул чөлөөтэй байгаа мөнгөн хөрөнгийг эдийн засгийн эргэлтэд татан оруулах арга хэрэгсэл болж чадаагүй байна.

1.2.4. Даатгалын тоготолцоо

Санхүүгийн олон төрлийн арга хэрэгслүүд дотроос иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудад учирч болзошгүй аливаа эрсдэлийг тараах механизм бүхий даатгалын эрэлт хэрэгцээ нь зах зээлийн эдийн засгийн өнөөгийн нөхцөлд өсөн нэмэгдэж байна. Иймд даатгуулагчдын эрх ашгийг баталгаажуулж хамгаалахад төрөөс даатгалын тоготолцоо, түүний үйл ажиллагаат боловсронгуй болгохоо чиглэгдсэн нэгдсэн бодлого, хяналт шаардагдах нь байна.

Монгол улсад арилжааны даатгалын байгууллага үүсч хөгжөөд 66 жил болж байна. 1990 он хүртэл арилжааны даатгалын үйл ажиллагаат хуучнаар Сангийн яамны харьяа Улсын даатгалын ерөнхий газар эрхлэн гүйцэтгэж байсан бөгөөд тухайн үеийн Засгийн газрын шийдвэрээр төрийн өмчийн 2 даатгалын компанийг үүсгэн байгуулж үйл ажиллагаат нь эхлүүлсэн түүхтэй.

Монгол улсын Засгийн газрын 1995 оны тогтоолыг үндэслэн арилжааны даатгалын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох түр журам батлагдаж, уг журмын дагуу даатгалын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг хувийн хэвшлийн аж ахуйн нэгжид олгож эхэлсэн байна.

Монгол улсын даатгалын тухай хууль 1997 оны 12 дугаар сарын 5-нд батлагдан гарснаар даатгалын үйл ажиллагаат хууль, эрх зүйн хүрээнд явуулах боломж бүрдсэн.

Одоогийн байдлаар манайд энэ хуулийн дагуу төрийн өмчийн 2, хувийн өмчийн 11, нийтдээ 13 компани даатгалын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авч үйл ажиллагаагаа явуулж байна.

· Даатгалын салбарын эдийн засгийн байдал:

Даатгалын хураамжийн орлого 1999 онд 3776.6 сая төгрөгт хүрч, 1997 оныхоос 1126.5 сая төгрөг буюу 45.2 хувиар, 1998 оныхоос 592.4 сая төгрөг буюу 18.6 хувиар тус тус өссөн байна. Энэ өсөлт нь зөвхөн Монгол даатгал компани "Д энд В даатгал" компаний орлогын өсөлтөөр хангагдаж, даатгалын бусад компаниудын орлого 5.2-4.5 сая төгрөгөөр буурсан байна.

1999 оны байдлаар улсын хэмжээнд орсон даатгалын хураамжийн орлогын 45.5 хувийг даатгалын нөхөн олговор болон давхар даатгалын хураамж төлөхөд зарцуулжээ. Хураамжийн нийт орлогын 9.8 хувийг иргэдийн амь нас, эрүүл мэнд, ашиг сонирхлын, 61.5 хувийг хөрөнгийн, 28.7 хувийг хариуцлагын даатгалын орлого тус тус эзэлж байна.

Даатгуулагчийг дотор нь ангилж үзэхэд даатгалын хураамжийн нийт орлогын 69 хувь буюу 2.6 тэрбум төгрөгийг аж ахуйн нэгж, байгууллагууд, 31 хувь буюу 1.2 тэрбум төгрөгийг хүн амаас оруулсан байна.

Даатгалын тухай Монгол улсын хуулийн дагуу 1999 онд 1673 сая төгрөгийн нөөцийн сан нэмж байгуулагдсан нь 1998 оныхоос 278.3 сая төгрөгөө их болсон байна.

Даатгалын системийн хэмжээгээр 1999 онд 751.1 сая төгрөгийн нөхөн олговор олгож, 273.1 сая төгрөгийн цэвэр ашигтай ажилсан улсын төсөвт 108.7 сая төгрөгийн татвар төлжээ.

· Даатгалын нөөцийн сан байгуулалт, ашиглалт:

Даатгалын нийт хураамжийн орлого жил бүр өсч байгаа хэдий ч цэвэр ашгийн хэмжээ 1999 онд өмнөх оноосоо буурсан үзүүлэлттэй байна. Хохирол нөхөх нөөцийн сангийн хуримтлагдсан үлдэгдэл хэмжээ 1998 онд 1798.4 сая төгрөг, 1999 онд 2612.4

сая төгрөг болж нэмэгдсэн хэдий ч энэ нь активын байршлын хувьд 38.3 хувь нь менгэн хөрөнгөөр, 24.4 хувь нь хөрөнгө оруулалтаар, 37.3 хувь нь бусад хэлбэрээр байгаа нь ихээхэн муу үзүүлэлт юм. Үүнд зарим арилжааны банк татан буугдахад Монгол даатгал компаниас тэдгээр банкны дүрмийн санд оруулсан болон харилцахын үлдэгдэл болох 700 гаруй сая төгрөгийн менгэн сан алдагдсан нь голлон нөлөөлжээ.

Даатгалын компаниудын дүнгээр даатгалын үйл ажиллагаанаас 1999 онд 273.0 сая төгрөгийн цэвэр ашиг олсноос даатгалын бус үйл ажиллагааны ашиг нь 257.6 сая төгрөгийг эзэлж байна. Үүнээс харахад даатгалын үйл ажиллагааны ашиг 5.6%, даатгалын бус үйл ажиллагааны ашиг 94.3%-г тус тус эзэлж байгаа нь даатгалын үйл ажиллагааны өнөөгийн байдлыг харуулж байна.

1998 оны байдлаар даатгалын компаниудын нөхөн олговрын байдлыг судлахад амь нас, эрүүл мэнд, ашиг сонирхлынх 35.3 хувь, эд хөрөнгийн даатгалынх 12.7 хувь, хариуцлагын даатгалынх 23.9 хувь тус тус эзэлсэн байна.

Дараахь хүснэгтээс үзэхэд нийт хураамжийн орлогод нөхөн олговрын эзлэх хувийн жин 17.9 хувиас 20.2 хувь болж 2.3 хувиар өссөн байна. Зах зээл өндөр хөгжсөн орнуудын даатгалын байгууллагуудад энэ үзүүлэлт 60-70 хувь байдаг тул харьцуулахад бага байгаа нь нэг талаас ашигт ажиллагааны түвшин өндөр мэт санагдаж болох боловч нөгөө талаас энэ нь даатгалын компаниуд хохирол нөхөн олгохдоо нэлээд хөшүүн байгаа гэсэн дүгнэлт хийж болно.

Хураамжийн орлогод нөхөн олговрын эзлэх хувь

(сая төг.)

	1998		1999	
	дүн	хувь	дүн	хувь
Нөхөн олговрын хэмжээ	569.3	17.9	751.1	19.9

Нөөцийн сангийн актив дахь байршил

(мян.төг)

№	Компанийн нэр	Бэлэн мөнгө	Харилцах	Хөрөнгө оруулалт	Нөөцийн сангийн дутуу	Нөөцийн сангийн дүн
1	Монгол даатгал	9458.7	277464.1	542190.3	701642.2	1530755.3
2	Түшиг даатгал	9486	49301.9		190576.1	249364.0
3	Торгон зам	66527.6	9481.2		32261.5	108270.3
4	Ай Ти Си Дат	20.6	10831.8	64204.9	26980.2	102037.5
5	Бодь даатгал		140288.5			140288.5
6	Эрэл даатгал		101805.5			101805.5
7	Ми энд Р	50000.0	53170.5			103170.5
8	Д энд Б	74000.0	39000.0		22715.0	135715.0
9	Ард даатгал	49090.0	53217.6	30059.0		132366.0
10	Ажнай даатгал	8669.0				8669.0
	Дүн	267251.9	734561.1	636454.2	974175.0	2612442.2
	Эзлэх хувь	10.2	28.1	24.4	37.3	100

Давхар даатгалын хувьд Монгол даатгал, Түшиг даатгал зэрэг компануид 968.7сая төгрөгийн давхар даатгалыг гадаадын давхар даатгалын компанид агаарын хөлөг, агаарын хөлөг эзэмшигчдийн хариуцлага, мал, таримлын төрлөөр хийгдэжээ. Даатгалын орлогоос 19.9 сая төгрөгийн гэрээг цуцалж буцаасан байна.

Хохирол нөхөлтийн бүтэц даатгалын компани түс бүр дээр еер байна. Тухайлбал амь нас, эрүүл мэнд болон ашиг сонирхлын даатгал Ай Ти Си Дат даатгал компанид 53.0 хувь, эд хөрөнгийн даатгал Түшиг компанид 34.4 хувь, хариуцлагын даатгал Монгол даатгал компанид 22.4 хувь байгаа нь улсын дунджаас дээгүүр байна.

1.2.5. Банк бус санхүүгийн байгууллага (ББСБ)

1. Өнөөгийн байдал

ББСБ-ын үндэсний тогтолцоог бүрдүүлэн хөгжүүлэх нь тухайн улс орны эдийн засагт санхүүгийн секторын үр нөлөөг дээшлүүлэх нэн чухал хүчин зүйл юм.

Төрийн мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх зорилгоор мөнгөний урсгалыг зөв чиг хандлагад оруулах, ажлын байр нэмэгдүүлэх, жижиг бизнес эрхлэгчдийн санхүүгийн үйл ажиллагаат дэмжих, төлбөр тооцоог түргэн шуурхай гүйцэтгэх, санхүүгийн зуучлалын үйл ажиллагаанд өрсөлдөөнийг бий болгох, санхүүгийн ажил, үйлчилгээг нийтэд хүртээмжтэй болгох зэрэг санхүүгийн салбарын өмнө тавигдаж байгаа зорилтыг ББСБ-ын үйл ажиллагаат хөгжүүлэхгүйгээр хэрэгжүүлэхийн аргагүй юм.

ББСБ-д уг үйл ажиллагаа эрхлэх даатгал, үнэт цаас, тэтгэврийн болон хамтын сангууд, хадгламж зээлийн хоршоо, санхүүгийн лизингийн компани, мөн банкны зарим үйл ажиллагаат эрхэлж байгаа банкнаас бусад төрлийн санхүүгийн зуучлагч байгууллагыг оруулж байгаагаас одоогийн байдлаар манай улсад даатгалын 10, санхүүгийн лизингийн 2, үнэт цаасны 41, хадгламж зээлийн хоршоо 90 гаруй, жижиг зээлийн үйл ажиллагаа эрхлэх санхүүгийн байгууллага 6, электрон төлбөр тооцооны 1 байгууллага тус тус ажиллаж байна.

Дээрх байгууллагуудаас банкны үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг эрх бүхий төрийн янз бүрийн байгууллагаас олгож, үйл ажиллагаанд нь хяналт тавьж байгаа боловч эрх зүйн нэгдмэл орчин бүрдээгүй байна.

Банкны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2-т заасны дагуу Монгол банк даатгал, үнэт цаас, тэтгэврийн болон хамтын сангууд, хадгламж зээлийн хоршоонооос бусад төрлийн санхүүгийн зуучлагч байгууллагад банкны зарим үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, хяналт тавих журмыг батлаж энэхүү үйл ажиллагаат зохицуулж байна. Түүнчлэн зээлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авсан 6 байгууллагын санхүү, төлбөрийн чадварын үзүүлэлтийг Монгол банкнаас тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтээр тооцож, үйл ажиллагаат нь хянаж байна.

Хэдийгээр банк бус санхүүгийн байгууллагын зөвшөөрлийг олгосон эрх бүхий төрийн байгууллагаас тэдгээрийн үйл ажиллагаанд хяналт тавьж байгаа ч хяналтыг бүрэн утгаар нь хэрэгжүүлэх, тэдгээрт хүлээлгэх хариуцлагын тогтолцоог бий болгохын тулд санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх байгууллагуудын хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх зайлшгүй шаардлага гарч байна. Тухайлбал, пирамид тогтолцооны хэлбэрээр зохион байгуулагдсан Шинэ санаа төв нэртэй төрийн бус байгууллага Монголд 1999 оноос эхлэн үйл ажиллагаагаа явуулснаар олон иргэдийг хохироосон билээ. Шинэ санаа төвийнх шиг үйл ажиллагаа газар авч байгаагийн илрэл нь бусдаас мөнгөн хөрөнгө авч богино хугацаанд хүй дахин өсгөж өгнө гэсэн зарыг хэвлэлд нийтлүүлж байгаа явдал юм. Зарим улсад энэ төрлийн үйл ажиллагаат хууль бус, луйвар гэж тодорхойлон үйл ажиллагаат нь бүрмөсөн хориглох, эсхүл хязгаарлалт тавьдаг байна.

Мөн Монгол банкнаас баталсан журмын дагуу санхүүгийн лизингийн компанид үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгон, хяналт тавих шаардлагатай. Үүний дагуу Монгол банкнаас Очир лизинг, Бодь лизинг хязгаарлагдмал хариуцлагатай компанийн санхүүгийн үйл ажиллагаанд шалгалт хийж, Монгол банкны зөвшөөрөлгүй санхүүгийн түрээсийн үйл ажиллагаа эрхэлж байсныг улсын байцаагч актаар тогтоон холбогдох арга хэмжээг авч ирсэн хэдийч санхүүгийн түрээсийн үйл ажиллагаат хуулиар зохицуулаагүй байснаас хариуцлага тооцох боломжгүйд хүрч байсан.

Манай улсад банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагаг зохицуулсан хууль, мөн хадгаламж зээлийн хоршоо, ломбард, тэтгэмжийн болон ядуурлыг бууруулах сангууд, гишүүдээсээ татвар буюу бэлэглэлийн хэлбэрээр мөнгөн хөрөнгө татаж буй пирамидын тогтолцоотой олон шатлалт маркетингийн зэрэг мөнгө үржүүлэгч төрийн бус байгууллагын эдийн засаг санхүүгийн харилцааг зохицуулсан хууль ч байхгүй байна.

Санхүүгийн зуучлалын үйл ажиллагаг эрхлэх банк бус санхүүгийн байгууллагууд түүний дотор жижиг зээлийн сангууд үүсч хөгжсөөр байгаа хэдий ч тодорхой үр дүнд хүрдэгүй нь дараахь шалтгаантай байна. Үүнд:

- Үйлчилгээгээ нийтэд хүртээмжтэй хэлбэрээр' явуулдаггүй, хөрөнгө нь хязгаарлагдмал;
- Жижиг зээлийн санг төслийн хэлбэрээр хэрэгжүүлэх хэналт-менежментийн арга зүй тогтоогүй, жижиг зээлийн үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналтын тогтолцоо бүрдээгүй;
- Жижиг зээлийн байгууллагын эрх статус хуульчлагдаагүй;
- Бичил санхүүгийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллагыг санхүүгийн эх үүсвэрээр хангах, мөн төлбөрийн чадварт холбоотой богино хугацаатай хүндрэлийг даван туулахад туслалцаа үзүүлэх байгууллага байхгүй;
- Зээлийг банк болон төсөл хэрэгжүүлэгч эрх бүхий этгээдээр дамжуулан олгоход зээлийн хүү нэмэгдэж анх гэрээгээр зөвсөн хөнгөлөлттэй нөхцөл нь алдагдаг байна.

ББСБ тодийгүй банкууд мөн санхүүгийн зуучлалын үүргээ тодийлэн сайн гүйцэтгэж чадахгүй байна. Өнөөдрийн байдлаар ихэнх банкууд хөдөө орон нутагт салбар нээгүгүй, салбар нээгээгүй хэдий ч санхүү, төлбөрийн чадвар нь алдагдсанаас зээл олгох эрх нь хязгаарлагдсан, зарим банкууд нь өөрийн цөөн тооны томоохон харилцагчдын хүрээнд үйл ажиллагаагаа явуулдаг, санхүү, төлбөрийн чадварын хувьд тодийлэн сайн биш, банк, санхүүгийн системийн хэмжээнд нийт активын 60 орчим хувийг зээл эзэлж байгаа зэргээс үзэхэд санхүүгийн зуучлалын үйл ажиллагаа нийтэд хүртээлтэй бус байна.

Хөдөө орон нутагт энэ үйл ажиллагаа маш ханагалтгүй байгааг дараахь тоо баримтаас харж болно. Монгол банкнаас 1998 онд хийсэн судалгаагаар банкнаас олгосон 1 сая төгрөгөөс доош хэмжээтэй зээл нийт зээлийн 3 хувийг эзэлж байгаа нь нийт 70 тэрбум төгрөгийн зээлийн дөнгөж 2 тэрбум төгрөгтэй тэнцэж байгаагаас дөнгөж 19 хувь нь аймаг, сум, орон нутагт олгогдсон байна.

Гадаад орны туршлагаас үзэхэд банк бус санхүүгийн байгууллагууд, үүний дотор бичил санхүүгийн байгууллагууд ядуурлыг бууруулахад чухал үүрэг гүйцэтгэдэг байна. Манай орны хувьд нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүн 400 ам.доллартай тэнцэж байгаа, Дэлхийн банкнаас 1997 онд явуулсан судалгаагаар нийт хүн амын 40 гаруй хувь ядуу буюу амьжиргааны баталгаажих доод түвшингээс бага хэмжээний орлоготой байгаагаас ядуучуудын 40% нь аймгуудын төвд, 23% нь сумдын төвд, 12% нь нийслэлэд амьдардаг нь ядуурал газар авсны илрэл юм.

Банкны системд татан төвлөрүүлсэн мөнгөн хөрөнгө нь манай улсын дотоодын нийт бүтээгдэхүүний 20 орчим хувийг эзэлж байгаа нь дэлхийн хөгжсөн орнуудаас дунджаар 5 дахин доогуур байна. Гэтэл банкнаас гадуурхи мөнгөний эргэлт өндөр хувьтай, мөн иргэдийн гар дээр, байгууллагын касст эдийн засгийн статистик тооцоонд хамрагддаггүй, хөдөлгөөнгүй мөнгөний ихээхэн масс байгаа нь нууц биш юм.

Дээрх байдлаас үзэхэд санхүүгийн зуучлалын үйл ажиллагаа хөдөө орон нутагт маш ханагалтгүй, алслагдмал нутагт бүр ч хүрэхгүй байгаа тул ББСБ-ын үйл ажиллагаат дэмжих нээлттэй бодлого бариментлэж, энэ асуудлыг санхүүгийн салбарын хөгжлийн бодлогын хамт цогцолбороор нь авч үзэх зайлшгүй шаардлагатайг харуулж байна.

2. Мөрдөж буй хууль эрх зүйн орчныг үялдаагүй байдлаас үүсч буй бэрхшээл:

- Жижиг зээлийн үйл ажиллагааг төрийн бус байгууллага (ТББ) эрхэлж байгаа болоовч ТББ-ын тухай хуульд заасанаар тэдгээр нь ашгийн төлөө бус зарчмаар ажиллах ёстой. Гэтэл зээлийн үйл ажиллагааны эцсийн зорилго нь ямар нэг хэмжээнд ашгийн төлөө байдаг. Үүний сацуу Банкны тухай хуульд заасанчлан ББСБ Монгол банкны зөвшөөрлөөр мөнгөн гүйлгээ, хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагаа явуулах, валютын арилжаа эрхлэх эрхтэй. Энэ хүрээнд ТББ үйл ажиллагаа эрхлэх эрх хэмжээтэй боловч зээлийн үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагын хувьд энэ ажиллагаанаас олсон ашгийн хуримтлал, дахин хуваарилалт, олон улсын байгууллага болон Засгийн газрын байгууллагаас хуваарилах хөрөнгө, хандивыг захиран зарцуулах, тэдгээр эх үүсвэрээс бүрэлдэх өмч хөрөнгө, үүнтэй холбогдсон эрх, хариуцлагын тогтолцоо бүрдээгүй байна.

Банкны тухай хуулийн 17-р зүйлд зааснаар “. . .олон нийтийн байгууллага, энэрэнгүй үйлсийн сан нь банк үүсгэн байгуулах эрхгүй бөгөөд банкны дүрмийн санг бүрдүүлэх, тодорхойлох журамд зааснаар эдгээр байгуулага нь аливаа банкны дүрмийн санд хувь хөрөнгө оруулах эрхгүй байгаа тул цаашид хөгжлийн сан, хөгжлийн банк, дундын сан байгуулан ажиллахад бодит хүндрэл учруулах төлөвтэй.

Улсын дээд шүүхийн тогтоол (1996.08.17, N197)-ын гуравт зээлийн үйл ажиллагааны тухай тайлбарлахдаа Иргэний хуулийн 229 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “. . .зээлийн гэрээгээр зээлдүүлэгч нь мөнгө, бусад эд хөрөнгийг зээлдэгчийн өмчлөл буюу эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхэд шилжүүлэх, зээлдэгч нь авсан мөнгө буюу ижил төрөл, чанар, хэмжээний эд хөрөнгийг зээлдүүлэгчид буцаан өгөх үүрэг хүлээнэ” гэсэн заалт нь ариллжааны банкууд болон барьцаалан зээлдүүлэх газраас өөр бусад аж ахуйн нэгж, байгууллага, иргэдээс бусадтай байгуулсан зээлийн гэрээнд хамаардаг. Ингэхлээр сүүлчийн дурдсан иргэд, хуулийн этгээд хооронд байгуулсан зээлийн гэрээнд хүүгийн тухай аливаа нөхцөлийг тусгаж болохгүй, зөвхөн алданги төлөх, төлүүлэх тухай тохиролцон тусгаж болохоор байгаа юм.

Дээд шүүхийн энэхүү тайлбар нь жижиг зээлийн байгууллагууд зээлийн ажиллагаа эрхлэх талаар Монгол банкнаас зөвшөөрөл авсан хэдий ч гэрээнд зээлийн хүү тооцох, барьцаалах эрхийг боогдуулж байгаа юм. Үүнээс үүдээд манай улсад хэрэгжүүлж байгаа “Малжуулах төсөл”, “Сум хөгжүүлэх сан”-гийн үйл ажиллагаа, “Ядуурлыг бууруулах төсөл” зэрэг арга хэмжээ нь хүү, ашиг, урамшуулал тооцох харьцааг ямар нэг байдлаар өөртөө агуулж байгаа болохоор чухамдаа хууль зөрчсөн ажиллагаа болж хувирахаар байна.

Дээд шүүхийн 1996 оны 197-р тогтоолоор батална тайлбарын дагуу хадгаламж, зээлийн хоршоод зээлийн хүүгийн менежментийн бодлого явуулах эрхээр хязгаарлагдаж байгаа нь хадгаламж зээлийн хоршооны үндэсэн зорилгод харшилж байна.

2.САНХҮҮГИЙН САЛБАРЫН ШИНЭЧЛЭЛИЙН ДУНД ХУГАЦААНЫ ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

2.1.Төсвийн удирдлагын тогтолцоо

2.1.1.Төсвийн орлогын суурийг өргөтгөх, орлого бүрдэлтийг сайжруулах,орлогын тогтвортой байдлыг хангах

Татварын тогтолцоог оновчтой болгох:

- Татварын шатлалыг цөөрүүлэх;

Татварт олон шатлал тогтоох нь гажуудуулах нөлөөллийг ихэсгэхээс гадна аж ахуйн нэгжүүдийг жижигрүүлэх эсвэл томоохон салбарласан аж ахуйн нэгжүүд ашиг багатай буюу алдагдалтай хэсэг рүүгээ ашгаа шилжүүлэх, татвараас зайлсхийх арга зам хайх, авилгал зэрэг зохисгүй хандлага гаргахад хүргэдэг талтайг анхаарч татварын нэгдсэн хувьд шилжих асуудлыг иж бүрнээр нь судалж шийдвэрлэх;

- Нэмэгдсэн өртгийн албан татвар (НӨТ)-ын бааз суурийг өргөн байлгах, элдэв хөнгөлөлт, чөлөөлөлтийг аль болох багасгах арга хэмжээ авах;

- Татварын ачааллыг бууруулах асуудлыг татварын суурийг өргөтгөх замаар шийдвэрлэнэ. Одоо байгаа татварынхаа суурийг өргөтгөх нь гажуудал гарах боломжийг багасгахын зэрэгцээ татварын тэгш байдлыг илүү ханган, хураан авалтын зардлыг өсгөхгүй харин ч бууруулах зэрэг давуу талтайд ач холбогдол өгөх;

- Татварын хууль, тогтоомжийн хэрэгжилтэд тавих хяналтыг өндөржүүлэх,тэдгээрийг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг чангатгах чиглэлээр татварын болон холбогдох бусад хуулиудад өөрчлөлт оруулах;

- Татварын давхардлыг багасгах;

- Татвар ногдуулах орлогыг оновчтой тогтоох, татварын бодлогыг үйлдвэрлэлийг дэмжих эдийн засгийн бодлоготой уялдуулах;

- Татварын хууль тогтоомжийг энгийн хялбар болгож, татварт хамрагдах хүрээг өргөжүүлэх,татвараас зайлсхийх явдлыг зогсооход чиглэсэн хууль эрх зүйн орчныг бүрдүүлж, далд эдийн засгийг ил хэлбэртэй болгох, хязгаарлах.

Орлого бүрдэлтийг сайжруулах:

- Бэлэн мөнгөний гүйлгээг хязгаарлахад чиглэсэн арга хэмжээ авна. Тухайлбал, кассын машин,

төлбөрийн чек, мөнгөний цахим карт болон урамшуллын зарим хөшүүргийг ашиглах;

- Экспортын гол нэрийн бүтээгдэхүүний дэлхийн зах зээлийн үнийн хэлбэлзлээс төсвийн орлого хамаарах хамаарлыг багасгаж, тогтвортой байдлыг хангахад чиглэсэн арга хэмжээ авах.

Дэлхийн зах зээл дээрх экспортын гол нэрийн бүтээгдэхүүний үнийн хэлбэлзлээс хамааралгүйгээр төсвийн орлого бүрдэлтийг тогтвортой байлгах.

Дэлхийн зах зээлийн үнийн хэлбэлзлээс үүсэх эрсдэлийг зөөлөвчлөх гадаад үнийн даатгалын "Hedging", "options", "futures" хэлцлийн аргуудыг хэрэглэдэг болох.

- Аж ахуйн нэгжүүд татвараас зайлсхийх үүднээс хэд хэдэн санхүүгийн тайлан гаргадаг явдлыг таслан зогсоох, аж ахуйн нэгжүүд зөвхөн нэг санхүүгийн тайлан гаргаж аудитороор баталгаажуулж байхыг хуульчилан тогтоох, татвар төлөх, банкнаас зээл авах, бусад үйл ажиллагаатай холбогдуулж санхүүгийн тайланг олон хувилбараар гаргах замаар бусдыг хууран мэхэлсэн аж ахуйн нэгжийн удирдлага, ерөнхий нягтлан бодогч, тухайн санхүүгийн тайланг баталгаажуулсан аудитор болон аудитын байгууллагад эрүүгийн хариуцлага хүлээлгэх эрх зүйн орчныг бий болгож, хэрэгжүүлэх;

2.1.2.Төсвийн зарлагын бүтцийг үр ашигтай, хэмнэлттэй болгох

- Төсөвт байгууллагын санхүүгийн удирдлагыг боловсронгуй болгох иж бүрэн арга хэмжээний хүрээнд гарцад суурилсан үр дүнгээр санхүүжүүлэх шаардлагын тогтоож, түүний үр дүнгээр санхүүжүүлэх зарчмыг тодорхой үе шатгайгаар хэрэгжүүлнэ. Энэ чиглэлд нэн тэргүүнд эрх зүйн орчныг нь бүрдүүлж өгөх.

- Төсвийн зарлагын бүтцийг оновчтой болгохдоо зарлагын ангилал бүр дээр бүтцийн өөрчлөлтийн зарчмыг үндэс болгоно. Төсвийн зарлагын бүтцэд голлох байр суурийг эзэлж байгаа боловсрол, эрүүл мэнд, батлан хамгаалах, нийгмийн хэв журам сахиулах байгууллагуудыг хэмнэлттэй, үр ашигтай тогтолцоонд шилжүүлэх чиглэлээр хийж буй бүтцийн өөрчлөлтийг гүнзгийрүүлэх замаар төсвийн урсгал зардлыг цаашид хязгаарлах.

- Шинээр төв, орон нутгийн төсвөөс санхүүжих үр ашигүй аливаа үйл ажиллагаат хязгаарлах зарчим баримтлах.

2.1.3.Төрийн сангийн тогтолцоог хөгжүүлэх

- Засгийн газрын өмнө олон талт төвлөрсөн зарчмын үндсэн дээр төсвийн санхүүжилтийн гүйлгээг зохицуулах, бүртгэл хийх, тайлан гаргах үүрэг бүхий төрийн сангийн тогтолцоог хөгжүүлэх.

- Төрийн сангийн тогтолцоонд шилжих үйл явцыг дараахь үе шаттайгаар хэрэгжүүлэх. Үүнд:

  - Засгийн газрын мэдлийн санхүүгийн нөөцийг Төв банкинд төвлөрүүлэн Төрийн сангийн нэгдсэн дансны тогтолцоог бий болгох;

  - Засгийн газрын мэдлийн орлого, зарлагын бүх дансыг төв банкинд татан байршуулж, санхүүгийн нэгдсэн удирдлагаар хангах арга хэмжээ авах. Ингэснээр төсвийн орлого, зарлагын гүйлгээний шуурхай байдлыг сайжруулах. Тухайлбал, татварын аливаа орлого өдөртөө төсвийн дансанд орох бөгөөд төсвийн менгэн хөрөнгийг банкуудаас зээлэн авах явдлыг арилгах. Мөн төсвийн хөрөнгийг ашиглалтад тавих хэмжээнд тогтолцоог сайжруулах тэдийгүй, нөөцийн удирдлагаар хангах боломж бүрдүүлэх.

  - Төрийн сангийн үйл ажиллагааны талаар бүрэн мэдээлэл өгөх шаардлага хангахуйц бүртгэлийн тогтолцоог бүрдүүлэх.

2.1.4.Төрийн санхүүгийн бүртгэлийг олон улсын стандартад нийцүүлэх

Олон улсын стандартад нийцэхүйц Засгийн газрын санхүүгийн тайлан, бүртгэлийн тогтолцоог бий болгох. Энэ хүрээнд дараахь арга хэмжээг авах. Үүнд:

- Дансны нэгдсэн төлөвлөгөө боловсруулах.

Дансны нэгдсэн төлөвлөгөөг Олон улсын хэмжээнд мөрдөгдөж буй Засгийн газрын Санхүүгийн Тайлан Мэдээ (GFS)-тэй нийцүүлэн боловсруулах бөгөөд Төрийн сан болон төсөвт байгууллага бүр энэхүү дансны төлөвлөгөөг ашиглах. Сумд тайлан мэдээгээ мөн энэ загвараар гаргаж ирүүлэх журамд шилжүүлэх.

  - Төсвийн бүх шатны байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагааг хамруулсан мэдээллийн сүлжээг бий болгох. Үүнд сум, аймаг, нийслэл, яам бүр холбогдох.

Төрийн сангийн удирдлагын нэгдсэн мэдээллийн сүлжээ бий болсноор СЭЗЯ нь төсвийн бүх шатны мэдээллийг шаардлагатай цаг үедээ

авах, төсвийн зарцуулалтад тухай бүр хяналт тавих боломжтой болох бөгөөд санхүүгийн удирдлагаар шуурхай зохицуулах нөхцөлөөр хангагдах. Нөгөө талаас уг сүлжээтэй холбогдсон байгууллагуудад төсвийн мэдээллийг ашиглах боломжийг олгож байгаа нь төсвийн ил тод байдлыг хангах нэг нөхцөлийг бүрдүүлэх юм. Энэхүү сүлжээнд Төр, засгийн үйлчилгээний болон нийтийн үйлчилгээний 5000 орчим байгууллагууд хамрагдах юм.

- Санхүүгийн удирдлагын иж бүрэн тогтолцоог бүрдүүлэхэд чиглэсэн зөр зүйн орчныг бий болгох.

Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг Олон улсын жишигт нийцүүлэх.

Засгийн газрын бүртгэлийг шинэчлэх явцад тулгарч болох хүндрэлүүдийг даван туулахын тулд дараахь арга хэмжээг авах. Үүнд:

1. Засгийн газар нь хөрөнгийн бүртгэл болон түүнтэй холбоотой гарч буй зардал, өөрчлөлтийн талаар хангалттай бүртгэл, мэдээлэлтэй байх. Үүний тулд дараахь алхмуудыг нэн тэргүүнд хэрэгжүүлэх шаардлагатай:
   - Бүх хөрөнгө тодорхойлох
   - Эзэмших эрхийг шалгаж тодруулах
   - Хөрөнгийн ертгийг тодорхойлох
2. Засгийн газрын бүртгэлийн талаар бодлого боловсруулж хэрэгжүүлэх
3. Бүртгэлийн зохистой тогтолцоог бүрдүүлэх
4. Санхүүгийн мэдээллийг боловсруулагчид болон ашиглагчдыг зохих сургалтад хамруулан ур чадварыг дээшлүүлэх.

2.1.5.Өрийн удирдлагыг шинэчлэх
Гадаад өрийн удирдлага

Гадаад өрийн удирдлагыг сайжруулах чиглэлээр дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэх. Үүнд:

- Гадаадын зээл, тусламжийг зохицуулах хуулийг боловсруулан гаргаж, өр, зээлийн асуудлыг зохицуулахтай холбогдсон дүрэм журмыг боловсруулж нэвтрүүлэх;
- Эдийн засагт гадаад зээлийг шингээх чадвар, төлбөрийн даацтай уялдуулан зээлийн жилийн хэрэгцээнд хязгаарлалт тогтоож мөрдүүлэх;
- Дамжуулан зээлдүүлэх гэрээгээр хугацаа хэтэрсэн зээлийн авлагыг цуглуулахдаа татварын байгууллагуудыг татан оролцуулах;
- Өрийн удирдлагын мэдээллийн сүлжээ байгуулах;
- УИХ-аас баталж гадаад орнууд, олон улсын байгууллагаас авсан 1990 оноос хойшхи зээлийн гэрээ болон түүний үндсэн өрийн төлбөрийг он тус бүрээр гаргаж, биелэлтийг тооцох;
- Төслүүдийн хэтийн зорилгод урьдчилсан үнэлгээ хийх, өртөг, үр ашгийн дүн шинжилгээ хийх, ач холбогдлын зэрэглэлийг тогтоох зэрэг ажлыг чанартай гүйцэтгэх, зээл авахын төлөө явж ирсэн хуучин зарчмыг халах механизмуудыг тогтоон хэрэглэх.

Дотоод өрийн удирдлага

Дотоод өрийн удирдлагын тогтолцоог сайжруулах ажлын хүрээнд дараахь арга хэмжээг авах. Үүнд:

- Өрийг төсөв, жилийн дундаж зарлагын хөтөлбөр, зээлийн бодлоготой уялдуулсан байх, төсвийн бодит хэрэгцээ, үнийн өсөлттэй нягт уялдулан төлөвлөх;
- Төсвийн алдагдал бага үед Засгийн газрын өр төлбөрийг барагдуулах арга хэмжээг түлхүү авах замаар Засгийн газарт итгэх итгэлийг сайжруулах;
- Өр, авлагыг нягтлан бодох бүртгэл, тайлан балансад тодорхой харуулах үүднээс аккруэл бүртгэлийн аргачлалд үе шаттайгаар шилжих;
- Иргэд, аж ахуйн нэгжүүдийн хаяг, хөдөлгөөн, санхүүгийн чадавхийн бүртгэлийн санг мэдээллийн орчин үеийн технологиор автоматжуулах ажлыг гадаад орон, олон улсын байгууллагуудтай хамтран судалж, тодорхой үе шаттайгаар хэрэгжүүлэх талаар санал боловсруулах;
- Засгийн газрын цэвэр зээлийн үлдэгдлийг хуульд заасан хэмжээнээс хэтрүүлэхгүй байх.

2.1.6.Засгийн газрын үнэт цаасны зах зээлийн ажиллагааг өргөжүүлэх

Засгийн газрын Үнэт цаасны хөрвөх чадвар болон төлбөрийн баталгаагаа сайжруулах, харилцагчдын итгэлийг төрүүлэхэд чиглэсэн цогцолбор арга хэмжээ авч, үнэт цаасыг хөрөнгийн зах зээл дээр борлуулах замаар төсвөөс гарах хүүгийн зардлыг хямдруулах;

Засгийн газрын үнэт цаасыг борлуулахтай холбогдсон эрх зүйн орчныг боловсронгуй болгох. Тухайлбал, үнэт цаас гаргах замаар төсвийн түр зуурын алдагдлыг уян хатан, шуурхай зохицуулах үүднээс Үнэт цаасны хуульд өөрчлөлт оруулах.

2.2.Мөнгөний бодлого, зохицуулалт, банкны бүтцийг сайжруулах

2.2.1.Мөнгөний бодлого, зохицуулалт

Төв банк мөнгөний агрегатын зохицуулалтын боловсронгуй шууд бус хэлбэр-нээлттэй захын аргыг шатлан нэвтрүүлэх бодлого явуулах. Үүний тулд:

- Төв банкны үнэт цаас (ТБҮЦ)-ны хэмжээ, хүүгийн түвшинг инфляцийн хяналттайгаар бууруулах зохицуулалт хийж, Засгийн газрын үнэт цаас (ЗҮЦ)-ны үүргийг санхүү, мөнгөний зах зээлд нэмэгдүүлэх;
- Төв банкнаас үнэт цаас гаргах, түүнд төрөөс хяналт тавих эрх зүйн орчныг бий болгох;
- Арилжааны банк дахь Засгийн газрын өрийн бичиг, бондыг төрийн өмчлөлийн тодорхой нэгж, нэр заасан хөрөнгө, түүний хувьцааны багцаар барьцаалах, өмчлөх эрхийн харилцааг бий болгож, үүнтэй цаасыг хөрвөх чадвартай сайжруулах;
- Зээлийг бүцаан төлүүлэх, олгогдсон зээлд зээлдэгчид эдийн хариуцлага хүлээдэг зарчмыг хуульчлах замаар мөрдөж байгаа хууль тогтоомжид энэ чиглэлээр өөрчлөлт оруулан хэрэгжүүлэх;
- Зээлийн эрсдэлийг бууруулахад шүүх үйл ажиллагаат шүүхэй болгох талаар хуулийн зарим заалтыг өөрчлөх;
- Өрийн биржийг дотоод зах зээлд зохион байгуулж, зээлийн ер төлөлтөд уян хатан орчныг бүрдүүлэх;
- Зээлийн ер барагдуулах албаны эрх зүйн статусыг тогтоож, бүтцийн шинэчлэлт хийх;
- Итгэлцлийн гэрээ (Trust)-ний хууль гаргаж, үг гэрээгээр хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлэх эрх зүйн орчин бүрдүүлэх талаар арга хэмжээ авах;
- Төрийн мөнгөний бодлогыг улс орны эдийн засаг, нийгмийн хөгжлийн бодлого, зорилттой нягт уялдуулах үүднээс мөнгөний бодлогын үндэсний зөвлөл, банкны зөвлөлийг байгуулж, энэ чиглэлд бодлого тодорхойлох, уялдуулах түвшинд ажиллуулах;
- Банк хоорондын захын талаар эрх зүйн орчныг бий болгож, түүнийг байгуулж цаашид хөгжүүлэх;
- Шүүхийн шийдвэр биелүүлэгч болон барьцаа хөрөнгийг борлуулах ажлыг гүйцэтгэгч хүмүүсийг мэргэжлийн сургалтад хамруулах ажлыг Засгийн газраас зохион байгуулах;
- Хууль зүй, дотоод хэргийн ямны компьютер, сүлжээний системийг суурилуулж дуусгах.

2.2.2.Банкны тогтолцоо

1/Төрийн өмчийн оролцоотой банкуудыг хувьчлахад бэлтгэж тухайн банкуудыг дотоод, гадаадын нэр хүнд бүхий стратегийн хөрөнгө оруулагчдад хувьчилж удирдлага, дотоод хяналтын тогтолцоог боловсронгуй болгох;

2/Системийн хэмжээний төвлөрлийн эрсдэлийг бууруулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх, энэ талаархи зохицуулалтыг холбогдох хууль тогтоомжид оруулах;

3/Бэлэн мөнгөний гүйлгээг хязгаарлах, Монгол Улсын нутаг дэвсгэр дээр гүйлгээ хийхэд тохиромжтой бэлэн бус төлбөр тооцооны арга хэрэгслийн үйлчилгээг нэвтрүүлэх арга хэмжээ авах;

4/Монгол Улсын эдийн засгийг бүсчлэн хөгжүүлэх үзэл баримтлалтай уялдуулан санхүүгийн үйл ажиллагааг хөгжүүлэх асуудлыг судлах;

5/Монгол банкны Зээлийн мэдээллийн сангийн үйл ажиллагаог боловсронгуй болгох, холбогдох яам, газартай харилцан мэдээлэл солилцох техникийн болон зохицуулалтын механизмыг сайжруулах;

6/Мөнгөн хадгаламжийн даатгалын тогтолцоог бүрэлдүүлж, нэвтрүүлэх арга хэмжээ авах;

7/Засгийн газрын нэр дээр хандивлагч орон болон олон улсын байгууллагуудаас хандивласан, эсхүл хөнгөлөлттэй зээл хэлбэрээр оруулж байгаа хөрөнгийг төвлөрүүлэх замаар стратегийн ач холбогдол бүхий салбаруудыг санхүүгийн эх үүсвэрээр хангахад чиглүүлэх хөгжлийн банкийг төрийн дэмжлэгээр байгуулах асуудлыг судлах;

8/Гадаадын болон гадаадын хөрөнгө оруулалттай банк, тэдгээрийн салбар нэгж, төлөөлөгчийн газыг Монголын санхүүгийн зах зээл дээр үйл ажиллагаа явуулах нөхцөлийг бүрдүүлэх, эрх зүйн орчныг боловсронгуй болгох;

9/Банкуудын санхүү төлбөрийн чадварын үндэсэн үзүүлэлтүүд, ялангуяа өөрийн хөрөнгө эрсдэлээр жигнэсэн активын зохистой харьцаа нь тогтоосон хувь хэмжээнээс буурсан нөхцөлд Төв банкнаас шат дараатайгаар авч хэрэгжүүлэх албадлагын арга хэмжээг хууль тогтоомжид тусгах.

2.2.3.Банк бус санхүүгийн байгууллагын тогтолцоо /ББСБ/

1/ББСБ-ын тухай тодорхой ойлголт, нэр томъёо, хяналт, зохицуулалтын талаархи орчныг эрх зүйн үүднээс боловсронгуй болгон, ББСБ хөгжих таатай нөхцөлийг бүрдүүлэх;

2/Ломбард, зээлийн үйл ажиллагаа эрхэлдэг сангууд (төрийн бус байгууллага), олон шатлалт маркетингийн хэлбэртэй мөнгө үржүүлэгч байгууллагуудын хяналт, эрх зүйн зохицуулалтыг бий болгох;

3/Хөдөө орон нутагт ажлын байр нэмэгдүүлэх, жижиг бизнес эрхлэгчдийн санхүүгийн үйл ажиллагаат дэмжих, төлбөр тооцоог шуурхай гүйцэтгэх зорилгоор ББСБ-ыг хөдөө орон нутагт түлхүү хөгжүүлэх, үүний тулд хот суурин газарт байгуулагдах ББСБ-тай харьцуулахад илүү таатай орчин нөхцөл бүхий байхаар үйл ажиллагаат нь зохицуулах;

4/Хөдөө орон нутагт санхүүгийн зуучлалыг нэмэгдүүлэхийн тулд хадгаламж зээлийн хоршоо /ХЗХ/-нд болон бусад санхүүгийн зуучлалын үйл ажиллагааны талаар олон нийтэд сурталчлах арга хэмжээг зохион байгуулах;

5/ББСБ-ын үйл ажиллагаат өргөжүүлэх, үр ашигтай явуулах нөхцөлийг ханган үүднээс төрийн зүгээс татварын бодлогоор дэмжих, болзошгүй алдагдлын сан гэх мэтээр хөнгөлөлтөд хамаарууллах.

2.2.4.Банкны хяналт шалгалт, бүртгэл,аудитын тогтолцоо

1/Монгол банкны хяналт шалгалтын зэрэгцээ банкны хувь нийлүүлэгчид, Төлөөлөн удирдах зөвлөл, Хянан шалгагчдын зөвлөл, Дотоод хяналтын алба, харилцагч, хадгаламж эзэмшигчдийн хяналт дээр үндэслэсэн хамтын / corporate/ удирдлагын тогтолцоог банкуудад мөрдүүлэх;

2/Банкны дотоод хяналт нь банкны үйл ажиллагааны болон бусад эрсдэлийг удирдаж байгаа байдалд дүгнэлт өгөхөд Монгол банкны хяналт шалгалтыг чиглүүлэх;

3/Банкны хяналт шалгалтын олон улсын шинэ стандартуудыг нэвтрүүлэх;

4/Бүртгэл, төлбөр тооцоонд тавих хяналтыг чангатгах, энэ чиглэлээр бодлого тодорхойлогч Банкны байгууллагын нягтлан бодох бүртгэл, төлбөр тооцооны зөвлөлийн үйл ажиллагааг боловсронгуй болгох;

5/Аудитын тогтолцоог олон улсын түвшинд хүргэх, холбогдох хууль тогтоомжид шаардлагатай нэмэлт, өөрчлөлт оруулах;

6/Олон улсын бүртгэлийн стандарт /IAS/-д тулгуурласан банкны бүртгэлийн үндэсний стандарт нэвтрүүлэх;

7/Санхүүгийн байгууллагуудад хяналт шалгалт явуулдаг хяналтын байгууллагуудын ажлын уялдаа холбоог сайжруулах, эрх бүхий төрийн хяналтын байгууллагууд хамтран олон улсын зарчимд тулгуурлан нэгдсэн хяналт шалгалт явуулах нөхцөл боломжийг судалж, шийдвэрлүүлэх.

2.2.5.Бусад

1/Банкны сургалтын төвийн үйл ажиллагаа, гадаад харилцааг өргөжүүлэх, боловсронгуй болгох.

2.3.Үнэт цаасны зах зээлийг хөгжүүлэх

Үнэт цаасны зах зээлийг хөгжүүлэх шаардлага:

Сул чөлөөтэй хөрөнгийн хуримтлалыг үнэт цаасны зах зээлд татан оруулснаар төсвийн орлогыг нэмэгдүүлэх, мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх, компани хуулийн этгээдийн үйлдвэрлэл, үйлчилгээг өргөтгөн шинэчлэх, урт, богино хугацааны томоохон төсөл хэрэгжүүлэх шууд хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг бий болгож байгаа бөгөөд хөрөнгө оруулалтын бодлого, үйлдвэрлэл, техник технологийн хөгжил дэвшлийн дэлхий нийтийн цаашдын чиг хандлагыг үнэт цаасны зах зээлгүйгээр төсөөлөхийн аргагүй болсон нь түүнийг хөгжүүлэх шаардлагатайг нотлон харуулж байна.

2.3.1.Үнэт цаасны зах зээлийн харилцааны төрийн зохицуулалтыг сайжруулах

Эдийн засгийг макро түвшинд тогтворжуулах, алангуяа төсвийн алдагдал, инфляци, хүүгийн бодит хувь хэмжээг боломжийн хэрээр бууруулах, банкны системийг эрүүлжүүлэх, гадаад худалдааны алдагдлыг бууруулах, эдийн засгийн бүх салбарт үр ашгийг нэмэгдүүлэх чиглэлээр бүтцийн өөрчлөлтөд хамруулах шаардлагатай. Үүнд:

1/Хувьчлалын хөтөлбөрийг хөрөнгийн зах зээлийн хөгжлийн бодлоготой уялдуулах;

Хөрөнгийн биржид бүртгэлтэй төрийн мэдлийн хувьцаат том, жижиг багц болгон зарим хэсгийг цөөн тоогоор биржээр дамжуулан худалдах бодлого боловсруулах.

2/Үнэт цаасны зах зээлийн хөгжлийн үзэл баримтлалыг оновчтой тодорхойлох, түүнийг хэрэгжүүлэх арга замуудыг боловсруулах, төрийн хүчтэй бодлогоор дэмжих замаар үнэт цаасны зах зээлийг цаашид хөгжүүлэх шаардлагатай бөгөөд үзэл баримтлалыг хэрэгжүүлэх хүрээнд дараахь асуудлуудыг шийдвэрлэх хэрэгтэй байна. Үнэт цаасны зах зээлийг зохицуулах эрх зүйн орчинг боловсронгуй болгох, Үүнд: "сул чөлөөтэй менген хөрөнгийг хөрөнгө оруулалтад ашиглах, үнэт цаасны зах зээлийн оновчтой дэд бүтцийг бүрдүүлэх, төрийн оролцоо, хяналт зохицуулалтын үр ашигтай, хэмнэлттэй механизмыг бий болгох, төрийн байгууллагуудын ажил үүргийн хуваарийг тодорхой зааглах, хариуцлагын хүчтэй тогтолцоог бий болгох" чиглэлээр Үнэт цаасны тухай хуулийг, "хувьцааны хяналтын багц хэмжигчдээс жижиг хувьцаа эзэмшигчдэд шударга бус шахалт дарамт үзүүлэх бололцоог хаах, бага хэмжээний хуримтлал, хадгаламжийг хөрөнгө оруулалтад татах таатай нөхцөлийг бүрдүүлэх" чиглэлээр Компаниин тухай хуулийг, "ашиг орлого нэмэгдэх тутам татвар төлөх хувь хэмжээ ихэсдэг өнөөгийн зарчмыг арилгах" чиглэлээр Татварын багц хуулиудыг тус тус өөрчлөх, шаардлагатай хуулиудын төслийг шинээр боловсруулах, үүнтэй уялдуулан холбогдох журам зааврүүдыг шинэчлэх;

3/Хөрөнгийн зах зээлийн мэдээллийн тогтолцоог бүрдүүлэх, үнэт цаас гаргагчид, үнэт цаасны зах зээлийн мэргэжлийн болон дэд бүтцийн байгууллагад олон улсын санхүүгийн бүртгэлийн стандарт нэвтрүүлэх, анхан шатны бүртгэлийг шаардлагын түвшинд хүртэл сайжруулах, бүртгэл, аудитын ажилтнуудын хариуцлагыг өндөржүүлэх чиглэлээр Нягтлан бодох бүртгэлийн болон Аудитын хуульд өөрчлөлт оруулах;

4/Хөрөнгө оруулагчдын ашиг сонирхлыг хамгаалах хөтөлбөр боловсруулан мөрдөх.

2.3.2.Үнэт цаасны зах зээлийн мэдээлэл, сургалт, сурталчилгааг боловсронгуй болгох

Хөрөнгийн зах зээлийн талаар дор дурдсан хэлбэрийг ашиглан нийтийг хамарсан сургалт сурталчилгаа явуулах:

- Үнэт цаасны хороо хариуцан радио, телевизээр сурталчлах. Үнэт цаасны хороо, Засгийн газраас сонирхогч төрийн бус байгууллагатай хамтран олон нийтэд зориулсан сургалт явуулах хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх;
- Үнэт цаасны хорооны дэргэд сургалт, сурталчилгааны төв байгуулах асуудлыг ESP2 хөтөлбөрийн матрицад тусган хэрэгжүүлэх;
- Үнэт цаасны хороо, Хөрөнгийн биржийн, Үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбооноос эрхлэн олон нийтийн тодорхой хэсэгт, ялангуяа бизнес эрхлэгчдэд зориулсан семинар уулзалтуудыг өргөнөөр зохион байгуулах;
- МХБ-ээс эрхлэн нийтэлдэг мэдээллийн тоо хэмжээ, чанарыг олон улсын стандартад нийцүүлэн боловсронгуй болгох;
- Үнэт цаасны хороо, Засгийн газраас хөрөнгийн зах зээлийн талаар тайлбар мэдээлэл хийх чиглэлээр сэтгүүлчидийг, үнэт цаасны зах зээлтэй холбоотой асуудлыг шийдвэрлэх чиглэлээр хууль хяналтын байгууллагын ажилтнуудыг сургаж мэргэшүүлэх ажил зохион байгуулах.

АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлагийн шугамаар хөрөнгийн зах зээлийн сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэх асуудлыг АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлаг болон Японы "ЖАЙКА"-д тавих.

Үнэт цаасны зах зээлийг зохицуулах хууль эрхийн актуудад зохих нэмэлт, өөрчлөлт оруулах, шинээр боловсруулах ажлын хэсэг байгуулж түүний гишүүдийг сургалтад хамруулах, АНУ-ын Үнэт цаасны комиссоос хөгжиж буй орнуудын үнэт цаасны зах зээлийг зохицуулах үүрэг бүхий байгууллагуудын шийдвэр гаргах түвшний ажилтнуудад зориулан жил бүр зохион явуулдаг семинарт оролцуулах асуудлыг АНУ-ын Үнэт цаасны комисст тавих.

- Үнэт цаасны хорооны төсөвт олон нийтэд зориулсан сургалт, сурталчилгаа явуулах, семинар зохион байгуулах, товхимол бэлдэхэд зориулсан зардлыг жил бүр тусгаж байх, мэдээллэл харилцааны хэлтэстэй болгох, мэдээллийн нэгдсэн сүлжээнд хамруулах.
- Үнэт цаасны хороо, Хөрөнгийн биржийн гадаад харилцааг өргөжүүлэх арга хэмжээ авах.

Үнэт цаасны хороо, Хөрөнгийн бирж, үнэт цаас

гаргагч бизнесийн байгууллагуудын удирдлага гэсэн 3 үндсэн чиглэлээр тодорхой хөтөлбөрөөр сургалт зохион байгуулах.

Үнэт цаасны хороотой хамтран үнэт цаасны зах зээлийн мэдээллийн тогтолцоо бүрдүүлэх хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх.

2.3.3.Үнэт цаасны зах зээлийн эрэлт, нийлүүлэлт

- Хувьчлагдах томоохон компаниудын Хөрөнгийн биржид бүртгэлтэй хувьцаат Хөрөнгийн биржээр дамжуулан худалдах бодлого боловсруулан хэрэгжүүлэх.
- Хувьчлагдах компанийн хувьцааны хяналтын багцыг стратегийн хөрөнгө оруулагчдад худалдах замаар компанийн удирдлагыг сайжруулах боломж бүрдүүлэхийн зэрэгцээ үлдэх хэсгийг олон нийтэд худалдаж үнэт цаасны нийлүүлэлтийг нэмэгдүүлэх.
- Томоохон компаниудыг хувьчлахдаа энгийн хувьцаанд нь урт хугацаатай опцион гаргаж, опцион эзэмшигчид тухайн компанийн энгийн хувьцааг урьдчилан тодорхойлсон үнээр тодорхой цаг хугацааны дараа худалдан авах эрх зүйн орчныг бүрдүүлэх.
- Засгийн газрын бондыг урт хугацаатай хөрвөх чадвартай болгох асуудлыг шийдвэрлэж уг бондын арилжаанд иргэд, хуулийн этгээд нийтлэг оролцох эрх зүйн орчныг бүрдүүлэх; Засгийн газрын үнэт цаасыг үнэ цэнэтэй үйлдвэрүүдийн хувьцаагаар барьцаалах, эсвэл шууд өмчлөх эрхийг олгосон хувьцаа гаргах.
- Компаниуд шинээр болон нэмж үнэт цаас, хөрвөх баталгаатай өрийн бичиг гаргах, эдгээр үнэт цаасыг гаргагчдын төлбөрийн баталгаанд үнэлгээ хийх тогтолцоог бүрдүүлэх.
- Иргэдийн урт хугацаатай хадгаламж, хөрөнгө оруулалтын болон тэтгэвэр, даатгалын сангийн хөрөнгийг үнэт цаасны зах зээлд татан оруулах эрх зүйн орчныг бүрдүүлэх.
- Хувьцаа /жижиг/ эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах механизмыг бүрдүүлэх, хувьцаат компаниуд, үнэт цаасны компани /брокерийн пүүсүүд/-уудын ажлыг шалгах, баримтын шалгалт хийх. Энэ талаар хувьцаа эзэмшигчдээс гарч байгаа өргөдөл, гомдлыг түргэн шуурхай, үнэн зөвөөр барагдуулахад анхаарах.
- Компаниуд хуулиар хүлээсэн үүргээ хэрэгжүүлэх хариуцлагын тогтолцоог чангатгах чиглэлээр "Компанийн тухай хууль"-д өөрчлөлт оруулах асуудлыг судлах.
- Гадаадын хөрөнгө оруулагчдыг үнэт цаасны зах зээлд татан оролцуулах бодлого боловсруулж, эрх зүйн орчин бүрдүүлэх;
- Гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдыг эрсдэлээс хамгаалах, урамшуулах ижил тэгш нөхцөл бүрдүүлэх.

2.3.4.Үнэт цаасны зах зээлийн дэд бүтэц

Хөрөнгийн зах зээлийн дэд бүтцэд үнэт цаасны арилжаа эрхэлдэг Хөрөнгийн биржээс, төлбөр тооцооны болон төвлөрсөн хадгаламжийн байгууллага ордог:

а/Хөрөнгийн биржийн санхүүжилт, санхүүгийн чадварыг дээшлүүлэх;

б/Хөрөнгийн биржийн хувьчлах бэлтгэлийг хангах;

в/Төлбөр тооцоо, хадгаламжийн төвийг бие даасан байгуулага болгон хувьчлах бэлтгэлийг хангах;

г/Хөрөнгө оруулалтын банк, андеррайтерийн үйлчилгээ эрхлэх, санхүүгийн байгууллага бий болгох асуудлыг судлах, холбогдох арга хэмжээ авах;

д/хөрөнгийн зах зээлийн мэдээллийн сүлжээ бий болгох;

е/брокер, дилерүүдэд тавих шаардлагыг өндөржүүлэх, энэ чиглэлээр мэргэжилтэн бэлтгэх асуудлыг их сургууль, коллежийн сургалтын программд холбогдох өөрчлөлт оруулах болон гадаадад сургах замаар шийдвэрлэх.

- Үнэт цаасны хорооноос зохион байгуулах брокер, дилерүүдэд эрх олгож буй одоогийн системийг өөрчлөх ажилд дэмжлэг үзүүлэх. Үнэт цаасны зах зээлийн мэргэжилтнүүд эдийн засаг, санхүүгийн өндөр мэдлэгтэй, зах зээлийн гүнзгийрүүлсэн судалгаа хийх чадвартай, үйлчлүүлэгчдэд хэрэгтэй мэдээллийг тэдний хэрэгцээнд нийцүүлэн боловсруулах чадвар эзэмшсэн байх шаардлагыг хангах үүднээс тэдэнд зориулсан мэргэжил дээшлүүлэх сургалтын тогтолцоо бүрдүүлэх;

- Хөрөнгийн зах зээлийн мэдээллийг нийтийн хүртээл болгох компанийн хуулиар тогтоосон мэдээллийг гаргаж толилуулаагүй тохиолдолд үнэт цаасыг нь бүртгэлээс хасах хүртэл арга хэмжээ авч байх. Жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хохироохгүй байх эрх зүйн орчныг бүрдүүлэх.
- Хөрөнгийн зах зээлийг урт хугацааны стратегийн үндсэн дээр хөгжүүлэхийн тулд хөрөнгө оруулалтын банкны үйлчилгээг хөгжүүлэх. Иймд арилжаны банкууд андеррайтерын үйл ажиллагаа эрхлэх боломжийг судлах.

2.4.Даатгалын үйл ажиллагааг боловсронгуй болгох

2.4.1. Даатгалын байгууллагын бүтэц, тогтолцооны шинэчлэл

- Даатгалын зах зээлийн монополът байдлыг арилган, төрийн өмчийн даатгалын компаниудыг задлан хувьчлах;
- Шударга өрсөлдөөн бий болгох, даатгалын бүх талын үйлчилгээ явуулж чадах дотоод, гадаадын даатгалын компанийг монголын даатгалын зах зээлд орж ирэх нөхцөл бүрдүүлэх;
- Даатгалын компани байгуулах дүрмийн сангийн доод хэмжээг хуульд заасан хэмжээнээс нэмэгдүүлэх замаар даатгалын компаниудын санхүүгийн чадварыг нэмэгдүүлэх арга хэмжээ авах, даатгалын компани байгуулах шалгуур үзүүлэлтийг боловсронгуй болгон мөрдүүлэх;
- Даатгалын зах зээлийн багтаамжийг судлан тооцож гаргах;
- Даатгалын компаниудын НББ-ийн хөтлөлтийг олон улсын даатгалын бүртгэлийн жишигт нийцүүлэн боловсронгуй болгох;
- Даатгалын компаниудын хохирол нөхөх нөөцийн санг дотоодын хөрөнгө оруулалтад татан оруулах асуудлаар холбогдох хуулинд өөрчлөлт оруулах;
- Даатгалын талаар нэгдсэн бодлого боловсруулах, даатгалын зах зээлийн судалгаа явуулах, төр, засгийн байгууллагад өөрийн боловсруулсан санал дүгнэлт гаргах, зөвлөмж хүргүүлэх үүрэг бүхий төрийн бус байгууллага-даатгагчдын холбооны үйл ажиллагааг дэмжих;
- Хариуцлагын даатгалын тогтолцоог боловсронгуй болгох бодлогыг төрөөс дэмжиж холбогдох хуулиудад тусгуулах;
- Даатгалын мэдээллийн хангамжийн систем бий болгох;
- Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжүүдийг даатгалд бүрэн хамруулах;
- Олон улсын даатгалын хяналтын байгууллагад гишүүнээр элсэх.

2.4.2. Даатгалын эрх зүйн орчны шинэчлэл

- Даатгалын ерөнхий хуулийг боловсронгуй болгох, даатгалын салбар хуулиуд /Малын даатгалын тухай, Газар тариалангийн даатгалын тухай, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Иргэдийн мөнгөн хадгаламж болон Эд хөрөнгийн даатгалын тухай/-ыг багцаар нь шинээр болон шинэчлэн боловсруулах.
- Даатгалын хууль хэрэгжүүлэх шатанд нэгэнт батлагдсан хуулиа хэрэгжүүлэх механизмыг бий болгох, тухайлбал: Үрийн тариаланг даатгах тухай хуулийг хэрэгжүүлэхийн тулд тодорхой журам боловсруулах, хяналт, шалгалтын хүвааръ гарган даатгагч, даатгуулагчдад хүлээлгэх хариуцлагыг өндөржүүлэх.
- Даатгалын байгууллагын санхүү, төлбөрийн чадварын үзүүлэлтийг тооцох журмыг өөрчлөн тогтоох.
- Заавал болон сайн дурын даатгалын хураамжийн хувь, хэмжээний доод хязгаарыг тогтоох.
- Даатгалын компанийг нийгмийн даатгалыг эрхэлж болох эрх зүйн үндсийг бүрдүүлэх.
- Даатгалын байгууллагын санхүү, төлбөрийн чадварын үзүүлэлтийг тооцох арга зүйг боловсронгуй болгох.

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Хаяг: «Төрийн мэдээлэл» эмхтгэлийн зөвлөл

Улаанбаатар-12 ☎ 329612
Төрийн ордон Индекс 14003

Улсын Их Хурлын Тамгын газрын
Хэвлэх хэсэгт хэвлэв.

☎ 329487



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 33 (220)

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ:

- *Хилийн цэргийн талаар авах зарим арга хэмжээний тухай*
- *Төрийн болон орон нутгийн өмчийн үзлэг, тооллогын дүнгийн тухай*
- *Дансны тогтолцоог журамлах зарим арга хэмжээний тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар

Улаанбаатар хот
2001 он

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот 2001 оны наймдугаар сарын 25 №33 (220)

Гарчиг

Нэг. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

399. Зарим шүүгч, ерөнхий шүүгчийг албан тушаалаас чөлөөлөх тухай Дугаар 31 833
400. Зарим хүмүүсийг шүүгчийн албан тушаалд томилох тухай Дугаар 32 834

Хоёр. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

401. Хилийн цэргийн талаар авах зарим арга хэмжээний тухай Дугаар 126 834
402. Төрийн болон орон нутгийн өмчийн үзлэг, тооллогын дүнгийн тухай Дугаар 127 835
403. Эмнэлгийн болон эм хангамжийн байгууллагуудын өр авлагыг барагдуулах талаар авах зарим арга хэмжээний тухай Дугаар 128 841
404. Бэлэн байдлын зэрэг, хорио цээрийн дэглэмийг өөрчлөх, цуцлах тухай Дугаар 129 841
405. Нэрэмжит болгох тухай Дугаар 130 842
406. Журам батлах тухай Дугаар 131 842
407. Дансны тогтолцоог журамлах зарим арга хэмжээний тухай Дугаар 132 845
408. Дүрэм батлах тухай Дугаар 133 846
409. Журам батлах тухай Дугаар 134 847

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2001 оны 8 дугаар сарын 10-ны өдөр **Дугаар 31** **Улаанбаатар хот**

Зарим шүүгч, ерөнхий шүүгчийг албан тушаалаас чөлөөлөх тухай

Монгол Улсын "Шүүхийн тухай" хуулийн 51 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1, 2 дахь заалтыг тус тус баримтлан, Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн ЗАРЛИГ болгох нь:

Өөрөө хүсэлт гаргасан Тогмидын Мөнхтуяаг Сүхбаатар аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчийн, төрийн өөр ажил, албан тушаалд томилогдох болсонтой холбогдуулан Чултэмийн Сүрэнжавыг Говьсүмбэр аймгийн шүүхийн шүүгч, ерөнхий шүүгчийн Сумъяагийн Доржнамжинг Дорноговь аймгийн шүүхийн шүүгчийн, Цэвээндоржийн Алтанцэцэгийг Говьсүмбэр аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчийн, Шадийгийн Загдаар Булган аймаг дахь сум дундын шүүхийн шүүгч, ерөнхий шүүгчийн, Жигмэддоржийн Долгормаар Дорнод аймгийн Хэрлэн сумын шүүхийн шүүгчийн албан тушаалаас тус тус чөлөөлсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ **Н.БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2001 оны 8 дугаар сарын 10-ны өдөр **Дугаар 32** **Улаанбаатар хот**

Зарим хуульд шүүгчийн албан тушаалд томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн тавин нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэг, "Шүүхийн тухай" хуулийн 6 дугаар зүйлийн 2, 4 дэх хэсгийг тус тус баримтлан, Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн ЗАРЛИГ болгох нь:

Сумьяагийн Доржнамжинг Нийслэлийн Баянзүрх дүүргийн шүүхийн шүүгчийн, Сугарын Өлзийсайханыг Сүхбаатар аймгийн шүүхийн ерөнхий шүүгчийн, Чүлтэмийн Сүрэнжавыг Нийслэлийн Багануур дүүргийн шүүхийн шүүгчийн, Цэвээндоржийн Алтанцэцэгийг Говьсүмбэр аймгийн шүүхийн шүүгчийн, Жигмэддоржийн Долгормааг Дорнод аймгийн шүүхийн шүүгчийн, Бандийн Одонцэцэгийг Сэлэнгэ аймаг дахь сум дундын 3 дугаар шүүхийн ерөнхий шүүгчийн, Шадийгийн Загдаагаа Булган аймгийн шүүхийн шүүгчийн, Лхамсүрэнгийн Батжаргалыг Дорнод аймгийн Хэрлэн сумын шүүхийн шүүгчийн, Буянтогтохын Сугаржавыг Дундговь аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчийн, Совдын Мөнхбаярыг Завхан аймаг дахь сум дундын 1 дүгээр шүүхийн шүүгчийн, Банзайгийн Манлайбаатарыг Дархан-Уул аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчийн, Шонхойгийн Оюунтуулыг Сэлэнгэ аймаг дахь сум дундын 3 дугаар шүүхийн шүүгчийн, Доржхорлоогийн Оюунжаргалыг Төв аймаг дахь сум дундын 1 дүгээр шүүхийн шүүгчийн, Очирбатын Номуулинг Говьсүмбэр аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчийн, Баттулгын Бадрахгэрэлийг Ховд аймаг дахь сум дундын 2 дугаар шүүхийн шүүгчийн албан тушаалд тус тус томилсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ **Н.БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 6 дугаар сарын 11-ний өдөр **Дугаар 126** **Улаанбаатар хот**

Хилийн цэргийн талаар авах зарим арга хэмжээний тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 30 дугаар зүйлд заасны дагуу болон Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Батлан хамгаалахын их сургуулийн Хилийн цэргийн дээд сургуулийг одоогийн ашиглаж байгаа хөрөнгө, орон тоо, Батлан хамгаалахын их сургуулийн 2001 оны нэгдсэн төсвөөс тус сургуульд хуваарилагдсан төсвийн гүйцэтгэлийн дараахь үлдэгдлийн хамтаар Хилийн цэргийг удирдах газрын мэдэлд шилжүүлэхийг Батлан хамгаалахын сайд Ж.Гүррагчаа, Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдорж нарт даалгасугай.

2. Төрийн өмчийн 13 дугаар байрыг Хилийн цэргийн дээд сургуулийн эзэмшилд шилжүүлэхийг Төрийн өмчийн хорооны дарга Л.Пүрэвдоржид, уг байрны засварт зарцуулсан 20.5 (хорин сая таван зуун мянган) сая төгрөгийг 2001 оны төсөвтөө багтаан түрээслэгчдэд нь нөхөн олгохыг Хилийн цэргийг удирдах газрын дарга П.Сүндэвт тус тус даалгасугай.

3. Хилийн цэргийн "Хилчин" хамтлагийг дуу, бүжгийн чуулга болгон өргөтгөн зохион байгуулах арга хэмжээг хилийн цэргийн батлагдсан төсөвт багтаан авахыг Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдоржид зөвшөөрсүгэй.

4. Улсын хил хамгаалалтад онц шаардлагатай байгаа "МИ-8" нисдэг тэргийг 2001 оны төвлөрсөн төсвийн хөрөнгө оруулалтаар Хилийн цэргийг удирдах газарт олгох арга хэмжээ авахыг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаанд даалгасугай.

5. Хилийн хороо, суманг зайлшгүй шаардлагатай шалгалтын болон түүгээ зориулалтын техник хэрэгслээр тэргүүн эгнэжинд хангах, Улаанбаатар хот дахь 36, Сэлэнгэ аймгийн Сүхбаатар суман дахь 58, Хөвсгөл аймгийн Мөрөн суман дахь 24 айлын орон сууцны барилгыг гүйцээн барихад шаардагдах хөрөнгө оруулалтын зардлыг жил бүрийн төсөвт туссан санхүүжүүлэх арга хэмжээг 2002 оноос эхлэн авч хэрэгжүүлэхийг Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдорж, Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаан нарт даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД **Ц.НЯМДОРЖ**

САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН САЙД **Ч.УЛААН**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 6 дугаар сарын 11-ний өдөр | Дугаар 127 | Улаанбаатар хот

Төрийн болон орон нутгийн өмчийн үзлэг, тооллогын дүнгийн тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1, 8 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Төвлөрсөн төсвийн хөрөнгө оруулалттай төсөл, гадаадын зээл, тусламжийн судалгаат нарийвчлан гаргаж тэдгээрийн хүрээнд шинээр бий болсон төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийг үнэлэх, бүртгэх, ашиглалт, хамгаалалтыг сайжруулах арга хэмжээ авахыг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаан, Төрийн өмчийн хороо (Л.ПҮРЭВДОРЖ), аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

2. 1997, 2001 оны төрийн өмчийн үзлэг, тооллогоор маргаантай өмчийн бүртгэлд орсон 1 дүгээр хавсралтад заасан байгууллагуудын хөрөнгөд төсвөөс хөрөнгө оруулалт хийгдсэн эсэхийг хянан үзэж өмчлөгчийн эрхийг нь баталгаажуулах асуудлыг эцэслэн шийдвэрлэхийг Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдорж, Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаан, Төрийн өмчийн хороо (Л.ПҮРЭВДОРЖ)-нд даалгасугай.

3. "Аймаг, нийслэлийн өмчлөлд эд хөрөнгө шилжүүлэх тухай" Улсын Их Хурлын 1999 оны 29 дүгээр тогтоолоор орон нутгийн өмчлөлд шилжсэн боловч нэгдсэн бодлогоор зохицуулагдаж төрийн өмчлөлд байх ёстой 2 дугаар хавсралтад дурдсан зарим байгууллага, аж ахуйн нэгжийг төрийн мэдэлд шилжүүлэн авах асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу эрх бүхий байгууллагад нь тавьж шийдвэрлүүлэхийг холбогдох сайд, Төрийн өмчийн хороо (Л.ПҮРЭВДОРЖ)-нд даалгасугай.

4. Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой байгууллага, аж ахуйн нэгжүүдэд төсөвтэй холбогдож үүссэн өр төлбөрийг барагдуулах талаар тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаан, Төрийн өмчийн хороо (Л.ПҮРЭВДОРЖ)-нд даалгасугай.

5. Төрийн өмчийн хороо (Л.ПҮРЭВДОРЖ)-нд даалгах нь:

а/үзлэг, тооллогод хамрагдаагүй, эзэнгүйдсэн, алдаж үрэгдүүлсэн, тооллогын явцад өмчлөлийн талаар маргаан гарсан 3 дугаар хавсралтад дурдсан эд хөрөнгийн өмчлөгчийг холбогдох яам, аймаг, нийслэлийн Засаг даргатай хамтран нарийвчлан судалсны үндсэн дээр тогтоож, шаардлагатай бол асуудлыг шүүхээр шийдвэрлүүлэх арга хэмжээ авсугай;

б/үзлэг, тооллогын явцад шинээр илрүүлсэн эд хөрөнгийн эзэмшлийг тодруулсны үндсэн дээр үнэлж, бүртгэх ажлыг зохион байгуулсугай.

6. Аймаг, нийслэлийн өмчлөлд байгаа эд хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтад бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах, хувьчлахаар санал болгож байгаа эд хөрөнгийн жагсаалтыг Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэхээр оруулахын өмнө холбогдох яам, тусгай газрын саналыг авч Төрийн өмчийн хороотой зөвшилцөж байхыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

7. Төрийн өмчит зарим аж ахуйн нэгж, байгууллагын эзэмшилд байгаа цөм сүргийн тоо толгойн бүрэн бүтэн байдлыг нарийвчлан тогтоож, өмчлөлийн маргаантай асуудлыг нь шийдвэрлэх, төрийн өмчийн цөм сүргийн малыг эзэмшиж, гардан өсгөн үржүүлж байгаа аж ахуйн нэгж, иргэдтэй гэрээ байгуулан ажиллуулах талаар арга хэмжээ авч, гэрээнийх хэрэгжилтэд хяналт тавин ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуйн сайд Д.Насанжаргал, Төрийн өмчийн хороо (Л.ПҮРЭВДОРЖ)-нд үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН САЙД **Ч.УЛААН**

Засгийн газрын 2001 оны 127 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

ӨМЧИЙН ҮЗЛЭГ, ТООЛЛОГООР МАРГААНТАЙ ӨМЧИЙН БҮРТГЭЛД ОРСОН БАЙГУУЛЛАГУУДЫН ЗАРИМ ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГӨ

№	Аймаг, нийслэлийн нэр	Байгууллага	Хөрөнгийн нэр	Хөрөнгийн үнэ (мян.төг)
		1.Намын байрууд		
1	Дорноговь	Аймгийн МАХН-ын хороо	Аймгийн МАХН-ын хорооны байр	
2	Дундговь	Аймгийн МАХН-ын хороо	Аймгийн МАХН-ын хорооны байр	160.0
3	Завхан	Аймгийн МАХН-ын хороо	Аймгийн МАХН-ын хорооны байр	1439.0
4	Төв	Аймгийн МАХН-ын хороо	Аймгийн МАХН-ын хорооны байр	836.0
5	Увс	Аймгийн МАХН-ын хороо	Аймгийн МАХН-ын хорооны байр	5000.0
6	Улаанбаатар	МАХН	МАХН-ын байр	
7	Улаанбаатар	МАХН-ын авто бааз	МАХН-ын авто баазын байр	
8	Улаанбаатар	МҮАН	МҮАН-ын байр	
9	Улаанбаатар	МоАХ	МоАХ-ны байр	224960.0
		2.Үйлдвэрчний эвлэл, түүний харьяа газрын байрууд		
10	Баянхонгор	Аймгийн ҮЭ-ийн холбоо	Аймгийн ҮЭ-ийн холбооны байр	758.1
11	Дорноговь	Аймгийн ҮЭ-ийн холбоо	Аймгийн ҮЭ-ийн холбооны байр	108.0
12	Дундговь	Аймгийн ҮЭ-ийн холбоо	Аймгийн ҮЭ-ийн холбооны байр	500.0
13	Увс	Аймгийн ҮЭ-ийн холбоо	Аймгийн ҮЭ-ийн холбооны байр	3500.0
14	Улаанбаатар	МҮЭ-ийн төв зөвлөл	МҮЭ-ийн төв зөвлөлийн байр	
15	Улаанбаатар	МҮЭ-ийн соёлын төв	МҮЭ-ийн соёлын төв ордны барилга	
16	Улаанбаатар	Нийслэлийн ҮЭХ	Хотын ҮЭ-ийн холбооны байр	
17	Улаанбаатар	ҮЭ-ийн эрдэм шинжилгээ сургалтын төв	ҮЭ-ийн эрдэм шинжилгээ сургалтын төвийн байр	
18	Улаанбаатар	МҮЭ-ийн авто бааз	МҮЭ-ийн авто баазын байр	
19	Улаанбаатар	Сонгино амралт	Сонгинын хойд амралтын байр	
20	Улаанбаатар	Хөдөлмөрийн дээд сургууль	ҮЭ-ийн цэцэрлэгийн байр	
21	Ховд	Аймгийн ҮЭ-ийн холбоо	Аймгийн ҮЭ-ийн холбооны байр	10000.0

3.Урчуудын эвлэлийн байрууд				
22	Улаанбаатар	Уран бүтээлчдийн урлан	Уран бүтээлчдийн урлангийн байр	59164.7
23	Улаанбаатар	Уран бүтээлчдийн урлан	Уран бүтээлчдийн урлангийн өргөтгөлийн барилга	37323.7
24	Улаанбаатар	Гар урлал, хэвлэлийн урлан	Гар урлал, хэвлэлийн урлангийн байр	59920.0
25	Улаанбаатар	Үзэсгэлэнгийн танхим	Үзэсгэлэнгийн танхимын байр	1840.0
26	Улаанбаатар	Хэвлэл чимэглэлийн үйлдвэр	Хэвлэл чимэглэлийн үйлдвэрийн барилга	
27	Увс	Урчуудын холбоо	Аймгийн урчуудын холбооны барилга	1800.0
4.Батлан хамгаалахад туслах нийгэмлэгийн байрууд				
28	Увс	Батлан хамгаалахад туслах нийгэмлэгийн аймгийн зөвлөл	Батлан хамгаалахад туслах нийгэмлэгийн аймгийн зөвлөлийн байр	10000.0
29	Дундговь	Батлан хамгаалахад туслах нийгэмлэгийн аймгийн зөвлөл	Батлан хамгаалахад туслах нийгэмлэгийн аймгийн зөвлөлийн байр	
30	Улаанбаатар	Батлан хамгаалахад туслах нийгэмлэг	Батлан хамгаалахад туслах нийгэмлэгийн Төв зөвлөлийн байр	
5.Монголын улаан загалмайн нийгэмлэгийн байрууд				
31	Дундговь	Аймгийн Улаан загалмайн нийгэмлэгийн зөвлөл	Аймгийн Улаан загалмайн нийгэмлэгийн байр	219.0
32	Дорноговь	Аймгийн Улаан загалмайн нийгэмлэгийн зөвлөл	Аймгийн Улаан загалмайн нийгэмлэгийн байр	3000.0
33	Ховд	Аймгийн Улаан загалмайн нийгэмлэгийн зөвлөл	Аймгийн Улаан загалмайн нийгэмлэгийн байр	7000.0
34	Улаанбаатар	Монголын Улаан загалмайн нийгэмлэг	Улаан загалмайн нийгэмлэгийн байр	
6.Хөдөө аж ахуйн хоршоологчдын байрууд				
35	Увс	Аймгийн хөдөө аж ахуйн хоршоологчдын холбоо	Аймгийн хөдөө аж ахуйн хоршоологчдын холбооны барилга	1300.0
36	Дундговь	Аймгийн хөдөө аж ахуйн хоршоологчдын холбоо	Аймгийн хөдөө аж ахуйн хоршоологчдын холбооны барилга	22.2
37	Завхан	Аймгийн хөдөө аж ахуйн хоршоологчдын холбоо	Аймгийн хөдөө аж ахуйн хоршоологчдын холбооны барилга	578.0
38	Улаанбаатар	Монголын хоршоологчдын холбоо	Монголын хоршоологчдын холбооны байр	

7.Бусад				
39	Увс	Аймгийн Залуучуудын холбоо	Аймгийн Залуучуудын холбооны байр	1500.0
40	Улаанбаатар	МХЗЭ-ийн Төв зөвлөл (хуучнаар)	Хуучин МХЗЭ-ийн Төв зөвлөлийн байр	
41	Улаанбаатар	Монголын Зохиолчдын эвлэл	Монголын зохиолчдын эвлэлийн байр	10000.0
42	Улаанбаатар	Монголын энх тайван найрамдлын байгууллагуудын холбоо	Монголын Энх тайван найрамдлын ордны барилга	3500.0
Дүн				447975.9

Засгийн газрын 2001 оны 127 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

ОРОН НУТГИЙН ӨМЧЛӨЛӨӨС ТӨРИЙН МЭДЭЛД ШИЛЖҮҮЛЭН АВАХ ТАЛААР САНАЛ БОЛОВСРУУЛЖ ШИЙДВЭРЛҮҮЛЭХ БАЙГУУЛЛАГА, АЖ АХУЙН НЭГЖИЙН ЖАГСААЛТ

№	Аймгийн нэр	Сум, дүүргийн нэр	Байгууллагын нэр	Нийт хөрөнгийн дүн 2001 оны тооллогоор (мян.төг)
1	Архангай	Эрдэнэбулган	Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв	62320.6
2	Баян-Өлгий	Өлгий	Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв	69559.4
3	Баянхонгор	Баянхонгор	Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв	47975.8
4	Булган	Өлзийт	Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв	114970.8
5	Булган	Булган	Эрдэнэсуврага ХК	336730.80
6	Говь-Алтай	Есөнбулаг	Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв	306153.2
7	Дархан-Уул	Дархан	Барилгын шаталсан сургалт үйлдвэрлэлийн төв	49788.8
8	Дархан-Уул	Дархан	Барилгын сургалтын П төв	62030.2
9	Дархан-Уул	Дархан	Зам засвар арчлалтын компани	96399.90
10	Дорноговь	Сайншанд	Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв	20343.7
11	Дорнод	Хэрлэн	Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв	40366.5
12	Дорнод	Хэрлэн	Нэгдсэн эмнэлэг (Бүсийн оношилгоо, эмчилгээний төв)	567456.40
13	Дундговь	Мандалговь	Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв	185116.5
14	Завхан	Улиастай	Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв	22180.2

15	Орхон	Орхон	Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв	46175.3
16	Өмнөговь	Даланзадгад	Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв	37056.2
17	Өмнөговь	Даланзадгад	Баталгаажуулалт эрүүл ахуйн төв	28330.20
18	Өвөрхангай	Нарийнтээл	Баянтээгийн нүүрсний уурхай ХК	113997.30
19	Өвөрхангай	Арвайхээр	Нэгдсэн эмнэлэг (Бүсийн оношилгоо, эмчилгээний төв)	835696.50
20	Сэлэнгэ	Сүхбаатар	Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв	77061.6
21	Төв	Заамар	Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв	107768.1
22	Төв	Зуунмод	Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв	28966.3
23	Төв	Угтаал	Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв	0
24	Увс	Улаангом	Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв	373415.3
25	Ховд	Жаргалан	Нэгдсэн эмнэлэг (Бүсийн оношилгоо, эмчилгээний төв)	592933.90
26	Хөвсгөл	Мөрөн	Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв	66466.3
27	Хөвсгөл	Цэцэрлэг	Могойн гол ХК	366539.40
28	Хөвсгөл	Хатгал	Хөвсгөлийн байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаа	80435.80
29	Хэнтий	Хэрлэн	Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв	116367.22
30	Улаанбаатар	Баянзүрх	Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв	51847.1
31	Улаанбаатар	Баянгол	Нялхсын клиник сувилал	267934.80
32	Улаанбаатар	Баянзүрх	Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэн	515439.30
33	Улаанбаатар	Баянзүрх	Уламжлалт эм, эмийн үргамал компани	87748.30
34	Улаанбаатар	Сүхбаатар	Соёлын төв өргөөний байр	4175503.80
35	Улаанбаатар	Сүхбаатар	Гэгээрэл ач ТӨҮГ	61158.30
Дүн				**10012233.82**

Засгийн газрын 2001 оны 127 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт

ТӨРИЙН ӨМЧИЙН ҮЗЛЭГ, ТООЛЛОГОД ХАМРАГДААГҮЙ, ЭЗЭНГҮЙДСЭН ӨМЧИЙН ТАЛААР МАРГААНТАЙ ЭД ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

№	Аймаг, нийслэлийн нэр	Хөрөнгийн нэр
1.	Булган	Арцат могой ХК
2.	Говьсүмбэр	Материал техникийн хангамжийн газар ТӨҮГ (хуучин нэрээр)
3.	Дархан-Уул	Да-Ит ТӨҮГ
4.	Дорноговь	Карьерын аж ахуй ТӨҮГ
5.	Дорнод	Цав ТӨҮГ
6.	Дорнод	Төв Ази уран ХХК (төрийн оролцоо)
7.	Орхон	"Эрдэнэт" үйлдвэрийн захиргааны контор
8.	Орхон	Эрдэнэхайрхан ХХК
9.	Сэлэнгэ	Цагаан-эрэг орхон ХК
10.	Төв	Уртаалцайдамын 36.0 мянган тоннын үр тарианы элеваторын дуусаагүй барилга
11.	Завхан	Биндэрхайрхан ХХК (Төрийн оролцоо 80%)
12.	Улаанбаатар	Монгол бөхийн өргөөний барилга
13.	Улаанбаатар	Хууль зүйн дунд сургуулийн хөрөнгө
14.	Улаанбаатар	Буга корпораци ТӨҮГ
15.	Улаанбаатар	Хадгаламж банкны тооцооны төвүүдийн түрээсээр эзэмшиж байгаа байрууд
16.	Улаанбаатар	Монгол шуудан компанийн түрээсээр эзэмшиж байгаа байрууд
17.	Улаанбаатар	Уран баримлын нэгдлийн урлангийн байр (Пассаж)
18.	Улаанбаатар	Батлан хамгаалах яамны 80 айлын орон сууц
19.	Улаанбаатар	Хилийн цэргийн 72 дугаар хотхоны зарим барилга, байгууламжууд (181 айлын 3 орон сууц)
20.	Улаанбаатар	Монголын барилгын зураг, төсөл ТӨҮГ
21.	Улаанбаатар	Говьгурвансайхан ХХК (15%)
22.	Улаанбаатар	Монголимпэкс ТӨҮГ
23.	Улаанбаатар	Шинэчлэл банк ХХК

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 6 дугаар сарын 20-ны өдөр Дугаар 128 **Улаанбаатар хот**

Эмнэлгийн болон эм хангамжийн байгууллагуудын өр, авлагыг барагдуулах талаар авах зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Эмнэлгийн байгууллагуудаас "Монголэмимпэкс" концернд төлөх өрийг тус концерноос төвлөрсөн төсөвт төвлөрүүлэх тусламжийн эмийн борлуулалтын орлого, эмийн эргэлтийн төвлөрсөн хөрөнгийн сан, эрүүл мэндийн даатгалын сангаас эмнэлэгт төлөх төлбөрөөс тус тус шилжүүлэн суутгах замаар эмнэлэг, эм хангамжийн байгууллагуудын өр авлагыг энэ оны 7 дугаар сарын 10-ны дотор зохицуулан барагдуулах арга хэмжээ авахыг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаан, Эрүүл мэндийн сайд П.Нямдаваа, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд Ш.Батбаяр нарт даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН САЙД **Ч.УЛААН**

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД **П.НЯМДАВАА**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 6 дугаар сарын 20-ны өдөр Дугаар 129 **Улаанбаатар хот**

Бэлэн байдлын зэрэг, хорио цээрийн дэглэмийг өөрчлөх, цуцлах тухай

Мал эмнэлэг, хүнсний аюулгүй байдал, хөдөө аж ахуйн улсын хяналтын байгууллагын мэргэжилтнүүдээс гаргасан санал, дүгнэлтийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Малын гоц халдварт өвчний цагийн байдалтай холбогдуулан дор дурдсан арга хэмжээг 2001 оны 6 дугаар сарын 21-ний өдрөөс эхлэн хэрэгжүүлэхээр тогтоосугай:

а/Орхон аймгийн Жаргалант, Булган аймгийн Хангал, Сэлэнгэ аймгийн Баруунбүрэн сумын нутаг дэвсгэрт дагаж мөрдөж байгаа иргэний хамгаалалтын бүх нийтийн бэлэн байдлын зэргийг өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэг, хорио цээрийн онцгой дэглэмийг хорио цээрийн хязгаарлалтын дэглэм болгон тус тус өөрчлөх;

б/Орхон аймгийн Баян-Өндөр, Булган аймгийн Орхон, Бугат, Сэлэнгэ, Сэлэнгэ аймгийн Цагааннуур, Хушаат, Сант, Орхон, Орхонтуул сумын нутаг дэвсгэрт дагаж мөрдөж байгаа иргэний хамгаалалтын өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэг, хорио цээрийн хязгаарлалтын дэглэмийг цуцлах.

2. Энэ тогтоолын 1 дүгээр зүйлийн "а"-д заасан сумдын нутгийн захиргааны болон хууль хяналтын байгууллага, иргэний хамгаалалтын албадын үйл ажиллагаог зохих журам, удирдамжийн дагуу иргэний хамгаалалтын өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлж, харуул хамгаалалтыг зохион байгуулан хорио цээрийн хязгаарлалтын дэглэмийг сахиулах, хүн, мал, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд хяналт тавьж зохицуулах, ариутгал хийх зэрэг шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Орхон, Булган, Сэлэнгэ аймгийн Засаг дарга К.Даулетбай, М.Оюунбат, Р.Нямсүрэн нарт даалгасугай.

3. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, мэргэжлийн удирдамж, зөвлөлгөөгөөр хангаж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуйн сайд Д.Насанжаргал, Улсын иргэний хамгаалалтын газрын дарга О.Үржин нарт үүрэг болгосугай.

4. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Иргэний хамгаалалтын бэлэн байдлын зэргүүдэд шилжүүлэх тухай" Засгийн газрын 2001 оны 5 дугаар сарын 18-ны өдрийн 111 дүгээр тогтоолын 7 дугаар зүйлээс бусад зүйл, заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙД **Ж.ГҮРРАГЧАА**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 6 дугаар сарын 20-ны өдөр | **Дугаар 130** | **Улаанбаатар хот**

Нэрэмжит болгох тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Монгол-Оросын хамтарсан "Эрдэнэт" үйлдвэрийн дэргэдэх Техникийн их сургуулийн харьяа Технологийн сургуулийг Монгол Улсын хөдөлмөрийн баатар, техникийн шинжлэх ухааны доктор Шагдарын Отгонбилэгийн нэрэмжит болгосугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

БАЙГАЛЬ ОРЧНЫ САЙД БӨГӨӨД БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙДЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ У.БАРСБОЛД

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 6 дугаар сарын 20-ны өдөр | **Дугаар 131** | **Улаанбаатар хот**

Журам батлах тухай

Төсвийн тухай хуулийн 5¹ дүгээр зүйлийг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Төсвийн ерөнхий нягтлан бодогчийг томилох, чөлөөлөх журам"-ыг хавсралт ёсоор батлэсугай.

2. Энэ журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Сангүү, эдийн засгийн сайд Ч.Улаан, аймаг, нийслэлийн төсвийн ерөнхийлөн захирагч, төвлөрүүлэн захирагч, шууд захирагч нарт үүрэг болгосугай.

3. Бүх шатны төсвөт байгууллага болон төв, орон нутгийн санхүүгийн байгууллагын ерөнхий нягтлан бодогчдыг сургалтад хамруулах, мэргэжил дээшлүүлэх ажлыг удирдан зохион байгуулж ажиллахыг Сангүү, эдийн засгийн сайд Ч.Улаанд даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

САНГҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН САЙД Ч.УЛААН

Засгийн газрын 2001 оны 131 дүгээр тогтоолын хавсралт

ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН БОЛОН ТӨВЛӨРҮҮЛЭН,ШУУД ЗАХИРАГЧ НАРЫН ТӨСВИЙН ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧИЙГ ТОМИЛОХ, ЧӨЛӨӨЛӨХ ЖУРАМ

Нэг. Ерөнхий заалт

1. Энэ журмын зорилт нь бүх шатны төсвийн ерөнхийлөн захирагч, төсөвт байгууллага, Засгийн газрын тусгай зориулалттай сангуудын ерөнхий (ахлах) нягтлан бодогч нар (цаашид "Төсвийн ерөнхий нягтлан бодогч" гэх)-ыг ажилд томилох, ажлаас чөлөөлөх, халах, тэдгээрт тавих шаардлага, эрх, үүрэг, баталгаат тогтоон зохицуулахад оршино.

Хоёр. Төсвийн ерөнхий нягтлан бодогч нарт тавих шаардлага

2. Төсвийн ерөнхий нягтлан бодогчоор дараахь шаардлагыг хангасан хүнийг ажиллуулна:

1/Төсвийн ерөнхий нягтлан бодогч нь мэргэжлийн магадлан итгэмжлэгдсэн дээд сургуулийг төгссөн, бакалавраас доошгүй зэрэгтэй, нягтлан бодогч эсвэл эдийн засагч-нягтлан бодогч мэргэжил эзэмшсэн байх;

2/Шууд захирагч нарын ерөнхий нягтлан бодогч нь төсвийн байгууллагын бүртгэл тооцооны ажил дээр 2-оос доошгүй жил ажилласан байх;

3/Төвлөрүүлэн захирагч нарын ерөнхий нягтлан бодогч нь төсөвт байгууллагын ерөнхий нягтлан бодогч, эсхүл төвлөрүүлэн захирагчийн тооцооны нягтлан бодогчийн ажлыг

3-аас доошгүй жил гүйцэтгэсэн, туршлагатай мэргэшсэн нягтлан бодогч байх;

4/Ерөнхийлөн захирагчийн төсвийн ерөнхий нягтлан бодогч нь төсөвт байгууллагын ерөнхий нягтлан бодогч, эсвэл санхүүгийн байгууллагад 3-аас доошгүй жил ажилласан, мэргэшсэн нягтлан бодогч байх;

5/Төрийн албаны тухай хуульд заасны дагуу туршилтын хугацаатай ажиллуулсан тохиолдолд туршилтын нэг жил хүртэлх хугацаанд ажлын шаардлага бүрэн хангаж байгаа нь нотлогдсон;

6/Ял шийтгэлгүй, татварын болон банкны зээлийн өр төлбөргүй, Захиргааны хариуцлагын тухай хуулийн 36, 43, 2, 43[1] дүгээр зүйлийн дагуу захиргааны шийтгэлгүй байх;

7/Тухайн төсвийн эрх захирагчийн гэр бүлийн буюу төрөл садангийн хүмүүс ерөнхий нягтлан бодогчоор ажиллахыг хориглоно.

Гурав. Төсвийн ерөнхий нягтлан бодогчийг төрийн албанаас халах ба чөлөөлөх

3. Төсвийн ерөнхий нягтлан бодогчийг Хөдөлмөрийн болон Төрийн албаны тухай хуульд заасан үндэслэлээр төрийн албанаас чөлөөлнө.

4. Төсвийн ерөнхий нягтлан бодогчийг Төрийн албаны тухай хуульд заасан болон дараахь үндэслэлээр захиргааны санаачилгаар албан тушаал бууруулах буюу төрийн албанаас хална:

1/Хүлээсэн үүргээ биелүүлээгүйн төлөө давтан сахилгын шийтгэл хүлээсэн;

2/Санхүүгийн болон хөндлөнгийн хяналтын удаа дараагийнх шалгалтаар үйл ажиллагааг нь зөрчил тогтоогдон, хянан байцаагчийн акт тавигдсан;

3/Үүрэгт ажлаа гүйцэтгэх явцдаа өмч хөрөнгө үрэгдүүлсэн, ашигласан нь хууль хяналтын байгууллагын шалгалтаар тогтоогдсон;

4/Мэргэжлийн хувьд ажил, үүрэг гүйцэтгэх чадваргүйг холбогдох мэргэжлийн дээд байгууллага нь албан ёсоор нотолсон.

5. Энэ журмын 4.3, 4.4-т заасан үндэслэлээр Санхүү, эдийн засгийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан ёсны шийдвэр гарсан.

6. Төсвийн бүх шатны эрх захирагч нь төсвийн ерөнхий нягтлан бодогчийг ажлаас халах, ажилд томилох саналаа Санхүү, эдийн засгийн яаманд албан ёсоор тавина.

7. Энэ журмын 6-д заасан албан ёсны саналыг тавихдаа төсвийн ерөнхий нягтлан бодогчийг ажлаас чөлөөлөх, халах үндэслэлийг холбогдох баримт, материалаар батлагаажуулан, ажилд томилохоор санал болгож буй хүмүүсийн Төрийн албан хаагчийн биеийн байцаалтыг маягт 1-ээр, мөн уг албан тушаалд ажиллуулж эхлэх хугацаа, зэрэг дэв, цалингийн саналын хамт ирүүлнэ.

8. Санхүү, эдийн засгийн яам тухайн төсвийн эрх захирагчийн энэ журмын 6-д заасан саналыг хүлээн авснаас хойш нэг сарын дотор Санхүү, эдийн засгийн яамны Төрийн сангийн удирдлага, зохицуулалтын газрын саналыг авч Төрийн нарийн бичгийн даргын албан ёсны хариуг өгнө.

Дөрөв. Төсвийн ерөнхий нягтлан бодогчийн эрх, үүрэг

9. Төсвийн ерөнхий нягтлан бодогч нь төрийн өмчийн эд хөрөнгө, төсвийн хөрөнгийн ашиглалт, зарцуулалт, хамгаалалтад бүртгэлээр тавих хяналтыг хэрэгжүүлэх үүднээс дараахь үүрэг хүлээнэ:

1/Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон санхүүгийн сахилга батыг хатуу чанд мөрдөн, хуулиар батлагдсан төсвийг үр ашигтай зориулалтын дагуу зарцуулж, төрийн өмч, төсвийн хөрөнгийг үрэгдүүлж шамшигдуулахгүй байх;

2/Анхан шатны баримтыг зөв бүрдүүлэн, Санхүү, эдийн засгийн яамнаас батлан гаргасан "Засгийн газрын байгууллагуудад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн аргачлал, дүрэм, заавар, маягт"-аар нягтлан бодох бүртгэлийг бүрэн хөтөлж, тэдгээрт үндэслэн үнэн зөв санхүүгийн тайлан гаргах ажлыг удирдан зохион байгуулах;

3/Нягтлан бодох бүртгэлийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн тусгай программ

хангамжийг ажиллуулж, өдөр тутмынхаа гүйлгээг цаг хугацаанд нь бүртгэж байх;

Нягтлан бодох бүртгэлийн тусгай программ хангамжгүй тохиолдолд нягтлан бодох бүртгэлийг гараар хөтлөх;

4/Харилцагч байгууллагуудтай тооцоо нийлсэн акт, эд хөрөнгийн сар, улирал, жилийн тооллогын бүртгэл, тооцоо бодсон актыг үндэслэн санхүүгийн тайланг гаргах;

5/Өөрийн хариуцсан төсөвт байгууллага, сум, дүүрэг, аймаг, хотын санхүүгийн тайланг харьяалагдах дээд шатны санхүүгийн байгууллагад Төсвийн тухай хуулинд заасан хугацаанд хүлээлгэн өгч байх;

6/Харьяалагдах дээд шатны санхүүгийн байгууллагад гаргаж өгөх графикт бүх төрлийн мэдээ, мэдээллийг тухай бүр хугацаанд нь үнэн зөв гарган өгч байх;

7/Төсвийн ерөнхийлөн захирагчийн зөвшөөрөл авсны үндсэн дээр банкинд харилцах данс нээх, хаах;

8/Хариуцсан ажлын чиглэлээр хэвлэл мэдээллийн хэрэгсэл, эрдэм шинжилгээний болон шүүх, цагдаагийн байгууллагад мэдээ, мэдээллийг зөвхөн эрх захирагчийн албаны шийдвэрээр гарган өгч байх;

9/Эрх бүхий байгууллагаас гаргасан шийдвэрийн дагуу ажлаас чөлөөлөгдөхөд өөрийн хариуцаж байсан байгууллагын тайлант хугацаанд хамаарах санхүүгийн тайланг бүрэн гарган, нягтлан бодох бүртгэлийн баримт, бусад холбогдох материалыг хүлээлгэж өгөх.

10. Төсвийн ерөнхий нягтлан бодогч нь санхүү, төсвийн асуудал хариуцсан Засгийн газрын гишүүний эрх мэдлийн хүрээнд олгосон дараахь эрх эдэлнэ:

1/Хариуцаж буй төсөвт байгууллага (Засгийн газрын бүх шатны санхүүгийн байгууллага, Засгийн газрын тусгай сан)-ын санхүүгийн баримтад хоёрдугаар гарын үсэг зурах;

2/Хариуцсан ажлын чиглэлээр төсвийн орлого, зарлагын гүйлгээтэй холбоотой тооцоо, тайлбар, танилцуулгыг татвар төлөгч аж ахуйн нэгж, байгууллага, холбогдох татварын албад болон бусад харилцагчдаас гаргуулан авах;

3/Өөрийн шууд удирдлагад болон харьяа санхүүгийн байгууллагад ажилжаж байгаа нягтлан бодогчийг ажилд томилох, ажлаас халах, албан тушаал дэвшүүлэх, шагнал урамшилд тодорхойлох, мэргэжил дээшлүүлэх курс, сургалтад хамруулах талаар санал гарган шийдвэрлүүлэх;

4/Ээлжийн амралт, түр чөлөөтэй байх хугацаанд өөрийн ажлыг орлон гүйцэтгэх ажилтныг томилох тухай санал гаргаж төсвийн эрх захирагчийн шийдвэр гаргуулах;

5/Улсын Их Хурал, аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлагдсан тухайн оны төсвийн тухай хуульд тусгагдаагүй зарлагын гүйлгээ хийхээс татгалзах;

6/Ерөнхийлөн болон төвлөрүүлэн захирагчийн төсвийн ерөнхий нягтлан бодогч нь анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийг дутуу хөтөлж, тайлан тэнцлийг буруу гаргасан доод шатны эрх захирагчийн санхүүжилтийг үг дутагдлыг арилгатал зогсоох саналыг өөрийн эрх захирагчид тавьж болно.

11. Хууль, тогтоомжоор олгогдсон бусад эрх.

Тав. Төсвийн ерөнхий нягтлан бодогчийг шагнах, урамшуулах

12. Улирлын болон жилийн санхүүгийн тайлан, тэнцэл, төсвийн гүйцэтгэлийн мэдээг цаг хугацаанд нь чанартай, бүрэн гаргаж, ер авлагыг улирал тутам бууруулж, мэргэжлийн ёс зүй, зарчмыг чанд мөрдөн ажиллаж байгаа төсвийн ерөнхий нягтлан бодогчийг түүний жилийн ажлын үр дүнг үндэслэн Төрийн албаны болон бусад хууль тогтоомжийн дагуу шагнаж урамшуулна.

Зургаа. Төсвийн ерөнхий нягтлан бодогч нарын хүлээх хариуцлага

13. Улирлын болон жилийн санхүүгийн тайлан, тэнцэл, төсвийн гүйцэтгэлийн мэдээг бодит бус мэдээлэлд үндэслэн, бүрэн бус, чанаргүй гаргасан, удаа дараа хугацаа хожимдуулсан төсвийн ерөнхий нягтлан бодогчид холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 6 дугаар сарын 20-ны өдөр Дугаар 132 Улаанбаатар хот

Дансны тогтолцоог журамлах зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Холбогдох бэлтгэл ажлыг хангасны үндэсэн дээр Төрийн сангийн нэгдсэн дансны тогтолцоонд шилжих нь зүйтэй гэж үзсүгэй.

2. Монгол банктай хамтарч Төрийн сангийн нэгдсэн дансны тогтолцоонд шилжих ажлыг эхлүүлэх зорилгоор "тэг" үлдэгдэлтэй дансны тогтолцоог турших байгууллагын жагсаалтыг 1 дүгээр хавсралт ёсоор, төрийн сангийн нэгдсэн дансны тогтолцоог турших байгууллагын жагсаалтыг 2 дугаар хавсралт ёсоор тус тус батлагдсугай.

3. Монгол банктай хамтран төсөвт байгууллага, Засгийн газрын тусгай зориулалтын санг төгрөгийн болон валютын тус бүр нэг дансаар дамжуулан төлбөр тооцоо хийдэг журамд шилжүүлэн бусад дансыг хаалгах арга хэмжээ авахыг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаанд даалгасугай.

4. Үндэсний татварын ерөнхий газрын дарга Л.Зоригт даалгах нь:

а/төрийн өмчийн болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийн татварын албанд бүртгэгдээгүй харилцах дансыг бүртэлд бүрэн хамруулах арга хэмжээ авсугай;

б/төсөвт байгууллага, Засгийн газрын тусгай зориулалтын санг улсын бүртгэлд бүртгэх ажлыг эрхлэн гүйцэтгэж, улсын бүртгэлд бүртгэх журмыг шинэчлэн боловсруулж, тэдгээрийг энэ оны Ш улиралд багтаан нэгдсэн регистрийн системд оруулан шинэчлэн бүртгэж гэрчилгээ олгосугай;

в/төрийн өмчийн болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, төсөвт байгууллага, Засгийн газрын тусгай зориулалтын сангийн харилцах дансны талаар мэдээллийн сан бүрдүүлж түүнийг баяжуулан улсын бүртгэлд шинээр бүртгүүлсэн болон өөрчлөлт хийсэн тухай мэдээг харилцах дансны бүртгэлийн мэдээний хамт хагас жил тутамд Санхүү, эдийн засгийн сайдад танилцуулж байсугай.

5. Төрийн өмчийн болон орон нутгийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, төсөвт байгууллага, Засгийн газрын тусгай зориулалтын сангийн харилцах дансны тооллогыг жил бүрийн I улиралд явуулж, дүнг Засгийн газарт танилцуулж байхыг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаанд даалгасугай.

6. Банкин дахь харилцах дансныхаа сарын дэлгэрэнгүй мэдээг Санхүү, эдийн засгийн яамнаас баталсан маягтын дагуу гаргаж харилцагч банкаараа баталгаажуулан дараа сарын 5-ны дотор Санхүү, эдийн засгийн яаманд ирүүлж байхыг төвлөрсөн төсөвтэй харилцагч төсвийн эрх захирагч нарт даалгасугай.

7. Төрийн сангийн нэгдсэн дансны туршилтыг ажил хэрэгч зохион байгуулж, тодорхой үр дүнд хүргэхийг туршилтад хамрагдах байгууллагуудын эрх захирагч нарт даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН САЙД Ч.УЛААН

Засгийн газрын 2001 оны 132 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

"ТЭГ" ҮЛДЭГДЭЛТЭЙ ДАНСНЫ АРГЫГ ТУРШИХ БАЙГУУЛЛАГУУДЫН НЭРС

1. Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам
2. Эрүүл мэндийн яам
3. Улсын нийгмийн даатгалын ерөнхий газар

Засгийн газрын 2001 оны 132 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

ТӨРИЙН САНГИЙН НЭГДСЭН ДАНСНЫ ТОГТОЛЦООГ ТУРШИХ БАЙГУУЛЛАГУУДЫН НЭРС

1. Улсын Их Хурал
2. Батлан хамгаалах яам
3. Байгаль орчны яам
4. Төрийн өмчийн хороо
5. Үндэсний татварын ерөнхий газар
6. Санхүүгийн улсын хяналт, шалгалтын газар
7. Монгол Улсын Үндэсний их сургууль
8. Клиникийн нэгдсэн I эмнэлэг

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 6 дугаар сарын 20-ны өдөр Дугаар 133 Улаанбаатар хот

Дүрэм батлах тухай

Геодези, зураг зүйн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Геодези, зураг зүйн улсын хяналтын дүрэм"-ийг хавсралт ёсоор батлагдсугай.

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Улсын хяналтын дүрэм батлах тухай" Засгийн газрын 1996 оны 7 дугаар сарын 10-ны өдрийн 162 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

ҮЙЛДВЭР, ХУДАЛДААНЫ САЙД
БӨГӨӨД ДЭД БҮТЦИЙН САЙДЫН
ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ Ч.ГАНЗОРИГ

Засгийн газрын 2001 оны 133 дугаар тогтоолын хавсралт

ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН УЛСЫН ХЯНАЛТЫН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Энэхүү дүрмийн зорилго нь Геодези, зураг зүйн тухай болон бусад хуульд нийцүүлэн геодези, зураг зүйн салбарт нийтээр дагаж мөрдөхөөр тогтоосон стандарт, дүрэм, журмын хэрэгжилтэд тавих улсын хяналт шалгалтыг хэрэгжүүлэхтэй холбогдсон үйл ажиллагааг зохицуулахад оршино.

2. Геодези, зураг зүйн улсын хяналтыг улсын хэмжээнд Засгийн газрын тохируулагч агентлаг-Дэд бүтцийн улсын хяналтын алба, аймаг, нийслэлийн Засаг даргын дэргэдэх мэргэжлийн хяналтын албаны геодези, зураг зүйн талаар мэргэшсэн улсын ерөнхий байцаагч, улсын ахлах байцаагч, улсын байцаагч /цаашид "улсын байцаагч" гэх/ хэрэгжүүлнэ.

3. Дэд бүтцийн улсын хяналтын албаны дарга нь геодези, зураг зүйн улсын ерөнхий байцаагч байна.

4. Дэд бүтцийн улсын хяналтын албаны улсын ахлах байцаагч, улсын байцаагчийг улсын ерөнхий байцаагчийн санал болгосноор геодези, зураг зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн томилж, чөлөөлнө.

5. Аймаг, нийслэлд ажиллах геодези, зураг зүйн улсын байцаагчийг Дэд бүтцийн улсын хяналтын албаны даргатай зөвшилцсөний үндэсэн дээр аймаг, нийслэлийн Засаг дарга томилж, чөлөөлнө.

6. Улсын байцаагчид нь үйл ажиллагаандаа Монгол Улсын хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр болон энэхүү дүрмийг удирдлага болгоно.

Хоёр. Геодези, зураг зүйн улсын хяналтын чиглэл

7. Геодези, зураг зүйн хяналтыг дор дурдсан чиглэлээр хэрэгжүүлнэ:

а/геодези, зураг зүйн талаар улсын хэмжээнд мөрдөж байгаа хууль тогтоомж, тэдгээрийг үндэслэн Засгийн газар, төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан шийдвэрийн хэрэгжилт, геодези, зураг зүйн үйлдвэрлэлийн холбогдолтой заавар, дүрэм, стандарт, техникийн баримт бичгийг мөрдөж байгаа байдал;

б/геодези, зураг зүйн хэмжлийн багаж, хэрэгслийн баталгаажуулалт;

в/геодези, зураг зүйн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл авсан байдал;

г/улсын геодезийн сүлжээний байнгын цэг, тэмдэгтийн хамгаалалт;

д/газрын зураг, атлас зохиож хэвлэх талаар тогтоосон журмын хэрэгжилт, хэвлэн гаргаж байгаа газрын зураг, атласт улс, аймаг, орон нутгийн засаг захиргааны нэгж, тэдгээрийн хил, хот суурин газар болон газар зүйн объектын нэр, галиглалыг зөв тусгасан байдал.

Гурав. Геодези, зураг зүйн хяналтын улсын байцаагчийн үүрэг, эрх

8. Улсын байцаагч нь Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан улсын байцаагчийн нийтлэг үүргээс гадна дор дурдсан үүрэг хүлээнэ:

а/хяналт шалгалтыг энэ дүрмийн 7-д заасан чиглэлийн дагуу дангаар болон бусад байгууллага, мэргэжлийн хяналтын улсын байцаагчтай хамтран зохион байгуулж илэрсэн зөрчлийг арилгах арга хэмжээ авах;

б/улсын төвлөрсөн болон орон нутгийн төсөв, төрийн байгууллагаас хэрэгжүүлж буй төсөл, гадаадын зээл, тусламжийн хүрээнд хэрэгжүүлэх төслийн хөрөнгөөр гүйцэтгэсэн геодези, зураг зүйн ажлыг улсын нэрийн өмнөөс хүлээн авах, акт тогтоох, чанарын дүгнэлт гаргах.

9. Улсын байцаагч нь Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 7, 27 дугаар зүйлд заасан улсын байцаагчийн нийтлэг эрхээс гадна дор дурдсан эрх эдэлнэ:

а/Геодези, зураг зүйн тухай хуулийн 14 дүгээр зүйл, Захиргааны хариуцлагын тухай хуулийн 38[2] дугаар зүйл, 49[1] дүгээр зүйл, Кадастрын зураглал баз газрын кадастрын тухай хуулийн 21 дүгээр зүйл, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 18 дугаар зүйлд заасан эрхийг хэрэгжүүлэх;

б/улсын төвлөрсөн болон орон нутгийн төсөв, төрийн байгууллагаас хэрэгжүүлж буй төсөл, гадаадын зээл, тусламжийн хүрээнд хэрэгжүүлсэн төслийн хөрөнгөөр гүйцэтгэсэн геодези, зураг зүйн ажил болон агаар мандлаас авсан газрын зургийн баримт материалыг улсын нэгдсэн санд тогтоосон хугацаанд нь тушаагаагүй байгууллага, аж ахуйн нэгжийн үйл ажиллагаат түр буюу бүрмөсөн зогсоох;

в/геодези, зураг зүйн үйл ажиллагаанд бусад салбарын харилцааг зохицуулсан стандарт, дүрэм, заавар, журмаар тогтоосон шаардлагыг хангаагүй зөрчил илэрвэл энэ талаар холбогдох мэргэжлийн хяналтын байгууллагад тухай бүр мэдэгдэж уг зөрчлийг арилгуулах арга хэмжээ авах.

Дөрөв. Бусад зүйл

10. Улсын байцаагчийн албан шаардлагыг байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтан, иргэд хугацаанд нь биелүүлж, хариуг нь албан ёсоор мэдээлж байх үүрэгтэй.

11. Шалгуулсан байгууллага, аж ахуйн нэгж нь улсын байцаагчийн шийдвэрийг үндэслэлгүй гэж үзвэл гомдлоо уг шийдвэр гарсан өдрөөс 10 хоногийн дотор шалгалт хийсэн байгууллагын эрх баригчид буюу улсын ерөнхий байцаагчид гаргана.

12. Гомдол гаргах нь торгууль, шийтгэврээр ногдуулсан төлбөр төлөхийг зогсоох үндэслэл болохгүй бөгөөд гомдлыг хүлээн авсан байгууллагын эрх баригч буюу улсын ерөнхий байцаагч нь түүнийг авсан өдрөөс 30 хоногт багтаан хянан шийдвэрлэнэ.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 6 дугаар сарын 20-ны өдөр **Дугаар 134** **Улаанбаатар хот**

Журам батлах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

"Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг түрээслүүлэх журам"-ыг хавсралт ёсоор батлалсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН САЙД Ч.УЛААН

Засгийн газрын 2001 оны 134 дүгээр тогтоолын хавсралт

ТӨРИЙН ӨӨРИЙН ӨМЧИЙН ЭД ХӨРӨНГӨ ТҮРЭЭСЛҮҮЛЭХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Монгол Улсын төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг иргэн, хуулийн этгээдэд холбогдох хууль тогтоомжийн дагуу түрээслүүлэхэд энэхүү журмыг дагаж мөрдөнө.

2. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3, 4, 5-д зааснаас бусад төрийн өөрийн өмчийн бүх төрлийн үл хөдлөх болон үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх эд хөрөнгийг түрээслүүлж болно.

3. Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг иргэн, хуулийн этгээдэд түрээсээр эзэмшүүлэх зорилго нь төрийн өмчийн ашиглалтыг сайжруулж, үр ашгийг дээшлүүлэх, төсвийн хөрөнгийг нэмэгдүүлэхэд чиглэгдэнэ.

4. Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг түрээсээр эзэмшигч, ашиглагч нь эд хөрөнгийн баталгаа, төлбөрийн чадвартай Монгол улсын болон гадаадын иргэн, хуулийн этгээд (цаашид "түрээслэгч" гэнэ) байна.

5. Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг түрээсээр эзэмшүүлэгч нь Төрийн өмчийн хороо

болон төрийн өмчит хуулийн этгээд (цаашид "түрэслүүлэгч" гэнэ) байна. Төрийн өмчит хуулийн этгээд нь өөрийн эзэмшиж буй төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг энэ журмын дагуу түрэслүүлнэ.

6. Түрэслүүлэгч нь нэг зориулалттай, нэгдмэл байдалтай ашиглагдах цогцолбор төрийн өөрийн өмчийн үл хөдлөх болон үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх эд хөрөнгийг түрэслүүлэхдээ холбогдох ямны саналыг авна.

7. Түрэслүүлэгч болон түрэслэгчийн хоорондын харилцааг хууль тогтооож, энэ журамд заасны дагуу байгуулсан түрэсэийн гэрээгээр зохицуулна.

8. Төрийн өөрийн өмчийн тухайн эд хөрөнгийг хоёр буюу түүнээс дээш этгээд түрэсэлэх бол түрэсэийн гэрээний нөхцөлийг түрэсэлэгч, түрэслүүлэгч харилцан тохироцоно.

Харин төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг зөвхөн нэг этгээдэд түрэслүүлэх бол түрэсэлэгчийг сонгон шалгаруулна.

9. Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг түрэслэгч нь түрэсээр эзэмшиж буй төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг дамжуулан түрэслүүлэх, хамтран түрэслэх, эрх залгамжлан түрэслэх бол Төрийн өмчийн хорооны зөвшөөрөл авна.

10. Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрэсэийн гэрээний үлгэрчилсэн загвар, түрэсэлэгчийг сонгон шалгаруулах журмыг Төрийн өмчийн хороо батална.

11. Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрэсэийн төлбөрийн жишиг үнийг Санхүү, эдийн засгийн сайдын саналыг авч Төрийн өмчийн хороо тогтооно.

Хоёр. Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрэсэийн гэрээ байгуулах

12. Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрэсэийн гэрээг Иргэний хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, энэхүү журамд нийцүүлэн бичгээр байгуулна.

13. Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрэсэийн гэрээг байгуулахдаа Төрийн өмчийн хорооноос баталсан түрэсэийн гэрээний үлгэрчилсэн загварыг үндэс болгоно.

14. Төрийн өөрийн өмчийн үл хөдлөх хөрөнгийн түрэсэийн гэрээг Төрийн өмчийн хороогоор батлуулан Үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн газарт бүртгүүлнэ.

15. Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрэсэийн гэрээний хугацаат хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол түрэсэлэж буй эд хөрөнгийн шинж байдал, зориулалт, онцлогийг харгалзан талууд харилцан тохиролцож тогтооно.

16. Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг түрэсэлүүлэхдээ түрэсэийн төлбөрийн хэмжээг энэ журмын 11-д заасан жишиг үнийг баримтлан, зах зээлийн тухайн үеийн үнэ болон бусад холбогдох үзүүлэлтүүдийг харгалзан тогтоож, гэрээнд тусгана.

17. Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрэсэийн төлбөрийг Төрийн өмчийн хороо төвлөрүүлж улсын төвлөрсөн төсөөт оруулна. Улсын төвлөрсөн төсөөт төвлөрүүлэх түрэсэийн төлбөрийн хувь, хэмжээг Санхүү, эдийн засгийн яамны батлалсан тухайн оны түрэсэийн орлогын төлөвлөгөөтэй уялдуулан Төрийн өмчийн хороо тогтооно.

18. Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрэсэийн гэрээний биелэлтэд Төрийн өмчийн хороо, түрэсэлэгч төрийн өмчит хуулийн этгээд хяналт тавина.

19. Төрийн өмчит хуулийн этгээд нь өөрийн эзэмшиж байгаа төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг бусдад түрэсэлүүлсэн бол энэ талаар дэлгэрэнгүй мэдээллийг тухай бүр Төрийн өмчийн хороонд ирүүлж байх үүрэгтэй.

20. Түрэслэгч нь төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг түрэсээр эзэмшиж хугацаандаа түүний бүрэн бүтэн байдал, урсгал засварыг хариуцах бөгөөд Төрийн өмчийн хорооны зөвшөөрөлгүйгээр анхны зураг төслийн шийдлийг өөрчлөх, хөрөнгө оруулалт хийхийг хориглоно.

21. Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгөд оруулах хөрөнгө оруулалтын зөвшөөрөл олгох, хяналт тавих, хүлээн авах, тооцож баталгаажуулах ажлыг зохион байгуулах журмыг Төрийн өмчийн хороо батална.

Гурав. Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрэсэийн гэрээг цуцлах

22. Түрэсэлэгч төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрэсэийн гэрээгээр хүлээсэн үүргээноцтой зөрчсөн буюу төлбөрийн чадваргүй болсон, эсхүл гэрээнд тусгайлан заасан тохиолдолд түрэслүүлэгч дангаар гэрээг цуцалж учирсан хохирлыг төлүүлнэ.

Дөрөв. Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг түрэсэсэр эзэмшүүлэхтэй холбогдсон маргааныг шийдвэрлэх

23. Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг түрэсэсэр эзэмшүүлэхтэй холбогдсон маргааныг Төрийн өмчийн хороо шийдвэрлэнэ.

24. Төрийн өмчийн хорооны шийдвэрийг эс зөвшөөрвөл зохих шатны шүүхэд хандаж маргааныг шийдвэрлүүлнэ.

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Хаяг: «Төрийн мэдээлэл» эмхтгэлийн зөвлөл

Улаанбаатар-12 ☎ 329612
Төрийн ордон Индекс 14003

Улсын Их Хурлын Тамгын газрын
Хэвлэх хэсэгт хэвлэв.
☎ 329487



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 34 (221)

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ:

- *Авирмэдийн Лхагваад Монгол Улсын гавьяат хуульч цол хүртээх тухай*
- *Элчин сайдыг эгүүлэн татах, томилох тухай*

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ:

- *Байгаль орчныг хамгаалах хөрөнгийн байршлын тухай*
- *Мал өвөлжилтийн талаар авах зарим арга хэмжээний тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар

Улаанбаатар хот
2001 он

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот 2001 оны есдүгээр сарын 1 №34 (221)

Гарчиг

Нэг. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

410. Авирмэдийн Лхагваад Монгол Улсын гавьяат хуульч цол хүртээх тухай Дугаар 34 849
411. Зарим хүнийг одон, медалиар шагнах тухай Дугаар 35 850
412. Элчин сайдыг эгүүлэн татах, томилох тухай Дугаар 36 851

Хоёр. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

413. Ой тэмдэглэх тухай Дугаар 112 852
414. Тусламжийн зарим хөрөнгийг "Монголын цахилгаан холбоо" ХК-ийн нэмэлт хөрөнгө оруулалтад тооцох тухай Дугаар 135 852
415. Байгаль орчныг хамгаалах хөрөнгийн байршлын тухай Дугаар 136 855
416. Хууль хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай Дугаар 137 855
417. Үндэсний зөвлөлийн дүрэм батлах тухай Дугаар 138 856
418. Журам батлах тухай Дугаар 139 858
419. Жагсаалт батлах тухай Дугаар 140 860
420. Дүрэм батлах тухай Дугаар 143 863
421. Мал өвөлжилтийн талаар авах зарим арга хэмжээний тухай Дугаар 144 867
422. Улсын циркийн талаар авах зарим арга хэмжээний тухай Дугаар 145 872
423. Нөхөн төлбөр олгох тухай Дугаар 146 872

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2001 оны 8 дугаар сарын 16-ны өдөр **Дугаар 34** **Улаанбаатар хот**

Авирмэдийн Лхагваад Монгол Улсын гавьяат хуульч цол хүртээх тухай

Цагдаагийн байгууллагад олон жил үр бүтээлтэй ажиллаж, шүүхийн шийдвэр биелүүлэх байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, боловсон хүчнийг сургаж дадлагажуулахад оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Цагдаагийн академийн шүүхийн шийдвэр биелүүлэх эрх зүйн тэнхмийн эрхлэгч, хурандаа Авирмэдийн Лхагваад Монгол Улсын гавьяат хуульч цол хүртээсүгэй

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ **Н.БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2001 оны 8 дугаар сарын 16-ны өдөр **Дугаар 35** **Улаанбаатар хот**

Зарим хүнийг одон, медалиар шагнах тухай

Үйлдвэрлэл, үйлчилгээ, боловсрол, соёл урлаг, төр, захиргаа, эрдэм шинжилгээний болон төрийн бус байгууллагад олон жил үр бүтээлтэй ажиллаж, амжилт гаргасан дор дурдсан хүмүүсийг одон, медалиар шагнасугай.

ХӨДӨЛМӨРИЙН ГАВЬЯАНЫ УЛААН ТУГИЙН ОДОНГООР:

Вандагийн Алзахгүй - Боловсрол, соёл, шинжлэх ухааны улсын хяналтын албаны ерөнхий байцаагч

ЦЭРГИЙН ГАВЬЯАНЫ УЛААН ТУГИЙН ОДОНГООР:

Юндэнгийн Сэрсэнжав - Цагдаагийн академийн шүүхийн шийдвэр биелүүлэх эрх зүйн тэнхимийн ахлах багш, хурандаа

"АЛТАН ГАДАС" ОДОНГООР:

1. Төмөрийн Ариунаа - "Ариун сэтгэл" сангийн тэргүүн, чөлөөт уран бүтээлч

2. Цэгмэдийн Даваадорж - ОХУ-ын Шинжлэх ухааны академийн докторант

3. Цэгмидийн Дамчаа - Нийслэлийн хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэгийн ахлах мэргэжилтэн

4. Лувсанцэрэнгийн Дугаржав - О Х У - ы н Плехановын нэрэмжит эдийн засгийн академийн Улаанбаатар хот дахь салбар сургуулийн дэд захирал

5. Лхагваагийн Дэмидбаатар - Үндэсний жүжгийн академик театрын жүжигчин

6. Цэрэндоржийн Нарангэрэл - Нийслэлийн худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээний "Техник хурд" ХХК-ийн ерөнхийлөгч

7. Цэдэн-Ишийн Тогтмол - Улаанбаатар хотын тээврийн газрын орлогч дарга

8. Хусманы Төмөрхаан - Нийслэлийн Хүүхэд, залуучуудын ордны сантехникийн инженер

9. Цогтын Тунгалаг - Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн дарга

10. Бадарчийн Энхтуяа - Монголын радио, телевизийн хэрэг эрхлэх газрын Монголын радиогийн программын захиргааны дарга

ЦЭРГИЙН ГАВЬЯАНЫ ОДОНГООР:

1. Гэлэгдоржийн Бямбадорж - Архангай аймаг дахь Шүүхийн шийдвэр биелүүлэх албаны дарга, дэд хурандаа

2. Хөхөөгийн Уламбаяр - Шүүхийн шийдвэр биелүүлэх ерөнхий газрын захиргааны удирдлагын газрын дарга, хурандаа

ХӨДӨЛМӨРИЙН ХҮНДЭТ МЕДАЛИАР:

1. Мөнхөөгийн Анхбаяр - Увс аймаг дахь Увс нуурын ай савын улсын тусгай хамгаалалттай газрын дарга

2. Жамбаагийн Балдорж - Шүүхийн шийдвэр биелүүлэх ерөнхий газрын харьяа Хорих 421 дүгээр ангийн санхүү, үйлдвэрлэл эрхэлсэн дэд дарга, дэд хурандаа

3. Ранжингийн Балдорж - Нийслэлийн Хүүхэд, залуучуудын ордны аж ахуй, техникийн албаны дарга

4. Рэнчингийн Батжаргал - Дархан-Уул аймгийн Засаг даргын Тамгын газрын нийгмийн хөгжлийн бодлогын хэлтсийн дарга

5. Дамчаагийн Бат-Очир - Төв аймгийн Мөнгөнморьт дахь хорих 417 дугаар ангийн дарга, дэд хурандаа

6. Надмидцэрэнгийн Баттогоо - Шүүхийн шийдвэр биелүүлэх ерөнхий газрын боловсон хүчин, сургалтын хэлтсийн дарга, хурандаа

7. Очирбатын Болд - Өвөрхангай аймгийн Хархорин сум дахь Шүүхийн шийдвэр биелүүлэх албаны дарга, хурандаа

8. Цэрэнхүүгийн Бямбаа - Хорихын нэгдсэн эмнэлэгийн сүрьеэгийн зохицуулагч эмч, дэд хурандаа

9. Жалбуугийн Вячеслав - Булган аймаг дахь Шүүхийн шийдвэр биелүүлэх албаны дарга, хурандаа

10. Гэсэржавын Ганболд - Шүүхийн шийдвэр биелүүлэх ерөнхий газрын харьяа Хорих 405 дугаар ангийн дарга, хурандаа

11. Сүхбаатарын Гомбодорж - Дорнод аймаг дахь Шүүхийн шийдвэр биелүүлэх албаны шийдвэр гүйцэтгэгч, ахлах дэслэгч

12. Лувсаннямын Гэрэлмаа - Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын зохион байгуулагч

13. Түвдэнгийн Дэмчиг - Нийслэлийн "Жавхлант" зуслангийн захирал

14. Чунагсүрэнгийн Жаргалсайхан - Булган айгийн Эрчим хүчний үйлдвэрийн ерөнхий инженер

15. Жекейн Жумагуль - Баян-Өлгий аймаг дахь Шүүхийн шийдвэр биелүүлэх албаны Хорих 449 дугаар ангийн ахуй дэглэмийн байцаагч, хошууч

16. Бирагийн Магсаржалам - Хөвсгөл аймаг дахь Шүүхийн шийдвэр биелүүлэх албаны туслах ажилтан, ахлах ахлагч

17. Намсрайжавын Мандах - Нийслэлийн "Соёл" зуслангийн захирал

18. Ламжавын Мөнхцэцэг - Нийслэлийн Хүүхэд, залуучуудын ордны үйлчлэгч

19. Доржийн Намжилдорж - Орхон аймаг дахь уул, уурхайн баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрийн автотээврийн байгууллагын ерөнхий энергетикч

20. Гунгаанямын Өлзийбаяр - Монголын залуучуудын холбооны сургалт, судалгааны "Полиси" төвийн хөдөлмөрийн биржийн зохион байгуулагч

21. Ишжамцын Сосор - Монголын залуучуудын холбооны гүйцэтгэх хорооны бичиг хэргийн ажилтан

22. Артын Сэр-Од - Завхан аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн тасгийн дарга, хошууч

23. Цэдэнгийн Түвшинтөгс - Нийслэлийн "Сэлбэ" зуслангийн захирал

24. Шарын Хажидмаа - Шүүхийн шийдвэр биелүүлэх ерөнхий газрын харьяа Хорих 401 дүгээр ангийн ахуй дэглэмийн байцаагч, дэд хурандаа

25. Равсалын Энхбаяр - Шүүхийн шийдвэр биелүүлэх ерөнхий газрын харьяа Хорих 401 дүгээр ангийн барилгын хэсгийн дарга, хурандаа

26. Дагвадоржийн Энхтайван - Баянхонгор аймаг дахь Шүүхийн шийдвэр биелүүлэх албаны дарга, хурандаа

27. Дэмбэрэлийн Энхтуяа - Нийслэлийн Хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын ажилтан

28. Батаагийн Эрдэнэбат - Нийслэлийн Багануур дүүрэг дэх Шүүхийн шийдвэр биелүүлэх албаны шийдвэр гүйцэтгэлийн хэсгийн дарга, хурандаа

29. Пүрэвжалын Эрдэнэцэцэг - Шүүхийн шийдвэр биелүүлэх ерөнхий газрын харьяа Хорих 411 дүгээр ангийн нийгмийн ахлах ажилтан, дэд хурандаа

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ **Н.БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2001 оны 8 дугаар сарын 16-ны өдөр **Дугаар 36** **Улаанбаатар хот**

Элчин сайдыг эгүүлэн татах, томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн 33 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5, Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг баримтлан ЗАРЛИГ болгох нь:

1. Монгол Улсаас Бүгд Найрамдах Хятад Ард Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Дагвын Цахилгааныг эгүүлэн татсугай.

2. Монгол Улсаас Бүгд Найрамдах Хятад Ард Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Лувсандагвын Амарсанаар томилсугай.

МОНГОЛ УЛСЫН

ЕРӨНХИЙЛӨГЧ **Н.БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 5 дугаар сарын 18-ны өдөр | **Дугаар 112** | **Улаанбаатар хот**

Ой тэмдэглэх тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2001 оны 118 дугаар зарлигийг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Чингис хаан мэндэлсний 840 жилийн ойг 2002 онд, Монгол Улсын тулгар төр байгуулагдсаны 800 жилийн ойг 2006 онд тус тус орон даяар төрт ёсны их баяр болгон тэмдэглэсүгэй.

2. Чингис хаан мэндэлсний 840 жилийн ой, Монгол Улсын тулгар төр байгуулагдсаны 800 жилийн ойн арга хэмжээг бэлтгэх, тэмдэглэн өнгөрүүлэх ажлыг удирдан зохион байгуулах Үндэсний хорооны бүрэлдэхүүнийг хавсралт ёсоор батлуулсугай.

3. Үндэсний хороонд даалгах нь:

а/Чингис хаан мэндэлсний 840 жилийн ой, Монгол Улсын тулгар төр байгуулагдсаны 800 жилийн ойд бэлтгэх, тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, түүнд шаардагдах хөрөнгийн тооцоог гарган 2001 оны Ш улиралд багтаан Засгийн газарт танилцуулсугай;

б/төрт ёсны их баяр наадмыг тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээнд төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийг өргөнөөр татан оролцуулсугай.

4. Төлөвлөгөөнд туссан арга хэмжээнд шаардагдах хөрөнгийн төсөөс гаргах хэсгийг жил жилийн улсын төсөвт тусган санхүүжүүлж байхыг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаанд үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙД **А.ЦАНЖИД**

Засгийн газрын 2001 оны 112 дугаар тогтоолын хавсралт

ЧИНГИС ХААН МЭНДЭЛСНИЙ 840 ЖИЛИЙН ОЙ, МОНГОЛ УЛСЫН ТУЛГАР ТӨР БАЙГУУЛАГДСАНЫ 800 ЖИЛИЙН ОЙГ ЗОХИОН БАЙГУУЛАХ ҮНДЭСНИЙ ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН

Дарга - Монгол Улсын Ерөнхий сайд
Орлогч дарга - Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд
Гишүүд:
- Батлан хамгаалахын сайд;
- Байгаль орчны дэд сайд;
- Дэд бүтцийн дэд сайд;
- Санхүү, эдийн засгийн дэд сайд;
- Хууль зүй, дотоод хэргийн дэд сайд;
- Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга (тохиролцсоноор);
- Нийслэлийн Засаг дарга;
- Төв аймгийн Засаг дарга;
- Хэнтий аймгийн Засаг дарга;
- Шинжлэх ухааны академийн дэд ерөнхийлөгч;
- Радио, телевизийн хэрэг эрхлэх газрын дарга;
- Төрийн ёслолын албаны дарга.

Нарийн бичгийн дарга - Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 6 дугаар сарын 27-ны өдөр | **Дугаар 135** | **Улаанбаатар хот**

Тусламжийн зарим хөрөнгийг "Монголын цахилгаан холбоо" ХК-ийн нэмэлт хөрөнгө оруулалтад тооцох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 4 дэх заалт, Төрийн өмчийг 2001-2004 онд хувьчлах үндсэн чиглэлийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Азийн хөгжлийн банк, "Нордикийн сан"-гаас Монгол Улсын Засгийн газарт буцалтгүй тусламжаар "МОН-1300" төслийн хүрээнд "Монголын цахилгаан холбоо" ХК-ийн мастер төлөвлөгөөг боловсруулах, олон улсын нягтлан

бодох буртэлийн стандартыг нэвтрүүлэх, боловсон хүчний сургалт, техникийн лабораторийг байгуулах зэрэг 1 дүгээр хавсралтад дурдсан ажил, үйлчилгээг гүйцэтгэсэн хөрөнгө оруулалт болон хөдөө орон нутгийн сум-багийн холбоожилтод зориулан Япон Улсын Засгийн газраас буцалтгүй тусламжаар өгч байгаа 2 дугаар хавсралтад заасан радио холбооны станц, түүний дагалдах техөөрөмж зэргийг тус тус дахин үнэлэж, "Монголын цахилгаан холбоо" ХК-ийн өмчлөлд Компанийн тухай хуулийн дагуу шилжүүлэх арга хэмжээ авахыг Төрийн өмчийн хорооны дарга Л.Пүрэвдоржид үүрэг болгосугай.

2. Сум-багийн холбоожилтод зориулан "Монголын цахилгаан холбоо" ХК-ийн өмчлөлд шилжүүлж байгаа энэ тогтоолын 2 дугаар хавсралтад заасан радио станцыг сумын Засаг дарга, хүн эмнэлэг, багууд болон бусад хэрэглэгчдэд түрээслэх төлбөр болон үйлчилгээний тарифын хэмжээг уг тоног, техөөрөмжийн хэвийн найдвартай ажиллагаагаар хангах зорилгоор хийх засвар үйлчилгээнд гарах зардлыг нөхөх хэмжээнд тогтоон мөрдүүлэхийг Дэд бүтцийн сайд Б.Жигжидэд даалгасугай.

3. Энэ тогтоолын 1 дүгээр зүйлд заасан хөрөнгө оруулалт, тоног техөөрөмжийг "Монголын цахилгаан холбоо" ХК-ийн өмчлөлд шилжүүлж байгаатай холбогдуулан уг хувьцаат компани дахь Монголын талын төрийн мэдлийн хувьцааны хэмжээг нэмэгдүүлэх асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу тавьж шийдвэрлүүлэх арга хэмжээ авахыг Төрийн өмчийн хорооны дарга Л.Пүрэвдоржид даалгасугай.

4. Монголын талын хувьцааны хэмжээг нэмэгдүүлэхтэй холбогдуулан "Кореа Телеком" компани өөрийн эзэмшлийн хувьцааны хэмжээг хувь тэнцүүлэн нэмэгдүүлэх хүсэлтэй бол холбогдох хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэхийг Төрийн өмчийн хорооны дарга Л.Пүрэвдоржид зөвшөөрсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

ДЭД БҮТЦИЙН САЙД **Б.ЖИГЖИД**

Засгийн газрын 2001 оны 135 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

ХАРИЛЦАА ХОЛБООНЫ САЛБАРТ ХЭРЭГЖСЭН МОН/1300 БАГЦ ТӨСЛИЙН ХҮРЭЭНД БУЦАЛТГҮЙ ТУСЛАМЖААР ҮЗҮҮЛСЭН АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЖАГСААЛТ

Ажил, үйлчилгээ, хөрөнгө оруулалтын нэр	Хаанахын тусламж	Хэрэгжсэн хугацаа	Гүйцэтгэсэн байгууллага	Тусламж мян.US$, мян. DM	Тусламж мян.төгрөг	Хийгдсэн ажил
Нягтлан бодох бүртгэл, удирдлагын мэдээллийн систем	Азийн хөгжлийн банк	1995-1996	Артур Андерсан	US $ 475.0	386 251.0	МЦХ ХК-ийн санхүү бүртгэлийн системийг Олон улсын нягтлан бодох бүртгэлийн стандартад зохицуулж шинэчилсэн
Холбох байгууламжийн зөвлөх үйлчилгээ	Германы сэргээн босголт, зээлийн банк	1996-1998	Детекон	DM 987.2	528 945.3	Тоон телефон станц суурилуулах, ашиглалт үйлчилгээг эрхлэх концепц боловсруулсан
Холбох байгууламжийн сургалт	Германы сэргээн босголт, зээлийн банк	1996-1997	Сименс	DM 943.8	505 695 .3	Холбооны салбарын удирдах боловсон хүчин, холбох байгууламжийн инженер техникийн ажилтнуудыг гадаад болон дотоодод сургасан
МЦХ ХК-ийн Ерөнхий төлөвлөгөө боловсруулах	Норвегийн Засгийн газар	1996	Теленор	US $ 416.8	324 785.8	МЦХ ХК-ийн бизнес төлөвлөгөө ба боловсон хүчнийг хөгжүүлэх мастер төлөвлөгөө боловсруулсан

Сургагчийн сургалт	Норвегийн Засгийн газар	1996	Кореа Телеком Интернэшнл	US $ 497.2	412 645.3	Холбооны техник, технологи, санхүү, зах зээл удирдлагын салбарт мэргэжилтэн бэлтгэх дотоод сургалт зохион байгуулсан
Дүн					2 158 322.8	

Засгийн газрын 2001 оны 135 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

ЯПОН УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРААС ГАМШГИЙН БУЦАЛТГҮЙ ТУСЛАМЖААР НИЙЛҮҮЛЭГДЭЖ БАЙГАА РАДИО СТАНЦ, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖҮҮДИЙН ЖАГСААЛТ

№	Барааны нэр	Модел	Тоо хэмжээ (ширхэг)	Нэг бүрийн үнэ (Японы иен)	Нийт үнэ (Японы иен)
Богино долгионы радио станцын иж бүрдэл (Баг-1 төслөөр нийлүүлэгдсэн бараа материал)					
1	Богино долгионы суурь станц	IC-78	174	62,799	10,927,026
2	Тэжээлийн блок	GSV-3000	174	17,002	2,958,348
3	Антенн	WD-330	174	18,025	3,136,350
4	Антенны кабель (30м)		174	-	-
5	Антенны тулгуур	FP-12/FB-4	45	52,458	2,360,610
6	Богино долгионы хөдөлгөөнт станц	IC-78	20	62,799	1,255,980
7	Антенны тюнер	AT-130	20	34,389	687,780
8	Антенны кабель	ICOM	20	11,662	233,240
9	Хөдөлгөөнт антенн	AH-2B	20	20,753	415,060
10	Хэт богино долгионы суурь станц	IC-F320	190	25,298	4,806,620
11	Тэжээлийн блок	GSV-1200	190	11,889	2,258,910
12	Антенн	BC-100	190	5,979	1,136,010
13	Антенны кабель (30м)	10D-2V	190	5,979	1,136,010
14	Антенны тулгуур	FP-12/FB-4	50	52,458	2,622,900
15	Хэт богино долгионы хөдөлгөөнт станц	IC-F320	50	25,298	1,264,900
16	Хөдөлгөөнт антенн	M285S	50	3,366	168,300
17	Антенны кабель	BL/ECH	50	3,138	156,900
18	Цахилгаан хөдөлгүүр	Yamaha650/950	400	28,300	11,320,000
Богино долгионы радио станцын иж бүрдэл (Баг-2 төслөөр нийлүүлэгдэх бараа материалын жагсаалт)					
19	Богино долгионы суурь станц	IC-78	939	56,546	53,096,694
20	Тэжээлийн блок	EP-825	200	10,179	2,035,800
21	Антенны тюнер	AT-130	939	28,012	26,303,268
22	Кабель	VCTF/5D-2V	939	5,186	4,869,654
23	Антенны зохицуулагч	TK-1173H	939	2,273	2,134,347
24	Газардуулагч	CA35RS	939	3,343	3,139,077

25	Антенн	TK-1173D	939	7,920	7,436,880
26	Антенны тулгуур, суурь	MT-15A/P-170	939	14,935	14,023,965
27	Богино долгионы хөдөлгөөнт станц	IC-78	620	58,341	36,171,420
28	Антенны тюнер	AT-130	620	28,012	17,367,440
29	Антенны кабель	VCTF/5D-2V	620	2,071	1,284,020
30	Антенн	TK-1173A	620	9,704	6,016,480
31	Нарны зайн модуль	GT136	739	60,668	44,833,652
32	Контроллёр	Sigma 20amp	739	34,946	25,825,049
33	Батарей	MF100sealed	739	5,668	4,188,652
34	Кабель	Cable among P	739	7,088	5,238,032
35	Нэмэлт тоноглол	Hcom-P1	739	9,557	7,062,623
	ДҮН				310,977,646 иен/ 2,591,480 ам.долл

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 6 дугаар сарын 27-ны өдөр **Дугаар 136** **Улаанбаатар хот**

Байгаль орчныг хамгаалах хөрөнгийн байршлын тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Төрийн нэгдсэн дансны тогтолцоонд шилжих болсонтой холбогдуулан гадаад, дотоодын төрийн бус байгууллага, олон улсын байгууллага, хувь хүмүүсээс байгаль орчныг хамгаалах чиглэлээр хандивласан хөрөнгийг төрийн бус байгууллагын дансанд байршуулж, уг хөрөнгөөр хэрэгжүүлэх үйл ажиллагааны төсөл, арга хэмжээний биелэлтэд хяналт тавьж жил бүр Засгийн газарт танилцуулж ажиллахыг Байгаль орчны сайд У.Барсболдод даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН САЙД **Ч.УЛААН**

БАЙГАЛЬ ОРЧНЫ САЙД **У.БАРСБОЛД**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 6 дугаар сарын 27-ны өдөр **Дугаар 137** **Улаанбаатар хот**

Хууль хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай, Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хууль болон "Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" Улсын Их Хурлын 2001 оны 35 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд Ш.Батбаярт даалгах нь:

а/хөдөлмөр эрхлэлтийн төв байгууллага, орон нутгийн албаны бүтэц, зохион байгуулалтыг 2001 оны Ш улиралд багтаан Хөдөлмөр эрхлэлтийн газар, аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн алба болгон зохион байгуулан ажиллуулсугай;

б/хөдөлмөр эрхлэлтийн албаны үйл ажиллагааны зардал, ажилгүйдлийн даатгалын сангийн хөрөнгөөс санхүүжүүлэх хөдөлмөр эрхлэлтийн албаны ажилтны сургалтыг аймаг, нийслэлийн Засаг даргатай хамтран 2001 оны Ш улиралд багтаан зохион байгуулсугай.

2. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд улсын төсвөөс төвлөрүүлэх хөрөнгө болон түүний хэмжээг жил бүрийн улсын төсөвт тусган санхүүжүүлж байхыг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаан, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд Ш.Батбаяр нарт үүрэг болгосугай.

3. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан, Ажилгүйдлийн даатгалын сангаас зарцуулах сургалтын зардлын нэг хүнд ногдох дээд хэмжээг 50 мянган төгрөгөөр тогтоосугай.

4. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд орон нутгийн төсвөөс 2001 оны сүүлийн хагас жилд олгох хөрөнгийн хэмжээ, аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн албаны зардлыг орон нутгийн төсөвт тодотгон тусгаж цаашид жил бүрийн төсөвт тусган Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулж байхыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

5. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Комиссыг шинэчлэн байгуулах тухай" Сайд нарын Зөвлөлийн 1989 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 312 дугаар тогтоол, "БНМАУ-д суугаа гадаадын дипломат төлөөлөгчийн газар, олон улсын байгууллага, гадаадын бусад байгууллагад иргэдийг ажиллуулах тухай" Засгийн газрын 1991 оны 8 дугаар сарын 23-ны өдрийн 249 дүгээр тогтоол, "Ажиллах хүчийг гадаад орнуудаас авах, гадаад орнуудад гаргах асуудлыг журамлах тухай" Засгийн газрын 1992 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн 14 дүгээр тогтоол, "Хүн амын хөдөлмөр эрхлэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 1992 оны 7 дугаар сарын 3-ны өдрийн 106 дугаар тогтоол, "Хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, ажилгүйдлийг бууруулах талаар авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 1993 оны 8 дугаар сарын 18-ны өдрийн 134 дүгээр тогтоол, "Журам батлах тухай" Засгийн газрын 1994 оны 3 дугаар сарын 2-ны өдрийн 49 дүгээр тогтоол, Засгийн газрын 1997 оны 11 дүгээр тогтоолоор баталсан "Ажилгүйдлийн даатгалын сангийн хөрөнгийг зарцуулах журам"-ын 20 дахь заалтыг тус тус хүчингүй болсонд тооцож, "Агентлаг байгуулах тухай" Засгийн газрын 2000 оны 9 дүгээр сарын 6-ны өдрийн 139 дүгээр тогтоолын 1 дүгээр зүйлийн "к" заалтын "Хөдөлмөр зохицуулалтын газар" гэснийг "Хөдөлмөр эрхлэлтийн газар", "Аймгийн Засаг дарын Тамгын газрын өрөнхий бүтэц, орон тоо, удирдлагын бүдүүвчийг шинэчлэн тогтоох тухай" Засгийн газрын 2000 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн 181 дүгээр тогтоолын 4 дүгээр зүйлийн "Хөдөлмөр зохицуулалтын алба" гэснийг "Хөдөлмөр эрхлэлтийн алба" гэж тус тус өөрчилсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

НИЙГМИЙН ХАМГААЛАЛ, ХӨДӨЛМӨРИЙН САЙД **Ш.БАТБАЯР**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 6 дугаар сарын 27-ны өдөр **Дугаар 138** **Улаанбаатар хот**

Үндэсний зөвлөлийн дүрэм батлах тухай

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 20 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасныг үндэслэн ажил олгогч, ажилтны хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалах улсын хэмжээний байгууллагатай зөвшилцсөнөөр Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн дүрмийг хавсралт ёсоор баталсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

НИЙГМИЙН ХАМГААЛАЛ, ХӨДӨЛМӨРИЙН САЙД **Ш.БАТБАЯР**

Засгийн газрын 2001 оны 138 дугаар тогтоолын хавсралт

ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөл (цаашид "Үндэсний зөвлөл" гэх)-ийн зорилго нь хөдөлмөр эрхлэлтийг дээшлүүлэх, ажилгүйдлийг бууруулах, ажилгүйдлийн даатгал болон түүнтэй холбогдох эдийн засаг, нийгмийн бодлогын асуудлаар үндэсний хэмжээнд зөвлөлдөх, энэ талаар төрийн бодлого боловсруулж хэрэгжүүлэхэд нөлөөлөх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн орлого, зарлагын төсөв, түүний гүйцэтгэл, холбогдох хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих, хөдөлмөр эрхлэлтийн асуудлаар дүгнэлт, зөвлөмж гаргах, шаардлагатай асуудлыг эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлэхэд оршино.

2. Үндэсний зөвлөл нь Засгийн газар, ажил олгогчийн болон ажилтны эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалах улсын хэмжээний байгууллагын төлөөлөл бүхий орон тооны бус үндэсний зөвлөлдөх байгууллага мөн.

3. Үндэсний зөвлөл нь Үндсэн хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль, бусад хууль, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ болон энэхүү дүрмийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгоно.

4. Үндэсний зөвлөл нь тогтоосон журмын дагуу хийсэн тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

Хоёр. Үндэсний зөвлөлийн удирдлага, зохион байгуулалт

5. Үндэсний зөвлөл нь Засгийн газар, ажил олгогч, ажилтны эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалах улсын хэмжээний байгууллагын төлөөлөл бүхий 9 гишүүний бүрэлдэхүүнтэй байна.

6. Үндэсний зөвлөлийн гишүүдийг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 20 дугаар зүйлийн 4 дэх хэсэг, орлогч даргыг мөн хуулийн 20 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт заасны дагуу тус тус батална.

7. Үндэсний зөвлөлийн ажлын албаны үүргийг Хөдөлмөр эрхлэлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага гүйцэтгэх бөгөөд Үндэсний зөвлөлийн үйл ажиллагааны зардлыг Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамны төсөвт тусган батална.

8. Үндэсний зөвлөлийн хуралдаанд талууд төлөөлөгчөө бүрэн оролцуулах үүрэг хүлээнэ. Хуралдааныг нийт гишүүдийн болон тал тус бүрийг төлөөлөх гишүүдийн олонхи оролцсон тохиолдолд хүчинтэйд тооцно.

9. Үндэсний зөвлөл нь улиралд нэгээс доошгүй удаа хуралдана. Хуралдааныг Зөвлөлийн дарга, түүний түр эзгүйд орлогч дарга зарлан хуралдуулна. Шаардлагатай үед аль нэг талын санаачилгаар ээлжит бус хуралдааныг хийж болно.

10. Үндэсний зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэх асуудалтай холбогдуулан шаардлагатай тохиолдолд зөвлөх мэргэжилтэн, шинжээч, төрийн болон төрийн бус байгууллагын төлөөлөгчдийг хуралдаанд оролцуулж болно.

11. Үндэсний зөвлөлийн хуралдаанаас санал, дүгнэлт, зөвлөмж гарах бөгөөд тэдгээрт тал тус бүрээс эрх олгосон нэг төлөөлөгч зөвшөөрөн гарын үсэг зурна.

Гурав. Үндэсний зөвлөлийн эрх, үүрэг

12. Үндэсний зөвлөл нь дор дурдсан эрхтэй байна:

а/хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх асуудлаар төрөөс явуулж буй бодлого, хууль тогтоомж, энэ чиглэлээр тус улсын нэгдэн

орсон олон улсын конвенцийн хэрэгжилтийн байдалд санал, дүгнэлт гаргах, холбогдох байгууллагад санал оруулах;

б/шинээр боловсруулж буй хууль тогтоомж, хөтөлбөрийн төсөлтэй танилцаж, хөдөлмөр эрхлэлтийн асуудлаар санал өгөх, холбогдох байгууллагатай зөвшилцөн ажлын хэсэгт үндэсний зөвлөлийн гишүүдээс томилж оруулах;

в/хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа, боловсон хүчний хангалт, санхүүгийн асуудлаар хөдөлмөр эрхлэлтийн байгууллагын тайлан, мэдээллийг сонсон хэлэлцэж санал, дүгнэлт гаргах, шаардлагатай асуудлыг холбогдох байгууллагад тавьж шийдвэрлүүлэх;

г/хөдөлмөр эрхлэлтийн талаархи хууль тогтоомжийн хэрэгжилт, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн орлого, зарлагын байдалд хяналт тавих;

д/Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хагас жилийн болон жилийн төсвийн тайланг хэлэлцэж дүгнэлт гаргах;

е/холбогдох мэдээ, материалыг зохих байгууллага, албан тушаалтнаас гаргуулан авах;

ж/хөдөлмөр эрхлэлтийн асуудлаар зөвлөмж гаргах.

13. Үндэсний зөвлөл дор дурдсан үүрэгтэй байна:

а/хөдөлмөр эрхлэлтийн талаархи хууль тогтоомж, хөтөлбөр, төслийг хэрэгжүүлэх, биелэлтэд хяналт тавихад төрийн захиргааны байгууллагад дэмжлэг үзүүлэх;

б/хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн орлого, зарлагын байдалд хяналт тавих ажлыг зохион байгуулж хэрэгжүүлэх;

в/хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны хүрээнд нийгмийн түншлэлийг хөгжүүлэх, иргэд, төрийн бус байгууллагын оролцоог идэвхжүүлэх;

г/хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ болон ажлын байр нэмэгдүүлэх хөтөлбөр, төсөл, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага, ажилгүйдлийн даатгалтай холбогдох асуудлыг бусад үндэсний зөвлөлтэй уялдуулан зохицуулах, санал тавьж шийдвэрлүүлэх;

д/хөдөлмөр эрхлэлтийг дэмжих талаар төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдээс гаргасан үүсгэл санаачилгыг дэмжин, үйл ажиллагааг нь уялдуулах, арга туршлагаа солилцож, хамтран ажиллахад нь дэмжлэг, туслалцаа үзүүлэх;

е/хөдөлмөр эрхлэлтийн асуудлаар олон улсын болон гадаад орнуудын холбогдох байгууллагатай харилцаа тогтоох, хамтын ажиллагааг хөгжүүлэх.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 6 дугаар сарын 27-ны өдөр **Дугаар 139** **Улаанбаатар хот**

Журам батлах тухай

Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 5 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

"Ажлын байрны төлбөр авах, хөнгөлөлт үзүүлэх, чөлөөлөх журам"-ыг хавсралт ёсоор батлагдсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

НИЙГМИЙН ХАМГААЛАЛ, ХӨДӨЛМӨРИЙН САЙД **Ш.БАТБАЯР**

Засгийн газрын 2001 оны 139 дүгээр тогтоолын хавсралт

АЖЛЫН БАЙРНЫ ТӨЛБӨР АВАХ, ХӨНГӨЛӨЛТ ҮЗҮҮЛЭХ, ЧӨЛӨӨЛӨХ ЖУРАМ

Нэг. Ерөнхий зүйл

1. Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хуулийн 9 дүгээр зүйлд заасан ажлын байрны төлбөр авах, хөнгөлөлт үзүүлэх, чөлөөлөхтэй холбогдсон харилцааг зохицуулахад энэхүү журмыг мөрдөнө.

2. Ажлын байрны төлбөр гэдэгт Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллага, иргэн /цаашид "байгууллага" гэх/ нь гадаадын иргэнийг ажлын байраар хангаж, орлого бүхий ажил эрхлүүлсний төлөө хуулиар ногдуулсан хураамжийг ойлгоно.

3. Ажлын байрны сарын төлбөр нь гадаадын иргэн бүрт Засгийн газраас тогтоосон хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцүү хэмжээтэй байна.

Хоёр. Ажлын байрны төлбөр авах

4. Байгууллага нь Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажилах хүч, мэргэжилтэн авах тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу хөдөлмөр эрхлэлтийн төв байгууллагаас гадаадын иргэнд Монгол Улсад хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл авахдаа ажлын байрны төлбөр төлнө.

5. Тухайн байгууллага хөдөлмөр эрхлүүлэх зөвшөөрлийг 5 хүртэл гадаадын иргэнд авах тохиолдолд ажлын байрны төлбөрийг урьдчилан төлөх ба түүнээс дээш тооны гадаадын иргэдийн хувьд ажлын байрны төлбөрийг төлөх хугацаа, нөхцөлийн талаар хөдөлмөр эрхлэлтийн төв байгууллагатай харилцан тохиролцож гэрээний дагуу төлж болно.

6. Хөдөлмөр эрхлэлтийн төв байгууллага ажлын байрны төлбөрийг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн дансанд төвлөрүүлэх ба ажлын байрны төлбөр төлсөн, эсхүл хөнгөлөлт үзүүлсэн, чөлөөлсөн тухай бүртгэл хөтөлнө.

7. Монгол Улсад хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл бүхий гадаадын иргэн нь тухайн байгууллагатай байгуулсан хөдөлмөрийн гэрээгээ хугацаанаас өмнө цуцалж, буцсан тохиолдолд ажиллаж байсан байгууллагын болон Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх албаны тодорхойлолтыг үндэслэн урьдчилан төлсөн төлбөрийг байгууллагад буцаан олгож болно.

Гурав. Ажлын байрны төлбөрөөс чөлөөлөх, хөнгөлөлт үзүүлэх

8. Дор дурдсан гадаадын иргэдийг ажлын байрны төлбөрөөс чөлөөлнө:

а/гадаадын дипломат төлөөлөгчийн болон консулын газар /Монгол Улсад суугаа гадаад орны Элчин сайдын яам, Консулын газар гэх мэт/-ын ажилтнууд, тэдний гэр бүлийн хүмүүс;

б/олон улсын байгууллагын суурин төлөөлөгчийн газар /НҮБ-ын хөгжлийн хөтөлбөрийн газар, Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын салбар гэх мэт/-т ажиллаж байгаа гадаадын иргэд, тэдний гэр бүлийн хүмүүс;

в/Монгол Улсын гэрээ болон төрийн захиргааны төв байгууллагатай байгуулсан гэрээ, хэлэлцээрийн дагуу ажиллаж байгаа сайн дурын ажилтан;

г/Засгийн газар хоорондын гэрээнд заасан тохиолдолд уг гэрээний дагуу ажиллаж байгаа мэргэжилтэн, ажилтнууд;

д/Монгол Улсад хүмүүнлэгийн үйл ажиллагаа явуулах хууль ёсны зөвшөөрөл бүхий гадаадын төрийн бус /ашгийн бус/ байгууллагын ажилтнууд;

е/боловсрол, шинжлэх ухааны салбарт гэрээгээр ажиллаж байгаа гадаадын мэргэжилтэн, ажилтнууд.

9. Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл

ажиллагаа явуулдаг боловсрол, шинжлэх ухааны байгууллагад зөвлөх мэргэжилтэн, багш, эрдэм шинжилгээний ажилтнаар ажиллаж байгаа гадаадын мэргэжилтэн, ажилтныг ажлын байрны төлбөрөөс чөлөөлөхэд тэдний мэргэжлийн диплом, үнэмлэх, байгууллагын хүсэлтийг үндэслэнэ.

10. Монгол Улсад хувийн хэргээр удаан хугацаагаар оршин суугч, байнга оршин суугч, цагаач иргэдэд энэ журамд заасан төлбөр хамаарахгүй.

11. Улсын хэмжээний томоохон төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, барилга, байгууламж барих, байгалийн гамшиг, суйрлийн хор хөнөөлийг арилгахад шаардагдах ажиллах хүч, мэргэжилтнийг Засгийн газрын шийдвэрийн дагуу гадаадаас авч ажиллуулах тохиолдолд ажлын байрны төлбөрөөс чөлөөлнө.

12. Яам, Засгийн газрын агентлагийн байгууллан гэрээ, албан ёсны урилгын дагуу хамтын ажиллагааны шугамаар төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, судалгаа, шинжилгээний ажил гүйцэтгүүлэх, зөвлөлгөө авах зорилгоор гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авч ажиллуулах тохиолдолд Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамны шийдвэрээр байгууллагыг ажлын байрны төлбөрөөс 50 хувиар хөнгөлнө.

13. Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн хөрөнгө оруулагч, удирдах бүрэлдэхүүний 3-аас дээшгүй гишүүн гадаадын компанийн Монгол Улс дахь төлөөлөгчийг Засгийн газрын холбогдох агентлагийн тодорхойлолтыг үндэслэн ажлын байрны төлбөрөөс чөлөөлнө.

Дөрөв. Бусад зүйл

14. Хөдөлмөр эрхлэлтийн төв байгууллага нь энэхүү журамд заасан төлбөрийн талаарх тайланг Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яаманд улирал тутам гаргаж өгнө.

15. Байгууллага нь энэхүү журамд заасан төлбөр авах, хөнгөлөлт үзүүлэх, чөлөөлөх асуудалд хамруулах гадаадын иргэдийн талаар үнэн зөв тодорхойлолт гаргах үүрэгтэй.

16. Байгууллага ажлын байрны төлбөрийг 1 сараас дээш хугацаагаар төлөөгүй, энэ журмын 5 дахь заалтад заасан гэрээний үүргээ биелүүлээгүй нөхцөлд хөдөлмөр эрхлэлтийн төв байгууллага нь тухайн гадаадын иргэний хөдөлмөр эрхлэх зөвшөөрлийг хүчингүй болгож, энэ тухай Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх албанд мэдэгдэнэ. Үүний зэрэгцээ тухайн байгууллагад Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хуулийн 12 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2-т заасан хариуцлага хүлээлгэнэ.

17. Энэ журмын хэрэгжилтэд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын улсын хяналтын алба хяналт тавина.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 6 дугаар сарын 27-ны өдөр **Дугаар 140** **Улаанбаатар хот**

Жагсаалт батлах тухай

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 10, Гаалийн тарифын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 1-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Гадаадын хөрөнгө оруулах тэргүүлэх ач холбогдол бүхий салбарын жагсаалтыг хавсралт ёсоор батална.

2. Жагсаалтад заасан салбар, технологийн зориулалтаар ашиглах, үгсарч суурилуулах тоног төхөөрөмж, хүнд механизмын жагсаалтыг Бараат тодорхойлох, кодлох уялдуулсан системийн кодоор гаргаж батлан мөрдүүлэхийг Сангүү, эдийн засгийн сайд Ч.Улаан, Үйлдвэр, худалдааны сайд Ч.Ганзориг нарт үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

ҮЙЛДВЭР, ХУДАЛДААНЫ САЙД **Ч.ГАНЗОРИГ**

Засгийн газрын 2001 оны 140 дүгээр тогтоолын хавсралт

ГАДААДЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАХ ТЭРГҮҮЛЭХ АЧ ХОЛБОГДОЛ БҮХИЙ САЛБАРЫН ЖАГСААЛТ

Салбар, дэд салбар	Бүлэг, дэд бүлэг	Салбар
A.01		***Хөдөө аж ахуй***
	0111	Үр тариа, жимс, чихрийн манжин, тосны болон малын тэжээлийн ургамал тариалах
	0121	Эрчимжсэн мал аж ахуй /сүү,махны чиглэл,тахиа/
		Олборлох үйлдвэр
C.10		Нүүрсний олборлолт
	1010	Бүх төрлийн чулуун нүүрсийг гүний болон ил уурхайн аргаар олборлох, бутлах, зэрэглэх, чанарыг сайжруулах. Шахмал түлш үйлдвэрлэх
	1020	Хүрэн нүүрс, нүүрсний төрлийн түлш олборлолт, шахмал түлш үйлдвэрлэх
	1030	Хүлэр, занар олборлолт
C.11		Газрын тос, шатдаг хийн олборлолт
	1110	Нефть болон нефть бүхий эрдэс бодис олборлолт, тунгаах, бэхжүүлэх, боловсруулах, шатдаг хий олборлох
	1120	Газрын тос, шатдаг хийн цооног өрөмдөж, тоноглох, цамхаг босгох, засварлах зэрэг ажил, үйлчилгээ үзүүлэх
C.12		Уран, торийн хүдрийн олборлолт
	1200	Уран, торийн хүдэр болон цацраг идэвхт бодис агуулсан хүдэр олборлох
C.13		Төмөрлөгийн хүдрийн олборлолт
	1310	Төмрийн хүдэр, төмөр агуулсан бодис олборлох, баяжуулах, ангижруулах /халаах, жижиглэх, тунгаах, ялгах, цэвэрлэх/
	1320	Зэс, цайр, цагаан тугалга, вольфрам, молибден болон алт, мөнгө, ховор /ниобий, тантал, цирконий гэх мэт/ металл, газрын ховор металл, стронцийн хүдэр олборлох
C.14		Бусад ашигт малтмалын олборлолт
	1421	Химийн болон бордооны эрдэс бодис олборлолт Азот, фосфор, хүхэр агуулсан эрдэс бодис, жонш, шороон будаг зэрэг химийн түүхий эд болох эрдэс бодис олборлох
	1429	Уул уурхайн бусад олборлолт Билүү чулуу, асбест, чулуужсан биет, шиллэг эд, өөхөн чулуу, гялтгануур, магнезит зэрэг эрдэс бодис олборлох
		Боловсруулах үйлдвэр
D.15		Хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл
	1511	Мах,махан бүтээгдэхүүн үйлдвэрлэлт, хадгалалт Мах хадгалах, хатаах, утах, давслах, лаазлах зэргээр боловсруулах
	1514	Ургамал, малын гаралтай тос үйлдвэрлэх

D.15		Гурил, малын тэжээлийн үйлдвэрлэл
	1533	Малын холимог, багсармал тэжээл үйлдвэрлэх
D.15		Хүнсний бусад үйлдвэрлэл
	1542	Нишингэ, манжингийн чихэр үйлдвэрлэх
D.17		Нэхмэлийн үйлдвэрлэл
	1711	Амьтан, үргамлын гаралтай ноосон болон цаасан утас ээрэх,нэхэх, будах, цайруулах, хэв тавих
	1712	Нэхмэл даавууны эцсийн боловсруулалт хийх
	1729	Шошго, тууз, ариун цэврийн зориулалттай нэхмэл бүтээгдэхүүн үйлдвэрлэх
D.18		Үслэг арьсны боловсруулалт
	1820	Үслэг, нэхий эдлэлийн эцсийн боловсруулалт хийх
D.19		Арьс, ширний боловсруулалт
	1911	Арьс, ширний боловсруулалт
	1912	Арьс ширэн эдлэл үйлдвэрлэх
	1920	Эрэгтэй, эмэгтэй, хүүхдийн бүх төрлийн гутал үйлдвэрлэх
D.20		Мод, модон эдлэл
	2021	Наамал, зоргодсон, үртсэн хавтан үйлдвэрлэх
D.23		Кокс, шингэн болон цацраг идэвхт түлш
	2310	Нүүрснээс кокс, давирхай, бусад дайвар бодис үйлдвэрлэх
	2320	Шатахуун үйлдвэрлэл Занар, газрын тосноос шингэн болон хийн түлш гаргах
D.24		Химийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл
	2411	Үйлдвэрлэлд ашиглагдах хий, ацетлин, хүчил, шүлт, будаг, идээлэх бодис зэргийг үйлдвэрлэх
	2412	Азот, фосфор, калийн бордоо, эдгээрийг агуулсан бодис үйлдвэрлэх
D.26		Төмөрлөг бус эрдэс бодисоор хийсэн эдлэл
	2692	Галд тэсвэртэй ваараан бүтээгдэхүүн Галд тэсвэртэй барилгын тоосго, тэсврийн хавтан, хоолой үйлдвэрлэх
	2694	Цемент, шохой, гөлтгөнө үйлдвэрлэх
D.27		Төмөрлөгийн үйлдвэрлэл
	2710	Ангижруулсан төмрийн хүдэр, төмрийн хаягдал хайлуулж анхдагч ширэм, ган үйлдвэрлэх /бэлдэц арматур, цутган хийсэн зам төмөр, хоолой, утас гэх мэт/

	2720	Үнэт, өнгөт металл, алт, мөнгө цэвэрлэх, хайлуулах, цахилгааны болон бусад химийн аргаар ялган өнгөт металл үйлдвэрлэх, зэс, хар тугалга, хөнгөн цагаан, цайр, молибден, вольфрам, ниобий, тантал, цирконий, газрын ховор металл, стронций зэрэг металл, тэдгээрийн хайлш үйлдвэрлэх
D.37		Хоёрдогч түүхий эдийн боловсруулалт
	3720	Төмрөөс бусад хоёрдогч түүхий эд бэлтгэж боловсруулах
		Дэд бүтцийн салбар
E.40		Цахилгаан, хий үйлдвэрлэл, ус хангамж
	4010	Цахилгаан үйлдвэрлэх, дамжуулах, хуваарилах үйл ажиллагаа /Усан цахилгаан станц, цахилгаан шугам сүлжээ, дулааны болон дизель цахилгаан станцууд/
	4030	Уур үйлдвэрлэл, халуун ус хангамж /Дулааны шугам сүлжээ/
E.41		Ус ариутгал, усан хангамж
	4100	Хүн ам, үйлдвэрлэлийн хэрэгцээний ус хуримтлуулан ариутгаж түгээх
F.45		Барилга
	4520	Инженерийн хийцтэй барилга байгууламж барих
	4530	Цахилгаан шат, дохиоллын тоноглол угсрах, байрлуулах, засвар хийх
	Тусгай	"Мянганы зам"-ын барилга байгууламжийг барих /машин механизм түрээслэх/
	Тусгай	Нефть, хий дамжуулах хоолойн барилга байгууламж

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 6 дугаар сарын 27-ны өдөр **Дугаар 143** **Улаанбаатар хот**

Дүрэм батлах тухай

Захиргааны хариуцлагын тухай хуулийн 4[1] дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Худалдаа, үйлдвэр, үйлчилгээний улсын хяналтын дүрэм"-ийг хавсралт ёсоор баталсугай.

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Худалдаа, үйлдвэр, үйлчилгээний улсын хяналтын дүрэм батлах тухай" Засгийн газрын 1995 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн 210 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

ҮЙЛДВЭР, ХУДАЛДААНЫ САЙД **Ч.ГАНЗОРИГ**

Засгийн газрын 2001 оны 143 дугаар тогтоолын хавсралт

ХУДАЛДАА, ҮЙЛДВЭР, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ УЛСЫН ХЯНАЛТЫН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Худалдаа, үйлдвэр, үйлчилгээний улсын хяналтын зорилго нь өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллага, Монгол Улсын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол тус улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа гадаадын аж ахуйн нэгж, байгууллагад Монгол Улсын Хүнсний тухай, Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай болон бусад хууль, тэдгээрийг үндэслэн төрийн эрх бүхий байгууллагаас нийтээр дагаж мөрдөхөөр тогтоосон стандарт, дүрэм, журмын хэрэгжилтэд хяналт тавих, бизнесийн ажил үйлчилгээг чөлөөтэй явуулах таатай орчинг бүрдүүлэхэд оршино.

2. Монгол улсын нутаг дэвсгэрт худалдаа, үйлдвэр, үйлчилгээний улсын хяналтыг Засгийн газрын тохируулагч агентлаг-Үйлдвэр, худалдааны улсын хяналтын алба, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын дэргэдэх мэргэжлийн хяналтын алба, улсын ерөнхий байцаагч, ахлах байцаагч, байцаагч /цаашид "улсын байцаагч"/ нар хэрэгжүүлнэ.

3. Худалдаа, үйлдвэр, үйлчилгээний улсын хяналтад гадаад, дотоодын хөрөнгө оруулалт, түүний эд бэлтгэлийн асуудал, худалдаа, нийтийн хоол, зочид буудал, ахуй үйлчилгээний бүх цэг, салбар, хөнгөн, хүнд үйлдвэр болон нефть боловсруулах үйлдвэр, агуулах, шатахуун түгээх станц зэргийн үйл ажиллагаа хамрагдана.

4. Худалдаа, үйлдвэр, үйлчилгээний улсын байцаагч нь хяналт шалгалтын үйл ажиллагаандаа хууль тогтоомж, эрх бүхий байгууллагаас гаргасан стандарт, дүрэм, журмыг удирдлага болгон ажиллана.

5. Худалдаа, үйлдвэр, үйлчилгээний улсын байцаагч үнэмлэх, хувийн дугаар бүхий тэмдэг, лац, түүнчлэн албан шаардлага, дүгнэлт, акт, торгуулийн хуудас хэрэглэнэ.

6. Үйлдвэр, худалдааны улсын хяналтын алба нь Худалдаа, үйлдвэр, үйлчилгээний улсын байцаагчийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, мэргэжил, ажлын ур чадварыг нь дээшлүүлэх үйл ажиллагааг нь шалгах, шалгалтын дүнг нэгтгэн дүгнэлт гаргаж холбогдох байгууллагуудад хүргэх, хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилах, шаардлагатай зарим асуудлаар авах арга хэмжээний талаар санал боловсруулж эрх бүхий байгууллагаар шийдвэрлүүлэхийг хариуцан хэрэгжүүлнэ.

7. Монгол Улсын хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан хууль, тогтоомжоор олгогдсон өөрийн бүрэн эрхэд хамаарах асуудлын хүрээнд нийтээр дагаж мөрдүүлэхээр эрх зүйн хэм хэмжээ тогтоосон баримт бичиг боловсруулан батлуулж хууль зүйн асуудал хариуцсан яамаар хянуулан улсын бүртгэлд оруулан мөрдүүлж болно.

Хоёр. Худалдаа, үйлдвэр, үйлчилгээний улсын хяналтын чиглэл

8. Худалдаа, үйлдвэр, үйлчилгээний улсын хяналтыг дор дурдсан чиглэлээр хэрэгжүүлнэ. Үүнд:

а/бараа бүтээгдэхүүний үйлдвэрлэл, үйлчилгээ, хадгалалт, хамгаалалт, тээвэрлэлт, худалдахтай холбогдуулан гаргасан хууль тогтоомж болон эрх бүхий байгууллагаас гаргасан стандарт, дүрэм, журмыг худалдаа, үйлдвэр, үйлчилгээний байгууллага, иргэд хэрэгжүүлж байгаа байдал;

б/худалдаа, үйлдвэр, үйлчилгээний зохион байгуулалт, ажил, үйлчилгээний соёл, технологийн горимд тогтоосон нийтлэг шаардлагыг хангасан байдал;

в/хоол үйлдвэрлэлийн газруудын

байр, орчин, технологийн үйл ажиллагаа болон хоолны технологийн карт /БСТ/ мөрдөлт, дээж авалт, түүнийг хөтөлж байгаа байдал, ариун цэвэр, бараа материал, түүхий эдийн хадгалалт нь эрүүл ахуйн шаардлага хангасан байдал;

г/Монгол Улсын нутаг дэвсгэрт худалдаа, үйлдвэр, үйлчилгээ явуулж байгаа гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж, байгууллага, тэдгээрийн төлөөлөгчийн газрын ажил, үйлчилгээний соёл, экспорт, импортын бараа бүтээгдэхүүний гарал үүслийг гэрчилсэн байдал;

д/хүн амын өргөн хэрэглээний нийтийн ахуйн болон техникийн засвар үйлчилгээ, зочид буудал, амралт сувиллын газрын технологи болон ажил, үйлчилгээний шаардлагын хэрэгжилтийн байдал;

е/улсын нөөцийн нефть бүтээгдэхүүний хадгалалт, хамгаалалт, зарцуулалт;

ж/хэрэглээний аюулгүй байдлыг хангах үүднээс хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд гэм хор учруулж болзошгүй бараа бүтээгдэхүүнийг эрүүл ахуй, стандарт, чанарын баталгаатай худалдаж байгаа эсэх;

з/сав баглаа, боодол, шошгонд олон улс болон Монгол Улсын хэмжээнд нийтлэг хэрэглэдэг барааны таних тэмдэг, анхааруулга, бичээс, үйлдвэрлэсэн огноо, хадгалах хугацаа, хэрэглэх зааврыг ил тод тавьсан байдал;

и/бараа, бүтээгдэхүүнийг шаардлагын дагуу шошголож савласан байдал;

к/хэрэглэгчдэд бараа материал, бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний зориулалт, тэдгээрийн хэрэглээний шинж чанар, хадгалах нөхцөл, хэрэглэх арга, баталгаат хугацааны талаар үнэн зөв, бүрэн мэдээлэл өгсөн байдал;

л/эрүүл ахуйн шаардлага хангаагүй байр орчин, худалдаа хийхийг зөвшөөрөөгүй газар, цэгт болон эмнэлгийн шинжилгээний баталгаагүй, насанд хүрээгүй, хуулийн хариуцлага хүлээх чадваргүй этгээдээр худалдаа, үйлчилгээ явуулж буй эсэх;

м/нефть боловсруулах үйлдвэр, нефтийн бүтээгдэхүүний агуулах, түгээх станцын барилга, байгууламж нь техникийн нөхцөл, зохих шаардлагад нийцэж байгаа байдал;

н/нефтийн бүтээгдэхүүний боловсруулалт, чанарын шаардлага, стандарт, техникийн нөхцөлийн хэрэгжилт, тээвэрлэлт, хүлээн авалт, хадгалалт, түгээлтийн аюулгүй ажиллагааны байдал;

о/нефть боловсруулах үйлдвэр, нефтийн бүтээгдэхүүний агуулах, түгээх станцын сав, түгээгүүр, хэмжих хэрэгслийн улсын баталгаажилт; тоног төхөөрөмжийн тохиргоо; сав, шугам хоолойн битүүмжлэл,түгээгүүрийн ажиллагаа стандарт, ашиглалтын зааварт нийцэж байгаа байдал;

п/зориулалтын бус байранд буюу орчинд албан ёсны зөвшөөрөлгүйгээр нефтийн бүтээгдэхүүнээр үйлчилгээ явуулж, хадгалж байгаа байдал;

р/худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээнд бүтээгдэхүүний борлуулалтын тооцооны кассын төхөөрөмж ашиглалтын шаардлага хангагдаж байгаа эсэх;

с/нефть боловсруулах үйлдвэр , нефтийн бүтээгдэхүүний агуулах, түгээх станцын ил далд барилга байгууламжид газар олгосон байдал, сав, тоног төхөөрөмж, шугам хоолой, агааржуулагч, амьсгалах клапан, аянга зайлуулагч, газардуулгын сүлжээний үзгралт, холболтын чанар, аюулгүй байдал нь стандарт, техникийн нөхцөлийн шаардлагад нийцсэн эсэх, далд ажлын актын бүрдэлд эрх бүхий байгууллагуудтай хамтран урьдчилсан хяналт хийж дүгнэлт гаргах;

т/нефтийн бүтээгдэхүүн боловсруулах, хадгалах, түгээх, борлуулах, химийн үгаалга, цэвэрлэгээтэй холбогдсон ажил, үйлчилгээ эрхэлж буй байгууллагын үйл ажиллагаанд тавигдах шаардлага, стандартын биелэлтийн байдал;

у/худалдаа, үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдэд аймаг, нийслэл, сум, дүүргээс олгож байгаа зөвшөөрөл /лицензэ/-ийг холбогдох хууль тогтоомжийн дагуу олгож байгаа байдал.

Гурав. Худалдаа, үйлдвэр, үйлчилгээний улсын байцаагчийн үүрэг, бүрэн эрх

9. Төрийн хяналт, шалгалтын тухай болон бусад хууль тогтоомжийн хүрээнд үйл ажиллагаа явуулж буй худалдаа, үйлдвэр, үйлчилгээний улсын байцаагч дор дурдсан үүрэг гүйцэтгэнэ:

а/хяналт шалгалтыг энэ дүрмийн 8 дугаар зүйлд заасан чиглэлээр энэ дүрэм болон хууль тогтоомжийн хүрээнд батлагдсан удирдамжийн дагуу зохион байгуулж явуулах, илэрсэн зөрчлийг шуурхай арилгах арга хэмжээ авах;

б/хууль тогтоомжийг чанд сахих, хөндлөнгийн нөлөөнд үл автах, албан үүргээ үнэнчээр гүйцэтгэх, төр, байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтан, тэдгээрийн нууцыг хадгалж хувь хүний хууль ёсны ашиг сонирхол, нэр төрийг хүндэтгэн хяналт шалгалтыг бүрэн гүйцэд хийж, үр дүнг холбогдох байгууллага, албан тушаалтан, иргэдэд мэдээлэх;

в/хийсэн шалгалт, илрүүлсэн зөрчил дутагдал, өгсөн албан шаардлага, гаргасан танилцуулга, дүгнэлт, тавьсан акт, торгууль, шийтгэвэр, тоо баримтын үндэслэл, нотлогооны үнэн зөвийг бүрэн хариуцах;

г/хийсэн шалгалт, илрүүлсэн зөрчлийн хүрээнд эрүүгийн хэргийн чанартай асуудал тулгарвал хууль хяналтын байгууллагад холбогдох материал, баримтыг шилжүүлэх.

10. Улсын байцаагч нь дор дурдсан эрх эдлэнэ:

а/хяналт шалгалт хийх объектод саадгүй нэвтрэн орох;

б/хяналт, шалгалтын явцад илэрсэн зөрчлийг газар дээр нь арилгуулах, түүний шалтгаан нөхцөлийг тогтоон засах талаар хүсэлтээ шаардлага тавьж биелэлтийг хангуулах, хариу авах;

в/холбогдох байгууллагатай тохиролцож зохих мэргэжлийн хүмүүсийг хяналт шалгалтын ажилд татан оролцуулах, лабораторийн буюу магадлан шинжилгээг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлж дүгнэлт гаргуулах;

г/хяналт шалгалтын ажилд шаардлагатай мэдээ, судалгаа, магадалгаа, тодорхойлолт, тайлбарыг холбогдох байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтнаас үнэ төлбөргүй гаргуулан авах;

д/хяналт шалгалтын явцад илэрсэн зөрчлийн талаар тодорхойлолт гаргуулах, бодит байдлыг харуулсан зураг авах, дүрс болон ярианы бичлэг хийх;

е/шаардлагатай үед бүтээгдэхүүний дээж, загварыг албан ёсоор төмдэглэл үйлдэн захиргааны хяналтын эрх бүхий байгууллагаас тогтоосон тоо хэмжээгээр авах;

ж/хяналт шалгалтын явцад шаардлагатай гэж үзвэл агуулах, үйлдвэрлэл, үйлчилгээний байрыг битүүмжлэн нягтлан шалгаж холбогдох арга хэмжээ авах;

з/хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд шууд буюу шууд бусаар хохирол учруулж байгаа эсвэл учруулж болзошгүй, түүнчлэн осол аюул гарч болох нь зохих ёсоор нотлогдсон; чанарын шаардлага хангахгүй бараа, бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн, нийлүүлсэн, хүлээн авсан, худалдсан болон худалдаа, үйлдвэр, үйлчилгээний дэг журмыг ноцтой зөрчсөн тохиолдолд холбогдох үйлдвэрлэл, ажил, үйлчилгээг үг зөрчлийг арилгах хүртэл бүхэлд нь буюу хэсэгчлэн түр зогсоох, холбогдох бүтээгдэхүүнийг худалдах, борлуулахыг хориглох акт үйлдэж улсын орлогод хураан авах, устгах буюу өөр зориулалтаар ашиглахад харшлахгүй бол зохих санал гаргаж шийдвэрлүүлэх, энэ тухай олон нийтэд мэдээлэх;

и/шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг шуурхай арилгахтай холбогдсон асуудлыг орон нутгийн болон төрийн захиргааны төв байгууллагад тавих;

к/улсын байцаагч нь хууль тогтоомж, стандарт, дүрэм журам зөрчсөн, эсхүл илэрсэн зөрчлийг арилгах талаар тавьсан шаардлагыг биелүүлээгүй аж ахуйн нэгж, байгууллага болон гэм буруутай этгээдэд Төрийн хяналт, шалгалтын тухай, Захиргааны хариуцлагын тухай, Хүнсний тухай, Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хууль болон холбогдох бусад хуулийн заалтыг үндэслэн захиргааны хариуцлага ногдуулах.

Дөрөв. Бусад зүйл

11. Худалдаа, үйлдвэр, үйлчилгээний улсын хяналтын алба, улсын байцаагчийн албан шаардлагыг байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтан, иргэд хугацаанд нь биелүүлж, хариуг албан ёсоор өгөх үүрэг хүлээнэ.

12. Худалдаа, үйлдвэр, үйлчилгээний улсын хяналтын алба нь худалдаа, үйлдвэр, үйлчилгээний үйл ажиллагаатай холбогдуулан гаргасан санал, хүсэлт, өргөдөл, гомдлыг зохих журмын дагуу шийдвэрлэнэ.

13. Шалгуулсан аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан, иргэд хяналт шалгалтын дүнгээр улсын байцаагчийн гаргасан шийдвэрийг үндэслэлгүй гэж үзвэл гомдлоо улсын ерөнхий байцаагчид 10 хоногийн дотор гаргана. Уг гомдлыг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор хянан шийдвэрлэнэ. Гомдол гаргагч уг шийдвэрийг эс зөвшөөрвөл гомдлоо шүүхэд гаргаж болно. Гомдол гаргах нь зөрчлийг арилгахгүй байх үндэслэл болохгүй.

14. Улсын байцаагч нь хяналт шалгалт хийж байгаа аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан, иргэдээс шууд буюу шууд бус хэлбэрээр шагнал урамшуулал авч болохгүй.

15. Улсын байцаагч энэ дүрмээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, хууль, тогтоомж зөрчсөн бол холбогдох хууль тогтоомжид заасны дагуу зохих хариуцлага хүлээнэ.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 6 дугаар сарын 27-ны өдөр **Дугаар 144** **Улаанбаатар хот**

Мал өвөлжилтийн талаар авах зарим арга хэмжээний тухай

2000-2001 оны малын өвөлжилт, хаваржилтын талаар Хүнс, хөдөө аж ахуйн сайд Д.Насанжаргал, Хөвсгөл аймгийн Засаг дарга Л.Дамдинсүрэн нарын мэдээллийг хэлэлцээд, сүүлийн жилүүдэд манай оронд тохиолдсон байгалийн гамшигийн байдалд дүгнэлт хийж, цаашид учирч болзошгүй хүндрэл, бэрхшээлээс урьдчилан сэргийлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Орон нутаг дахь хадлан бэлтгэл, тэжээлийн үйлдвэрлэлийн хэмжээг нэмэгдүүлэх, мал сүргийг байгалийн болзошгүй гамшгийн эрсдэлээс хамгаалах чиглэлээр боловсруулсан "Хадлан, тэжээл-2001" төслийг хавсралт ёсоор батлагдсугай.

2. Хүнс, хөдөө аж ахуйн сайд Д.Насанжаргалд даалгах нь:

а/Байгаль орчны яам, Улсын байцаагчийн онцгой комисстой хамтран 2001 оны зуншлага, ирэх өвлийн цаг агаарын тойм, зураглалыг энэ оны 7 дугаар сард багтаан аймаг, сум бүрээр нарийвчлан гаргасны үндсэн дээр отор нүүдэл хийх, хадлан бэлтгэх газар нутгийг зохицуулах арга хэмжээг шуурхай зохион байгуулж хэрэгжүүлсүгэй;

б/таваарын зориулалтаар ОХУ-д мал экспортлох асуудлыг зохицуулан шийдвэрлүүлж, хэрэгжилтэд нь хяналт тавьж байсугай;

в/"Хадлан, тэжээл-2001" төслийг хэрэгжүүлэх ажлын явц, биелэлтэд тогтмол хяналт тавьж дүнг 2001 оны 12 дугаар сард багтаан Засгийн газарт танилцуулсугай.

3. Аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгах нь:

а/ газар нутгийн онцлог, бэлчээрийн гарц, усан хангамж зэргийг харгалзан мал оторлох, өвөлжүүлэх нутгийг оновчтой тогтоож, шаардагдах хашаа, хорооны хангамжийг сайжруулах, уст цэгийг сэргээн засварлаж, лайдах, улмаар түүнийг малчдад эзэмшүүлэх, дулаалга хийлгэх, энгийн уурхайн худаг гаргах ажлыг зохион байгуулан 11 дүгээр сарын 20-ны дотор багтаан дүгнэсүгэй;

б/"Мал сүргийг ган, зудаас хамгаалахад туслах үндэсний хөтөлбөр", "Хадлан, тэжээл-2001" төслийг хэрэгжүүлэх ажлыг шуурхай зохион байгуулж, биелэлтэд нь байнын хяналт тавьж ажиллах, энэ хүрээнд хадлан, тэжээл бэлтгэх ажлыг аймаг, сум, баг, өрхийн хэмжээнд 7 дугаар сараас эхлэн хэрэгжүүлэх арга хэмжээ авсугай;

в/2000-2001 оны өвөл, хавар мал нь

олноор хорогдож малгүй буюу цөөн малтай болсон өрхийн судалгааг нарийвчлан гаргаж, малжуулах болон тэдний амьжиргааг дэмжлүүлэх бодлогыг энэ оны 7 дугаар сард боловсруулан хэрэгжүүлж эхэлсүгэй;

г/мал өвөлжүүлэх газар, отрын бүс нутгийг аймгийнхаа зуншлага,намаржилтын байдалтай уялдуулан 9 дүгээр сард багтаан тогтоож, өвөлжөө, хаваржааны бэлчээрийг нөөцлөж хамгаалах арга хэмжээ авсугай;

д/малын халдварт, паразиттах өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрүүлжүүлэх арга хэмжээ, өвөлжөө, хаваржааны орчны ариутгал, халдваргүйжүүлэлтийг технологийн хугацаанд нь чанартай зохион байгуулж явц, үр дүнд хяналт тавьж ажилласугай;

е/малчид, иргэдийн хүч хөдөлмөр, хөрөнгийг хорших, хамтын хүчийг ашиглах замаар хадлан, тэжээл бэлтгүүлэх, сум, баг бүрийг өвөрлөн өвс, тэжээлийн нөөцтэй болгох ажлыг зохион байгуулахын хамтаар малчдад хадлангийн талбай эзэмшүүлж хамгаалалтад авахуулах, бордох, услах зэргээр ургац нэмэгдүүлэх, хадлан, тэжээлээ бэлтгэхэд нь боломлоотой бүх талын дэмжлэг, туслалцаа үзүүлэх арга хэмжээ авч ажилласугай;

ж/мал өвөлжүүлэх бэлтгэлийг сум, баг, өрх бүрээр 10 дугаар сард багтаан шалгаж үнэлэлт, дүгнэлт өгч дүнг Хүнс, хөдөө аж ахуйн яаманд ирүүлсүгэй.

4. "Хадлан тэжээл-2001" төслийг хэрэгжүүлэхэд зориулан эргэн төлөгдөх нөхцөлөөр 650, 0 (зургаан зуун тавин) сая төгрөг гаргахыг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаанд даалгасугай.

5. Гадаад орон, олон улсын байгууллагаас Улсын байнгын онцгой комиссын нэр дээр ирүүлсэн хандив, тусламжаас Санхүү, эдийн засгийн яамтай тохиролцсон хуваарийн дагуу хадлан, тэжээлийн нөөцийг нэмэгдүүлэхэд зориулан эргэж төлөгдөх нөхцөлөөр зарим аймагт санхүүгийн дэмжлэг үзүүлэхийг Батлан хамгаалахын сайд, Улсын байнгын онцгой комиссын дарга Ж.Гүррагчаад даалгасугай.

6. Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаан, Хүнс, хөдөө аж ахуйн сайд Д.Насанжаргал нарт даалгах нь:

а/мал аж ахуйг байгалийн эрсдэлээс хамгаалахад зориулан байгуулах "Мал хамгаалах сан"-г эхний ээлжинд улсын төвлөрсөн төсөв, гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөс бүрдүүлж, түүнийг зарцуулах журам, зээл төлөгдөх нөхцөлийг боловсруулан батлаж мөрдүүлсүгэй;

б/аймаг дундын отрын бүс нутагт хашаа барих, уст цэг гаргах, улсын нөөцийн өвс, тэжээлийг нэмэгдүүлэхэд шаардагдах хөрөнгийг тооцож 2002 оноос эхлэн улсын төвлөрсөн төсөвт тусгаж байх арга хэмжээ авсугай.

7. Малчдад эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг хийх, эрүүл мэндийн тусламж үзүүлэх арга хэмжээг аймгийн Засаг дарга нартай хамтран хэрэгжүүлэхийг Эрүүл мэндийн сайд П.Нямдавваад үүрэг болгосугай.

8. Мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн, өргөн хэрэглээний бараа худалдах, солилцох зорилгоор байнын ажиллагаатай хилийн боомт нээн ажиллуулах талаар аймгуудаас тавьж байгаа санал, хүсэлтийг судалж шийдвэрлэх арга хэмжээ авахыг Гадаад хэргийн сайд Л.Эрдэнэчулуун, Үйлдвэр, худалдааны сайд Ч.Ганзориг, Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдорж нарт даалгасугай.

9. Малын хашаа, саравч барьж өвлийн бэлтгэлийг хангах, байгалийн болзошгүй гамшгаас урьдчилан сэргийлэхэд шаардагдах мод, модон материал ойгоос бэлтгэх эвөшөөрлийг зохих хуульд тогтоомжийн дагуу олгох арга хэмжээ авахыг Байгаль орчны сайд У.Барсболдод даалгасугай.

10. Мал сүргийг даатгалын системд хамруулах асуудлыг боловсруулж, энэ оны Ш улиралд багтаан Засгийн газарт оруулахыг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаан, Хүнс, хөдөө аж ахуйн сайд Д.Насанжаргал, Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдорж нарт даалгасугай.

11. Мал өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын явц, үр дүнг нийтэд тогтмол мэдээлж байхыг Радио, телевизийн хэрэг эрхлэх газрын дарга Б.Ганболдод даалгасугай.

12. Сүүлийн жилүүдэд манай оронд тохиолдож байгаа байгалийн гамшгаас сургамж авч, мал аж ахуйн ирэх өвлийн бэлтгэлийг бүрэн хангах, хэрэгцээтэй өвс, тэжээлээ хүрэлцэхүйц хэмжээгээр бэлтгэж нөөцлөхөд идэвх чармайлт гаргаж, нөөц, боломжоо дайчлан ажиллахыг манай орны нийт иргэд, малчдад уриалсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН САЙД **Д.НАСАНЖАРГАЛ**

САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН САЙД **Ч.УЛААН**

Засгийн газрын 2001 оны 144 дүгээр тогтоолын хавсралт

"ХАДЛАН, ТЭЖЭЭЛ-2001" ТӨСӨЛ

Нэг. Төслийн үндэслэл

1. "Мал сүргийг ган, зудаас хамгаалахад туслах үндэсний хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх хүрээнд аймаг, сумын хэмжээнд өвс, тэжээлийн аюулгүйн нөөцийг бүрдүүлэх, нэмэгдүүлэх зорилгоор энэхүү төслийг боловсруулав.

Хоёр. Төслийн зорилго

2. "Мал сүргийг ган, зудаас хамгаалахад туслах үндэсний хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэхийн тулд өвс, тэжээл үйлдвэрлэлийн хэмжээг нэмэгдүүлж, мал сүргийг байгалийн болзошгүй зудын гамшгаас хамгаалах өвс, тэжээлийн нөөц бий болгох нөхцөл бүрдүүлэхэд төслийн зорилго оршино.

Гурав. Төслийн зорилт

3. Бүс нутагт говь, хангайн аймгууд хоршин ажиллаж хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, малчдын хүчээр хадлангийн талбайг сайжруулж, зохистой ашиглах замаар өвс бэлтгэлийн хэмжээг нэмэгдүүлэх.

4. Багсармал тэжээлийн зарим үйлдвэрийг сэргээн чанар сайтай тэжээл үйлдвэрлэх нөхцөлийг бүрдүүлэх.

5. Тэжээл үйлдвэрлэлийг хувийн хэвшилд тулгуурлан хөгжүүлэх явдлыг дэмжих.

6. Нөөцийн өвс, тэжээлийг хорогдолгүй, чанарыг нь бууруулахгүйгээр удаан хадгалах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор агуулах, саравчийг сэргээн засварлах.

7. Тэжээл үйлдвэрлэх, өвс хадах, гар тэжээл бэлтгэх, хадгалах арга технологийг үйлдвэрлэгчид, малчдад зээмшүүлэх, энэ чиглэлээр сургалт, сурталчилгаа зохион байгуулах.

Дөрөв. Төсөл хэрэгжүүлэх арга зам

8. Хадлан, тэжээл бэлтгэх нөөц бололцоо, туршлага, материаллаг бааз сайтай аж ахуйн нэгж, байгууллага, малчдыг сонгон шалгаруулах замаар уг төсөлд хамруулж эргэлтийн хөрөнгийг эргэн төлөгдөх нөхцөлөөр олгоно.

9. Түүхий эдийн нөөц, санхүүгийн чадавхи бүхий аж ахуйн нэгж, байгууллага, малчдын захиалга, хүсэлтийг үндэслэн хадлангийн техник, хэрэгсэл, тэжээл үйлдвэрлэлийн жижиг цехийн тоног төхөөрөмжийг импортоор авах, хангах ажлыг нэгдсэн бодлогоор зохицуулна.

10. Бага оврын хадуур, хадлангийн бусад хэрэгсэл үйлдвэрлэх аж ахуйн нэгж, байгууллагыг сонгон шалгаруулж, зээлийн бодлогоор дэмжинэ.

11. Өвс, тэжээлийн нөөц бий болгоход шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг аймаг, сумын дотоод нөөц бололцоог дайчлан бүрдүүлэхээс гадна улсын төвлөрсөн болон орон нутгийн төсвийн хөрөнгө, түүнчлэн Улсын байнгын онцгой комисст гадаад орон, олон улсын байгууллагаас ирүүлсэн хандив, тусламжаас эргэж төлөгдөх нөхцөлтэйгээр зээл олгоно.

12. Аймаг, сумын аюулаас хамгаалах тэжээлийн нөөцийг нэмэгдүүлэх болон малчдыг хүчит тэжээлээр хангах зорилгоор гурилын үйлдвэрийг түшигласэн тэжээлийн үйлдвэрүүдийг сэргээн ажиллуулах арга хэмжээг тухайн аймгууд хариуцан хэрэгжүүлж эхэлнэ.

13. Тэжээл үйлдвэрлэлийн шинжлэх ухааны ололт, туршлага, гар тэжээл бэлтгэх арга, уламжлалыг малчид, иргэдэд сургах, семинар, үзүүлэх сургууль зохион байгуулах, үйлдвэрлэлд нэвтрүүлэх ажилд сургалт, эрдэм шинжилгээний холбогдох байгууллагыг татан оролцуулна.

14. Баруун бүсэд аймаг дундын отрын нутаг тогтоох судалгаа хийж, бэлчээрийн даац, багтаамжийг тооцон хилийн зураглал гарган тогтооно.

15. Аймаг, сум, малчин өрхөд 2001 оны эцэст бэлтгэн нөөцөлсөн байх өвс, тэжээлийг улсын дүнгээр доорхи хүснэгтэд заасан хэмжээгээр бүрдүүлнэ:

Асуулт	Төрөл	Бэлтгэх хэмжээ (мян. тонн)
Аймгийн нөөцөд	Өвс, тэжээл	185.8
	Тэжээлийн нэгж	102.3
Сумын нөөцөд	Өвс, тэжээл	99.4
	Тэжээлийн нэгж	33.6
Малчин өрхийн	Өвс, тэжээл	629.2
	Тэжээлийн нэгж	251.6
ДҮН	Өвс, тэжээл	914.4
	Тэжээлийн нэгж	387.5

Тайлбар: Энэхүү тооцоогоор 2001 онд улсын хэмжээнд бэлтгэх нийт өвс, тэжээлийн 66.6 хувийг малчид өөрсдөө, 19.3 хувийг аймгийн нөөцөд, 10.3 хувийг сумын нөөцөд тус тус бэлтгэх юм. Улсын нөөцөд бүрдүүлэх өвс, тэжээлийн хэмжээг жич тогтоолоор заасан болно.

16. Аймаг, нийслэл бүр 2001 онд доорхи хэмжээний өвс, тэжээл нөөцөлсөн байна

№	Аймгийн нэр	Нийт малын тоо /хонин толгойд шилжүүлснээр/	Шаардагдах нийт тэжээл (мян.тонн)	Үүнээс		
				Аймгийн нөөцөд (мян.тонн)	Сумын нөөцөд (мян.тонн)	Малчдын хүчээр (мян.тонн)
1	Архангай	5947,9	87,8	17,8	9,5	60,4
2	Баян-Өлгий	2180,2	32,2	6,5	3,5	22,1
3	Баянхонгор	4047,0	59,7	12,1	6,5	41,1
4	Булган	3763,2	55,6	11,3	6,0	38,2
5	Говь-Алтай	2913,3	43,0	8,7	4,7	29,6
6	Дорноговь	2281,7	33,7	6,8	3,7	23,2
7	Дорнод	2182,9	32,2	6,5	3,5	22,2
8	Дундговь	2218,8	32,8	6,7	3,6	22,5
9	Завхан	3541,5	52,3	10,6	5,7	36,0
10	Өвөрхангай	4094,5	60,4	12,3	6,6	41,6
11	Өмнөговь	2488,1	36,7	7,5	4,0	25,3
12	Сүхбаатар	3706,3	54,7	11,1	5,9	37,6
13	Сэлэнгэ	1458,5	21,5	4,4	2,3	14,8
14	Төв	4406,1	65,0	13,2	7,1	44,8
15	Увс	2577,8	38,1	7,7	4,1	26,2
16	Ховд	3132,9	46,2	9,4	5,0	31,8
17	Хөвсгөл	5678,9	83,8	17,0	9,1	57,7
18	Хэнтий	3710,9	54,8	11,1	6,0	37,7
19	Дархан-Уул	424,2	6,3	1,3	0,7	4,3
20	Улаанбаатар	588,8	8,7	1,8	0,9	6,0
21	Орхон	363,9	5,4	1,1	0,6	3,7
22	Говьсүмбэр	237,6	3,5	0,7	0,4	2,4
Улсын дүн		61945,0	914,4	185,8	99,4	629,2

Тайлбар: Нийт бэлтгэх биет тэжээлийн 70 хувь нь өвс, 30 хувь нь хүчит тэжээл байхаар тооцов

Тав. Төслийн зардал

17. 2001 онд бэлтгэх аймаг, сумдын аюулаас хамгаалах өвс, тэжээл, хадлангийн салаа байгуулах төслийн зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны зардлыг хэрэгцээ, шаардлагад үндэслэн аймаг бүрээр гаргана.

№	Аймаг	Нийт бэлтгэх өвс (мян.тн)	Хадах талбай /мян. га/	Төсөлд хамрагдах аж ахуйн тоо	Шаардагдах хөрөнгө /мян.төг/	Үүнээс (мянган төг)		
						Техник шинэчлэлд гарах зардал	Үйл ажиллагааны зардалд	Усалгаатай үргамал тарих зардал
1	Архангай	27,3	54,6	2	205193,6	42600,0	162593,6	0
2	Баян-Өлгий	10,0	20,0	1	126672,1	880,0	59409,2	66382,9
3	Баянхонгор	18,6	37,2	1	186524,7	76305,0	110219,7	0
4	Булган	17,3	34,6	3	103184,4	0,0	103184,4	0
5	Говь-Алтай	13,4	26,8	1	151396,3	5280,0	79733,4	66382,9
6	Дорноговь	10,5	21,0	1	106334,3	44580,0	61754,3	0
7	Дорнод	10,0	20,0	1	59409,2	0,0	59409,2	0
8	Дундговь	10,3	20,6	1	100570,9	40380,0	60190,9	0
9	Завхан	16,3	32,6	1	111945,8	15015,0	96930,8	0
10	Өвөрхангай	18,9	37,8	2	123223,1	11440,0	111783,1	0
11	Өмнөговь	11,5	23,0		114347,9	46340,0	68007,9	0
12	Сүхбаатар	17,0	34,0	2	145364,8	44525,0	100839,8	0
13	Сэлэнгэ	6,7	13,4	4	39866,7	0,0	39866,7	0
14	Төв	20,3	40,6	3	121163,5	0,0	121163,5	0
15	Увс	11,8	23,6	3	144754,2	8800,0	69571,3	66382,9
16	Ховд	14,4	28,8		152369,9	0,0	85987,0	66382,9
17	Хөвсгөл	26,1	52,2	2	251656,6	96880,0	154776,6	0
18	Хэнтий	17,1	34,2	3	100839,3	0,0	100839,3	0
19	Дархан-Уул	2,0	4,0	1	10943,8	0,0	10943,8	0
20	Улаанбаатар	2,7	5,4		24034,0	8400,0	15634,0	0
21	Орхон	1,7	3,4	1	10162,1	0,0	10162,1	0
22	Говьсүмбэр	1,1	2,2	1	11333,6	5080,0	6253,6	0
Улсын дүн		285,0	570,0	34	2401290,3	446505,0	1689253,7	265531,6

18. Гурилын үйлдвэрүүдийг түшиглэсэн зарим тэжээлийн үйлдвэрийг сэргээн ажилуулахад дараахь зардал гарах болно:

Үйлдвэрийн нэр	Түүхий эдийн зардал /сая.төг/	Урсгал засвар /сая.төг/	Нийт зардал /сая.төг/
Сүхбаатар хотын гурил, тэжээлийн үйлдвэр	198.0	2.0	200.0

Тайлбар: Тухайн үйлдвэрийн хүчин чадлын 20 хувийг ашиглахаар зардлын тооцоог хийв.

19. Төслийг дараахь байдлаар санхүүжүүлнэ:

Нийт гарах зардал (мян.төг)	Үүнээс (мян.төг)					
	Засгийн газрын нөөц хөрөнгөөс		Мал сүргийг ган, зудаас хамгаалахад туслах үндэсний хөтөлбөрөөс		Шинээр олох эх үүсвэр	
	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
2601290.3	650322.6	25.0	650322.6	25.0	1300645.1	50.0

Зургаа. Төслийн үр дүн

20. Одоогийн бэлтгэж байгаа өвс, тэжээлийн хэмжээг 2001 онд 30.9 хувиар нэмэгдүүлж, улсын нөөцөөс гадна 914.4 мянган тонн өвс, тэжээл үйлдвэрлэнэ.

21. Баруун бүсэд аймаг дундын отрын бус нутаг бий болгох талаар судалгаа хийж хил хязгаар, даац багтаамжийг тодорхойлно.

22. Гурилын үйлдвэр түшиглэсэн зарим тэжээлийн үйлдвэрийг сэргээн ажилуулж, багсармал тэжээлийн үйлдвэрлэлийг 2.5 дахин нэмэгдүүлнэ.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 7 дугаар сарын 4-ний өдөр **Дугаар 145** **Улаанбаатар хот**

Улсын циркийн талаар авах зарим арга хэмжээний тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 5 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Улсын циркийг 2002 оноос эхлэн төсөвт байгууллагын хэлбэрээр ажиллуулсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙД А.ЦАНЖИД

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 7 дугаар сарын 4-ний өдөр **Дугаар 146** **Улаанбаатар хот**

Нөхөн төлбөр олгох тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Налайх дүүргийн уурхай, зарим үйлдвэр, аж ахуйн газарт ажиллаж байгаад үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас тахир дутуу болж хөдөлмөрийн чадвараа алдсан боловч 1995 оноос хойш нөхөн төлбөрөө авч чадаагүй байгаа иргэдэд хөдөлмөрийн чадварааа алдсаны өмнө авч байсан дундаж цалингаас тэдний мэргэжлийн хөдөлмөрийн чадвар алдалтын хэмжээнд ногдох хувь, ажилласан жилийг харгалзан нэг удаа нөхөн төлбөр олгохыг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаан, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд Ш.Батбаяр, Дэд бүтцийн сайд Б.Жигжид нарт даалгасугай.

2. Дэд бүтцийн яам, Үйлдвэр худалдааны яам, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамнаас гарсан хамтарсан ажлын хэсгийн судалгаанд заасан нэр бүхий иргэдэд олгох нөхөн төлбөрт шаардагдах 243700000 /хоёр зуун дөчин гурван сая долоон зуун мянган/ төгрөгийг Засгийн газрын нөөц хөрөнгөөс гаргахыг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаанд зөвшөөрсүгэй.

3. Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас тахир дутуу болж хөдөлмөрийн чадвараа алдсан, 1991 оны Хөдөлмөрийн хуулийн дагуу нөхөн төлбөр авч байсан бөгөөд өөрсдийн бүрүү биш шалтгаанаар харьяалах байгууллагагүй болсон, энэ тогтоолын нэгдүгээр зүйлд хамрагдаагүй иргэнд олгох нөхөн төлбөрийг "Хөдөлмөрийн тухай хуулийн зарим зүйл, хэсгийг тайлбарлах тухай" Улсын Дээд шүүхийн 2000 оны 259 дүгээр тогтоолын 28-д заасныг бариментлан нэг удаа нөхөн олговор олгох асуудлыг шийдвэрлэх арга хэмжээ авахыг Үйлдвэр, худалдааны сайд Ч.Ганзориг, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд Ш.Батбаяр, Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаан нарт үүрэг болгосугай.

4. Налайх дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээнд хайгуулын болон ашиглалтын лицензи эзэмшигчдийн Ашигт малтмалын тухай хуулийн дагуу хүлээсэн үүргийн биелэлт хангалтгүй байгааг хянан шалгаж, олон хүний амь нас үрэгдэж болзошгүй аваарь, осол, сүйрлээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлж, түүнд хяналт тавьж ажиллахыг Үйлдвэр, худалдааны сайд Ч.Ганзориг, Дэд бүтцийн сайд Б.Жигжид, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч М.Энхболд нарт үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

ҮЙЛДВЭР, ХУДАЛДААНЫ САЙД БӨГӨӨД ДЭД БҮТЦИЙН САЙДЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ Ч.ГАНЗОРИГ

САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН САЙД Ч.УЛААН

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Хаяг: «Төрийн мэдээлэл» эмхтгэлийн зөвлөл

Улаанбаатар-12 ☎ 329612
Төрийн ордон Индекс 14003

Улсын Их Хурлын Тамгын газрын Хэвлэх хэсэгт хэвлэв.
☎ 329487



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 35 (222)

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ:

- *Улсын төвлөрсөн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх барилга байгууламж, төсөл, арга хэмжээний жагсаалт батлах тухай*
- *Хэлэлцээр батлах тухай*
- *Журам батлах тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар

Улаанбаатар хот
2001 он

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот 2001 оны есдүгээр сарын 8 №35 (222)

Гарчиг

Нэг. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

424. Улсын төвлөрсөн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх барилга байгууламж, төсөл, арга хэмжээний жагсаалт батлах тухай Дугаар 147 873

425. Хэлэлцээр батлах тухай Дугаар 148 878

426. Журам батлах тухай Дугаар 150 878

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 7 дугаар сарын 4-ний өдөр **Дугаар 147** **Улаанбаатар хот**

Улсын төвлөрсөн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх барилга байгууламж,төсөл,арга хэмжээний жагсаалт батлах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Улсын төвлөрсөн төсвийн хөрөнгө оруулалтаар 2001 онд хэрэгжүүлэх барилга байгууламж, төсөл, арга хэмжээний жагсаалтыг 1 дүгээр хавсралт, улсын төвлөрсөн төсвийн болон замын сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх зам, гүүрийн барилга байгууламж, арга хэмжээний жагсаалтыг 2 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

2. Улсын төвлөрсөн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх барилга байгууламж, төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн явц, төслийн ач холбогдол, ашиглалтад оруулах хугацаа, санхүүжилтийн байдалд хяналт тавьж, захиалагч байгууллагуудтай тохиролцон энэ тогтоолоор батлагдсан хөрөнгийн дунд багтаан шаардлагатай зохицуулалт хийж ажиллахыг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаанд зөвшөөрсүгэй.

3. "Улсын төвлөрсөн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх барилга байгууламж, төсөл, арга хэмжээний жагсаалт батлах тухай" Засгийн газрын 2001 оны 2 дугаар сарын 20-ны өдрийн 36 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН САЙД **Ч.УЛААН**

Засгийн газрын 2001 оны 147 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

УЛСЫН ТӨВЛӨРСӨН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР 2001 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАРИЛГА БАЙГУУЛАМЖ, ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТ

/сая төг/

д/д	Барилга байгууламж, төсөл, арга хэмжээний нэр, байршил, хүч чадал	Эхлэх, дуусах хугацаа	Нийт төсөвт өртөг	Үүнээс: 2001 онд санхүүжих	Ерөнхий захиалагч
	А	1	2	3	4
I	**ДУЛААНЫ СТАНЦ**		**3581,5**	**890,2**	
1	Дулааны цахилгаан станцын шинэчлэлтийн Монголын талын хөрөнгө, Чойбалсан хот, Дорнод	1999-2001	1600,0	200,0	ДБЯ
2	Дулааны цахилгаан станцын инженерийн гадна шугам сүлжээ, технологийн машин, тоног төхөөрөмж, Даланзадгад сум, Өмнөговь	1999-2001	1839,0	649,9	ДБЯ
3	Дулааны төв шугамын шинэчлэлт, 583 м, Сайншанд	2000-2001	142,5	40,3	ДБЯ
II	**ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ ШУГАМ, ДЭД ӨРТӨӨ**		**11970,1**	**4298,4**	
II.1	**110 кВ-ын шугам, дэд станц**		**4000,0**	**756,3**	
1	Сайншанд-Замын-Үүд боомт, 205 км, Дорноговь	2001-2002	4000,0	756,3	ДБЯ
II.2	**35 кВ-ын цахилгаан дамжуулах шугам, дэд өртөө**		**7 399,9**	**2 971,9**	
1	Даланзадгад-Хүрмэн сум, 45 км, Өмнөговь	2001-2001	480,0	480,0	ДБЯ
2	Баянгол-Төгрөг сум, 46.1 км, Өвөрхангай	2001-2001	533,6	533,6	ДБЯ
3	Ховд-Дуут сум, 85 км, Ховд	2001-2002	709,0	200,0	ДБЯ
4	Алтанбулаг-Баян-Өнжүүл сум, 80.4 км, Төв	2001-2002	831,4	250,0	ДБЯ
5	Мянгад-Эрдэнэбүрэн сум, 58,2 км, Ховд	1999-2001	739,0	325,0	ДБЯ
6	Баянгол-Сайхан-Овоо сум, 55 км, Дундговь	1999-2001	688,0	100,0	ДБЯ
7	Баруун-Урт-Халзан сум, 68 км, Сүхбаатар	2000-2001	659,6	325,0	ДБЯ
8	Бэрх-Батноров сум, 35 км, Хэнтий	2000-2001	459,3	300,0	ДБЯ
9	Өндөр-Улаан-Тариат сум, 52 км, Архангай	2000-2001	600,0	328,3	ДБЯ
10	Цахилгаан шугам сулжээний алдагдлыг багасгах төсөл, УБ /ДБ-ны зээлийн дотоод эх үүсвэр/	2001-2003	1700,0	130,0	ДБЯ
II.3	**10 кВ-ын цахилгаан дамжуулах шугам, дэд өртөө**		**570,2**	**570,2**	
1	Сагсай-Буянт сум, 45 км, Баян-Өлгий	2001-2001	183,7	183,7	ДБЯ
2	Хутаг-Өндөр-Тэшиг сум, 60 км, Булган	2001-2001	277,0	277,0	ДБЯ
3	Баруун-Урт-Асгат сум, 45 км, Сүхбаатар	2001-2001	109,5	109,5	ДБЯ
III	**СЭРГЭЭГДЭХ ЭРЧИМ ХҮЧ**				
III.1	**Усан цахилгаан станц**		**7780,0**	**150,0**	
1	Усан цахилгаан станц, 150 кВт, Мөнххайрхан, Ховд	2001-2002	300,0	100,0	ДБЯ
2	Улаанбоомын УЦС-ын Монголын талын хөрөнгө	2001-2003	7480,0	50,0	ДБЯ
III.2	**Нар, салхины эрчим хүч ашиглах**		**1441,1**	**250,0**	
1	Нарны эрчим хүчийг ашиглах төсөл	2001-2001	1300,0	200,0	ДБЯ
2	Салхин цахилгаан станцын даусгал,Бугат,Говь-Алтай	1995-2001	141,1	50,0	ДБЯ
IV	**ТҮЛШ**		**110,0**	**50,0**	
1	Олонбулагийн нүүрсний уурхай, 10-15 мян.тн/жил, Үенч, Ховд	2001-2002	110,0	50,0	ДБЯ

V	**АЖ ҮЙЛДВЭР**		**778,7**	**200,0**	
1	Цементийн үйлдвэрийн дуусгал, жилд 10-15 мян.тн Ховд	2001-2003	778,7	200,0	ДБЯ
VI	**ТЭЭВЭР**		**843,9**	**165,0**	
1	Нисэх буудлын барилга, Өлгий сум, Баян-Өлгий	2000-2002	828,9	150,0	ДБЯ
2	Гатлага онгоц, Орхон туул-Эрдэнэт-Баруунбүрэн	2001-2001	15,0	15,0	ЗДТГ
VII	**АХУЙН ҮЙЛЧИЛГЭЭ**		**4 123,1**	**2 571,0**	
1	АХБ-ны зээлээр хэрэгжиж буй "Орон нутгийн НААУ сэргээн хөгжүүлэх төсөл", "Дулааны үр ашгийн төсөл"-чийн Монголын талын хөрөнгө, баруун таван аймаг, Улаанбаатар	1998-2001	1 533,1	1194,5	ДБЯ
2	Хлоржуулах системийн шинэчлэлт, аймгуудад	1997-2004	474,6	40,0	ДБЯ
3	Цэвэр усны нөөцийн сан 1000 м3, Даланзадгад, Өмнөговь	2001-2001	273,6	273,6	ДБЯ
4	Аймаг, сумын төвийн нийтийн халуун ус	2001-2001	340,0	340,0	ДБЯ
5	Бохир усны шугам, 3.1 км, Улаанбаатар	2000-2001	867,2	617,2	ДБЯ
6	Цэвэр усны шугам, 2700 м3/хоног, Арвайхээр, Өвөрхангай	1999-2001	175,0	12,0	ДБЯ
7	Цэвэр усны өндрийн сангийн дуусгал /6000 м3/, Дархан	1990-2001	459,6	93,7	ДБЯ
VIII	**ОРОН СУУЦ**		**400,0**	**200,0**	
1	Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэж цагаатгагдсан иргэдийн болон ар гэрийнхэнд орон сууц худалдан авах	2000-2001	300,0	100,0	НЗДТГ
2	Парламентийн гишүүдийн нэгдсэн байр болон АНХ-ын чуулганы танхимыг УИХ-ын танхим болгон өөрчлөх бэлтгэл ажил, зураг, төсөв	2001-2001	100,0	100,0	УИХТГ
IX	**ХӨДӨӨ АЖ АХУЙ**		**190,0**	**100,0**	
1	Усалгаатай тариалан эрхлэх, Булган, Үенч сум, гүрилын үйлдвэр Булган сум, Ховд	2000-2001	190,0	100,0	ХХААЯ
X	**ЭРҮҮЛ МЭНД**		**3 370,0**	**571,8**	
1	"Эрүүл мэндийн хөгжил хөтөлбөр"-ийн Монголын талын хөрөнгө	1998-2002	3270,0	471,8	ЭМЯ
2	Сумын хүн эмнэлэг, 15 ор, Бөхмөрөн, Увс	2001-2001	100,0	100,0	ЭМЯ
XI	**НИЙГМИЙН ХАМГААЛАЛ**		**57,7**	**57,7**	
1	"SOS" хүүхдийн тосгоны Монголын талын хөрөнгө	2001-2001	27,7	27,7	НХХЯ
2	Ахмад настан, ядуу хүмүүсийн асрамж, халамж, үйлчилгээний төвийн барилга, Төв аймаг, УБ Чингэлтэй дүүрэг	2001-2001	30,0	30,0	НХХЯ
XII	**БОЛОВСРОЛ, СОЁЛ**		**2 376,4**	**1 738,0**	
1	Сургуулийн барилгын дуусгал, 320 суудал, Бор-Өндөр, Хэнтий	2000-2001	452,7	452,7	БСШУЯ
2	Сургуулийн барилгын дуусгал, 928 суудал, Өндөрхаан, Хэнтий	2000-2001	704,6	570,6	БСШУЯ
3	Сургуулийн барилгын дуусгал, 240 суудал, Сэлэнгэ	2000-2001	279,5	199,5	БСШУЯ
4	8 жилийн сургуулийн барилгын дуусгал, 340 суудал, Өлгий сум, Баян-Өлгий	2000-2001	196,6	96,6	БСШУЯ
5	Сургуулийн барилгын дуусгал, 160 суудал, Эрдэнэ сум, Дорноговь	2000-2001	223,0	161,2	БСШУЯ
6	8 жилийн сургуулийн барилгын дуусгал, 400 суудал, Жаргалант сум, Архангай	1995-2001	135,0	60,0	ЗДТГ
7	Хичээлийн байрны өргөтгөл, 160 суудал, Цээл сум, Төв	2001-2002	100,0	100,0	ЗДТГ

8	Сургуулийн барилга, 320 суудал, Гурванбулаг сум, Баянхонгор	2001-2002	75,0	75,0	ЗДТГ
9	Сургуулийн барилга, 240 суудал, Цахир сум, Архангай	1999-2001	195,0	21,0	БСШУЯ
10	Соёлын төв, Хушаат сум, Сэлэнгэ	2000-2001	15,0	1,4	ЗДТГ
XIII	**АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ**		**100,0**	**100,0**	
1	Рашаан сувиллын эмчилгээний байрны шинэчлэлт, Хужирт, Өвөрхангай	2001-2001	100,0	100,0	ДБЯ
XIV	**БАТЛАН ХАМГААЛАЛ**		**591,0**	**478,0**	
1	Цэргийн байр, Эрдэнэт /186-р анги/	2000-2001	195,0	145,0	БХЯ
2	Орон сууцны халаалтын зуух БЗУИ-100х4, гадна инженерийн шугам сүлжээ,Арвайхээр, Өвөрхангай /256-р анги /	2001-2001	140,0	140,0	БХЯ
3	Орон сууц, 48 айл, Өвөрхангай	2000-2001	256,0	193,0	БХЯ
XV	**ХИЛ ХАМГААЛАЛ**		**910,0**	**325,0**	
1	Тамсагбулагийн хилийн хороо, Матад, Дорнод	1999-2002	735,0	150,0	ХЦУГ
2	Хилийн хороо, Баруунтуруун, Увс	2001-2001	175,0	175,0	ХЦУГ
XVI	**НИЙГМИЙН ХЭВ ЖУРАМ. АЮУЛГҮЙ БАЙДАЛ**		**1037,0**	**497,3**	
1	Цагдаагийн хэлтэс, цагдан хорих, Улаангом сум, Увс	2000-2002	459,0	190,3	ЦЕГ
2	Цагдаагийн хэлтэс, урьдчилан хорих, эрүүлжүүлэх байр, гадна холболт, Сайнцагаан сум, Дундговь	2000-2001	210,0	210,0	ЦЕГ
3	"Танц худаг"-ийн урьдчилан хорих төвийн барилга	1999-2001	368,0	97,0	ЦЕГ
XVII	**ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭЛ**		**170,0**	**170,0**	
1	Дотоодын цэргийн байр	2000-2001	90,0	90,0	ШШБЕГ
2	Хөрс хуулалт	2000-2001	80,0	80,0	ШШБЕГ
XVIII	**БАЙГАЛЬ ОРЧИН**		**270,0**	**270,0**	
1	Нисэх буудлуудад салхины ажиглалтын цамхаг байгуулах,аэрологийн станцын барилга, Улаангом, Дорнод	2001-2001	40,0	40,0	БОЯ
2	Газрын бүртгэл, мэдээллийн сангийн сүлжээ байгуулах	2001-2001	40,0	40,0	БОЯ
3	Түлш бага зарцуулдаг, утаа багатай 15 мян. зуух үйлдвэрлэх	2001-2001	190,0	190,0	БОЯ
XIX	**ГААЛИЙН САН**	1996-2002	**3 500,0**	**3100,0**	УТЕГ
XX	**ЗАМЫН САН**	1994-2004	**10 000,0**	**11000,0**	ДБЯ
	Үүнээс: -төвлөрсөн төсвийн хөрөнгө		5 400,1	6400,1	
	-замын сангийн хөрөнгө		4599,9	4599,9	
XXI	**ГАДААД ХАРИЛЦАА**		**800,0**	**400,0**	
1	Элчин сайдын яаманд байр худалдан авах, засвар хийх, Берлин	2000-2001	800,0	400,0	ГХЯ
XXII	**БУСАД**		**100,0**	**100,0**	
1	Барилга байгууламж, төсөл, арга хэмжээний ТЭЗҮ, зураг, төсөв боловсруулах зардал	2001-2001	100,0	100,0	СЭЗЯ
XXII I	**ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ**	2001-2001	**1 711,4**	**1711,4**	
	ТӨВЛӨРСӨН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН НИЙТ ДҮН		**56 211,9**	**29 393,8**	
XXI V	**ИХ ЗАСВАР**	2001-2001	**3 421,2**	**3421,2**	
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН НИЙТ ДҮН		**59 633,1**	**32 815,0**	

Улсын төвлөрсөн төсвийн болон Замын сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх, зам, гүүрийн барилга байгууламж, арга хэмжээний жагсаалт

д/д	Төсөл, арга хэмжээний нэр, байршил	Хүч чадал	Барих хугацаа	Төсөвт өртөг	2001 оны төлөвлөгөө	Үүнээс: Замын сан	Үүнээс: Улсын төсөв	Ашиглалтад орох хүч чадал	Ашиглалтад орох улирал
	1	2	3	4	5	6	7	8	9
	Нэг.Мянганы зам.			**7731,8**	**1888,4**	**560,0**	**1328,4**		
1	Багануур чиглэлийн зам	37.5 км	1999-2004	5250,0	560	560			
2	**Баруун чиглэлийн давааны замууд:** Хашаат /Ховд/,Бураат /Баян-Өлгий/, Загастай, Булжих, Бөхөн шар / Завхан/, Ухаачулуут /Архангай/, Хангай, Дөтлүүр / Төв/	80 км	2001-2001	797,8	689,5		689,5		
3	**Зам, гүүрийн геологи, хайгуул:** / Улаанбайшинт-Завханы Завхан-Тээлийн бэлчир 500 км, Луун, Төв/	800 км	2001-2001	740,0	250		250		
	Төмөр бетон гүүрүүд: Завхан гол, Орхон гол, Халх гол, Хонгио, Шурагын гол, Тогосын хоолойн гүүр	682 у/м	2001-2001	944,0	388,9		388,9		
	Хоёр.Төмөр бетон гүүр			**2568,6**	**954,4**	**954,4**			
1	Завханы Баянтээ-Тэсийн гол	144.9 у/м	1995-2001	440,1	187,3	187,3		144.9 у/м	III
2	Булганы Тэшиг. Эгийн гол	289.3 у/м	1994-2001	1137,2	653,3	653,3		289.3 у/м	III
3	Архангайн Өлзийт-Орхон гол	171 у/м	1996-2001	571,3	78	78		171 у/м	II
4	Сэлэнгийн салаа, Зүүнбүрэн, Сэлэнгэ	168 у/м	2001-2002	420,0	35,8	35,8			
	Гурав. "Авто замын хууль"-ийн дагуу санхүүжүүлэх бусад арга хэмжээ, улсын чанартай зам, гүүрийн засварт		2001-2001	**2045,8**	**2045,8**	**2045,8**			
	Дорнод.Гадаадын зээлийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төслийн дотоод эх үүсвэр			**20185,6**	**6111,4**	**1039,7**	**5071,7**		
1	Кувейтийн сангийн зээлээр хэрэгжиж байгаа Дархан-Эрдэнэтийн хатуу хучилттай зам	184 км	1996-2001	6213,2	2500,0		2500,0	184 км	III
2	АХБ-ны зээлээр хэрэгжих Налайх-Маанът-Чойрын зам	200 км	2000-2004	9000,0	1192,5		1192,5		
3	ДБ-ны зээлийн хөрөнгөөр хэрэгжих замын ажил :			**3140,9**	**1496,2**	**416,3**	**1079,9**		
	а/Эрдэнэсант-Арвайхээрийн хатуу хучилттай замын хэсэгчилсэн шинэчлэлт	211 км	2001-2003	1507,4	461,2	350,8	110,4		
	б/Хархорин-Цэцэрлэг-Тосонцэнгэл чиглэлийн хэсэгчилсэн хайрган зам	87,2	2001-2002	1076,7	556,8		556,8		
	в/Зураг хайгуул, ТУН-ийн зардал, НӨТ /т. төхөөрөмж/		2001-2001	556,8	478,2	65,5	412,7		
4	ДБ-ны зээлийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа Цэцэрлэг-Тосонцэнгэлийн хайрган замын хэсэгчилсэн шинэчлэлт, дуусгал	44,1	1997-2001	**1140,7**	**231,9**	**231,9**		44,1	II
5	АҲБ-ны УБ-Дархан-Алтанбулагийн замын гүйцэтгэгчдийн суутгалын бүцах мөнгө		2001-2001	**690,8**	**690,8**	**391,5**	299,3		
	Дүн			**32531,8**	**11000,0**	**4599,9**	**6400,1**		

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ
2001 он, №35 (222)

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 7 дугаар сарын 4-ний өдөр **Дугаар 148** **Улаанбаатар хот**

Хэлэлцээр батлах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

2000 оны 4 дүгээр сарын 17-нд Улаанбаатар хотноо гарын үсэг зурсан Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улсын Засгийн газар хоорондын "Хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих, хамгаалах тухай хэлэлцээр"-ийг баталсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

ГАДААД ХЭРГИЙН САЙД **Л.ЭРДЭНЭЧУЛУУН**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 7 дугаар сарын 4-ний өдөр **Дугаар 150** **Улаанбаатар хот**

Журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Улсын сайн малчин шалгаруулах журам"-ыг 1 дүгээр хавсралт, "Улсын тэргүүний тариаланч хамт олон, улсын тэргүүний тариаланч шалгаруулах журам"-ыг 2 дугаар хавсралт ёсоор тус тус батлсугай.

2. Улсын сайн малчин, Улсын тэргүүний тариаланч хамт олон, тэргүүний тариаланч шалгаруулан шагнахад шаардагдах хөрөнгийг жил бүрийн улсын төвлөрсөн төсөвт тусгаж байхыг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаан, Хүнс, хөдөө аж ахуйн сайд Д.Насанжаргал нарт даалгасугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Журам батлах тухай" Засгийн газрын 1997 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 32 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН САЙД **Д.НАСАНЖАРГАЛ**

Засгийн газрын 2001 оны 150 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

УЛСЫН САЙН МАЛЧИН ШАЛГАРУУЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Малчдын идэвх санаачилгыг урамшуулах замаар малын үүлдэрлэг байдлыг сайжруулах, бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, мал аж ахуйг эрчимжүүлэх, гахай, шувууны аж ахуйг дэмжин хөгжүүлэхэд шагналын зорилго оршино.

2. Энэ журмын хоёрт заасан үзүүлэлтийг хангасан 20 хүртэлх малчдыг "Улсын сайн малчин"-аар жил бүр шалгаруулан шагнана.

3. "Улсын сайн малчин"-аар шагнах асуудлыг хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн сайдын саналыг үндэслэн Засгийн газар шийдвэрлэнэ.

Хоёр. Шагналд тодорхойлох үндэслэл

4. "Улсын сайн малчин"-аар тодорхойлох малчин дор дурдсан шалгуур, үзүүлэлтийг хангасан байна:

4.1. Бодод шилжүүлснээр 150-иас доошгүй малтай, мал сүргээ сүүлийн 3 жил дараалан төлөөрнь өсгөсөн байх;

Малын тоонд тавиул малыг оролцуулан тооцохгүй.

4.2. Хэлтэгчийн тоо нь тогтвортой нэмэгдэн сүрэгт эзлэх хувийн жин бог малд 50, бодод 32-оос доошгүй хувьд хүрсэн, үржлийн албаар баталгаажсан жишигт тэнцсэн хэлтүүлэгчтэй байх;

4.3. Оны эхний 100 хэлтэгч мал тутмаас бойжуулсан төлийн тоо улсын дунджаас илүү, гурван жил дараалан өссөн байхаас гадна сүүлчийн жилд хэлтэгч бүрээс төл бойжуулсан байх;

Жил тутам 100 ба түүнээс дээш хувиар төл бойжуулсан малчинд 100 хэлтэгчээс бойжуулсан төл жил дараалан өссөн байхыг шаардахгүй.

4.4. Нэгжээс ашигласан ашиг шим, мал аж ахуйн бүтээгдэхүүний хэмжээг нэмэгдүүлэх, чанарыг сайжруулан ерхийн орлогоо нэмэгдүүлсэн байх;

4.5. Мал эмнэлэг, үржлийн ажил, үйлчилгээ эрхэлдэг нэгжтэй байнгын гэрээтэй ажиллаж, мал сүргээ урьдчилан сэргийлэх арга хэмжээнд бүрэн хамруулан, эрүүл сүрэгтэй болсон байх;

4.6. Ажлын байр шинээр бий болгох, малаа борлуулах, үржилд худалдах зэргээр эргэлтэд оруулж, зах зээлийн нөхцөлд тохирсон бизнесийн үйл ажиллагаа явуулсан байх.

5. "Улсын сайн малчин-"аар шалгаруулахдаа дараахь нэмэлт үзүүлэлтүүдийг харгалзана:

5.1. Тоготоосон бүс нутагт отор хийж, бүх малдаа дундаас дээш тарга хүч авахуулсан байх;

5.2. Малаа гэрээ, түрээсээр маллуулах, хоршоо байгуулах, малгүй ерхийг малжуулахад туслах зэргээр хөдөөд ядуурлыг бууруулахад тодорхой хувь нэмэр оруулсан байх;

5.3. Өвөлжөө, хаваржааны хашаатай, уст цэгтэй болж, түүнийгээ тохижуулсан байх;

5.4. Үржлийн албаны буюу хэрэглэгчдийн захиалгаар үржлийн мал бойжуулан худалдсан байх;

5.5. Нэг хонин толгойд ойт хээрт 30 кг, өндөр уул, тал хээрийн бүсэд 10 кг, говийн бүсэд 3 кг-аас доошгүй хадлан, гар тэжээл өөрийн хүчээр бэлтгэж, говиос бусад бүсэд өөрийн эзэмшлийн хадлангийн талбайтай болж, түүнийг хамгаалсан байх;

5.6. Холбогдох хууль тогтоомжийн дагуу татвар, хураамжийг төлж, мал хамгаалах санд жил бүр хувь нэмэр оруулах.

6. Сүүний аж ахуй (25–аас доошгүй саалийн үнээтэй) эрхэлдэг малчид дээр дурдсан шалгуур болон харгалзах үзүүлэлтийн 4.1, 4.2, 5.5 дугаар заалтаас бусад заалтад заасан нөхцөлийг биелүүлсэн байхаас гадна дунджаар нэг үнээнээс саасан сүү нь 3 жил дараалан өссөн, улсын хэмжээнд хамгийн өндөр үзүүлэлтэд хүрсэн байна. Үнээ, тугалдаа зориулж өвс, дарш бэлтгэсэн байна.

7. Дараахь үзүүлэлтийг хангасан гахайчин, шувуучныг "Улсын сайн малчин"-аар тодорхойлж болно:

7.1. Оны эхэнд 500-гаас доошгүй өндөглөгчтэй байж, нэг өндөглөгчөөс жилд 200-гаас доошгүй өндөг авсан, 50-иас доошгүй үржлийн шувуу бойжуулж борлуулсан шувууны аж ахуй эрхлэгчид;

7.2. Оны эхэнд 20-иос доошгүй үндсэн мэгж тоолуулж мэгж бүрээс жилд 20-иос доошгүй торой бойжуулж, 1.5 тн. мах үйлдвэрлэн, шалгалтын 20-иос доошгүй мэгж бойжуулан үржилд борлуулсан гахайн аж ахуй эрхлэгчид.

Гурав. Тодорхойлолт бүрдүүлэх, шалгаруулах зарчим

8. Баг, хорооны Засаг дарга "Улсын сайн малчин"-аар тодорхойлох үзүүлэлтийг хангасан гэж үзэж байгаа малчны тодорхойлолт, холбогдох материалыг бүрдүүлж, баг хорооны иргэдийн хурлаар хэлэлцүүлэн сум, дүүргийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлнэ.

9. Энэ журмын 6, 7 дугаар заалтад заасан үзүүлэлтийг сум, дүүргийн Засаг дарга газар дээр нь шалгаж, анхан шатны бариментууд, хийсэн гэрээ, түүний гүйцэтгэл, хэрэв аж ахуйн нэгжтэй бол тайлан тэнцлийг үндэслэн тодорхойлолт, баталгаа гаргана.

10. Тодорхойлолтод энэхүү журмын 4, 5, 6, 7 дугаар заалтад заасан үзүүлэлтүүдийг хэрхэн

биелүүлснийг тусгах бөгөөд үзүүлэлт бүрийг тодорхой баримтыг үндэслэн баталгаажуулсан байна:

10.1. Баг, хорооны Засаг дарга 4.1, 4.3, 4.4, 5.3, 5.5 дугаар заалтад заасан үзүүлэлтийг мал тооллогын материалаар;

10.2. Үржлийн улсын байцаагч 4.2, 5.1, 5.4 дугээр заалтад заасан үзүүлэлтийг мал тооллогын материал, өгсөн захиалга, хуваарь, үржлийн бүртгэл, мал авсан этгээдийн гаргасан баримтаар;

10.3. Засаг даргын орлогч 4.6, 5.2 дугаар заалтад заасан үзүүлэлтийг сум, дүүргийн Засаг даргын гаргасан шийдвэр, мал авсан этгээдийн болон бусад баримтаар;

10.4. Мал эмнэлэг, үржлийн ажил, үйлчилгээ эрхэлдэг орон нутгийн нэгж 4.5 дугаар заалтад заасан үзүүлэлтийг байгуулсан гэрээ болон анхан шатны бүртгэлээр;

10.5. Сум, дүүргийн татварын болон даатгалын байцаагч 5.6 дугаар заалтад заасан үзүүлэлтийг татвар хураалгасан баримт болон даатгалын гэрээг үндэслэн баталгаа гаргана.

11. Тодорхойлолт, ажлын үзүүлэлт, холбогдох материалыг сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар хянан үзэж, бүх баталгааг гаргуулан хамгийн өндөр амжилт гаргасан хоёр малчныг шагналуулан аймгийн Засаг даргын Тамгын газарт тодорхойлолт, бусад материалын хамт хүргүүлнэ.

12. Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар тодорхойлолт, бусад материалыг хүлээн авмагц газар дээр нь шалгаж, дүгнэлт гаргана.

13. Шалгаж баталгаажсан материалуудыг аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлэн хамгийн өндөр үзүүлэлттэй хоёр хүртэл малчныг "Улсын сайн малчин"-аар шалгаруулахаар материалыг нь 1 дүгээр сарын 10-ны дотор хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

14. Малчныг "Улсын сайн малчин"-аар шалгаруулахаар тодорхойлохдоо дор дурдсан материалыг бүрдүүлнэ.

14.1. Малчны товч анкет (энэхүү журмын 1 дүгээр хавсралт);

14.2. Ажлын үзүүлэлт (энэхүү журмын 2, 3 дугаар хавсралт);

14.3. Баг, хорооны Иргэдийн нийтийн хурлын тэмдэглэл;

14.4. Сум, дүүрэг, аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн тогтоол;

14.5. Холбогдох байгууллагуудаас гаргасан баталгаа, тодорхойлолт (энэхүү журмын 4 дүгээр хавсралт);

14.6. Аймгийн Засаг даргын Тамгын газраас шалгаж гаргасан дүгнэлт.

15. Аймгийн сайн малчин болсноос хойш хоёроос доошгүй жил тогтвортой амжилт гаргасан малчин, гахай, шувууны аж ахуй эрхлэгчдийг "Улсын сайн малчин"-аар шалгаруулахаар тодорхойлно.

16. Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газраас зохих хугацаанд ирүүлсэн тодорхойлолт, холбогдох материалыг хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хянан үзэж, энэхүү журмын дагуу шалгуур болон харгалзах үзүүлэлтийг бүрэн биелүүлсэн малчид, гахай, шувууны аж ахуй эрхлэгчдийг "Улсын сайн малчин"-аар шалгаруулах саналыг Засгийн газарт оруулна.

17. "Улсын сайн малчин"-аар зөвхөн нэг удаа шагнах бөгөөд уг шагналыг улсын аварга малчинтай адилтган үзэх тул урьд нь ийм шагнал авсан малчныг дахин шалгаруулахгүй.

Дөрөв. Олгох шагнал

18. Шалгарсан малчин, гахай, шувууны аж ахуй эрхлэгчдэд Улсын сайн малчны үнэмлэх, энгэрийн тэмдэг олгож, 500 мянган төгрөгийн үнэ бүхий дурсгалын зүйлээр шагнана.

19. Улсын сайн малчны шагналыг билгийн тооллын хаврын тэргүүн сарын шинийн нэгнийг тохиолдуулан гардуулна.

"Улсын сайн малчин шалгаруулах журам"-ын 1 дүгээр хавсралт

"УЛСЫН САЙН МАЛЧИН"-ААР ТОДОРХОЙЛОГДОЖ БАЙГАА МАЛЧНЫ ТОВЧ АНКЕТ

он сар өдөр

1	Аймаг, сум, баг	
2	Эцгийн /эх/ нэр	
3	Нэр	
4	Төрсөн он, нас, хүйс	
5	Боловсрол	
6	Ам бүлийн тоо, таны юу болох	
7	Ажилласан нийт хугацаа, хийж байсан ажил	
8	үүнээс малчнаар ажилласан хугацаа	
9	Төр, засгаас хэдэн онд ямар шагнал авч байсан	
10	Аймгийн сайн малчнаар хэдэн онд шалгарсан, үнэмлэхийн дугаар	

"Улсын сайн малчин шалгаруулах журам"-ын 2 дугаар хавсралт

"УЛСЫН САЙН МАЛЧИН"-ААР ТОДОРХОЙЛОГДОЖ БАЙГАА
. . . . . АЙМГИЙН . . . . . СУМЫН МАЛЧИН
. . . . . ЫН АЖЛЫН ҮЗҮҮЛЭЛТ

он сар өдөр

Үзүүлэлт	Малын төрөл	Онууд		
		.. он	.. он	.. он
1. Оны эхний мал /бодод шилжүүлснээр/	Бүгд			
2. Оны эхний мал	Бүгд			
Үүнээс:	Тэмээ			
	Адуу			
	Үхэр			
	Хонь			
	Ямаа			
3. Хэялтэгч	Бүгд			
Үүнээс:	Ингэ			
	Гүү			
	Үнээ			
	Эм хонь			
	Эм ямаа			
4. Хэялтүүлэгч	Бүгд			

Үүнээс:	Бүүр			
	Азрага			
	Бух			
	Хуц			
	Ухна			
5. Бойжсон төл	Бүгд			
Үүнээс:	Ботго			
	Унага			
	Тугал			
	Хурга			
	Ишиг			
6. Борлуулсан мал	Бүгд			
	Тэмээ			
	Адуу			
	Үхэр			
	Хонь			
	Ямаа			
7. Үржилд худалдсан мал	Бүгд			
Үүнээс:	Тэмээ			
	Адуу			
	Үхэр			
	Хонь			
	Ямаа			
8. Малжуулахад өгсөн мал	Бүгд			
Үүнээс:	Тэмээ			
	Адуу			
	Үхэр			
	Хонь			

	Ямаа			
9. Зүй бусаар хорогдсон мал	Бүгд			
Үүнээс:	Тэмээ			
	Адуу			
	Үхэр			
	Хонь			
	Ямаа			
10. Өөрийн хэрэгцээнд хэрэглэсэн мал	Бүгд			
Үүнээс:	Тэмээ			
	Адуу			
	Үхэр			
	Хонь			
	Ямаа			
11. Оны эцэст тоологдсон мал	Бүгд			
Үүнээс:	Тэмээ			
	Адуу			
	Үхэр			
	Хонь			
	Ямаа			
12. Цөм, торгон сүрэг, шилмэл малын тоо	Бүгд			
Үүнээс:	Тэмээ			
	Адуу			
	Үхэр			
	Хонь			
	Ямаа			
13. Оны эцэст бэлэн байгаа хэлтэгч	Бүгд			
Үүнээс:	Ингэ			
	Гүү			
	Үнээ			
	Эм хонь			
	Эм ямаа			

14. Жишиг тэнцсэн хэлтүүлэгч	Бүгд			
Үүнээс:	Буур			
	Азрага			
	Бух			
	Хуц			
	Ухна			
Ашиг шим ашиглалтын байдал				
Үзүүлэлт	Нэр, төрөл			
15. Нийт үйлдвэрлэл	Тэмээний ноос, кг			
Үзүүлэлт нэмж болно.	Хонины ноос, кг			
	Ямааны ноолуур, кг			
	Сүү,литр			
16.Нэг малаас ашигласан ноос,гр	Тэмээний ноос			
Үзүүлэлт нэмж болно.	Хонины ноос			
	Ямааны ноолуур			
17.Төлтэй нэг эх малаас ашигласан сүү, литр	Интэнээс			
	Гүүнээс			
	Үнээнээс			
	Эм хониноос			
	Эм ямаанаас			
18.Бүтээгдэхүүнээс орсон орлого, мянган төгрөг	Бүгд			
Үүнээс:	Мал борлуулс-наас			
	Махнаас			
	Ноос, ноолуураас			
	Сүүнээс			
	Арьс, ширээс			
	Бусад			
19.Өөрийн хүчээр бэлтгэсэн тэжээл, тн	Өвс			
	Гар тэжээл			
	Хужир, шүү			
20.Хадлангийн талбайтай эсэх	Талбайн хэмжээ, $м^2$			
	Авсан ургац, тн			
21.Хашаа, худгийн байдал	Хашааны тоо			
	Тохижилтын байдал			
	Худгийн тоо			
	Тохижилтын байдал			

Тайлбар: Дээрх үзүүлэлтүүдийг улсын тооллого, бусад холбогдох материалуудыг үндэслэн баталгаажуулна.

————————аймаг /нийслэл/-ийн ———— сум /дүүрэг/-ын
————————баг /хороо/-ийн Засаг дарга ————————
Мэргэжилтэн ————————

"Улсын сайн малчин шалгаруулах журал"-ын 3 дугаар хавсралт

"УЛСЫН САЙН МАЛЧИН"-ААР ТОДОРХОЙЛОГДОЖ БАЙГАА
. . . . . АЙМАГ (НИЙСЛЭЛ)-ИЙН . . . . . .
СУМ (ДҮҮРЭГ)-ЫН ГАХАЙЧИН (ШУВУУЧИН) . . . . . -НЫ
АЖЛЫН ҮЗҮҮЛЭЛТ

он сар өдөр

Үзүүлэлт	Оноод		
	.. он	.. он	.. он
Нэг. Гахайчны ажлын үзүүлэлт			
1.Оны эхний үндсэн мэгжийн тоо			
2.Бойжуулсан торойн тоо			
3.Үйлдвэрлэсэн гахайн мах, тн			
4.Маханд борлуулсан нэг гахайн дундаж амьдын жин, кг			
5.Бойжуулж үржилд худалдсан шалгалтын мэгж			
6.Оны эцэст тоологдсон гахай			
7.Үүнээс үндсэн мэгж			
Хоёр. Шувуучны ажлын үзүүлэлт			
1.Оны эхэнд байсан өндөглөгч			
2.Нийт үйлдвэрлэсэн өндөг, мянган ширхэг			
3.Үүнээс борлуулсан өндөг, мянган ширхэг			
4.Бойжуулсан дэгдээхэй			
5.Бойжуулан үржилд худалдсан шувуу			
6.Оны эцэст байгаа нийт шувуу			
7.Үүнээс өндөглөгч			

Тайлбар: Үзүүлэлтийг сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар шалгаж баталгаажуулна.

————————сум/дүүрэг/-ын
Засаг дарга————————
Мэргэжилтэн————————

"Улсын сайн малчин шалгаруулах журам"-ын 4 дүгээр хавсралт

"УЛСЫН САЙН МАЛЧИН"-ААР ТОДОРХОЙЛОГДОЖ БАЙГАА
..... АЙМАГ (НИЙСЛЭЛ)-ИЙН .....
СУМ (ДҮҮРЭГ)-ЫН ..... ЫН АЖЛЫН ҮЗҮҮЛЭЛТ, ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГАА

он сар өдөр

№	Баталгаа гаргасан байгууллага, албан тушаалтан	Журмын ямар үзүүлэлтүүдийг баталгаажуулж буй	Баталгаа болгох материалын он, сар, өдөр, дугаар	Гарын үсэг, тэмдэг
1	Сумын Засаг даргын орлогч	4.6, 5.2, 6.7		
2	Мал эмнэлэг	4.5		
3	Мал зүйч	4.2, 5.1, 5.4		
4	Татварын алба	5.6		
5	Даатгалын байцаагч	Малаа даатгуулсан эсэх		
6	Багийн Засаг дарга	4.1, 4.2, 4.3, 4.4, 5.3, 5.5		
7	Хуулийн байгууллага	Гэмт хэрэг,хэв журмын зөрчилтэй эсэх		

Тайлбар: 1. Холбогдох баримтыг хавсаргаагүй баталгаа хүчингүйд тооцогдоно.
2. Үзүүлэлт бүрээр тус, тусад нь баталгаа гаргана.

——сум/дүүрэг/-ын

Засаг дарга——

Засгийн газрын 2001 оны 150 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

"УЛСЫН ТЭРГҮҮНИЙ ТАРИАЛАНЧ ХАМТ ОЛОН", "УЛСЫН ТЭРГҮҮНИЙ ТАРИАЛАНЧ" ШАЛГАРУУЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Газар тариалангийн бүтээгдэхүүний чанар, үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхэд идэвх санаачилга гаргаж тогтвортой өндөр амжилт үзүүлсэн аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийг улсын хэмжээнд шалгаруулан урамшуулахад энэхүү журмын зорилго оршино.

2. Газар тариалангийн үйлдвэрлэлийг үр дүнтэй эрхлэж, уринш боловсруулалт, үрийн үйлдвэрлэл, нөөцлөлт, газрын ашиглалтыг сайжруулсан 5 хүртэл аж ахуйн нэгж, байгууллага, 10 хүртэл иргэнийг сүүлийн 3 жилийн ажлын үзүүлэлтээр жил бүр шалгаруулан "Улсын тэргүүний тариаланч хамт олон", "Улсын тэргүүний тариаланч" шагнал олгоно.

3. "Улсын тэргүүний тариаланч хамт олон", "Улсын тэргүүний тариаланч"-аар шалгаруулж шагнал олгох асуудлыг Хүнс, хөдөө аж ахуйн сайдын саналыг үндэслэн Засгийн газар шийдвэрлэнэ.

Хоёр. Шагналд тодорхойлох үндэслэл

4. "Улсын тэргүүний тариаланч хамт олон", "Улсын тэргүүний тариаланч"-аар шалгаруулах аж ахуйн нэгж, байгууллага, иргэн дор дурдсан шаардлага хангасан байна:

а/жил тутам улсад шалгаруулах хамт олон үр тариа 250 га, төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнэ 10 га, иргэн үр тариа 100 га, төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнэ 0.2 га-гаас доошгүй талбайд тус тус тариалалт хийж өндөр ургац авсан байна;

б/усалгаагүй талбайн үр тариа, төмсний тариалсан га тутмаас хураан авсан ургац нь суүлийн 3 жил дараалан аймгийнхаа дунджаас 20-иос доошгүй хувиар илүү байх;

в/усалгаатай талбайн үр тарианы тариалсан га тутмаас хураан авсан ургац нь тухайн аймгийн дунджаас 3 жил дараалан 2-оос доошгүй дахин их, төмсний ургац нь 40-өөс доошгүй хувиар илүү байх;

г/хүнсний ногоо, жимс, жимсгэний 1 га тутмаас хураан авсан ургац нь тухайн аймгийн дунджаас сүүлийн 3 жил дараалан 30-аас доошгүй хувиар илүү байх;

д/хөрсийг элэгдлээс хамгаалах, түүний үржил шимийг дээшлүүлэх, хог үргамлыг устгах арга, технологи нэвтрүүлж, зохих хугацаанд хийгэсэн лабораторийн шинжилгээний дүнгээр хөрсний бүтэц, үржил шимийг бууруулаагүй байх;

е/үр тарианы үйлдвэрлэл эрхлэгчид чанарын шаардлага хангасан өөрийн үрээр тариалсан байх;

ж/ээзэмшсэн талбайг 100 хувь ашигласан байх бөгөөд сүүлийн гурван жилд бэлтгэсэн уринш нь 100 хувь чанарын онц, эсүүл сайн үнэлээлттэй байх (хүнсний ногоо, жимс, жимсгэнэд энэ заалт хамаарахгүй);

з/борлуулсан үргацын чанар нь улсын стандартын шаардлага хангасан байх;

и/хугацаа хэтэрсэн,баталгаа алдсан өр,зээлгүй байх;

к/үрийн тариалангаа хуульд заасны дагуу даатгуулсан байх;

л/үйлдвэрлэлийн осол гаргаагүй байх;

м/татвар, хураамж болон газрын төлбөрийг хугацаанд нь төлсөн байх.

Гурав. Шагналд тодорхойлох, шалгаруулах журам

5. "Улсын тэргүүний тариаланч"-аар шалгаруулах аж ахуйн нэгж, байгууллага, иргэний тодорхойлолт, холбогдох материалыг сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар жил бүрийн 11 дүгээр сард багтаан аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газарт ирүүлнэ.

6. Аймаг, нийслэлийн Засаг дарга нь сум, дүүргээс ирүүлсэн тодорхойлолт, холбогдох материалыг хянан үзэж, хамгийн өндөр амжилт гаргасан гурав хүртэл аж ахуйн нэгж, байгууллага, нэг тариаланчийн тодорхойлолт, холбогдох материалыг жил бүрийн 12 дугаар сарын 25-ны дотор хөдөө аж ахуйн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад ирүүлнэ.

7. Хөдөө аж ахуйн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага нь аймаг, нийслэлээс ирүүлсэн аж ахуйн нэгж, байгууллага, иргэнийг ажлын үзүүлэлтээр нь байр эзлүүлэн энэхүү журмын шаардлагыг биелүүлж өндөр амжилт гаргасан аж ахуйн нэгж, байгууллага, иргэнийг "Улсын тэргүүний тариаланч хамт олон", "Улсын тэргүүний тариаланч"-аар шалгаруулах саналыг Засгийн газарт оруулна.

8. "Улсын тэргүүний тариаланч хамт олон", "Улсын тэргүүний тариаланч"-аар шалгаруулахаар тодорхойлсон дор дурдсан материалыг бүрдүүлнэ:

а/аж ахуйн нэгж, байгууллага, иргэний ажил байдлын талаархи аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын тодорхойлолт;

б/аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлын тогтоол, санал дүгнэлт;

в/сүүлийн 3 жилийн ажлын үзүүлэлтийг энэ журмын хавсралтын дагуу бүрдүүлэх;

г/харилцагч банк, татвар, даатгалын болон гэрээт байгууллагын тодорхойлолт;

д/бүтээгдэхүүнээ борлуулсан гурилын үйлдвэр, төмс, ногооны зоорийн тодорхойлолт, орлогын татвар төлөлтийн баримт;

е/хураан авсан үргацын чанар болон хөрсний үржил шимийн тухай холбогдох лабораторийн шинжилгээний дүн.

9. Бүтээгдэхүүн, үйлдвэрлэлийн дүнд бүсдаас худалдан авсан болон өр төлбөрт авсан бүтээгдэхүүн орохгүй.

Дөрөв. Олгох шагнал

10. Улсын тэргүүний тариаланчаар шалгарсан аж ахуйн нэгж, байгууллагыг "Улсын тэргүүний тариаланч хамт олон" диплом, цом, 500.0 мянган төгрөгөөр, иргэнийг "Улсын тэргүүний тариаланч" диплом, 150.0 мянган төгрөгөөр тус тус шагнана.

11. "Улсын тэргүүний тариаланч хамт олон", "Улсын тэргүүний тариаланч"-ийн шагналыг билгийн тооллын хаврын тэргүүн сарын шинийн нэгнийг тохиолдуулан гардуулна.

"Улсын тэргүүний тариаланч хамт олон", "Улсын тэргүүний тариаланч" шалгаруулах журмын хавсралт

"УЛСЫН ТЭРГҮҮНИЙ ТАРИАЛАНЧ ХАМТ ОЛОН", "УЛСЫН ТЭРГҮҮНИЙ ТАРИАЛАНЧ" ШАЛГАРУУЛАХ ҮЗҮҮЛЭЛТ

Үзүүлэлт	Онууд			Тайлбар
	.. он	.. он	.. он	
- Тариалангийн эргэлтийн талбай, га				
Үүнээс: - тарьсан				
- уриншилсан				
- Таримлын төрөл				
- Хураан авсан ургац, тонн				
Үүнээс:				
- нөөцөлсөн үр, тонн				
- Улсын захиалга гэрээгээр болон зах зээлд борлуулсан ургац, тонн				
- Нэг га-гийн ургац /тарьсан талбайд цн-ээр/				
- Нийт борлуулалт, сая төг				
Үүнээс:				
Татварт сая төг.				
Даатгалд сая төг.				
6. Ашиг, сая төг				

Жич: Энэ хүснэгтэд зөвхөн сүүлийн 3 жилийн тариалангийн үзүүлэлтээ бичих ба бусад тухлах аж ахуй, үйлдвэрлэл, үйлчилгээ, шалгаруулалтын шаардлагын талаар тодорхойлолтод дэлгэрэнгүй бичсэн байна.

Үзүүлэлтийг гаргасан:

Сумын Засаг дарга ———————— (.....)
Мэргэжилтэн ———————— (.....)

Хянаж батлсан:

Аймгийн ЗДТгын дарга ———————— (.....)
Мэргэжилтэн ———————— (.....)

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Хаяг: «Төрийн мэдээлэл» эмхтгэлийн зөвлөл
Улаанбаатар-12 ☎ 329612
Төрийн ордон Индекс 14003

Улсын Их Хурлын Тамгын газрын Хэвлэх хэсэгт хэвлэв.
☎ 329487



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 36 (223)

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ:

- *Александр Менаткатыг "Найрамдал" медалиар шагнах тухай*
- *Барилга, боловсролын салбарын зарим хүнийг одон, медалиар шагнах тухай*

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ:

- *Тогтоолын заалтад өөрчлөлт оруулах тухай*
- *Хөтөлбөр батлах тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар

Улаанбаатар хот
2001 он

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот 2001 оны есдүгээр сарын 15 №36 (223)

Гарчиг

Нэг. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

427. Александр Менамкатыг "Найрамдал" медалиар шагнах тухай Дугаар 39 889
428. Нямринчингийн Төмөрбаатарт Монгол Улсын гавьяат багш цол хүртээх тухай Дугаар 40 890
429. Жамъянгийн Найданд Монгол Улсын гавьяат багш цол хүртээх тухай Дугаар 41 890
430. Барилга, боловсролын салбарын зарим хүнийг одон, медалиар шагнах тухай Дугаар 42 890
431. Элчин сайдыг эгүүлэн татах, томилох тухай Дугаар 43 892
432. Элчин сайдыг эгүүлэн татах, томилох тухай Дугаар 44 892

Хоёр. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

433. Тогтоолын заалтад өөрчлөлт оруулах тухай Дугаар 151 892
434. Хөтөлбөр батлах тухай Дугаар 153 893
435. "НИК" хувьцаат компанийн талаар авах зарим арга хэмжээний тухай Дугаар 154 903
436. Засгийн газрын хүндэт өргөмжлөлөөр шагнах тухай Дугаар 156 904

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2001 оны 8 дугаар сарын 30-ны өдөр **Дугаар 39** **Улаанбаатар хот**

Александр Менамкатыг «Найрамдал» медалиар шагнах тухай

Монгол Улсад ядуурлыг бууруулах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх, үндэсний болон орон нутгийн боловсон хүчнийг сургаж дадлагажуулахад оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Ядуурлыг бууруулах хөтөлбөрийн газрын зөвлөх, НҮБ-ын сайн дурын ажилтан Александр Менамкатыг "Найрамдал" медалиар шагнасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ **Н.БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2001 оны 8 дугаар сарын 30-ны өдөр **Дугаар 40** **Улаанбаатар хот**

Нямринчингийн Төмөрбаатарт Монгол Улсын гавьяат багш цол хүртээх тухай

Их, дээд сургуульд олон жил санаачилга, үр бүтээлтэй ажиллаж эрдэм судлалын бүтээлүүд туурвиж, инженер техникийн дээд боловсролтой мэргэжилтэн бэлтгэх, залуу үеийг сурган хүмүүжүүлэх үйлсэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Техникийн их сургуулийн техникийн механикийн тэнхмийн багш Нямринчингийн Төмөрбаатарт Монгол Улсын гавьяат багш цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2001 оны 8 дугаар сарын 30-ны өдөр **Дугаар 41** **Улаанбаатар хот**

Жамъянгийн Найданд Монгол Улсын гавьяат багш цол хүртээх тухай

Ерөнхий боловсролын сургууль дуу, хөгжмийн багшаар олон жил санаачилга, үр бүтээлтэй ажиллаж, заах аргын ур чадвараа нэмэгдүүлэн, хүүхэд залуучуудад урлагийн авьяасыг нь хөгжүүлж, дуу хөгжмийн боловсрол олгох, хөдөө орон нутгийн хөдөлмөрчдөд урлагаар үйлчлэх үйлсэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлэн Увс аймгийн Улаангом сумын найман жилийн нэгдүгээр дунд сургуулийн багш Жамъянгийн Найданд Монгол Улсын гавьяат багш цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2001 оны 8 дугаар сарын 30-ны өдөр **Дугаар 42** **Улаанбаатар хот**

Барилга, боловсролын салбарын зарим хүнийг одон, медалиар шагнах тухай

Барилга, боловсролын салбарт олон жил үр бүтээлтэй ажиллаж байгаа дор дурдсан хүмүүсийг одон, медалиар шагнасугай.

ХӨДӨЛМӨРИЙН ГАВЬЯАНЫ УЛААН ТУГИЙН ОДОНГООР:

Юнгэрэнгийн Билгээ - Дархан-Уул аймгийн Шарын гол сумын "Ирээдүй-II" цогцолбор сургуулийн бага ангийн багш

"АЛТАН ГАДАС" ОДОНГООР:

1. Даржаагийн Алтанцэцэг - Нийслэлийн "Эрэл-барилга" компанийн бригадын дарга

2. Даваажавын Гантөмөр - Нийслэлийн барилгын "Чандмань-Өлзийт" ХХК-ийн зөвлөх инженер

3. Банзрагчийн Даажав - Нийслэлийн "Барилга-Архитектур" корпорацийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан

4. Хасын Дагийсүрэн - Нийслэлийн 28 дугаар цэцэрлэгийн эрхлэгч

5. Намсрайн Даш - Нийслэлийн "Барилга-Архитектур" корпорацийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан

6. Аригдийн Дашням - Нийслэлийн 70 дугаар туслай дунд сургуулийн захирал

7. Пэрэнлэйн Дулмаа - Нийслэлийн 66 дугаар цэцэрлэгийн арга зүйч багш

8. Дашцэрэнгийн Думбаа - Ховд аймгийн Мэргэжлийн хяналтын албаны улсын байцаагч

9. Гончигдоржийн Жавзансүрэн - Нийслэлийн 38 дугаар дунд сургуулийн хичээлийн эрхлэгч

10. Дамдинсүрэнгийн Загдсамбуу - Булган аймгийн Булган сумын 2 дугаар дунд сургуулийн хичээлийн эрхлэгч

11. Дуламсүрэнгийн Зундуй - Нийслэлийн барилгын "Гангаринвест" ХХК-ийн БНХАУ-ын Хөх хотод суугаа төлөөлөгч

12. Төмөрсүхийн Лувсанцэвээн - Нийслэлийн "Улаанбаатар-Барилга" ХК-ийн дэд захирал

13. Цэрмаагийн Намсрай - Нийслэлийн түүх,

соёлын дурсгалт зүйлийг сэргээн засварлах "Соёлын өв" ХХК-ийн захирал

14. Тогтохын Наран - "Отгонтэнгэр" их сургуулийнн менежер

15. Данаажавын Нямдаваа - "Отгонтэнгэр" их сургуулийн эчнээ, орой ангийн сургалт хариуцсан ажилтан

16. Дэмбэрэлийн Ожоовор - Булган аймгийн Хангал сумын Хялгант тосгоны дунд сургуулийн зураг хөдөлмөрийн багш

17. дарьсүрэнгийн Өлзийдолгор - МУИС-ийн Нийгмийн ухааны факультетийн багш

18. Баньдийн Самдан - Увс аймгийн Баруунтуруун сумын дунд сургуулийн физикийн багш

19. Бадрахын Сурмаажав - Нийслэлийн "Ирээдүй" цогцолбор сургуулийн гүйцэтгэх захирал

20. Раднаабазарын Сүхбат - Нийслэлийн барилгын "Гангаринвест" ХХК-ийн ерөнхий нягтлан бодогч

21. Сүхийн Тойвгоо - Нийслэлийн "Эрэл" ХХК-ийн тоосгоны үйлдвэрийн албаны дарга

22. Самдангийн Тунгалаг - СУИС-ийн төгөлдөр хуурийн багш

23. Ширмэнгийн Хүрэлтогоо - Нийслэлийн "Улаанбаатар - Барилга" ХК-ийн ахлах инженер

24. Бадрахын Цэнгэлдорж - Увс аймгийн "Увс - Барилга" ХХК-ийн захирал

25. Санжаажамцын Цэнд - Нийслэлийн "Гурван-Эрдэнэ" БДС-ийн багш

26. Димбүүгийн Цэрэндорж - Увс аймгийн Цагаанхайрхан сумын дунд сургуулийн монгол хэл, уран зохиолын багш

27. Даржаагийн Цээпэл - Увс аймгийн "Увс-Барилга" ХХК-ийн ерөнхий инженер

28. Самдангийн Шархүү - Нийслэлийн түүх, соёлын дурсгалт зүйлийг сэргээн засварлах "Соёлын өв" ХХК-ийн инженер

29. Бүлтэнхүүгийн Энхжаргал - Нийслэлийн цахилгаан, сантехник угсралтын "Хүрд" ХХК-ийн ерөнхий захирал

30. Басьмины Эрдэнэ-Уул - Нийслэлийн барилга архитектур корпорацийн инженер

31. Санжмятавын Янжиндулам - Нийслэлийн "Монгени" цогцолбор сургуулийн түүхийн багш

ХӨДӨЛМӨРИЙН ХҮНДЭТ МЕДАЛИАР

1. Балдандуйнхарын Алтангэрэл - Дорнод аймгийн Чойбалсан сумын цэцэрлэгийн эрхлэгч

2. Пүрэвжавын Алтанцэцэг - Нийслэлийн 22 дугаар цэцэрлэгийн багш

3. Балдандоржийн Батлхагва - Нийслэлийн 87 дугаар дунд сургуулийн зураг хөдөлмөрийн багш

4. Гэндэнжамцын Батцэрэн - СУИС-ийн гоцлол дууны багш

5. Сүрэнхорын Баяраа - Нийслэлийн "Улаанбаатар - Барилга" ХК-ийн жолооч

6. Баатарын Ганболд - Нийлэлийн "Эрэл" ХХК-ийн тоосгоны үйлдвэрийн захирал

7. Бавалын Даваадорж - МУИС-ийн Ховд аймаг дахь салбар сургуулийн монгол хэл, уран зохиолын багш

8. Цэвээндоржийн Дэлгэр - СУИС-ийн уртын дууны багш

9. Гармаагийн Жамбалдорж - Нийслэлийн барилга үйлдвэрлэлийн "Улаанбаатар - БҮК" ХК-ийн ерөнхий механикч

10. Лхагважавын Жүгдэр - Нийслэлийн 74 дүгээр цэцэрэгийн эрхлэгч

11. Бадарчийн Лхагва - Нийслэлийн "Барилга архитектур" ХК-ийн секторын эрхлэгч

12. Чүлтэмийн Лхагва-Очир - Сэлэнгэ аймгийн Сайхан сум дахь Хөтөлийн цемент, шохой /УҮГ/-ын зуухны машинч

13. Сосорбурамын Лхагвасүрэн - Өвөрхангай аймгийн Арвайхээр сумын "Мэрэгд" цогцолбор сургуулийн бага ангийн багш

14. Бавуугийн Лундаа - Нийслэлийн цахилгаан, сантехник угсралтын "Хүрд" ХК-ийн токарьчин

15. Лувсансамдангийн Мягмаржав - Нийслэлийн барилгын материал үйлдвэрлэлийн "Бетон-арматур" ХК-ийн дэд захирал

16. Ёндон-Осорын Наранхүү - Өмнөговь аймгийн барилгын үйлдвэрлэлийн "Говьгурвансайхан" ХК-ийн ерөнхий менежер

17. Чүлтэмжамцын Нямсүрэн - Булган аймгийн Хишиг-Өндөр сумын дунд сургуулийн биеийн тамирын багш

18. Дэмбэрэлийн Оюунхишиг - СУИС-ийн найрал дууны багш

19. Банзрагчийн Пүрэвсүрэн - Сүхбаатар аймгийн Мөнххаан сумын 8-н жилийн дунд сургуулийн хичээлийн эрхлэгч

20. Равчигийн Самъяа - МУИС-ийн биологийн факультетийн декан

21. Содномдашийн Санжид - Нийслэлийн барилгын материал үйлдвэрлэлийн бетон арматур ХК-ийн ерөнхий инженер

22. Дагвын Сундуйжав - Дархан -Уул аймгийн Дархан сум дахь мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн физикийн багш

23. Ходройн Сэргэлэн - Нийслэлийн 2 дугаар цэцэрлэгийн ахлах тогооч

24. Цэвээнжамбын Түмэнжаргал - Дорнод аймгийн Булган сумын дунд сургуулийн бага ангийн багш

25. Ойдовын Цогзолмаа - Завхан аймгийн Улиастай сумын 2 дугаар дунд сургуулийн бага ангийн багш

26. Сэрэндашийн Цэвээндорж - Нийслэлийн "Улаанбаатар-Барилга" ХК-ийн механик инженер

27. Батын Цэнд-Аюуш - Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сумын дунд сургуулийн монгол хэл, уран зохиолын багш

28. Дэмбэрэлийн Цэрэндулам - Нийслэлийн барилгын материал үйлдвэрлэлийн бетон арматур ХК-ийн цехийн дарга

29. Өлзийн Цэцгээ - Циркийн дунд сургуулийн захирал

30. Лхасранжавын Чулуунбаатар -Хөвсгөл аймгийн Чандмань-Өндөр сумын дунд сургуулийн захирал

31. Лувсанжамцын Энхбат - Сэлэнгэ аймгийн Сайхан сум дахь Хөтөлийн цемент, шохой /УУГ/-ын засварчин

32. Сэрээнэнгийн Энхтайван - Нийслэлийн 16 дугаар дунд сургуулийн хичээлийн эрхлэгч

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2001 оны 8 дугаар сарын 31-ний өдөр **Дугаар 43** **Улаанбаатар хот**

Элчин сайдыг эгүүлэн татах, томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5, Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг баримтлан ЗАРЛИГ болгох нь:

1. Монгол Улсаас Бүгд Найрамдах Ардчилсан Солонгос Ард Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Дамдины Бямбааг эгүүлэн татсугай.

2. Монгол Улсаас Бүгд Найрамдах Ардчилсан Солонгос Ард Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Жанчивдоржийн Ломбыг томилсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2001 оны 8 дугаар сарын 31-ний өдөр **Дугаар 44** **Улаанбаатар хот**

Элчин сайдыг эгүүлэн татах, томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5, Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг баримтлан ЗАРЛИГ болгох нь:

1. Монгол Улсаас Бүгд Найрамдах Австри Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Равдангийн Хатанбаатарыг эгүүлэн татсугай.

2. Монгол Улсаас Бүгд Найрамдах Австри Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Таукейн Султааныг томилсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 7 дугаар сарын 4-ний өдөр **Дугаар 151** **Улаанбаатар хот**

Тогтоолын заалтад өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

өдрийн 32 дугаар тогтоолд дор дурдсан өөрчлөлт оруулсугай:

"Төрийн өмчийн байрыг худалдах тухай" Засгийн газрын 1999 оны 2 дугаар сарын 24-ний

а/3 дугаар зүйлд "3.2" гэснийг "3.0" гэж, "10 жилийн дотор" гэснийг "2001 оны 9 дүгээр

сард багтаан" гэж өөрчлөх;

б/4 дүгээр зүйлийн "в" заалтыг "худалдан авагч нь худалдан авсан барилгын тохиролцсон үнийн үлдэгдлийг 2001 оны 7 дугаар сард 40 хувийг нь, 9 дүгээр сард 60 хувийг нь тус тус Төрийн өмчийн хороотой байгуулсан гэрээний дагуу зохих дансанд шилжүүлэх журмаар төлөх, хэрэв төлбөрийн хугацааг хожимдуулбал Иргэний хуулийн 180 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт заасны дагуу хожимдуулсан хоног тутам төлөх ёстой төлбөрийн 0.5 хувьтай тэнцэх алданги төлөх" гэж өөрчлөн найруулах.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН САЙД Ч.УЛААН

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 7 дугаар сарын 4-ний өдөр **Дугаар 153** **Улаанбаатар хот**

Хөтөлбөр батлах тухай

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн нөхцөлийг сайжруулах Үндэсний хөтөлбөр"-ийг 1 дүгээр хавсралт, Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 2 дугаар хавсралт, Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний санхүүжилтийг 3 дугаар хавсралт ёсоор тус тус батлуулсугай.

2. Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд Ш.Батбаярт даалгасугай.

3. Үндэсний хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээг салбар, орон нутгийн хэмжээнд хэрэгжүүлж, биелэлтийг нь жил бүрийн 12 дугаар сард багтаан Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яаманд ирүүлж байхыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт, дунг нэгтгэн дараа оны 2 дугаар сард багтаан Засгийн газарт танилцуулж байхыг Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд Ш.Батбаярт үүрэг болгосугай.

4. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн нөхцөлийг сайжруулах Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээ болон түүнд шаардагдах хөрөнгийг эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх жил бүрийн үндсэн чиглэл, улсын төвлөрсөн төсөвт тусган санхүүжүүлж байхыг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаан, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд Ш.Батбаяр, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нарт даалгасугай.

5. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Хөдөлмөр хамгаллын талаар авах зарим арга хэмжээний тухай" БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 1969 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 433 дугаар тогтоол, "Хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны талаар авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 1996 оны 1 дүгээр сарын 30-ны өдрийн 19 дүгээр тогтоол, "Хөтөлбөр батлах тухай" Засгийн газрын 1997 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 257 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД БӨГӨӨД НИЙГМИЙН ХАМГААЛАЛ,ХӨДӨЛМӨРИЙН САЙДЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ П.НЯМДАВАА

Засгийн газрын 2001 оны 153 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГАА, ЭРҮҮЛ АХУЙН НӨХЦӨЛИЙГ САЙЖРУУЛАХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн өнөөгийн байдал

Зах зээлийн эдийн засагт шилжсэн 1990-ээд оноос эхлэн хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн асуудлыг төр хариуцах болсон бөгөөд энэ хугацаанд хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн талаар хэд хэдэн шийдвэр гарган хэрэгжүүлж байна. 1997 онд улсын хэмжээнд аж ахуйн нэгж, байгууллагын хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн нөхцөлд үзлэг явуулж, үг үзлэгийн дүнг үндэслэн Засгийн газраас Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн нөхцөлийг сайжруулах Үндэсний хөтөлбөр (1997-2000 он)-ийг батлан хэрэгжүүлэх арга хэмжээ авлаа.

Энэ хугацаанд Хөдөлмөрийн тухай шинэ хууль батлагдаж, Олон улсын хөдөлмөрийн байгууллагын Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй, үйлдвэрлэлийн орчны тухай 155 дугаар конвенцид манай улс нэгдэн ороод байна.

Хөдөлмөрийн гэрээгээр ажилтан ажиллуулж байгаа ажил олгогч бүхэнд хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн асуудал шууд хамааралтай бөгөөд энэ ажлыг зохион байгуулан удирдах, төлөвлөх, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн асуудалд зориулсан хөрөнгийн эх үүсвэр бий болгон зарцуулах, ажилтныг хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны арга техникт сургах, үйлдвэрлэлийн осол, аваарь гаргахгүй байх, гарсан ослыг нарийн бүртгэж, дахин гарахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах, ажилтныг ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслээр хангах нь тухайн аж ахуйн нэгж, байгууллагын гол асуудал юм.

Зах зээлийн эдийн засгийн харилцааны өнөөгийн нөхцөлд ажил олгогчийн ашгийн төлөө хэт хөөцөлдөх хандлага нь зарим тохиолдолд ажилтны хөдөлмөрлөх эрх ашиг болон хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн талаар тогтоосон журмыг зөрчихөд хүргэж байна.

Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн үндэсний хөтөлбөр хэрэгжүүлж эхлэхийн өмнөх үеийн үйлдвэрлэлийн осол, түүнд өртсөн болон нас барсан хүний тоог 2000 оны жилийн эцсийн дүнтэй харьцуулахад 1000 хүнд ногдох үйлдвэрлэлийн осол 1.16-гаар, осолд өртсөн хүний тоо 1.25-аар, ослын улмаас нас барсан хүний тоо 0.065-аар тус тус буурсан үзүүлэлт гарч байна.

Гэвч эдгээр үзүүлэлтээр хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн одоогийн нөхцөл байдал сайжирсан гэж үзэхэд зарим талаар учир дутагдалтай байна.

Энэ нь манай оронд урьд өмнө ажиллаж байсан улсын чанартай томоохон үйлдвэрийн газрууд задарч, олонхи нь ажиллахаа больсон, үндэсний үйлдвэрлэл зүс буурсан, нөгөө талаар хувийн хэвшилд давамгайлах болсноос тэдгээрт гарч байгаа үйлдвэрлэлийн осол тэр бүр бүртгэгдэхгүй байгаатай холбоотой юм.

Мөн мэргэжлээс шалтгаалсан өвчлөлд өртөж, хөдөлмөрийн чадвараа алдан эрүүл мэндээр хохирсон хүний тоо буураагүй байна.

Жил бүр дунджаар (1997-2000 он) 5692 хүн мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас тахир дутуу болж, хөдөлмөрийн чадвараа алдаж байна. Үүнд тоосны гаралтай цагаан мөгөрсөн хоолойн архаг үрэвсэл 55.7 хувь, уушиг тоосжих өвчин 16.2 хувь, мэдрэлийн өвчин 8.3 хувь, хурц хордлого 8.4 хувь, мэс засал, яс булчингийн өвчин 7.0 хувиар тус тус зонхилох байр эзэлж байгаа бөгөөд эдгээр өвчлөл нь түлш, эрчим хүч, геологи, уул уурхай, барилгын салбарт илүү гарсан байна. Үүний зэрэгцээ 20-30 жилийн өмнө ашиглалтад орсон үйлдвэрийн ажиллагсдын өвчлөлийн оргил үе таарч байгаа, түүнд үйлдвэрлэлийн хуучирсан техник, тоног төхөөрөмж нөлөөлж байгаатай холбоотой юм.

2. Тулгамдаж буй асуудал

Ажлын байрны хэвийн нөхцөлийг хангах, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн талаархи хууль тогтоомжийг мөрдөхүй байгаа явдал аж ахуйн нэгж, байгууллагад байсаар байна.

Төрийн болон төрийн бус байгуулага, аж ахуйн нэгжийн хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн хяналтын асуудал хариуцсан ажилтныг мэргэшүүлэх, хяналт шалгалтын ажлын арга барилыг бүх шатанд дээшлүүлэх явдал хурцаар тавигдаж байна.

Түүнчлэн үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний талаар мэдээллийн тогтсон системгүй байгаа бөгөөд мэдээ, мэдээлэл нь хяналтын байгууллагын улсын байцаагчийн хүрээнээс хальж чадаагүй байна.

Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний талаар урьдчилан сэргийлэх ажил шаардлагын түвшинд хүрээгүй нь хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн талаар хийсэн судалгаа, шинжилгээний ажил дутагдаж байгаатай холбоотой юм.

Хөдөлмөрийн нөхцөлд хэмжилт, судалгаа хийдэг лаборатори, түүний тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл нь хоцрогдсоны улмаас хөдөлмөрийн нөхцөлийн хэмжилт, судалгааг мэргэжлийн өндөр түвшинд хийх боломжгүй байна.

Иймд хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн нөхцөлийг сайжруулах төр, засгийн бодлого, зорилтыг хэрэгжүүлэх үүднээс "Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн нөхцөлийг сайжруулах үндэсний хөтөлбөр"-ийг (цаашид "Хөтөлбөр" гэх) Засгийн газраас батлан гаргаж байна.

Хоёр. Хөтөлбөрийн зорилго, зорилт, хэрэгжүүлэх арга хэмжээ

3. Хөтөлбөрийн зорилго нь хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн эрх зүй, удирдлага, зохион байгуулалт, хяналт, мэдээллийн тогтолцоог боловсронгуй болгох, гарч болзошгүй аюул, осол, аваариас урьдчилан сэргийлэх ажлыг сайжруулах, үйлдвэрлэлийн орчноос үүсэх таагүй нөлөөллийг шалтгааныг тогтоон арилгах, өвчийн бүх хэвшлийн аж ахуйн нэгж, байгуулагын ажил олгогч болон ажилтны хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн талаар хүлээх үүрэг, хариуцлагыг өндөржүүлэхэд оршино.

4. Хөтөлбөрийн зорилгыг хэрэгжүүлэхийн тулд дараахь үндсэн зорилт, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээг дэвшүүлж байна:

5. Хууль тогтоомжийг боловсронгуй болгох талаар шийдвэрлэх зорилт:

Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн эрх зүйн орчинг нийгэм, эдийн засгийн харилцаанд гарч байгаа өөрчлөлт, Олон улсын хөдөлмөрийн байгуулагын конвенц, зөвлөмжтэй нийцүүлэн боловсронгуй болгоно.

6. Хэрэгжүүлэх арга хэмжээ:

а/хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн асуудлыг боловсронгуй болгох чиглэлээр холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах;

б/хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн нөхцөлийг хангахад тавигдах шаардлагыг Олон улсын хөдөлмөрийн байгуулагын конвенц, зөвлөмж, хөдөлмөрийн стандарттай нийцүүлэн боловсронгуй болгох;

в/төрийн өмчит хуулийн этгээдийн ажилтны хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн нөхцөлийг хангахад чиглэсэн зардалтай холбоотой асуудлыг хуулиар зохицуулах.

7. Удирдлага, зохион байгуулалтыг боловсронгуй болгох талаар шийдвэрлэх зорилт:

Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн ажлын удирдлага, зохион байгуулалтын бүтэц, хяналтын тогтолцоог боловсронгуй болгож,мэргэжлийн боловсон хүчнээр бэхжүүлнэ.

8. Хэрэгжүүлэх арга хэмжээ:

а/хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн төв, орон нутгийн байгууллагын бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгох, боловсон хүчний чадавхийг дээшлүүлэх;

б/хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн хяналтын үр нөлөөг сайжруулах.

9. Сургалтын тогтолцоог бий болгох талаар шийдвэрлэх зорилт:

Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн сургалтын тогтолцоог бий болгоно.

10. Хэрэгжүүлэх арга хэмжээ:

а/хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн сургалтын нэгдсэн тогтолцоо бий болгох;

б/сургалтын төлөвлөгөөнд хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн зохих мэдлэг, дадал олгох асуудлыг тусгах;

в/хөдөлмөрийн болон хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын байцаагч, шинжээч, мэргэжилтнүүдийн ажлын арга барилыг дээшлүүлж, мэргэшүүлэх.

11. Мэдээллийн нэгдсэн систем бий болгох талаар шийдвэрлэх зорилт:

Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн мэдээллийн нэгдсэн тогтолцоотой болж, олон нийтэд сурталчилах ажлыг чанаржуулна.

12.Хэрэгжүүлэх арга хэмжээ:

а/үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалах өвчний мэдээллийн нэгдсэн системийг бий болгож, мэдээллийн урсгалыг сайжруулах;

б/хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн талаархи хууль тогтоомжийг олон нийтэд сурталчилах, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх ажилд хэвлэл, мэдээллийн байгууллагыг өргөнөөр татан оролцуулах.

13. Судалгаа шинжилгээний ажлыг сайжруулах талаар шийдвэрлэх зорилт:

Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн ажлыг судалгаа шинжилгээний үндсэн дээр хөгжүүлнэ.

14. Хэрэгжүүлэх арга хэмжээ:

а/үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний судалгааг шинжлэх ухааны үндсэн дээр хөгжүүлэх;

б/мэргэжлээс шалтгаалсан өвчнийг эрт оношлох, эмчлэх, урьдчилан сэргийлэх ажлыг сайжруулах;

в/хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн судалгаа шинжилгээний нэгж бий болгох.

15. Төрийн бус байгууллага, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх талаар шийдвэрлэх зорилт:

Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн нөхцөлийг сайжруулахад төрийн бус байгууллага, олон нийтийн оролцоог нэмэгдүүлнэ.

16. Хэрэгжүүлэх арга хэмжээ:

а/хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн олон нийтийн хяналтыг бий болгох;

б/хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн ажилд ажилтны эрх ашиг хууль ёсны сонирхлыг төлөөлөн хамгаалах байгууллагын оролцоог нэмэгдүүлэх;

в/хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн асуудалд ажил олгогчийн оролцоо, үүрэг хариуцлагыг өндөржүүлэх.

17. Хөдөлмөрийн нөхцөлийн хэмжилт судалгааны ажлыг өргөжүүлэх талаар шийдвэрлэх зорилт:

Ажлын байрны нөхцөлийн үнэлгээ, хэмжилтийн ажлыг өргөжүүлж, материаллаг баазыг сайжруулна.

18. Хэрэгжүүлэх арга хэмжээ:

а/хөдөлмөрийн хяналтын хэмжилтийн техникийн чадамжийг дээшлүүлэх;

б/ажлын байрны нөхцөлийн үнэлгээ хийх төв лабораторийг шинэчлэн тоноглож, материаллаг баазыг өргөжүүлэх.

19. Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааны үүрэг хариуцлагыг өндөржүүлэх талаар шийдвэрлэх зорилт:

Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн талаархи хууль тогтоомжийн шаардлагыг аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд хэвшүүлж, үүрэг хариуцлагыг өндөржүүлнэ.

20. Хэрэгжүүлэх арга хэмжээ:

а/аж ахуйн нэгж, байгууллагад

үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх, сэрэмжлүүлэх ажлыг хэвшүүлэх;

б/аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн стандартын шаардлага хангуулах;

в/аж ахуйн нэгж, байгууллагын ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийг аттестатчилж, аюулгүй ажиллагааны шаардлагыг хангуулах;

г/эрсдэл бүхий зарим салбарт хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн дэд хөтөлбөр хэрэгжүүлэх.

Гурав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа, удирдлага, зохион байгуулалт, санхүүжилт

21. Хөтөлбөрийг 2001-2004 онд хэрэгжүүлнэ.

22. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалтын бүтэц:

а/хөтөлбөрийн хэрэгжилтийг удирдлага, зохион байгуулалтаар хангах ажлыг нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрээр байгуулсан Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн Үндэсний хороо, аймаг, нийслэлийн салбар зөвлөл хариуцна;

б/хөтөлбөрийн хэрэгжилтийг улсын хэмжээнд зохион байгуулах, зохицуулах үүргийг Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамны хөдөлмөрийн асуудал хариуцсан нэгж гүйцэтгэнэ;

в/үндэсний хөтөлбөр хэрэгжүүлэхэд үйлдвэрчний эвлэл, ажил олгогч, төрийн бус байгууллага өөрсдийн чиг үүргийн дагуу оролцоно.

23. Хөтөлбөрийн санхүүжилтийг дараахь эх үүсвэрээс бүрдүүлнэ:

а/улсын төвлөрсөн төсөв;

б/орон нутгийн төсөв;

в/хандивлагч орон, олон улсын байгууллагын зээл, тусламж;

г/аж ахуйн нэгж, байгууллагын өөрийн хөрөнгө;

д/хөрөнгийн бусад эх үүсвэр.

Дөрөв. Хөтөлбөрийн үр дүн, хяналт, мониторинг

24. Хөтөлбөрийн үр дүн:

а/хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн хууль эрх зүйн орчин боловсронгуй болно;

б/хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн удирдлага, зохион байгуулалт, хяналтын зохистой тогтолцоо, бүтэц бий болно;

в/хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн мэргэшсэн боловсон хүчнээр бэхжиж, тэдний ажиллах нөхцөл, баталгаа сайжирна;

г/хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн мэдээллийн тогтолцоо бий болж, судалгаа шинжилгээний ажлын үр дүн сайжирна;

д/үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчлөл буурна;

е/хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн ажилд ажил олгогч, ажилтан, иргэд, төрийн бус байгууллагын оролцоо нэмэгдэнэ;

ж/ажлын байрны хөдөлмөрийн нөхцөл сайжирна;

з/хөтөлбөрийн нийгэм, эдийн засгийн үр ашиг нь хүний амь нас, эрүүл мэндэд учирч болзошгүй гарз хохирлоос урьдчилан сэргийлж, улмаар нийгмийн даатгал болон аж ахуйн нэгж, байгууллагын хөрөнгөөс гарах хэмнэлтээр хэмжигдэнэ.

25.Хөтөлбөрийн хяналт, мониторинг:

а/хөтөлбөрийн хэрэгжилтэд мониторинг хийх үүргийг Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн үндэсний хороо, түүний салбар зөвлөл, төрийн захиргааны төв байгууллагын мэдээлэл, үнэлгээ, хяналт, шинжилгээний албад хариуцна;

б/хөтөлбөрийн мониторингийн үйл ажиллагаанд дэвшилтэт арга хэрэглэж, олон нийт, төрийн бус байгууллагыг өргөнөөр оролцуулна;

в/хөтөлбөрийн хэрэгжилтэд хөндлөнгийн хяналт хийх нөхцөлийг бүрдүүлнэ.

Засгийн газрын 2001 оны 153 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГАА, ЭРҮҮЛ АХУЙН ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

1. Хөдөлмөрийн тухай хуульд хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн асуудлыг боловсронгуй болгох талаар нэмэлт, өөрчлөлт оруулах;

2003 онд НХХЯ, ХЗДХЯ

2. Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэрэгжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг боловсруулж, шийдвэрлүүлэх;

2002-2004 он НХХЯ, СЭЗЯ, ХЗДХЯ

3. Олон улсын хөдөлмөрийн байгууллагын 81, 161 дүгээр конвенц, зөвлөмжид нэгдэн орох асуудлыг судалж, шийдвэрлүүлэх;

2002-2004 он НХХЯ, ГХЯ, ХНХУХА

4. Төрийн өмчит хуулийн этгээдийн ажилтны хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн арга хэмжээнд зарцуулах хөрөнгийг улсын төсөвт тусгах эрх зүйн зохицуулалт бий болгох асуудлыг боловсруулж, шийдвэрлүүлэх;

2001-2004 он СЭЗЯ, НХХЯ

5. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн стандартуудыг Хөдөлмөрийн тухай хууль, олон улсын стандартуудтай нийцүүлэн шинэчлэх, шинээр боловсруулж мөрдүүлэх;

2001-2003 он НХХЯ, СХЗҮТ

6. Ажлын тусгай хувцас, бие хамгаалах хэрэгслийн стандартыг боловсруулж батлуулан мөрдүүлэх;

2001-2002 он НХХЯ, СХЗҮТ

7. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн төв, орон нутгийн байгууллагын бүтцийг боловсронгуй болгож, боловсон хүчнээр бэхжүүлэн, тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг бүрдүүлэх;

2001-2002 он НХХЯ, ДБЯ, ХХААЯ, ЭМЯ, ҮХЯ

8. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн хяналтыг захиргааны хяналтын чиг үүрэг гүйцэтгэдэг албадын үйл ажиллагаатай уялдуулан зохицуулж, хөдөлмөрийн хяналтын үр нөлөөг дээшлүүлэх;

2002-2003 он НХХЯ, ХНХУХА

9. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн мэргэшсэн ажилтан бэлтгэх асуудлыг боловсруулж шийдвэрлүүлэх;

2001-2004 он БСШУЯ, НХХЯ, ЭМЯ

10. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн сургалтын тогтолцоо бий болгох асуудлыг боловсруулж хэрэжүүлэх;

2002 он БСШУЯ, НХХЯ, МҮЭХ, МАОЭНХ

11. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн асуудлыг холбогдох их сургууль, коллежийн сургалтын төлөвлөгөөнд оруулах асуудлыг шийдвэрлэх;

2002-2003 он БСШУЯ, НХХЯ

12. Ерөнхий боловсролын сургуулиудад хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн анхан шатны мэдлэг, дадал олгох асуудлыг сургалтын төлөвлөгөөнд оруулах асуудлыг боловсруулах;

2002-2003 он БСШУЯ, НХХЯ

13. Хөдөлмөрийн болон хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын байцаагч, мэргэжилтнийг гадаад, дотоодын сургалт, семинарт хамруулах, туршлага судлуулах, мэргэшлийг дээшлүүлэх арга хэмжээ авах;

2001-2004 он НХХЯ, ХНХУХА

14. Улсын иргэний хамгаалалтын газрыг түшиглэн байгалийн гамшиг, үйлдвэрлэлийн осол, авариас урьдчилан сэргийлэх, хамгаалахад хүн амыг бэлтгэх, сургах төв бий болгох асуудлыг шийдвэрлэх;

2002-2003 он БХЯ, СЭЗЯ, БСШУЯ

15. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн мэдээллийн төвийг материаллаг бааз, боловсон хүчнээр бэхжүүлэх арга хэмжээ авах;

2002-2003 он НХХЯ, ХНХУХА

16. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалах өвчний мэдээг үндэсний статистикийн мэдээнд оруулах асуудлыг шийдвэрлэх;

2001-2002 он ҮСГ, НХХЯ

17. Хөдөлмөрийн талаархи хууль тогтоомж, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн стандартын эмхтгэл, гарын авлага, материалаар аж ахуйн нэгж, байгууллагыг хангах, олон нийтэд сурталчилах ажлыг өргөжүүлэх;

2001-2004 он НХХЯ, МҮЭХ, МАОЭНХ

18. Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний шалтгаан нөхцөлийг нарийвчлан судалж, холбогдох арга хэмжээ авах;

2002-2003 он НХХЯ, ЭМЯ, ДБЯ, ҮХЯ

19. Мэргэжлээс шалтгаалсан өвчнийг эрт оношлох, эмчлэх, урьдчилан сэргийлэх ажлыг сайжруулах санал боловсруулж, шийдвэрлэх;

2002-2003 он НХХЯ, ЭМЯ, УНДЕГ, МӨСӨХМҮТ

20. Үйлдвэрлэлийн осол гаргаагүй аж ахуйн нэгж, байгууллага болон хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн ажлыг үлгэр жишээчээр зохион байгуулсан ажилтанд урамшуулал олгох;

2001-2004 он НХХЯ, МҮЭХ, МАОЭНХ

21. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн хяналтын ажилд төрийн бус байгууллагын ажилтныг оролцуулах;

2001-2002 он НХХЯ, ХНХУХА

22. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн орон тооны бус байцаагчийг сургах ажлыг зохион байгуулах;

2001-2003 он НХХЯ, МҮЭХ, МАОЭНХ

23. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн зарим асуудлыг гэрээний үндсэн дээр төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх;

2001-2004 он НХХЯ, МАОЭНХ

24. Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн стандартын шаардлага хангуулах арга хэмжээ авах;

2002-2004 он НХХЯ, ХНХУХА

25. Хөдөлмөрийн хяналтын улсын байцаагчийг хэмжилтийн багаж хэрэгслээр хангах;

2002-2003 он НХХЯ, СЭЗЯ, ХНХУХА

26. Тоосжилт, хорт утаа, хий ихтэй болон химийн бодис хэрэглэдэг аж ахуйн нэгж, байгууллагуудад хэмжилт, судалгааны лабораторитой болох ажлыг зохион байгуулах;

2001-2003 он ДБЯ, БОЯ, МАОЭНХ

27. Олон улсын хөдөлмөрийн байгууллага, Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын силикоз өвчнийг бүрэн устгах олон улсын 2000-2030 оны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээ авах;

2001-2002 он НХХЯ, ЭМЯ, МҮЭХ, МАОЭНХ

28. Ажлын байрны нөхцөлийн үнэлгээ хийх лабораторийг бие даалган ажиллуулах, шаардлагатай багаж, тоног төхөөрөмжөөр хангах асуудлыг шийдвэрлэх;

2002-2003 он НХХЯ, СЭЗЯ, ХНХУХА

29. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх, сэрэмжлүүлэх ажлыг зохион байгуулах;

2001-2004 он НХХЯ, ДБЯ, ЭМЯ, ҮХЯ, ХНХУХА, РТХЭГ, МҮЭХ, МАОЭНХ

30. Уул уурхай, геологи, эрчим хүч, барилгын салбарын байгууллагуудад "Тоосжилтыг багасгаж, бууруулах хөтөлбөр" боловсруулан хэрэгжүүлэх;

2002-2004 он НХХЯ, ДБЯ, ЭМЯ

31. Аж ахуйн нэгж, байгууллагыг хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн чиглэлээр аттестатчилах ажлыг хоёр үе шаттайгаар зохион байгуулах.

2002-2004 он НХХЯ, ХНХУХА, ЗДТГ

Засгийн газрын 2001 оны 133 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт

ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГАА, ЭРҮҮЛ АХУЙН НӨХЦӨЛИЙГ САЙЖРУУЛАХ ҮНДСЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ САНХҮҮЖИЛТ

№	Хөдөлмөрийн эрүүл ахуйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ	Санхүүжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Санхүүжилт (сая төг)					Хэрэгжүүлэх холбогдох байгууллага
				2001	2002	2003	2004	Дүн	Эх үүсвэр	
1	5 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн стандартудыг шинэчлэн боловсруулж, мөрдүүлэх	Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн стандартуудыг шинэр болон шинэчлэн боловсруулж, мөрдүүлэх	2001-2003	1.0	3.0	1.0	-	5.0	Төвлөрсөн төсөв	НХҮЯ, СЗЗҮТ
2	6 Ажлын түгээй хувцас, бие хамгаалах хэрэгслийн стандартыг шинэр боловсруулах	Ажлын түгээй хувцас, бие хамгаалах хэрэгслийн стандартыг шинэр боловсруулах	2001-2002	-	1.0	1.0	-	2.0	-"-	-"-
3	8 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн хяналтын ажлын үзлэгт хөдөлмөрийн нөлөөг дэзшүүлэх, эвдэлгүй, сургалт зохион байгуулах, улсын байцаагчдыг аттестатчилах	Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн хяналтын ажлын үзлэгт хөдөлмөрийн нөлөөг дэзшүүлэх, ажил гэрлийн эвдэлгүй, сургалт зохион байгуулах, улсын байцаагчдыг аттестатчилах	2001-2004	-	5.0	5.0	5.0	15.0	-"-	-"-
	Аж ахуйн нэгж, байгууллагад хяналтын карт, тоног төхөөрөмж, ажлын байрны паспорт, гэрчилгээ хэвлүүлэх	Аж ахуйн нэгж, байгууллагад хяналтын карт, тоног төхөөрөмж, ажлын байрны паспорт, гэрчилгээ хэвлүүлэх	2001-2002	-	3.0	3.0	-	6.0	-"-	ХНХҮҮХА
4	9 Хөдөлмөрийн нөхцөлийн хэмжилт судалгааны лабораторийн физик, химич нарыг мэргэжил дээшлүүлэх сургалтад хамруулах	Хөдөлмөрийн нөхцөлийн хэмжилт судалгааны лабораторийн физик, химич нарыг мэргэжил дээшлүүлэх сургалтад хамруулах	2001-2004	-	8.0	-	8.0	16.0	ОУХБ (төсөл)	НХҮЯ, ХНХҮХА
	Хөдөлмөрийн хяналтын улсын байцаагч мэргэжлээс шалгаалах өөчин судлагч эмч нарыг мэргэжил дээшлүүлэх сургалтад хамруулах	Хөдөлмөрийн хяналтын улсын байцаагч мэргэжлээс шалгаалах өөчин судлагч эмч нарыг мэргэжил дээшлүүлэх сургалтад хамруулах	2002	-	8.5	-	-	8.5	Төвлөрсөн төсөв	ХНХҮХА, МӨСЭЗМҮТ

5	10	Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн сургалтын стратегийн бэримт бичиг, хөтөлбөр боловсруулах	2001	25.0	-	-	-	25.0	ОУХБ (тесеп)	НХҮЯ, ХНХҮХА
6	13	Хөдөлмөрийн болон хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын улсын байцаагч нарыг гадаад оронд сургах, туршлага судлуулах	2001-2004	-	15.0	-	15.0	30.0	Төлөвлөсөн төсөв	НХҮЯ, ХНХҮХА
7	14	Улсын иргэний хамгаалалтын газарыг түшиглэн осол, сүйрлээс урьдчилан сэрилтэх, хамгаалахад хүн амыг сургах, бэлтгэх төв байгуулах	2002-2003	-	-	20.0	-	20.0	-"-	БХЯ, БСШУЯ
8	15	Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн мэдээллийн төвийг бэхжүүлэх, тоног төхөөрөмж, сургалтын багаж хэрэгсэлээр хангах	2002-2003	-	2.0	3.5	-	5.5	-"-	НХҮЯ, ХНХҮХА
9	17	Хөдөлмөрийн хууль тогтоомжийн зөмхтэл, гарын авлага хэвлүүлэх	2001-2004	2.0	2.0	3.0	3.0	10.0	-"-	ХНХҮХА
		Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн сургалтнилтаны ажлыг зохион байгуулах	2001-2004	4.0	4.0	4.0	3.0	15.0	-"-	ХНХҮХА
10	18	Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний шалтгаан, нөхцөлийн нарийвчлалсан судалгаа хийх	2002-2003	-	1.5	-	-	1.5	-"-	ХНХҮХА, МЕСЭЗМУТ
11	21	Үйлдвэрлэлийн осол гаргалгүй аж ахуйн нэгж, байгууллага, Хөдөлмөрийн аюулгүй ажилпагаа, эрүүл ахуйн ажлыг үлгэр жишээ зохион байгуулсан ажилтныг урамшуулах	2001-2004	-	7.5 31.0	-	- 31.0	7.5 62.0	-"- орон нутгийн төсөв	НХҮЯ, МҮЭХ, Засаг дарга нар

12	22	Төрийн бус байгууллагын орон тооны бус хяналтын байцаагчдыг хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн чиглэлээр сургалтад хамруулах	2001-2002	-	4.0	-	-	4.0	Төвлөрсөн төсөв	ХНХУХА, МҮЭХ, Хөдөлмөр хамгаалал хөдөлгөөн
13	26	Хөдөлмөрийн болон хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын улсын байцаагчдыг хэмжилтийн багаж, хэрэгслээр хангах	2002-2003	-	25.0	20.0	-	45.0	Азийн хөгжлийн банк, Хөнгөлөлттэй зээл	НХХЯ
14	29	Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлд үнэлгээ хийх лабораторийг ергэлтех, багаж хэрэгсэл, урвалж бодис, техөөремжөөр хангах	2002-2003	-	13.0 70.0	20.0 -	- -	33.0 70.0	Төвлөрсөн төсөв, Азийн хөгжлийн банк, Хөнгөлөлттэй зээл	НХХЯ, ХНХУХА,
15	30	Аж ахуйн нэгжид хэрэглээ буй химийн бодисыг шошгожуулах ажлыг зохион байгуулж, хэрэгжүүлэх	2002	-	2.0	-	-	2.0	Төвлөрсөн төсөв	БОЯ, ХНХУХА
		Орон нутгийн аж ахуйн нэгж, байгууллага, ажил олгогч нарын богино хугацааны сургалт зохион байгуулах	2001-2004	31.0	31.0	31.0	31.0	124.0	Орон нутгийн төсөв	Засаг дарга нар
16	32	Аж ахуйн нэгж, байгууллагыг 2 үе шаттайгаар аттестатчилах ажлыг улсын хэмжээнд зохион байгуулах	2002-2004	-	10.0	-	5.0	15.0	Төвлөрсөн төсөв	НХХЯ, ХНХУХА
		ДҮН	-	63.0	246.5	111.5	101.0	522.0		

Үүнээс :

Төвлөрсөн төсөв	7.0	81.5	60.5	31.0	180.0
Орон нутгийн төсөв	31.0	62.0	31.0	62.0	186.0
ОУХБ-ын хөрөнгө	25.0	103.0	20.0	8.0	156.0

ТАЙЛБАР : Аймаг, нийслэл, дүүргийн төсөвт 2001, 2003 онуудад тус бүр 1 сая төгрөг, 2002, 2004 онуудад тус бүр 2 сая төгрөг тусгах шаардлагатай.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 7 дугаар сарын 4-ний өдөр | Дугаар 154 | Улаанбаатар хот

"НИК" хувьцаат компанийн талаар авах зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "НИК" ХК-ийн хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор удирдлага, зохион байгуулалтыг боловсронгуй болгон сайжруулах, орон тоо, зардлыг хэмнэх, өр авлагыг шуурхай барагдуулах, хариуцлага тооцох чиглэлээр тодорхой арга хэмжээг 2001 оны 7 дугаар сарын эхний хагаст багтаан авч хэрэгжүүлэхийг Үйлдвэр, худалдааны сайд Ч.Ганзориг болон Төрийн өмчийн хороо (Л.ПҮРЭВДОРЖ)-нд даалгасугай.

2. Тус компанийн нефтийн бүтээгдэхүүний татан авалт, нийлүүлэлт, борлуулалтын үйл ажиллагааг тогтворжуулан хөдөө орон нутгийг шатахуунаар тасралтгүй хангах арга хэмжээ авахыг Үйлдвэр, худалдааны сайд Ч.Ганзоригт даалгасугай.

3. "НИК" ХК-ийн улсын төсөвт төлөх нефтийн бүтээгдэхүүний нэмэгдсэн өртгийн албан татвар болон онцгой албан татвар, улсын төсөвт төлөх төлбөрийг яаралтай барагдуулах талаар тодорхой арга хэмжээ авч энэ оны 8 дугаар сард Засгийн газарт танилцуулахыг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаан, Улсын гаалийн ерөнхий газрын дарга Х.Баатар болон Төрийн өмчийн хороо (Л.ПҮРЭВДОРЖ)-нд даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

ҮЙЛДВЭР, ХУДАЛДААНЫ САЙД **Ч.ГАНЗОРИГ**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 7 дугаар сарын 4-ний өдөр | Дугаар 156 | Улаанбаатар хот

Засгийн газрын хүндэт өргөмжлөлөөр шагнах тухай

Монгол Улсын Засгийн газраас ойр тохиолдуулан дор дурдсан хүмүүсийг Монгол Улсын Засгийн газрын Хүндэт өргөмжлөлөөр шагнасугай:

ТОГТООХ нь:

Монгол Ардын хувьсгалын 80 жилийн

1.	Жамбалсүрэнгийн Нарантуяа	-Улсын Их Хурлын Тамгын газрын нэгдүгээр нарийн бичгийн дарга;
2.	Шилаагарьдын Солонго	-Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын хуулийн хэлтсийн дарга;
3.	Цэсэдийн Банзрагч	-Байгаль орчныг хамгаалах албаны дарга;
4.	Аюушжавын Баасанжав	-Үйлдвэр, худалдааны яамны ахлах мэргэжилтэн;
5.	Баатарын Цэвээн	-Хууль зүй, дотоод хэргийн яамны мэргэжилтэн;
6.	Баавгайн Хүрэнбаатар	-Европын холбооны ТАСИС хөтөлберийн зохицуулах товчооны гүйцэтгэх захирал;
7.	Цэнд-Аюушийн Чулуунцэцэг	-Хөдөлмөр, нийгмийн хамгаллын хяналтын улсын албаны ахлах эдийн засагч-нягтлан бодогч;
8.	Бизъяагийн Тогоо	-Баянгол дүүргийн 19 дүгээр хорооны Засаг дарга;
9.	Доржнамжилын Янжинлхам	-Багануур дүүргийн боловсрол цогцолборын гадаад хэлний тэнхмийн эрхлэгч;
10.	Нямцэрэнгийн Чулуунбат	-Өмнөговь аймгийн нийтийн аж ахуйн "Гүний ус" үйлдвэрийн ажилчин;
11.	Түвдэнгийн Данзанлхагва	-Ховд аймгийн Чандмань сумын хүн эмнэлгийн их эмч;
12.	Лувсангийн Баярхүү	-Увс аймгийн Баруунтуруун сумын "Амьд баялаг" хоршоонд нягтлан;
13.	Цэвээндоржийн Ганболд	-Зэвсэгт хүчний 026 дугаар ангид жолооч;
14.	Хорлоогийн Цэвлээ	-Сэтгүүлч;
15.	Жамбалжавын Будрагчаа	-Хөвсгөл аймгийн Цагаан-уул сумын малчин.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

ЗАСГИЙН ГАЗРЫН ГИШҮҮН, ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА **Ө.ЭНХТҮВШИН**

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Хаяг: «Төрийн мэдээлэл» эмхтгэлийн зөвлөл

Улаанбаатар-12 ☎ 329612
Төрийн ордон Индекс 14003

Улсын Их Хурлын Тамгын газрын Хэвлэх хэсэгт хэвлэв.

☎ 329487



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 37 (224)

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ:

- *"Говь" хувьцаат компанийн нийт хувьцааны төрийн эзэмшлийн хувьцааг худалдах тухай*
- *Тогтоолд өөрчлөлт оруулах тухай*
- *Хөрөнгө гаргах тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар

Улаанбаатар хот
2001 он

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот 2001 оны есдүгээр сарын 22 №37 (224)

Гарчиг

Нэг. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

437. "Говь" хувьцаат компанийн нийт хувьцааны төрийн эзэмшлийн хувьцааг худалдах тухай Дугаар 155 905

438. Тогтоолд өөрчлөлт оруулах тухай Дугаар 159 920

439. Хөрөнгө гаргах тухай Дугаар 161 920

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 7 дугаар сарын 4-ний өдөр **Дугаар 155** **Улаанбаатар хот**

"Говь" хувьцаат компанийн нийт хувьцааны төрийн эзэмшлийн хувьцааг худалдах тухай

Төрийн өмчийг 2001-2004 онд хувьчлах үндсэн чиглэл, Төрийн өмчийг 2001 онд хувьчлах хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 46-54 дүгээр зүйлийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Говь" ХК-ийн нийт хувьцааны төрийн эзэмшлийн 70 хувьд ногдох 5,460,788 ширхэг хувьцааг худалдах "Уралдаант шалгаруулалт /тендер/-ын зар мэдээ"-г 1 дүгээр, "Уралдаант шалгаруулалт /тендер/-ын журам"-ыг хоёрдугаар хавсралт ёсоор тус тус батлсугай.

2. "Говь" ХК-ийн нийт хувьцааны төрийн эзэмшлийн 70 хувьд ногдох 5,460,788 ширхэг хувьцааг худалдах доод үнийг 18500000 (арван найман сая таван зуун мянган) ам.доллараар тогтоосугай.

3. Төрийн өмчийн хороо /Л.ПҮРЭВДОРЖ/-нд даалгах нь:

а/"Говь" ХК-ийн нийт хувьцааны төрийн эзэмшлийн 70 хувьд ногдох 5,460,788 ширхэг хувьцааг худалдах "Уралдаант шалгаруулалт /тендер/-ын зар мэдээ"-г дотоод, гадаадын хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлж ажилласугай;

б/"Говь" ХК-ийн нийт хувьцааны төрийн эзэмшлийн 70 хувьд ногдох 5,460,788 ширхэг хувьцааг худалдах уралдаант шалгаруулалтыг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, "Уралдаант шалгаруулалт /тендер/-ын журам"-ын дагуу зохион байгуулан явуулсугай;

в/"Говь" ХК-ийн нийт хувьцааны төрийн эзэмшлийн 70 хувьд ногдох 5,460,788 ширхэг хувьцааг худалдах уралдаант шалгаруулалт /тендер/-д ялсан худалдан авагчтай "Уралдаант шалгаруулалтын журам"-д заасан болзол, нөхцөлийн талаар харилцан тохиролцож, Хувьцаа худалдах, худалдан авах тухай гэрээ байгуулахыг зөвшөөрсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН САЙД **Ч.УЛААН**

Засгийн газрын 2001 оны 155 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР ТӨРИЙН ӨМЧИЙН ХОРОО УРАЛДААНТ ШАЛГАРУУЛАЛТ /ТЕНДЕР/-ЫН ЗАР МЭДЭЭ

Монгол Улсын Их Хурлын 2001 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 10 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн өмчийг 2001-2004 онд хувьчлах үндсэн чиглэл", Засгийн газрын 2001 оны 2 дугаар сарын 20-ны өдрийн 35 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн өмчийг 2001 онд хувьчлах хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд ноолууран бүтээгдэхүүний үйлдвэрлэл, борлуулалт эрхэлдэг "Говь" ХК /цаашид "Говь" буюу "компани" гэх/ ийн нийт хувьцааны төрийн эзэмшлийн 70 хувьд ногдох 5,460,788 ширхэг энгийн хувьцааг уралдаант шалгаруулалт /цаашид "тендер" гэх/-ын аргаар хувьчлах үйл ажиллагаанд оролцохыг өмөл, сүлжмэл эдлэл, бэлэн хувцасны үйлдвэрлэлийн салбар дахь стратегийн хөрөнгө оруулагчдад Монгол Улсын Засгийн газраас урьж байна. "Говь" ХК нь ноолууран эдлэл, бэлэн бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрхэлдэг Монгол Улсын хамгийн том компани бөгөөд ноолуурын салбар дахь дэлхийн томоохон компанийн нэг юм.

Тендерийг Монгол Улсын Засгийн газрын 2001 оны 155 дугаар тогтоолоор батлагдсан "Уралдаант шалгаруулалт /тендер/-ын журам"-д тусгагдсан нөхцөл, болзлын дагуу Төрийн өмчийн хороо /цаашид "ТӨХ" гэх/ зохион байгуулж дүгнэнэ. Засгийн газрын шийдвэрээр компанийн нийт хувьцааны 70 хувийг худалдах доод үнийг 18 500 000 /арван найман сая таван зуун мянган/ ам. доллараар тогтоов.

"Говь" ХК-ийг хувьчлах ажилд Монгол Улсын Засгийн газраас АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлагтай байгуулсан гэрээний дагуу КПМЖ консалтинг ХК-ийн харьяа Баренц Булэг Төрийн өмчийн хороонд зөвлөхөөр ажиллаж байгаа болно.

Тендерт оролцох сонирхлоо илэрхийлэх

Тендерийн зар мэдээ гарсны дараа тендерт оролцох хүсэлтэй эттэзд /цаашид "өргөдөл гаргагч" гэх/ нь сонирхлоо илэрхийлсэн албан ёсны захидлыг дараахь материалын хамт ТӨХ-нд ирүүлнэ. Үүнд:

1. Өргөдөл;

2. Өргөдөл гаргагчийг төлөөлөх эрх бүхий этгээдийн гарын үсэг зурсан нууцыг хадгалах тухай гэрээ;

3. Буцааж төлөгдөхгүй нөхцөлтэй 1,000 ам. долларын тендерийн хураамж төлснийг нотлох баримт;

4. Итгэмжлэгдсэн төлөөлөгчийг томилсон тохиолдолд түүнд зохих журмын дагуу олгосон итгэмжлэл;

5. Өргөдөл гаргагчийн танилцуулга:

· Өргөдөл гаргагчийн бизнесийн үйл ажиллагааны чиглэл болон компанийн бүтэц, оёмол, сүлжмэл эдлэл, бэлэн хувцасны үйлдвэрлэлийн салбарын үйл ажиллагаа /консорциумаар оролцож байгаа тохиолдолд хамтарч буй компаниудын үйл ажиллагаа/-ны болон өндөр хөгжилтэй гадаадын орнууд дахь борлуулалтын сүлжээний талаар дэлгэрэнгүй танилцуулга;

· Өргөдөл гаргагчийн дэлгэрэнгүй бүтцийг дараахь байдлаар ангилан гаргана: 1/хувийн байгууллага, 2/хувь хүн, 3/төрийн бүюу ямар нэгэн төрийн оролцоотой байгууллага, 4/ улсын төсөөс санхүүждэг төрийн бус байгууллага. Нийт гаргасан хувьцааны тавааc дээш хувийг эзэмшиж буй хувьцаа эзэмшигчдийн жагсаалтыг эзэмшиж буй хувьцааны хэмжээг тодорхой зааж гаргана;

· Сүүлчийн жилийн эцсийн байдлаар гаргаж аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан тэнцэл /нээлттэй компанийн хувьд хувьцаа эзэмшигчдэд зориулсан жилийн тайлан/;

· Тендерт оролцохыг зөвшөөрч өргөдөл гаргагчийн удирдах байгууллагаас гаргасан шийдвэр, тендерт консорциумын хэлбэрээр оролцох тохиолдолд консорциумын гишүүдийн хооронд байгуулсан гэрээ;

· Тендерт оролцож байгаа компани / компаниуд/-ийг үүсгэн байгуулж буртгүүлсэн тухай (тухайн компанийн хууль эрх зүйн орчны хувьд түгээмэл) баримт бичгүүд;

Банкны тодорхойлолт.

Өргөдөл болон нууцыг хадгалах тухай гэрээний загварыг энэхүү зар мэдээний ард бичигдсэн хаягаар буюу Төрийн өмчийн хорооны www.spc.gov.mn вэб хуудаснаас авч болно. Тендерийн хураамжийг Монгол Улсын Монгол банк дахь Төрийн өмчийн хорооны 3332404 дүгээр дансанд төлнө.

Хуулийн этгээд дангараа, эсвэл хамтарч консорциумын хэлбэрээр тендерт оролцож болно.

Өргөдөл гаргагч тендерт өөрийгөө төлөөлүүлэн оролцуулахаар итгэмжлэгдсэн төлөөлөгч томилж, төлөөлөх эрхийг зохих журмын дагуу бичгээр үйлдсэн итгэмжлэлээр нотолно.

Тендерт хэд хэдэн хуулийн этгээд хамтарч консорциумын хэлбэрээр оролцож байгаа бол тэд зөвхөн нэг итгэмжлэгдсэн төлөөлөгчийг томилж, тендерт нэг оролцогч болж оролцоно.

Тендерт оролцох хүсэлтээ илэрхийлсэн захидлаа 2001 оны 8 дугаар сарын 31-ний өдрийн (Улаанбаатарын цагаар) 18.00 цагаас өмнө Төрийн өмчийн хороонд ирүүлнэ.

Урьдчилан шалгаруулах шалгуур

Тендерт оролцох эрхтэй болж тендерийн баримт бичгүүдийг авахын тулд өргөдөл гаргагч дараахь шаардлагыг хангасан байвал зохино. Үүнд:

1. Тендерт оролцогч нь оёмол, сүлжмэл эдлэл, бэлэн хувцасны үйлдвэрлэлийн салбарт үйл ажиллагаагаа амжилттай эрхлэн явуулж байгаа компанийг зээмшиж, тодорхой амжилтад хүрсэн туршлагатай стратегийн хөрөнгө оруулагч байх;

2. Хөгжилтэй орнуудын зах зээлийн өндөр үр ашигтай борлуулалтын сүлжээнд нэвтрэх чадварыг батлах баримттай байх;

3. 50 /тавин/ сая ам. доллараас доошгүй өөрийн хөрөнгөтэй байх;

4. 100 хувь хувийн өмчийн этгээд байх.

Монголын болон гадаад улсын дор дурдсан хуулийн этгээд тендерт оролцохыг хориглоно:

1. Төрийн байгууллага;

2. Төрийн өмчит үйлдвэрийн газар;

3. Улсын төсвөөс санхүүждэг албан газар;

4. Төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж;

5. Улсын төсвөөс санхүүждэг төрийн бус байгууллага.

Урьдчилан шалгаруулалтын үр дүнг мэдээлэх

Төрийн өмчийн хороо өргөдөл хүлээн авснаас хойш ажлын арван өдөрт багтаан урьдчилсан шалгаруулалтын шалгуурыг ханган тендерт оролцох эрхтэй болж тендерийн баримт бичгүүдийг авах болсон эсэх талаар өргөдөл гаргагчид мэдэгдэнэ. Энэхүү мэдэгдлийг буухиа шуудан, баталгаат шуудангаар өргөдөлд заасан хаягаар явуулна.

Урьдчилсан шалгаруулалтын шалгуурыг хангасан тендерт оролцогчдод тендерийн баримт бичгүүдийг мэдэгдлийн хамт хүргүүлнэ.

Тендерийн баримт бичгүүд

Тендерийн баримт бичгүүд гэдэгт:

1) Уралдаант шалгаруулалт /тендер/-ын журэм;

2) Ерөнхий мэдээлэл;

3) Хувьцаа худалдах, худалдан авах тухай гэрээний төслийн иж бүрдлийг ойлгоно.

Худалдах нөхцөл

Говь ХК-ийн хувьцааны 70 хувийг худалдахад Засгийн газраас тавих нөхцөл:

а) худалдан авагч нь оёмол, сүлжмэл эдлэл, бэлэн хувцасны үйлдвэрлэлийн салбарт үйл ажиллагаагаа амжилттай эрхлэн явуулж байгаа компанийг зээмшиж, тодорхой амжилтад хүрсэн туршлагатай, хөгжингүй орнуудын зах зээлийн чамин тансаг эд хэрэглэгчдэд хүрсэн борлуулалтын сүлжээнд нэвтрэх чадвартай байх бөгөөд орчин үеийн удирдлага, маркетинг, технологийн ноу хауг нэвтрүүлэх замаар "Говь" ХК-ийн өрсөлдөх чадварыг дээшлүүлж, санхүүгийн болон үйл ажиллагааны үр дүнг сайжруулах чадвартайгаа нотолсон байх;

б) худалдан авагч нь компанийн бизнесийн үндсэн чиглэл, Монгол Улсын ноос, ноолууран

бүтээгдэхүүний тэргүүний үйлдвэрлэгч болохын хувьд урьд өмнө зах зээлд эзэлж байсан байр суурийг хадгалах, сайжруулахаа баталж байх;

в) худалдан авагч нь "Говь" ХК-ийн өндөр үнэ цэнэтэй, дээд зэрэглэлийн эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлтийг өргөтгөж, иймбүтээгдэхүүнийг чамин тансаг эд хэрэглэгчдэд хүргэж, бүтээгдэхүүн борлуулах хэмжээг нэмэгдүүлэхээ батлах;

г) компанийн үйлдвэрлэл, техникийн хүчин чадлыг нэмэгдүүлж, компанийн маркетинг, хуваарилалт болон олон улсын зах зээл дэх өрсөлдөх чадварыг дэзшлүүлэх тодорхой хэмжээний хөрөнгө оруулалтыг өмчлөл шилжсэнээс хойшхи эхний хоёр жилийн дотор нэн даруй хийх баталгаа гаргах.

Тендерийн ажиллагаа

Тендерт оролцогчид техникийн болон санхүүгийн саналаас бүрдэх тендерийн саналаа Төрийн өмчийн хороонд 2001 оны 10 дугаар сарын 8-ны өдрийн (Улаанбаатарын цагаар) 18.00 цагаас өмнө тендерийн дэнчин төлсний нотлох баримтын хамт ирүүлнэ.

Тендерийн дэнчин гэж хувьцаа худалдах, худалдан авах тухай гэрээг байгуулах чадвар, санхүүгийн эх үүсвэрийн баталгаа болгон тендерт оролцогчоос төлөх 100 000 (нэг зуун мянган) ам. доллартай тэнцэх хүүгүй мөнгөн хадгаламж эсвэл Төрийн өмчийн хорооны нэр дээр гаргасан буцалтгүй аккредитивийг хэлнэ. Тендерт оролцогчид дэнчинг Монгол Улсын "Монгол банк" дахь Төрийн өмчийн хорооны 3332404 дүгээр дансанд байршуулна.

Тендерийн саналыг үнэлсний дараа тендерт оролцогч алагчаар шалгараагүй тохиолдолд тендерийн дэнчинг /дэнчинг шилжүүлэх банкны дансны дугаарыг тодорхой заасан/ тендерт оролцогчийн хүсэлтийн дагуу ажлын долоо хоногт багтаан бүрэн буцаан олгоно.

Тендерт ялагчаар шалгарсан оролцогчийн дэнчинг худалдан авах үнэд оролцуулан тооцно.

Тендерийн саналаа бэлтгэхэд нь туслах зорилгоор тендерт оролцогчдыг Засгийн газрын холбогдох албан тушаалтан болон компанийн удирдлагатай уулзах, газар дээр нь танилцах бололцоогоор хангана. Тендерт оролцогчдыг хувьцаа худалдах, худалдан авах тухай гэрээнийтөсөлд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай санал гаргах бололцоогоор хангана.

Техникийн саналыг дор дурдсан үзүүлэлтүүдээр шалгаруулна:

1. Тухайн салбарт үйл ажиллагаа явуулж ирсэн туршлага болон түүхэн замнал (0-40 оноо);

2. Санал болгож байгаа бизнесийн төлөвлөгөөний чанар, Засгийн газраас тавих нөхцөлүүдийг хүлээн авч тусгасан байдал (0-40 оноо);

3. Байгаль орчны бохирдлыг арилгах, байгаль орчныг хамгаалах эрмэлзэл (0-10 оноо);

4. Хүний нөөцийг хөгжүүлэх болон хөдөлмөр эрхлэлтийн төлөвлөгөө (0-10 оноо).

Нийлбэр дүнгээр 70-аас доошгүй оноо авсан оролцогчийн техникийн саналыг хүлээн авна.

Санхүүгийн санал нь хувьцаа худалдан авах үнэ, өмчлөл шилжсэнээс хойшхи эхний хоёр жилийн хугацаанд компанид нэн даруй оруулахаар амласан хөрөнгө оруулалтын хэмжээнээс бүрдэх бөгөөд дараахь байдлаар үнэлэгдэнэ:

1) Санал болгож байгаа худалдан авах үнийн дүнгийн ам. доллар бүрт нэг оноо;

2) Нэн даруй хийх хөрөнгө оруулалтын дүнгийн ам. доллар бүрт 0.75 оноо;

3) Эцсийн оноо нь худалдан авах үнэ болон нэн даруй оруулах хөрөнгө оруулалтын хэмжээнд тус тус ногдуулсан онооны нийлбэртэй тэнцэнэ.

Санхүүгийн саналын үнэлгээгээр хамгийн өндөр оноо авсан оролцогчийг тендерийн ялагчаар шалгаруулна.

"Говь" ХК-ийн тухай

1976 онд UNIDO-ийн тусламжтайгаар "Самнасан ямааны ноолуур, тэмээний ноос боловсруулах туршилтын үйлдвэр" байгуулагдсан нь одоогийн "Говь" компани байгуулагдах эхлэл болсон юм. "Говь" компанийн гол үйлдвэр нь Японы эдийн засаг, техникийн тусламжтайгаар 1981 онд баригдсан.

1993 онд "Говь" компани нь 100.00 төгрөгийн нэг бүрийн нэрлэсэн үнэтэй 7,801,125 ширхэг

хувьцаанаас бүрдсэн хувьцаат компани болж өөрчлөн байгуулагджээ. Үүнээс 5,843,681 ширхэг буюу нийт хувьцааны 74.9 хувь нь Засгийн газрын өмчлөлд байгаа юм. Нийт хувьцааны 25.1 хувь буюу үлдэх 1,957,444 ширхэг хувьцаа нь хувьчлагдсан бөгөөд Монголын хөрөнгийн биржээр арилжаалагдаж байна. Нэгж хувьцааны жилийн дундаж үнэ нь 1999 онд 1040.29 төгрөг, 2000 онд 1071.15 төгрөг байв.

"Говь" компани нь самнасан ноолуур, ноолууран бэлэн сүлжмэл, нэхмэл, ээрмэл бүтээгдэхүүн үйлдвэрлэн борлуулахаас гадна тэмээний ноос, сарлагийн хөөвөр боловсруулдаг. Жилдээ 1,000 тонн түүхий ноолуур, ноос боловсруулж, 30 тонн бөмбөгөн ноолуур, 210 тонн самнасан ноолуур, 350,000 ширхэг сүлжмэл болон 153,000 урташ метр нэхмэл бүтээгдэхүүн үйлдвэрлэх хүчин чадалтай.

"Говь" компани нийт 1941 ажилчинтай.

Компани нь дэлхийн өндөр чанартай түүхий ноолуур бэлтгэлийн 2 дахь томоохон зах зээлд оршдог. Дэлхийн нийт түүхий ноолуурын 21 хувийг Монгол, үлдэх хэсгийг БНХАУ (67%), Иран, Афганистан, Албани, ОХУ зэрэг орнуудад бэлтгэдэг юм. Компани нь ноолуурыг малчдын гар дээрээс шууд худалдан авдаг, монгол орон даяар тархсан 17 төлөөлөгчийн газар бүхий өргөн сүлжээтэй. Компани 2000 онд 623.7 тонн түүхий эд бэлтгэснээс 381.7 тонн нь ноолуур, 198.8 тонн нь тэмээний ноос, 43.1 тонн нь хонины ноос, сарлагийн хөөвөр байв.

Компанийн үйлдвэрлэл нь Улаанбаатар хотод, үйлдвэрийн 2 хэсэгт төвлөрдөг. Нийслэлийн газрын албатай байгуулсан газар ашиглах тухай гэрээ ёсоор компани нийт 129,316 квадрат метр газрыг ашиглаж газар ашигласны түрээсийн төлбөрт жилдээ 9,244,488 төгрөг төлдөг.

"Говь" компанийн үйлдвэрлэлийн хүчин чадал нь "Говь", "Говь-2" гэсэн 2 үйлдвэр дээр төвлөрсөн. Ноолуурын анхан шатны боловсруулалт болон ээрмэл, бэлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт нь уг 2 үйлдвэрт явагддаг боловч ноолуурын анхан шатны боловсруулалтыг гагцхүү "Говь" үйлдвэр дээр гүйцэтгэдэг юм. Компанийн ноолуурын үйлдвэрлэл нь дараахь шат дамжлагуудаас бүрдэнэ:

§ Анхан шатны боловсруулалт-ангилан ялгах, угаах, хялгас ялгах;

§ Будүүн ээрмэлийн шугам-будах, холих, аппарат самнах, ээрэх, эрчлэх, ороох;

§ Нарийн ээрмэлийн шугам-хувинт самнах, туузлах, нарийн зүүн самнах, нарийсган сунгах, нарийн самнах, ээрэх, эрчлэх, ороох;

§ Бэлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх-сүлжих, оёх, нэхэх, эцсийн боловсруулалт хийх.

1995 онд компани үйлдвэрийн шат дамжлагуудын ажиллагаа, тэдгээрээс гарах бүтээгдэхүүнийг ISO-9000 чанарын стандартын дагуу хянах 3 лабораторийг үйлдвэрлэлд нэвтрүүлсэн.

Компани нь бүтээгдэхүүнээ Европ, Ази, Америкийн 22 орны 90 орчим компаниудад борлуулдаг. 2000 оны байдлаар нийт бүтээгдэхүүний 90.8 хувийг Их Британи, Япон, Франц, Макао, Бельги, Герман, АНУ зэрэг улсуудад экспортолсон. Компанийн экспортын гол бүтээгдэхүүн нь самнасан ноолуур ба ноолууран ээрмэл юм. Эдгээр бүтээгдэхүүн нь компанийн 2000 оны нийт экспортын 53.9 хувийг эзэлж байжээ. Экспортын үлдсэн хэсгийг сүлжмэл эдлэл, хөнжил, ноолууран даавуу голлон бүрдүүлж байна. Компанийн гадаад дахь томоохон харилцагчдын тоонд Их Британий Z.Hinchliffe & Sons Ltd., Seal International Ltd., Францын Safico-2, Бельгийн Gobi-Europa S.A., Германы Cashmere products Gmbh (хуучин нэрээр Oriental Pacific), Макаогийн Talent Hill International Ltd., Японы Altai Co., Ltd, Onoda Co., Ltd болон Yamaki Trading Co., Ltd, АНУ-ын Safico-USA, Энэтхэгийн SAS International зэрэг компаниуд ордог.

1997 онд Бельги улсын United cashmere S.P.A-тай хамтран байгуулсан "Говь-Европ" компанийн 75 хувийг "Говь" компани эзэмшдэг. Мөн 1998 онд "Говь-АНУ" компанийг АНУ-д байгуулсан байна.

2000 оны тайлан тэнцлийн үзүүлэлтээр компани нь нийт 20.7 сая ам. долларын борлуулалт хийж, 3.9 сая ам. долларын үйл ажиллагааны ашиг, 2.4 сая ам. долларын цэвэр ашигтай ажилласан байна.

Санхүүгийн тайлан тэнцлийн үзүүлэлтүүд:

БАЛАНС
(мян.төгрөгөөр)

12 дугаар сарын 31-ний байдлаар	1998	1999	2000
Эргэлтийн хөрөнгө			
Мөнгөн хөрөнгө	765 506	6 388 116	1 557 737
Авлага	4 443 426	3 784 259	3 297 491
Бараа материал	10 593 492	7 558 161	12 878 018
Урьдчилгаа	0	106 093	0
Эргэлтийн хөрөнгийн дүн	**15 802 424**	**17 836 629**	**17 733 246**
Эргэлтийн бус хөрөнгө			
Үндсэн хөрөнгө	11 738 360	11 004 261	14 726 140
Хөрөнгө оруулалт	1 569 981	909 492	896 908
Биет бус хөрөнгө	0	409 011	442 863
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	**13 308 342**	**12 322 764**	**16 065 911**
Нийт хөрөнгө	**29 110 766**	**30 159 394**	**33 799 157**
Богино хугацаат өр төлбөр			
Өглөг	1 245 358	784 796	447 157
Богино хугацаат зээлийн өглөг	0	0	0
Ногдол ашгийн өглөг	122 115	76 273	179 489
Богино хугацаат өр төлбөрийн дүн	**1 367 473**	**861 070**	**626 646**
Урт хугацаат өр төлбөр	**0**	**0**	**0**
Өр төлбөрийн дүн	**1 367 473**	**861 070**	**626 646**
Эзэмшигчийн өмч			
Хувьцаа	780 113	780 113	780 113
Дахин үнэлгээний зөрүү	6 885 220	6 306 948	9 169 679
Хуримтлагдсан ашиг	20 077 960	22 211 264	23 222 719
Эзэмшигчийн өмчийн дүн	**27 743 293**	**29 298 324**	**33 172 510**
Өр төлбөр ба эзэмшигчдийн өмчийн дүн	**29 110 766**	**30 159 394**	**33 799 157**

ОРЛОГО, ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН
(мян. төгрөгөөр)

12 дугаар сарын 31-ний байдлаар	1998	1999	2000
Борлуулалтын орлого	**16 267 613**	**23 367 017**	**21 922 279**
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	10 402 887	17 069 997	17 050 609
Нийт ашиг	**5 864 726**	**6 297 020**	**4 871 671**
Үйл ажиллагааны зардал	949 822	1 062 556	988 696
Бусад орлого	188 310	0	0
Үйл ажиллагааны орлого	**5 103 214**	**5 234 464**	**3 882 975**
Үйл ажиллагааны бус орлого	370 460	1 892 811	1 477 336
Үйл ажиллагааны бус зардал	463 505	160 196	1 132 599
Татвар төлөхийн өмнөх ашиг	**5 010 169**	**6 967 079**	**4 227 712**
Орлогын татвар	2 004 068	2 761 832	1 666 085
Цэвэр ашиг	**3 006 102**	**4 205 247**	**2 561 627**

Тендерт оролцох албан ёсны захидал болон тендерийн саналуудыг дараахь хаягаар ирүүлнэ:
Л.Пүрэвдорж
Төрийн өмчийн хорооны дарга
Засгийн газрын 4-р байр, 408 тоот өрөө
Улаанбаатар-11, Монгол Улс
Утас: 976-11-312460
Факс: 976-11-312798

Нэмэлт мэдээллийн талаар Төрийн өмчийн хорооны дээр дурдсан хаягаар болон Төрийн өмчийн хорооны зөвлөх КПМЖ Консалтинг ХК-ийн Баренц бүлэгт дараахь хаягуудаар хандана уу:

Даниела Стефанова
Зөвлөх
E-mail: daniela.stefanova@usa.net

Живко Ненов
Тєслийн удирдагч
E-mail: znenov@magicnet.mn

Мелисса Данн
Тєслийн дэд удирдагч
E-mail: mdunn@kpmg.com

Хаяг:
КПМЖ консалтинг ХК-ийн Баренц бүлэг
Төрийн өмчийн 1-р байр, 301 тоот өрөө
Улаанбаатар-38
Монгол Улс
Утас: 976-11-324149
Факс: 976-11-324149
Электрон шуудан: barents@magicnet.mn

Эсвэл
Teresa Slazas
Barents Group of KPMG Consulting, Inc
1676 International Drive
McLean, VA 22102, USA
Tel: +1 703-747-7698
Fax: +1 703-747-3919
E-mail: tslazas@kpmg.com

Компанитай холбоотой дэлгэрэнгүй мэдээллийг http://www.spc.gov.mn вэбсайтаас үзнэ үү.

Засгийн газрын 2001 оны 155 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

УРАЛДААНТ ШАЛГАРУУЛАЛТ (ТЕНДЕР)-ЫН ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Монгол Улсын Иргэний хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Монгол Улсын Их Хурлын 2001 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 10 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн өмчийг 2001-2004 онд хувьчлах үндсэн чиглэл", Засгийн газрын 2001 оны 2 дугаар сарын 20-ны өдрийн 35 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн өмчийг 2001 онд хувьчлах хөтөлбөр"-ийн дагуу "Говь" ХК /цашид "компани" гэх/-ийн нийт хувьцааны төрийн эзэмшлийн 70 хувьд ногдох

5,460,788 ширхэг энгийн хувьцааг уралдаант шалгаруулалт /тендер/-ын аргаар оёмол, сүлжмэл эдлэл, бэлэн хувцасны үйлдвэрлэлийн салбарын стратегийн хөрөнгө оруулагчид худалдахад энэхүү журам /цаашид "журам" гэх/-ыг мөрдөнө.

1.2 Төрийн өмчийн хороо нь зөвлөхүүдийн туслалцаатайгаар тендерийг зохион байгуулж явуулна.

Хоёр. Нэр томъёоны тодорхойлолт

Энэхүү журамд хэрэглэсэн нэр томъёог дор дурдсанаар тодорхойлно:

2.1 "Компани" гэж "Говь" ХК-ийг хэлнэ.

2.2 "Оёмол, сүлжмэл эдлэл, бэлэн хувцасны үйлдвэрлэлийн салбарын стратегийн хөрөнгө оруулагч" гэж оёмол, сүлжмэл эдлэл, бэлэн хувцасны үйлдвэрлэлийн салбарт үйл ажиллагаагаа амжилттай эрхлэн явуулж байгаа компанийг эзэмшиж, тодорхой амжилтад хүрсэн байхын зэрэгцүэ өндөр үр ашигтай борлуулалтын сүлжээтэй, орчин үеийн удирдлага, маркетинг, технологийн ноу хаут нэвтрүүлэх замаар "Говь" ХК-ийн өрсөлдөх чадварыг дээшлүүлж, санхүүгийн болон үйл ажиллагааны үр дүнг сайжруулах чадвартай хөрөнгө оруулагч, эсвэл тухайн салбарын стратегийн хөрөнгө оруулагчаар толгойлуулсан консорциумыг хэлнэ.

2.3 "Ерөнхий мэдээлэл" гэж тендерт оролцогч түс бүрт хүргэх "Говь" ХК болон Монгол Улс, түүний бизнесийн орчны талаарх мэдээллийг баримт бичгийг хэлнэ.

2.4 "Дэнчин" гэж хувьцаа худалдах, худалдан авах тухай гэрээг байгуулах чадвар, санхүүгийн эх үүсвэрийн баталгаа болгон тендерт оролцогчоос төлөх 100,000 /нэг зуун мянган/ ам. доллартай тэнцэх хүүгүй мөнгөн хадгаламж эсвэл Төрийн өмчийн хорооны нэр дээр гаргасан буцалтгүй аккредитивийг хэлнэ.

2.5 "Зар мэдээ" гэж Төрийн өмчийн хорооноос тендер явуулах тухай нийтэд сонордуулсан албан ёсны зар мэдээллийг хэлнэ.

2.6 "Зөвлөх" гэж Америкийн Нэгдсэн Улсын Олон улсын хөгжлийн агентлагийн тусламжтайгаар Төрийн өмчийн хороонд зөвлөх үйлчилгээ үзүүлж буй КПМЖ Консалтинг ХК-ийн Баренц бүлгийн зөвлөх /зөвлөхүүд/-ийг хэлнэ.

2.7 "Нууцыг хадгалах тухай гэрээ" гэж компани, Төрийн өмчийн хороо, Монгол Улсын Засгийн газар болон зөвлөхүүдээс өгсөн компанитай холбоотой аливаа мэдээллийг ямар нэгэн хэлбэрээр тараах болон мэдээлэхийг хориглосон гэрээг хэлнэ.

2.8 "Нэн даруй хийх хөрөнгө оруулалтын хэмжээ" гэж тендерт оролцогчдоос хувьцааны өмчлөл шилжэнээс хойшхи эхний хоёр жилийн дотор компанид оруулахаар амласан бэлэн мөнгө болон зах зээлийн үнээр үнэлэгдэх бусад хэлбэрийн хөрөнгө оруулалтын мөнгөн дүнг хэлнэ.

2.9 "Өргөдөл" гэдэгт тендерт оролцогчоос ирүүлэх бүрэн бөглөсөн өргөдлийн маягт, зохих ёсоор үйлдэгдэж, өргөдөл гаргачийг төлөөлөх эрх бүхий этгээдийн гарын үсэг зурсан нууцыг хадгалах тухай гэрээ болон тендерийн хураамж төлснийг нотлох баримтын иж бүрдлийг ойлгоно. Иттэмжлэгдсэн төлөөлөгчийн төлөөлөх эрхийг зохих журмын дагуу бичгээр үйлдэж өргөдөлд хавсаргасан итгэмжлэхээр нотолсон байна. Өргөдөл гаргач тендерийн оролцогч болохын тулд урьдчилсан шалгаруулалтад шаардагдах өөрийн компанийн болон консорциумын талаархи танилцуулгыг өргөдөлд хавсаргасан байна.

2.10 "Тендерийн баримт бичгүүд" гэдэгт дараахь иж бүрдлийг ойлгоно. Үүнд:

1) Уралдаант шалгаруулалт /тендер/-ын журам,

2) Ерөнхий мэдээлэл,

3) Хувьцаа худалдах, худалдан авах тухай гэрээний төсөл.

2.11 "Тендерт оролцогч" гэж тендерт оролцох өргөдөл гаргаж, урьдчилан шалгаруулалтын шаардлагыг ханган, Төрийн өмчийн хороо өргөдлийг нь хүлээн авсан хуулийн этгээд буюу түүнтэй хамтарсан консорциумыг хэлнэ.

2.12 "Тендерийн санал" гэж оролцогчоос тендерт оролцохоор ирүүлсэн саналыг хэлнэ. Тендерийн санал нь техникийн санал, санхүүгийн санал гэсэн хоёр хэсэгтэй байна.

2.13 "Тендерийн хураамж" гэж тендерийн баримт бичгүүдээр ханган үйлчилгээний хураамж болгон Төрийн өмчийн хороонд оролцогчоос төлөх 1,000 /нэг мянган/ ам. долларын, буцааж төлөгдөхгүй нөхцөлтэй төлбөрийг хэлнэ.

2.14 "Уралдаант шалгаруулалт /цаашид "тендер" гэх/" гэж тендерт оролцогчдоос ялагчийг тодруулан, түүнтэй хувьцаа худалдах, худалдан авах гэрээ байгуулахын тулд ирүүлсэн саналыг нь хянан үзэх үйл ажиллагааг хэлнэ.

2.15 "Хувьцаа худалдах, худалдан авах тухай гэрээний төсөл" гэж Төрийн өмчийн хорооноос санал болгож буй, тендерт оролцогчдын саналыг авахаар хүргүүлэх, хувьцаа худалдах худалдан авах гэрээний төслийн эхний хувилбарыг хэлнэ.

2.16 "Хувьцаа худалдах, худалдан авах тухай гэрээний шинэчилсэн төсөл" гэж хувьцаа худалдах, худалдан авах тухай гэрээний төслийн эхний хувилбарт тендерт оролцогчдын өгсөн саналыг тусгасан шинэчилсэн хувилбарыг хэлнэ.

2.17 "Хувьцаа худалдах, худалдан авах тухай гэрээний эцсийн төсөл" гэж хувьцаа худалдах, худалдан авах тухай гэрээний шинэчилсэн төсөлд тендерт оролцогчдоос оруулахаар санал болгосон нэмэлт, өөрчлөлтөөс хүлээн авч болохуйц саналуудыг тусган Төрийн өмчийн хорооноос эцэслэн бэлтгэж гаргах төслийг хэлнэ.

2.18 "Худалдан авах үнэ" гэж тендерээр худалдагдах компанийн хувьцаат худалдан авахаар тендерт оролцогчоос санал болгож буй үнийн дүнг хэлнэ.

2.19 "Трансферт үнэлгээ" гэж үндэстэн дамнасан корпорацийн салбарууд өөр хоорондоо бараа үйлчилгээгээр гүйлгээ хийхдээ баримталдаг үнийг хэлнэ.

Гурав. Тендерийн хуваарь

3.1 Тендерийг энэхүү журамд хавсаргасан хуваарийн дагуу бэлтгэж, явуулна.

Дөрөв. Тендерт оролцогчийн эрх, үүрэг

4.1 Тендерт оролцогчийн эрх зүйн байдал

4.1.1 Монголын болон гадаад улсын дор дурдсанаас бусад хуулийн этгээд тендерт оролцож болно:

1) Төрийн байгууллага;

2) Төрийн өмчит үйлдвэрийн газар;

3) Улсын төсвөөс санхүүждэг албан газар;

4) Төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж;

5) Улсын төсвөөс санхүүждэг төрийн бус байгууллага.

4.1.2 Хуулийн этгээд дангаараа эсвэл хамтарч консорциумын хэлбэрээр тендерт оролцож болно.

4.1.3 Тендерт оролцогч тендерт төлөөлүүлэн оролцохоор итгэмжлэгдсэн төлөөлөгч томилж, төлөөлөх эрхийг зохих жүрмын дагуу бичгээр үйлдсэн итгэмжлэлээр баталгаажуулна.

4.1.4 Тендерт хэд хэдэн хуулийн этгээд хамтарч консорциумын хэлбэрээр оролцож байгаа бол тэд эвхэн нэг итгэмжлэгдсэн төлөөлөгчийг томилж, тендерт нэг оролцогч болж оролцоно.

4.2 Тендерт оролцогчийн эрх

1) Оролцогч нь тендерт оролцох өргөдлөө ирүүлж, урьдчилан шалгаруулах шалгууруудыг хангаснаар Төрийн өмчийн хорооноос баталж, тэмдэг дарсан тендерийн баримт бичгүүдийн иж бүрдэл нэг хувийг авах эрхээр хангагдана.

2) Оролцогчид дараахь эрх эдэлнэ:

а) Мэдээллийн танхимд тавигдсан мэдээллийг ашиглах;

б) Төрийн өмчийн хорооноос баталсан хуваарийн дагуу компанитай танилцах, дун шинжилгээ хийх, уулзалт зохиох, компанийн удирдлагатай уулзах, барилга байгуулламжийг үзэх;

в) Төрийн өмчийн хорооноос бичгээр зөвшөөрөл авсны үндсэн дээр Монгол Улсын Засгийн газрын ажилтнуудтай уулзах;

г) Энэхүү журам болон тендерийн үйл ажиллагаатай холбогдсон мэдээллийн талаар тайлбар авах зорилгоор Төрийн өмчийн хорооны ажилтнуудтай уулзах;

Тайлбар авах хүсэлтийг англи, монгол хэлний аль нэг дээр үйлдэж Төрийн өмчийн хороонд дараахь хаягаар бичгээр ирүүлнэ.

Л. Пүрэвдорж
Төрийн өмчийн хорооны дарга
Засгийн газрын 4-р байр, 408-р өрөө
Улаанбаатар-11, Монгол Улс
Утас: 976-11-312460
Факс: 976-11-312798

Төрийн өмчийн хороо ирсэн бүх хүсэлтэд бичгээр хариулт өгөх бөгөөд асуулт, хариултын хувийг тендерт оролцогч бүрт тэдний өргөдөл дээр заасан хаягаар хүргүүлнэ. Иймхүү хүргүүлэхдээ буухиа шуудан, баталгаат шуудан, факс эсвэл электрон шуудангаш ашиглана.

Тендерийн санал авах хугацаа дуусахаас ажлын таваас доош өдөрт ирүүлсэн тайлбар авах хүсэлтийг Төрийн өмчийн хороо хүлээж авахгүй байж болно.

д) Монгол Улсын Иргэний хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд заасан бусад эрх эдлэх.

4.3 Тендерт оролцогчийн үүрэг

Оролцогч нь дараахь үүрэгтэй:

1) Өөрийн бизнес, эрх зүй, санхүүгийн байдлын талаар үнэн зөв мэдээлэл өгөх;

2) Тендерт оролцох явцад өөрийн бизнес, эрх зүй, санхүүгийн байдалд гарсан, тендерт оролцоход нь нөлөөлж болзошгүй аливаа материаллаг өөрчлөлтийн талаар Төрийн өмчийн хороонд нэн даруй мэдээлэх;

3) Компанийн хувьцааг худалдан авах талаар тендерийн бусад оролцогчидтой ямар нэгэн харилцаа холбоо болон хэлэлцээрийн аливаа хэлбэрт орохгүй байх;

4) Компанитай байгуулсан буюу байгуулахаар төлөвлөж байгаа бизнесийн аливаа гэрээ, хэлэлцээрийн талаар Төрийн өмчийн хороонд бичгээр мэдэгдэх;

5) Тендерт оролцох буюу оролцохтой холбогдон гарах бүх зардлыг өөрөө хариуцах;

6) Монгол Улсын хууль, тогтоомж болон энэхүү тендерийн журмыг сахин биелүүлэх.

Тав. Тендерийн баримт бичгүүд

5.1 Тендерт оролцогч түс бүрт Улаанбаатар шалгаруулалт /тендер/-ын журам, компанийн талаархи ерөнхий мэдээлэл болон хувьцаа худалдах, худалдан авах тухай гэрээний төслөөс бүрдсэн тендерийн баримт бичгүүдийн нэг иж бүрэн багцыг олгоно.

5.2 Төрийн өмчийн хорооноос олгох тендерийн баримт бичгүүдэд Төрийн өмчийн хорооны тэмдэг дарсан байна.

5.3 Төрийн өмчийн хороо болон зөвлөхүүд тендертэй холбоотой мэдээллийг аль болох бүрэн хэмжээгээр тендерийн баримт бичгүүдэд оруулахыг чармайна. Энэхүү мэдээллийг ашиглахтай холбоотойгоор үүсч болох аливаа үүрэг, хариуцлагыг Төрийн өмчийн хороо болон зөвлөхүүдийн аль аль нь хүлээхгүй.

Зургаа. Дүн шинжилгээ хийх

6.1 Компани болон Засгийн газрын ажилтнуудтай уулзах, компанитай танилцах хүсэлт гаргасан тендерт оролцогчдыг энэ талын бололцоогоор хангана.

6.2 Тендерийн саналаа ирүүлэхээс өмнө тендерт оролцогчыг компани дээр очиж компанийн хөрөнгө, өр төлбөрийн талаар нарийвчилсан дүн шинжилгээ хийх, компанийн хувьчлалын дараахь үйл ажиллагаанд Засгийн газраас тавих шаардлагуудын талаар Засгийн газрын ажилтнууд болон зөвлөхүүдтэй уулзах бололцоогоор хангана. Төрийн өмчийн хороо тендерт оролцогч тус бүрт компани дээр очиж компанийн үйл ажиллагаанд нарийвчилсан дүн шинжилгээ хийх хуваарь гаргаж өгнө. Дүн шинжилгээний хугацаанд тендерт оролцогчид компанийн удирдлага, ажилтнуудтай уулзах өргөн боломжоор хангагдах бөгөөд санхүүгийн болон нягтлан бодох бүртгэлийн баримтууд, компьютерийн систем, конторын болон бусад барилга байгууламжийн байдал, түүнчлэн өөрсдийн сонирхсон хүрээнд аливаа бусад асуудлыг судлан танилцах эрхээр хангагдана.

6.3 Төрийн өмчийн хороо компани дээр очиж дүн шинжилгээ хийх хуваарийг хүсэлт хүлээж авсан дараалалаар гарган, тендерт оролцогчдод энэ тухай факс буюу электрон шуудангаар мэдэгдэнэ.

6.4 Тендерт оролцогч нь тендерийн саналаа ирүүлснээр компанийн байдал, үйл ажиллагаагүй судлан, Төрийн өмчийн хорооноос буюу компанийн талаар гаргаж өгсөн бусад бүх мэдээллийн үнэн зөв болохыг албан ёсоор хүлээн зөвшөөрсөнд тооцогдоно. Байгаа мэдээлэл, тухайн байдалтай танилцаж чадаагүй оролцогчийг тендерийн санал болговсруулах, хувьцаа худалдах, худалдан авах тухай гэрээний төслийг эцэслэх үүргээс чөлөөлөхгүй. Төрийн өмчийн хороо, түүний зөвлөх, компани, эдгээрийн төлөөлөгчдөөс гаргаж өгсөн мэдээлэлд үндэслэн тендерт оролцогчийн гаргасан дүгнэлт, тайлбарын талаар Төрийн өмчийн

хороо, түүний зөвлөх, тендерийн комисс, компани, тэдгээрийн төлөөлөгчдийн аль аль нь хариуцлага хүлээхгүй.

6.5 Тендерт оролцогч дүн шинжилгээ хийхүүй байхаар шийдвэрлэсэн тохиолдолд тендерийн санал өгөх эрхтэй хэвээр үлдэнэ.

Долоо. Хувьцаа худалдах, худалдан авах тухай гэрээг эцэслэн боловсруулах

7.1 Тендерт оролцогчдоос 2001 оны 9 дүгээр сарын 10-ны дотор Төрийн өмчийн хороонд ирүүлж санал болгосон нэмэлт, өөрчлөлтүүдийг харгалзан Төрийн өмчийн хороо хувьцаа худалдах, худалдан авах тухай гэрээний төсөлд нэмэлт, өөрчлөлт оруулж, уг гэрээний шинэчилсэн төслийг боловсруулж болно.

7.2 Төрийн өмчийн хороо хувьцаа худалдах, худалдан авах тухай гэрээний шинэчилсэн төслийг боловсруулсан тохиолдолд энэ тухай тендерт оролцогч тус бүрт мэдэгдэж, шинэчилсэн төслийн хувийг 2001 оны 9 дүгээр сарын 17-ны дотор тараана.

7.3 Тендерт оролцогчдод хувьцаа худалдах, худалдан авах тухай гэрээний шинэчилсэн төсөлд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай саналаа 2001 оны 9 дүгээр сарын 24-ний дотор ирүүлэхийг санал болгоно. Энэ өдрөөс хойш ирүүлсэн санал, тайлбарыг хүлээж авахгүй.

7.4 Тендерт оролцогчдоос хувьцаа худалдах, худалдан авах тухай гэрээний шинэчилсэн төсөлд оруулахаар санал болгосон нэмэлт, өөрчлөлтүүдийг харгалзан Төрийн өмчийн хороо хувьцаа худалдах, худалдан авах тухай гэрээний эцсийн төслийг боловсруулж, тендерт оролцогч тус бүрт 2001 оны 10 дугаар сарын 1-ний дотор тараана.

Найм. Тендерийн санал бэлтгэх, ирүүлэхэд тавигдах ерөнхий шаардлага

8.1 Бүх мөнгөн дүнг Америкийн Нэгдсэн Улсын долларааар илэрхийлнэ.

8.2 Тендерт оролцогчид тендерийн саналаа англи, монгол хэл дээр бэлтгэж тус бүр нэг эх хувь болон таван хуулбарыг ирүүлнэ.

8.3 Саналын эх хувь болон хуулбаруудын хооронд аливаа зөрүү гарах тохиолдолд эх хувийг баримтална.

8.4 Тендерийн саналыг бэлтгэсэн хэл дээрх эх хувь болон орчуулгын хооронд зөрүү гарах тохиолдолд эх хувийг баримтална. Тендерийн саналд аль хэлийг „эх хувийг бэлтгэсэн хэл" гэж үзэхийг заавал заана.

8.5 Тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч тендерийн саналын хуудас бүрт хар буюу хөх енгийн бэхээр гарын үсэг зурна. Итгэмжлэгдсэн төлөөлөгчид олгосон эрхийг зохих журмын дагуу бичгээр гаргаж, тендерийн саналд хавсаргасан итгэмжлэлээр баталгаажуулна.

8.6 Тендерийн санал оруулсан бүх засварт тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч гарын үсгээ зурах буюу эсвэл үсэглэн баталгаажуулна.

8.7 Тендерийн саналыг шуудангаар ирүүлсэн тохиолдолд Төрийн өмчийн хороо хүлээн авсан өдрийг тендерийн санал ирүүлсэн өдөр гэж тооцно.

8.8 Төрийн өмчийн хороо тендерийн саналыг хүлээж авсан огноо, цагийг тэмдэглэсэн баримтыг оролцогч тус бүрт илгээж хүлээн авснаа батална. Шуудангаар ирүүлсэн тендерийн саналд хариу илгээх факсын дугаарыг заагаагүй тохиолдолд хүлээн авсан тухай баримтыг ирүүлсэн саналын дугтуйн дээрх хаягаар юмуу тендерт оролцогчийн Төрийн өмчийн хорооны бүртгэлд тусгагдсан хаягаар илгээнэ.

8.9 Оролцогч нь тендерийн санал хүлээн авах хугацаа дуусахаас өмнө Төрийн өмчийн хороонд бичгээр мэдэгдэж, тендерийн саналаа өөрчлөх, эсвэл татан авах эрхтэй.

Ес. Дэнчин

9.1 Тендерийн саналаа ирүүлэх хүсэлтэй тендерт оролцогчид хувьцаа худалдах, худалдан авах тухай гэрээг байгуулах чадвар, санхүүгийн эх үүсвэрийн баталгаа болон тендерт оролцох хүсэлтээ баталж Төрийн өмчийн хорооны валютын харилцах дансанд 100,000 /нэг зуун мянган/ америк долларын дэнчин төлнө. Тендерийн дэнчинг дор дурдсан дансанд төлнө. Үүнд:

Банк: Монгол Улсын " Монгол банк" [хаяг]

Дансны дугаар:3332404
SWIFT код:

Тендерийн дэнчин төлснийг нотолсон банкны баримтын хуулбарыг техникийн саналд хавсаргана.

9.2 Тендерт оролцогч нь дэнчин тавиагүй тохиолдолд тендерт оролцох эрхгүй.

9.3 Тендерт ялагчаар шалгарсан оролцогчийн тавьсан дэнчинг худалдан авах үнэд оролцуулан тооцно.

9.4 Тендерийн саналыг үнэлсний дараа, тендерт оролцогч ялагчаар шалгараагүй тохиолдолд тендерийн дэнчинг тендерт оролцогчийн хүсэлтийн дагуу ажлын долоон өдөрт багтаан бүрэн бүцаан олгох бөгөөд хүсэлтэд дэнчинг шилжүүлэх банкны дансны дугаарыг тодорхой заана.

9.5 Тендерийн дэнчинг дараахь тохиолдолд буцааж олгохгүй:

1) Ялагч нь санхүүгийн саналтайгаа хамт англи болон монгол хэл дээр тус бүр хоёр хувь үйлдэж гарын үсэг зурсан хувьцаа худалдах, худалдан авах тухай гэрээний эцсийн төслийг ирүүлээгүй буюу түүний итгэмжлэгдсэн төлөөлөгч тендерийн үр дүнгийн тухай мэдэгдэл /протокол/-д гарын үсэг зурахаас татгалзсан,

2) Ялагч нь Хувьцаа худалдах, худалдан авах тухай гэрээний нөхцөл, болзлын дагуу худалдан авах үнийн төлбөрийг хийгээгүй.

9.6 Дэнчинд хүү төлөхгүй.

9.7 Тендерийн дэнчин төлөхтэй холбогдсон банкны бүх зардлыг тендерт оролцогч хариуцна.

Арав. Тендерийн санал бэлтгэх, ирүүлэх

10.1 "Говь" ХК-ийн хувьцааны 70 хувийг худалдахад Засгийн газраас дараахь нөхцөл тавина. Үүнд:

а) худалдан авагч нь оёмол, сүлжмэл эдлэл, бэлэн хувцасны үйлдвэрлэлийн салбарт үйл ажиллагаагаа амжилттай эрхлэн явуулж байгаа компанийг эзэмшиж, тодорхой амжилтад хүрсэн туршлагатай, хөгжингүй орнуудын зах зээлийн чамин тансаг эд хэрэглэгдэд хүрсэн борлуулалтын сүлжээнд нэвтрэх чадвартай байх бөгөөд орчин үеийн удирдлага, маркетинг, технологийн ноу хаут нэвтрүүлэх замаар „Говь" ХК-ийн өрсөлдөх чадварыг дээшлүүлж, санхүүгийн болон үйл ажиллагааны үр дүнг сайжруулах чадвартайгаа нотолсон байх;

б) худалдан авагч нь компанийн бизнесийн үндсэн чиглэл, Монгол Улсын ноос, ноолууран бүтээгдэхүүний тэргүүний үйлдвэрлэгч болохын хувьд урьд өмнө зах зээлд эзэлж байсан байр суурийг хадгалах, сайжруулахаа баталж байх;

в) худалдан авагч нь „Говь" ХК-ийн өндөр үнэ цэнэтэй, дээд зэрэглэлийн эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлтийг өргөтгөж, ийм бүтээгдэхүүнийг чамин тансаг эд хэрэглэгчдэд хүргэж, бүтээгдэхүүн борлуулах хэмжээг нэмэгдүүлэхээ батлах;

г) Компанийн үйлдвэрлэл, техникийн хүчин чадлыг нэмэгдүүлж, компанийн маркетинг, хуваарилалт болон олон улсын зах зээл дэх өрсөлдөх чадварыг дээшлүүлэх тодорхой хэмжээний хөрөнгө оруулалтыг, өмчлөл шилжсэнээс хойшхи эхний хоёр жилийн дотор нэн даруй хийх баталгаа гаргах.

10.2 Тендерийн санал дараахь хоёр хэсэгтэй байна. Үүнд:

- Техникийн санал /бизнесийн төлөвлөгөөний хамт/,
- Санхүүгийн санал.

10.3 Техникийн болон санхүүгийн саналын англи, монгол хэл дээрх эх хувь болон хуулбаруудыг „ЭХ ХУВЬ", „ХУУЛБАР", „ТЕХНИКИЙН САНАЛ," „САНХҮҮГИЙН САНАЛ" гэж хаяглан тус тусад нь битүүмжлэн дугтуйлна. Эдгээр дугтуйг өөр дугтуйд давхар хийж битүүмжилнэ. Гаднахь дугтуй дээр Төрийн өмчийн хорооны хаяг, тендерт оролцогчийн албан ёсны нэр, хаягийг бичиж:

„ГОВЬ ХК-ийн хувьцааг худалдан авах нууц санал - Тендерийн санал.
ТЕНДЕРИЙН КОМИССЫГ БАЙЛЦУУЛАХГҮЙГЭЭР НЭЭХИЙГ ХОРИГЛОНО" гэсэн тэмдэглэл хийнэ.

Тендерийн саналыг Төрийн өмчийн хорооны дараахь хаягаар 2001 оны 10 дугаар сарын 8-ны өдрийн (Улаанбаатарын цагаар) 18.00 цагаас өмнө ирүүлнэ:

Л. Пүрэвдорж
Төрийн өмчийн хорооны дарга

Засгийн газрын 4-р байр, 408-р өрөө
Улаанбаатар-11, Монгол Улс

10.4 Техникийн санал

Техникийн санал нь дор дурдсан хэсгүүдээс бүрдэнэ. Үүнд:

А. Оролцогчийн эзэмшлийн бүтээц, чадвар, туршлагын талаар тодорхой тусгасан оролцогчийн тухай танилцуулга

(1) Тендерт оролцогчийн оёмол, сүлжмэл эдлэл, бэлэн хувцасны үйлдвэрлэлийн салбарын туршлага. Энэ нь тухайн салбарт үйл ажиллагаагаа амжилттай эрхлэн явуулж байгаа компанийг эзэмшиж, тодорхой амжилтад хүрсэн туршлага, хөгжингүй орнуудын зах зээлийн чамин тансаг эд хэрэглэгчдэд хүрсэн борлуулалтын сүлжээтэй байх, эсвэл түүнд нэвтрэх чадвараа тодорхойлох,

(2) Сүүлийн гурван жилийн эцсийн байдлаар гаргаж аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан тэнцэл (нээлттэй компанийн хувьд хувьцаа эзэмшигчдэд зориулсан жилийн тайлан). Сүүлчийн жилийн санхүүгийн тайланг англи, монгол хэл дээр ирүүлэх бөгөөд түүнээс өмнөх хоёр жилийн санхүүгийн тайланг англи хэл дээр ирүүлж болно.

(3) Нийт гаргасан хувьцааны тавааас дээш хувийг эзэмшиж буй хувьцаа эзэмшигчдийн жагсаалт,

(4) Тендерт оролцогчийн ирүүлэх хүсэлтэй тендерт холбогдох бусад баримт бичиг.

Б. Бизнесийн төлөвлөгөө

Бизнесийн төлөвлөгөөний зорилго нь тендерт оролцогчийн "Говь" ХК-ийг ирээдүйд хөгжүүлэх стратегийг тодорхойлоход оршино. Компанийн таван жилийн бизнесийн төлөвлөгөөнд дараахь зүйлийг тусгасан байна. Үүнд:

(1) "Говь" ХК-ийн өндөр үнэ цэнэтэй, дээд зэрэглэлийн эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг өргөжүүлэх талаар санал болгож буй бизнесийн стратеги, хяналт, шалгалтыг хөнгөвчлөх зорилгоор баримт, дүн шинжилгээг баримтжуулахтай холбоотой дэлгэрэнгүй мэдээлэл,

(2) Өндөр үнэ цэнэтэй, дээд зэрэглэлийн эцсийн бүтээгдэхүүний Монгол дахь үйлдвэрлэлтийн зорилт (өндөр үнэ цэнэтэй, дээд зэрэглэлийн эцсийн бүтээгдэхүүний ангилал тус бүрийн жилийн борлуулалтын тоо хэмжээ),

(3) Шинээр нэвтрүүлэх болон үйлдвэрлэлтийн хүчин чадлыг шинэчилж сайжруулахад зориулах технологи, ноу-хау-гийн талаархи дэлгэрэнгүй мэдээлэл болон хэрэгжүүлэх хөтөлбөр,

(4) Техникийн шинэчлэл хийхэд зориулсан хөрөнгө оруулалтын төлөвлөгөө (шинэ эсвэл хуучин тоног төхөөрөмж ашиглах эсэхийг тодруулах) өртгийн тооцооны хамт, санал болгож буй хуваарь,

(5) Бүтээгдэхүүн, түүний ангилал тус бүрийн борлуулалтын тоо хэмжээний талаархи таван жилийн прогнозыг хамарсан Маркетингийн төлөвлөгөө,

(6) Түүхий эд бэлтгэлийн стратеги,

(7) 5 жилийг хамарсан санхүүгийн прогноз (орлого, үр дүнгийн тайлан, баланс, мөнгөн урсгалын тайлан, санхүүжилтийн эх үүсвэр), түүнчлэн улсын төсөвт төлөх 5 жилийг хамарсан орлогын татварын прогноз,

(8) Санал болгож буй трансферт үнэлгээний бодлогын тухай мэдээлэл, түүнчлэн удирдлага болон татварын албаны хяналт, шалгалтыг хөнгөвчлөх зорилгоор баримт, дүн шинжилгээг баримтжуулахтай холбоотой дэлгэрэнгүй мэдээлэл,

(9) Хөдөлмөр эрхлэлтийн түвшин /үндсэн ажиллагсдын тоог жил бүрээр гаргах/, цалин урамшуулал, сургалтын хөтөлбөр, эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдлыг хамарсан хүний нөөцийн болон хөдөлмөр эрхлэлтийн төлөвлөгөө,

(10) Байгууллагын болон удирдлагын хөгжлийн төлөвлөгөө,

(11) Төлөвлөгөөт хугацаанд жил бүр шаардагдах Монголын харьяат бус техникийн мэргэжилтэн болон удирдлагын ажилтнуудын тоо, албан тушаал,

(12) Байгаль орчныг хамгаалах, бохирдлыг арилгах төлөвлөгөө болон түүний хугацаа.

В. Тендерийн дэнчин төлснийг нотлох баримт

Г. Тендерийн энэхүү журмын сүүлчийн хуудсанд гарын үсэг зурсан хуулбар. Тендерт оролцогч нь Тендерийн журамд гарын үсэг зурснаар энэхүү журмын заалтыг сахин мөрдөхийг хүлээн

зөвшөөрснөө илэрхийлнэ.

Д. Тендерт оролцохыг зөвшөөрч удирдах байгууллагаас нь гаргасан шийдвэр.

10.5 Санхүүгийн санал

Санхүүгийн санал нь дор дурдсан хэсгүүдээс бүрдэнэ. Үүнд:

А. "Говь" ХК-ийн нийт хувьцааны төрийн эзэмшлийн 70 хувьд ногдох 5,460,788 /таван сая дөрвөн зуун жаран мянга долоон зуун наян найман/ ширхэг хувьцааг худалдан авах үнэ.

Б. Хувьцааны өмчлөл шилжсэнээс хойшхи эхний хоёр жилийн дотор компанид нэн даруй хийх хөрөнгө оруулалтын хэмжээ. Эдгээр хөрөнгө оруулалт нь компанийг хөгжүүлэх, үйл ажиллагаагаа сайжруулахад шууд чиглэгдсэн байх шаардлагатай.

В. Тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн гарын үсэг зурсан Хувьцаа худалдах, худалдан авах тухай гэрээний эцсийн төслийн англи болон монгол хэл дээрх тус бүр хоёр ижил эх хувь.

Хувьцаа худалдах, худалдан авах тухай гэрээний эцсийн төслийн гарын үсэг зурсан бүх эх хувийг санхүүгийн саналын эх хувьд хавсаргана. Хувьцаа худалдах, худалдан авах тухай гэрээний эцсийн төслийн гарын үсэг зурсан англи болон монгол хэл дээрх эх хувийн хуулбаруудыг санхүүгийн саналын бүх хуулбарт хавсаргана.

Хувьцаа худалдах, худалдан авах тухай гэрээний эцсийн төсөлд дараахь зүйлийг хавсаргана:

1. Гэрээнд гарын үсэг зурахыг зөвшөөрсөн хуулийн этгээдийн удирдах байгууллагын шийдвэр,

2. Итгэмжлэгдсэн төлөөлөгчид дараахь эрх олгосныг нотлох итгэмжлэл:

§ Гэрээнд гарын үсэг зурах,

§ Санхүүгийн саналыг нээх ажиллагаанд Тендерт оролцогчийг төлөөлөх.

Тендерт оролцогчийн өргөдөлд хавсаргасан итгэмжлэлд эдгээр эрхийг итгэмжлэгдсэн төлөөлөгчид олгосон тохиолдолд итгэмжлэлийн хувийг хавсаргана.

Арван нэг. Тендерийн саналын үнэлгээ

11.1 Төрийн өмчийн хороо тендерийн саналуудад үнэлгээ хийгүүлэх зорилгоор тендерийн комиссыг томилно. Тендерийн саналыг үнэлэх үйл ажиллагаа нь дараахь хоёр үе шаттай байна. Үүнд:

- Техникийн саналын үнэлгээ,
- Санхүүгийн саналын үнэлгээ.

11.2 Тендерийн комисс нь техникийн саналуудыг дор дурдсан шалгаруулах үзүүлэлт болон онооны системээр үнэлнэ. Үүнд:

1) Тухайн салбарт үйл ажиллагаа явуулж ирсэн туршлага болон түүхэн замнал (0-40 оноо),

2) Санал болгож буй бизнесийн төлөвлөгөөний чанар, Засгийн газраас тавих нөхцөлүүдийг хүлээн авч тусгасан байдал (0-40 оноо).

Дэд үзүүлэлт:

§ Бизнесийн төлөвлөгөөний цар хүрээ, тодорхой байдал (0-10 оноо),

§ Засгийн газраас тавих нөхцөлүүдэд төлөвлөгөө, стратегийн нийцсэн байдал (0-30 оноо). Үүнээс:

§ Санал болгож буй трансферт үнэлгээний бодлогын тухай мэдээлэл, түүнчлэн удирдлага болон татварын албаны хяналт, шалгалтыг хөнгөвчлөх зорилгоор баримт,дүн шинжилгээг баримтжуулахтай холбоотой мэдээллийн дэлгэрэнгүй, зохистой байдал (0-10 оноо).

3) Байгаль орчныг хамгаалах, байгаль орчны бохирдлыг арилгах эрмэлзэл (0-10 оноо),

4) Хүний нөөцийг хөгжүүлэх болон хөдөлмөр эрхлэлтийн төлөвлөгөө (0-10 оноо).

Тендерт оролцогч өөрийн бизнесийн хөгжлийн стратегитэй уялдуулан хөдөлмөр эрхлэлтийн өнөөгийн түвшинг хадгалах болон нэмэгдүүлэх, хөдөлмөр хамгаллыг сайжруулах үүрэг авсан байна.

11.3 Техникийн үнэлгээгээр 70-аас доошгүй оноо авсан саналыг шалгаруулна.

11.4 Техникийн саналыг үнэлэх үйл ажиллагаат дуусгасны дараа тендерийн комисс нь техникийн саналын үнэлгээний тайлан гаргана.

11.5 Техникийн саналын үнэлгээ дууссаны дараа Төрийн өмчийн хороо техникийн санал нь тэнцсэн оролцогчдод тендерт цаашид оролцохоор шалгарсан тухай болон санхүүгийн саналыг нээхээр товлосон газар, цагийг мэдэгдэнэ. Төрийн өмчийн хороо техникийн санал нь тэнцээгүй оролцогчдод энэ тухай болон дэнчинг бүцаан олгох тухай мэдэгдэнэ. Мэдэгдлийг буухиа шуудан, факс буюу электрон шуудангаар явуулж болно.

11.6 Санхүүгийн саналуудыг тендерт оролцогчдын итгэмжлэгдсэн төлөөлөгчдийг байлцуулан нийтийн өмнө тендерийн хуваарът заасны дагуу 2001 оны 10 дугаар сарын 26-ны өдөр задална.

11.7 Техникийн саналын үнэлгээгээр 70-аас доошгүй оноо авсан тендерт оролцогчдын санхүүгийн саналыг нээж үнэлнэ.

11.8 Тендерт оролцогчийн нэр, санал болгож буй худалдан авах үнэ болон нэн даруй хийх хөрөнгө оруулалтын хэмжээг чангаар уншиж, бүртгэнэ. Тендерийн комисс Санхүүгийн санал бүрт Хувьцаа худалдах, худалдан авах тухай гэрээний эцсийн төслийг хавсаргаж, зохих ёсоор гарын үсэг зурсан эсэхийг шалгах ба Санхүүгийн саналуудыг нийтийн өмнө задлах ажиллагааны тэмдэглэл хөтөлнө.

11.9 Тендерийн комисс нь Санхүүгийн саналуудыг дор дурдсан онооны системээр үнэлнэ. Үүнд:

(1) санал болгож буй худалдан авах үнийн дүнгийн ам. доллар бүрт нэг оноо,

(2) нэн даруй хийх хөрөнгө оруулалтын дүнгийн ам. доллар бүрт 0.75 оноог тус тус ногдуулна.

(3) эцсийн оноо нь худалдан авах үнэ болон нэн даруй оруулах хөрөнгө оруулалтын хэмжээнд тус тус ногдуулсан онооны нийлбэртэй тэнцэнэ.

11.10 Хоёр буюу түүнээс дээш тендерт оролцогч ижил оноо авсан тохиолдолд тэдгээрийг техникийн саналын үнэлгээгээр авсан онооны дагуу эрэмбэлнэ. Хэрэв техникийн саналын үнэлгээгээр авсан оноо нь мөн тэнцсэн тохиолдолд худалдан авах үнийн шинэ саналыг нэг цагийн дотор бичгээр өгөх боломж олгоно. Хэрэв хоёр буюу түүнээс дээш тендерт оролцогчийн эцсийн оноо нь дахин тэнцвэл худалдан авах үнийнхээ саналыг нэг цагийн дотор дахин шинэчлэх боломж олгоно. Энэ ажиллагааг аль нэг тендерт оролцогч бусдаасаа хамгийн өндөр эцсийн оноотой болох хүртэл үргэлжлүүлэн явуулна.

11.11 Санхүүгийн саналыг албан ёсоор нээж үнэлсэн өдрөө тендерийн комисс нь тендерийн үр дүнгийн мэдэгдэл /протокол/-ийн теслийг бэлтгэж, Төрийн өмчийн хороогоор хянуулан батлуулах зорилгоор нээлттэй хуралдааны ажиллагаат түр завсарлана.

11.12 Тендерийн комисс, Төрийн өмчийн хорооны гишүүд мөн өдөр нээлттэй хамтарсан хуралдаан хийж, Төрийн өмчийн хорооны даргын гарын үсэг зурсан тендерийн нэгдсэн мэдэгдэл / протокол/-ийг уншиж тендерийн үр дүнг зарлана.

11.13 Ялагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийг тендерийн үр дүнгийн мэдэгдэл / протокол/-д гарын үсэг зурахыг урих бөгөөд түүнд уг мэдэгдлийн гарын үсэг зурсан хувийг Төрийн өмчийн хорооны даргын гарын үсэг бүхий Хувьцаа худалдах, худалдан авах тухай гэрээний эх хувьтай хамт олгоно.

Арван хоёр. Тендерийг явагдаагүйд болон хүчингүйд тооцох, өргөдөл, санал ирүүлэх хугацааг сунгах

12.1 Төрийн өмчийн хороо өргөдөл, тендерийн санал ирүүлэх хугацааг /өөрийн санаачилгаар эсвэл хүсэлтийн дагуу/ сунгах буюу тендерийн хуваарийг хэдийд ч ямар ч байдлаар өөрчилж болно.

12.2 Монгол Улсын Засгийн газар нь аль ч үед урьдчилан мэдэгдэлгүйгээр Уралдаант шалгаруулалт /тендер/-ын журмын аль ч заалтыг хасах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах эрхтэй. Тендерийн журамд оруулсан аливаа өөрчлөлтийн талаар Төрийн өмчийн хороо бүх оролцогчдод бичгээр мэдэгдэнэ.

12.3 Зөвхөн нэг этгээд тендерт оролцох өргөдөл ирүүлсэн, эсвэл зөвхөн нэг оролцогч тендерийн санал ирүүлсэн тохиолдолд тендерийг цуцлаж эсвэл өргөдөл, тендерийн санал ирүүлэх хугацааг сунгаж болно.

Тендерт оролцогчийн гарын үсэг

_____

Он, сар, өдөр _____

Хавсралт 1

ТЕНДЕРИЙН ХУВААРЬ

Үйл ажиллагаа	Огноо/Эцсийн хугацаа
Тендерийн зар мэдээ	7-р сарын 9
Өргөдлөө ирүүлэх/Урьдчилан шалгаруулалт/Тендерийн баримт бичгийг хүргүүлэх	7-р сарын 9-8-р сарын 31
Компани дээр дүн шинжилгээ хийх/санал, дүгнэлт гаргах хугацаа	7-р сарын 23-10-р сарын 5
Компанитай танилцаж, уулзалт хийх хүсэлтээ ирүүлэх	8-р сарын 31
ХХХАГ-ний төслийн талаар санал авах	9-р сарын 10
ХХХАГ-ний шинэчилсэн төслийг боловсруулан гаргах	9-р сарын 17
ХХХАГ-ний шинэчилсэн төслийн талаар санал авах	9-р сарын 24
ХХХАГ-ний эцсийн төслийг бэлтгэн гаргах	10-р сарын 1
Тендерийн санал ирүүлэх	10-р сарын 8
Техникийн саналыг үнэлэх	10-р сарын 8-19
Техникийн саналын үр дүнг мэдээлэх	10-р сарын 19
Санхүүгийн саналыг нийтийн өмнө нээж үнэлэх/Тендерийн үр дүнг нийтэд мэдээлэх	10-р сарын 26
Гэрээнд гарын үсэг зурах	10-р сарын 26

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 7 дугаар сарын 9-ний өдөр **Дугаар 159** **Улаанбаатар хот**

Тогтоолд өөрчлөлт оруулах тухай

Улсын хил хамгаалалтын асуудал Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх ажлын хүрээнд шилжсэнтэй холбогдуулан Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

"Засгийн газрын комисс, Үндэсний зөвлөл, хороо, ажлын хэсгийн тухай" Засгийн газрын 1996 оны 9 дүгээр сарын 20-ны өдрийн 238 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтын 4 дэх заалтын "Гадаад харилцааны сайд" гэснийг "Хууль зүй, дотоод хэргийн сайд" гэж өөрчилсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД **Ц.НЯМДОРЖ**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 7 дугаар сарын 9-ний өдөр **Дугаар 161** **Улаанбаатар хот**

Хөрөнгө гаргах тухай

Тахир дутуу иргэдийг дэмжих жилийн ажлын хүрээнд тахир дутуу тамирчин иргэдэд дэмжлэг үзүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Итали Улсын Ром хотноо энэ оны 7 дугаар сарын 18-наас 8 дугаар сарын 1-ний өдрүүдэд болох Дэлхийн дүлий иргэдийн зуны спортын XIX тоглолтод чөлөөт болон сонгомол бөхийн төрлөөр оролцох тамирчдын зардалд зориулан 15,2 (арван таван сая хоёр зуун мянган) сая төгрөгийг Засгийн газрын нөөц хөрөнгөөс гаргахыг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаанд зөвшөөрсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН САЙД **Ч.УЛААН**

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Хаяг: «Төрийн мэдээлэл» эмхтгэлийн зөвлөл

Улаанбаатар-12 ☎ 329612
Төрийн ордон Индекс 14003

Улсын Их Хурлын Тамгын газрын Хэвлэх хэсэгт хэвлэв.

☎ 329487



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 38 (225)

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ:

- *Алан хядах ажиллагааг бууруашаах тухай*

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ:

- *Жорж Соросыг "Алтан гадас" одонгоор шагнах тухай*
- *Элчин сайдыг эгүүлэн татах, томилох тухай*

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ:

- *Төрийн албан хаагчдын цалингийн талаар авах зарим арга хэмжээний тухай*
- *Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн доод хэмжээг нэмэгдүүлэх тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар

Улаанбаатар хот
2001 он

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот 2001 оны есдүгээр сарын 30 №38 (225)

Гарчиг

Нэг. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

440. Алан хядах ажиллагааг буруушаах тухай Дугаар 66 922

Хоёр. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

441. Жорж Соросыг "Алтан гадас" одонгоор шагнах тухай Дугаар 46 922
442. Элчин сайдыг эгүүлэн татах, томилох тухай Дугаар 47 922
443. Элчин сайдыг эгүүлэн татах, томилох тухай Дугаар 48 922
444. Элчин сайдыг эгүүлэн татах, томилох тухай Дугаар 51 923
445. Элчин сайдыг эгүүлэн татах, томилох тухай Дугаар 52 923
446. Элчин сайдыг эгүүлэн татах, томилох тухай Дугаар 53 923
447. Элчин сайдыг эгүүлэн татах, томилох тухай Дугаар 54 924

Гурав. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

448. Дарханы хар төмөрлөгийн үйлдвэрийн талаар авах зарим арга хэмжээний тухай Дугаар 142 924
449. Тогтоолд өөрчлөлт оруулах тухай Дугаар 162 924
450. Туршилтын хугацааг сунгах тухай Дугаар 163 924
451. Эрчим хүчний салбарын төрийн өмчит үйлдвэрийн газруудад бүтцийн өөрчлөлт хийх тухай Дугаар 164 925
452. Төрийн албан хаагчдын цалингын талаар авах зарим арга хэмжээний тухай Дугаар 165 927
453. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн доод хэмжээг нэмэгдүүлэх тухай Дугаар 166 927
454. Халдварт өвчинтэй тэмцэх ажлыг эрчимжүүлэх тухай Дугаар 167 928
455. Бэлэн байдлын зэрэг, хорио цээрийн дэглэмийг цуцлах тухай Дугаар 169 928
456. Журам батлах тухай Дугаар 171 929
457. Шонхор шувууны жишиг үнэ, төлбөр, хураамжид өөрчлөлт оруулах, 2001 онд гадаадад гаргах тоог тогтоох тухай Дугаар 172 932
458. Зарим барилга байгууламж шилжүүлэх тухай Дугаар 173 932

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2001 оны 9 дүгээр сарын 14-ний өдөр | Дугаар 66 | Улаанбаатар хот

Алан хядах ажиллагааг буруушаах тухай

Америкийн Нэгдсэн Улс 2001 оны 9 дүгээр сарын 11-ний өдөр алан хядах ажиллагаанд өртэж, мянга мянган хүний амь эрсдэж, хүнд гарз хохирол учирсантай холбогдуулан Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Алан хядах ажиллагааг эрс буруушааж, түүний эсрэг тэмцэх, таслан зогсоохоод чиглэсэн дэлхийн хамтын нийгэмлэгийн хүчин чармайлтыг Монгол Улсын Их Хурал дэмжиж, эв санааны нэгдэлтэй байгаагаа илэрхийлсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Л.ЭНЭБИШ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2001 оны 9 дүгээр сарын 10-ны өдөр | Дугаар 46 | Улаанбаатар хот

Жорж Соросыг "Алтан гадас" одонгоор шагнах тухай

Монгол Улсын боловсрол, соёл урлаг, эрүүл мэнд, хууль эрх зүй, хэвлэл мэдээлэл, мэдээллийн технологийн салбарт хэрэгжүүлж байгаа төслүүдийг санхүүжүүлэх, манай оронд иргэний нийгмийг төлөвшүүлж хөгжүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Нэлтгэй нийгэм хүрээлэнгийн тэргүүн, АНУ-ын иргэн Жорж Соросыг "Алтан гадас" одонгоор шагнасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2001 оны 9 дүгээр сарын 13-ны өдөр | Дугаар 47 | Улаанбаатар хот

Элчин сайдыг эгүүлэн татах, томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5, Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг баримтлан ЗАРЛИГ болгох нь:

1. Монгол Улсаас Оросын Холбооны Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Цэрэндашийн Цолмонг эгүүлэн татсугай.

2. Монгол Улсаас Оросын Холбооны Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Санжаагийн Баярыг томилсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2001 оны 9 дүгээр сарын 13-ны өдөр | Дугаар 48 | Улаанбаатар хот

Элчин сайдыг эгүүлэн татах, томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5, Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг баримтлан ЗАРЛИГ болгох нь:

1. Монгол Улсаас Бүгд Найрамдах Чех Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Пэрэнлэйн Нямааг эгүүлэн татсугай.

2. Монгол Улсаас Бүгд Найрамдах Чех Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Шижээхүүгийн Одонбаатарыг томилсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2001 оны 9 дүгээр сарын 18-ны өдөр **Дугаар 51** **Улаанбаатар хот**

Элчин сайдыг эгүүлэн татах, томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5, Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг баримтлан ЗАРЛИГ болгох нь:

1. Монгол Улсаас Бүгд Найрамдах Португали Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Хасбазарын Бэхбатыг эгүүлэн татсугай.

2. Монгол Улсаас Бүгд Найрамдах Португали Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Готовдоржийн Луузанг томилсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2001 оны 9 дүгээр сарын 18-ны өдөр **Дугаар 52** **Улаанбаатар хот**

Элчин сайдыг эгүүлэн татах, томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5, Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг баримтлан ЗАРЛИГ болгох нь:

1. Монгол Улсаас Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Цэдэнжавын Сүхбаатарыг эгүүлэн татсугай.

2. Монгол Улсаас Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Далрайн Даваасамбууг томилсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2001 оны 9 дүгээр сарын 18-ны өдөр **Дугаар 53** **Улаанбаатар хот**

Элчин сайдыг эгүүлэн татах, томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5, Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг баримтлан ЗАРЛИГ болгох нь:

1. Монгол Улсаас Кувейт Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Кадырын Сайрааныг эгүүлэн татсугай.

2. Монгол Улсаас Кувейт Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Чойжилжавын Болдыг томилсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2001 оны 9 дүгээр сарын 18-ны өдөр **Дугаар 54** **Улаанбаатар хот**

Элчин сайдыг эгүүлэн татах, томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5, Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг баримтлан ЗАРЛИГ болгох нь:

1. Монгол Улсаас Арабын Нэгдсэн Эмират Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Кадырын Сайрарааныг эгүүлэн татсугай.

2. Монгол Улсаас Арабын Нэгдсэн Эмират Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Чойжилжавын Болдыг томилсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ **Н.БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 6 дугаар сарын 27-ны өдөр **Дугаар 142** **Улаанбаатар хот**

Дарханы хар төмөрлөгийн үйлдвэрийн талаар авах зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Их Хурлын 2001 оны 10 дугаар тогтоолоор батлсан Төрийн өмчийг 2001-2004 онд хувьчлах үндсэн чиглэлийн 2.1.8 дугаар заалтыг үндэслэн Дарханы хар төмөрлөгийн үйлдвэрийн санхүү, эдийн засгийн чадавхийг дээшлүүлэх, үйлдвэрлэлийн үйл ажиллагааг тогтворжуулж, үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Дарханы хар төмөрлөгийн үйлдвэр /ТӨҮГ/-ийн эд хөрөнгө, хөрөнгийн эрх хувийн өмчид шилжихгүй нөхцөлтэйгээр удирдлагын гэрээгээр ажиллах этгээдийг уралдаант шалгаруулалтын аргаар шалгаруулахыг Үйлдвэр, худалдааны сайд Ч.Ганзориг, Төрийн өмчийн хороо (Л.ПҮРЭВДОРЖ)-нд үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

ҮЙЛДВЭР, ХУДАЛДААНЫ САЙД **Ч.ГАНЗОРИГ**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 7 дугаар сарын 9-ний өдөр **Дугаар 162** **Улаанбаатар хот**

Тогтоолд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

"Дансны тогтолцоог журамлах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2001 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн 132 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтын "1.Улсын Их Хурал" гэснийг хассугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

ЗАСГИЙН ГАЗРЫН ГИШҮҮН, ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА **Ө.ЭНХТҮВШИН**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 7 дугаар сарын 9-ний өдөр **Дугаар 163** **Улаанбаатар хот**

Туршилтын хугацааг сунгах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

"Төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэх туршилтын тухай" Засгийн газрын 1999 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн 176 дугаар тогтоолын 1 дүгээр зүйлд заасан туршилтын хугацааг 2001 оныг дуустал сунгасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

ЗАСГИЙН ГАЗРЫН ГИШҮҮН, ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА **Ө.ЭНХТҮВШИН**

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ 2001 он №38 (225)

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 7 дугаар сарын 9-ний өдөр | Дугаар 164 | Улаанбаатар хот

Эрчим хүчний салбарын төрийн өмчит үйлдвэрийн газруудад бүтцийн өөрчлөлт хийх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйл, Компанийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 5 дахь хэсэг болон Улсын Их Хурлын 2001 оны 10 дугаар тогтоолыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Эрчим хүчний удирдах газрын бүрэлдэхүүнд байгаа Дулааны II цахилгаан станц /ДЦС-2/, Дулааны III цахилгаан станц /ДЦС-3/, Дулааны IV цахилгаан станц /ДЦС-4/, Дарханы Дулааны цахилгаан станц /ДДЦС/, Эрдэнэтийн Дулааны цахилгаан станц /ЭДЦС/, Налайхын Дулааны станц /НДС/, Багануурын Дулааны станц /БНДС/, Даланзадгадын Дулааны цахилгаан станц /ДДЦС/-ийг тус тус бие даасан төрийн өмчит хувьцаат компанийн хэлбэрт шилжүүлэн өөрчлөн зохион байгуулсугай.

2. Улаанбаатар хот, Багануур дүүрэг, Дархан-Уул, Сэлэнгэ, Төв, Булган, Орхон, Архангай, Өвөрхангай, Говьсүмбэр, Хэнтий, Дорноговь, Дундговь аймгийн нутагт байгаа 110-аас дээш киловольтын цахилгаан дамжуулах шугам, түүний дэд станцууд, мөн систем үүсгэж байгаа бусад шугам сүлжээг түшиглэн "ТБЦДС" төрийн өмчит хувьцаат компанийг; Увс, Ховд, Баян-Өлгий аймаг дахь цахилгаан дамжуулах өндөр хүчдэлийн шугам, түүний дэд станцуудыг түшиглэн "ББЦДС" төрийн өмчит хувьцаат компанийг; Дорнод, Сүхбаатар аймгийн нутаг дахь өндөр хүчдэлийн цахилгаан дамжуулах шугам, түүний дэд станц, Чойбалсан хот дахь Дулааны цахилгаан станц, түүнтэй аймгийн төвийн цахилгаан, дулаан түгээх шугам зэрэгт түшиглэн "ДБЭХС" төрийн өмчит хувьцаат компанийг тус тус шинээр байгуулсугай.

3. Улаанбаатар хот дахь цахилгаан түгээх сүлжээг түшиглэн "УБЦТС" төрийн өмчит хувьцаат компанийг; Дархан-Уул, Сэлэнгэ аймаг дахь цахилгаан түгээх сүлжээг түшиглэн "ДСЦТС" төрийн өмчит хувьцаат компанийг; Булган, Орхон аймгийн чиглэлийн цахилгаан түгээх сүлжээг түшиглэн "ЭБЦТС" төрийн өмчит хувьцаат компанийг; Багануур дүүрэг, Хэнтий, Дорноговь, Говьсүмбэр аймгийн чиглэлийн цахилгаан түгээх сүлжээг түшиглэн "БНЭӨБЦТС" төрийн өмчит хувьцаат компанийг; Улаанбаатар хотын дулаан дамжуулах сүлжээг түшиглэн "УБДС" төрийн өмчит хувьцаат компанийг; Дархан хотын дулаан дамжуулах сүлжээг түшиглэн "ДДС" төрийн өмчит хувьцаат компанийг тус тус шинээр байгуулсугай.

4. Цахилгаан, дулааны эрчим хүчний диспетчерийн зохицуулалт хийх, энэ чиглэлээр эрчим хүчний салбарт хэрэгжих төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, салбарын боловсон хүчнийг дадлагажуулах, мэргэшүүлэх, холбогдох байгууллагуудад мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх үүрэг бүхий "Диспетчерийн үндэсний төв" төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийг шинээр үүсгэн байгуулж ажиллуулсугай.

5. Энэ тогтоолын 1, 2, 3 дугаар зүйлд заасан төрийн өмчит хувьцаат компаниудын хувьцааны 41,0 хувийг Дэд бүтцийн яам, 39,0 хувийг Төрийн өмчийн хороо, 20,0 хувийг Санхүү, эдийн засгийн яам, 4 дүгээр зүйлд заасан төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хувьцааны 51,0 хувийг Дэд бүтцийн яам, 49,0 хувийг Төрийн өмчийн хороо тус тус эзэмшиж байхаар тогтоосугай.

6. Шинээр болон өөрчлөн байгуулах замаар байгуулагдаж байгаа дээр дурдсан төрийн өмчит хувьцаат компаниудад шилжих хөрөнгө, өглөг, өр төлбөр, өөрийн хөрөнгө, гаргах хувьцааны хэмжээ, төрийг төлөөлж хувьцаа эзэмших эзэмшигч 1 дүгээр хавсралт ёсоор батална сугай.

7. Шинээр болон өөрчлөн байгуулах замаар байгуулагдаж байгаа төрийн өмчит хувьцаат компаниудын дүрмийг боловсруулан Компанийн тухай хуулийн дагуу батлуулан, холбогдох байгууллагад бүртгүүлж, үйл ажиллагаа нь эхлүүлэхийг Дэд бүтцийн сайд Б.Жигжид, Төрийн өмчийн хорооны дарга Л.Пүрэвдорж нарт тус тус даалгасугай.

8. Засгийн газрын 2001 оны 35 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтад дор дурдсан агуулгатай 28 дахь заалт нэмсүгэй:

28	"УБЦТС" ТӨХК	Улаан-баатар	Эрчим хүч	100	Ш	Уралдаант шалгаруу-лалт	ДЦС-2 ТӨХК-тай нэг багц болгон гадаадын хөрөнгө оруулагчдын дунд

9. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажилан үр дүнг 2001 оны 8 дугаар сард Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Дэд бүтцийн сайд Б.Жигжид, Төрийн өмчийн хорооны дарга Л.Пүрэвдорж нарт даалгасугай.

10. Энэ тогтоол гарсантай холбогдуулан 2 дугаар хавсралтад заасан тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

ДЭД БҮТЦИЙН САЙД **Б.ЖИГЖИД**

ЭРЧИМ ХҮЧНИЙ САЛБАРЫН БҮТЦИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ХҮРЭЭНД БИЙ БОЛОХ ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИУДАД ШИЛЖИХ ХӨРӨНГИЙН ТООЦОО

2000-12-31-ний байдлаар

/сая төгрөг/

	Компаниудын нэр	Хөрөнгө			Өр төлбөр			Өөрийн хөрөнгө	Гаргах хувьцааны тоо /Нэрлэсэн үнэ - 1000/	Хувьцаа эзэмшигчдийн нэр
		Биет хөрөнгө /дэвэр/	Эргэлтийн хөрөнгө	Нийт хөрөнгө	Урт хугацаат	Богино хугацаат	Нийт ер төлбөр			
1	2	3	4	5	6	7	8	9	10	11
1	Дулааны II цахилгаан станц (ДЦС-2)	2 714,5	939,0	3 653,50		1 510,7	1 510,70	2 142,80	21 428 000	ДБЯ, ТӨХ, СЭЗЯ
2	Дулааны III цахилгаан станц (ДЦС-3)	84 038,9	2 155,6	86 194,50	49 583,3	5 165,8	54 749,10	31 445,40	314 454 000	ДБЯ, ТӨХ, СЭЗЯ
3	Дулааны IV цахилгаан станц (ДЦС-4)	119 377,0	9 022,9	128 399,90	44 655,8	16 653,2	61 509,00	66 890,90	668 909 000	ДБЯ, ТӨХ, СЭЗЯ
4	Дарханы Дулааны Цахилгаан Станц (ДДЦС)	10 033,9	975,5	11 009,40	7 205,3	821,48	8 026,70	2 982,70	29 827 000	ДБЯ, ТӨХ, СЭЗЯ
5	Эрдэнэтийн Дулааны Цахилгаан Станц (ЭДЦС)	9 790,5	2 110,6	11 901,10		548,1	548,10	11 353,00	113 530 000	ДБЯ, ТӨХ, СЭЗЯ
6	Төвийн Бүсийн Цахилгаан Дамжуулах Сүлжээ (ТБЦДС)	10 140,80		10 140,80			-	10 140,80	101 408 000	ДБЯ, ТӨХ, СЭЗЯ
7	Баруун Бүсийн Цахилгаан Дамжуулах Сүлжээ (ББЦДС)	4 885,6	962,5	5 848,10		10,9	10,90	5 837,20	58 372 000	ДБЯ, ТӨХ, СЭЗЯ
8	Дорнод Бүсийн Цахилгаан Дамжуулах Систем (ДБЦДС)	16 457,4	1 280,4	17 737,80	7 720,1	317,1	8 037,20	9 700,60	97 006 000	ДБЯ, ТӨХ, СЭЗЯ
9	Улаанбаатарын Цахилгаан Түгээх Сүлжээ (УБЦТС)	7 409,0	7 087,9	14 496,90		53,8	53,80	14 443,10	144 431 000	ДБЯ, ТӨХ, СЭЗЯ
10	Дархан Сэлэнгийн Цахилгаан Түгээх Сүлжээ (ДСЦТС)	1 149,6	2 892,3	4 041,92		34,2	34,20	4 007,72	40 077 200	ДБЯ, ТӨХ, СЭЗЯ
11	Эрдэнэт Булганы Цахилгаан Түгээх Сүлжээ (ЭБЦТС)	4 413,7	2 619,7	7 033,40		16,8	16,80	7 016,60	70 166 000	ДБЯ, ТӨХ, СЭЗЯ
12	Багануур-Зүүн Өмнөд бүсийн ЦТС (БНЗӨБЦТС)	5 541,9	1 615,7	7 157,60		58,1	58,10	7 099,50	70 995 000	ДБЯ, ТӨХ, СЭЗЯ
13	Улаанбаатарын Дулаан Дамжуулах Сүлжээ (УБДДС)	29 796,0	2 375,5	32 171,50	12 950,8	6,4	12 957,20	19 214,30	192 143 000	ДБЯ, ТӨХ, СЭЗЯ
14	Дарханы Дулаан Дамжуулах Сүлжээ (ДДДС)	964,4	279,6	1 244,00		8,1	8,10	1 235,90	12 359 000	ДБЯ, ТӨХ, СЭЗЯ
15	Налайхын Дулааны станц (НДС)	1 226,9	637,6	1 864,50		149,2	149,20	1 715,30	17 153 000	ДБЯ, ТӨХ, СЭЗЯ
16	Багануурын Дулааны Станц (БНДС)	4 336,4	782,4	5 118,80		371,0	371,00	4 747,80	47 478 000	ДБЯ, ТӨХ, СЭЗЯ
17	Даланзадгадын Дулааны Цахилгаан Станц (ДЗДЦС)	17 677,7		17 677,70	5 598,1	2 65	600,70	12 077,00	120 770 000	ДБЯ, ТӨХ, СЭЗЯ
18	Эрчим Хүчний Диспетчерийн Үндэсний Төв (ДҮТ)	1 312,70	-	1 312,70	-	-	-	1 312,70	13 127 000	ДБЯ, ТӨХ, СЭЗЯ
	Дүн	329 954,2	35 737,2	365 691,4	127 913,4	25 727,4	153 640,8	212 050,6	2 120 506 200	

* Энэхүү шилжих хөрөнгийн тооцоог 2001 оны эхний хагас жилийн тайлан тэнцлийн дүнгээр тодотгоно.

Тайлбар:

Засгийн газрын 2001 оны 164 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт

ЗАСГИЙН ГАЗРЫН ХҮЧИНГҮЙ БОЛГОХ ТОГТООЛЫН ЖАГСААЛТ

1. "Дулаацуулах байгуулалтыг хүлээж авахтай холбогдсон зарим арга хэмжээний тухай" Сайд нарын Зөвлөлийн 1959 оны 9 дүгээр сарын 9-ний өдрийн 367 дугаар тогтоол.

2. "Толгойтын цахилгаан станцын бэлтгэл ажлыг хангах тухай" Сайд нарын Зөвлөлийн 1961 оны 3 дугаар сарын 8-ны өдрийн 107 дугаар тогтоол.

3. "Эрдэнэтийн дулааны цахилгаан станцыг ашиглалтад оруулахтай холбогдсон зарим арга хэмжээний тухай" Сайд нарын Зөвлөлийн 1985 оны 7 дугаар сарын 5-ны өдрийн 177 дугаар тогтоол.

4. "Төрийн өмчит үйлдвэрийн газар байгуулах тухай" Засгийн газрын 2000 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн 159 дүгээр тогтоол.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 7 дугаар сарын 9-ний өдөр **Дугаар 165** **Улаанбаатар хот**

Төрийн албан хаагчдын цалингийн талаар авах зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын 2001 оны төвлөрсөн төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар батalсан цалингийн санд багтаан төрийн албан хаагчдын цалинг нэмэгдүүлэх ээлжит арга хэмжээг 2001 оны 10 дугаар сарын 1-нээс авахаар тогтоосугай.

2. Энэ тогтоолын 1 дүгээр заалттай холбогдуулан Олон улсын валютын сантай хамтран хэрэгжүүлэх "Ядуурлыг бууруулах, өсөлтийг хангах" хөтөлбөрт заасан нөхцөлийн дагуу 40000 хүртэлх төгрөгийн цалинтай төрийн албан хаагчийн сарын цалинг дунджаар 3000 төгрөгөөр, 40000-аас дээш төгрөгийн цалинтай төрийн албан хаагчийн сарын цалинг дунджаар 2500 төгрөгөөр тус тус нэмэгдүүлэхээр тооцож, төрийн албан хаагчийн цалингийн сүлжээ, доод жишгийг шинэчлэн тогтоох талаар санал боловсруулж Засгийн газарт оруулах арга хэмжээ авахыг Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд Ш.Батбаяр, Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаан нарт даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН САЙД **Ч.УЛААН**

НИЙГМИЙН ХАМГААЛАЛ, ХӨДӨЛМӨРИЙН САЙД **Ш.БАТБАЯР**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 7 дугаар сарын 9-ний өдөр **Дугаар 166** **Улаанбаатар хот**

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн доод хэмжээг нэмэгдүүлэх тухай

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 30 дугаар зүйлийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Нийгмийн даатгалын сангаас олгох бүрэн тэтгэврийн доод хэмжээг 18850 төгрөгөөр шинэчлэн тогтоож, 2001 оны 10 дугаар сарын 1-нээс эхлэн мөрдүүлэх арга хэмжээ авахыг Санхүү,эдийн засгийн сайд Ч.Улаан, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд Ш.Батбаяр нарт даалгасугай.

2.Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх тухай" Засгийн газрын 2001 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн 88 дугаар тогтоолын 1 дүгээр зүйлийн "...бүрэн тэтгэврийн доод хэмжээг 10.6 хувиар ..." гэснийг 2001 оны 10 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН САЙД **Ч.УЛААН**

НИЙГМИЙН ХАМГААЛАЛ, ХӨДӨЛМӨРИЙН САЙД **Ш.БАТБАЯР**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 7 дугаар сарын 9-ний өдөр **Дугаар 167** **Улаанбаатар хот**

Халдварт өвчинтэй тэмцэх ажлыг эрчимжүүлэх тухай

Хүний дархлал хомсдолын вирусийн халдвар шинээр илэрсэнтэй холбогдуулан халдварт өвчинтэй тэмцэх ажлыг эрчимжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Хүний дархлал хомсдолын вирусийн халдвар эмнэлгийн багаж хэрэгслээр дамжин халдваралахаас сэргийлэхэй чиглэсэн судалгаа, үнэлгээний ажлыг 2001 оны 10 дугаар сард багтаан хийж, түүний мөрөөр шаардлагатай арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Эрүүл мэндийн сайд П.Нямдаваад даалгасугай.

2. Хүний дархлал хомсдолын вирусийн халдварын болон дархлалын олдмол хомсдол, бэлгийн замын халдварт өвчний өндөр эрсдэл бүхий бүлгийн хүмүүсийг энэ оны 10 дугаар сард багтаан холбогдох үзлэг шинжилгээнд хамруулах, бэлгийн замын халдварт өвчин илрэгсдийг эмчилж эрүүлжүүлэх арга хэмжээ авч дүнг Дархлалын олдмол хомсдол өвчнөөс сэргийлэх үйл ажиллагаат зохицуулах Үндэсний хороонд ирүүлэхийг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Хүний дархлал хомсдолын вирусийн халдвар, дархлалын олдмол хомсдол, бэлгийн замын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэхтэй холбогдсон сэрэмжлүүлэг, сургалт, суртагчилгааг үндэсний радио, телевизээр сар тутам үнэ төлбөргүй нэвтрүүлэх арга хэмжээ авахыг Монголын радио, телевизийн Хэрэг эрхлэх газрын дарга Б.Ганболдод даалгасугай.

4. Хүний дархлал хомсдолын вирусийн халдвар, дархлалын олдмол хомсдол, бэлгийн замын халдварт өвчний оношилгоо, эмчилгээнд нэн шаардлагатай оношлуур,эм, багаж төхөөрөмж авахад зориулж Засгийн газрын нөөц хөрөнгөөс 77.3 /далан долоон сая гурван зуун мянган/ сая төгрөг гаргахыг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаанд зөвшөөрсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД **П.НЯМДАВАА**

САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН САЙД **Ч.УЛААН**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 7 дугаар сарын 18-ны өдөр **Дугаар 169** **Улаанбаатар хот**

Бэлэн байдлын зэрэг,хорио цээрийн дэглэмийг цуцлах тухай

Мал эмнэлэг, хүнсний аюулгүй байдал, хөдөө аж ахуйн улсын хяналтын байгууллагын мэргэжилтнүүдээс гаргасан санал, дүгнэлтийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Сэлэнгэ аймгийн Шаамар, Ерөө, Жавхлант, Дархан-Уул аймгийн Орхон сумын нутгийн захиргааны болон хууль хяналтын бүх шатны байгууллага, аж ахуйн нэгж, иргэний хамгаалалтын албадад дагаж мөрдүүлж байгаа иргэний хамгаалалтын өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэг, хорио цээрийн хязгаарлалтын дэглэмийг 2001 оны 8 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн цуцлахаар тогтоосугай.

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Гоц халдварт өвчний цагийн байдалтай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2001 оны 7 дугаар сарын 4-ний өдрийн 149 дүгээр тогтоолын 1 дүгээр зүйлийн "а" заалт, 2, 3 дугаар зүйлийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙД **Ж.ГҮРРАГЧАА**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 7 дугаар сарын 18-ны өдөр **Дугаар 171** **Улаанбаатар хот**

Журам батлах тухай

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 13 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журам"-ыг

хавсралт ёсоор баталсугай.

2. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санг бүрдүүлж, хөдөлмөр эрхлэлтийг дээшлүүлэх арга хэмжээнд зарцуулан хяналт тавьж ажиллахыг Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд Ш.Батбаяр, Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаан, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

НИЙГМИЙН ХАМГААЛАЛ, ХӨДӨЛМӨРИЙН САЙД Ш.БАТБАЯР

Засгийн газрын 2001 оны 171 дүгээр тогтоолын хавсралт

ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ САНГ БҮРДҮҮЛЭХ, ЗАРЦУУЛАХ, ХЯНАЛТ ТАВИХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан /цаашид "сан" гэх/-гийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, түүнд хяналт тавих үйл ажиллагаанд энэхүү журмыг дагаж мөрдөнө.

2. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгө нь хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, шинээр ажлын байр бий болгох, ажилгүй иргэдэд хөдөлмөр эрхлэх боломжийг бүрдүүлэхэд чиглэгдсэн арга хэмжээнд зориулагдана.

3. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн орлогыг төвлөрүүлэх, уг сангаас хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаат зохион байгуулан санхүүжүүлэх, гүйцэтгэлийг тайлагнах үүргийг хөдөлмөр эрхлэлтийн төв болон орон нутгийн алба гүйцэтгэнэ.

4. Энэхүү журмын хэрэгжилт болон сангийн бүрдүүлэлт, санхүүжилт, сангийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулах асуудлыг Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам хариуцна.

Хоёр. Сангийн бүрдүүлэлт

5. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгө нь дор дурдсан эх үүсвэрээс бүрдэнэ:

5.1. Улсын Их Хурлаар батлагдсан тухайн жилийн улсын төвлөрсөн төсвийн орлогоос хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд хуваарилсан хөрөнгө;

5.2. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас орон нутгийн тухайн жилийн төсвийн орлогоос хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд хуваарилсан хөрөнгө;

5.3. Ажилгүйдлийн даатгалын шимтэлийн орлогоос хуулийн дагуу олгох тэтгэмж болон сургалтын зардалд зориулсан хөрөнгө;

5.4. Сангийн чөлөөт үлдэгдлийг банкинд хадгалуулсны хүүгийн орлого;

5.5. Олон улсын байгууллага, бусад орноос олгосон зээл, тусламжийн хөрөнгө;

5.6. Олон улсын байгууллага, гадаад орон, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдээс санд оруулсан хандивын хөрөнгө;

5.7. Гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авч ажиллуулсны төлбөр;

5.8. Жижиг зээлийн хүүгийн орлого;

5.9. Бусад эх үүсвэр.

Гурав. Сангийн хөрөнгийн төлөвлөлт, санхүүжилт

6. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан нь мөнгөн сан байх бөгөөд улсын хэмжээний төвлөрсөн сан, орон нутгийн дэд сантай байна.

7. Орон нутгийн төсвөөс дэд санд олгох хөрөнгийн хэмжээг аймаг, нийслэл, дүүргийн Засаг дарга тухайн орон нутгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлнэ.

Орон нутгийн хөдөлмөр эрхлэлтийн алба дэд сангийн орлого, зарлагыг төлөвлөж, жил бүрийн 8 дугаар сарын 1-ний дотор Хөдөлмөр эрхлэлтийн газарт ирүүлнэ.

8. Хөдөлмөр эрхлэлтийн газар нь улсын төвлөрсөн төсвөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төвлөрсөн санд олгох хөрөнгийн хэмжээ болон сангийн орлого, зарлагыг төлөвлөж, жил бүрийн 8 дугаар сарын 10-ны дотор Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яаманд хүргүүлнэ.

9. Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам нь хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төвлөрсөн санд жил бүр улсын төсвөөс олгох хөрөнгийн хэмжээ болон сангийн орлого, зарлагын жилийн төлөвлөгөөг хянан үзэн улсын хэмжээгээр нэгтгэж, Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн саналыг тусган жил бүрийн 8 дугаар сарын 15-ны дотор Санхүү, эдийн засгийн яаманд хүргүүлнэ.

10. Сангийн хөрөнгийн зарлагыг төлөвлөхдөө Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 9 дүгээр зүйлд заасан сургалтын зардалд сангийн хөрөнгийн нийт орлогын 20 хүртэл, мөн хуулийн 10 дугаар зүйлд заасан жижиг зээл олгох арга хэмжээнд 30 хүртэл, 12 дугаар зүйлд заасан нийтийг хамарсан ажил зохион байгуулахад 15 хүртэл хувийг тус тус зарцуулахаар тооцно.

11. Санхүү, эдийн засгийн яам сангийн орлого, зарлагыг хянаж жил бүрийн төсвийн төлөвлөгөөнд тусгана.

12. Улсын Их Хурлын чуулганаар батлагдан улсын төвлөрсөн төсвөөс олгох хөрөнгийг орлогын гүйцэтгэлтэй уялдуулан улирал бүр санхүүжүүлэх бөгөөд санд олгох хөрөнгө нь жилийн дунгэвэр төлөвлөсөн хэмжээнээс хэтрэхгүй байна. Тухайн жилд дутуу хийгдсэн санхүүжилтийн хөрөнгийг дараа онд нөхөн олгоно.

13. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн тухайн жилийн орлого, зарлагын төсөв, сангийн хагас жилийн болон жилийн төсвийн тайланг Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлөөр хэлэлцүүлэн хөдөлмөрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

Дөрөв. Сангийн зарцуулалт

14. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд заасны дагуу хөдөлмөрийн зах зээлийн харилцаанд оролцогч ажилгүй иргэн, ажил хайгч, ажилгүйдэлд өртөж болзошгүй иргэн, ажил ологч, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, төсөл санаачлагч иргэд нь хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас санхүүжилт авах болзол, нөхцөлийг хангасан тохиолдолд энэхүү журам болон Засгийн газраас батагдсан бусад журмын дагуу холбогдох дэмжлэгийг авч болно.

15. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих улсын хэмжээний сангийн тухайн жилийн орлогын хөрөнгө /ажилгүйдлийн даатгалын шимтгэлийн орлогоос орсон хөрөнгийг тооцохгүйгээр/-ийг дор дурдсанаар хуваарилан зарцуулна:

15.1. Мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөлгөө өгөх, мэдээллээр хангах, ажилд зуучлах үйлчилгээнд;

15.2. Ажилгүйдлийн даатгалд хамрагдаагүй иргэнийг мэргэжил олгох, давтан сургалтад хамруулах үйлчилгээнд;

15.3. Хувиараа хөдөлмөр эрхлэх хүсэлтэй иргэнийг аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх арга барил, ур чадвар эзэмшүүлэх сургалтад хамруулах үйлчилгээнд;

15.4. Хувиараа болон нөхөрлөл, хоршооны хэлбэрээр хөдөлмөр эрхлэх иргэн, аж ахуйн нэгжид жижиг зээл олгох арга хэмжээнд;

15.5. Ажил олгогчийг дэмжих арга хэмжээнд;

15.6. Нийтийг хамарсан ажил зохион байгуулах арга хэмжээнд;

15.7. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хууль тогтоомжид заасан бусад үйлчилгээ, арга хэмжээний зардалд.

16. Ажилгүйдлийн даатгалын шимтгэлийн орлогоос санд төвлөрсөн хөрөнгийг Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай хуульд заасны дагуу зарцуулна.

17. Олон улсын байгууллага, хандивлагч орноос олгосон зээл, тусламжийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулж тайлагнана.

18. Сангаас орон нутагт хуваарилах хөрөнгийн хэмжээг хөдөлмөр эрхлэлтийн төв байгууллагын саналыг үндэслэн Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам улиралаар хуваарилан батална, үүнд хуваарийг Санхүү, эдийн засгийн яаманд жил бүрийн 1 дүгээр сард багтаан хүргүүлж байна.

19. Хөдөлмөр эрхлэлтийн төв байгууллага нь хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийг батлагдсан хуваарийн дагуу аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн албанд дараахь байдлаар хуваарилна:

19.1. Улсын төвлөрсөн болон орон нутгийн төсөөс хуваарилсан хөрөнгийг:

а/хөдөлмөр эрхлэлтийн албаас ажилгүй иргэнд мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөлгөө өгөх, мэдээллээр хангах үйлчилгээг хэсэг, бүлгээр зохион байгуулахтай холбогдсон зардалд /мэргэжлийн байнгын ажлын хөлс, ажлын байрны талаарх захиалга, мэдээлэл, ажил мэргэжлийн тодорхойлолт, техник хэрэгсэл, зураг худдас, гарын авлага хэвлүүлэх зардал/;

б/ажилд зуучлахад /ажилтнуудын хотын доторхи тээвэр,холбооны зардал, зарлал, сурталчилгаа, ажилгүйчүүдийн хувийн хэрэг,анкет,холбогдох бичиг баримт, маягтын зардал/;

в/мэргэжил олгох, давтан сургалтад хамруулах сургалтын зардалд /хугацаат цэргийн албанаас халагдсан болон өрөнхий боловсролын 8, 10 дугаар анги төгсөөд ажил, сургуульгүй байгаа, нийгмийн даатгалд хамрагдаагүй, мэргэжилгүй, эсхүл мэргэжлийн ур чадвар доогуур, хүн амын эмзэг бүлэгт хамрагдах иргэд, хувиараа хөдөлмөр эрхлэх, аж ахуйн үйл ажиллагаа явуулах арга барил, ур чадвар эзэмшүүлэх сургалтад хамрагдах хүсэлтэй иргэдийн сургалтын зардал/;

г/нийтийг хамарсан ажилд /төсөвт өртгийн дагуу/;

д/хувиараа болон нөхөрлөл, хоршооны хэлбэрээр аж ахуй эрхлэх иргэнд жижиг зээл олгоход тус тус зарцуулна.

19.2. Гадаад орон, олон улсын байгууллагаас олгосон зээл, тусламж, сангийн чөлөөт үлдэгдлийг банкинд хадгалуулсны хүү, ажлын байры төлбөр, аж ахуйн нэгж, байгууллага, иргэнээс өргөсөн хандив, тусламжийг:

а/Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан нөхцөлийг хангасан ажил олгогчид олгох сургалтын зардалд;

б/мөн хуулийн 11 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан нөхцөлийг хангасан ажил олгогчид олгох сургалтын зардалд;

в/мөн хуулийн 11 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасан нөхцөлийг хангасан ажил олгогчид сургалтын болон цалингийн дэмжлэг үзүүлэх зардалд;

г/хөдөлмөр эрхлэлтийн албадын материаллаг баазыг бэхжүүлэх, ажилтнуудын мэдлэг,мэргэшлийг дээшлүүлэх сургалт, семинар зохион байгуулахад тус тус зарцуулна.

20. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 9, 11 дүгээр зүйлд заасан хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ, арга хэмжээнд шаардагдах зардлыг олгохоо дор дурдсан бичиг баримтыг бүрдүүлсэн байна:

20.1. Хуулийн 9.1.1-д заасан иргэн:

-тухайн иргэний ам бүлийн талаарх баг, сум, хорооны Засаг даргын тодорхойлолт;

-тухайн иргэний ам бүлийн орлогын тодорхойлолт;

-хувийн өргөдөл.

20.2. Хуулийн 9.1.2-т заасан иргэн:

-эзэмшсэн мэргэжлээрээ ажиллах орон тоонь цомхотгогдсон тухай ажил олгогчийн шийдвэрийн хувь;

-мэргэжлээ өөрчлөх шаардлагатай байгаа тухай хөдөлмөр зохицлтийн албаны дүгнэлт;

-хувийн өргөдөл.

20.3. Хуулийн 9.1.3-т заасан иргэн:

-мэргэжлээс шалтгаалсан өвчний тухай мэргэжлийн байгууллагын магадалгаа;

-хувийн өргөдөл.

20.4. Хуулийн 9.1.4-т заасан иргэн:

-ажил олгогчийн тодорхойлолт;

-хувийн өргөдөл.

20.5. Хуулийн 9.1.5-д заасан иргэн:

-тухайн онд 8,10 дугаар анги төгссөн гэрчилгээ;

-хугацаат цэргийн албанаас халагдсан тухай цэрэг,

иргэний хамгаалалтын хэлтсийн тодорхойлолт;

-ажил болон сургуульгүй байгаа тухай баг, хороо, сумын Засаг даргын тодорхойлолт.

20.6. Хуулийн 9 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт дурдсан үйлчилгээнд хамрагдах иргэн:

-жижиг зээл олгох тухай хөдөлмөр зохицлтийн албаны шийдвэр;

-сургалтад хамруулах тухай хөдөлмөр зохицлтийн албаны дүгнэлт;

-хувийн өргөдөл.

20.7. Хуулийн 11 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт дурдсан арга хэмжээнд хамрагдах ажил олгогч:

-тухайн иргэний ажилгүй байсан хугацааны тухай хөдөлмөр зохицлтийн албаны тодорхойлолт;

-байгууллагын үйл ажиллагааны талаар холбогдох татварын албаны тодорхойлолт;

-шимтгэл төлөлтийн талаар нийгмийн даатгалын байгууллагын тодорхойлолт;

-тухайн иргэнийг ажилд авсан шийдвэр,хөдөлмөрийн гэрээ;

-тухайн иргэний нийгмийн даатгалын дэвтэр;

-хүсэлт тавьсан тухайн байгууллагын албан бичиг.

20.8. Хуулийн 11 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт дурдсан арга хэмжээнд хамрагдах ажил олгогч:

-хөдөлмөр зохицлтийн албатай байгуулсан гэрээ;

-тухайн иргэнийг ажилд авсан шийдвэр,хөдөлмөрийн гэрээ;

-тухай иргэний нийгмийн даатгалын дэвтэр;

-мэргэжил эзэмшсэн тухай үнэмлэх, гэрчилгээ;

-хүсэлт тавьсан тухайн байгууллагын албан бичиг.

20.9. Хуулийн 11 дүгээр зүйлийн 3-т дурдсан арга хэмжээнд хамрагдах ажил олгогч:

-хөдөлмөрийн гэрээ цуцлах мэдэгдэл;

-тухайн иргэнийг шинэ ажлын байранд томилсон шийдвэр, хөдөлмөрийн гэрээ;

-тухай иргэний нийгмийн даатгалын дэвтэр;

-мэргэжил эзэмшсэн тухай үнэмлэх, гэрчилгээ;

-орон тоо цомхотгох болсон тухай шийдвэрийн хувь;

-хүсэлт тавьсан тухайн байгууллагын албан бичиг.

21. Улсын хэмжээний сангийн харилцах дансны 1 дүгээр болон 2 дугаар гарын үсгийг Хөдөлмөр зохицлтийн газрын дарга, сан хариуцсан нягтлан бодогч, орон нутгийн дэд сангийн харилцах дансны 1 дүгээр болон 2 дугаар гарын үсгийг Хөдөлмөр зохицлтийн албаны дарга, нягтлан бодогч зурна.

22. Жилийн эцэст харилцах дансанд зарцуулагдаагүй үлдсэн хөрөнгийг дараа жилд шилжүүлэн зарцуулж болно.

23. Сангийн хөрөнгийг энэ журмын 15 дугаар заалтад зааснаас бусад зориулалтаар ашиглахыг хориглоно.

Тав. Сангийн хөрөнгийн зарцуулалтад тавих хязгаалт, тайлан

24. Хөдөлмөр зохицлтийг дэмжих үйл ажиллагаанд хамрагдагсдыг бүртгэх, сангаас олгох хөрөнгийн хэмжээг тодорхойлох, тогтоосон хугацаанд олгох, хязгаалт тавих, зохион байгуулах үүргийг орон нутгийн хөдөлмөр зохицлтийн албад гүйцэтгэнэ.

25. Хөдөлмөр зохицлтийг дэмжих сангийн зарцуулалтад дараахь байдлаар хязгаалт тавина:

25.1. Улсын хязгаалтыг Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам, Санхүүгийн улсын хязгаалшалгалтын газар, Төрийн хязгаалшалгах хороо, Хөдөлмөр, нийгмийн хамгаалалын улсын хязгаалтыг албад тус тусын эрх хэмжээний дагуу;

25.2. Орон нутагт улсын хязгаалтыг эдгээр байгууллагын харьяа орон нутгийн албад хэрэгжүүлнэ.

26. Хөдөлмөр зохицлтийг дэмжих сангийн орлого, зарлагын тайланг дор дурдсан хугацаанд гаргана:

26.1. Улирлын тайланг сумын хөдөлмөрийн асуудал зохицсэн ажилтан дараа улирлын эхний сарын 5-ны дотор аймгийн хөдөлмөр зохицлтийн албанд, аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр зохицлтийн албад дараа улирлын эхний сарын 15-ны дотор хөдөлмөр зохицлтийн төв байгууллагад тус тус ирүүлнэ.

26.2. Хөдөлмөр зохицлтийн төв байгууллагань улирлын нэгдсэн тайланг дараа улирлын хоёрдахь сарын 5-ны дотор, жилийн эцсийн тайланг дараа оны 2 дугаар сарын 15-ны дотор тус тус гаргаж Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам, Санхүү, эдийн засгийн яаманд хүргүүлнэ.



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 39 (226)

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ:

- *Д.Мөнхтуулыг Улсын дээд шүүхийн шүүгчээр томилох тухай*
- *Элчин сайдыг эгүүлэн татах, томилох тухай*

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ:

- *Чанга дэглэмтэй хорих анги байгуулах тухай*
- *Монгол Улсад Шинжлэх ухааны байгууллага үүсч хөгжсөний 80 жилийн ойг тэмдэглэхэд дэмжлэг үзүүлэх тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар

Улаанбаатар хот
2001 он

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот 2001 оны аравдугаар сарын 8 №39 (226)

Гарчиг

Нэг. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

459. Г.В.Ефимовыг "Найрамдал" медалиар шагнах тухай Дугаар 33 933
460. Д.Мөнхтуулыг Улсын дээд шүүхийн шүүгчээр томилох тухай Дугаар 55 934
461. Элчин сайдыг эгүүлэн татах, томилох тухай Дугаар 56 934

Хоёр. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

462. Журам батлах тухай Дугаар 174 934
463. Монгол Улсад залуучуудын байгууллага үүсч хөгжсөний 80 жилийн ойг тэмдэглэхэд дэмжлэг үзүүлэх тухай Дугаар 177 938
464. Чанга дэглэмтэй хорих анги байгуулах тухай Дугаар 178 938
465. Хөтөлбөрийн заалтад өөрчлөлт оруулах тухай Дугаар 179 938
466. Монгол Улсад Шинжлэх ухааны байгууллага үүсч хөгжсөний 80 жилийн ойг тэмдэглэхэд дэмжлэг үзүүлэх тухай Дугаар 180 939
467. Техникийн Их Сургуулийн талаар авах зарим арга хэмжээний тухай Дугаар 181 939
468. Аймаг, нийслэлийн хүүхдийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвийн анхан шатны ангийн болон дотуур байрны нэг хүүхдэд ногдох хувьсах зардлын дундаж хэмжээг шинэчлэн тогтоох тухай Дугаар 182 940
469. Хөтөлбөр батлах тухай Дугаар 183 941
470. Хөрөнгө гаргах тухай Дугаар 184 944
471. Худалдаа хөгжлийн банкны төрийн эзэмшлийн хувьцааг худалдах тухай Дугаар 185 945

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2001 оны 8 дугаар сарын 16-ны өдөр **Дугаар 33** **Улаанбаатар хот**

Г.В.Ефимовыг "Найрамдал" медалиар шагнах тухай

Физикийн шинжлэх ухааны хамтын ажиллагааг хөгжүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж ОХУ-ын Дубна хотын Цөмийн шинжилгээний нэгдсэн институтын Онолын физикийн лабораторийн эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан Гарий Владимирович Ефимовыг "Найрамдал" медалиар шагнасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ **Н.БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2001 оны 9 дүгээр сарын 20-ны өдөр **Дугаар 55** **Улаанбаатар хот**

Д.Мөнхтуулыг Улсын дээд шүүхийн шүүгчээр томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн тавин нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэг, "Шүүхийн тухай" хуулийн 6 дугаар зүйлийн 3, 51 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг тус тус баримтлан, Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн ЗАРЛИГ болгох нь:

Даваахүүгийн Мөнхтуулыг Нийслэлийн Хан-Уул дүүргийн шүүхийн шүүгч, ерөнхий шүүгчээс чөлөөлж, Монгол Улсын дээд шүүхийн шүүгчийн албан тушаалд томилсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ **Н.БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2001 оны 9 дүгээр сарын 24-ний өдөр **Дугаар 56** **Улаанбаатар хот**

Элчин сайдыг эгүүлэн татах, томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5, Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг баримтлан ЗАРЛИГ болгох нь:

1. Монгол Улсаас Япон Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Содовжамцын Хүрэлбаатарыг эгүүлэн татсугай.

2. Монгол Улсаас Япон Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Замбын Батжаргалыг томилсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ **Н.БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 7 дугаар сарын 18-ны өдөр **Дугаар 174** **Улаанбаатар хот**

Журам батлах тухай

Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 5, 14 дүгээр зүйл, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Согтууруулах ундааны үйлдвэрийн төсөл сонгон шалгаруулж зөвшөөрөл олгох, үйлдвэрлэлд хяналт тавих журам"-ыг хавсралт ёсоор батална, 2002 оны 1 дүгээр сарын 1-нээс эхлэн мөрдүүлсүгэй.

2. Согтууруулах ундааны үйлдвэрлэл эрхэлдэг аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд хяналт тавих үүрэг бүхий ажлын хэсгийг улсын байцаагчийн эрх бүхий мэргэжлийн хүмүүсийн бүрэлдэхүүнтэйгээр байгуулж, энэ чиглэлээр байнгын хяналт тавьж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт, согтууруулах ундаа үйлдвэрлэх, худалдах, түүгээр үйлчлэх үйл ажиллагаа эрхлэж буй аж ахуйн нэгжийг жил тутам аттестатчилан, аймаг, нийслэлийн мэргэжлийн хяналтын байгууллагын ажилд үнэлэлт өгч байхыг Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдорж, Хүнс, хөдөө аж ахуйн сайд Д.Насанжаргал, Үйлдвэр, худалдааны сайд Ч.Ганзориг нарт тус тус даалгасугай.

3. Спирт, согтууруулах ундааны үйлдвэрлэлийн улсын стандартыг 2001 онд багтаан боловсруулж батлуулан, энэ төрлийн үйлдвэрлэлийн түүхий эд, бэлэн бүтээгдэхүүний урсгал шугамыг тоолууржуулах ажлыг 2002 онд багтаан зохион байгуулахыг Хүнс, хөдөө аж ахуйн сайд Д.Насанжаргал, Үйлдвэр, худалдааны сайд Ч.Ганзориг нарт үүрэг болгосугай.

4. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Журам батлах тухай" Засгийн газрын 1997 оны 9 дүгээр сарын 22-ны өдрийн 195 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН САЙД **Д.НАСАНЖАРГАЛ**

Засгийн газрын 2001 оны 174 дүгээр тогтоолын хавсралт

СОГТУУРУУЛАХ УНДААНЫ ҮЙЛДВЭРИЙН ТӨСӨЛ СОНГОН ШАЛГАРУУЛЖ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ, ҮЙЛДВЭРЛЭЛД ХЯНАЛТ ТАВИХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1 дэх заалт, 5, 14 дүгээр зүйл, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 4 дүгээр заалтад заасны дагуу согтууруулах ундааны үйлдвэрийн төсөл сонгон шалгаруулж зөвшөөрөл олгох, үйлдвэрлэлд хяналт тавихад энэхүү журмыг мөрдөнө.

2. Олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол Монгол улсын нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулах гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж, олон улсын болон гадаадын үйлдвэрийн газарт энэ журам нэгэн адил хамаарна.

Хоёр. Сонгон шалгаруулах журам

3. Хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тухайн жилд зөвшөөрөл олгох аж ахуйн нэгж, байгууллагын тоо, байршил, үйлдвэрлэлийн хүчин чадал, сонгон шалгаруулах хугацааг согтуурулах ундааны хэрэгцээ, аймаг, нийслэлийн Засаг даргын саналыг харгалзан жил бүрийн 1 дүгээр сард тогтоож зарлана.

4. Согтуурулах ундааны үйлдвэрлэл шинээр эрхлэх зөвшөөрлийг аж ахуйн нэгж, байгууллагад төсөл сонгон шалгаруулах үндсэн дээр олгох бөгөөд төсөлд дараахь нөхцөл, шаардлагыг тусгасан байна.

4.1. Зах зээлд өрсөлдөх чадвартай шинэ нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд чиглэсэн дэвшилтэт технологи нэвтрүүлэхээр байх.

4.2. Согтуурулах ундааны үйлдвэр байгуулах зургийн даалгавар, эдийн засгийн үндэслэл, үр ашгийн тооцоог боловсруулсан байх

4.3. Үйлдвэрийн зураг төсөл боловсруулахад шаардагдах техникийн нөхцлийг бэлэн болгосон байх, Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах тухай хуулийн дагуу хэмжил зүйн экспертиз хийлгэсэн байх

4.4. Исгэлтийн үйлдвэрлэлийн технологич, мэргэшсэн ажилчидтай байх

4.5. Үйлдвэрийн дотоод дүрэм, бүтээгдэхүүн үйлдвэрлэх технологийн заавар, хөдөлмөр хамгаалал, галын аюулгүй байдлыг хангах дүрмийн төслийг бэлтгэсэн байх

4.6. Үйлдвэрлэл явуулах байр нь эрүүл ахуй, ариун цэвэр, техникийн болон галын аюулгүйн дүрмийн шаардлага хангасан байх, энэ талаар мэргэжлийн хяналтын байгууллагуудын санал, дүгнэлт авсан байх

4.7. Түүхий эд, бүтээгдэхүүний чанарт физик, химийн,микробиологийн иж бүрэн шинжилгээ хийх лабораторитай байгуулах шаардлагыг хангасан байх

4.8. Үйлдвэрлэх бүтээгдэхүүний 20-иос доошгүй хувийг жижиглэн /250 гр, түүнээс бага хэмжээгээр/ савлах нөхцөл бүрдүүлэх, шошигны загварыг стандартад заасны дагуу боловсруулж, түүнд согтуурулах ундааг хэтрүүлэн хэрэглэснээс гарч болох хор хөнөөл, хэрэглээний соёлын талаарх санамж тусгасан байх

4.9 Тухайн аж ахуйн нэгж, байгууллагад харьяалагдах татварын албаны тодорхойлолт

5. Аж ахуйн нэгж, байгууллага нь согтуурулах ундааны үйлдвэрлэл эрхлэх сонгон шалгаруулалтанд оролцох тухай хүсэлтээ тухайн аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газарт гаргах бөгөөд энэхүү журмын 4-т заасан шаардлагыг тусгасан төслийг хавсаргасан байна.

6. Хүсэлт, төслийн материалыг аймаг нийслэлийн Засаг даргын Тамгын газар хүлээн авч, мэргэжлийн хэсэг томилон урьдчилсан сонгон шалгаруулалт хийж, зөвшөөрөл гаргуулах шаардлагатай гэж үзсэн материалыг аймаг, нийслэлийн Засаг даргын саналын хамт хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад жил бүрийн нэгдүгээр улиралд багтаан ирүүлнэ.

7. Дээрх материалыг хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хүлээн авч Санхүү, эдийн засгийн, Хууль зүй, дотоод хэргийн, Хүнс, хөдөө аж ахуйн сайдын хамтарсан шийдвэрээр ажлын хэсэг томилон сонгон шалгаруулах нөхцөл, согтуурулах ундааны орон нутгийн хэрэгцээ хангалтын бодлого аж ахуйн нэгж байгууллагын үйлдвэрлэл эрхлэх нөхцөл шаардлага, шалгуурыг үндэслэн сонгон шалгаруулалт хийж, дүгнэлт санал гаргана.

8. Ажлын хэсгийн дүгнэлт, саналыг үндэслэн аж ахуйн нэгж, байгууллагад согтуурулах ундааны үйлдвэрлэл эрхлэх зөвшөөрөл олгох асуудлыг Хүнс, хөдөө аж ахуйн сайд, Засгийн газрын хуралдаанд оруулж шийдвэрлүүлнэ.

Гурав. Шинээр үйлдвэрлэл эрхлэгчийн хэрэгжүүлэх үйл ажиллагаа

9. Соггууруулах ундааны үйлдвэрлэл эрхлэх зөвшөөрөл авсан аж ахуйн нэгж, байгууллага нь доорхи үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

9.1. Зургийн даалгаврын дагуу зураг төсөл хийлгэж, холбогдох мэргэжлийн хяналтын байгууллагаар хянуулан, үйлдвэрийн барилгыг барьж байгуулах, ашиглалтад бэлэн болгох;

9.2. Ажиллагсдыг сургаж дадлагажуулах, мэргэжлийн заавар, зөвлөмж өгөх, эрүүл мэндийн үзлэгт оруулах, хүнсний үйлдэрлэлийн ариун цэвэр, аюулгүй ажиллаагааны дүрэм, заавартай танилцуулах;

9.3. Үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийг угсрах, лобаратори байгуулах, даралтат сав, хэмжих хэрэгслийг шалгуулж баталгаажуулах;

9.4. Үйлдвэрлэлийн туршилт явуулах;

9.5. Туршилтаар үйлдвэрлэсэн соггууруулах ундаа, түүхий эд /спирт, зөөлрүүлсэн ус, улаан буудай, арвайн соёолж/-ийг итгэмжлэгдсэн лабораториор шинжлүүлж холбогдох хяналтын байгууллагаар дүгнэлт гаргуулах;

9.6. Мэргэжлийн технологич ажиллуулж, түүхий эд хүлээн авахаас эхлэн бэлэн бүтээгдэхүүн гаргах хүртлэх технологийн үе шатанд чанарын хяналтын тогтолцоог бүрдүүлж, технологийн бүртгэл хөтлөх хэвшил;

9.7. Түүхий эд, бэлэн бүтээгдэхүүн болон лабораторийн шинжилгээнд мөрдөх улсын стандартыг бүрдүүлсэн байх.

10. Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага үйлдвэрийг ашиглалтад оруулах хүсэлтийг Хүнсний аюулгүй байдал, хөдөө аж ахуйн улсын хяналтын албанд тавина.

11. Хүнсний аюулгүй байдал, хөдөө аж ахуйн улсын хяналтын алба, Эрүүл мэндийн улсын хяналтын алба, Стандартчилал хэмжил зүйн үндэсний төв, тухайн аймаг, нийслэлийн мэргэжлийн хяналтын алба, гал түймэртэй төмцэх байгууллагатай хамтран үйлдвэрийн байр, техник технологийн байдал, түүхий эд, бүтээгдэхүүний чанар, нэр төрөл, лабораторийн нөхцөл, ариун цэвэр, эрүүл ахуй, хөдөлмөр хамгаалал, гаднаас аюулгүй байдлыг төслийн материалтай харьцуулан шалгаж, дүгнэлт санал гаргана.

12. Уг дүгнэлт, саналыг үндэслэн зохих шаардлага хангасан аж ахуйн нэгж,байгууллагад Хүнс, хөдөө аж ахуйн сайдын тушаалаар соггууруулах ундааны үйлдвэрлэл эрхлэх гэрчилгээ олгоно.

13. Гэрчилгээнд соггууруулах ундааны үйлдвэрлэл эрхлэх шийдвэр, байршил үйлдвэрлэх бүтээгдэхүүний нэр төрөл, бүтээгдэхүүний чанарын шинжилгээний дүгнэлт, үйлдвэрлэл эрхлэх хугацаат заана.

14. Соггууруулах ундааны үйлдвэрлэл эрхлэх гэрчилгээ авсан аж ахуйн нэгж, байгууллага нь баталгаажуулалтын тухай хуулийн 8, 11 дүгээр зүйлийн дагуу бүтээгдэхүүнээ Стандартчилал, чанарын баталгаажуулалтад хамруулж, зохих зөвшөөрөл, гэрчилгээ авсан байна.

15. Соггууруулах ундаа үйлдвэрлэх зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж, байгууллага нь байршилаа өөрчлөн тухайн хот, аймгаас өөр хот аймагт шилжих, өөрийн салбарыг шинээр нээн ажиллуулах тохиолдолд үйлдвэрлэл шинээр эрхлэгчийн нэгэн адил материал бүрдүүлж, энэхүү журмын хоёрдугаар бүлэгт заасны дагуу шийдвэрлүүлнэ.

16. Сүүн бүтээгдэхүүнээр шимийн архи үйлдвэрлэх эрх олгох, үйлдвэрлэлийн ажилгааnd хяналт тавих ажлыг аймаг, нийслэлийн Засаг дарга зохицуулна.

17. Соггууруулах ундааг үйлдвэрийн зөвшөөрөгдсөн байршлаас өөр газар савлах, бусдын шошго, нэр ашиглаж үйлдвэрлэл эрхлэхийг хориглоно.

Дөрөв. Хяналт тавих журам

18. Соггууруулах ундааны үйлдвэрлэл эрхэлж байгаа аж ахуйн нэгж, байгууллагын бүтээгдэхүүний чанар, стандартын мөрдөлт, лабораторийн болон үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд аймаг, нийслэл, сум, дүүргийн мэргэжлийн хяналтын улсын байцаагч нар байнын хяналт тавьж ажиллана.

19. Соггууруулах ундааны аюулгүйн болон чанарын хөндлөнгийн хяналтын бүрэн шинжилгээ / хими, микробиологи, хор судлал, хүнд металл/ итгэмжлэгдсэн лабораториудад улиралд хоёроос доошгүй удаа хийлгэж, эрх бүхий албан тушаалтнаар дүгнэлт гаргуулна. Шинжилгээний дээжийг мэргэжлийн хяналтын байцаагч газар дээр нь зохих жүрмын дагуу авна.

20. Аж ахуйн нэгж, байгууллага нь хандмал болон түсгай технологиор үйлдвэрлэх соггууруулах ундаа, цагаан архинд улсын стандартын үзүүлэлт, шаардлагыг өндержүүлсэн буюу дэлгэрүүсэн хэм хэмжээг заасан байгууллагын стандартыг батлуулж мөрдүүлсэн байна.

21. Соггууруулах ундааны үйлдвэр, цех нь байгууллагын дотоод хяналтыг бүтээгдэхүүний болон шинжилгээний аргын улсын стандартын хангалт мөрдөлт, лабораторийн шинжилгээгээр дамжуулан хэрэгжүүлнэ.

22. Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар аж ахуйн нэгж, байгууллагын жилийн үйл ажиллагааны тайлан, мэргэжлийн хяналтын улсын байцаагчийн хийсэн шалгалтын дүнг жил бүрийн эхний улиралд хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ирүүлж байна.

23. Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газраас томилогдсон мэргэжлийн хэсэг тухайн орон нутагт согтууруулах ундааны үйлдвэрлэл эрхэлж байгаа нийт аж ахуйн нэгж, байгууллагын үйлдвэрлэл эрхлэх эрхийн гэрчилгээний хугацаа дуусахаас нэг сарын өмнө техник, технологийн ажиллагаа, эрүүл ахуй, ариун цэвэр, бүтээгдэхүүний чанар, хөдөлмөр хамгаалал, галын аюулгүйн шаардлага, анхан шатны бүртгэл /технологийн болон лабораторийн журнал/ хөтлөлт, татвар төлөлт болон холбогдох хууль тогтоомжийн биелэлтийг шалгаж аттестатчилна.

24. Аттестатчилалын дүнг үндэслэн аж ахуйн нэгж, байгууллагын үйлдвэрлэл эрхлэх гэрчилгээний хугацаг сунгах эсэх тухай саналаа аймаг, нийслэлийн Засаг дарга хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ирүүлнэ. Энэ саналд дараахь бичиг баримтыг хавсаргасан байна.

24.1. Аттестатчилал явуулсан тухай ажлын хэсгийн акт, хурлын тэмдэглэл;

24.2. Стандартчилал хамжил зүйн төв, эрүүл мэндийн улсын хяналтын алба, гал түймэртэй тэмцэх байгууллагын шалгалтад оролцон байцаагчдын дүгнэлт;

24.3. Спиртийн татан авалт, зарцуулалт, зориулалт, онцгой албан татварын төлөлтийн талаар татварын албанаас шалгасан шалгалтын дүн;

24.4. Бүтээгдэхүүний чанарт хийсэн итгэмжлэгдсэн лабораторийн бүрэн шинжилгээ / хими, микробиологи, хүнд металл, хор судлалын үзүүлэлтээр/-ний дүн;

24.5. Аж ахуйн нэгж, байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээний болон согтууруулах ундааны үйлдвэрлэл эрхлэх гэрчилгээний хуулбар, жилийн ажлын тайлан;

24.6. Стандартчилал, хэмжил зүйн үндэсний төв, эрх бүхий чанарын баталгаажуулалт хийх лабораторийн олгосон зохих зөвшөөрөл, гэрчилгээний хуулбар.

25. Үйлдвэрлэлийг үргэлжлүүлэх хугацаг хүнсний асуудал эрхэлсэн сайдын тушаалаар сунгана.

26. Согтууруулах ундааны үйлдвэр эрхэлж байгаа аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааг аймаг, нийслэлийн мэргэжлийн хяналтын байгууллагууд хэрхэн хяналт тавьж, ямар үр дүнд хүрч байгаа талаар мэргэжлийн хяналтын улсын албад шалгаж, холбогдох арга хэмжээ авна.

Тав. Хариуцлага

27. Улсын байцаагч нь аж ахуйн нэгж, байгууллагын согтууруулах ундааны үйлдвэрлэл эрхлэх зөвшөөрлийг дараахь тохиолдолд хүчингүй болгох тухай саналыг хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад оруулна:

27.1. Согтууруулах ундааны үйлдвэрлэл эрхлэх гэрчилгээний хугацаат зохих журмын дагуу сунгуулалгүй үйлдвэрлэл эрхэлсэн;

27.2. Согтууруулах ундаа үйлдвэрлэх зөвшөөрлөө бусдад шилжүүлсэн;

27.3. Зөвшөөрөлд заагдсан үйлдвэрийн байршлыг дур мэдэн өөрчилсэн;

27.4. Согтууруулах ундааг хүнсний зориулатын бус түүхий эдээр болон зориулалтын биш төхөөрөмжөөр үйлдвэрлэсэн;

27.5. Технологийн горим, ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлага хангаагүй нөхцөлд үйлдвэрлэл явуулсан;

27.6. Үйлдвэрийн дотоодын болон хөндлөнгийн хяналтын шинжилгээгээр стандартын шаардлага хангаагүй бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн;

27.7. Онцгой албан татварын тэмдэгтүй архи худалдаанд нийлүүлсэн, хуурамч тэмдэг хэрэглэсэн буюу үйлдвэрлэх, худалдах, худалдан авах, хадгалах үйл ажиллагаанд оролцох, зохион байгуулах зэргээр Онцгой албан татварын тэмдгийн тухай хууль зөрчсэн;

27.8. Согтууруулах ундааг зөвшөөрсөн байршлаас өөр газар савлаган, бусдын шошго, нэр ашиглаж үйлдвэрлэл явуулсан.

28. Энэ дүгнэлт саналыг үндэслэн Хүнс, хөдөө аж ахуйн сайд аж ахуйн нэгж, байгууллагын согтууруулах ундааны үйлдвэрлэл эрхлэх зөвшөөрлийг хүчингүй болгох асуудлыг Засгийн газарт оруулж шийдвэрлүүлнэ.

29. Эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр согтууруулах ундаа үйлдвэрлэсэн бол үйлдвэрлэлийг зогсоож, холбогдох хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

30. Согтууруулах ундааны үйлдвэрлэл эрхлэх явцад зөрчил, дутагдал гарсан тохиолдолд эрх бүхий албан тушаалтан холбогдох хуулийн заалтын дагуу захиргааны арга хэмжээ ногдуулна.

31. Засгийн газрын шийдвэр гарснаас хойш архи, дарс, пивоны үйлдвэрлэл эрхлэлгүй 2 жил, спиртийн үйлдвэрлэл эрхлэлгүй 3 жилийн хугацаа өнгөрсөн аж ахуйн нэгж, байгууллагын согтууруулах ундаа үйлдвэрлэх зөвшөөрлийг хүчингүйд тооцно. Энэ тухай саналыг Хүнс, хөдөө аж ахуйн сайд Засгийн газарт оруулж шийдвэрлүүлнэ.

Зургаа. Бусад зүйл

32. Энэхүү журмыг мөрдөх явцад үйлдвэрлэгч нь зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллага, мэргэжлийн хяналтын болон захиргааны байгууллагуудын хяналт шалгалтын дүгнэлт, шийдвэрийг эс зөвшөөрвөл гомдлоо дээд шатны байгууллага буюу шүүхэд хандан тавьж болно.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 8 дугаар сарын 13-ны өдөр | **Дугаар 177** | **Улаанбаатар хот**

Монгол Улсад залуучуудын байгуллага үүсч хөгжсөний 80 жилийн ойг тэмдэглэхэд дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Монгол Улсад залуучуудын байгуллага үүсч хөгжсөний 80 жилийн ойн арга хэмжээнд зориулан 24650.0 (хорин дөрвөн сая зургаан зуун тавин мянган) мянган төгрөгийг Засгийн газрын нөөц хөрөнгөөс гаргахыг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаанд зөвшөөрсүгэй.

2. Монгол Улсад залуучуудын байгуллага үүсч хөгжсөний 80 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэхэд зохион байгуулалтын дэмжлэг үзүүлж ажиллахыг Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд Ш.Батбаярт даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙДЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ БӨГӨӨД ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД Ц.НЯМДОРЖ

НИЙГМИЙН ХАМГААЛАЛ, ХӨДӨЛМӨРИЙН САЙД Ш.БАТБАЯР

САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН САЙД Ч.УЛААН

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 8 дугаар сарын 22-ны өдөр | **Дугаар 178** | **Улаанбаатар хот**

Чанга дэглэмтэй хорих анги байгуулах тухай

Шүүхийн шийдвэр биелүүлэх тухай хуулийн 73 дугаар зүйлийн 1-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Шүүхийн шийдвэр биелүүлэх ерөнхий газрын Нэгдсэн хорих ангийн харьяа "Тусгай эмнэлэг-тасаг"-ийг чанга дэглэмтэй хорих анги болгон өөрчлөн зохион байгуулсугай.

2. Шинээр байгуулагдах чанга дэглэмтэй хорих ангийн дохиолол, харуул хамгаалалтыг батлагдсан орон тоо, төсөв зардалд багтаан зохицуулахыг Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдоржид даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙДЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ БӨГӨӨД ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД Ц.НЯМДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 8 дугаар сарын 22-ны өдөр | **Дугаар 179** | **Улаанбаатар хот**

Хөтөлбөрийн заалтад өөрчлөлт оруулах тухай

"Хэмжлийн нэгжийн үндэсний эталоныг хөгжүүлэх хөтөлбөр"-ийн хэрэгжилтийн явцыг хэлэлцүүлэг Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Хэмжлийн нэгжийн үндэсний эталоныг хөгжүүлэх хөтөлбөр"-ийн хоёрдугаар бүлгийн 5 дахь заалтын "гурван жилийн" гэснийг "таван жилийн" гэж өөрчилсүгэй.

2. Үйлдвэр, худалдааны сайд Ч.Ганзориг, Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаан нарт даалгах нь:

а/хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн тодорхой хэсгийг улсын төвлөрсөн төсвийн жил бүрийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлж байсугай;

б/энэ хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэхээр төлөвлөгдсөн урт, цаг давтамж, цахилгаан, даралт, физик-хими, усны зарцуулалтын эталон бий болгох, тоног төхөөрөмжийн шинэчлэл хийхтэй холбогдсон төслүүдийг хандивлагч орон, олон улсын байгууллагын техникийн буцалтгүй тусламжийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ авч ажилласугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙДЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ БӨГӨӨД ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД Ц.НЯМДОРЖ

ҮЙЛДВЭР, ХУДАЛДААНЫ САЙД Ч.ГАНЗОРИГ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 8 дугаар сарын 22-ны өдөр **Дугаар 180** **Улаанбаатар хот**

Монгол Улсад Шинжлэх ухааны байгууллага үүсч хөгжсөний 80 жилийн ойг тэмдэглэхэд дэмжлэг үзүүлэх тухай

Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам, Шинжлэх ухааны академийн саналыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Монгол Улсад шинжлэх ухааны байгууллага үүсч хөгжсөний 80, Шинжлэх ухааны академи байгууллагдсаны 40 жилийн ойн арга хэмжээний хүрээнд "Монгол Улсын үндэсний нэвтэрхий толь","Монгол Улсын шинжлэх ухаан XXI зуун", "Монгол Улсын шинжлэх ухааны академи" номуудыг хэвлүүлэх, тэзвэрлэх зардлын төсвийг хянаж эргэж төлөгдөх нөхцөлтэйгээр санхүүжүүлэхийг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаанд зөвшөөрсүгэй.

2. Монгол Улсад шинжлэх ухааны байгууллага үүсч хөгжсөний 80 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэхэд зохион байгуулалтын дэмжлэг үзүүлэхийг Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд А.Цанжидад даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙДЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ БӨГӨӨД ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД Ц.НЯМДОРЖ

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙД А.ЦАНЖИД

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 8 дугаар сарын 22-ны өдөр **Дугаар 181** **Улаанбаатар хот**

Техникийн их сургуулийн талаар авах зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын "Шинжлэх ухаан, технологийг 2010 он хүртэл хөгжүүлэх үндэсний хөтөлбөр","Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх, сургалт-эрдэм шинжилгээ-үйлдвэрлэлийн холбоог сайжруулах, мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэхэд их сургуулийн гүйцэтгэх үүргийг дээшлүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Техникийн их сургуулийг 2001 оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс Монгол Улсын Шинжлэх ухаан, технологийн их сургууль болгон өргөтгөн зохион байгуулахыг зүйтэй гэж үзсүгэй.

2. Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн сургалт-эрдэм шинжилгээний зарим лабораторийг орчин үеийн багаж, техник хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр шинэчлэн тоноглоход шаардагдах хөрөнгийг олон улсын байгуллага, хандивлагч орнуудын техникийн бүцалтгүй тусламж, хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрээр санхүүжүүлэх арга хэмжээ авахыг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаан, Гадаад хэргийн сайд Л.Эрдэнэчулуун, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд А.Цанжид нарт зөвшөөрсүгэй.

3. "Монгол Улсын шинжлэх ухаан, технологийг 2010 он хүртэл хөгжүүлэх үндэсний хөтөлбөр"-т тусгагдсан, төсөл сонгон шалгаруулахад хамрагдаж шалгарсан салбар дундын ашиглалт бүхий шинэзэр буй болгох жижиг, дунд үйлдвэр болон зарим лабораторийг Шинжлэх ухаан, технологийн их сургуулийг түшиглүүлэн байгуулах ажлыг Үйлдвэр, худалдааны сайд Ч.Ганзориг, Хүнс, хөдөө аж ахуйн сайд Д.Насанжаргал, Дэд бүтцийн сайд Б.Жигжид нартай зөвшилцөж тохиролцсоны үндэсн дээр зохион байгуулахыг Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд А.Цанжидад даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙДЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ БӨГӨӨД ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД Ц.НЯМДОРЖ

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙД А.ЦАНЖИД

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 8 дугаар сарын 29-ний өдөр Дугаар 182 Улаанбаатар хот

Аймаг, нийслэлийн хүүхдийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвийн анхан шатны ангийн болон дотуур байрны нэг хүүхдэд ногоох хувьсах зардлын дундаж хэмжээг шинэчлэн тогтоох тухай

Боловсролын тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Аймаг, нийслэлийн хүүхдийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль,мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвийн анхан шатны ангийн нэг сурагчид ногдох хувьсах зардлын дундаж хэмжээг хавсралт ёсоор батлсугай.

2. Хүүхдийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн байршил, онцлогийг харгалзан нэг сурагчид ногдох хувьсах зардлын хэмжээг цэцэрлэг, сургууль бүрээр ялгавартай тогтоож байхыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.

3. Жилийн хоолны зардлын хэмжээг цэцэрлэгийн нэг хүүхэдэд 36000 төгрөг, дотуур байранд амьдрах ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвийн анхан шатны (8 дугаар анги төгсөөд элссэн) ангийн нэг сурагчид 110950 төгрөг байхаар тус тус тогтоож улсын төсвөөс санхүүжүүлж байсугай.

4. Хүүхдийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвийн болон сурагчдын дотуур байрын цахилгаан, дулаан, ус, тээврийн зардлыг тухайн цэцэрлэг, сургуулийн байршил, хэв шинжийг харгалзан орон нутгийн төсвөөс санхүүжүүлж байсугай.

5. Батлагдсан хувьсах зардлын хэмжээг үндэслэн цэцэрлэг, сургуулийн төсвийн төлөвлөгөөг боловсруулж байхыг төсвийн эрх захирагч нарт даалгасугай.

6. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, нэгдсэн заавар, журмаар хангаж ажиллахыг Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд А.Цанжид, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.

7. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Ерөнхий боловсролын сургуулийн болон дотуур байрны нэг хүүхдэд ногдох хувьсах зардлын хэмжээг шинэчлэн тогтоох тухай" Засгийн газрын 2000 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн 186 дугаар тогтоол, "Мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвийн анхан шатны ангийн нэг сурагчид ногдох хувьсах зардлын хэмжээг тогтоох тухай" Засгийн газрын 2000 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн 97 дугаар тогтоолын 1, 3 дахь заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙД А.ЦАНЖИД

Засгийн газрын 2001 оны 182 дугаар тогтоолын хавсралт

АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГ, ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬ,МЭРГЭЖЛИЙН СУРГАЛТ-ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТӨВИЙН АНХАН ШАТНЫ АНГИЙН НЭГ СУРАГЧИД НОГДОХ ХУВЬСАХ ЗАРДЛЫН ДУНДАЖ ХЭМЖЭЭ

№	Аймаг, хотын нэр	Цэцэрлэгийн нэг хүүхэдэд ногдох хувьсах зардал /төгрөг/	Ерөнхий боловсролын сургуулийн нэг сурагчид ногдох хувьсах зардал /төгрөг/			Мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвийн анхан шатны ангийн нэг сурагчид ногдох хувьсах зардал /төгрөг/
			Бага анги	Дунд анги	Ахлах анги	
1	Архангай	80580	57540	70140	77570	137400
2	Баян-Өлгий	85330	61240	76730	79860	145600
3	Баянхонгор	82950	57810	70410	77840	141500
4	Булган	80580	57540	70140	77570	137400
5	Говь-Алтай	85330	58280	70880	78310	144500
6	Дорноговь	80580	57590	73340	77620	137400
7	Дорнод	82950	57810	70410	77840	141500
8	Дундговь	80580	57200	72950	77220	137400
9	Завхан	85330	58280	70880	78310	141500
10	Өвөрхангай	80580	57200	69790	77220	137400
11	Өмнөговь	82950	57760	73510	77790	141500
12	Сүхбаатар	80580	57810	73560	77840	
13	Сэлэнгэ	82950	57260	69860	77290	137400
14	Төв	80600	56890	69490	76920	137000
15	Увс	85330	58600	74350	78620	145600
16	Ховд	85330	58600	74350	78620	145600
17	Хөвсгөл	82950	57850	70450	77870	141500
18	Хэнтий	80580	57420	70020	77440	141500
19	Дархан-Уул	80630	56300	68710	76030	137100
20	Улаанбаатар	80600	55570	67980	75300	136200
21	Орхон	80580	56470	68880	76190	137100
22	Говьсүмбэр	80580	57120	69720	77150	

Тайлбар: 1. Дээрх хувьсах зардлын хэмжээнд цалингийн сангийн өзлэх хувь цэцэрлэгт 70.7, ерөнхий боловсролын сургуульд 74.5,мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвд 65 хувь байна.
2. Цэцэрлэгийн нэг хүүхдэд ногдох хувьсах зардлын дүнд хоолны зардал ороогүй болно.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 8 дугаар сарын 29-ний өдөр **Дугаар 183** **Улаанбаатар хот**

Хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Монгол орны геомэдээллийн сан" хөтөлбөрийг хавсралт ёсоор батлуулсугай.

2. "Монгол орны геомэдээллийн сан" хөтөлбөрийн хэрэгжилтэд тогтмол хяналт тавьж ажиллахыг Үйлдвэр, худалдааны сайд Ч.Ганзоригт үүрэг болгосугай.

3. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг 2002 оноос эхлэн жил бүрийн үлэн төвлөрсөн төсвийн геологийн судалгааны зардалд оруулан тусгаж байхыг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаан, Үйлдвэр, худалдааны сайд Ч.Ганзоригт нарт даалгасугай.

4. Геологийн мэдээллийн төвийг тусгай байранд байршуулах асуудлыг судлан шийдвэрлэхийг Үйлдвэр, худалдааны сайд Ч.Ганзориг, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч М.Энхболд нарт болон Төрийн өмчийн хороо (Л.ПҮРЭВДОРЖ)-нд даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

ҮЙЛДВЭР, ХУДАЛДААНЫ САЙД **Ч.ГАНЗОРИГ**

Засгийн газрын 2001 оны 183 дугаар тогтоолын хавсралт

МОНГОЛ ОРНЫ ГЕОМЭДЭЭЛЛИЙН САН БҮРДҮҮЛЭХ ХӨТӨЛБӨР

Нэг. Монгол Улсын геологийн судалгааны ажлын мэдээ, үр дүнгийн тайлан, тэдгээрийн хадгалмажийн өнөөгийн байдал

1. Монгол орны нутаг дэвсгэр дээр 1925 оноос хойшхи хугацаанд хийгдсэн хайгуулын ажлын үр дүнд боловсруулагдсан геологийн тайлан, эрдэс баялгийн шинжилгээ, туршилтын үр дүнгийн тухай дүгнэлт, техник, эдийн засгийн үнэлгээ зэрэг баримт бичгүүд нь Геологийн мэдээллийн төвд хадгалагдаж байна. 5277 судалгааны ажлын үр дүнгийн тайлан буюу ном, хавсралт зургийн хамт Геологийн мэдээллийн төвийн хадгаламжийн сангийн үйлчилгээнд ашиглагдаж байна. Улсын төсвийн болон хувийн хэвшлийн байгууллагуудын гүйцэтгэж байгаа судалгааны ажлын үр дүнгийн тайлангуудын тоо хэмжээ нь жилээс жилд өссөөр байгаа бөгөөд тэр хэмжээгээр хадгаламжийн санд нэмэлт баяжуулалт хийгдэж байна.

1990 оноос өмнө Монгол улсын хэмжээнд геологийн судалгааны ажил эрхэлж байсан Дархан, Чойр, Хөвсгөл, Ховд, Дорнод, Улаанбаатар хотын Төв, Эрэл Геофизикийн цогцолбор экспедици, Геологийн эрдэм шинжилгээний хүрээлэн болон Олон улсын Геологийн экспедици, Оросын Холбооны улсын олон тооны геологийн байгууллагууд өөрийн гэсэн геологийн хадгаламжтай байсан хэдий ч 1992-1995 онуудад эдгээр материалыг Геологийн мэдээллийн төвд төвлөрүүлсэн болно. Сүүлийн жилүүдэд судалгааны ажлын явцад бүрдүүлсэн анхдагч баримт бичгийг Геологийн мэдээллийн төвд хүлээн авч хадгалах болсон.

Геологийн судалгааны болон ашигт малтмалын мэдээллийн сан байгуулах ажлын эхлэлийг 1993-1994 онд НҮБ-ын төслийн шугамаар гүйцэтгэсэн юм. Энэ төслийн хүрээнд 800 гаруй орд, 5400 орчим илрэл, 7000 шахам уст цэгийн мэдээллээр сан үүсгэж, 1:3200000-ын масштабаар геологи, тектоник, соронзон, хүндийн хүчний гажигийн болон 1:500000, 1:200000, 1:50000-ны масштабын геологи, 1:500000-ны масштабын гидрогеологийн, 1:200000, 1:100000, 1:50000-ны масштабын агаарын геофизикийн судалгааны зургуудыг зохиожээ. Мөн ирээдүйтэй орд, илрэлүүд 1800 гаруйг хамруулсан 9 төрлөөр 1:3200000-ны масштабын ашигт малтмалын зургийг зохиогоод байна.

1997 оноос БНФранц улсын тусламжаар сансрын зургийн тоон мэдээллийг боловсруулан геологийн судалгаанд ашиглах зорилго бүхий "МЭЙЖИК" төсөл хэрэгжүүлснээр Геологийн мэдээллийн төвийн боловсон хүчний сургалт явуулж, зарим техник, тоног төхөөрөмжид шинэчлэлт хийсэн.

Хайлуур жоншны 1959-1998, алтны 1973-1998 оны нөөцийн хөдөлгөөний балансыг компьютерт орууллаа.

Ашигт малтмалын улсын нөөцийн тоо

бүртгэлд нийт 320 орчим объектыг хамруулжээ. Бичмэл мэдээллийн сан бүрдүүлэх, хатуу ашигт малтмалын орд, илрэлийн бүртгэлийн 5, уст цэгийн 3, геологийн тайлангийн агуулгын 1 загварыг боловсруулан мөрдэж байна. Одоогийн байдлаар геологийн судалгааны үр дүнгийн мэдээллийн 18-20 хувь компьютерийн мэдээллийн санд ороод байна.

Гэвч дэлхийн электрон техникийн хөгжилд хэд хэдэн удаа шинэчлэлт хийгдсэнээс төслөөр хэрэгжүүлсэн, түрүүчийн нийлүүлэгдсэн техник хэрэгсэл хоцрогдож, программ хангамж нь үйлчилгээнээс гарч, зарим техник хэрэгслийн эдэлгээний хугацаа дуусч өнөөгийн шаардлага хангахгүй болсон байна. Үүнээс болж геологийн судалгааны асар их мэдээллийг системтэй сангийн хэлбэрт оруулах ажил удааширч, дэлхийн мэдээлэл боловсруулах аргаас хоцорч, хэрэглэгчдийг шаардлагатай мэдээллээр нь шуурхай хангаж чадахгүй байна.

Хоёр. Хөтөлбөр боловсруулах үндэслэл

2. Монгол орны эдийн засгийн чадавхид чухал үүрэг гүйцэтгэж буй геологи, эрдэс баялгийн салбар, орд газруудын өнөөгийн байдлыг тодорхойлох, нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд геологийн судалгааны мэдээ, материалыг нэгтгэх, дүн шинжилгээ өгөх, геологийн төрөл бүрийн судалгааны ажлуудын үр дүнг олон улсын түвшинд нэгтгэн гаргаж улсын хэмжээний мэдээллийг бий болгох шаардлагыг харгалзан; геологийн судалгаагаар хэдэн арван жилийн хугацаанд хөрөнгө хүч зарцуулан бий болгосон тайлан, мэдээ, материалыг найдвартай хадгалж хойч үедээ өвлүүлэн үлдээх, түүгээр олон нийтэд тогтвортой шуурхай үйлчлэх үүргийг бодолцоно. Монгол орны геомэдээллийн сан бүрдүүлэх хөтөлбөрийг боловсруулав.

Гурав. Хөтөлбөрийн зорилго

3. Геологийн судалгааны ажлын үр дүн, тайлан материалаар газар зүйн мэдээллийн системд тулгуурлан мэдээллийн сан байгуулж, дотоод, гадаадын хөрөнгө оруулагчдын сонирхлыг татах, хөрөнгө оруулалтыг дэмжих, цаашид сонирхолтой талбайнуудад илүү нарийвчилсан судалгааг явуулах төлөвлөлтийн үндэслэлийг боловсронгуй болгоход хөтөлбөрийн зорилго оршино.

Дөрөв. Хөтөлбөр хэрэгжүүлэх арга, хэлбэр, баримтлах зарчим

4. Геомэдээллийн сан нь Монгол улсын хэмжээнд хийж гүйцэтгэсэн төрөл бүрийн геологийн судалгааны ажлын үр дүнд боловсруулагдсан тайлан, тэдгээрийн анхдагч материалуудыг бүртгэн хадгалж, сонирхогчдод үйлчилгээ үзүүлэх <u>хадгаламжийн сан</u>, дээрх мэдээ, анхдагч материалыг газар зүйн мэдээллийн систем (GIS) дээр үндэслэн боловсруулсан <u>геомэдээллийн сан</u> гэсэн хоёр үндсэн сангаас бүрдэнэ.

5. Хадгаламжийн сан нь **тайлангийн, чулуун дээжийн, анхдагч материалын** гэсэн 3 дэд сангаас бүрдэнэ.

6. **Геомэдээллийн сан** нь **<u>үндсэн мэдээллийн сан</u>** (Монгол орны хэмжээнд хийгдсэн бүх төрлийн геологи ба ашигт малтмалын мэдээллийг бүрэн хамруулан нэгтгэж, байр зүйн 1:200000 масштабын зургийн хэмжээнд үүсгэсэн), **<u>ерөнхий мэдээллийн сан</u>** (Монгол орны геологи, гидрогеологи, геоморфологи, инженер-геологийн ерөнхий нөхцөл, геофизик, геохими, ашигт малтмалын зургийг жижиг масштабын хэмжээнд үүсгэсэн), **<u>нарийвчилсан мэдээллийн сан</u>** (Ашигт малтмалын орд, илрэлийн байршлын зүй тогтол, тархац, түүний баримт бичгээ, олсон үр дүн зэрэг тодорхой мэдээллийг 1:2000-1:50000-ны масштабын хэмжээнд бүрдүүлсэн)-гаас бүрдэнэ.

7. Геомэдээллийн санг **зураг**, түүнд хийсэн тайлбар буюу тодорхой геологийн биет, нэгж, ашигт малтмалын орд, илрэл, гажиг, сарнилын хүрээ зэргийн бүртгэл хэлбэрийн **бичмэл** мэдээлэл гэсэн 2 үндсэн хэсэгтэйгээр боловсруулна.

Зургийн хэсэг нь: Байр зүйн зургийн; Агаар, сансрын зургийн; Геологийн зургийн; Давхарга зүйн нэгжийн; Интрузив чулуулгийн биетийн; Деревдегчийн геологийн; Геоморфологийн; Тектоникийн; Гидрогеологийн; Инженер-геологийн; Агаарын ба газрын геофизикийн; Ашигт малтмалын; Геохимийн; Баримт материалын зургийн; салбар сангуудаас бүрдэнэ.

Эдгээрийг өөр хооронд нь харьцуулах, боловсруулах, нэмэлт хийх, давхцуулах замаар шинэлэг мэдээ, баримт, мэдлэг олж авах боломж бүрдэхээс гадна бичмэл мэдээлэл бүхий **салбар сан**гуудтай холбож нэгдсэн мэдээллийн багц үүсгэнэ.

8. Дэд сангууд: Геомэдээллийн санд судлаачдын хийсэн үнэлэлт дүгнэлт, шинжлэх ухааны нээлт, ололтууд зэрэг эх үүсвэрийн хувьд ном, хэвлэл, товхимолд тусгагдсан мэдээллүүд, эрдэс баялгийн олборлолт, боловсруулалтын холбогдолтой мэдээллүүд, өөрийн орны болон дэлхийн бусад орнуудын ашигт малтмалын нөөц, баялгийн тоо хэмжээ зэрэг мэдээллийг агуулсан хэвлэмэл мэдээллийн; ашигт малтмалын нөөцийн; лицензэ эзэмшлийн гэсэн 3 дэд сантай байна.

<u>Ашигт малтмалын нөөцийн дэд сан</u>: Энэ санг

ашигт малтмалын нөөцийг улсын нөөцийн тоо бүртгэлд албан ёсоор бүртгэсэн **нөөцийн**, геологийн судалгааны ажлын явцад эрдэс баялгийн хэтийн төлөвийг үнэлсэн **үнэлгээний** гэсэн 2 хэсэгтэйгээр үүсгэнэ.

Ашигт малтмалын нөөцийн хэсэгт геологи, хайгуулын судалгаагаар батлагдаажсан, үйлдвэрлэл явуулахад үндэслэл болохуйц, улсын бүртгэлд хамрагдсан ашигт малтмалын нөөцийг оруулан сан үүсгэж түүний олборлосон, хаясан, бохирдсон, ашиглалтын явц болон ашиглалтын үеийн судалгааны ажлын үед хасагдсан, нэмэгдсэн зэрэг өөрчлөлтийг тухай бүр тусган үлдэгдлийг тогтоож байхын зэрэгцээгээр нөөцийн дунд орсон өөрчлөлтийн хэмжээг тодорхой цаг хугацааны хооронд, эсвэл ашиглалтын хугацааны эхнээс гэх мэтээр тооцон гаргаж харах боломжтойгоор бүрдүүлнэ. Үнэлгээний хэсгийг бүх үе шатны геологийн судалгааны үед тааманаглан, багцаалсан, үнэлсэн ашигт малтмалын нөөцийн бүртгэлээр үүсгэнэ. Дээрх хоёр төрлийн бүртгэлд тусгагдаж сан орсон нөөц нь ашигт малтмалын төрлөөр ангилагдах ба чанарын зарим үзүүлэлтээр нь сонголт хийж үзэх боломжтой байна. Мөн түүнчлэн ашигт малтмалын орд, илрэлийн сантай холбогдон харилцан уялдаатай байна.

Лиценз эзэмшлийн дэд сан: Ашигт малтмалын лицэнз эзэмшлийн дэд санг хайгуулын ба ашиглалтын гэж 2 хэсэгтэйгээр байгуулна. Монгол орны нутаг дэвсгэр дээр геологийн зураглал, ашигт малтмалын эрэл, хайгуул, ашиглалтын ажил гүйцэтгэх тухай эрхийн лицэнз эзэмшигч аж ахуйн нэгж, байгууллага, хувь хүний үйл ажиллагаа явуулах газар нутгийн хил хязгаар, байршлын талаар мэдээллийн сан үүсгэнэ.

Хэвлэмэл мэдээллийн дэд сан: Дэлхийн янз бүрийн орны судлаачдын нээлт, бүтээл, өдөр тутмын сонин, сэтгүүл, ном, хэвлэмэл мэдээллийг эх баримтаас нь бүрдүүлэн уг дэд санг үүсгэх бөгөөд дотор нь төрөлжүүлэн ангилж чиглэл, утга агуулгаар нь ялгаж сонирхсон этгээдэд үйлчилнэ.

9. Мэдээллийн сангийн нэр томъёоны коджуулалт, шифрлэлт: Геомэдээллийн сан нь асар том хэмжээтэй, бүтцийн хувьд нийлмэл, агуулгын хувьд баян учир туйлын сайн боловсруулсан кодлолт, шифрлэлтийг зүй ёсоор шаардана. Санд орж буй мэдээллийг оновчтой, зохих шаардлагыг хангасан байх, хялбар болгохын үүднээс компьютерийн тодорхой төмдэгтийг ашиглан баталгаажуулна. Үүнийг кодлолт гэсэн нэрээр нэрлэж байна.

Харин геологийн нэр томъёог олон улсын жишгийн хэмжээнд сонгон авч хэрэглэхийг шифрлэлт гэнэ.

Ашигт малтмал, тектоник, давхарга зүй, деревдөгч, интрузив чулуулгийн туслах шифрийг болон гидрогеологи, геоморфологийн зургийн үндсэн болон туслах шифрийг сан бүрдүүлэх үед нь боловсруулна.

Агаар, сансар, байр зүйн зургуудын туслах кодыг төмдэглэхдээ дэлхий дахинаа болон монголд мөрдөж буй шифрийг нь хэрэглэнэ. Онооссон шифрийн хувьд ашигт малтмалыг химийн томъёогоор, хэрэв томъёо, төмдэг байхгүй бол латинаар бичсэн нэрийн товчлол (зохиож)-оор төмдэглэх зарчмыг баримтлан тухайн үед нь нэмэлт болгон баяжуулж хэрэглэнэ.

Хурдас, чулуулгийн хувьд геологийн онцлогоор нь давхарга зүйн ангиллаар нь, найрлагаар нь ялган төмдэглэсэн товчлол, нэрээр нь онооссон шифр, код болгон авна. Үндсэн, туслах ба онооссон шифрийг хэрэглэхдээ дунд нь зураас татаж өөр хооронд нь ялгана.

10. **Мэдээллийн сангийн хэл**: Геологийн мэдээллийн сангийн үндсэн хэл нь монгол хэл байна. Дэлхийн зах зээлд өрсөлдөх чадвартай томоохон орд газрын, сонирхол татахуйц хүдрийн талбай, бүс, зангилааны холбогдолтой багц мэдээлэл, тэнд байгаа орд, илрэлүүдийн мэдээлэл зэргийг англи хэл дээр хөрвүүлэн өрөнхий санд оруулж хадгална. Үүнээс гадна интернетээр цацах мэдээллийг англи хэл дээр бэлтгэнэ.

Тав. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

11. Монгол орны геомэдээллийн сан бүрдүүлэх хөтөлбөрийг Геологийн мэдээллийн төвд хэрэгжүүлнэ.

12. Хөтөлбөрийн өрөнхий болон үндсэн сантай холбоотой геологийн зарим салбар сангуудыг Шинжлэх ухааны академийн Геологи, эрдэс баялгийн хүрээлэн, Монголын стратиграфын комисс, ТИС, МУИС болон геологийн бусад байгууллагуудын геологич эрдэмтдийн оролцоотойгоор боловсруулж бүрдүүлнэ.

13. Хөтөлбөрт тусагдсан зорилтуудыг шийдвэрлэхэд хоёр талын болон олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлнэ.

14. Хөтөлбөрийн хэрэгжилтэд Үйлдвэр, худалдааны яам хяналт тавьж, үр дүнг үнэлнэ.

Зургаа. Хөтөлбөрийн санхүүжилт, хэрэгжүүлэх хугацаа

15. Геологийн мэдээллийн сан бүрдүүлэх ажилд доорхи хөрөнгө шаардагдана:

а/үйл ажиллагааны нийт зардал 485,0 сая төгрөг;

б/компьютерийн техник хэрэгсэл, программ хангамжийн хөрөнгө оруулалтын зардал 350,0 сая төгрөг;

в/Геологийн мэдээллийн төвийн барилга барих зардал 300 сая төг;

г/төсөл хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын нийт дүн 1135,0 сая төгрөг байна.

16. Хөтөлбөрийг 10 жилийн хугацаанд хэрэгжүүлнэ. Хөтөлбөрт тусгагдсан ажлуудыг геологийн даалгавар боловсруулж төсөл, төсөв зохион тодорхой үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

Долоо. Хөтөлбөрийн үр дүн, шалгуур үзүүлэлт

17. Геомэдээллийн сан хөтөлбөр хэрэгжсэнээр дараахь үр дүнд хүрсэн байна:

а/Монгол оронд хийгдсэн геологийн судалгааны мэдээлэл нийтдээ компьютерийн мэдээллийн санд орно;

б/Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, Засгийн газар, яам, агентлаг болон аймаг, орон нутгийн удирдлагыг геологи, эрдэс баялгийн шинэчлэгдсэн мэдээллээр тогтмол хангана;

в/геологи, эрдэс баялгийн салбарт оруулах гадаад, дотоодын хөрөнгө оруулалт нэмэгдэнэ;

г/гадаад орнуудын ижил төстэй байгууллагуудтай хамтран ажиллах, мэдээлэл солилцох боломжтой болно;

д/олборлосон, шинээр нээн илрүүлсэн ашигт малтмалын талаархи мэдээллийг тухай бүрт бүртгэж нийтэд шуурхай мэдээлэх нөхцөл бүрдэнэ;

е/монгол орны бүсчилсэн хөгжлийн бодлогод геологи, эрдэс баялгийн салбарын оролцоог цаг хугацаанд нь тусгах нөхцөл бүрдэнэ;

ж/Монгол Улсын геологи, эрдэс баялгийн салбарыг дэлхийн бусад орнуудад сурталчлах мэдээллийн баазтай болно;

з/геологийн судалгааны ажлын үр дүнгийн тайлан, материал, мэдээлэл зэргийг найдвартай хадгалах, сэргээн засварлах, тэдгээрт нэмэлт баяжуулалт хийх илүү нөхцөл бүрдэнэ;

и/Монгол Улсын үндэсний архивын нэг хэсэг болох геологийн төрөлжсөн архивын аюулгүй байдал хангагдана;

к/гадаад, дотоодын байгууллага, иргэдийг хүссэн мэдээллээр нь нэг цэгээс шуурхай хангах боломжтой болно.

18. Геомэдээллийн сан хөтөлбөрийн хэрэгжилтийг дараахь шалгууруудаар хэмжинэ:

а/геологи хайгуул, судалгааны үр дүнгийн мэдээллийг компьютержсэн мэдээллийн санд 100 хувь оруулсан байх;

б/мэдээллийн сангийн чиглэлээр энэ хөтөлбөрийн дөрөвдүгээр бүлэг бүрэн хэрэгжсэн байх;

в/санг шинэлэг мэдээллээр баяжуулан нэмэлт хийж байх;

г/сангийн мэдээлэл нь бүртгэл-статистик болон хэрэглээний чиглэлийг хангасан байх.

19. Дээрх шалгууруудыг хэмжих үзүүлэлтийг тухайн үед нь яам тогтоож түүний дагуу хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийж, үр дүнг үнэлж байна.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 8 дугаар сарын 29-ний өдөр **Дугаар 184** **Улаанбаатар хот**

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагын ерөнхий захирал Др Жак Диоуфын айлчлалын зардалд зориулж 2707,6 (хоёр сая долоон зуун долоон мянга зургаан зуун) мянган төгрөгийг Засгийн газрын нөөц хөрөнгөөс гаргахыг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаанд зөвшөөрсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН САЙД **Ч.УЛААН**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 8 дугаар сарын 29-ний өдөр | Дугаар 185 | Улаанбаатар хот

Худалдаа хөгжлийн банкны төрийн эзэмшлийн хувьцаат худалдах тухай

Төрийн өмчийг 2001-2004 онд хувьчлах үндсэн чиглэл, Төрийн өмчийг 2001 онд хувьчлах хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор Төрийн болон орон нуттийн өмчийн тухай хуулийн 33, 46-54 дүгээр зүйлийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Засгийн газрын 2001 оны 35 дугаар тогтоолоор батлсан "Төрийн өмчийг 2001 онд хувьчлах хөтөлбөр"-ийн 1 дүгээр хавсралтын 3 дахь мөрний "Худалдаа хөгжлийн банк" ХХК-ийн хувьчлах төрийн өмчийн хувийг "76" гэж өөрчилсүгэй.

2. "Худалдаа хөгжлийн банк" ХХК-ийн нийт хувьцааны төрийн эзэмшлийн 76 хувьд ногдох 1 520 000 ширхэг хувьцааг худалдах "Уралдаант шалгаруулалт /тендер/-ын зар мэдээ"-г 1 дүгээр, "Уралдаант шалгаруулалт /тендер/-ын журам"-ыг 2 дугаар хавсралт ёсоор тус тус батална.

3. "Худалдаа хөгжлийн банк" ХХК-ийн нийт хувьцааны төрийн эзэмшлийн 76 хувьд ногдох 1 520 000 ширхэг хувьцааг худалдах доод үнийг 12.226.000 /арван хоёр сая хоёр зуун хорин зургаан мянган/ ам.доллараар тогтоосугай.

4. Төрийн өмчийн хороо /Л.ПҮРЭВДОРЖ/-нд даалгах нь:

а/"Худалдаа хөгжлийн банк" ХХК-ийн нийт хувьцааны төрийн эзэмшлийн 76 хувьд ногдох 1 520 000 ширхэг хувьцааг худалдах "Уралдаант шалгаруулалт /тендер/-ын зар мэдээ"-г дотоод, гадаадын хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд шуурхай мэдээлж ажиллуулсугай;

б/"Худалдаа хөгжлийн банк" ХХК-ийн нийт хувьцааны төрийн эзэмшлийн 76 хувьд ногдох 1 520 000 ширхэг хувьцааг худалдах уралдаант шалгаруулалтыг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, "Уралдаант шалгаруулалт /тендер/-ын журам"-ын дагуу зохион байгуулж явуулсугай;

в/"Худалдаа хөгжлийн банк" ХХК-ийн нийт хувьцааны төрийн эзэмшлийн 76 хувьд ногдох 1 520 000 ширхэг хувьцааг худалдах уралдаант шалгаруулалт /тендер/-д ялсан худалдан авагчтай "Уралдаант шалгаруулалтын журам"-д заасан болзол, нөхцөлийн талаар харилцан тохиролцож "Хувьцаа худалдах, худалдан авах тухай гэрээ" байгуулахыг зөвшөөрсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН САЙД Ч.УЛААН

Засгийн газрын 2001 оны 185 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР ТӨРИЙН ӨМЧИЙН ХОРОО

УРАЛДААНТ ШАЛГАРУУЛАЛТ /ТЕНДЕР/-ЫН ЗАР МЭДЭЭ

Монгол Улсын Их Хурлын 2001 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 10 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн өмчийг 2001-2004 онд хувьчлах үндсэн чиглэл", Засгийн газрын 2001 оны 2 дугаар сарын 20-ны өдрийн 35 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн өмчийг 2001 онд хувьчлах хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Монгол Улсын банкны салбарт ашигтай үйл ажиллагаа явуулж буй хамгийн том арилжааны банк болох "Худалдаа хөгжлийн банк" ХХК /цаашид "ХХБ" ХХК буюу "банк" гэх/-ийн нийт хувьцааны төрийн мэдлийн 76 хувьд ноогдох 1 520 000 ширхэг энгийн хувьцаагаар бөгц болгон уралдаант шалгаруулалт /цаашид "тендер" гэх/-ын аргаар хувьчлах үйл ажиллагаанд оролцохыг банкны салбарын стратегийн хөрөнгө оруулагчдыг Монгол Улсын Засгийн газар урьж байна.

Тендерийг Монгол Улсын Засгийн газрын 2001 оны 8 дугаар сарын 29-ний өдрийн 185 дугаар тогтоолоор батлсан "Уралдаант шалгаруулалт /тендер/-ын журам"-д тусгагдсан нөхцөл, болзлын дагуу Төрийн өмчийн хороноос зохион байгуулж дүгнэнэ. Засгийн газрын шийдвэрээр банкны нийт хувьцааны 76 хувийг худалдах доод үнийг 12.226.000 /арван хоёр сая хоёр зуун хорин зургаан мянган/ ам. доллараар тогтоов.

"ХХБ" ХХК-ийг хувьчлах ажилд Монгол Улсын Засгийн газраас АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлагтай байгуулсан гэрээний дагуу "КПМЖ Консалтинг" компанийн "Баренц Бүлэг" Төрийн өмчийн хороонд зөвлөхөөр ажиллаж байгаа болно.

Олон улсын санхүүгийн корпораци /цаашид "ОУСК" гэх/ болон Азийн хөгжлийн банк /цаашид "АХБ" гэх/ нь "ХХБ" ХХК-ийн хувьцааны цөөн хувийг худалдаж авах, эсвэл бусад хэлбэрээр хөрөнгө оруулах зэрэг хөрөнгө оруулалтын аль хэлбэрийг сонгох талаар судалгаа хийж байна. ОУСК болон

АХБ-наас оруулах хөрөнгө оруулалт нь тус хоёр байгууллагын судалгаа, дүгнэлт, Монгол Улсын Засгийн газраас хувьчлалын талаар баримталж буй чиглэл, "ХХБ" ХХК-ийг хувьчлах тендерийн зар мэдээ, тендерийн журмын дагуу тус банкийг амжилттай хувьчилсан эсэх, ОУСК болон АХБ, Монгол Улсын Засгийн газар ба тендерт ялагчийн харилцан хэлэлцэж тохирох хөрөнгө оруулалтын бүтээц, ОУСК болон АХБ-ны ажлын дотоод журмын дагуу авбал зохих тус тусын удирдах дээд байгууллагын зөвшөөрөл болон бусад хүчин зүйлээс хамаарна.

ОУСК болон АХБ-ны хувьчлалд оролцох сонирхлыг тус хоёр байгуллага "ХХБ" ХХК-д хөрөнгө оруулахаар шийдвэрлэсэн байдлаар ойлгож болохгүй. Боломжит хөрөнгө оруулагчид ОУСК болон АХБ-наас илэрхийлж буй сонирхлыг харгалзахгүйгээр "ХХБ" ХХК-ний талаар өөрийн бие даасан судалгаа хийх нь зүйтэй. ОУСК болон АХБ нь 2001 оны 8 дугаар сарын байдлаар гаргасан "ХХБ" ХХК-ийн талаарх Ерөнхий мэдээлэл болон тендерийн явцад гаргаж өгөх бусад аль ч мэдээллийн үнэн зөв, бүрэн дүүрэн эсэх талаарх хариуцлагыг хүлээхгүй.

Тендерт оролцох сонирхлоо илэрхийлэх

Тендерийн зар мэдээ гарсны дараа тендерт оролцох хүсэлтэй этгээд /цаашид "өргөдөл гаргагч" гэх/ нь англи, эсвэл монгол хэл дээр сонирхлоо илэрхийлсэн албан ёсны захидлыг дараахь материалын хамт Төрийн өмчийн хороонд ирүүлнэ. Үүнд:

1. Өргөдөл;
2. Өргөдөл гаргагчийг төлөөлөх эрх бүхий этгээдийн гарын үсэг зурсан нууцыг хадгалах тухай гэрээ;
3. Бүцаж төлөгдөхгүй нөхцөлтэй 1 000 /нэг мянган/ ам. долларын тендерийн хураамж төлснийг нотлох баримт;
4. Итгэмжлэгдсэн төлөөлөгчийг томилсон тохиолдолд түүнд зохих журмын дагуу олгосон итгэмжлэл;
5. Өргөдөл гаргагчийн танилцуулга. Үүнд дараахь зүйлийг оруулсан байх шаардлагатай:

- Өргөдөл гаргагчийн бизнесийн үйл ажиллагааны чиглэл, компанийн бүтэц, арилжааны банк болон олон улсын банкны үйл ажиллагааны дэлгэрэнгүй танилцуулга /консорциумаар оролцож байгаа тохиолдолд хамтарч буй компанийн үйл ажиллагаа/.
- Сүүлчийн жилийн эцсийн байдлаар гаргаж аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан тэнцэл /нээлттэй компанийн хувьд хувьцаа эзэмшигчдэд зориулсан жилийн тайлан/.
- Тендерт оролцох хүсэлтэд өгсөн өргөдөл гаргагч компанийн нийт гаргасан хувьцааны арваас дээш хувийг эзэмшиж буй хувьцаа эзэмшигчдийн жагсаалт. Тендерт оролцохыг зөвшөөрч өргөдөл гаргагчийн удирдах байгууллагаас гаргасан шийдвэр, тендерт консорциумын хэлбэрээр оролцох тохиолдолд консорциумын гишүүдийн хооронд байгуулсан гэрээ.
- Тендерт оролцох буй компанийг үүсгэн байгуулж бүртгүүлсэн тухай баримт бичгүүд.
- Үйл ажиллагааны зэрэглэл тогтоодог байгууллагын үнэлгээ.

Өргөдөл болон нууцыг хадгалах тухай гэрээний загварыг **интернет** дэх Төрийн өмчийн хорооны www.spc.gov.mn вэб хуудаснаас буюу энэхүү зар мэдээний ард бичигдсэн хаягаар авч болно.

Тендерийн хураамжийг Монгол Улсын Монголбанк дахь Төрийн өмчийн хорооны дараахь дансанд төлнө:

Банкны нэр:	Монгол Улсын "Монголбанк"
SWIFT код:	BOMUMNUB
Дансны нэр:	Төрийн өмчийн хороо
Дансны дугаар:	3332404
Монголбанкны харилцагч банк:	Federal Reserve Bank of New York, NY, USA
SWIFT код:	FRNYUS33
Дансны дугаар:	021088506
Дансны нэр:	Монголбанк

Хуулийн этгээд дангаараа буюу хэд хэдэн хуулийн этгээд хамтарч консорциумын хэлбэрээр тендерт оролцож болно. Консорциумыг арилжааны банкны салбарын стратегийн хөрөнгө оруулагч толгойлсон байна.

Өргөдөл гаргагч тендерт өөрийгөө төлөөлүүлэн оролцуулахаар итгэмжлэгдсэн төлөөлөгч томилвол түүний төлөөлөх эрхийг зохих журмын дагуу бичгээр үйлдсэн итгэмжлэлээр нотолно.

Тендерт хэд хэдэн хуулийн этгээд хамтарч консорциумын хэлбэрээр оролцох тохиолдолд тэд зөвхөн нэг итгэмжлэгдсэн төлөөлөгчийг томилж, тендерт нэг оролцогч болж оролцоно.

Тендерт оролцох хүсэлтэд илэрхийлсэн өргөдлийг 2001 оны 10 дугаар сарын 5-ны өдрийн (Улаанбаатарын цагаар) 18.00 цагаас өмнө Төрийн өмчийн хороонд ирүүлнэ.

Урьдчилан шалгаруулалтын шалгуур

Тендерт оролцох эрхтэй болж, тендерийн баримт бичгүүдийг хүлээж авахын тулд дор дурдсан шаардлагыг хангасан байвал зохино. Үүнд:

1. Арилжааны банкны чиглэлээр 10-аас доошгүй жил ажилласан, өөрийн орноос бусад оронд олон улсын банкны үйл ажиллагаагаа 3-аас доошгүй жил эрхэлсэн байх;
2. 50 /тавин/ сая ам. долларааас доошгүй өөрийн хөрөнгөтэй байх;
3. Үйл ажиллагааны зэрэглэл тогтоодог олон улсын нэр хүнд бүхий агентлагаас санхүүгийн чадавхи, ашигт ажиллагааны талаар өндөр үнэлгээ авсан байх;
4. Монгол Улсын болон гадаадын улсын дор дурдсанаас бусад хуулийн этгээд тендерт оролцож болно:

- төрийн байгуллага,
- төрийн өмчит үйлдвэрийн газар,
- улсын төсөвт албан газар,
- төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж,
- улсын төсвийн хөрөнгөөр санхүүждэг төрийн бус байгуулага.

Урьдчилан шалгаруулалтын үр дүнг мэдэгдэх

Төрийн өмчийн хороо өргөдөл хүлээн авснаас хойш ажлын арван едерт багтаан урьдчилан шалгаруулалтын шалгуурыг ханган тендерт оролцох эрхтэй болж, тендерийн баримт бичгүүдийг авах болсон эсэх талаар өргөдөл гаргагчид мэдэгдэнэ. Энэхүү мэдэгдлийг буухиа шуудан, баталгаат шуудангаар өргөдөлд заасан хаягаар явуулна.

Урьдчилан шалгаруулалтын шалгууры ханган тендерт оролцогчдод тендерийн баримт бичгүүдийг мэдэгдлийн хамт хүргүүлнэ.

Тендерийн баримт бичгүүд

Тендерийн баримт бичгүүд гэдэгт:

1. Компанийн тухай ерөнхий мэдээлэл
2. Үралдаант шалгаруулалт /тендер/-ын журам
3. Хувьцаа худалдах, худалдан авах тухай гэрээний төслийн иж бүрдлийг ойлгоно.

Хувьчлах нөхцөл

"ХХБ" ХХК-ийн хувьцааны 76 хувийг худалдахад Засгийн газраас тавих нөхцөл:

1. "ХХБ" ХХК-ийн үйл ажиллагаат сайжруулах, бүс нутгийн хэмжээнд өрсөлдөх чадвартай банк болгох;

2. Олон улсын өргөн хүрээтэй туршлага, стандартад нийцэхүйц банкны хамгийн орчин үеийн мэргэжил мэдлэг, техник технологи, удирдлагын арга барилыг нэвтрүүлэх;

3. Банкны өөрийн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлснээр санхүүгийн зуучлалын хүрээг өргөтгөх, гадаадын болон дотоодын томоохон аж ахуйн нэгж, хөрөнгө оруулагчдын зээл ба зээлийн баталгааны эрэлт хэрэгцээг ханган чаддаг болгох, эрсдэлийг багасгах шинэ арга барилыг нэвтрүүлэх, аж ахуйн нэгж, иргэдэд илүү өргөн хүрээтэй иж бүрэн багц үйлчилгээг санал болгох, үйлчилгээний чанарыг сайжруулан үнэ өртгийг хямдруулах. Хувьцаа эзэмших эрх шилжэний дараахь хоёр жилийн хугацаанд Засгийн газраас тавих нөхцөлүүдийг ханган чиглэгдсэн тодорхой хэмжээний хөрөнгө оруулалтыг нэн даруй хийх тухай баталгаа гаргах;

4. Орчин үеийн банкны мэргэжил, мэдлэг, шинэ төрлийн үйлчилгээ нэвтрүүлэх замаар "мэргэжлийн хөрөнгө" оруулах.

Тендерийн ажиллагаа

Тендерт оролцогчид техникийн болон санхүүгийн саналаас бүрдэх тендерийн саналаа Төрийн өмчийн хороонд 2001 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн (Улаанбаатарын цагаар) 18.00 цагаас өмнө тендерийн дэнчин төлснийг нотлох баримтын хамт ирүүлнэ.

Тендерийн дэнчин гэж хувьцаа худалдах, худалдан авах тухай гэрээг байгуулах чадвар, санхүүгийн эх үүсвэрийн баталгаа болгон тендерт оролцогчоос төлөх 100 000 (нэг зуун мянган) ам. доллартай тэнцэх хүүгүй мөнгөн хадгаламж, эсвэл Төрийн өмчийн хорооны нэр дээр гаргасан буцалтгүй аккредитивийг хэлнэ. Тендерт оролцогчид дэнчинг Монгол Улсын "Монголбанк" дахь Төрийн өмчийн хорооны 3332404 дугаартай валютын дансанд байршуулна.

Тендерийн саналыг үнэлсний дараа тендерт оролцогч ялагчаар шалгараагүй тохиолдолд тендерийн дэнчинг /дэнчинг шилжүүлэх банкны дансны дугаарыг тодорхой заасан/ тендерт оролцогчийн хүсэлтийн дагуу ажлын долоо хоногт багтаан бүрэн буцаан олгоно.

Тендерт ялагчаар шалгарсан оролцогчийн дэнчинг худалдан авах үнэд оруулуулан тооцно.

Тендерийн саналаа бэлтгэхэд нь туслах зорилгоор тендерт оролцогчдыг Засгийн газрын холбогдох албан тушаалтан болон компанийн удирдлагатай уулзах, газар дээр нь танилцах бололцоогоор хангана. Тендерт оролцогчдыг хувьцаа худалдах, худалдан авах гэрээний төсөлд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай санал гаргах бололцоогоор хангана.

Техникийн саналыг дор дурдсан үзүүлэлтүүдээр шалгарууулна:

1. Тухайн салбарт үйл ажиллагаа явуулж ирсэн туршлага, санхүүгийн чадавхи, үйл ажиллагааны зэрэгтэл (0-40 оноо),

2. Санал болгож буй бизнесийн төлөвлөгөөний чанар, Засгийн газраас тавих нөхцелүүдийг хүлээн авч тусгасан байдал (0-40 оноо),

3. Байгаль орчны бохирдлыг арилгах, байгаль орчныг хамгаалах төсөл, үйл ажиллагааг зээлжүүлэх шалгуур (0-10 оноо),

4. Хүний нөөцийг хөгжүүлэх төлөвлөгөө (0-10 оноо).

Нийлбэр дүнгээр 70-аас доошгүй оноо авсан оролцогчийн техникийн саналыг шалгаруулна.

Санхүүгийн санал нь хувьцаа худалдан авах үнэ, хувьцаа эзэмших эрх шилжсэнээс хойшхи эхний хоёр жилийн хугацаанд компанид нэн даруй оруулахаар амлаж буй хөрөнгө оруулалтын хэмжээнээс бүрдэх бөгөөд дараахь байдлаар үнэлэгдэнэ:

1. Санал болгож буй худалдан авах үнийн ам. доллар бүрт нэг оноо;

2. Нэн даруй хийх хөрөнгө оруулалтын дүнгийн ам. доллар бүрт 0.75 оноо;

3. Эцсийн оноо нь худалдан авах үнэ болон нэн даруй оруулах хөрөнгө оруулалтын хэмжээнд тус тус ногдуулсан онооны нийлбэртэй тэнцэнэ.

Санхүүгийн саналын үнэлгээгээр хамгийн өндөр эцсийн оноо авсан оролцогчийг тендерийн ялагчаар шалгаруулна.

"ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК" ХХК-ийн тухай

"ХХБ" ХХК нь түү улсад ашигтай үйл ажиллагаа явуулж буй хамгийн том банк юм. "ХХБ" ХХК нь 1990 онд байгуулагдаж, 1991 оны 1 дүгээр

сараас үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн.

"ХХБ" ХХК-ийн нийт 2 000 000 ширхэг хувьцааны 76 хувийг буюу 1 520 000 ширхэг хувьцааг Монгол Улсын Засгийн газар эзэмшдэг. Үлдэх 24 хувь буюу 480 000 ширхэг хувьцааг тус банкны ажиллагсад эзэмшиж байна.

"ХХБ" ХХК нь хадгаламж, зээл, төслийн санхүүжилт, төгрөгийн болон гадаад валютын төлбөр тооцоо, кредит карт зэрэг үйлчилгээг хүний бөгөөс болон улсын үйлдвэр, аж ахуйн нэгж, төрийн байгууллага, хувь хүмүүст үзүүлж байна.

Монголын банкны салбарт "ХХБ" ХХК нь гадаад валют /гол төлөв амь. доллар/-ын гүйлгээ эрхлэх хөрөнгө хуримтлуулж буй гол банк юм. Тус банк нь дэлхийд хэрэглэгддэг гол гол кредит картыг хүлээн авч үйлчилдэг бөгөөд Американ Экспресс болон замын бусад чекийг борлуулах бүрэн эрхтэй юм.

"ХХБ" ХХК нь алт, зэс, жонш олборлох уул уурхайн үйл ажиллагаа, ноолуурын боловсруулалт болон экспорт, нефтийн бүтээгдэхүүний импорт, мах боловсруулалт, аялал жуулчлал, эрчим хүч, тээвэр зэрэг монголын эдийн засгийн үндсэн салбаруудыг санхүүжүүлэхэд идэвхтэй оролцож байна.

"ХХБ" ХХК-ийн зах зээлд эзлэх хувийг 2000 оны эцсийн байдлаар харуулав:

- Нийт зээл /цэвэр/ (36.4%)
- Харилцах, хадгаламж (41,9%)
- Нийт хөрөнгө (43,1%)
- Гадаад валют (78.9%)

"ХХБ" ХХК-ийн Улаанбаатар хотод орших төв салбарт банкны удирдлага, түүний газар, нэгжүүд байрладаг. Тус банк 8 салбар, 6 тооцооны төвтэй. Эдгээр салбарууд нь монголын хүн ам төвлөрсөн, төмөр зам дагуухи эдийн засгийн гол бүсүүдэд байрладаг. Банкны 3 салбар, тооцооны 4 төв нь Улаанбаатарт, бусад салбарууд нь Дархан-Уул, Дорноговь, Сэлэнгэ, Орхон болон Дорнод аймгийн төвд, тооцооны бусад төвүүд нь Замын-Үүд, Зүүнхараад тус тус оршдог.

Тус банк байгуулагдсанаасаа хойш одоог хүртэл Дэлхийн банк, ХБНГУ-ын Засгийн газраас Монгол Улсын Засгийн газарт олгосон төслийн зээлийг харилцагчдад дамжуулан зээлдүүлж, БНХАУ, Өмнөд Солонгос болон Энэтхэг Улсын Засгийн газраас олгосон зээлийн төлбөр тооцоог нь гүйцэтгэж байна.

1997 онд Дэлхийн банкны техникийн туслажтайгаар Норвегийн банктай "шууд харилцаа" (Bank Twinning Agreement) тогтоон ажилласж, олон улсын арилжааны банкны туршлага, орчин үеийн менежмент, технологийн арга барилыг нэвтрүүлж эхэлсэн.

Худалдаа, хөгжлийн банк 1997 онд "Хэрэглэгчидийн найдвартай түнш", 1999 онд "Найдвартай татвар төлөгч", "1999 оны шилдэг аж ахуйн нэгж", 2000 онд "Монгол Улсын тэргүүний татвар төлөгч", "Ниймгийн даатгалын шимтэл төлөгч тэргүүний байгуулагч"-аар тус тус шалгарч байсан.

"ХХБ" ХХК-ийн 1997, 1998, 1999, 2000 оны санхүүгийн тайланг олон улсын аудитын байгууллагаар баталгаажуулсан болно. 1997, 1998 оны санхүүгийн тайланд Артур Андерсен компани, 1999, 2000 оны санхүүгийн тайланд Ернст Энд Янг компани нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу аудит хийсэн. Санхүүгийн үндсэн үзүүлэлтүүдийг дараахь байдлаар харуулав:

- 2000 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар "ХХБ" ХХК-ийн нийт хөрөнгийн хэмжээ 97.4 тэрбум төгрөг (88.8 сая ам. доллар);
- Зээлийн нийт багц 27.7 тэрбум төгрөг (25.2 сая ам. доллар) бөгөөд түүнд 6.7 тэрбум төгрөгийн (6 сая ам. доллар) эрсдэлийн сан байгуулсан;
- Цэвэр зээл нь нийт хөрөнгийн 21.6%-тай тэнцүү;
- Нийт өр төлбөр 83.7 тэрбум төгрөг (76.3 сая ам. доллар), үүнийг 78 тэрбум төгрөг (71 сая ам. доллар) буюу 93.2% нь харилцагчийн хадгаламж зээлж байна;
- Өөрийн хөрөнгө 13.7 тэрбум төгрөг (12.5 сая ам. доллар) байсны 9 тэрбум төгрөг (8.3 сая ам. доллар) нь хуримтлагдсан ашиг;
- Хүүгийн орлого 10 тэрбум төгрөг (9.2 сая ам. доллар), хүүгийн зардал 1.5 тэрбум (1.4 сая ам. доллар) төгрөг;
- Комисс болон хураамжаас бүрдэх хүүгийн бус орлого 6 тэрбум төгрөг (5.6 сая ам. доллар) тус тус гарчээ.

Тус банк орлогынхоо ихэнх хувийг гадаад валютын гүйлгээ, зээлийн ба бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгийн хүүгийн зөрүүгээс олж байна. Бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгийн хүүгийн зардал бага байгаа нь харилцах дансанд бага хүү төлдөг, эсвэл огт төлдөггүйтэй холбоотой.

- 1998, 1999, 2000 онд зээлийн ба бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгийн хүүгийн зөрүү 13.79%, 10.36%, 9.45%;
- 1998, 1999, 2000 онд цэвэр ашгийн хувийн жин 19.35%, 35%, 41%;

Мөн онуудын жилийн эцсийн байдлаар нийт хөрөнгийн өгөөж 3.71%, 5.18%, 6.77%-тай тус тус гарчээ.

"ХХБ" ХХК-ийн зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд

	1998	1999	2000
Өөрийн хөрөнгийн хүрэлцээ (>=10%)	13.5%	32.7%	35.9%
Төлбөр түргэн гүйцэтгэх чадвар (>=18%)	54.6%	76.1%	77.3%
Зээлийн төвлөрлийн эрсдэл (<=20.0%)	47.5%	24.7%	16.0%
Гадаад валютынханшийн эрсдэл (< =+-20.0%)	-13.5%	12.2%	16.3%

"ХХБ" ХХК нь газар ашиглах/эзэмших гэрээний үндсэн дээр газар эзэмшдэг. Гэрээгээр ашиглах газрын нийт хэмжээ 6158 м². Газар ашиглах гэрээг 1999 оны 1 дүгээр сарын 1-нээс дөрвөн жилийн хугацаатай, газар эзэмших гэрээг мөн үеэс зургаан жилийн хугацаатай тус тус байгуулсан бөгөөд дахин шинэчлэх боломжтой. Газар ашиглах гэрээний дагуу газрын жилийн төлбөрийн хэмжээ 1 276 мянган төгрөг, улирал бүр төлөх төлбөрийн хэмжээ 319 мянган төгрөг. Газар эзэмших гэрээний дагуу газрын жилийн төлбөрийн хэмжээ 891,6 мянган төгрөг, улирал бүр төлөх төлбөрийн хэмжээ 222,9 мянган төгрөг.

"ХХБ" ХХК нь хүү, шимтгэлийн хэмжээг бууруулснаас гадаад төлбөр тооцооны орлого багассан боловч 2001 оны эхний хагас жилийн ашгийн төлөвлөгөөг биелүүлж чадсан.

2001 оны эхний хагас жилд татварын өмнөх ашиг 2000 оны мөн үетэй харьцуулахад 5.6 хувиар буюу 5.2 тэрбум төгрөг хүртэл өссөн байна. Цэвэр ашиг 2000 оны эхний хагас жилтэй харьцуулахад 3.8-аас 3.4 тэрбум төгрөг хүртэл буурсан нь орлогын татварын хэмжээ нэмэгдсэнтэй холбоотой.

"ХХБ" ХХК-ийн аудитаар баталгаажуулсан сүүлийн гурван жилийн санхүүгийн тайлан, аудитаар баталгаажуулаагүй 2000 ба 2001 оны эхний хагас жилийн санхүүгийн үзүүлэлтүүдийг нэг ба хоёрдугаар хавсралтаар харьцуулж үзүүлэв.

Хаяг

Тендерт оролцох албан ёсны өргөдөл болон тендерийн саналуудыг дараахь хаягаар ирүүлнэ үү:

Л.Пүрэвдорж
Төрийн өмчийн хорооны дарга
Засгийн газрын IY байр, 408 тоот өрөө
Улаанбаатар-11, Монгол Улс
Утас: 976-11-312460
Факс: 976-11-312798

Нэмэлт мэдээллийн талаар Төрийн өмчийн хорооны дээр дурдсан хаягаар болон Төрийн өмчийн хорооны зөвлөх "КПМЖ Консалтинг" компанийн Баренц бүлэгт дараахь хаягуудаар хандана уу:

Жеймс Двайер
Зөвлөх
E-mail: jbd35238@aol.com

Живко Ненов
Төслийн удирдагч
E-mail: znenov@magicnet.mn

Мелисса Данн
Төслийн дэд удирдагч
E-mail: mdunn@kpmg.com

Хаяг:
"КПМЖ консалтинг" компанийн
"Баренц бүлэг"
Төрийн өмчийн I байр, 301 тоот өрөө
Улаанбаатар-38
Монгол Улс
Утас: 976-11-324149
Факс: 976-11-324149

эсвэл

Teresa Slazas
Barents Group of KPMG Consulting, Inc
1676 International Drive
McLean, VA 22102, USA
Tel: +1 703-747-7698
Fax: +1 703-747-3919
E-mail: tslazas@kpmg.com

Электрон шуудан: barents@magicnet.mn

Компанитай холбоотой дэлгэрэнгүй мэдээллийг http://www.spc.gov.mn вэбсайтаас үзнэ үү.

Нэгдүгээр хавсралт

МОНГОЛЫН ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК

ОРЛОГО, YP ДҮНГИЙН ТАЙЛАН
(Мянган төгрөгөөр)

	1998	1999	2000
Хүү болон түүнтэй адилтгах орлого	7 977 548	8 919 704	10 060 103
Хүүгийн болон түүнтэй адилтгах зардал	(924 338)	(1 225 672)	(1 527 351)
Хүүгийн цэвэр орлого	7 053 210	7 694 032	8 532 752
Хураамж ба шимтгэл	1 743 092	2 124 077	2 291 840
Валютын арилжаа,ханшийн тэгшитгэлийн цэвэр орлого	870 540	750 576	807 277
Үйл ажиллагааны бусад орлого	65 565	235 072	2 942 680
Хүүгийн бус орлого	2 679 197	3 109 725	6 041 797
Үйл ажиллагааны ашиг	9 732 407	10 803 757	14 574 549
Үйл ажиллагааны зардал	(1 831 639)	(3 243 948)	(3 338 571)
Нөөцийн сан ба онцгой шинжтэй ашгаас өмнөх ашиг	7 900 768	7 559 809	11 235 978
Нөөцийн сан	(4 833 025)	(3 591 028)	(64 569)
Онцгой шинжтэй ашиг	-	1 735 982	-
Татварын өмнөх ашиг	3 067 743	5 704 763	11 171 409
Татвар	(1 005 709)	(1 491 187)	(4 573 948)
ЦЭВЭР АШИГ	**2 062 034**	**4 213 576**	**6 597 461**

ҮЛДЭГДЛИЙН ТЭНЦЭЛ

(Мянган төгрөгөөр)

	1998	1999	2000
Актив:			
Бэлэн мөнгө ба богино хугацаат нөөц	6 529 063	10 908 724	13 074 746
Санхүүгийн бусад байгууллага дахь харилцах, хадгаламж	15 430 672	30 923 223	38 921 400
Үнэт цаасаар оруулсан хөрөнгө оруулалт	11 105 042	17 758 183	16 390 466
Зээл ба урьдчилгаа	16 538 612	13 345 031	21 005 164
Засгийн газрын үнэт цаас	1 552 683	1 357 990	866 749
Үндсэн хөрөнгө	3 693 154	6 580 468	6 771 411
Бусад актив	733 414	488 923	379 974
НИЙТ АКТИВ	**55 582 640**	**81 362 542**	**97 409 910**
Пассив:			
Харилцагчдын харилцах, хадгаламж	43 527 526	65 870 494	77 980 552
Санхүүгийн бусад байгууллагуудын харилцах, хадгаламж	1 563 021	607 660	1 501 424
Гадаадын банкнаас авсан зээлийн эх үүсвэр	4 854 926	3 196 632	3 549 352
Нөгөдл ашгийн өглөг	1 819 099	634 716	-
Бусад пассив	293 021	80 800	69 267
Татварын өглөг	209 263	833 722	564 718
Хойшлогдсон татвар	156 924	-	-
Нийт пассив	52 423 780	71 224 024	83 665 313
Өөрийн хөрөнгө:			
Дүрмийн сан	963 000	1 500 000	1 500 000
Нөөцийн сан	-	3 217 672	3 152 619
Хуримтлагдсан ашиг	2 195 860	5 420 846	9 091 978
Нийт өөрийн хөрөнгө	3 158 860	10 138 518	13 744 597
НИЙТ ПАССИВ БА ӨӨРИЙН ХӨРӨНГӨ	55 582 640	81 362 542	97 409 910
Төгрөг/ам. долларын зах зээлийн ханш (хугацааны эцэст)	902.00	1072.37	1097.00

Хоёрдугаар хавсралт

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК
САНХҮҮГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД - 2000, 2001 оны II дугаар улирал

	2000.06.30 (мян. төг)	**2001.06.30** (мян. төг)
Хүүгийн цэвэр орлого	3 886 876	4 480 388
Хүүгийн бус орлого	2 574 693	2 284 503
Зээлийн эрсдэлийн сан	199 888	72 023
Татварын өмнөх орлого	4 890 790	5 164 999
Татварын дараахь орлого	3 783 667	3 448 632
Нийт актив	92 052 821	107 090 022
Цэвэр зээл	15 065 568	29 017 880
Нийт пассив	80 027 015	93 800 837
Бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгө	75 139 801	87 496 927
Нийт өөрийн хөрөнгө	12 025 806	13 289 185
Төгрөг/ам долларын зах зээлийн ханш (хугацааны эцэст)	**1 065.00**	**1 097.00**

Засгийн газрын 2001 оны 185 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

УРАЛДААНТ ШАЛГАРУУЛАЛТ /ТЕНДЕР/-ЫН ЖУРАМ

Нэг. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1 Монгол Улсын "Иргэний хууль", "Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль", Монгол Улсын Их Хурлын 2001 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 10 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн өмчийг 2001-2004 онд хувьчлах үндсэн чиглэл", Засгийн газрын 2001 оны 2 дугаар сарын 20-ны өдрийн 35 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн өмчийг 2001 онд хувьчлах хөтөлбөр"-ийн дагуу "Худалдаа хөгжлийн банк" ХХК /цаашид "ХХБ" эсвэл "банк" гэх/-ийн нийт хувьцааны 76 хувьд ногдох төрийн эзэмшлийн 1 520 000 ширхэг энгийн хувьцаа /цаашид "хувьцаа" гэх/-г нэг багц болгон уралдаант шалгаруулалт /тендер/-ын аргаар арилжааны банкны салбарын стратегийн хөрөнгө оруулагчид худалдахад энэхүү журам /цаашид "журам" гэх/-ыг мөрдөнө.

1.2 Монгол Улсын Төрийн өмчийн хороо нь эвлэлхүүдийн туслалцаатайгаар тендерийг зохион байгуулж явуулна.

Хоёр. НЭР ТОМЪЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ

Энэхүү журамд хэрэглэсэн нэр томъёог дор дурдсанаар тодорхойлно:

2.1 "Банк" гэж "Худалдаа хөгжлийн банк" ХХК-ийг хэлнэ.

2.2 "Арилжааны банкны салбарын стратегийн хөрөнгө оруулагч" гэж арилжааны банкны чиглэлээр баялаг туршлага хуримтлуулж, өөрийн орноос бусад оронд олон улсын банкны үйл ажиллагаат тодорхой хугацаанд зэрэлцэн хөрөнгө оруулагч буюу арилжааны банкны салбарын стратегийн хөрөнгө оруулагчаар толгойлуулан консорциумыг хэлнэ.

2.3 "Ерөнхий мэдээлэл" гэж тендерт оролцогч тус бүрт хүргэх ХХБ болон Монгол Улс, түүний бизнесийн орчны талаархи мэдээллийн баримт бичгийг хэлнэ.

2.4 "Дэнчин" гэж хувьцаа худалдах, худалдан авах тухай гэрээг байгуулах чадвар, санхүүгийн эх үүсвэрийн баталгаа болгон тендерт оролцогчоос төлөх 100 000 /нэг зуун мянган/ ам. доллартай тэнцэх хүүгүй менгөн хадгаламж, эсвэл Төрийн өмчийн хорооны нэр дээр гаргасан буцалтгүй аккредитивийг хэлнэ. Дэнчинг Монголбанк дахь Төрийн өмчийн хорооны дансанд байршуулна.

2.5 "Зар мэдээ" гэж Төрийн өмчийн хорооноос тендер явуулах тухай нийтэд сонордуулсан албан ёсны зар мэдээллийг хэлнэ.

2.6 "Зөвлөх" гэж Америкийн Нэгдсэн Улсын Олон улсын хөгжлийн агентлагийн туслamжтайгаар Төрийн өмчийн хороонд зөвлөх үйлчилгээ үзүүлж буй "КПМЖ Консалтинг" компанийн "Баренц бүлэг"-ийн зөвлөх /зөвлөхүүд/-ийг хэлнэ.

2.7 "Нууцыг хадгалах тухай гэрээ" гэж Төрийн өмчийн хороо, Монгол Улсын Засгийн газар болон зөвлөхүүдээс өгөх банктай холбоотой аливаа мэдээллийг ямар нэгэн хэлбэрээр тараах болон мэдээлэхийг хориглосон гэрээг хэлнэ.

2.8 "Нэн даруй хийх хөрөнгө оруулалтын хэмжээ" гэж тендерт оролцогчдоос хувьцаа эзэмших эрх шилжсний дараахь хоёр жилийн дотор компанид оруулахаар амласан бэлэн мөнгө болон зах зээлийн үнээр үнэлэгдэх бусад хэлбэрийн хөрөнгө оруулалтын мөнгөн дүнг хэлнэ.

2.9 "Өргөдөл" гэдэгт тендерт оролцогчоос ирүүлэх бүрэн бөглөсөн өргөдлийн маягт, зохих ёсоор үйлдэгдэж, өргөдөл гаргагчийг төлөөлөх эрх бүхий этгээдийн гарын үсэг зурсан нууцыг хадгалах тухай гэрээ болон тендерийн хураамж төлснийг нотлох баримтын ижил бүрдлийг ойлгоно. Итгэмжлэгдсэн төлөөлөгчийн төлөөлөх эрхийг зохих журмын дагуу бичгээр үйлдэж өргөдөлд хавсаргасан итгэмжлэлээр баталгаажуулна. Өргөдөл гаргагч тендерийн оролцогч болохын тулд урьдчилан шалгаруулалтад шаардагдах өөрийн компанийн болон консорциумын талаархи мэдээллийг өргөдөлд хавсаргасан байна.

2.10 "Тендерийн баримт бичгүүд" гэдэгт:

- Уралдаант шалгаруулалт /тендер/-ын журам,
- Ерөнхий мэдээлэл,
- Хувьцаа худалдах, худалдан авах тухай гэрээний төслийн иж бүрдлийг ойлгоно.

2.11 "Тендерт оролцогч" гэж тендерт оролцох өргөдөл гаргаж, урьдчилан шалгаруулалтын шаардлагыг хангаж, Төрийн өмчийн хороо өргөдлийг нь хүлээн авсан хуулийн этгээд буюу тэдгээрийн хамтарсан консорциумыг хэлнэ.

2.12 "Тендерийн санал" гэж тендерт оролцогчоос тендерт оролцохор ирүүлсэн саналыг хэлнэ. Тендерийн санал нь техникийн санал ба санхүүгийн саналаас бүрдэнэ.

2.13 "Тендерийн хураамж" гэж тендерийн баримт бичгүүдээр хангах үйлчилгээний хураамж болгон Төрийн өмчийн хороонд тендерт оролцогчоос төлөх 1 000 /нэг мянган/ ам. долларын төлбөрийг хэлнэ. Тендерийн хураамжийг бүгаан олгохгүй.

2.14 "Уралдаант шалгаруулалт /цаашид "тендер" гэх/" гэж тендерт оролцогдсоо ирүүлсэн тендерийн саналуудыг хянан үзэж, ялагчийг тодруулан, түүнтэй хувьцаа худалдах, худалдан авах гэрээ байгуулах үйл ажиллагаат хэлнэ.

2.15 "Хувьцаа худалдах, худалдан авах тухай гэрээний төсөл" гэж тендерт оролцогчдод танилцуулан тэдний саналыг авахаар Төрийн өмчийн хорооноос хүргүүлэх хувьцаа худалдах, худалдан авах гэрээний төслийн эхний хувилбарыг хэлнэ.

2.16 "Хувьцаа худалдах, худалдан авах тухай гэрээний шинэчилсэн төсөл" гэж хувьцаа худалдах, худалдан авах тухай гэрээний төслийн эхний хувилбарт тендерт оролцогчдоос өгсөн саналыг тусгасан шинэчилсэн хувилбарыг хэлнэ.

2.17 "Хувьцаа худалдах, худалдан авах тухай гэрээний эцсийн төсөл" гэж хувьцаа худалдах,

худалдан авах тухай гэрээний шинэчилсэн төсөлд тендерт оролцогчдоос санал болгосон нэмэлт, өөрчлөлтөөс хүлээн авч болохуйц саналуудыг тусган Төрийн өмчийн хороонооос зцэслэн бэлтгэж гаргах төслийг хэлнэ.

2.18 "Худалдан авах үнэ" гэж банкны хувьцааг худалдан авахаар тендерт оролцогчоос санал болгож буй үнийн дүнг хэлнэ.

ГУРАВ. ТЕНДЕРИЙН ХУВААРЬ

3.1 Тендерийг энэхүү журамд хавсаргасан хуваарийн дагуу зохион байгуулж явуулна.

ДӨРӨВ. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧ

4.1 Тендерт оролцогч, түүний эрх зүйн байдал

4.1.1 Монгол Улсын болон гадаадын улсын дор дурдсанаас бусад хуулийн этгээд тендерт оролцож болно:

1. төрийн байгууллага,
2. төрийн өмчит үйлдвэрийн газар,
3. улсын төсөвт албан газар,
4. төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж,
5. улсын төсвийн хөрөнгөөр санхүүждэг төрийн бус байгууллага.

4.1.2 Хуулийн этгээд дангаараа эсвэл хамтарч консорциумын хэлбэрээр тендерт оролцож болно. Консорциумыг арилжааны банкны салбарын стратегийн хөрөнгө оруулагч толгойлсон байна.

4.1.3 Тендерт оролцогч тендерт өөрийгөө төлөөлүүлэн оролцуулахаар итгэмжлэгдсэн төлөөлөгч томилвол түүний төлөөлөх эрхийг зохих жүрмын дагуу бичгээр үйлдсэн итгэмжлэлээр баталгаажуулна.

4.1.4 Тендерт хэд хэдэн хуулийн этгээд хамтарч консорциумын хэлбэрээр оролцож байгаа бол тэд зөвхөн нэг итгэмжлэгдсэн төлөөлөгчийг томилж, тендерт нэг оролцогч болж оролцоно.

4.2 Тендерт оролцогчийн эрх

4.2.1 Оролцогч нь тендерт оролцох өргөдлөө ирүүлж, урьдчилан шалгаруулалтын шалгууруудыг хангаснаар Төрийн өмчийн хороонооос батлуулж, тэмдэг дарсан тендерийн баримт бичгүүдийн иж бүрдэл нэг хувийг авах эрхтэй хангагдана.

4.2.2 Тендерт оролцогчид дараахь эрх эдэлнэ:

1. Мэдээллийн танхимд тавигдсан мэдээллийг ашиглах,

2. Төрийн өмчийн хороонооос батлагдсан хуваарийн дагуу банктай танилцах, дун шинжилгээ хийх, банкны удирдлага болон холбогдох хүмүүстэй уулзах, барилга байгуулламжийг үзэх,

3. Төрийн өмчийн хороонооос бичгээр зөвшөөрөл авсны үндсэн дээр Монгол Улсын Засгийн газрын ажилтнуудтай уулзах,

4. Энэхүү журам болон тендерийн үйл ажиллагаатай холбогдсон мэдээллийн талаар тайлбар авах хүсэлт тавих зорилгоор Төрийн өмчийн хороны банк хариуцсан итгэмжлэгдсэн төлөөлөгчтэй уулзах.

Тайлбар авах хүсэлтийг англи буюу монгол хэл дээр үйлдэж, Төрийн өмчийн хороонд дараахь хаягаар бичгээр ирүүлнэ:

Л. Пүрэвдорж
Төрийн өмчийн хорооны дарга
Засгийн газрын IУ байр, 408-р өрөө
Улаанбаатар-11, Монгол Улс
Утас: 976-11-312460
Факс: 976-11-312798

Төрийн өмчийн хороо ирсэн бүх хүсэлтэд бичгээр хариулт өгөх бөгөөд асуулт, хариултын хувийг тендерт оролцогч бүрт тэдний өргөдөл дээр заасан хаягаар хүргүүлнэ. Иймхүү хүргүүлэхдээ буухиа шуудан, баталгаат захиа, факс, эсвэл электрон шууданг ашиглаж болно.

Тендерийн санал авах хугацаа дуусахаас ажлын таваас доош өдерт ирүүлсэн тайлбар авах хүсэлтийг Төрийн өмчийн хороо хүлээж авахгүй байж болно.

5. Монгол Улсын "Иргэний хууль", "Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль"-д заасан бусад эрх эдлэх.

4.3 Тендерт оролцогчийн үүрэг

Тендерт оролцогч нь дараахь үүрэгтэй:

4.3.1 Өөрийн бизнес, эрх зүй, санхүүгийн байдлын талаар үнэн зөв мэдээлэл өгөх,

4.3.2 Тендерт оролцох явцад өөрийн бизнес, эрх зүй, санхүүгийн байдалд гарсан, тендерт оролцоход нь нөлөөлж болзошгүй аливаа материаллаг өөрчлөлтийн талаар Төрийн өмчийн хороонд нэн даруй мэдээлэх,

4.3.3 Банкны хувьцааг худалдан авах талаар тендерийн бусад оролцогчидтой ямар нэгэн харилцаа холбоо болон хэлэлцээрийн аливаа хэлбэрт орохгүй байх,

4.3.4 Банктай байгуулсан буюу байгуулахаар төлөвлөж байгаа бизнесийн аливаа гэрээ, хэлэлцээрийн талаар Төрийн өмчийн хороонд бичгээр мэдэгдэх,

4.3.5 Тендерт оролцох буюу оролцохтой холбогдон гарах бүх зардлыг өөрөө хариуцах,

4.3.6 Монгол Улсын хууль тогтоомж болон энэхүү журмыг сахин биелүүлэх.

ТАВ. ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧГҮҮД

5.1 Тендерт оролцогч тус бүрт үралдаант шалгаруулалт /тендер/-ын журам, банкны талаархи өрөнхий мэдээллэл болон хувьцаа худалдах, худалдан авах тухай гэрээний төслөөс бүрдсэн тендерийн баримт бичгүүдийн нэг иж бүрэн багцыг олгоно.

5.2 Төрийн өмчийн хорооноос өгөх тендерийн баримт бичгүүдэд Төрийн өмчийн хороны тэмдэг дарсан байна.

5.3 Төрийн өмчийн хороо болон зөвлөхүүд тендертэй холбоотой аливаа мэдээллийг аль болох бүрэн хэмжээгээр тендерийн баримт бичгүүдэд оруулна. Эдгээр мэдээллийг ашиглахтай холбоотойгоор үүсч болох аливаа үүрэг, хариуцлагыг Төрийн өмчийн хороо болон зөвлөхүүдийн аль аль нь хүлээхгүй.

ЗУРГАА. БАНК ДЭЭР ОЧИЖ ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙХ

6.1 Тендерт оролцогчдыг тэдгээрийн хүсэлтийн дагуу Засгийн газрын холбогдох албан тушаалтан болон компанийн удирдлагатай уялзх, газар дээр нь танилцах бололцооогоор хангана.

6.2 Тендерт оролцогчдыг техникийн саналаа бэлтгэх зорилгоор банк дээр очиж банкны хөрөнгө, өр төлбөрийн талаар нарийвчилсан дүн шинжилгээ хийх, ХХБ-ны хувьчлалын дараахь үйл ажиллагаанд Засгийн газраас тавих нөхцөлүүдийг Засгийн газрын ажилтан болон зөвлөхүүдтэй хэлэлцэх бололцооогоор хангана. Төрийн өмчийн хороо тендерт оролцогч тус бүрт банк дээр очиж банкны үйл ажиллагаанд нарийвчилсан дүн шинжилгээ хийхэд зориулж ойролцоогоор хоёр долоо хоногийн хугацаа олгоно. Дүн шинжилгээний хугацаанд тендерт оролцогчид банкны удирдлага, ажилтнуудтай уялзах өргөн боломжоор хангагдах бөгөөд санхүүгийн болон нягтлан бодох бүртгэлийн баримтууд, түүнчлэн компьютерийн систем, салбар, тооцооны төв, бусад нэгжүүдийн барилга байгууламжийн байдал, өөрсдийн сонирхсон хүрээнд аливаа бусад асуудлыг судлах эрхээр хангагдана.

6.3 Төрийн өмчийн хороо нь банк дээр очиж дүн шинжилгээ хийх хуваарийг хүсэлт хүлээж авсан дараалаагаар гаргаж, тендерт оролцогчдод энэ тухай факс буюу электрон шуудангаар мэдэгдэнэ.

6.4 Тендерт оролцогч нь тендерийн саналаа ирүүлснээр банкны байдал, үйл ажиллагаагүй судлан зөвшөөрч, Төрийн өмчийн хороонооос буюу түүний өмнөөс банкны талаар гарган өгсөн бүх мэдээллийн үнэн зөв болохыг албан ёсоор хүлээн зөвшөөрсөнд тооцогдоно. Байгаа мэдээлэл, бодит байдалтай танилцаж чадаагүй тендерт оролцогч нь тендерийн санал, хувьцаа худалдах, худалдан авах тухай гэрээний төслийг боловсруулах үүргээс чөлөөлөгдөхгүй. Төрийн өмчийн хороо, түүний зөвлөх, ХХБ, тэдгээрийн төлөөлөгчдээс гаргаж өгсөн мэдээлэлд үндэслэн тендерт оролцогчийн гаргасан дүгнэлт, тайлбарын талаар Төрийн өмчийн хороо, түүний зөвлөх, тендерийн комисс, ХХБ, тэдгээрийн төлөөлөгчдийн аль аль нь хариуцлага хүлээхгүй.

6.5 Тендерт оролцогч дүн шинжилгээ хийхгүй байхаар шийдвэрлэсэн тохиолдолд тендерийн санал өгөх эрхтэй хэвээр үлдэнэ.

ДОЛОО. ХУВЬЦАА ХУДАЛДАХ, ХУДАЛДАН АВАХ ТУХАЙ ГЭРЭЭНИЙ ТӨСЛИЙГ ЭЦЭСЛЭН БОЛОВСРУУЛАХ

7.1 Тендерт оролцогчдоос 2001 оны 10 дугаар сарын 15-ны дотор Төрийн өмчийн хороонд ирүүлж санал болгосон нэмэлт, өөрчлөлтүүдийг харгалзан Төрийн өмчийн хороо хувьцаа худалдах, худалдан авах тухай гэрээний төслөд нэмэлт, өөрчлөлт оруулж, үг гэрээний шинэчилсэн төслийг боловсруулж болно.

7.2 Төрийн өмчийн хороо хувьцаа худалдах, худалдан авах тухай гэрээний шинэчилсэн төслийг боловсруулсан тохиолдолд энэ тухай тендерт оролцогч тус бүрт мэдэгдэж, шинэчилсэн төслийн хувийг 2001 оны 10 дугаар сарын 22-ны дотор тараана.

7.3 Тендерт оролцогчдод хувьцаа худалдах, худалдан авах тухай гэрээний шинэчилсэн төслөд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай саналаа 2001 оны 10 дугаар сарын 29-ний дотор ирүүлэхийг санал болгоно. Энэ едреес хойш ирүүлсэн санал, тайлбарыг хүлээж авахгүй.

7.4 Тендерт оролцогчдоос хувьцаа худалдах, худалдан авах тухай гэрээний шинэчилсэн төсөлд оруулахаар санал болгосон нэмэлт, өөрчлөлтүүдийг харгалзан Төрийн өмчийн хороо хувьцаа худалдах, худалдан авах тухай гэрээний эцсийн төслийг боловсруулж, тендерт оролцогч тус бүрт 2001 оны 11 дүгээр сарын 5-ны дотор тараана.

НАЙМ. ТЕНДЕРИЙН САНАЛ БЭЛТГЭХ, САНАЛ ИРҮҮЛЭХЭД ТАВИГДАХ ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

8.1 Бүх мөнгөн дүнг Америкийн Нэгдсэн Улсын доллараар илэрхийлнэ.

8.2 Тендерт оролцогчид тендерийн саналыг англи, монгол хэл дээр бэлтгэж, тус бүр нэг эх хувь болон таван хуулбарыг ирүүлнэ.

8.3 Саналын эх хувь болон хуулбарүудын хооронд аливаа зөрүү гарах тохиолдолд эх хувийг баримтална.

8.4 Тендерийн саналыг бэлтгэсэн хэл дээрх эх хувь болон орчуулгын хооронд зөрүү гарах тохиолдолд эх хувийг баримтална. Тендерийн саналд аль хэлийг "эх хувийг бэлтгэсэн хэл" болохыг заавал заана.

8.5 Тендерт оролцогч буюу түүний итгэмжлэгдсэн төлөөлөгч тендерийн саналын хуудас бүрт хар буюу хөх өнгийн бэхээр гарын үсэг зурна. Итгэмжлэгдсэн төлөөлөгчид олгосон эрхийг зохих журмын дагуу бичгээр гаргаж, тендерийн саналд хавсаргасан итгэмжлэлээр баталгаажуулна.

8.6 Тендерийн саналд оруулсан бүх засварт тендерт оролцогч буюу түүний итгэмжлэгдсэн төлөөлөгч гарын үсгээ зурах буюу эсвэл нэрийнхээ эхний үсгийг тавьж баталгаажуулна.

8.7 Тендерийн саналыг шуудангаар ирүүлсэн тохиолдолд Төрийн өмчийн хороон дээр хүлээн авсан өдрийг тендерийн санал ирүүлсэн өдөр гэж тооцно.

8.8 Төрийн өмчийн хороо тендерийн саналыг хүлээж авсан огноо, цагийг тэмдэглэсэн баримтыг оролцогч тус бүрт илгээж хүлээн авснаа батална. Шуудангаар ирүүлсэн тендерийн саналд хариу илгээх факсын дугаарыг заагаагүй тохиолдолд хүлээн авсан тухай баримтыг ирүүлсэн саналын дугтуйн дээрх хаягаар юмуу тендерт оролцогчийн Төрийн өмчийн хорооны бүртгэлд тусгагдсан хаягаар илгээнэ.

8.9 Тендерт оролцогч нь тендерийн санал хүлээн авах хугацаа дуусахаас өмнө Төрийн өмчийн хороонд бичгээр мэдэгдэж, тендерийн саналаа өөрчлөх, эсвэл татан авах эрхтэй.

ЕС. ДЭНЧИН

9.1 Тендерийн саналаа ирүүлэх хүсэлтэй тендерт оролцогчид хувьцаа худалдах, худалдан авах тухай гэрээг байгуулах чадвар, санхүүгийн эх үүсвэрийн баталгаа болон тендерт

оролцох хүсэлтээ баталж Төрийн өмчийн хороонооо валютын харилцах дансанд 100000 /нэг зуун мянган/ америк долларын дэнчин төлнө. Тендерийн дэнчинг дор дурдсан дансанд төлнө. Үүнд:

Банкны нэр:	Монгол Улсын "Монголбанк"
SWIFT код:	BOMUMNUB
Дансны нэр:	Төрийн өмчийн хороо
Дансны дугаар:	3332404

Монголбанкны харилцагч банк: Federal Reserve Bank of New York, NY, USA
SWIFT код: FRNYUS33
Дансны дугаар: 021088506
Дансны нэр: Монголбанк

Тендерийн дэнчин төлснийг нотолсон банкны баримтын хуулбарыг техникийн саналд хавсаргана.

9.2 Тендерт оролцогч нь дэнчин тавиагүй тохиолдолд тендерт оролцох эрхгүй.

9.3 Тендерт ялагчаар шалгарсан оролцогчийн тавсан дэнчинг хувьцаагаар хүдалдаж авах үнэд оруулан тооцно.

9.4 Тендерийн саналыг үнэлсний дараа, тендерт оролцогч ялагчаар шалгараагүй тохиолдолд тендерийн дэнчинг тендерт оролцогчийн хүсэлтийн дагуу ажлын долоон өдерт багтаан бүрэн бүцаан олгох бөгөөд хүсэлтэд дэнчинг шилжүүлэх банкны дансны дугаарыг тодорхой заана.

9.5 Тендерийн дэнчинг дараахь тохиолдолд бүцааж олгохгүй:

1. Ялагч нь санхүүгийн саналтайгаа хамт англи, монгол хэл дээр тус бүр хоёр хувь үйлдэж, хувь тус бүр дээр гарын үсэг зурсан хувьцаа хүдалдах, хүдалдан авах тухай гэрээний эцсийн хувилбарыг ирүүлээгүй бүюу түүний итгэмжлэгдсэн төлөөлөгч тендерийн үр дүнгийн тухай мэдэгдэл / тэмдэглэл/-д гарын үсэг зурахаас татгалзсан.

2. Ялагч нь хувьцаа хүдалдах, хүдалдан авах тухай гэрээний нөхцөл, болзлын дагуу хүдалдан авах үнийн төлбөрийг хийгээгүй.

9.6 Дэнчинд хүү төлөхгүй.

9.7 Дэнчин төлөхтэй холбогдсон банкны бүх зардлыг тендерт оролцогч хариуцна.

АРАВ. ТЕНДЕРИЙН САНАЛЫГ БЭЛТГЭН ИРҮҮЛЭХ

10.1 ХХБ-ны хувьцааны 76 хувийг хүдалдахад Засгийн газраас дараахь нөхцөл тавина. Үүнд:

1. ХХБ-ны үйл ажиллагааг сайжруулах, бүс нутгийн хэмжээнд өрсөлдөх чадвартай банк болгох;

2. Олон улсын өргөн хүрээтэй туршлага, стандартад нийцэхүйц банкны хамгийн орчин үеийн мэргэжил мэдлэг, техник технологи, удирдлагын арга барилыг нэвтрүүлэх;

3. Банкны өөрийн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлснээр санхүүгийн зуучлалын хүрээг өргөтгөж, гадаадын болон дотоодын томоохон аж ахуйн нэгж, хөрөнгө оруулагчдын зээл ба зээлийн баталгааны эрэлт хэрэгцээг хангаж чаддаг болгох, эрсдэлийг багасгах шинэ арга барилыг нэвтрүүлэх, аж ахуйн нэгж, иргэдэд илүү өргөн хүрээтэй иж бүрэн багц үйлчилгээг санал болгох, үйлчилгээний чанарыг сайжруулан үнэ өртгийг бууруулах. Хувьцаа эзэмших эрх шилжсэний дараахь хоёр жилийн хугацаанд Засгийн газраас тавих нөхцөлүүдийг хангахад чиглэгдсэн тодорхой хэмжээний хөрөнгө оруулалтыг нэн даруй хийх тухай баталгаа гаргах;

4. Орчин үеийн банкны мэргэжил, мэдлэг, шинэ төрлийн үйлчилгээ нэвтрүүлэх замаар "мэргэжлийн хөрөнгө" оруулах.

10.2 Тендерийн санал дараахь хоёр хэсгээс бүрдэнэ. Үүнд:

· Техникийн санал /бизнесийн төлөвлөгөөний хамт/

· Санхүүгийн санал

10.3 Техникийн болон санхүүгийн саналын англи, монгол хэл дээрх эх хувь болон хуулбаруудыг "ЭХ ХУВЬ", "ХУУЛБАР", "ТЕХНИКИЙН САНАЛ", "САНХҮҮГИЙН САНАЛ" гэж хаяглан тус тусад нь битүүмжлэн дүгуйлна. Эдгээр дүгуйг өөр дүгуйд давхар хийж битүүмжилнэ. Гаднаҳ дүгуй дээр Төрийн өмчийн хорооны хаяг, тендерт оролцогчийн албан ёсны нэр, хаягийг бичиж:

"ХХБ ХХК-ийн хувьцаа хүдалдан авах нууц санал - Тендерийн Санал.

ТЕНДЕРИЙН КОМИССЫГ БАЙЛҚУУЛАХГҮЙГЭЭР НЭЭХИЙГ ХОРИГЛОНО" гэсэн тэмдэглэл хийнэ.

Тендерийн саналыг Төрийн өмчийн хорооны дараахь хаягаар 2001 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн (Улаанбаатарын цагаар) 18.00 цагаас өмнө ирүүлнэ.

Л. Пүрэвдорж
Төрийн өмчийн хороо дарга
Засгийн газрын IY байр, 408-р ерее
Улаанбаатар-11, Монгол Улс
Утас: 976-11-312460
Факс: 976-11-312798

10.4 Техникийн санал

Техникийн санал нь дор дурдсан хэсгүүдээс бүрдэнэ. Үүнд:

А. Тендерт оролцогчийн талаархи мэдээлэл. Үүнд:

1. Тендерт оролцогчийн бизнесийн үйл ажиллагааны чиглэл, компанийн бүтэц, ариллаганы банк болон олон улсын банкны үйл ажиллагааны дэлгэрэнгүй танилцуулга /консорциумаар оролцож байгаа тохиолдолд хамтарч бүй компаниудын үйл ажиллагаа/,

2. Суүлчийн гурван жилийн эцсийн байдлаар гаргаж аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан тэнцэл /нээлттэй компанийн хувьд хувьцаа эзэмшигчдэд зориулсан жилийн тайлан/. Суүлчийн жилийн санхүүгийн тайланг англи, монгол хэл дээр ирүүлэх бөгөөд түүнээс өмнөх хоёр жилийн санхүүгийн тайланг англи хэл дээр ирүүлж болно.

3. Тендерт оролцогч компанийн нийт гаргасан хувьцааны тавааc дээш хувийг эзэмшиж буй хувьцаа эзэмшигчдийн жагсаалт,

4. Тендерт оролцогчоос санал болгож буй тендерт хамаатай байж болох бусад мэдээлэл.

Б. Банкны үйл ажиллагааны төлөвлөгөө. ХХБ-г цаашид хөгжүүлэх хоёроос доошгүй жилийн төлөвлөгөөнд дор дурдсан зорилт, арга хэмжээг тусгасан байвал зохино:

1. Стратегийн зорилт, түүнд ирээдүйд банкны үндсэн үйл ажиллагаанд хийх хөрөнгө оруулалтыг тусган оруулах,

2. Санал болгож, сонгож буй зах зээлийн хүрээ,

3. Үйлчилгээний хөгжил , нэр төрөл, арга хэмжээ,

4. Төлөвлөж буй санхүүгийн үндсэн үзүүлэлтүүд /активын өгөөж, өөрийн хөрөнгийн өгөөж, өөрийн хөрөнгийн хүрэлцээ г.м./, хоёр жилийн санхүүгийн прогноз /Орлого, үр дүнгийн тайлан, Тайлан тэнцэл, Мөнгөн урсгалын тайлан/,

5. Банкны мэдээллийн технологи ба дэд бүтцийг хөгжүүлэх хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, түүнийг хэрэгжүүлэх хугацаа, өртөг зардлын бүтэц,

6. Дундаж цалингийн доод хэмжээ, үндсэн ажиллагсдын тоо эзэгийг тусгасан хүний нөөцийг хөгжүүлэх төлөвлөгөө /хөдөлмөр өрхлэлтийн түвшин, цалин урамшуулал, мэргэжил дээшлүүлэх сургалтын хөтөлбөр г.м./, гадаадын удирдлагын бүрэлдэхүүн, тоо, албан тушаал,

7. Байгаль орчны бохирдлыг арилгах, байгаль орчныг хамгаалахад чиглэгдсэн үйл ажиллагаа, түүнийг санхүүжүүлэхэд олгох зээлийн шалгуурыг мөрдөх зарчим.

В. Тендерийн дэнчин төлснийг нотлох баримт

Г. Тендерийн энэхүү журмын сүүлчийн хуудсанд гарын үсэг зурсан хуулбар. Тендерт оролцогч нь Тендерийн журамд гарын үсэг зурснаар энэхүү журмын заалтыг сахин мөрдөхийг хүлээн зөвшөөрснөө илэрхийлнэ.

Д. Тендерт оролцохыг зөвшөөрч хуулийн этгээдийн удирдах байгууллагаас гаргасан шийдвэр.

10.5 Санхүүгийн санал

Санхүүгийн санал нь дор дурдсан хэсгүүдээс бүрдэнэ. Үүнд:

А. ХХБ ХХК-ийн нийт хувьцааны төрийн эзэмшлийн 76 хувьд ногдох 1 520 000 ширхэг хувьцааг худалдан авах үнэ.

Б. Хувьцаа шилжүүлсний дараахь хоёр жилийн дотор банкинд нэн даруй хийх хөрөнгө оруулалтын хэмжээ. Эдгээр хөрөнгө оруулалт нь банкийг хөгжүүлэх, үйл ажиллагаагаа сайжруулахад шууд чиглэгдсэн байх шаардлагатай.

В. Тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн гарын үсэг зурсан Хувьцаа худалдах, худалдан авах тухай гэрээний эцсийн төслийн англи болон монгол хэл дээрх тус бүр хоёр ижил эх хувь.

Хувьцаа худалдах, худалдан авах тухай гэрээний эцсийн төслийн гарын үсэг зурсан бүх эх хувийг санхүүгийн саналын эх хувьд хавсаргана. Хувьцаа худалдах, худалдан авах тухай гэрээний эцсийн төслийн гарын үсэг зурсан англи болон монгол хэл дээрх эх хувийн хуулбаруудыг санхүүгийн саналын бүх хуулбарт хавсаргана.

Хувьцаа худалдах, худалдан авах тухай гэрээний эцсийн төсөлд дараахь зүйлийг хавсаргана:

1. Гэрээнд гарын үсэг зурахыг зөвшөөрсөн хуулийн этгээдийн удирдах байгуллагын шийдвэр,

2. Итгэмжлэгдсэн төлөөлөгчид дараахь эрх олгосныг нотлох итгэмжлэл:

§ Гэрээнд гарын үсэг зурах,

§ Санхүүгийн саналыг нээх ажиллагаанд Тендерт оролцогчийг төлөөлөх.

Тендерт оролцогчийг өрөвдөлд хавсаргасан итгэмжлэлд эдгээр эрхийг / итгэмлэгдсэн төлөөлөгчид олгосон тохиолдолд итгэмжлэлийн хувийг хавсаргана.

АРВАН НЭГ. ТЕНДЕРИЙН САНАЛЫН ҮНЭЛГЭЭ

11.1 Төрийн өмчийн хороо тендерийн саналуудад үнэлгээ хийлгүүлэх зорилгоор тендерийн комиссыг томилно. Тендерийн саналыг үнэлэх үйл ажиллагаа нь дараахь хоёр үе шаттай байна. Үүнд:

- Техникийн саналын үнэлгээ,
- Санхүүгийн саналын үнэлгээ.

11.2 Тендерийн комисс нь техникийн саналуудыг дор дурдсан шалгарууллах үзүүлэлтүүдийг үндэслэн онооны системээр үнэлнэ. Үүнд:

1. Тухайн салбарт үйл ажиллагаа явуулж ирсэн туршлага, санхүүгийн чадавхи, үйл ажиллагааны зэрэглэл (0-40 оноо),

2. Санал болгож буй бизнесийн төлөвлөгөөний чанар, Засгийн газраас тавих нөхцөлүүдийг хүлээн авч тусгасан байдал (0-40 оноо),

Дэд үзүүлэлт:

§ Бизнесийн төлөвлөгөөний цар хүрээ, тодорхой байдал (0-10 оноо),

§ Засгийн газраас тавих нөхцөлүүдэд төлөвлөгөө, стратегийн нийцэн байдал (0-30 оноо),

3. Байгаль орчны бохирдлыг арилгах, байгаль орчныг хамгаалах төсөл, үйл ажиллагаат зээлжүүзх шалгуур (0-10 оноо),

4. Хүний нөөцийг хөгжүүлэх төлөвлөгөө (0-10 оноо).

11.3 Нийлбэр дүнгээр 70-аас доошгүй оноо авсан техникийн саналыг шалгаруулна.

11.4 Техникийн саналыг үнэлэх үйл ажиллагаат дуусгасны дараа тендерийн комисс нь техникийн саналын үнэлгээнийг тайлан гаргана.

11.5 Техникийн үнэлгээ дууссаны дараа Төрийн өмчийн хороо техникийн санал нь тэнцсэн оролцогчдод тендерт цаашид оролцохоор шалгарсан тухай болон санхүүгийн саналыг нээхээр товлосон газар, цагийг мэдэгдэнэ. Төрийн өмчийн хороо техникийн санал нь тэнцээгүй оролцогчдод энэ тухай болон дэнчинг буцаан олгох тухай мэдэгдэнэ. Мэдэгдлийг бүхнээ шуудан, факс буюу электрон шуудангаар явуулж болно.

11.6 Санхүүгийн саналуудыг тендерт оролцогчдын итгэмжлэгдсэн төлөөлөгчдийг байцуулан нийтийн өмнө тендерийн хуваарьт заасны дагуу 2001 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр задална.

11.7 Техникийн саналын үнэлгээгээр 70-аас доошгүй оноо авсан тендерт оролцогчдын санхүүгийн саналыг нээж үнэлнэ.

11.8 Тендерт оролцогчийн нэр, санал болгож буй худалдан авах үнэ болон нэн даруй хийх хөрөнгө оруулалтын хэмжээг чангаар уншиж, бүртгэнэ. Тендерийн комисс Санхүүгийн санал болгонд Хувьцаа худалдах, худалдан авах гэрээний

эцсийн төслийг хавсаргаж, зохих ёсоор гарын үсэг зурсан эсэхийг шалгах ба санхүүгийн саналуудыг нийтийн өмнө задлах ажиллагааны тэмдэглэлэ хөтөлнө.

11.9 Тендерийн комисс нь санхүүгийн саналуудыг дор дурдсан онооны системээр үнэлнэ. Үүнд:

1. Санал болгож буй худалдан авах үнийн дүнгийн ам. доллар бүрт нэг оноо,
2. Нэн даруй хийх хөрөнгө оруулалтын дүнгийн ам. доллар бүрт 0.75 оноог тус тус ногдуулна.
3. Эцсийн оноо нь худалдан авах үнэ болон нэн даруй оруулах хөрөнгө оруулалтын хэмжээнд тус тус ногдуулсан онооны нийлбэртэй тэнцэнэ.

11.10 Хоёр буюу түүнээс дээш тендерт оролцогчид ижил оноо авсан тохиолдолд тэдгээрийг техникийн саналын үнэлгээгээр авсан онооны дагуу эрэмбэлнэ. Хэрэв техникийн саналын үнэлгээгээр авсан оноо нь мөн тэнцсэн тохиолдолд худалдан авах үнийн шинэ саналыг нэг цагийн дотор бичгээр өгөх боломж олгоно. Хэрэв хоёр буюу түүнээс дээш тендерт оролцогчдын эцсийн оноо нь дахин тэнцвэл худалдан авах үнийнхээ саналыг нэг цагийн дотор дахин шинэчлэх боломж олгоно. Энэ ажиллагаат аль нэг тендерт оролцогч бусдаасаа хамгийн өндөр эцсийн оноотой болох хүртэл үргэлжлүүлэн явуулна.

11.11 Санхүүгийн саналыг албан ёсоор нээж үнэлсэн өдрөө тендерийн комисс нь тендерийн үр дүнгийн мэдэгдэл /протокол/-ийн төслийг бэлтгэж, Төрийн өмчийн хороогоор хянуулан батлуулах зорилгоор нээлттэй хуралдааны ажиллагаат түр завсарлана.

11.12 Тендерийн комисс, Төрийн өмчийн хорооны гишүүд мөн өдөр нээлттэй хамтарсан хуралдаан хийж, Төрийн өмчийн хорооны даргын гарын үсэг зурсан тендерийн нэгдсэн мэдэгдэл / протокол/-ийг үншиж тендерийн үр дүнг зарлана.

11.13 Ялагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийг тендерийн үр дүнгийн мэдэгдэл / протокол/-д гарын үсэг зурахыг урих бөгөөд түүнд уг мэдэгдлийн гарын үсэг зурсан хувийг Төрийн өмчийн хорооны даргын гарын үсэг бүхий Хувьцаа худалдах, худалдан авах гэрээний эх хувьтай хамт олгоно.

АРВАН ХОЁР. ТЕНДЕРИЙГ ЯВАГДААГҮЙД БОЛОН ХҮЧИНГҮЙД ТООЦОХ, ӨРГӨДӨЛ, САНАЛ ИРҮҮЛЭХ ХУГАЦААГ СУНГАХ

12.1 Төрийн өмчийн хороо өргөдөл, санал ирүүлэх хугацааг өөрийн санаачилгаар болон тендерт оролцогчийн хүсэлтийн дагуу сунгах буюу тендерийн хуваарийг хэдийд ч ямар ч байдлаар өөрчилж болно.

12.2 Монгол Улсын Засгийн газар нь аль ч үед урьдчилан мэдэгдэлгүйгээр үралдаант шалгаруулалт /тендер/-ын журмын аль ч заалтыг хасах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах эрхтэй. Тендерийн журамд оруулсан аливаа өөрчлөлтийн талаар Төрийн өмчийн хороо бүх тендерт оролцогчдод бичгээр мэдэгдэнэ.

12.3 Зөвхөн нэг эгтэйд тендерт оролцох өргөдөл ирүүлсэн, эсвэл тендерт зөвхөн нэг оролцогч тендерийн санал ирүүлсэн тохиолдолд тендерийг цуцлах, эсвэл өргөдөл, тендерийн санал ирүүлэх хугацааг сунгаж болно.

Тендерт оролцогчийн гарын үсэг _____
Он, сар, өдөр _____

ХАВСРАЛТ 1

ТЕНДЕРИЙН ХУВААРЬ

Үйл ажиллагаа	Огноо/Эцсийн хугацаа
Тендерийн зар мэдээ	2001 оны 9 дүгээр сарын 3
Өргөдлөө ирүүлэх /Урьдчилан шалгаруулалт/ Тендерийн баримт бичгийг хүргүүлэх	2001 оны 9 дүгээр сарын 3-наас 10 дугаар сарын 5
Банк дээр дүн шинжилгээ хийх/санал, дүгнэлт гаргах хугацаа	2001 оны 9 дүгээр сарын 17-ноос 11 дүгээр сарын 9
Банктай танилцаж, үүлэлт хийх хүсэлтээ ирүүлэх	2001 оны 10 дугаар сарын 5
ХХХАГ-ний төслийн талаар санал авах	2001 оны 10 дугаар сарын 15
ХХХАГ-ний шинэчилсэн төслийг боловсруулан гаргах	2001 оны 10 дугаар сарын 22
ХХХАГ-ний шинэчилсэн төслийн талаар санал авах	2001 оны 10 дугаар сарын 29
ХХХАГ-ний эцсийн төслийг бэлтгэн гаргах	2001 оны 11 дүгээр сарын 5
Тендерийн санал ирүүлэх	2001 оны 11 дүгээр сарын 12
Техникийн саналыг үнэлэх	2001 оны 11 дүгээр сарын 12-ноос 11 дүгээр сарын 19
Техникийн саналын үнэлгээний дүнг мэдэгдэх	2001 оны 11 дүгээр сарын 19
Санхүүгийн саналыг нийтийн өмнө нээж үнэлэх/Тендерийн үр дүнг нийтэд мэдээлэх	2001 оны 11 дүгээр сарын 28
Гэрээнд гарын үсэг зурах	2001 оны 11 дүгээр сарын 28

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Хаяг: «Төрийн мэдээлэл» эмхтгэлийн зөвлөл

Улаанбаатар-12 ☎ 329612
Төрийн ордон Индекс 14003

Улсын Их Хурлын Тамгын газрын Хэвлэх хэсэгт хэвлэв.

☎ 329487